


Дэн Браун



Да Винчийн

КОД

Да Винчийн код

Дэн Браун

Эхийг бэлдэж, Электрон хувилбарт : Someone

Парист ажил хэргээр ирсэн Харвардын сургуулийн тэмдэгт судлаач, профессор Роберт Ландонд Луврын музейн эрхлэгч учир битүүлгээр нас барсан байна хэмээн шөнө дунд мэдэгджээ. Түүнийцогцсын дэргэд үл тайлагдах код бичигдсэнийг цагдаагийнхан олсон байна. Энэхүү ээдрээтхэргийн учрыг тайлах явцад Ландон хэргийн учиг Леонардо Да Винчийн бүтээлүүдтэй холбоотойгэдгийг гадарлаж эхэлнэ.

Францын мэргэжилтэн, авьяаслаг шинжээч Софи Нөвүтэй хамт хэргийг мөрдөх явцад музейнэрхлэгчийг Сионий Прайорид хамаатай байсныг Ландон олж мэджээ. Сионий Прайори хэмээх энэнууц бүлэглэлд Исаак Ньютон, Ботичелли, Виктор Гюго, Леонардо Да Винчи зэрэг алдарт хүмүүсхарьяалагдаж байсан аж. Ландон, Нөвү хоёр хэргийн халуун мөрөөр орж, Парис, Лондон зэрэгхотуудыг хэрэн сүлжих бүрт тэдний мөрийг мөшгөх хэн нэгэн байгаа нь илэрхий болно. Хэрэв тэрхоёр хэргийн учгийг тайлж чадахгүй бол олон зууны туршид Прайори бүлэглэлийн хадгалж байсаннууц ор мөргүй устан алга болох байлаа ...

Эхлэл

... Луврын музей, Парис. Оройн 10 цаг 46 мин.

Музейн эрхлэгч Жак Сониех ухаан зулаггүй гүйсээр, музейн гол танхимыг өнгөрөв. Ханандөлгөсөн Караважиогийн уран зургийн дэргэд хүрч ирсэн хойноо, амьсгаагаа дарав. Эрхлэгч өвгөнтэр зургийн алтадмал том жаазны өнцгөөс чангаасаар доош унагахдаа, хүчиндээ дийлдэн өөрөө дорнь дарагдчихав. Түүний тооцоолсон ёсоор болж, төмөр торнууд гарцыг хаан нирхийтэл доош буухнь тэр. Шал хүчтэй доргих нь мэдрэгдэж, тэртээ цаана түгшүүрийн дохио хангинаж эхлэв..

Эрхлэгч шалан дээр хэсэг хугацаанд чимээгүй хэвтсэнээ, амьсгаадан ухаан орох зуур, өөрийгөөамьд гэдэгт удалгүй итгэлээ. Тэр жаазтай зурган дороос мөлхөж гаранг уутаа, танхимын эргэнтөйрныг нэгжин харав.

Гэтэл ардаас нь "Битгий хөдөл!" гэх дуу гэнэт сонслоо.

Эрхлэгч өвгөн дөрвөн хөллөсөн чигтээ хөдөлгөөнгүй болж, гагцхүү толгойгоо тэр зүг эргүүлэв.Ердөө 6 - 7 алхмын зайд төмөр торны цаана бадируун биетэй, өндөр н уруутай, хий үзэгдэл шигцагаан царай, тачир цагаан үстэй этгээд бараан дүрстэй эрлэгийн элч дүрээр зогсч байлаа. Цайварзүст альбиногийн (Төрөлхийн цагаан цайвар зүстэй төрсөн хүн) нүд нь улаанаар эргэлдэх бөгөөд,хүрэмнийх нь халааснаас цухуйх бууны ам эрхлэгч рүү чиглэсэн байв.

"Зугтаад нэмэргүй шүү! Харин одоо тэр зүйл хаана байгааг хэл" гэж англиар нэдХээд аялгатайхэлэв.

"Би чамд хэлсэн шүү дээ. Чи юуны тухай яриад байгааг чинь мэдэхгүй байна" хэмээн эрхлэгч ээрчтүгдрэн хариулав.

"Чи худлаа ярьж байна" хэмээн цайвар зүст нүдэндээ оч гялалзуулан огт хөдөлгөөнгүй чигээрэгүүлэв. "Чи болоод чиний хүмүүс өөрт хамаагүй зүйлийг нуусан".

Өвгөн маш цочирдож, нууц хэрхэн задарсан болохыг олж ядна.

"Хаана байгааг нь хэлбэл чи амьд үлдэнэ" гэж хэлээд өвгөний толгой РУУ буугаа чиглүүлэв. "Энэнууцын төлөө чи амиа золиослох юм гэж үү?"

Сониех тэр дороо хөшчихөв. вайвар зүст толгойгоо сэгсрэн, буугаа түүн рүү доошлуулахад,

" Байз! Хүлээгээрэй! Би чамд хэрэгтэй байгаа зүйлийг чинь хэлж өгье" гэж эрхлэгч арга ядсандуугаар өгүүлэв.

Тэрээр өмнө нь хэдийгээр хэрэг болохгүй гэж боддог байсан ч аргагүй тохиолдолд худал хэлэхдасгал нэдээд хийснийгээ турших цаг нь одоо нэгэнт болжээ.

Түүнийг зохиомол зүйдээ ярьж дуусахад, алуурчин эр тавлан инээснээ, "Тиймээ. Бусад чинь ч басингэж хэлсэн юмсан".

Сониех айх, гайхах зэрэгцэн бусдынхаа тухай бодлоо.

"Би тэднийг олсон. Яг л чамтай адил. Бусад гурав чинь ч чиний хэлсэнтэй адил зүйлийг хэлсэн".

Тэднийг олсон байх ёсгүй дээ!

Сониех бодоод бусад хүмүүс үнэндээ хэн болох нь тэдний хадгалж буй нууцтай адилхан хаашаа чзадрах ёсгүй юм. Нөгөөтэйгүүр бүгд л түүнтэй адил худал зүйл хэлсэн нь ингэх л ёстой байснаастэр.

Алуурчин түүн рүү буугаа онилж, "Чамайг үхсэний дараа бүх үнэнийг зөвхөн би л мэдэж хоцорно" гэв.

Бүх үнэн гэнэ үү? Гэвч намайг үхчихвэл, бүх үнэн ор мөргүй алга болно.

Тэр бүх хүчээ шавхан бууны амнаас холдохоор ухасхийн хөдлөв.

Буу тасхийж, гэдсэнд нь сум нэвтрэн ороход, эрхлэгчийн бие буцлам халууныг мэдрэх шиг болов. Доош эвхрэн унаад, алуурчин руу эргэн харж амжив.

Айдас, харуусал зэрэгцэн хэвтэх зуур, гох дарах дуу дахин гарсан боловч, сум нь дууссанбололтой, хоосон чагчаг хийх дуу танхимд цуурайтав.

Эрхлэгч нүдээ нээлээ. Энэ мөчид альбино эр буугаа шалгаад, дайзаа солих гэснээ больж, түүнийгэдсэн дэх шархыг хараад инээмсэглэв.

"Миний ажил ингээд дууссан бололтой".

Эрхлэгч цээжнийх нь яльгүй доод хэсэгт цамцыг нь нэвтрэн орсон Сумны ормыг хараад, Сумзүрхэн тушаа тун ойрхон туссаныг анзаарлаа.

Алжирт байлдаж байсан ахмад дайчны хувьд түүнийг ямар үхэл хүлээж байгааг тэр мэдэж байв. Сумны шархаар гадагшлах ходоодны хүчиллэг шүүс түүний цээжний хөндийд нэвчиж, ердөө 15 минутын дараа тэр үхдэл болох болно.

"Өвдөлт мэдрэх ч сайхан шүү, ноёнтоон!" гэж алуурчин эр хэлээд түүнийг орхин одлоо.

Ганцаар үлдсэн Сониех төмөр хаалт руу ширтэнэ. Тэр занганд оржээ. Төмөр хаалтууд дор хаяж 20 минутын дараа нээгдэнэ. Харин гаднаас хэн нэгэн түүнд туслахаар орж ирэх үед, тэр аль хэдийнээүхчихсэн байх болно. Гэвч түүнийг эзэмдэх айдас түүний үхлийн тухай бодлоос хавьгүй хүчтэйбайлаа.

Би нууцыг цааш дамжуулах ёстой! Гэхдээ энд музейн гол танхимд түгжигдчихсэн байтлаа нууцыгбуслад хэрхэн дамжуулах вэ?

Тансаг орд харш шиг шоронд байгаагаа Сониех сая л ухаарлаа. Хананд өлгөөтэй алдарт бүтээлүүдэртний анд нар мэт түүний дээрээс өнгийн хараад инээх мэт санагдана.

Дааж давшгүй мэт санагдах өвчинтэйгөө тэмцсээр, өөрийгөө хүчлэн бослоо. Хувиршгүй зорилгообиелүүлэхийн тулд, тэрээр исгэрэн өнгөрөх хором бүрийг алдахгүйг хичээх хэрэгтэй байлаа.

Хэсэг 1

Утасны чихэнд танил бус хангинах чимээ дуулдана.

Тэрээр орны дэргэдэх ханын гэрлийг тэмтэцсээр унтраалгыг дарав. Гэрэлд гялбасан нүдээ хагаснээгээд харвал, Льюис XVI- р үеийн тавилга бүхий унтлагын өрөөний хананд уран зургууд олноорөлгөсөн байх бөгөөд Роберт Ландон өөрөө уужим орон дээр тухалсан байлаа.

Би одоо ямар гээч газар байгаа юм бэ? гэж эргэцүүлэнгээ, орны дэргэд өлгөөстэй халаадны энгэрдээр " **Рийц зочид буудал. Парис**" гэж бичсэнийг олж уншлаа. Тэр сая л бүхнийг санаж эхлэв.

Ландон харилцуурыг авч, "Байна уу?" гэхэд өөдөөс нь,

" Мүсьюү Ландон?" гээд цааш үргэлжлүүлэн, "Би таныг сэрээчихэв үүдээ?" хэмээн үүдний лавлахасуухад, Ландон гайхан цагаа харвал шөнийн 12.30 болж байв. Хэдийгээр тэр цагийн өмнөхөнунтсан боловч, үхсэн хүн шиг болчихжээ.

"Буудлын лавлахаас ярьж байна, Мүсьюү? Төвөг удсанд уучлаарай. Тань дээр зочин ирлээ.Яаралтай ажлаар тантай уулзах гэнэ".

Ландон учрыг ойлгосонгүй.

Зочин ий? гэж амандаа бувтнангаа, орны хажуугийн ширээн дээрх үнгэгдсэн цаасыг харвал, "Парис дах Америкийн Их сургуулийн урилгаар Харвардын Их сургуулийн профессор, тэмдэгтсуллаач Роберт Ландон илтгэл тавина" гэсэн байлаа.

Ландон санаа алдаад, түүний өнөөдөр тавьсан илтгэл хэн нэгний дургүйцлийг төрүүлээд тэр ньодоо түүнтэй уулзаж, уураа гаргахаар ирж гэж бодлоо.

"Уучлаарай. Би маш их ядраад бас ..." гэж Ландоныг хэлтэл,

" Мэ Мүсьюү!" гээд үүдний лавлах харилцуурын цаанаас, "Тан дээр маш чухал зочин ирсэн" гэжшивэгнэх шахам хэлээд, дуугүй болчихов .

Ландоны бичсэн шашны чиглэлийн уран зураг болоод бэлгэдлийн талаарх номууд нь түүнийг машалдартай болгосон бөгөөд, өнгөрсөн жил тэрээр Ватиканы тусгай хуралдаанд оролцсон нь олнытанил хүн болоход хүргэсэн билээ. Үүнээс хойш урлагийн болоод шашны чиглэлийн хорхойтнуудтүүнийг эцэс төгсгөлгүй зорьж ирэх болсон юм. "Та надад тус болоод, наад ирсэн зочныхоо нэр,холбогдох утсыг аваад үлдчихгүй юу? Би ирэх мягмар гаригт буцахаасаа өмнө түүнтэй эргэжхолбоо барья. Баярлалаа!" гээд хариу ч хүлээсэнгүй харилцуураа тавьчихав .

Ландон орон дээрээ босч суугаад, буудлын танилцуулга дээрх өгүүлбэрийг хөмсөг зангидануншлаа:

"Гэрэл цацарсан Парис хотод нялх хүүхэд шиг амгалан нойрс! Рийи зочид буудалд л таүүнийг мэдрэх болно".

Толинд тусах өөрийнхөө дүрсийг Ландон арайхийн танилаа. Тэр хэдийгээр өнгөрсөн жил нэлээдтуйлдаж ядарсан ч гэлээ, одоогийн байгаа төрх, байдалдаа сэтгэл гонсгор байв. Олон хоногхусаагүй сахал нь том эрүү, хүчирхэг шанааг нь нуун далдлаад, санчигт нь гялтганах цагаан үсөтгөн ширүүн хар үс рүү нь уусан оржээ.

Бостон сэтгүүл намайг одоо нэг хардаг ч болоосой хэмээн Ландон дотроо бодлоо.

Сарын өмнө түүнийг Бостон сэтгүүлээс тус хотын хамгийн дур булаам 10 хүний тоонд багтаасан юм. Энэ шалгаруулалтаас болж, сургуулийнхаа багш нарын тоглоом наргианы байнаас арайхийнхолдоод байтал, өнөө орой илтгэл дээр хөтлөгч эмэгтэй түүнийг дахин эвгүй байдалд оруулахшахсанаа өөрөө ч сайн мэдээгүй билээ.

"Ноёд, хатагтай нар аа! Өнөөдрийн манай зочин бол илүү тайлбар хийлгэхээргүй алдартай хүн. Түүний бичсэн "Нууц урсгалынхны бэлгэдэл", "Дүрс бичлэгийн алдагдсан соёл", "Шашныгэмдэгзүй" гээд олон номуудыг та бүхэн өнөөдөр сурах бичиг болгон ашиглаж байгаа" гэж хөтлөгчэмэгтэйг хэлэхэд, танхимд цугласан оюутнууд бүгд толгой дохилоо.

"Тэгвэл одоо түүнийг арай өөр өнцгөөс танилцуулахыг та бүхэн зөвшөөрнө үү! Учир нь нэгэноюутан түүний тухай өгүүлэл бичсэн нэгэн сэтгүүлийг надад өгсөн билээ" хэмээн хэлэх тэр агшиндхөтлөгч эмэгтэйн гарт Бостон сэтгүүл байхыг, Ландон анзаарлаа.

Ландон ичихийн дээдээр ичив.

Тэр үүнийг хаанаас олоод авдаг байна аа?

Хөтлөгч өөрийн тэмдэглэсэн хэсгээс уншиж эхлэв. Танхимд цуглагсад инээмсэглэл тодруулан, эмэгтэйг сонсох бөгөөд тэрээр, "Ноён Ландоны Ватиканы тусгай хуралдаанд оролцсон явдал манайсэтгүүлийн дур булаам шалгуурын үзүүлэлтийг суга татахад хургэсэн" гэж уншсаныхаа дараа, "Танар цааш нь сонсмоор байна уу?" гэж зориул асуув.

Бүгд л цааш сонсохоо илэрхийлэн, алга нижигнүүлэн ташлаа.

Түүнийг хэн нэг нь болиулаасай!

"Хэдийгээр профессор Ландон бусад залуу нэр дэвшигчдийн адил дур булаам байж чадахгүй ч, энэхижээл эрд бусдыг татах нэг нууцхан зэвсэг байдаг. Түүний нам дуугаар хүнгэнүүлэн ярихыг, эмэгтэй оюутнууд сонсоод, тэсэхийн аргагүй болж, суудал дээрээ "хавчганадаг" байна.

Үүнийг сонссон танхим тэр чигээрээ доргин инээлдэв. Ландон аргагүй байдалд оронинээмсэглэхийг оролдоно. Хэрэв энэ өгүүллийг цааш уншвал, Ландоныг "Хар ноосон цамцтай Харрисон Форд" гэж бичсэн байсан бөгөөд, хамгийн инээдтэй нь тэрээр энэ орой хоолойгоохалхалсан нимгэн цамцны гадуур өнөөх хар ноосон цамцаа өмссөн байсан юм.

"Баярлалаа, Монике!" гэж Ландон хэлээд эмэгтэйг индрээс эвтэйхэн буулгасныхаа дараа, "Бостонбол нэмж хачирлахдаа гаргууд сэтгүүл шүү дээ! Харин энэ сэтгүүлийг Моникед өгсөн оюутныголбол түүнийг Америк руу буцааж дөнгөнө шүү!" гэхэд танхимд байсан оюутнууд бүгд инээлдэв.

"За, хүүхдүүдээ! Өнөөдөр би та бүхэнд бэлэг тэмдгийн агуу их чанарын тухай ярихаар

ирсэнгэдгийг та нар бүгд мэдэж байгаа".

Нам гүмийг эвдэн утас дахиад хангинав.

Ландон харилцуурыг авч "За!" хэмээн хариулбал, мөнөөх лавлахын ажилтан,

"Ноён Ландон. Намайг өршөөгөөрэй! Тань дээр ирсэн зочин одоо танай өрөө рүү очиж байгаа. Битанд дуулгах хэрэгтэй гэж бодлоо".

Ландон нойрноосоо бүрмөсөн сэргэж, "Манай өрөө рүү хүн явууллаа гэнэ ээ?" хэмээн уурсахад,

"Миний буруу, эрхмээ. Гэхдээ түүнд саад хийх эрх надад байхгүй".

"Тэр хэн юм бэ?" гэж асуухад, үүдний лавлах аль хэдийнээ утсаа тасалсан байлаа.

Тун ч удалгүй хаалга хүчтэй тогших нь сонсогдож, Ландон орноосоо сугаран босоод, халаадаа өмсөж, хаалга руу дөхлөө. "Хэн бэ?"

"Ноён Ландон мөн үү? Би тантай ярилцах хэрэгтэй байна" гэж хаалганы цаанаас зочин англиараялгатай хэлээд, "Намайг Жером Коле гэдэг. Шүүх цагдаагийн газраас явж байна"

Ландон түр азнаж, Шүүх цагдаа гэдэг чинь манайхаар бол "Холбооны мөрдөх товчоо" гэсэн үг шүүдээ! хэмээн өөртөө тайлбарлалаа.

Хаалганы гинжийг мултлахаа түр азнаж, тэрээр хаалгаа бага зэрэг онгойлгов. Хаалганы цаанатуранхай, цэвэрхэн царайтай цагдаагийн ажилтан залуу зогсох бөгөөд, албаны хөх хослол өмсжээ.

"Би орж болох уу?" гэж дэслэгчийг асуухад, Ландон дэслэгчийн хурц шар нүд рүү ширтэнгээ түртээнэгэлзэв.

"Та ямар хэргээр явж байгаа юм бэ?" гэхэд, дэслэгч "Манай ахмад танаас мэргэжлийн туслалцаа хүссэн юм".

"Яг одоо юу?" гээд Ландон цагаа харж, "Одоо яг шөнө дунд болж байна шүү дээ!"

"Андуураагүй бол та өнөө орой Луврын музейн эрхлэгчтэй уулзахаар товлосон байсан уу?" гэж дэслэгч асуув.

Үнэхээр Ландон эрхлэгч Жак Сониехтэй илтгэлийн дараа уулзахаар болзсон боловч, Сониехирээгүй юм.

"Тиймээ. Та энэ талаар яаж мэдсэн юм бэ?" гэхэд,

"Түүний тэмдэглэлээс олж уншсан юм".

"Ямар нэг муу зүйл болоо юу?" гэхэд, дэслэгч гүнээр санаа алдаад, хаалганы завсраар нэгэн гэрэлзураг өгөнгөө, "Энэ зургийг Луврын музейд цагийн өмнө авсан юм" гэв .

Ландон тэрхүү аймшигт зургийг хараад, эхэндээ цочирдсон боловч, яваандаа уур цухал нь бадраадирэв.

Хэн үүнийг хийдэг байнаа?!" "Харин та л энэ асуултад хамгийн сайн хариулж чадах мэргэжлийн хүн шүү дээ! Тэмдэгт судлалаар болон, түүнтэй уулзахаар товлосон байсны хувьд хэргийн мөрдөлтөд тус хүргэж чадна гэж танд найдаж байна" гэж дэслэгч хариулав.

Дэслэгч Ландоныг зураг руу удаан ширтэхийг нь хүлээж тэвчихгүй бололтой, цаг руугаа хяламхийснээ, "Ахмад таныг хүлээж байгаа ноёнтоон!" гэв.

Ландон түүний хэлснийг анзаарсангүй, зураг руу ширтсээр л байв. "Энд байгаа эдгээр тэмдгүүдболон цогцос үнэхээр онцгой..." гэхэд,

"Онцгой байдалтай байна гэж үү?" хэмээн дэслэгч түүний үгийг гүйцээн асуув.

Ландон толгой дохиж, "Хэн ийм зүйл хийснийг төсөөлөх ч аргагүй юм" гэж шогширлоо.

Дэслэгч төв дуугаар, "Та ойлгохгүй байна, ноён Ландон! Таны энэ харж байгааг Сониех өөрөөхийсэн юм" гэлээ.

Хэсэг 2

Хэрэг явдал ийм болж байхад, тэндээс милийн зайтай газар Силас нэрт альбино Рью Ла Брүех дэхдотуур байр луугаа харьж явлаа. Гуянд нь зүүлттэй байх өргөст бүсэнд зовиурлан шаналах өвчиннь түүнийг Ертөнцийн эзний төлөө үйлчилдэг гэдгийг нь батална.

Өвдөлт мэдрэх ч сайхан шүү!

Дотуур байр луу орох үедээ, тэрээр үүдний хонгилыг сайтар ажиглаад, тэнд хэн ч байгаагүй тул,шатаар шалмаг гэгч өгсөн гарлаа. Силас өөр бусдыг сэрээхийг хүссэнгүй. Түүний өрөөний хаалгаонгорхой байсан учир шууд орж, хаалгыг дотроос нь болгоомжтой хаав.

Хатуу модон шалтай, ганц шүүгээ, даавуун гудас дэвссэн тэр өрөө бол Силасын хоноглох байр.Тэрээр Нью - Иоркт бас л иймэрхүү байранд олон жил амьдарсан бөгөөд, Парист түр байххугацаандаа энэ дотуур байранд оржээ.

Ертөнцийн эзэн надад орох орон, зорих зорилго хайрласан.

Харин одоо бурхны ачийг хариулах боломж Силаст тохиосон нь энэ билээ. Шүүгээ рүү ухасхийн,хамгийн доод талын нүднээс гар утсаа гаргаад, гадагш залгалаа.

"Байна уу?" гэх эрэгтэй хүний дуу харилцуурын цаана сонстов.

"Багш аа! Би ирчихлээ".

"За! Ярь, ярь" гэж хэлэхдээ нөгөө эрийн дуунд сэтгэл хангалуун байдал мэдрэгдэнэ.

"Тэд дөрвүүлээ үхсэн. 3 гишүүн, тэргүүнийхээ хамт".

Нөгөө хүн харилцуурын цаана залбирч байгаа бололтой хэсэг дуугүй байснаа, "Чи тэднээс амөчгийг нь авч чадав уу?"

"Тэгсэн. Бүгд ам өчгөө өгсөн".

"Чи тэгээд тэдэнд итгэж байна уу?"

"Тэдний хэлсэн нь хоорондоо яг тохирч байгаа".

"Маш сайн байна. Би ч тэднийг нууцаа тууштай хамгаалсаар үхэх болов уу гэж айж байлаа".

"Үхлийн өөдөөс сөрж, худал ярих зориг хэнд ч байхгүй шүү дээ",

"Тэгвэл шавь минь! Багшдаа сайхан мэдээгээ дуулгаач дээ",

Түүний олж авсан мэдээлэл Багшийг маш ихээр гайхшруулна гэдгийг Силас мэдэж байв.

"Багш аа! Онъсон чулууны байгаа газрыг тэд бүгд ямар ч эргэлзээгүй адилхан хэлсэн".
"Онъсончулуу! Тиймээ , бидий бодсоноор болжээ".

Олны ам дамжсан яриагаар бол, Ахан дүүсийн холбоо нь Онъсон чулууг хадгалж буй газрыгчандлан нууцлах үүрэг хүлээсэн бөгөөд, тийм ч учраас Онъсон чулуу нь Ахан дүүсийн холбооныоршин тогтнохын үндэс болсоор ирсэн билээ.

"Бид Онъсон чулууг гартаа оруулчихвал, зорилгодоо нэг алхмаар ойртлоо л гэсэн үг".

"Багш аа, Онъсон чулуу таны бодож байгаагаас ч ойрхон газарт, энд Парист байгаа".

"Парис гэнэ ээ?! Гайхалтай! Тэгвэл бүх зүйл хялбар шийдэгдэж байх шив".

Силас болсон бүх явдлыг Багшид ярив.

Түүнд алагдсан 4 хүн үхэхийнхээ өмнө, өөрсдийн амийг хэлтрүүлэхийн тулд, нууцаа хялбарханхэлсэн тухай Багшдаа ярьж өгөв. Онъсон чулууг Парист, тэр дотроо Дарь Эхийн сүмд байгаагэдгийг тэд бүгд ахин дахин хөдөлбөргүй хэлсэн билээ,

"Онъсон чулуу Бурхны сүмд байгаа гэж үү?" гэж Багш уулга алдаад, "Тэд биднийг яаж дөнгөжчадав аа?"

Багш өөрийг нь эзэмдэх ялгуусан их ялалтаа мэдрэхийн тулд дуугаа хэсэг хураав. Эцэст нь тэрээр,

"Чи Бурханд бүхнээ зориуллаа, Силас. Бид энэ мөчийг мөн ч удаан хүлээсэн шүү. Одоо харин чионъсон чулууг надад авчрах ёстой. Нэн даруй, энэ шөнөдөө. Ойлгов уу?"

Багшийн өгсөн, энэ тушаал Силаст боломжгүй мэт санагдана.

"Сүмд шөнө дөлөөр нэвгэрнэ гэдэг цайзад нэвтрэхтэй адил хэцүү шүү дээ! Би чадах болов уу?"гэхэд, Багш ятгалга, сэнхрүүлдгийн үнэр нэвг шингэсэн дуугаар Силаст заавар, зөвлөгөө өглөө.

Силас утсаа таслаад, цаашид юу болохыг бодохоос, нуруу нь хүйт оргино. Сүмд очихоос өмнөөнөөдөр үйлдсэн нүглээ цайруулж. бие сэтгэлээ ариусгах ёстой. Гэхдээ өнөөдрийн үйлдсэн нүгэлбол Бурхны төлөө байсан тул Силас өршөөгдөнө. Бурханд тэрслэгчидтэй нь ийм л аргаар тэмцэжирсэн юм чинь!

Силас өрөөний голд очоод, бүх хувцсаа тайчиж , гуян дахь өргөст бүсээ шалгаад, доош өвдөглөнсуув.

Бурхны үнэнч шавь нар ийм өргөст бүс зүүдэг бөгөөд, өргөс нь дотогш харсан ширэн бүсийгчангалахад, арьсанд шигдэн орсон өргөс Ертөнцийн эзэн Есүсийн мөнхийн зовлон шаналлыгхуваалцаж

буйн илрэл болдог аж. Мөн түүнээс гадна өвдөлт нь дур хүслийг хазаарлах том хэрэгсэл болдогюм.

Силас хэдийгээр зүүх ёстой хугацаагаа /өдөрт 2 цаг/ хэтрүүлсэн өнөөдөр түүний хувьд

онцгой өдөртул, бүсийг дахин нэг нүх дотогш чангалав. Амьсгалаа удаанаар гаргаж, саяхь үйлдлээсээ таашаалавчээ.

"Өвдөлт мэдрэх сайхан!" хэмээх Их багш Хосемариа Эскривагийн сургаалийг Силас давтаншивигнэнэ .

Хэдийгээр Их багш Хосемариа Эскрива 1975 онд нас барсан ч, түүний сургаал болоод "өөрийгөө тарчлаах" тухай ойлголт одоо хэр хүчтэй хэвээр байгаа юм.

Силас шалан дээр хэвтэх хүнд гэгчийн олс руу гараа сунгав. Олсны олон салаа үзүүрт хатсан цусны толбо үзэгдэнэ. Силас нүдээ анин, олсыг мөрөө давуулан хүчтэй шидэх тэр агшинд, шавхуурдах чимээ гарч, түүний нуруу өвдөлтийг мэдэрдээ .

Нуруугаа ташуураар хүчтэй саван ороолгож, энэ үйлдлээ олон дахин давтана.

"Кастиго Корпус Мэум" (өвдөлт мэдрэх сайхан)

Удалгүй ар нурууг нь даган бүлээн юм урсах нь мэдрэгдэв. Энэ бол түүний цус байлаа.

Хэсэг 3

Хаврын бүгчим агаар машины цонхоор нэвтэрч, Citroen ZX маркийн цагдаагийн машин Дуурийн театрыг өнгөрөн, Вендомыг чиглэн давхина.

Ландон жирэлзэн өнгөрөх байшин барилгуудыг харангаа, өөрийн бодлыг арчин хаяхыг оролдон байлаа. Хэдийгээр тэр өрөөнөөсөө гарахдаа шүршүүрт орж, сахлаа хусаад, өнгө зүс зассан ч, бодол санаа шралаасаа салж чадсангүй. Эрхлэгч өвгөний сэтгэл сэрдхийм дүр зураг түүний нүдэнд байнга харагдсаар байв.

Жак Сониех үхсэн !

Ландон түүний төлөө юу ч хийж чадахгүй ч, маш их харамсч байлаа.

Сониех маш нууцлагдмал хүн байсан боловч, урлагт, уран зурагт оруулсан түүний хувь нэмрийг үнэлж баршгүй билээ. Пуссин , Тениерс нарын уран зураг дахь далд утгын тухай бичсэн түүний номноос Ландон үргэлж жишээ татах дуртай байсан юм.

Энэ үдэш түүнтэй уулзахаар тэсэн ядан хүлээж байсан авч, Сониех ирээгүй ажээ. Дахиад л үхдэл өвгөний хирдхийм дүр тодроход, Жак Сониех өөрийгөө хорлосон гэж үү? гэж Ландон гайхан, энэ бодлоосоо салахын тулд, цонхоор гадагш харав.

Дэслэгч машиныхаа дохиог хангинуулан давхихад, замбараагүй хөлхөлдөх машинууд замын хоёртал руу ярагдаж зай тавьж өгнө.

Дэслэгч замд гарснаас хойш анх удаа ам нээж, "Таныг Парист байгааг мэдээд ахмад маш ихолзуурхсан шүү. Азтай тохиолдол гэж байна лээ" гэв.

Ландон тэр бүр тохиолдол, учралд итгэдэггүй хүний нэг. Олон жилийн турш бэлэг тэмдгийн тухай судлахдаа, тэрээр ямарваа нэгэн зүйлийн үр дагавар нөгөөгийнхөө шалтгаан болдгийг бат нотойлгосон билээ.

Тэрээр Харвардад заадаг тэмдэгт судлалын хичээлдээ ямарваа зүйлс хоорондоо огт хамааралгүймэт харагдаж болох ч, энэ бол зөвхөн өнгөн тал байдаг гэж үргэлж онцолдог юм.

"Намайг энд байгааг Америкийн Их сургуулийнхан та нарт хэлсэн үү?"

Дэслэгч Коле толгойгоо сэгсрээд, "Интерпол" гэж хариулав. Нээрээ, тийм л дээ!

Европын аль ч зочид буудалд буухад паспортаа шалгуулахыг хүсдэг нь бусдад шоолуулах гэсэндээбиш хууль дүрмийг сахин ажиллаж байгаа хэрэг. Иймээс л Интерпол Европ даяар ямар хүн хаана

буудаллаж тухалсныг төвөггүйхэн мэдэх нь аргагүй. Тэр тусмаа Ландоныг Рийц зочид буудлаасолоход хэдхэн секунд зарцуулсан биз.

Тэд хотын өмнө дүүргийг чиглэн хурдлах үед Эйфелийн цамхаг тодрон үзэгдэв.

Ландон дурлалт бүсгүй Витториатай жилийн өмнө ам өчиг авалцан байж, жидд 2 удаа сэтгэл татамгазруудад болзоо тогтон уулзахаар болоод салсан билээ. Эйфелийн цамхгийг тэр газруудынхаажгаалтад багтааж болох байжээ. Харамсалтай нь дурлалт хосууд хамгийн сүүлд Ромын нисэхонгоцны буудал дээрээс үнсэлцэн байж салсан юм.

"Та дээр нь гарч амжсан уу?" гэж дэслэгчийг асуухад, Ландон гайхаж,

"Өршөөгөөрэй?"

"Сэтгэл алдмаар сайхан биз, тийм үү?" гээд, урд цонхоор харагдах цамхаг руу заагаад,

"Та түүний дээр нь гарсан уу?" гэж дахин асуухад Ландон сая л учрыг ойлгон, нүдээргэлдүүлснээ,

"Үгүй юм байна" гэж хариулав.

"Тэр бол Францын сүр жавхлангийн бэлгэ тэмдэг. Миний бодлоор төгс төгөлдрийн дээд байгааюм"

Ландон дуртай дургүй толгой дохив.Тэмдэг судлаачдын ихэнх нь Франц орныг хүүхэмсэг байдал,эсвэл давжаа биетэй, намхан удирдагчдаар / Напелеон , Пепин/ төлөөлүүлж үздэг юм.

Рью Ла Риволид хүрэх үед дөрвөн замын уулзвар харагдсан боловч дэслэгч хурдаа саасангүй,ирсэн хурдаараа Рью Кастиглионаар орж эрчлэн давхив. Энэ зам Парисын Үндэсний цэцэрлэгтхүрээлэн болох Туилри руу хүрдэг билээ.

Хэдийгээр энэ цэцэрлэг романтик адал явдлын бэлгэдэл болдог ч, өмнө нь эндээс дээврийнхавтанцрын түүхий эд хийхийн тулд, их хэмжээний шавар олборлосноос тогоон чинээ том нүхүлдэж, түүнийгээ даллах зорилгоор цэцэрлэг байгуулсан юмсанж.

Цэцэрлэгт хүрээлэнд машинтайгаа нэвтэрсэн хойноо, дэслэгч дохиогоо унтраав. Ландон түрамсхийж, нэг ч гэсэн чимээнээс салсандаа дотроо баярлав. Ландон энэ цэцэрлэгийг өмнө нь ариундагшин газар гэж санаж явжээ. Гэтэл одоо цонхны цаанаас харагдах нь хүйтэн хөндий оргиод нэг лэвгүй санагдана.

Машин зүүн тийш эргэж, цэцэрлэгийн гол гудмаар явж эхлэв. Дугуй нуурыг хагас тойроод, засмалзам дээр гарч ирэхэд цэцэрлэгт хүрээлэнгийн зах харагдав.

Каруссель хэмээх чулуун арк харагдвал, цэцэрлэгт хүрээлэн дуусч буйн тэмдэг болно. Энэ чулуунаркийн алдар суу нь ур хийцэд нь бус харин давгагдашгүй байршилдаа байгаа юм. Урлагсудлаачид зөвхөн Карусселийн дэргэдээс л дэлхийд алдартай 4 музейг нэгэн зэрэг харж болдогхэмээн шагшдаг. Тэр тусмаа Каруссель тэдгээр музейн тэхий голд луужин адил оршдог ньгайхмаар.

Ландон цонхоор баруун гар тийш харвал d"Orsay музей, зүүн талаа харвал "Орчин үеийн

урлагийн"музей, харин хойшоо эргэж харвал Jeu De Paume музей, урагш харвал дэлхийд хамгийн алдартайдтооцогдох Луврын музей байлаа.

Өмнө нь сүндэрлэх Луврын аварга байгууламжийн сүр хүчинд автахгүй гэж дэмий л оролдовч, танил дотно өнгө төрх Ландоны нүдэнд эрхгүй тусна. Морины тах шиг хэлбэртэй музейн барилга Европтоо хамгийн уртад тооцогддог бөгөөд, Эйфелийн цамхгийн өндрөөс 3 дахин урт юм.

Ландон нэг удаа Луврын музейг бүхэлд нь тойрохын тулд 3 миль газар туулсан удаатай.

Жуулчид музейд тавигдсан 65300 гаруй үзмэрүүдийг үзэхийн тулд, 5 өдөр элбэг зарцуулна. Гэвч тэдний ихэнх нь Ландоны нэрлэснээр "Луврын товчлол" маршрутыг сонгодог бөгөөд, энэ нь музейн хамгийн алдартай 3 бүтээл болох Мона Лизагийн хөрөг, Хайрын Бурхан (Venus de Milo), Ялгуусан ялалт буюу Никаб (Winged Victory) - г үзээд аяллаа дуусгана гэсэн үг. Бушвальд хэмээх алдартан дээрх 3 бүтээлийг үзэхийн тулд, 5 минут 56 секунд зарцуулсан гэж сайрхсан удаатай.

Дэслэгч халааснаасаа станц гарган, Францаар дуржигнуулав. "Мүсьюү Ландон эт агивэ" (Ноён Ландон ирлээ).

Үл ойлгогдох хариу цаанаас ирж, яриа дууссан бололтой, удалгүй станцаа унтраалаа. Дэслэгч тэрдаруй Ландон руу эргэж хараад,

"Ахмад тантай музейн гол хаалган дээр уулзана гэж байна" гэж дэслэгч хэллээ.

Луврын музейн гол хаалга удалгүй Ландонд харагдав. Пирамид - хаалга.

Луврын музейн шинэчлэгдсэн үүд нь пирамид хэлбэртэй бөгөөд, өнөө үед музей ш игээ алдартай болоод байгаа юм. Хятад гаралтай, уран барималч И.М.Пейгийн санаачилсан шилэн пирамид боссон даруйдаа, үндсэрхэг үзэлтнүүдийн жигшил зэвүүцлийн бай болсоор иржээ. Нэгэнтээ Гётеэнэхүү пирамидыг "Царцсан аялгуу" хэмээн тодорхойлсон бол, бусад шүүмжлэгчид "Самбар дээрнаалдсан хумсны хэлтэрхий" гэж хүртэл хэлж байжээ. Харин Пейгийн бүтээлийг сайшаагчид энэхүү шилэн пирамидыг эрт, эдүгээгийн хосгүй зохиилын бэлгэдэл төдийгүй, Луврын музейн ирээдүйг шинэ тавцанд гаргасан бүтээл хэмээн өндрөөр үнэлдэг.

"Танд манай пирамид таалагддаг уу?" гэж Дэслэгч Ландоноос асуухад, тэрээр хөмсгөө зангидан бодолхийлнэ.

Францчуудын Америк хүнээс асуух дуртай зүйлийн нэг.

Энэ бол ёгт утгатай асуулт гэдгийг Ландон мэднэ. Хэрэв таалагддаг гэж хариулбал урлагийн мэдрэмжгүйд тооцогдож, харин таалагддаггүй гэвэл Францчуудыг доромжилсон хэрэг болно гэж бодоод, Ландон зориуд сэдвийг гуйвуулж,

"Ерөнхийлөгч Миттеранд ч зоримог, шулуухан хүн байсан даа" гэж хариулав.

Францын ерөнхийлөгч асан Миттерандыг засгийн эрхэнд байхад нь, түүнийг "Фараоны цогцолбор" - г бариулах гэж байна хэмээн олон нийтээрээ шүүмжилж байсан юм. Франсуа Миттеранд Эгиптийн соёлыг бишрэн хүндэлдэг нэгэн байж.

"Танай ахмадыг хэн гэдэг юм бэ?" гэж Ландоныг асуухад,

"Бээү Фааш. Бид нар түүнийг Тауру (Taureau) гэж дууддаг юм" гэж хариулав.

Ландон гайхаж, Франц хүн бүр амьтны нэрээр хочлогддог эсэхийг сонирхон,

"Тэгээд та нар түүнийг Бух гэж хочилдог юм биз дээ?" гэж лавлавал, дэслэгч илтэд гайхан,

"Та ч франц хэлийг сайн мэддэг бололтой, ноён Ландон" гэв.

Миний Франц хэлний мэдлэгт биш, харин зурхайн тэмдэгт судлалд байгаа юм. Taurus гэдэг үг альч хэлэнд Бүх гэж орчуулагддаг. Зурхай судлалын нэршил, ойлголтууд өөрчлөгдөж байсан удаагүйгэж Ландон дотроо бодлоо.

Гол хаалганы өмнө машинаа зогсоосны дараа, дэслэгч түүн рүү эргэж,

"Бид хүрээд ирлээ. Танд амжилт хүсье, эрхэм ээ!" гэхэд Ландон хариуд нь, "Та өөрөө хамт явна биздээ?"

"Би таныг үүдэнд буулгах үүрэгтэй. Өөр ажилтай байгаа л даа"

Ландон санаа алдаад, машинаас буув. Түүнийг буунгуут машин асч, хурдаа авсаар холдон одов.Ландон машины арын гэрлийг харсаар хоцрохдоо, Эндээс хурдхан холдож, такси бариад,буудалдаа очиж амрах юмсан гэж бодож амжив.

Гэвч энэ бол гэнэхэн бодол байлаа.

Тэрээр үүдний өмнөх усан оргилуураас гарсан манан дунд орчихоод, өөрийгөө эгээ л харьертөнцөд байгаа юм шиг төсөөлөв.

Дөнгөж 20 минутын өмнө, буудлын өрөөнд тав тухтай нойрсч , байсан бол, одоо Энд Бух хочитцагдаагийн ахмадын тушаалаар шилэн пирамидын өмнө зогсч байх ч гэж дээ.

Ландон үүд рүү дөхөнгөө, танхим доторхыг ажиглавал бүдэг гэрэл туссан байх ба, тэнд нэг ч хүнхарагдсангүй.

Тогших хэрэг гарах нь ээ?

Түүнийг шилэн хаалгыг тогшиж эхлэнгүүт, нэг хүн шатаар өгсөн наашилсаар гарч ирэв. Мөнөөххүн лагс чийрэг биетэй, эртний хүн - Неандерталь төрхтэй бөгөөд, бараан өнгийн хослолоор өргөнмөрөө халхаджээ. Тэр хүн гар утсаар ярьж байснаа, үүдэнд ирэхдээ яриагаа дуусгаад, "Ор!" хэмээнЛандоныг гараараа дохив.

"Намайг Бээү Фааш гэдэг" гэж Ландоныг хаалга түлхэн орох зуур, ахмад хэлээд "Шүүх цагдаагийнгазрын ахмад" гэж өөрийгөө товчхон танилцуулав.

Түүний дуу хоолой удахгүй эрчлэн хуйлрах гэж байгаа их шуурганы нүргээн шиг сүртэй дуулдана.Хариуд нь, "Роберт Ландон" гээд, гарыг нь атгахад, Фаашийн гар түүнийхийг бүрхээд авах шигболов. Ландон,

"Дэслэгч надад гэрэл зургийг үзүүлсэн. Тэр хэлэхдээ, Сониех өөрөө энэ бүхнийг хийсэн гэх юм"хэмээхэд ахмадын харц түүн дээр тогтож, "Ноён Ландон! Таны харсан зүйл бол зөвхөн эхлэл нь"гэж нухацтай өгүүлэв.

Мона Лиза

Луврын Пирамид хаалга

Ника ялгуусан ялалт (Winged Victory)

Хайрын бурхан (Venus de Milo)

Хэсэг 4

Ахмадын биеэ авч яваа байдал ороо нь орсон бух мэт аж. Тэрээр өргөн мөрөө хойш хаяж, хүчирхэгтөм эрүүгээ цээжиндээ бараг наах шахан явна. Өтгөн хар үсээ толийтол нь тосолж хойш самнаад,

өндөр ёнхор хамар нь бараг нийлэх шахсан хоёр хөмсгийг заагласан нь усан онгоцны хошуугсанагдуулна. Түүний нүд тэнгэр ниргэсэн ч ажрахааргүй мэт урдах замаа цоо ширтэх нь гайхмаар.

Тэр хоёрыг танхимаар явж байхад нь автомат буутай хоёр харуул зөрж өнгөрөв Энэ шөнөдөөахмадын зөвшөөрөлгүйгээр энд хэн ч нэвтрэхгүй, нэвгэрсэн бол гарахгүй гэдэг нь ойлгомжтойбайв.

Газар доорх хасах давхар луу буухдаа, Ландон сэтгэл хөдлөлөө дарж ядан байв. Хэдийгээрахмадын байр байдал түүнд сөрөг сэтгэгдэл төрүүлээгүй ч, музей доторх уур амьсгал түүнийгжихүүцүүлнэ. Ландон шатаар доош буунгаа, чанх дээш харвал пирамидын орой дахь шилний гаднатал усан оргилуурын ууранд цохиулж, хөлөрсөн байв.

"Танд таалагддаг уу?" хэмээн Фааш шилэн пирамид руу эрүүгээр заан асуухад, Ландон тоглоомшоглоомны энэ асуултаас залхахдаа,

"Тиймээ. Танай пирамид хосгүй" гэж хариулав. Фааш хариуд нь жигшсэн дуугаар,

"Парисын нүүрэн дээрх сорви" гэж түс тас хэлэв.

Эхний дайралтаа ийнхүү хийсэн нь ахмад бол "хатуу самар" гэсэн дохио болов.

Доод давхарт бууж ирэхэд, танхимын эргэн тойрон сүүдрээс чөлөөлөгдөн ил харагдаж эхлэв.

Газрын төвшнөөс доош 57 фут ухаж доод хонгилыг байгуулснаар, Луврын музей 70 мянган хавтгайдөрвөлжин талбай бүхий том агуй мэт болсон юм.

Өнөө шөнө энд хүнгүй бас харанхуй бодоод ч тэрүү, хүйтэн хөндий байдалтай харагдана.

"Музейн хамгаалалтын алба хаана байгаа юм бэ?"

"Одоогоор хорио тогтоочоод байгаа. Эндхийн хамгаалалтынхан өнөө шөнөдөө Сулли жигүүртшилжсэн. Манай хүмүүс энд байдлыг хяналтдаа авсан" гэхэд, Ландон толгой дохингоо, Фаашийнараас мөр даран алхана.

"Та Сониехтой хэр дотно байсан бэ? "

"Үнэндээ би түүнийг сайн мэдэхгүй ээ. Бид өмнө нь уулзаж байгаагүй л дээ".

Фааш гайхаж, "Та хоёр өнөөдөр анх удаагаа уулзах байжээ?"

"Тиймээ. Намайг энд Америкийн Их сургууль дээр лекц уншсаны дараа, бид уулзах ёстой байсан юм. Гэвч тэр ирээгүй". Фааш түүний хэлснийг тэмдэглэлийн дэвтэртээ сараачаад, цааш алхав.

Луврын музейн олонд бага танигдсан, нэгэн бүтээлийг Ландон явдал дундаа олж харав. Энэ болурвуулж бүтээсэн пирамид бөгөөд, таазнаас зүүгдсэн байдал нь дээврийн үзүүрт тогтсон мөс мэтхарагдана.

Фааш Ландонд замчилж, нэгэн хонгил руу эргэсэн нь, Аенон жигүүр байв. Аенон жигүүр болЛуврын музейн онцлох газрын нэг билээ.

"Өнөө шөнийн уулзалтыг хэн нь анх товлосон бэ? Та юу эсвэл, тэр ҮҮ?"

Ландонд асуулт хачирхалтай санагдав. Гэвч тэрээр, "Ноён Сониех товлосон" гээд, "Түүний нарийнбичиг хэдэн 7 хоногийн өмнө надтай мэйлээр харилцсан юм. Нарийн бичиг нь надад хэлэхдээ,

Сониех эрхлэгч намайг Парист ирэхийг дуулаад, зарим нэг зүйлийн тухай ярилцмаар байна гэж байсан".

"Юун тухай?"

"Би мэдэхгүй ээ. Урлагийн талаар л юм болов уу. Бид зөвхөн урлагаар л холбогдох хүмүүс шүүдээ".

Фааш сэжиглэсэн байдалтай, "Та тэгээд юун тухай ярилцахаа мэдэхгүйгээр уулзахаар тохирсон юм биз дээ?"

Ландон анх тохирохдоо, юун талаар ярилцахаа, нарийн асууж төвдөөгүй юм. Учир нь Жак Сониехбол тэр бүр уулзалт товлоод байдаггүй, нууцлагдмал амьдралтай боловч, нэр хүндтэй хүн байсан. Түүнтэй учрах нь Ландонд дахин олдохгүй ховор боломж учир, түүний саналыг шууд зөвшөөрсөнхэрэг.

"Ноён Ландон! Үхдэл болохынхоо өмнө, Сониех тантай юун тухай ярилцах гэж байсныг та ядажтаамаглахгүй байна уу? Таны хариулт бидэнд маш хэрэгтэй байна".

Асуултын цаана цухалзаж буй санаа Ландоныг эвгүйтүүлж орхив.

"Би төсөөлж ч чадахгүй байна. Юун тухай ярилцахыг би асуугаагүй. Зөвхөн түүнтэй уулзахболсондоо л баярлаж байсан юмсан. Ноён Сониехын бүтээлийг шимтэгчийн хувьд, би хичээлзаахдаа түүний судалгаанаас жишээ татдаг байсан нь үнэн" гэв.

Фааш үүнийг хэлсэн даруйд нь тэмдэглэн авав.

"Тэгэхээр та хоёрын судалдаг чиглэл ижил юм биз дээ?"

"Яг тийм. Би жилийн өмнөөс Сониехийн судалдаг сэдэвтэй холбоотой судалгааны ном бичижбайгаа. Түүний тархинаас будаа идэх мөчийг тэсэн ядан хүлээж байсан юм".

Фааш зогтусч,

"Уучлаарай, та юу гэж хэлсэн бэ?" гэхэд, хэлц үг буруугаар ойлгогдсоныг гадарласан Ландон,

"Би түүний санааг өөрийнхөө номонд оруулахыг тэсэн ядан хүлээж байсан юм" гэж өмнөх үгээзалруулав.

"Аан. За за! Ямар санаа оруулах гэж тэр билээ?"

Ландон түр эргэлзээд, "Үндсэндээ миний бүтээл бол дарь эх бүрхны шүтээний бэлгэдэл бодоод, түүнтэй холбоотой урлагийн чиглэлээр бичигдсэн".

Фааш махлаг том гараараа үсээ хойш илж, "Сониех ийм чиглэлийг бас судалдаг хэрэг үү?"

"Энэ чиглэлээр түүн шиг нарийн судалсан хүнийг өөр хаанаас ч эрээд олохгүй".

"Тийм байх нь ээ!" Гэвч үнэндээ Фааш бүрэн ойлгоогүй бодолтой байв.

Жак Сониех 20 гаруй жил музейн эрхлэгчээр ажиллахдаа, өөрийн судалгааны чиглэлийн

түүхэнолдворуудыг Луврын музейн өвд авч, хадгалж чадсан гавьяатай хүн.

"Магадгүй Сониех таны бичиж буй номын агуулгыг мэдчихээд, тантай уулзаж, санал зөвлөгөө өгөхгэсэн юм болов уу?"

Ландон толгой сэгсэрч, "Миний номын эхийг хэн ч уншаагүй байгаа. Оаоо хүртэл засварлажбайгаа болохоор номын хянагчаас өөр хүн энэ тухай мэдэхгүй".

Фааш дуугаа хураачхав.

Ландон номынхоо эхийг бусдад үзүүлээгүй шалтгаанаа ахмадад хэлсэнгүй. Учир нь түүний бичижбуй "Мартагдсан шүтээний бэлгэдэл" нэртэй номонд олон нийтийн ойлголтыг орвонгоор эргүүлэхолон тайлбар, нотолгоог оруулсан тул, жинхэнэ шуугиан тарих сэдэв болох ёстой байлаа.

Ландоныг эргээд хартал, ахмад аль хэдийнээ түүнээс холдчихоод, цахилгаан шатанд хүлээгээдзогсч байв.

"Үүгээр явья. Тэгэхгүй бол музейд явган алхах танд хэцүү байгаа байх" гэлээ. Хэдийгээр ахмадынхэлдэг ортой ч, Ландон зогсч буй газраасаа огтхон ч хөдөлсөнгүй.

"Юу болов, та?" гэж асуухдаа ахмад тэвчээр алдарсан байдалтай харагдана. Ландоны царайцонхийсон чигтээ, "Зүгээр, зүгээр" гэж худал хэлээд цахилгаан шатанд оров.

Бага байхдаа тэрээр уурхайн дутуу ухсан, устай цооногт унаад живж үхэхийн даваан дээр, амьгарсан билээ. Урьдын бараан дурсамж, түүнд одоо ч тод санагддаг болохоор, давчуу зайтай газартэр тусмаа, цахилгаан шат, метро, хүн шахцалдсан газарт байж чаддаггүй юм. Хэдийгээр цахилгааншат найдвартай боловч, давчуу зайд дээш доош холжих дөрвөлжин хайрцаг мэт Ландонд бодогддогбайв.

Цахилгаан шатаар доод давхарт хүрэхэд, лавтай 10 секунд зарцуулах байх даа!

"Сониех, та хоёр хоорондоо нэг ч удаа нүүр тулаагүй, яриагүй бас захиа, зурвас солилцоогүй юмбиз дээ?"

"Үгүй ээ. Нэг ч удаа үзээгүй".

цахилгаан шат хөдлөхөд, Ландон 4 хананы дунд байгаагаа мэдрэхгүйг хичээх зуур, хаалганы толингадаргууд туссан, ахмадын зангианы хавчаарын дүрс түүнд харагдав.

Бас л загалмай хэлбэртэй, дээрээ хар чулуун шигтгээтэй эд байв.

Францын цагдаа өөрийн шүтлэгийг ийм нээлттэй илэрхийлж байгаа нь, Ландонд хачирхалтайсанагдана.

"Энэ бол загалмай - шүтээн" гэж Фаашийг огцом хэлэхэд, Ландон цочиж, хаалган дээр туссанахмадын харц өөр дээр нь тогтсоныг олж харав.

Цахилгаан шат үл мэдэг чичрэн зогсож, хаалга нээгдлээ. Ландон тэндээс түргэн гэгч гараад, уужиморон зай бүхий Луврын галерейг бахдан харав. Түүний одоо гишгэж буй газар нь түүнд ийм ихтаашаал авчирна чинээ санаагүй явжээ. Ахмад Фааш,

"Ноён Ландон! Та дөнгөж саяхан энд ирсэн юм шиг харагдаад байх юм" гэхэд,

"Үгүй байлгүй дээ" гээд Ландон хэвийн төрхөндөө эргэж орохоор шамдав.

Луврын галерейн гял цал байдал энэ мөчид алга болж, дагжин чичрэм харанхуйд

нөмрөгджээ.Ердийн үед тусдаг байсан өдрийн гэрлийн оронд, ослын үед асдаг бүдэг улаан гэрлүүд ёлтойж,өнгө төрхийг нь улам ч өөр болгожээ.

"Ийшээ!" гэж ахмад хэлээд, баруун тийш огцом эргэн, сүлжилдсэн олон танхимыг чиглэн алхав.

Ландоны нүд харанхуйд аяндаа дасч, зарим нэг зүйлийг ялгахтай болов. Нэлээд өндөртбайрлуулсан хяналтын том камерууд "Битгий хүр! Ажиглаж байгаа!" гэж анхааруулж байх шиг санагдана.

"Эд нар бүгд ажилладаг уу?" гэж Ландон камерийн зүг дохиж асуухад ахмад,

"Мэдээж үгүй" гэв.

Ландон гайхсангүй. Хяналтын камерийг Луврын музейд ажиллуулна гэдэг бол ур ашиггүй, инээдтэй явдал болно. Олон акр талбайг камераар хянах гэвэл хэдэн зуун техникийн ажилчид хэрэгтэй. Харин одоо бол ихэнх том музейд "Түгжих" системийг нэвтрүүлсэн.

Хулгайчийг музейд түгжих арга. Өөрөөр хэлбэл хулгайч үзмэрийг авлаа ч гэсэн, түүнийг гарахаас өмнө дохиолол ажиллаж, бүх хаалга үүд түгжигдэнэ гэсэн үг. Хулгайч танхимд түгжигдэж, цагдааирж гавлахыг хүлээхээс өөр арга үлдэхгүй.

Хурц гэрэл үзэгдэж, хүмүүс хоорондоо ярилцах нь сонсогдоход,

"Энэ бол музейн эрхлэгчийн өрөө" гэж ахмад танилцуулав.

Тэр хоёрыг өрөөнд ороход цагдаагийн ажилтнууд дотор нь хөлхөлдөх бөгөөд зарим нь утсаар ярьж, зарим нь хэлснийг тэмдэглэж авна. Эрхлэгчийн өрөөний хананд Их мастеруудын зургууд өлгөөстэй, эртний хийцтэй өргөн модон ширээний дэргэд 2 футын өндөртэй, хуяг дуулга, өвчбүрэн тоноглолтой хөлөг баатрын өмсгөл тавиастай байв.

Тэнд цагдаагийн түр хороо байгуулчихсан юм шиг л бужигнаж байв.

"Мэсьюү!":э гэж ахмадыг хэлэхэд бүгд эргэж харав. "Нө но дэхонжи па сус өкүн претекстэ. Онтондү?" гэж ахмадыг хэлэхэд, цагдаа нар бүгд ойлгосноо мэдэгдэж, толгой дохив.

Ландон буудлын өрөөний хаалган дээр зүүлттэй байдаг пайзан дээр "Нө па дэхонжи!" гэсэн үгсбайдгийг санаад, ахмадын хэлсэн үгийн утгыг битүүхэндээ гадарлав.

Тэр хоёрт хэн ч саад хийх ёсгүй гэж ахмад тушаажээ.

Өрөөг орхин гарч, тэд цааш харанхуй танхим руу зүглэв. 30 ярд хэртэй газар яваад, Их галерейдорж ирснээ, Ландон ойлгов. Учир нь эрхлэгч Сониехийн цогцос Их Галерейн зүймэл модон шаландээр хэвтэж байсныг, гэрэл зургаас Ландон олж харсан билээ.

Тэдний өмнө галерейн танхимыг халхалж, доош буусан төмөр торнууд ярайх нь, эгээ л дундадзууны цайз хэрмийн хамгаалалт адил сүртэй харагдана.

"Түгжих систем" гэж ахмад дэргэд нь ирсэн хойноо түүнд тайлбарлав. Ландон торны завсраар Ихгалерейн танхим доторхыг ажиглана.

"Таны араас, ноён Ландон!" гэж Фаашийг хэлэхэд Ландон гайхаж,

"Миний араас хаашаа гэж?" хэмээн асуув.

Фааш доош заахад, төмөр тор шалнаас 2 фут хэртэй дээш өргөгдсөнийг, сая л олж анзаарлаа.

"Манайхан танхим доторхыг бүрэн шалгаад дууссан. Та энэ доогуур шургаад дотогшоо орчих" гэв.

Ландон өргөгдсөн зай хүнд төмөр тор хоёр луу ээлжлэн харснаа,

"Та унэнээсээ хэлж байна уу? Энэ чинь надад цаазын тавцантай адил санагдаад байх юм" гэв.

Фааш амандаа нэг зүйл бувтнан, цаг руугаа хяламхийснээ, доош бөхийж нарийхан завсраар хүндбиеэ шургуулав. Ахмад хормын дотор цаана нь гараад, Ландон руу эргэж харвал, тэрээр альхэдийнэ алгаа шалан дээр тавьчихсан элгээрээ доош харан гулгаж байв. Түүний зузаан ноосонцамцны урт зах нь төмөр торны үзүүрт тээглэхэд, Ландон сандарсандаа дээш болох гээд толгойгоохүчтэй цохичхов. Ландон яст мэлхийн хурдаар мөлхсөөр, торон доороос өөри йгөө алгуур татангаргалаа.

Тэр босч биеэ цэхлэн зогсохдоо, өнөө шөнө хувьд нэлээд урт болно гэдгийг зөнгөөрөө мэдэрлээ.

Урвуулсан Пирамид

Их Галерейн зүймэл модон шал

Хэсэг 5

Муррей Хилл бол Опус Дейн шинээр баригдсан удирдлагын төв бөгөөд, Нью - ЙоркийнЛексинтоны 243 - р өргөн чөлөөнд оршдог. 47 сая долларын өртгөөр боссон, 133 мянган фут хавтгай

дөрвөлжин талбай бүхий энэ барилгыг улаан тоосгоор барьж, Индиана мужийн шохойн чулуугаар өнгөлсөн аж.

100 гаруй унтлагын өрөө, 6 том гал тогоо, номын сан, зочны өрөө. уулзалтын танхим, албаны өрөө зэргийг өөртөө багтаасан, энэ барилгын зураг төслийг Мей, Пинска нар боловсруулсан юм. 2, 8, 16-р давхрыг бунханд зориулж, харин 17-р Давхарт дотуур байр төлөвлөжээ. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн аль аль нь барилгад тусдаа үүдээр нэвтрэх ба дотуураа ч мөн адил бүрмөсөнтусгаарлагдахаар анхнаас нь зохиожээ.

Хамба лам Мануэль Арингароза өглөө эртлэн босч, аяны цүнхээ баглаад, кассокоо (Санваартны өмсгөл) өмсөн, аялалд гарахад бэлэн болжээ. Ердийн үед бүсэлдэг бүсээ энэ удаад бүслээгүй нь, өөрийн өндөр хэргэм цолыг бусдад харуулахыг хүсээгүйгээс тэр аж.

Зөвхөн сайтар ажсан хүнд 14 каратын алмазан шигтгээтэй, алтан бөгж нь түүнийг хэн бэ гэдгийг хэлээд өгөхөөр байв. Тэрээр аман дотроо залбирал үйлдээд өрөөнөөс гарч, нисэх онгоцны буудалруу явахаар, машиндаа суув.

Онгоц нэгэнт хөөрч хамба лам Арингароза Ром тийш хүлгийн жолоо залаад, цонхоор харагдах Атлантын далайг ширтэн сууж байлаа. Нар хэдийнээ жаргасан авч, түүний хувьд ажил, амжилтын наран мандаж байгааг хамба сайн мэднэ.

Өнөөдөр болох цусгүй тулаанд тэр ялах болно.

Гэвч урьд нь түүний өрсөлдөгчид Арингарозаг бүтээн босгосон ертөнцтэй нь цуг доош унагах шахсан юм.

Өнгөрсөн 10 жилийн хугацаанд Мануэль Арингароза Опус Дейн тэргүүнээр ажиллахдаа, "Бурхны үйл хэрэг" нэрийн дор олон нийтэд байгууллагаа таниулж чадсан. Энэхүү үйл хэргийг анх Испанийн ламтан Хосеммариа Эскрива эхлүүлж байсан удаатай. Түүний бичсэн "Замнал" сургаал номлол 42 хэлнээ хэвлэгдэж, дэлхийн өнцөг булан бүрт хүчтэй нөлөөллийг үзүүлж байжээ.

Гэвч өнөөдрийн хувьд Опус Дейг ичгүүр сонжуургүй явдал, нууц бүлэглэлийн үйл ажиллагаатай холбоотой хэмээн олон нийт сөргөөр хүлээж авах болсон юм.

"Олон хүн Опус Дейг "тархи угаадаг" газар гэх юм. Харин үлдсэн хэсэг нь Христийн хэт үндсэрхэг нууц бүлэглэл гэдэг. Та Үүнийг юу гэж тайлбарлах вэ?" хэмээн сэтгүүлчдийг асуухад,

"Дээрхийн аль нь ч биш" гэж хамба тайвнаар хариулах бөгөөд, "Опус Дей бол Католик шашны Сүмхийд. Манай шүтлэгтнүүд Католикийн сургаал, номлолыг өдөр тутмын амьдралдаа хатуу чанд мөрддөг".

"Бурхны үйл хэрэг" гэдэг нэр томъёонд цэвэр, ариун байдлаа хадгалах, нүглээ наманчлахын тулд өөрийгөө тарчлаах зэрэг ойлголтууд багтах уу?"

"Та бүхэн Опус Дейг өрөөсгөл талаас нь дүгнээд байна. Хүмүүс шашныг маш одон хэлбэрээр шүтдэг. Опус Дейн мянга, мянган гишүүд гэрлэж, үр хүүхэдтэй болж, Бурхны үйл хэргийг хэрэгжүүлдэг. Үлдсэн хэсэг нь бясалгал, даяаны амьдралыг сонгож, Сүм хийдэд шавилан суудаг. Хэдийгээр шүтлэгийн дээрх хэлбэрууд нь хоорондоо ялгаатай боловч, эцэстээ

бүгд л "Бурхны үйлхэргийн" төлөө энэ бүхнийг хийж байгаа шүү дээ".

Одоогоос 2 сарын өмнө, Опус Дейд харьяалагддаг их сургуулийнхан шинээр элссэн оюутнуудаахар тамхиар тарьж, албадан итгүүлэх арга хэрэглэх гэж оролдсон нь илэрсэн юм. Бас нэгэн оюутанөргөст бүсийг хугацаанаасаа хэтрүүлэн зүүж, үхлийн шарх олсон аж. Мөн саяхан Бостон хотын

итгэл алдарсан, нэгэн банкир гэрээслэлдээ өөрийн хуримтлуулсан их хэмжээний хадгаламжийг Опус Дейн нэр дээр шилжүүлээд, амиа егүүтгэсэн байжээ.

"Буруу ишилсэн сүх" хэмээн Дрингароза дээрх хүмүүсийг буруутгана.

Энэ бүх явдлын дараа "Опус Дейг хянах сүлжээ" нэртэй сонирхлын бүлэг үүсч, түүний вэб хаягийг www.odan.org гэж нэрлэжээ. Энэхүү вэб хуудсанд Опус Дейтэй холбоотой аймшигт түүхийг хуучин гишүүн байсан хүмүүс нэгд нэгэнгүй дэлгэн тавьж, Опус Дей хэмээх байгууллагад элсэж болохгүйг анхааруулсан байх жишээтэй.

Вэб хуудсанд Опус Дейг "Бурхны мафи", эсвэл "Христийн нууц бүлэглэл" гэж нэрлэжээ.

Үнэндээ бол энэ байгууллага Ромын Пап ламын ивээл дор үйл ажиллагаагаа явуулдаг юм. Хамбалам Арингарозад хэвлэл мэдээллийнхнээс илүүтэй, санааг нь өөр зүйл зовоож байгаа юм.

5 сарын өмнө түүний эсрэг боссон, дийлэгдэшгүй хүч Арингарозаг суудлаас ховх татан буулгах шахсан ажээ. "Ямар тулааныг эхлүүлснээ та нар даанч төсөөлөхгүй байна" гэж Арингароза хөмхийгөө зуун хэлээд, онгоцны цонхонд тусах өөрийн дүрийг анхааралтай ажиглав.

Бараан царай, гонзгой нүүртэй хамба ламын тусгал. Түүний муруй хамар нь залуудаа Испанид номлогч байх үеийн хар дурсамж байлаа. Гэвч одоо түүний гадаад төрх тийм ч чухал бус, тэрнэгэнт хүчирхэг удирдагч болжээ.

Онгоц Португалийн эргээр нисэн өнгөрөхөд, түүний гар утас чичрэх нь дуудлага ирснийг гэрчилнэ. Дүрэм журмаар бол, нислэгийн үед гар утсаар ярихыг хориглодог ч, хамба лам энэ удаагийн дуудлагад заавал хариу өгөх ёстой. Түүний утасны дугаарыг энэ утсыг түүн рүү илгээсэн хүнээсөөр хүн мэдэхгүй.

Хамба намуухан боловч, илт догдолсон дуугаар, "Байна уу?" гэж хариулав.

"Силас Онъсон чулууны байгаа газрыг олсон. Парисын Дарь Эхийн Сүмд гэнэ".

Хамба хариуд нь сэтгэл хангалуунаар инээмсэглэж, "Тэгвэл ч бид тун ойртож байгаа юм шив".

Тэхдээ эхлээд, Онъсон чулууг гартаа оруулахын тулд, таны туслалцаа хэрэгтэй байна".

"За. Яаж туслах вэ?"

Арингароза гар утсаа унтраачхаад, зүрхнийхээ хүчтэй цохихыг хэсэгтээ чагнан суув.

Тэндээс 500 милийн зайд Силас умгар өрөөндөө шархаа төмпөнтэй усандугааж байв. Нуруунаас ньурсах цус төмпөнтэй устай холилдоод, Улаан хоормог шиг юм болжээ.

"Бие сэтгэл минь ариусч, цаснаас цагаан болно" хэмээн аман дотроо тэрээр шившинэ.

2000 жилийн турш, Христийг хамгаалагч дайчид унэн мөний төлөө эцсээ хүртэл тэмцсээр ирсэн. Энэ орой Силасын ээлж иржээ.

Шархаа хатаасны дараа, өмсгөлөө өмсч, юүдэнг нь толгойдоо углав. Түүний өмсгөл хар бараанөнгөтэй учир, альбино Силас эгээ л цочмоор төрхтэй эрлэгийн элч шиг харагдана. өргөст бүсээчангалж, толинд хараад өөрийн гаднах төрхдөө сэтгэл хангалуун байх аж.

Бүх зүйл ном ёсоороо ...

Хэсэг 6

Ландон Их Галерейн танхимд зогсож байлаа.

Эртний язгууртнуудын царай төрхийг дүрсэлсэн Да Винчи, Тициан, Караважио нарын алдартбүтээлүүд танхимын хананд өлгөөтэй. Хэдийгээр Их галерейд тавигдсан уран зургууд зочдыннүдэнд тусдаг ч, танхимын зүймэл модон шалны ур хийцийг гайхан шагшдаггүй хүн ховор билээ.Геометрийн төгс шийдэл бүхий царс модон шалан дээр явж буй, хэн бүхэнд Их галерейд хөвж явааюм шиг сэтгэгдэл эрхгүй төрнө.

Ландон зургуудыг гүйлгэн харж явтал, түүний зүүн талд нэг зүйл хэвтэж байх нь тэр. Ландонахмад руу эргэж,

"Энэ чинь Караважио мөн үү?"

Фааш тэр зүг хараагүй чигтээ толгой дохив.

Дор хаяж 2 сая доллараар үнэлэгдэх энэ зураг хэнд ч хэрэггүй зурагт хуудас шиг хөсөр хэвтэх ньхачирхалтай. "Яагаад шалан дээр уначихдаг байнаа?" гэхэд Фааш хөмсөг зангидан,

"Энэ бол гэмт хэргийн дүр зураг, ноён Ландон. Бид юуг ч өөрчлөөгүй. Эрхлэгч энэ зургийгхананаас салгаж унагасан бололтой. Ингэж л хамгаалалтын торнууд гарц хааж доош буусан ньтэр".

Ландон юу болсныг дотроо төсөөлөн бодохыг оролдов.

"Эрхлэгч алуурчнаас зугтаан өрөөнөөсөө гарч, Их галерейн танхимд орж ирсэн байна. Тэгээдзургийг унагааж, хамгаалалтын системийг ажиллуулжээ. Торнууд тэр дороо доош бууж, гарцыгхаасан байна" гээд Фааш төмөр тор луу заан хэлэв. "Шинжээчийн баг үүнийг нотолсон. Алуурчинтанхимын гаднаас төмөр торны завсраар эрхлэгчийг буудаж шархдуулаад явсан хойгуур, Сониехганцаараа энд тарчилж үхжээ",

Ландон гэрэл зураг дээрхийг санахыг хичээн,

"тэгээд түүний цогцос хаана байгаа юм бэ?" гэж асуухад Фааш зангианыхаа хавчаарыг нямбайлантэгшлээд, "Их галерей маш уужим гэдгийг та өөрөө мэднэ байх" гээд цааш эргэн алхлаа.

Хэрэв Ландоны санаж байгаа зөв бол, Их Галерейн танхим уртаараа 1500 фут буюу өөрөөр хэлбэл,Вашингтоны дурсгалын хөшөөний өндрөөс 3 дахин урт байдаг.

Фааш зүүн талаа барьж, урагш амьсгал даран түрүүлж алхана. Ландон сор болсон бүтээлүүдийндэргэдүүр хайхрамжгүй яваа, түүнд дургүйцэнгээ нүд гүйлгэн харсаар араас нь дагана. Цааш алхахтусам Ландон гайхширна. Ямар ч цогцос үзэгдсэнгүй.

"Жак Сониех ийм хол явсан гэж үү?"

"Ноён Сониех хэвлийдээ шархадсаны дараа удаан шаналсан. 15 - 20 минут амьд байсан байх. Тэрүнэхээр тэвчээртэй хүн байжээ". "Хамгаалалтынхан тэгээд ийшээ бүтэн 15 минутын дараа ирсэнхэрэг үү?"

"Үгүй дээ. Хамгаалалтын албаныхан дохиолол дуугарангуут очсон бодовч төмөр хаалт

нэгэнтбуучихсан байснаас дотогш нэвтэрч чадаагүй юм. Хаалтын цаана хүн хөдөлж байхыг сонссон

боловч харанхуйд хэн гэдгийг нь таньж чадаагүй гэсэн. Тэд хашхирсан авч, хариу сонсоогүй гэнэ. Тэгээд түүнийг гэмт этгээд гэж таамаглаад биднийг дуудсан нь энэ". .

"Тэгээд яасан бэ?"

"Бид түүнээс өөр хэнийг ч дотроос одоогүй" гээд хуруугаараа заахад, тэр зүг харвал гэрэл тусгасанхэсэг газар үзэгдлээ. Шавьж лугаа нэгэн цогцос музейн шалан дээр хөдөлгөөнгүй тэрийн хэвтэнэ. Гэрэл зургийг танд үзүүлсэн болохоор цочирдохгүй байх гэж найдаж байна".

Гэвч Ландон урьд хожид ийм зүйлтэй учирч байгаагүй билээ.

Жак Сониехийн амьгүй болсон биеийг Ландон хурц гэрэлд сайтар тогтож харлаа. Эрхлэгч өвгөнбүх хувцсаа тайчиж, нуруугаараа харан хэвтсэн байлаа. Тэрээр 4 мөчөө тэлсэн байдалтай хэвтэх нь, нисэх гэж байгаа бүргэд мэт харагдана. Түүний хэвлийн тус газарт нь сүм нэвтэрсэн цусан толбоүзэгдэх бөгөөд халыг харвал, үзэгдэхэд бэрхтэй жижиг шарх олсон байлаа.

Сониех шархнаасаа урсах цусаар бэх хийж, цээжин дээрээ дүрс зурсан нь түүний цус болсондолоовор хуруунаас илэрхий байв. Түүний цээжиндээ дүрсэлсэн дүрс бол огтлолцсон 5 шулуунбуюу Таван хошуу байлаа.

Таван хошуу!

Цогцосон дээр зурагдсан дүрс хийгээд, Сониехийн үхсэн байдал зэрэг нь нийлээд жихүүцэм дүрзургийг харуулна. Эрхлэгч өвгөн өөртөө ийм зүйл хийсэн гэхэд үнэхээр итгэхэд бэрхтэй аж.

"Эрхэм Ландон, та үүнийг юу гэж хэлэх вэ? гэж асуухдаа, Фааш Ландоныг нүд салгалгүй ширтэнэ.

"Таван хошуу. Энэ бол хамгийн эртний дүрсүүдийн нэг. Христийн тооллоос 4 мянган жилийн өмнөөүссэн".

"Энэ дүрс тэгээд ямар учиртай юм бэ?"

Ландон иймэрхүү асуултаас үргэлж зайлсхийдэг билээ. Учир нь энэ дуу хэрхэн таалагдав гэжасуухад хүн бүр өөр өөр хариу хэлдэгтэй яг адил. Жишээ нь, том юүдэн / малгай/ Америкт арьсөнгөөр ялгаварлах үзлийг илтгэж байхад, Испанид түүнийг үнэнч шүтлэг бишрэлийн бэлгэдэлболгосон байдаг.

"Дүрс тэмдэгүүд маш олон утгыг давхар илтгэж байдаг л даа. Ихэнх тохиолдолд Таван хошуу ньшашингүйн үзлийнхний бэлгэдэл болсоор ирсэн"

Фааш толгой дохиж "Яг тийм. Ад зэтгэрийн бэлгэдэл",

"Үгүй дээ" гэж Ландон залруулснаа, зөв үг сонгож тайлбарлахын тулд түр саатлаа.

"Одоо үед шашингүйн үзлийнхнийг ад зэтгэртэй холбож тайлбарладаг буруу ойлголт их гарчбайна. Шашингүйн үзлийнхний уг гарлыг хайвал, байгальд шүтсэн нэг төрлийн шашны

урсгал юм. Тийм болохоор Таван хошуу бод байгальд шүтсэн шашны урсгалынхны бэлгэдэл болж таарна. Энэ урсгалынхан ертөнцийг бүхэлд нь 2 хэсэгт хуваадаг. Эр ба эм тал. Эр, Эм бурхад тэнцвэрийг хадгалж байдаг гэж үздэг. Өөрөөр хэлбэл арга, билиг гэсэн үг л дээ. Арга, билиг тэнцвэржсэн үеддэлхий ертөнцөд амар амгалан ноёлж, тэнцвэр алдагдахад эмх замбараагүй байдал үүсдэг гэж итгэдэг" гээд Сониех руу зааж. "Энэ Таван хошуу бол эм буюу билиг галыг нь бэлгэдсэн байна. Сониех ч үүнийгээ өөрөө мэдэж зурсан байх" гэлээ.

"Сониех өөр дээрээ дарь эх бурхныг зурсан гэх гээд байна уу?"

"Бүр нарийвчлан тайлбарлавал, Таван хошуу бол дур тачаал, гоо үзэсгэлэнгийн Бурхан Сугаргаригийг бэлгэддэг юм.

Фааш хөмсгөө зангидан нүцгэн цогцсыг ажиглана.

"Байгальд шүтсэн шашин учраас бүх зүйл нь байгаль, түүний үзэгдэлтэй холбоотой. Венус Бурхан, Сугар гариг хоёр угтаа ижил. Сугар гаригийг Дорнын од, Ишгар, Астарте хэмээн олон янзаар нэрлэдэг байсан" гэхэд, Фаашийн толгой нь улам эргэвч. Ад зэтгэрийн бэлгэдлийн тухай бодлоосоо салахгүй зууралдсаар л байв.

Оюутан байхдаа Ландон Сугар гаригийг нэлээд шимтэн судалж байсан бөгөөд, энэхүү гариг нь 4 жил тутамд огторгуйн хавтгайд Таван хошуу дүрс үүсгэж явдгийг мэдэх болсон юм. Ийм ч учраас эртний Грекчуул Олимпийн наадмыг 4 жил тутам явуулах болсныг зарим хүмүүс мэддэг боловч, Олимпийн 5 цагираг Таван хошуунаас үүсэлтэйг гэр бүр мэддэггүй бил ээ.

"Эрхэм Ландон," гэж Фааш огцом дуугараад "Гэхдээ таван хошуу дүрс ад зэтгэрийн бэлгэдэлтэй холбоотой гэж та бодохгүй байна уу? Танай Америкчуул аймшгийн кинонд оо ингэж үзүүлдэг биздээ". '

Гялайлаа чамд Голливуд!

Голливудад хийгдсэн ихэнх аймшгийн кинонд Таван хошууг Сатаны бэлгэ тэмдэг болгон гуйвуулсныг хүмүүс тэр болгон анзааралгүй явсаар өдий хүрсэн юм. Үнэн хэрэгтээ бод энэ тэмдэг нь ад зэтгэрийн гэхээсээ бүрханлиг тал руугаа байх ёстой юмсанж.

Танд л гэж хэлэхэд Таван хошуу бол тэдгээр кинонд гардгаас шал ондоо агуулгаар тайлбарлагдана. Миний түрүүнд хэлсэнчлэн энэ тэмдэг бод дарь эх Бурхныг бэлгэдэж байгааг би баталж байна" гэж хэлээд, Ландон ахмадын хүзүүн дэх загалмайг нүднийхээ булангаар харж амжив.

Ландон болгоомжтойгоор үргэлжлүүлэн, "Бэлгэ тэмдэг иагхугааа өнгөрөхийн хэрээр хувирч өөрчлөгдөж байдаг. Загалмайтны шашныг дэлгэрүүлэх Ватиканы бодлогын үр дүнд Шашингүйн үзлийнхэн аяндаа шахагдаж, тэдний бэлгэдэл ад зэтгэрийнх мэт хүмүүст ОЙЛГОГДОХ болсон юм".

"Тэгээд?"

"Жишээ нь Шашингүй үзлийнхэн, Загалмайтнуудын хооронд тэмцэл өрнөж, Загалмайтнууд ялахад, Посейдоны 3 үзүүрт жад тамын эрлэгийн сэрээ, сэцэн эмэгтэйн малгай шуламсын малгай, Таванхошуу тэмдэг ад зэтгэрийн бэлгэдэл болж хувирсан юм" гээд, түр завсарлаад цааш үргэлжлүүлэв. "Сонирхолтой нь АНУ - ын батлан хамгаалахынхан Таван хошуу дүрсийг цэрэг дайны гол тэмдэг болгон ашиглаж байгаа. Генералын мөрдөс, сөнөөгч онгоцны далбаандаа ч энэ тэмдгийг дүрсэлдэг".

"Нээрээ тийм юм байна шүү" гээд Фааш 4 мөчөө тэлсэн цогцос руу чандаж, "Тэгвэл цогцосны байрлалын учрыг та юу гэж бодож байна?"

Ландон мөрөө хавчиж, "Цогцосны байрлал өөрөө Таван хошуу болоод дарь эх бүрхны агуулгыгдавхар баталгаажуулж байна. Тэмдгийг давтана гэдэг бол түүний утгыг багтай болгож байгаахэрэг. Сониех өөрийнхөө биеийг Таван хошуу мэт дүрсэлсэн нь үүнийг гэрчилнэ".

Фааш цогцсыг анхааралтай ажиглаад. "Сонирхолтой л дүгнэлт байна. Аа, тэгвэл нүцгэн байгааучир нь? Тэр ямар учраас бүх хувцсаа тайчсан юм бол?"

Энэ асуултын хариуг Ландон аль эрт гэрэл зургийг анх харахдаа л хайж эхэлсэнсэн.

"Ахмад аа. би таны тавьсан асуултад хариулж чадахгүй ч, Жак Сониех өөр дээрээ дарь эх бурхныгэмдгийг зурсныг л баттай хэлэх байна" гэв.

"За за, ойлголоо. Тэгвэл яагаад өөрийнхөө цусаар бие дээрээ зурсан юм бол?"

"Өөр бичих зүйл олдоогүй болоод тэр биз".

Фааш дуугаа хэсэг хурааснаа, "Миний бодлоор тэр цагдаагийнхны анхаарлыг зориуд татах гэжингэсэн байх".

"Үгүй, байлгүй дээ".

"Тэгвэл, түүний зүүн гар дахыг та нэг хар даа".

Ландон тэр зүг харвал, эрхлэгч гартаа тодруулагч барьсан байв.

Бид түүнийг анх олоход л ийм байдалтай байсан" гээд шинжээчийн багажаар дүүрсэн ширээ руудөхөнгөө, "Та энэ төрлийн тодруулагчийг өмнө нь харсан уу?"

Ландон доош бөхийж, тодруулагчийг сайтар харав.

Стило Де Льюмиэрэ Нуа" гэсэн бичигтэй тодруулагч байсанд тэр зогтусав. Энэ төрлийн үзгийгзөвхөн музей, архив, цагдаагийнханд зориулж хийдэг. Түүгээр бичсэн зүйлийг зөвхөн тусгайгэрлийн туяанд л уншиж болох бөгөөд, музейн ажилтнуудын хувьд үзмэрийн бүрэн бүтэн байдалдсанаа тавихад ашигладаг билээ.

Фаашийг гэрэл унтраахад галерей тэр чигтээ харанхуйд автав. Удалгүй, ахмад хэт ягаан т уяатайгэрэл барьсаар дөхөж ирэв. Эд мөрийн баримт олж илрүүлэхийн тулд энэ гэрлийг ашигладгийг тамэднэ байх гээд Фааш цогцос руу гэрлийг тусгалаа.

Ландон доош харснаа тэр дороо огло үсрэв. Цогцосны дэргэд бичигдсэн үгсийг Ландон хараад,манан будан дунд төөрчих шиг л болов. Ландон шалан дээрх үгийг дахин уншсанаа, ахмад руухараад, "Энэ ч одоо ямар чөтгөр авмаар утгатай уг вэ?"

Фаашийн нүд гялалзах бөгөөд, "Энэ асуултад хариулах ёстой хүн нь та өөрөө шүү дээ" гэжасуултыг сөргүүлэв.

Ландон, Фааш хоёрыг их галерейн танхимд ярилцаж байх үед, Дэслэгч Коле музейн эрхлэгчийнөрөөнөөс тэдний яриаг бичиж байв.

Бүх зүйл ном ёсны дагуу ажиллаж байна.

Галерейд болж буй бүх яриа соронзон хальсанд төвөггүй бууж байгаад, дэслэгч Коле сэтгэлхангалуун суух ажээ .

Хэсэг 7

Дарь Эхийн сүмийн 2 - р давхарт нэгэн тохилог оромж байх бөгөөд тэр бол Сандрин Биеилгэлэнмаагийн хоёр өрөө бүхий чулуун шалтай байр аж. Гэлэнмаа өөрийн хүссэнээр чимээшуугианаас хол байж, өрөөгөө ор, утас гэх мэт хэрэг болох бүх зүйлээр тохижуулж чаджээ.

Энэ орой түүнийг ид тайван нойрсож байтал утас хангинаж сэрээх нь тэр. Гэлэнмаа харилцуурыгаваад, "Дарь Эхийн Сүмийн Сандрин гэлэнмаа байна", хэмээн хариуллаа. Хариуд нь Францаар,

"Сайн байна уу, эгч гэлэнмаа" гэхэд гэлэнмаа эзнийхээ дуу хоолойг таниад, тэр дороо өндийн босч, 15 жилийн турш түүнээс сураг ажиггүй байсан болохоор нэлээд балмагдав. Түүний эзэн үнэнчшүтлэгтэн хүн бөгөөд бусад хүн амрахаар хэвтсэн хойно л мөргөлөө үйлдэж, орондоо ордоггэдгийг гэлэнмаа мэддэг байв.

"Таныг сэрээсэнд хүлцэл өчье. Гэвч танд дуулгахад би саяхан Америкийн нэр нөлөө бүхий хамбаламтантай утсаар ярьсан юм. Та ч түүнийг эчнээ мэдэх биз. Нэр нь Мануэль Арингароза.

"Тиймээ. Опус Дейн тэргүүн хамбыг мэдэлгүй яахав".

Опус Дейн тэргүүн хамба Арингарозагийн явуулж буй үйл хэрэг сүүлийн үед нэлээд амжилттайбайгаа юм. 1982 онд 2 - р Пап Опус Дейг өөрийнхөө ивээлд авснаар энэхүү байгууллагын сэргэнмандалтын үе эхэлсэн ажээ. Гэлэнмаа Сандриний бодлоор Опус Дейн амжилтад сэжигтэй зүйлбайдаг боловч энэ бүхнийг ил гарган хэлэх нь тэр бүр зохимжгүй.

"Хамба лам Арингароза танаас надаар дамжуулан нэгэн зүйл хүссэн юм" гэж хэлэхдээ эзний дуундсэтгэл түгшсэн байдал илэрнэ. Тэрээр цааш "Түүний нэг шавь нь өнөөдөр Парист ирсэн гэнэ. Танайсүмийг үзэх бололтой".

Гэлэнмаа учрыг нь бүрэн ойлгоогүй тул маш ихээр гайхаж, "Өршөөгөөрэй, Опус Дейн шавь манайСүмд маргаашдаа зочилж болохгүй юм уу!".

"Тэгж амжихгүй бололтой. Маргааш эрт буцна гэнэ. Шавь нь Сүмийг үзэх хүсэл дүүрэн байгаагэнэ".

"Сүм өдрийн цагт л дур булаам сайхан харагддаг юм. Сүмийн цонхоор нэвт тусах нарны гэрэл,түүнтэй хослох сүүдрийн зохицол энэ бүхэн Дарь Эхийн Сүмийг алдартай болгосон шүү дээ".

"Би таныг ойлгож байна. Гэвч танаас аминчлан хүсэхэд түүнийг энэ оройдоо хүлээн авбал, тэр маших талархах болно. Шөнийн 1 цаг гэхэд Сүм дээр очих байх. өөрөөр хэлбэл 20 минутын дараа" гэхэд гэлэнмаа хөмсгөө зангидан бодлогоширсон ч, хариул нь "За. Ойлголоо, эзэнтээн" гэв. Эзэнталархсанаа хэлээд, утсаа тавив.

Нойрноосоо бүрэн сэргээгүй байсан гэлэнмаа юу болсныг нэхэн санахын тулд, зузаан хөнжилдөөхэсэг хэвтэв. Тэрээр өдий наслахдаа ийм байдлаар сэрж байсан тохиолдол үгүй тул бүхий лмэдрэхүй нь аяндаа сэрчихжээ. Опус Дей байнга л түүнд гаагүй байдал үүсгэдэг. Ялангуяаэмэгтэйчүүдэд хандах Опус Дейн хандлага дундад зууны арг а барилаасаа салаагүйг Сандрингэлэнмаа анх сонсоод маш цочирдсон билээ. Гэлэнмаа нараар лам нарын өрөөг цэвэрлүүлж, "өөрийгөө тарчлаах" ёсыг эрэгтэйчүүдээс ч илүү хүнд нөхцөл тулгадаг гэж

дуулжээ.

Хэдийгээр сүүлийн үед католикийн Сүмүүд эмэгтэйчүүдийн талаар баримтлах бодлогоо зөөлрүүлжбайгаа боловч, Опус Дей энэ хүрдийг буруу тийш эргүүлж буй мэт түүнд санагдана. Гэлэнмаахөнжлөөсөө аажим сугаран босч, хөлөө чулуун шалан дээр тавихад, хүйт даасан мэдрэмж дээшөгссөөр бүх биенд нь тархах шиг бодов.

Эмэгтэй хүний зөн совин түүнд нэгийг хэлжээ.

Хэсэг 8

Ландон шалан дээр бичсэн үгсийг нүд салгалгүй ширтэнэ. Сониехийн үхэхдээ үлдээсэн энэ гэрээсүг түүнд огтхон ч ойлгомжгүй санагдах ажээ.

Бичээс:

13-3-2-21-1-1-8-5

O, DRACONIAN DEVIL! (ЭЭ, ДОГШИН ЧӨТГӨР!)

OH, LAMA SAINT! (ЭЭ, ДОГОЛОН ГЭГЭЭН!)

Ландон хэдийгээр ямар учиртай уг болохыг тайлбарлах аргагүй байдалд орсон ч, ад зэтгэрийнутгатай ямарваа нэг байдлаар холбогдоно гэсэн ахмад Фаашийн бодол хэвээр байгааг зөнгөөрөөмэдэж байв.

O, draconian devil! (Ээ, догшин чөтгөр!)

Сониех чөтгөртэй холбоотой ямар нэгэн зүйл хэлэхийг хүсжээ. Гэвч дээр нь бичигдсэн цифрүүдтүүнд туйлын сонин байлаа.

"Зарим хэсэг нь тайлагдаж болмоор ч юм шиг"

"Тийм ээ. Манай мэргэжилтэн - шинжээчид үүн дээр ажиллаж байгаа. Эдгээр цифрүүд алуурчныголоход бидэнд тусална гэж итгэж байгаа. Магадгүй утасны дугаар, эсвэл үнэмлэхийн дугаар чбайхыг үгүйсгэхгүй. Танд энэ үгнүүд ямар нэг зүйл хэлэхгүй байна уу?"

Ландон уг руу дахин нэг хараад, бэлгэдлийн чанартай гэдгийг нь тодруулахад нэлээд хугацаашаардана гэдгийг ойлголоо.

Харин түүнд эхний мөрөн дэх цифрүүд эмх замбараагүй мэт харагдана. Хэдийгээр Ландонд эдгээртэмдэгт дүрс бодон цифрүүд бэлгэдлийн хувьд тус тусдаа утгатай байж бодох ч, хоорондооавцалдаж утга илэрхийлнэ гэдэг огт боломжгүй мэт санагдана. Фааш,

"Та түрүүнд Сониехийн үлдээсэн дүрс тэмдгүүд дарь эх бурхантай холбоотой гэж батлаад байсан. Тэгвэл энэ үгс болоод цифр таны баталсантай холбогдож чадаж байна уу?". Ландон ахмадын энэүгэнд өдөөн хатгасан өнгө аяс цухалзаж байгааг мэдэж байв. Гэвч үнэндээ ахмадын хэлдгээр энддарь эхийн тухай дүгнэлт огт авцалдахгүй байв.

O, DRACONIAN DEVIL! (ЭЭ, ДОГШИН ЧӨТГӨР!)

OH, LAMA SAINT! (ЭЭ, ДОГОЛОН ГЭГЭЭН!)

"Энэ үгс ямар нэг байдлаар зэмлэл, цээрлэл шиг санагдаад байх юм. Та юу гэж бодож байна?" гэжФааш асуув.

Ландон, эрхлэгч өвгөн сүүлчийн мөчид Их Галерейд түгжигдчихээд байх үеийг төсөөлөн бодов. Учир холбогдлын хувьд байж болох л юм. "Алуурчинд хандсан түүний үг ч байж болох юм". "Миний ажил бол алуурчныг олох. Тийм болохоор, ноён Ландон, танаас 1

зүйл асууя. Таныхаарэнэ хоёр мөр үгсээс юу нь анхаарлыг чинь хамгийн ихээр татаж байна?"

Анхаарал татах гэнэ үү? Галерейд түгжигчихээд үхэхийнхээ өмнө өөртөө таван хошуу зурж, шаландээр зэмлэлийн үг сараачсан зэргээс алийг нь онцолж анхаарал татам байна гэх юм бэ? Энэ бүгдхэн хүний айж цочирдом дүр зургууд биш гэж үү?

"Draconian гэж үг бол" гээд Ландон анх төрсөн бодол нь явцгүйг ойлгоод, "Draconian devil гэжүгийн сонголт их хачирхалтай санагдаад байна" гэв. Фааш, "Сониех бол Франц х үн" гээд цааш нь, "Тэр Парист амьдардаг байсан. Тэгээд англи үгийг өөрөөр яаж сонгох байсан гэж...?"

Ландон Сониехийг англи хэл гаргууд эзэмшсэн гэдгийг сайн мэднэ. Харин яагаад заавал англиарбичсэний учрыг ойлгохгүй байв. Фааш Сониехийн хэвлий руу зааж "Ад зэтгэртэй холбоогүй гэдэгтта одоо ч итгэлтэй байна уу?"

Ландон энэ удаад аргагүй байдалд оров. "Тэмдэгт болоод үгс хоорондоо ямар ч утга авцалдаагүйюм байна. Би та нарт тус болж чадахгүй нь бололтой",

"Магадгүй нэг зүйд нөхцөл байдлыг тодорхой болгож магад" гээд, Фааш гар дахь гэрлийг цогцостойруулан тусгав.

Эрхлэгчийн цогцсыг тойруулан цагираг зурсан байлаа. Сониехийн бие тэр тойрогтоо бүтнээрээбагтсан харагдана.

Ландон үүнийг харсан даруйд юу болохыг нь ойлгов.

"Харьцаа" (Vitruvian) гэж Ландон амандаа шивнээд, Сониех Да Винчийн бүтээлийг өөрийн биеэрдүрсэлснийг ухаарлаа.

Да Винчийн бүтээл болох "Харьцаа" бол өнөө цагийн хамгийн их дэлгэрсэн дүрслэл болоодзогсохгүй зурагт хуудас, футболк зэрэгт өргөнөөр ашиглагддаг юм. Нүцгэн эрэгтэй тойрог дотор 4мөчөө дэлгэн хэвтэх уран зураг.

Да Винчи!

Ландон аянгад цохиулсан юм шиг цочин давхийв. Сониех санаа бодлоо илэрхийлэхийн тулд,үхэхээсээ өмнө бүх хувцсаа тайчиж хаяад, Леонардо Да Винчигийн бүтээлийг дүрсэлсэн гэхэдүнэхээр хачирхмаар, энэ бүхний дараа ганц бодол түүний толгойд эргэлдэнэ.

Сониех яагаад алдарт бүтээлийг дуурайн дүрслэх болов?

"Ноён Ландон" гэж Фааш хэлээд. "Тань шиг хүн Аа Винчиг зургаа далдлах аргаар зурдаг байсныгмэдэх байлгүй" гэв.

Ад зэтгэрийн талаарх түүний гөжүүд бодолд туйлдаад байсан Ландон энэ удаад түүний ДаВинчийн талаарх мэдлэгт гайхан цочлоо.

Да Винчи Христийн соёлд өөрийн гэсэн зам мөрөө гаргасан хүн. Хэдийгээр тэр алдарт хүн билэгтанхай байсан боловч, Дивиний дарааллыг шүтдэг, мөн ижил хүйстнээ сонирхдог байсан ньБурхны үүрдийн нүгэл хилэнцийн золиос болсон юм. Винчи хүний биеийн бүтцийг судлахын тулдцогцос задалж, нууцаар хууль бус сэтгүүл гаргаж. Алхимийн шинжлэх ухааныг эзэмшлээ гэжөөртөө эрдэж үхлийг зайлуулах шидэт ус бүтээж, хэний ч санаанд оромгүй дайн тулааны зэв сэг,эрүү шүүлтийн багаж анх сэдэж байв.

Да Винчийн Христийн соёлд оруулсан хувь нэмэр нь хэдий их боловч түүний сүмийнхэнд талзассан байдал дараах зүйлтэй холбоотой. Ватиканы сүмийн олон ашигтай саналуудыг хүлээж

авснаар, христийн шашинтай холбоотой маш олон бүтээлүүдийг туурвиж, өөрийн үрэлгэнамыдралдаа хөрөнгө оруулж байсан юм. Гэвч тэрээр сүмийнхнийг элдвээр хэлж гоочлохоомартаагүй байж.

Ландон нэгэнтээ Лондон дахь үндэсний Галерейд "Леонардогийн нууцлаг амьдрал - шашингүйнурсгалын бэлгэдэл христийн соёлд тусгалаа олсон нь" хэмээх илтгэлээ тавьж байсан юм.

"Би таны санааг ойлгож байна. Гэхдээ "Да Винчи хэзээ ч далд аргаар зураг зурж байгаагүй" гэжЛандон хэлээд түүний толгойд нэгэн хачин бодол орж ирлээ. Ландон шалан дээр бичсэн үг рүүдахин нэг харав.

O, DRACONIAN DEVIL! (ЭЭ, ДОГШИН ЧӨТГӨР!)

OH, LAMA SAINT! (ЭЭ, ДОГОЛОН ГЭГЭЭН!)

"За, ямар утгатай гэж бодож байна?" гэж Фаашийг асуухад. Ландон үгээ зөөн ингэж хэлэв.

"Сониех Леонардо Да Винчитэй адил Христийн Сүмийнхнээс илүү шашингүй үзлийнхний талыгбаримталдаг байсан. Да Винчийн бүтээлийг дууриаж дүрсэлснээрээ өнөөгийн ХристийнСүмийнхийг нэг хэлбэрээр зэмлэсэн байх" гэлээ.

Фаашийн нүд нь орой дээрээ гарч, "Та тэгээд Сониех Сүмийнхнийг зэмлэн цээрлүүлсэн гэж хэлэхгээд байна үү?" .

Ландон дахин нягтлахад, таван хошуу дүрс түүний бодлыг батлаад байх шиг санагдав.

"Минийхээр бод Сониех өөрийн амьдралыг дарь эх бурхныг судлахад бүрэн зориулсан хүн байсан.Католик Сүмээс өөр хүч түүний энэ хичээл зүтгэлийг хавчин гадуурхаж чадахгүй байх байсан.Тийм болоод Сониех Эцсийн үгэндээ сэтгэл дундуур байна гэдэг санаагаа илэрхийлсэн байх" гэв.

"Сэтгэл дундуур ий?" гэж Фааш хорсол дүүрэн өнгөөр асуугаад "Тэгвэл, Сониехийн бичсэн үгссэтгэл дундуур байдлыг хэлэхээсээ илүү бусдыг өдөөн хатгасан утгатай гэж танд бодо гдохгүйбайна уу?"

Ландоны тэвчээр нь алдарч, "Ахмад аа, та надаас тусламж хүссэн. Тэгээд л би энд тантай цуг учрыгтайлах гэж хэрэндээ л оролдож байгааг та харж байгаа биз дээ".

Фааш шүд зуун, "Энэ үг тэгээд сүмд ял тулгаж үлдээсэн уг юм биз дээ? Би ажиллаж байх явцдаамаш олон үхлийг харсны хувьд танд нэг зүйл хэлье. Хэн нэгэн хүн бусдад алуулж үхсэн л бол хэзээч өөрийн үзэл баримтлалаа, этгээд, нууцлаг байдлаар үлдээгээд үхэхгүй. Харин түүний оронд ганцзүйлийн тухай л бодох байсан" гэж шивэгнэх шахам х элээд, "Энэ бол өс хонзон. Сониех бидэндтүүнийг хэн алсныг зааж өгсөн байх".

Ландон зогтусч, Гэхдээ энд тэгж бичсэн гэж харагдахгүй л байна даа".

"Үгүй гэж үү?"

"Үгүй" гэж Ландон түс тас хэлээд "Сониех өөрийнхөө ажлын өрөөнд хэн нэгнийг уриад,

харин тэрхүн түүнд халдсан гэж та надад ярьсан шүү дээ"

"Тэгж хэлсэн"

"Тийм бол эрхлэгчид халдсан хүнийг Сониех өөрөө мэддэг байж" Фааш толгой дохиж цаашүргэлжлүүлэхийг хүсэв.

"Сониех хэрэв алуурчныг мэдэж байсан юм бол яагаад энэ бүхнийг хийсэн юм бэ?" гэж шал руузааж "Үл Тайлагдах эдгээр цифрүүд, Draconian devil, цээжин дээрээ зурсан таван хошуу, энэ бүхэноньсого таавар мэт биш гэж үү!".

Фааш өмнө ингэж бодож байгаагүй тул хөмсгөө зангидан, "Танд өөр санаа төрсөн байгаа юмбайна, тийм үү?"

"Нөхцөл байдлыг үзвэл, Сониех алуурчны тухай хэлэх гэж бодсон бол тэр хэн нэгний нэрийгбичиж үлдээсэн байх ёстой" гэлээ. Ландон ийн хэлж дуусаагүй байхад, Фаашийн уруулдинээмсэглэл тодрох нь харагдав.

"Илүү тодорхой зүйл хэрэгтэй" хэмээн ахмад хоёронтоо давтан хэлэв.

Дэслэгч Коле чихэвчний дууг чангалан, Фаашийн яриаг сонсонгоо, Их мастер - ахмадын аргабарилыг шагшин бахадна.

Фаашаас өөр хэн ч ийм арга хэрэглэж чадахгүй.

Өнөөдрийн байдлаар бусдыг сэтгэл зүйн дарамтад оруулж хэрэг хүлээлгэх арга тэр бүрхэрэглэгдэхээ больсон. Цөөн хэдэн хүн л үүнийг хэрэглэж дөнгөдгийн дотор, ахмад Фааш багтдагюм, түүний тэвчээр, хүлээцтэй байдал нь роботын хэмжүүрт тулж очно.

Фааш бусдадаа цагийн өмнө, товчхон бөгөөд тодорхой мэдэгдэл хийсэн аж. "Би Сониехыг алсанхүнийг мэдэж байна".

Түүний энэ мэдэгдэлд ямар ч алдаа байх ёсгүй. Тэр юу хийхээ сайн мэднэ. Одоогоор энд нэг чалдаа гараагүй л байна.

Фаашийн зөн совин бусдаас онцгой. Түүний тухай нэгэн мөрдөгч ярихдаа. Бурхан түүний чихэндсэжигтний нэрийг шивнэж хэлдэг гэж бусдадаа аминчлан ярьжээ. Коле ч мөн адил хэрвээ Бурханбайдаг л юм бол, ахмад Фаашийг Бурхны элч хэмээн заримдаа боддог байв.

Хэдэн жилийн өмнө Ромын Папыг айлчлахад, Фааш өөрт буй бүхийл нөөцөө дайчилж, олны зүгээсталархал хүлээж байсан юм. Паптай хамт авахуулсан гэрэл з ураг одоо түүний ажлын өрөөнийхананд өлгөөтэй байдаг. Ямартаа л ажлынхан нь түүнийг Бүх Пап гэж далдуур хочилсон байхав.

Коле зөөврийн компьютер луу эргэж, СРБ мөрдөх систем ажиллаж байгааг шалгав. Компьютерийндэлгэцэд харагдах Денон жигүүрийн нарийвчилсан план зураг дээрээс хайсан зүйлээ олохооршамдав. Галерейн орц, гарц, хонгилын танхимыг дагуулан нэгжсээр эцэст хайсан зүйлээ олжхарлаа. Их Галерейн тэхий голд нэгэн улаан цэг анивчих нь үзэгдэнэ.

Фааш өөрийн олзыг гартаа чанга атгасан ажээ. Харин Роберт Ландон өөрийгөө түүнд тус хүргэжбайна л гэж бодож байв.

Хэсэг 9

Ландонтай цуг байхад нь саад болно гээд Бэзу Фааш гар утсаа унтраасан байв. Харамсалтай ньхоёр шугам зэрэг хүлээн авдаг утас байсан тул, Фааш энэ тухай мартаад үлдсэн шугамыг хаасангүйорхижээ. цагдаагийн ажилтан шугамаар ахмадыг дуудна.

"Ахмад аа?" гэж дотуур холбоо мэт гэнэт шуугихад, Фааш тэвчээр заан шүдээ зуугаад, онцгойтохиолдолд л түүн руу залгана гэдгийг мэдэх тул Ландон руу уучлал хүссэн харцаар харж, "Түрхүлээгээрэй" гээд утсаа бүснээсээ мулталж авав.

"Уи?" (За!)

"Капитан, ан агон дү депактемон дэ криптографи эт агивэ*. (Ахмадаа! Шинжээчийн хэлтсээс хүнирсэн байна.)

Фаашийн оволзсон уур дарагдав бололтой. "Шинжээч гэнэ ээ?"

Энэ түүнд сайхан мэдээ байдаа. Фааш хэргийн газар ирэнгүүтээ, Сониехийн гэрэл зургийгдариулж, шинжээчийн албанд явуулчхаад хариу хүлээж байсан юм.

Хэрэв шинжээч ирсэн бол эдгээрийн утгыг тайлсан байх ёстой.

"Би одоогоор завгүй байна" гэж Фааш хариулаад, *Шинжээчийг наанаа түр хүлээж бай гэж хэл. Биөөрөө дуудъя" гэв.

"Шинжээч Софи ирчихсэн байна".

Фаашийн баяр хөөр бага багаар замхран алга болов. Софи бол цагдаагийн газрын удирдлагынхныгаргасан том алдааны нэг. Энэ эмэгтэй Английн Роял Холлоуэйн их сургуульд мэргэжил эзэмшсэ нбөгөөд, 2 жилийн өмнө Фаашийг цагдаагийн албандаа эмэгтэй хүний тэгш эрхийг хангажажилладаггүй гэж дээд удирдлагадаа гомдол мэдүүлж байсан юм. Үүнийг Фааш эсэргүүцсэнболовч, энэ нь буруугаар эргэж, түүний нэр хүндийг унагахад хүргэсэн аж.

Эмэгтэй хүн бие бялдраас гадна, цагдаагийн эрэгтэй ажилтнуудын сэтгэл зүйд муугаар нөлөөлдөг. Фаашийн бодлоор, Софи ч үүнд хамаатай.

32 настай энэ бүсгүйд дэндүү шаргуу мөртлөө зөрүүд зан давхар заяажээ. Түүний Англид олжавсан мэдлэг туршлагаа Францад өргөнөөр ашиглаж байгаа явдал хамт ажилладаг заримшинжээчдийн дургүйцлийг ихээр төрүүлдэг ажээ.

Утасны цаанаас, "Шинжээч Софи Нөвү тантай уулзахыг шаардаад байна, ахмад аа! Би түүнийг саатуулах гэсэн боловч чадсангүй. Тэр одоо тань дээр очиж байгаа" гэв,

Фааш огло үсэрч, сайхь үгэнд итгэсэнгүй. "Хүлээж авахгүй. Би та нарт тодорхой хэлсэн шүү дээ" гээд гацчихав.

Ахмад үгээ гүйцээж чадсангүй, ам нь ангайн, нүд нь бүлтрэх шахан зогсоно. Фааш Ландоны мөрөндээгүүр давуулан, цааш харж байгаа бололтой. Ландоныг эргэж харахын завдалгүй эмэгтэй хүнийдүү хадаад явчхав.

"Экскуземуа месьюу!" (Өршөөгөөрэй, эрхмүүд ээ!)

Ландон дөхөн ирж буй эмэгтэйг ажиглан харлаа. Эмэгтэй хонгил даган том том алхсаар наашлах нь мөсөн гулгуурын тамирчныг эрхгүй санагдуулна.

Өвдгөө дөнгөж давсан юбкан дээр, хүрэн улаан өнгийн хоолойтой цамц өмссөн нь түүнийг дурбулаам харагдуулах бөгөөд түүнийг даруй 30 эргэм насных гэж таамаглахаар байв. Өтгөн хүрэн үсмөрийг нь давж нуруунд нь асгараад, царайг нь улам ч дулаахан харагдуулах аж. Шаргал үст, хоосон толгойтой зарим бүсгүйчүүдээс огт өөр гоо үзэсгэлэнг цогцлоож, өөртөө итгэлтэй дүр төрх нь бүсгүйг давхар чимэх нь гайхалтай.

Ландоныг алмайрч байх хооронд, бүсгүй түүн дээр ирж гараа сунгаад,

"Ноён Ландон, намайг Софи Нөвү гэдэг. Цагдаагийн газрын Шинжээчийн хэлтсийн ажилтан" гэж өөрийгөө танилцуулав. Түүний ярихыг сонсвол Англо - Франко аялгыг хослуулсан аж. "Тантай уулзсандаа баяртай байна" гэж Софи хэлэв.

Ландон бүсгүйн гараас атгангаа, түүний нүд руу харвал, гүн ногоон нүдтэй бөгөөд харц ньтунгалаг аж. Харин тэр үед, Фааш оргилсон уураа дарж, өөрийгөө эзэмдэж амжив.

"Ахмадаа?" гэж бүсгүй хэлээд цааш сэхээ авах завдалгүй дуржигнуулан, "Төвөг удсанд уучлаарай, гэхдээ..." гэж бүсгүйг хэлтэл,

"Сэ нэ па лэ мому" (Одоо л биш шүү!) гэж Фааш амандаа бувтнав.

"Би тань руу залгасан ч холбогдож чадаагүй" гэж Софи хэлээд, "Таны утас унтраастай байсан" гэв.

"Би ажилтай байсан" гэж Фааш исгэрэх шахам хэлээд, "Ноён Ландонтой ярилцаж байсан юм" гэв.

Бүсгүй хариуд нь, "Би кодыг тайлсан" гэв.

Ландон гайхаж, кодыг уншчихлаа гэж үү хэмээн бүсгүйг дотроо шагшлаа.

Фааш юу гэж хариулахаа мэдэхгүй зогсоно.

"Тайллыг хэлэхээс өмнө Ноён Ландонд нэг зүйл дамжуулж хэлэх ёстой" гэж Софи хэлэв.

Фааш тэр агшинд анхаарал нь төвлөрч, "Ноён Ландонд уу?" хэмээн асуув.

Бүсгүй толгой дохиод, Ландон руу эргэж "Таныг АНУ - ын ЭСЯ - тай заавал холбоо бариарай гэж дамжуулсан байна лээ. Америкаас нэг зурвас танд үлдээсэн бололтой" гэв.

Ландон бүр гайхшаа барж, шалан дээрх бичээсийг ахмадад тайлбарлаж байснаа ч мартчихав.

Америкаас гэнэ үү? Хэн надад зурвас үлдээдэг билээ? Хэдхэн нөхдөөс бусад нь намайг Паристбайгааг мэдэхгүй шүү дээ.

Фаашийн ангайсан ам сая л хаагдаж, "АНУ - ын ЭСЯ гэсэн үү?" гэж сэжиглэнгүй асуугаад, "Тэд Ландоныг энд байгааг яаж мэдсэн юм бол?" гэв.

Софи мөрөө хавчаад, "Бодвол Ноён Ландоны энд урьсан хүн рүү залгаад, зочид буудлын үүдний лавлахаас ийшээ ирснийг дуулсан биз".

Фаашийн царай бүр цонхийж, "ЭСЯ тэгээд шинжээчийн хэлтэсрүү энэ тухай мэдэгдэж, холбообарьсан юм уу?"ь,.

"Үгүй ээ. Би харин тантай холбогдох гээд төв руу залгасан чинь намайг энд ирэхийг дуулаад, энэ тухай ноён Ландонд дамжуулаарай гэсэн юм" гэв.

Фааш будлиж эргэлзсэндээ хөмсгөө зангидна. Ахмад ам нээж ярих гэсэн боловч, Софи Ландонтой ярьж байв.

"Ноён Ландон!" гэж Софи хэлээд, халааснаасаа цаас гаргаж, "Энд танай ЭСЯ - ны утасны дугаарбайгаа. Таныг яаралтай холбоо бариарай гэсэн шүү!" гэв. Бүсгүй цаасыг Ландонд эвтэйхэнатгуулаад, "Би кодын тайллыг ахмадад тайлбарлаж байх хооронд та утсаар, ярьсан нь дээр байх"гэлээ.

Ландон цаасыг дэлгэн харвал, Парисын утасны дугаар гэдэг нь тодорхой байв.

"Баярлалаа, танд!" гэж хэлэхдээ, санаа нь зовниж эхлэхийг Ландон мэдрэв.

"Надад утас байхгүй шүү дээ?" гэвэл, Софи цамцныхаа халааснаас утас гаргаж ирсэн боловч, Фаашгараа саван бүсгүйг болиулав.

Ахмад оргилох гэж буй галт уул шиг үзэгдэнэ. Тэрээр Софигоос нүд салгалгүй ширтэнгээ, утсаагарган асаагаад, "Үүгээр ярьсан нь найдвартай, ноён Ландон" гэв.

Фааш яагаад Софид уурлаад байгаагийн учрыг Ландон олохгүй байв. Ахмадаас утсыг нь авахдаатүүний сэтгэл зовних аж. Фааш утсаа өгсөн даруйдаа, Софиг цааш дагуулан хол очиж зогсоод, нэлээд зандчих байгаа бололтой. Ландон ахмадад илт дургүйцэвч, тэр хоёрыг орхиж, өөр тийшхараад, ЭСЯ - ны дугаарыг цуглуулав.

Софигийн өгсөн дугаар луу тэр залгалаа.

1 дуугарав. 2 дуугарав. 3 дахиа дуугарав .

Хариу өгөв бололтой. Ландон ЭСЯ - ны оператортай холбогдлоо гэж бодсон ч, өмнөөс нь автоматхариулагч дуугарав. Хачирхалтай нь автомат хариулагчид бичигдсэн дуу хоолой түүнд

танилсонсогдов. Энэ бол Софи Нөвүгийн дуу байлаа. Автомат хариулагч,

"Бонжүү вү сэт бизн ше Софи Нөвү. Же сүй сабсонт пө ле момун, май..." (Сайн байна уу! Та СофиНөвүтэй холбогдлоо. Одоохондоо би эзгүй байна.Та...) гэв.

Аргаа барсан Ландон Софи руу эргэн, "Уучлаарай, хатагтай Нөвү. Та надад дугаараа...." гэвэл "Зүгээр, зүгээр. Наадах чинь зөв дугаар" гэж Софи тэр дор нь таслан хэлээд, "Элчин Сайдын Яамныхан автомат хариулагч тавьсан байна лээ. Танд өгсөн цаасан дээр мэдээгээ сонсох кодыг чинь бичсэн байгаа" гэв. Ландон үнэн байдлыг учирлах гэтэл Софи түүн дээр харцаа тогтоон, Америк эрийг аргамжчихав. Түүний харцанд "Битгий асуу. миний хэлснийг л хий" гэсэн үгстөдрөхыг Ландон олж харлаа. Тэрээр хэлсэн дагуу нь кодыг хийж эхлэв.

4-5-4

Автомат хариулагч үгээ давтахаа больж, "Танд зурвас үлдээсэн байна" гэж хэлэв.

Магадгүй 454 гэсэн кодоор Софи гэрийнхээ гаднаас зурвасыг сонсдог байсан байх.

Софигийн дуу дахин сонсогдож, "Ноён Ландон?" гэж Софи айж ширвээтсэн дуугаар намуухан хэлээд, "Үүнийг сонсоод та гайхсан дүр огтхон ч гаргаж болохгүй. Намайг сайн сонс. Та машаюултай байдалд байна. Миний зааврыг хэлсэн дагуу минь хийгээрэй..."

Хэсэг 10

Багшийн зааврын дагуу, Силас Ауди маркийн хар өнгөтэй машин хөлөглөсөөр, Дарь Эхийн Сүмдхүрч ирэв. Сүм рүү хурц тод гэрэл тусахад, түүний хоёр талд байх хонхтой өндөр цамхгууд цайзынаварга харуул мэт сүндэрлэн үзэгдэнэ. Сүмийн гол дагуу эгнэсэн, олон баганууд хүчит араатныхавирганы яс шиг зурайн тодроод, гайхмаар харагдана.

Бурхны энэ ариун газарт буруу номтнууд оньсон чулууг нуужээ.

Ахан дүүс ээлжит заль мэхээ урласан нь энэ. Силас оньсон чулууг олж, багшид аваачсанаар бүхзүйл ном журамдаа орж, үнэн ёс ялна.

Хэрэв ингэж чадвал Опус Дей хүчирхэгжиж үүрд мандана.

Сүмийн гадна машинаа зогсоогоод, өмнөө тавьсан зорилтоо биелүүлэхийн тулд, Силас хамаганхаарлаа дайчлан төвлөрүүлэв. Ар нуруугаа ташуурдсанаас болж хөндүүрлэн өвдөвч, Опус Дей дэлсэхээс өмнөх түүний туулсан, зовлон зүдгүүртэй энэ мэт өвчин шаналал харьцуулшгүй хөнгөн мэт санагдана.

Өмнөх бараан дурсамж түүний сэтгэлийг дахин үймүүлэв. Гэвч зовсны эцэст жаргадаг. Түүнийгугтаа бол Силас гэдэггүй ч, тэрээр өөрийн төрсөн нэрийг санадаггүй аж. 7 настайдаа төрсөн гэрээорхижээ. Боомтод ачигчаар ажиллаж байсан эцэг нь түүнийг альбино болж төрсөнд эгдүүцэж, эхийг нь байнга зоддог байв. Эхийгээ хамгаалах гэж оролдсон ч бас л хамт зодуулна. Нэгэн удаа эх нь ээлжит зодуурын дараа дахин босч ирсэнгүй. Эхийгээ үхсэнийг мэдээд ийм зүйл болсондөөрийгөө буруутгажээ.

Энэ бол ганцхан миний буруу!

Ад зэтгэрийн бодол түүний сэтгэлийг эзэмдэхэд, тэрээр хутга шүүрэн согтуу хэвтэх эцгийнхээ арнуруунд чичин хатгажээ. Өвдсөндөө чарлан хөрвөх эцгийнхээ дууг дахин гарахгүй болтол тэрхутгалаад л байсан аж. Ингээд гэрээ орхиж, Марселийн гудамжинд гарсан ч шинэ ертөнц түүндтаатай хандсангүй. Түүний этгээд, онцгой дүр төрх түүнийг бусдаас холдуулж зожгироход хүргэн, улмаар нэгэн үйлдвэрийн балгас дээр амьдрах болсон

Боомтоос жимс, түүхий загас хулгайлж идэн, өөрийн ганц нөхөр болох ноорхой сэтгүүлийг хогоостүүж уншина. Тэр өөрөө уншиж сурчээ. Силас өсч том болсоор.... 12 - той байхдаа эгчмэдтэнүүлчинд залилуулж, оромжоо алдаад идэх хоол ч үгүй болсон. Гэвч тэнүүлч охин буруу хүнтэйорооцолдсоноо ойлгоогүй учир аминаасаа хагацжээ. Орон нутгийн шийдвэр гүйцэтгэгчид СиластМарселиас зайлан гарах эсвэл хүүхдийн колонид орох тухай тулган шаардах бичиг өгчээ.

Жаал хүү Тулон руу шилжив. Цаг хугацаа өнгөрөх тусам түүний өрөвдөм дүр төрх, айдас төрүүлэмдүр төрхөөр солигдож байлаа. Хүчирхэг том биетэй Силас нэгэнт эрийн цээнд хүрчээ. Түүнтэйзөрөн өнгөрөх хүмүүс хоорондоо айн ширвээтсэн харц солилцож, сүнс явж байна хэмээн биебиендээ шивнэнэ.

"Чөтгөрийн нүдтэй сүнс!!!"

Тэр өөрийгөө боомтоос боомт дамжих сүнс мэт төсөөлж байлаа. 18 настайдаа хайрцагтай утсанмах хулгайлах гэж байгаад боомтын хоёр ажилчинд баригджээ. Шар айрганд хөлчүүрсэн далайчинэрс түүнийг эцэг шиг нь хэрцгийлэн зодож эхэлсэн аж. Олон жилийн өмнөх дурсамж дахин сэргэж, Силасын араатны араншинг сэрээснээ, согтуу эрс тэр үед огтхон ч гадарласангүй. Залуу хүүнэгнийх нь хүзүүг нүцгэн гараараа хугартал нь цохиж, нөгөөх нь амь тасрахын даваан дээрцагдаагийнхан ирж аварчээ.

Тэр явдлаас хойш, 2 сарын дараа Андоррын шоронд залуу эр дөнгөлөгдөж ирэв. Түүнийгшоронгийн өрөөнд анх оруулахад, хоригдлууд түүнийг элэглэн шоолж, "Сүнс шиг цагаан" хэмээнинээлдэж байж.

Сүнс шиг цагаан юм чинь би шоронгийн хана нэвтлэх ч юм билүү! гэж тэр үед бодсон аж.

Гэвч Силас тэнд 12 жил хоригдов. Нэгэн шөнө өрөөний хоригдлын хашхирах дуунаар сэрвэл, үлмэдэх хүчний нөлөөгөөр шал доргиж чичирч байснаа, гэнэт дээрээс нь үхэр шиг том бул чулуубуун ирэхэд, тэр босч зайлж амжив.

Унасан чулууны нүхээр дээш тааз руу харвал 10 - аад жилийн турш үзэгдээгүй зүйл түүний нүдэндтусав. Сар!

Дээш авирсаар тэрхүү нүхээр гадагш гарч зугтав. Бүхэл шөнөжин уулын бэл уруудаж гүйсээр, өлсөж ядрахын туйлд хүрсэн байв. Ухаан нь бүдэг бадаг сүүмэлзэвч, сэтгэлээ хөвчлөн урагшилсаар, төмөр зам даган хэсэг алхсан аж. Ачааны хоосон галт тэрэг харсан даруйдаа түүндшургаж ороод хэсэг амсхийжээ. Галт тэргэнд хэр удаан, хэр хол явснаа ч тэр мэдсэнгүй. Өвчин ньтүүний голд ортол шархирна.

Би үхэж байгаа юм болов уу?

Дахин хэсэг унтаад сэртэл хэн нэгэн түүнийг зодоод, галт тэрэгнээс хөөн буулгаж байв. Жижигхэнтосгоны захад буусан цустай босуул эр дэмий л хоол эрж хэсэг гэлдрэв. Ухаан нь орж гарсаар, урагш алхах тэнхэлгүй болж, замын голд хөсөр ойчив.

Гэрэл түүн руу удаанаар дөхөхөд, сүнс тэнд хэр удсанаа ер мэдсэнгүй.

1, 2 эсвэл 3 өдөр. За, хэд ч байсан яахав.

Түүний унтаж буй ор хөвөн шиг зөөлөн бөгөөд, эргэн тойрон лааны үнэр нэвт шингээстэй байв. Есүс Христ түүний дээрээс ширтэнэ.

"Би энд байна" гэж Есүс хэлэв. "Чиний дээрээс чулуу унахад, чи дахин мэндэлсэн".

Тэр дахин нойрсоод удалгүй сэрэв. Түүний бодол манан дунд төөрчээ.

Силас диваажинд итгэж байгаагүй ч, Есүс түүн дээр ирсэн байж. Түүний дэргэд хоол тавьжээ. Тэридчихээд дахин унтав. Түүнийг сэрэхэд Есүс мөн л инээмсэглээд түүнд ингэж хэлнэ. "Хүү минь, чи адислагдсан. Тиймээс миний заасан замаар явах ёстой".

Тэр дахин нойрондоо дарагдав.

Гэнэт аврал эрсэн чарлах дуун хадаж, түүнийг сэрээв. Орноосоо сугаран босч чарлаж буй зүгхарайлгав. Гал тогоонд гүйн ортол, лагс том биетэй нэг эр, давжаа биетэй нөгөөгөө зодож байхыг харав. Учрыг үл ойлгосон ч, сүнс залуу лагс биет эрийг барьж аваад, хана руу түлхчхэв. Түлхүүлсэн даруйдаа нөгөө эр зайлан одоход, Силас жижиг биетэй номлогчийг олж харлаа. Номлогчийн хамар айхтар мурийсан байх бөгөөд, нил цус болсон түүнийг Силас буйдан дээрсуулгав.

"Баярлалаа, анд минь!" гэж номлогч Франц аялгатай хэлээд, "Сүмийн хандиваар цугласан мөнгөхулгайч нарын анхаарлыг татсан бололтой. Чи зүүдэндээ Францаар ярьсан, харин Испаниар ярьдагуу?"

Сүнс залуу толгойгоо сэгсрэв.

Номлогч эр Францаар дулимаг үргэлжлүүлж, "Чамайг хэн гэдэг вэ?"

Сүнс залуу өөрийнхөө нэрийг санахгүй байв. Шоронгийн харгалзагчдын элэг доог болсон нэр лтүүний санаанд тод байлаа.

Номлогч инээмсэглэж, "Санаа зоволтгүй. Намайг Мануэль Арингароза гэдэг. Би энд Обра Де Диос Сүмийг байгуулахаар Мадридаас ирсэн юм" гэв.

"Би хаана байгаа юм бэ?" гэж сүнс залуугийн асуухад, түүний дуу нь бараг үл сонсогдох аж.

"Овиедод. Испанийн хойд хэсэгт".

"Би энд яаж ирсэн юм бэ?"

"Чамайг хэн нэг нь олоод, Сүмийн үүдэнд орхисон байсан. Чиний бие их хүнд байдалтай байсан. Би чамайг олон хоног асарсан шүү".

Сүнс залуу асран хамгаалагчаа анхааралтай ажиглав. Тэрээр энэрэл нигүүлслийг бараг мэдэхгүй шахам байсаар өдийг хүрсэн юм.

"Баярлалаа, Эцэг минь" гэхэд, номлогч эр цус болсон уруулаа тэмтэрч үзээд "Харин би л чамдбаярлах ёстой" гэв.

Сүнс залуу өглөө нь босвол, амьдрал шинээр эхэлсэн юм шиг түүнд санагдав. Орны дээд талдөлгөсөн загалмай өөрийн эрхгүй сэтгэлд дотно харагдана. Орны дэргэдэх ширээн дээр сонинхайчилбар тавьсан байв. Францаар бичигдсэн тэрхүү мэдээ 7 хоногийн өмнөх бололтой. Тэрээр мэдээг уншиж эхлэнгүүтээ, айдас хүйдэст авгав. Тэнд газар хөдлөлийн талаар дурдаад, түүнээсүүдэж шорон нурж, олон хоригдол оргосон тухай бичсэн байв.

Зүрх нь хүчтэй цохилно. Номлогч түүний тухай бүгдийг мэдсэн болж таарав. Ичгүүр,

ГЭМШИЙНАЛЬ АЛЬ НЬ ХОСОЛСОН МЭДРЭМЖ СҮНС ЗАЛУУГИЙН БҮХ БИЕЙГ НЬ ЭЗЭМДЭВ. ТЭР ДАРУЙ
ОРНООСОО СУГАРАНХАРАЙЖ, ХААШ ЗУГТААХАА, ӨӨРӨӨСӨӨ АСУУЛАА.

"Ариун судар" гэж хэлэх нэг хүний дуу ард нь гарав.

Залуу айж эмээсэн харцаар эргэж харвал, номлогч ороод ирчихсэн инээмсэглэн зогсож байв. Тэрээр хамраа эв хавгүй боож, Библийн хуучин судар гартаа атгажээ.

"Би эндээс чамд франц хэл дээр нэг зүйл оллоо. Бүлгийг нь энд тэмдэглэсэн байгаа"

Сүнс залуу Библийг аваад тэмдэглэсэн бүлгийг нь хайж олов.

16- р бүлэг.

Энэ бүлэгт нэгэн Силас нэрт хоригдлын тухай өгүүлэх бөгөөд, тэрээр Бурханд зориулж дуулалдуулсан тухай гарна. Цааш уншиж байтал санаанд оромгүй зүйл тэнд гарч ирэв.

"...Гэнэт газар хөдөлж, шоронгийн бүх хаалга нуран ойчлоо" гэсэн байв.

Сүнс залуу номлогч руу цоо ширтлээ.

Номлогч сэтгэлд дотно инээмсэглэж, "Одооноос эхлэн чамайг Силас гэж нэрлэе, анд минь" гэлээ.

Сүнс залуу өөрийн мэдэлгүй толгой дохив.

Силас!

Түүнд эрч хүч, сүр сүлд нь эргэж иржээ.

Миний нэр Силас.

"Өглөөний унд уух цаг болчихлоо" гэж номлогч хэлээд, "Чи энэ Сүмийг байгуулахад надад туслах гэж байгаа бол, чамд хүч чадал юунаас ч илүү хэрэгтэй".

Газар Дундын тэнгис дээгүүр 20 мянган футийн өндөрт нисч буй онгоц агаарын урсгалд оржсэгсчүүлэхэд, зорчигчдын дотор нь баахан эвгүйцэв. Харин хамба лам Арингароза үүнийг юманчинээ тоосонгүй. Опус Дейн Сүмийн ирээдүйн тухай бодолд тэрээр бүрэн автсан байлаа. Парисдахь ажил хэргийн явцыг мэдэхийн тулд тэрээр Силастай холбоо баримаар санагдана. Гэвч энэ боломжгүй. Учир нь Багш ингэж зөвлөсөн юм.

"Ингэх нь чиний аюулгүй байдлыг хангаж чадна" гэж Багш франц аялгаар хэлээд, "Би одоогийн холбоо харилцааны найдваргүй байдлыг мэдэх тул ингэж хэлж байна. Чамд л уршигтай" гэж анхааруулсан ажээ.

Түүний хэлдэг түмэн зөв. Багш бол маш хашир хянуур хүн.

Тэрээр өөрийн жинхэнэ нэрийг хүртэл Арингарозад хэлээгүй мөртлөө, өөртөө итгүүлж дөнгөсөн юм. Мөн тэрээр маш нууц мэдээллийг олж чадсан аж. Энэ бол Ахан дүүсийн холбооны тэргүүлэгч 4 гишүүний нэрийг мэдсэн явдал. Үүнийг мэдсэн нь, Арингароза Багшид итгэх гол нөхцөл болсо нюм.

"Хамбатаан, би бүгдийг нарийн төлөвлөсөн. Тэр дагуу, Силас энэ хэдэн өдөртөө зөвхөн надтай харьцах болно. Та хоёр хоорондоо харьцаж хэрхэвч болохгүй. Би өөрөө түүнтэй нууц

шугамаархолбогдох болно".

"Та түүнтэй эелдэг харьцана биз дээ?"

"Итгэл үнэмшил биднийг холбож байгаа цагт, би түүнтэй эелдэг харьцах болно".

"Сайн байна. Тэгвэл болно. Силас, бид хоёр энэ ажил хэргийг дуустал, хоорондоо холбоо барихгүйбайж болно".

"Би үүнийг чиний төлөө, Силасын төлөө, бас оруулсан өөрийнхөө хөрөнгө оруулалтыгхамгаалахын төлөө хийж байгаа юм".

"Хөрөнгө оруулалт гэнэ ээ?"

"Хамбатан минь, хэрэв чамайг энэ хэргийг анхнаас нь удирдсан гэж шүүх мэдвэл, чи шорондсууна. Тэгчихвэл би чамд оруулсан хамаг хөрөнгөө эргүүлэн авч чадахгүй болно шүү дээ".

Хамба инээмсэглэж, "Тийм шүү. Бидний зорилго нэг. Хамтдаа Бурхны төлөө л байгаа шүү дээ".

Хамба онгоцны цонхоор гадагш харахдаа, 20 сая еврогийн тухай бодов. Энэ бол 30 сая доллартойтэнцэх хэмжээний мөнгө.

Их үйл хэрэгт нэмэр болох өчүүхэн хөрөнгө.

Тэрээр Багш, Силас хоёрыг амжилт хүлээж байгаа гэж өөртөө итгүүлэхийг оролдоно.

Мөнгө, итгэл үнэмшил хоёр ямагт их хэргийг бүтээж байсан юм.

Хэсэг 11

"Уне плезантори нумерик!" (Даажигнасан цифрүүд!)

Бэзу Фааш үл итгэсэн харцаар Софиг харна. Даажигнасан цифрүүд гэж үү? Сониехийн би чсэн зүйлзүгээр л даажигнасан цифрүүд гэж эцэст нь чи дүгнэсэн юм уу?"

Фаашийн уур цухал хамрынх нь үзүүрээр гарах шахна. Шинжээч бүсгүй хэргийн газарзөвшөөрөлгүй нэвтэрсэн нь багадаад, Сониехийн үлдээсэн гэрээслэлийг зүгээр нэг математикийндаажигнасан илэрхийлэл гэж тайлбарлаад зогсож байгааг тэсч үл чадна.

"Энэ код" гээд Софи Францаар дуржигнуулж, "... учир утгагүй нь харагдаж байна. Сониех чүүнийгээ утгагүй гэдгийг мэдэж байсан байх" гээд, бүсгүй халааснаасаа нугалсан цаас гаргаж, түүнийгээ Фаашид өгөв. "Энд кодын тайлал байгаа".

Фааш цаасыг дэлгэн харвал дээр нь:

1-1-2-3-5-8-1 3- 21 гэж бичсэн байв.

"Ингээд л болоо юу?" гэж ахмад уулга алдаад, "Чиний хийсэн ажил чинь ердөө л цифрүүдийг өсөхэрэмбээр нь жагсааж бичсэн байна шүү дээ!"

Софи хэдийгээр дотроо цухалдсан ч, сэтгэл хангалуун инээмсэглэл тодруулаад, "Яг тийм" гэжхариулав.

Фашийн хоолой нь цахиртаж, "Хатагтай Нөвү! Би хийсэн зүйлийг чинь сайн ойлгохгүй байна.Гэхдээ нэг л зүйлийг зөвлөхөд, энэ кодыг хурдан тайлаатах".

Ахмад тэднээс холгүй зогсоод, АНУ - ын Элчин Сайдын яамны утсаар зурвасаа сонсож байгаа Ландон руу сэтгэл дундуур байдалтай харснаа, түүний царай зэвхий даахыг хараад, муу мэдээгэдгийг нь гадарлав.

"Ахмад аа!" хэмээсэн Софигийн зориуд өдсөн дуу гарч, "Танд үзүүлсэн саяны дараалал бол түүхэндэх хамгийн алдартай илэрхийллийн нэг юм шүү!"

Фааш энэ талаар огт мэдлэггүй ч, Софигийн дууны өнгөнд дургүйцэл цухалзахыг анзаарав.

"Энэ бол Фибоначийн дараалал" гэж Софи хэлээд, Фаашийн гар дахь цаас руу заав. "Өөрөөр хэлбэл ч цифр нь өмнөх 2 цифрийнхээ нийлбэр байдаг юм".

Фааш цифрийг ажиглав. Нээрээ л бүсгүйн хэлснээр байсан боловч, энэ бүхэн Сониехийн үхэлтэй ямар холбоотойг төсөөлж ойлгож чадсангүй.

"Математикч Леонардо энэхүү Фибоначи хэмээх илэрхийллийг 13 - р зуунд гаргаж томьёолсон. Гэвч энд бичсэн эдгээр цифрүүдийн утга Фибоначийн дараалалтай ямар ч холбоо авцалдаагүй байна".

Фааш хэдэн хором залуу бүсгүйг ширтээд, "За яахав. Хэрэв ямар ч авцалдаагүй байгаа юм бол чинадад Сониех яагаад ингэж бичсэн, юу гэж хэлэхийг хүссэн, ямар утгатайг нь тайлбарлаж хэлж чадах уу?"

Софи мөрөө хавчаад, "Тайлбарлаж чадахгүй байна. Энэ зүгээр л нэг наргиа шиг санагдаж байна. Ягл алдартай шүлгийн үгний байрлалуудыг сольж бичээд, түүнийг таньж чадах эсэхийг нь асуудагшиг"

Фааш томоор алхаж, Софигийн нүд рүү бүр ойртож ширтэнгээ, "Би чамайг үүнээс илүү тайлбархийнэ гэж найдаж байна".

Софигийн зөөлөн байсан төрх ор мөргүй арилж, ахмад руу бас ойртож, бараг нүүрээ наагаад, "Ахмад аа, Сониехийг зүгээр л биднээр даажигнасныг нь танд дуулгавал таныг баярлах байх гэж бодсон юмсан. Үгүй ч байж магад. Би хэлтсийн даргадаа бидний туслалцаа танд хэрэггүй болсныг хэлэхээс".

Ингэж хэлээд бүсгүй цааш эргэж, ирсэн замаараа буцаж алхав.

Фааш бүсгүйг харанхуй хонгил даган цааш уусан алга болох дүрсийг харан баярлаж хоцорлоо.

Тэр яачихсан юм бол? Софи Нөвү нэр төрдөө өөрөө сэв суулгачихлаа шүү дээ!

Фааш Ландон руу эргэж харахад, Ландон утаснаас зүүгдсэн хэвээрээ түрүүчээсээ бүр ч илүүгээр анхаарал нь төвлөрчихсөн, зурвасаа сонсож байв.

АНУ - ын ЭСЯ - г Безу Фааш үл тэвчих зүйл олон гардаг ч, давж донгосон удаагүй. Ахмадын АНУ -ын ЭСЯ - тай тэмцлээ өрнүүлдэг гол шалтгаан нь Францын Шүүх цагдаагийнхан Америкийн солилцооны оюутнуудыг хар тамхины хэргээр өдөр алгасалгүй баривчилж, насанд хүрээгүй биеэүнэлэгчдийг наймаалагч Америкчуудыг хорьж, танхай балмад жуулчдыг саатуулдаг зэрэг явдлаас үүдэлтэй. Хуулиар бол АНУ - ын ЭСЯ хэрэгт

холбогдсон тэдгээр хүмүүсийг эх орондоо буцаантатах үүрэгтэй боловч, өөрсөд дээрээ шилжүүлэн хүлээн авсныхаа дараа, олигтой шийтгэлхүлээлгэлгүй суллан явуулдаг байв.

Фааш Үүнийг "Лемаскулацион дела полицэ жудишах" гэж нэрлэжээ.

Парисын Мач сити сонины эхний нүүрэнд Фаашийг Америкийн гэмт хэрэгтнүүдийг зуухаар дайрчбуй, цагдаагийн нохойгоор дүрслээд, харин АНУ - ын Элчин Сайдын яамнаас гинжлэгдсэн учирхүрч чадахгүй байгаагаар зурсан байжээ.

Энэ удаад л биш шүү гэж Фааш бодно. Дэндүү олон шүдээр түүнийг таг зуусан байгаа шүү дээ.

Түүнийг ингэж бодох зуур, Ландон утсаа таслаад, шаналсан төрхтэй буцаж ирэв.

"Бүх юм зүгээр уу?"

Ландон дорой байдлаар толгойгоо сэгсэрнэ.

Гэр бүлд нь муу юм тохиолдсон байх гэж Фааш гадарлаад, Ландоноос утсаа авахдаа, профессорынхөлс урсаж байхыг анзаарав.

"Осол!" гэж Ландон ээрэн хэлээд, Фааш руу харжэвгүй царайлаад, "Найз маань..". гээд түрэргэлзэж байснаа, "Би өглөөний онгоцоор эндээс нисэх ёстой".

Фааш түүнд ер эргэлзээгүй ч, Америк эрийн нүдэнд айдас хургасныг олж харлаа.

"Үүнийг сонсоход, надад харамсалтай байна" гээд Фааш Ландон руу ойртон харж, "Та суухгүй юмуу?" гээд галерейн хананд тулган тавьсан вандан сандал руу заав.

Ландон толгой дохиод, сандал руу зүглэн алхав. Алхах тусам түүний царай улам зэвхий даана. "Бибие засах өрөөнд ормоор байна".

Фааш дотроо бодолхийлж, түр тээнэгэлзэв.

"Бие засах өрөө юу? Тэгэлгүй яахав. Бид хоёр түр завсарласан нь дээр юм шиг байна"

Ахмад ирсэн зүг рүү буцаан заан, "Бие засах өрөө эрхлэгчийн өрөөнөөс цааш байгаа".

Ландон эргэлзэж, өөр зүг рүү заагаад, "Бие засах өрөө тэр зүг арай ойрхон гэж би бодсон юмсан" гэв.

Ландоны хэлсэн зөв гэдгийг Фааш ойлголоо. "Би тантай хамт явах уу?"

Ландон толгой сэгсэрч, тэр дороо заасан зүг рүүгээ алхлаа. Тэрээр явдал дундаа, "Хэрэггүй байхаа. Би ганцаараа хэсэг баймаар байна".

Фааш үнэндээ түүнийг зугтана гэж бодохгүй байгаа ч, хашир хүн болохоор Ландоны явж буй зүгбол мухар гарцгүй гэдгийг санасан дороо тайвшрав.

Ландоны явж байгаа зүгт аваарын гарц - шат байгаа боловч эрхлэгч Сониех нэгэнт дохиоллыгажиллуулан, хаалтыг буулгачихсан тул, тэр шатаар зугтаах боломжгүй. Аваарын шатыгажиллууллаа ч дохио хангинаж, цагдаа нар тэр дороо хөдөлж амжих л байсан. Ландон Фаашидмэдэгдэлгүйгээр, музейгээс зугтаж чадахгүй байв.

"Би эрхлэгчийн өрөө руу очих хэрэг гарлаа. Та миний араас хүрээд ирээрэй, ноён Ландон. Бидэндярилцах зүйл их байгаа шүү !"

Ландон толгой дохьсоор, харанхуйд уусан алга болов.

Фааш эсрэг тийш ууртай алхалсаар, хаалтан доогуур шурхийн гарч, Их Галерейгаас холдоод, хонгил даган алхсаар, Сониехийн өрөөнд шуурга шиг давхин оров.

"Хэн Софи Нөвүг дотогш нэвтрүүлсэн бэ?" хэмээн ахмад бараг архирах шахан асуув.

Коле хамгийн түрүүнд дуугарч, "Тэр хамгаалагчдад кодыг тайлсан гэж хэлсэн гэсэн".

Фааш эргэн тойрон харж, "Тэр явчихсан уу?"

"Тантай хамт байгаагүй юм уу?"

"Тэр саяхан надаас салаад явсан" гээд харанхуй хонгил руу харав.

Бодвол Софи уурлаж багтарсандаа болоод, хэнтэй ч дуугаралгүй гараад явчихсан бололтой.

Фааш дотуур холбоогоор үүдний харуулуудад тушаал өгч, Софиг гарч явбал, түүнийг ямар нэгзүйл сэдэхээс нь өмнө саатуулж авчир гэж үүрэгдлээ.

Ингэсэн нь дээр гэж ахмад үзжээ. Өнөө шөнөдөө түүнд саад бэрхшээл багадаагүй байгаа.

Шинжээч Нөвүтэй одоохондоо зохицож байгаад, түүний толгойг эргэтэл загнаж зандрах мөчийгахмад тэсгэлгүй хүлээнэ.

Софигийн тухай бодлоо орхиж, Фааш Сониехийн ширээн дээр байх хуяг дуулга бүхий хөлөгбаатрын жижиг өмсгөлийг харав. Дараа нь Коле руу эргэж, "Чи түүнийг харж байна уу?" гэж асуув.

Коле тэр дороо толгой дохиж, компьютерийн дэлгэцийг Фааш руу эргүүлж харуулав.

Дэлгэцэн дээр өнөөх улаан цэг байх ёстой газраа анивчиж байв.

"Тойлете публик" гэсэн бичгийн дээр анивчина.

"Сайн байна" гээд ахмад тамхиа асааж, хонгил руу гарахдаа, "Би утсаар ярих хэрэгтэй байна. Тэрхооронд Ландон битгий л зугтчихаасай билээ".

Хэсэг 12

Роберт Ландон Их Галерейн танхимд ганцаар сажлан алхахдаа, сэтгэл дотор нь маш ихээрдавчдана. Софигийн утсан дээрээ үлдээсэн зурвас түүний чихэнд ахин дахин сонсогдох ажээ. Ихгаллерейн төгсгөлд бие засах өрөөний тэмдгийг хүйсээр нь ялган өлгөсөн тэмдэг холоос тодронгэрэлтэнэ.

Ландон бие засах өрөө руу орж, гэрлийг нь асаав.

Өрөө хоосон байв. Угаалтуур луу очиж, гоожуурыг тосоод, хүйтэн усаар нүүрээ шавшиж, сэргэхийг оролдов. Хурц гэрэлд нүд нь гялбахад өрөөгөөр дүүрэн шивтрийн үнэр хамар нэвтцоргино. Түүнийг гараа арчиж дуустал, ард нь хаалга гэнэт нээгдэв. Тэрээр огцом эргэж харлаа.

Софи Нөвү ороод ирчихсэн зогсох бөгөөд, нүд нь дүрлийн айдаст автжээ.

"Бурхны авралаар чи ирчихлээ шүү дээ. Бидэнд цаг бага байна".

Ландон бүр будлиж самуурсан төрх үзүүлсээр, Софи Нөвүг ширтэнэ. Хэдхэн хормын өмнө Ландонбүсгүйн зурвасыг анх сонсохдоо, түүнийг галзуу солиотой эмэгтэй гэж бодож байсан аж. Хариндараа нь түүний зурвасыг сонсох тусам бүсгүй ухаалаг хэрсүү гэдгийг гадарлаж ойлгожээ.

"Үүнийг сонссон даруйдаа бүү цочирдоорой. Харин тайван сонс. Та аюулд өртчихөөд байна. Миний хэлснийг л хийгээрэй".

Эргэлзээгээр дүүрсэн Ландон эцэст нь Софигийн зөвлөснөөр бүхнийг хийж, ахмад Фаашиднайзыгаа осолд орсон тул, харих ёстой гэж хэлээд, дараа нь бие засах өрөө рүү ирсэн билээ. Тэрахмадын заасан зүгт биш, харин бүсгүйн заасан бие засах өрөөнд эцэст нь ирж чадсан.

Бүсгүй шулуун харцтай, Ренуарын хөрөг шиг нууцлаг мөртлөө хурц төрхтэй нэгэн байлаа.

"Би танд анхааруулах хэрэгтэй гэж бодсон, Ноён Ландон" гэж хэлээд, Софи амьсгаагаа түгжсэнийдараа, "Та цагдаагийнхны хараанд мөрдөлтөд байна" гэж англиар ярих нь плитан ханатай өрөөндцуурайтаад, бүсгүй хол хөндий байгаа юм шиг санагдана.

"Гэхдээ ... яагаад?" гэж Ландон шалгаав. Софи түүнд бүх зүйлийг зурвасаар тайлбарласан боловч, профессор бүсгүйн амнаас сонсохыг хүсчээ.

"Яагаад гэвэл" гээд Софи түүн руу ойртож, "Фаашийн гол сэжиглэж байгаа хүн бол та".

Ландон энэ үгийг сонсоод хэлэх үг олдсонгүй, хоолой нь хоосон хэржигнэнэ. Софигийн хэлснээрбол, Ландон үнэндээ тэмдэгт судлаачийн хувьд Луврт дуудагдаагүй, харин сэжигтнийг өөрөөр нйлчлэх гэсэн цагдаагийнхны хэрэглэдэг аргад хууртан, энд ирсэн хэрэг байж. цагдаагийнхансэжигтнийг гэм буруутай эсэхийг мэдэхийн тулд, хэргийн газар огт гэмгүй царайлан дуудажирүүлээд, сэжигтэн тэвдэж сандраад, хэргээ өөрөө хүлээх арга бол тэр чигтээ сэтгэл зүйдтулгуурласан, гэдгийг Софи тайлбарлалаа.

"Та хүрэмнийхээ халаасыг шалга даа. Танд дамжуулагч суурилуулсан байгаа".

Ландоны айдас, түгшүүр илт нэмэгдэж, "Халаасаа шалгах ий? Бяцхан заль шиг санагдаад байхчинь".

"Та шалгаад үз л дээ".

Тэрээр огт ашигладаггүй зүүн халаасаа тэмтрэв.

Юу ч байхгүй байна. Юу ч байх билээ дээ! гэж Ландон бодоод, Софиг солиотой мэт санаж эхлэв.

Гэтэл түүний хурууны үзүүрт нэг зүйл мэдрэгдэв. Жижиг, хатуу тэр зүйлийг хуруугаараа чимхэнхалааснаасаа гаргалаа. Ландон түүнийг ширтэнгээ, алмайран зогсоно. Металл гадаргуу бүхий, товчшиг хэлбэртэй, цагны зай шиг хэмжээтэй зүйл байв. Ийм зүйлийг Ландон өмнө нь огт үзээгүйюмсанж.

"Энэ бол мөрдөх дамжуулагч. GPS - г ашиглан байршлаа тасралтгүй дамжуулж, Үүнийг ньманайхан хянадаг юм. Манайхан Үүнийг хүн ажиглахад, зориулж ашигладаг. Дэлхийн хаана чявсан байршлыг мэдээлж чадна. Өөрөөр хэлбэл электрон дөнгөнд орлоо гэсэн үг. Таныг зочидбуудлаас авч гарсан цагдаа таныг байхгүйд халаасанд чинь үүнийг хийсэн байж таарна".

Ландон тэр тухай эргэн санахыг хичээв. Шүршүүрт ороод, хувцаслаж, Гггггггарахаар завдахаддэслэгч түүнд хүрмээ өмсөхийг найрсаар сануулсан аж.

"Гадаа сэрүүн байна, ноён Ландон. Парисын хаврын салхи таны бардам төрхийг

арилгаж дөнгөнөшүү".

Ландон түүнд талархаж хүрмээ өмсжээ.

Софигийн харц нь зөөлөрч, "Би танд өмнө нь дамжуулагчийн тухай сануулж болохгүй байсан юм. Учир нь Фаашийн дэргэд халаасаа ухаж харагдахвий гэсэндээ тэр .

Ландон юу гэж хариулахаа мэдэхгүй байв.

Тэд танд дамжуулагч суулгасан нь оргож зугтахаас сэргийлсэн хэрэг. Үнэндээ, хэрэв та эндээсзугтвал өөртөө төвөг удаж тэдэнд ашигтай нөхцөл үүсгэх болно".

"Би яагаад зугтах ёстой гэж. Би огт гэм буруугүй шүү дээ!",

"Фааш тэгж бодохгүй байгаа".

Ландоны уур, цухал нь оволзож, дамжуулагчийг хогийн саванд хийхээр завдав.

"Болохгүй ээ!" гээд Софи түүний гараас барьж зогсоогоод, "Халаасандаа түр байлгаж бай. Хэрэвхаячихвал, дамжуулагч хөдлөхөө больснийг тэд анзаараад, дамжуулагчийг олсон байна гэж мэдэхболно. Фааш таныг ажиглаж байгаа болохоор, ганцааранг чинь ийш явуулсан хэрэг. Хэрэв ахмадынсанааг мэдсэнийг чинь тэр өөрөө гадарлах юм бол..." гээд Софи үгээ гүйцээсэнгүй.

Ингэж хэлээд Ландоны гар дахь дамжуулагчийг авч халаасанд нь буцааж хийв.

"Дамжуулагч одоохондоо танд байж байг. Ядаж хэдэн хором хүлээ" .

Ландон бүр будлиж гүйцжээ. "Фааш намайг Сониехийн үхэлд буруутай гэж яаж итгэж байна аа ?"

" Таныг сэжиглэх шалтгаан түүнд бий " гэж хэлээд Софи төв царайтай болж, "Таны хараагүй нэгзүйл тэнд байсан юм. Фааш үүнийг нуусан".

"Чи шалан дээр бичсэн 3 мөр үгийг санаж байна үү?"

Ландон толгой дохив. Ландоны сэтгэлд шалан дээр байсан, цифрүүд болон үг бүр нь хадагджээ.

Софи бараг шивнэх шахам дуугарч, "Харамсалтай нь таны харсан зүйл анх байснаасаа ялимгүй өөрболчихсон юм. Фааш бичээсийг 4 дэх мөрийн үгтэй нь цуг гэрэл зурагт буулгачхаад, таныг ирэхээсөмнө сүүлчийн мөрийг арчиж арилгуулсан юм

Ландон хэдийгээр тодруулагчийн бэх хялбар арилдгийг мэдэх боловч, Фааш түүнийг ямар учраасарилгасныг төсөөлөх ч үгүй байв.

"Сүүлчийн мөрийг Фааш чамд үзүүлэхгүй гэж бодсон юм" гэж хэлээд Софи дуугүй болов.

Тэгээд халааснаасаа гэрэл зургийн хуулбарыг гаргаж ирэв.

"Фааш энэ гэрэл зургийг авсан даруйдаа манай шинжээчийн хэлтэс рүү илгээж, учрыг ньтодруулах үүрэг өгсөн. Энэ бол хэргийн газраас ямар ч засваргүй авсан гэрэл зураг" гээд Ландондзургийг өгөв.

Ландон зургийг харав. Ойроос авсан тэр гэрэл зураг дээр шалан дахь зурвас бичгүүд тодронүзэгдэнэ.

Сүүлчийн мөрийг Ландон уншаад, толгойдоо сүхээр цохиулсан юм шиг болов.

13-3-2-21-1-1-8-5

Хэсэг 13

Ландон Сониехийн бичсэн үгийн сүүлийн мөрийг удтал харж зогсов.

Жич: Роберт Ландоныг ол.

Түүний дороос шал эргэлдэн босох шиг санагдана.

Сониех үгийнхээ төгсгөлд нь миний нэрийг бичлээ гэж үү?

Зүүдэнд ч орохооргүй энэ явдлын учрыг Ландон үнэндээ бодоод олсонгүй.

"Фааш чамайг яагаад энд дуудсан учрыг ойлговуу? Яагаад сэжигтэн болсноо бас ухаарав уу?"

"Нөхцөл байдлыг үзвэл, Сониех алуурчны тухай хэлэх гэж бодсон бол тэр хэн нэгний нэрийгбичиж үлдээсэн байх ёстой" гэж Ландоныг хэлэхэд, Фааш бах нь ханасан байдалтай жумалзажбайсныг санаад, учрыг ойлгов.

Жич: Роберт Ландоныг ол.

"Сониех яагаад ингэж бичих болов?" гэж Ландон бүсгүйгээс тулгаж асуухдаа, уур цухал нь оргилжбайв. "Би ямар учраас Сониехийг хөнөөх ёстой гэж?"

"Фааш бүхнийг илэрхий болгохын тулд, галерейд болсон та хоёрын бүх яриаг нууцаар бичижбайсан байх".

Үүнийг сонсоод, Ландон үг хэлэх гэсэн ч ам нь дэмий л ангалзана.

"Тэр бичил дуу хураагууртай явдаг юм" гэж Софи тайлбарлаад, "Тэр хураагуур нь долгионашиглаж, төвтэй шууд холбогдсон байдаг".

"Ингэж болохгүй шүү дээ. Би чинь хэрэгт ямар ч холбогдолгүй хүн. Би илтгэлийнхээ дараа шуудзочид буудал руугаа харьсан. Зочид буудлын үүдний лавлахаас шалгасан ч болно".

"Фааш бүгдийг шалгасан. Түүний хавтаст хэрэгт таныг зочид буудалдаа 10 цаг 30 минутад ирсэнгэж бичсэн байсан. Гэвч аллага 11 цагийн орчимд болсон гэж үзэж байгаа. Та зочид буудлаасаахэнд ч харагдахгүйгээр гарсан байж болох шүү дээ".

"Энэ бол галзуурал. Фаашид ямар ч нотолгоо байхгүй шүү дээ".

Софигийн нүд том болж, "Нотолгоо гэсэн уу, ноён Ландон? Таны нэр түүний цогцосны дэргэдбичигдэж, бас түүний тэмдэглэлд Сониех, та хоёр 11 цагийн орчим уулзах ёстой байсан нь гарчирсэн. Энэ бол аллага үйлдэгдсэн үе гэдгийг санаарай. Фааш одоо ч таныг баривчлан саатуулахбүрэн эрхтэй байгаа шүү".

Ландонд өмгөөлөгч хэрэгтэй болсныг хар аяндаа ойлгов.

"Би үүнийг хийгээгүй"

Софи санаа алдаад, "Ноён Ландон, энэ бол танай Америкийн телевизийн шоуугай огтхон ч адилгүй. Францын шүүх гэмт хэрэгтний талд биш цагдаагийн талд үйлчилдэг юм. Харамсалтай нь ямар чхэвлэл мэдээллээр шүүхийн шийдвэр цацагдахгүй. Харин Жак Сониех бол олны танил, бусдадхүндлэгдсэн хүн байсан учир, түүний үхлийн талаар маргааш өглөө гэхэд телевизээр шууд цацахболно. Фааш хэрэгтнийг илрүүлсэн тухайгаа өглөөнөөс өмнө мэдэгдэл хийхгүй бол хэвлэлийнхнийдарамтад давхар өртөнө. Харин таныг гэм буруугүй

байсан гэдгийг шүүх эцэслэн шийдвэрлэтэл, тацагдаагийнхны хяналтад байх болно".

Ландон торонд орсон араатан шиг харагдана. "Чи энэ бүхнийг яагаад надад ярьж байгаа юм бэ?".

"Яагаад гэвэл би таныг гэм буруугүй гэдэгт итгэлтэй байна" гэж Софи хэлэхдээ, Ландоноос нүдээбуруулаад, дараа нь түүн руу дахин ширтэв.

"Таны ийм гайд дайруулсан явдал бол миний буруу".

"Уучлаарай, юу гэнэ ээ? Сониех намайг буруутгасан нь танаас болсон гэсэн үг үү?"

"Сониех таныг буруутгаагүй. Энэ бол түүний гаргасан алдаа байсан юм. Сониехийн бичсэн үг бүгднадад зориулсан байсан".

Ландонд учрыг ухах гэж оролдоод чадсангүй. "Энэ чинь юу гэсэн үг вэ? Би ойлгосонгүй".

"Шалан дээрх бичээсийг цагдаагийнханд зориулж бичээгүй юм. Тэр үүнийг надад хандаж бичсэн. Сониех хэтэрхий яарч бачимдсандаа болоод, эдгээрийг бичихдээ цагдаа нар олчихно г эж ухаарчамжаагүй бололтой. Цифрээр илэрхийлсэн код бол утга авцалдаагүй зүйл байсан ч, түүний үхлийнтухай намайг хурдан мэдээсэй гэсэндээ тэр үүнийг бичсэн байх. Би чинь код тайлагч, шинжээч хүншүү дээ".

"Гэвч яагаад заавал танд хандаж бичсэн гэж?"

"Харьцаа" гэж бүсгүй шууд хэлээд, "Харьцаа бол Да Винчийн бүтээлүүдээс миний хамгийн дуртайнь байгаа юм. Эрхлэгч өвгөн миний анхаарлыг зориуд татах гэж үүнийг дүрсэлсэн гэж бодожбайна".

"Байзнаарай. Тэгэхээр эрхлэгч чиний дуртай зургийг мэддэг байсан гэв үү "

Бүсгүй толгой дохиж, "Уучлаарай! Одоо бүгдийг хэлэх цаг нь болсон бололтой. Жак Сониех бол ..." гээд Софи дуугүй бодчихов.

Бодвол бараан дурсамжаа санасан биз гэж Ландон дотроо гадарлалаа. Софи Сониехтэй ямар нэгэндотно харьцаатай байсан юм болов уу?

Ландон түүний өмнө зогсох шавилхан, царайлаг бүсгүйг харангаа, франц хөгшин эрчүүд залууханэмэгтэйг нууц амрагаа болгодог тухай дуулснаа санав. Гэвч Софи Нөвү тиймэрхүү "далд байрсууринд" огт тохирохгүй гэдэг нь Ландонд илт мэдрэгдээд байв.

"Би түүнээс салаад 10 - аад жил болж байна" гээд Софигийн дуу намсч, "Түүнээс хойш бид барагуулзаагүй. Өнөө шөнө манай хэлтэс дээр, түүний цогцос бүхий зураг, зурвасын хамт ирсэн ньнадад нэг зүйлийг сануулсан юм. Тэр надад ямар нэг зүйл хэлэх гээд байгааг би ойлгосон".

"Харьцааг" өөрөөрөө дүрсэлж үү?"

"Тийм. Түүнээс гадна P.S. гэсэн үг надад хамаатай".

"Жич гэсэн үг үү?"

Софи толгойгоо сэгсэрч, "P.S. бол Жич гэсэн үг огт биш. Харин миний нэрийн товчлол байгаа юм".

"Гэхдээ бүтэн нэрийг чинь Софи Нөвү гэдэг биз дээ?"

Бүсгүй харцаа буруулж, "Тэр намайг P.S. гэж дууддаг байсан юм" гээд нүүр нь улайж, "Энэ бол Princesse Sophie буюу Софи гүнж гэсэн үг л дээ".

Ландон хариуд нь юу ч дуугарсангүй.

"Инээдтэй сонсогдож байгааг, би мэдэж байна. Гэхдээ энэ бол олон жилийн өмнө, намайг багабайхад өгсөн хоч юм л даа". "Чи эрхлэгчийг бүр багаасаа мэддэг байсан юм уу?"

"Маш сайн мэднэ" гэж Софи хэлээд, "Жак Сониех бол миний өвөө байгаа юм".

Хэсэг 14

Ахмад тамхиа татаж дуусангуутаа, "Ландон хаана байна?" гэсээр өрөөнд орж ирэв.

"Бие засах өрөөндөө байна" гэж дэслэгч тэр дор нь хариулав.

"Цаг нөхцөөж байгаа юм биз дээ" гэж Фааш амандаа бувтнав.

Ахмад дэслэгч Колегийн ард зогсоод, анивчиж буй улаан цэгийг харж байлаа. Тэрээр Ландоныгочиж шалгамаар санагдаад, тэсгэл алдрах шахна.

Гэвч эхлээд, Ландон хэвийн байдалдаа эргэж орох ёстой. Түүнд тайтгарч амжих хугацаа өгөххэрэгтэй. Гэвч одоо аль хэдийн 10 минут өнгөрчихлөө шүү дээ. Хангалттай урт хугацаа биш гэжүү?

"Ландон дамжуулагчийг мэдсэн байх бололцоотой юу?"

Коле толгой сэгсэрч, "Бие засах өрөөн дэх дамжуулагч хэлбэлзэх хөдөлгөөнд байна, Тэгэхээртүүний халаасанд дамжуулагч байгаа гэсэн үг. Тэр дамжуулагчийг олсон бол, түүнийг газар дээрнь хаяад зугтаах гэж оролдох байсан".

Фааш цагаа харангаа "За, тэгвэл сайн байна"

Ахмад бодлогоширсон байдлаасаа салж чадсангүй. Энэ хэрэг явдал түүний хувийн амьдралтайямар нэг талаар холбоотой гэж санагдахаар, үйл хөдлөлийг ахмад алхам тутамдаа үзүүлсээр лбайгаа юм.

Энэ нь ч аргагүй биз гэж дэслэгч Коле дотроо эргэцүүлнэ. Фааш энэ хэргийг амжилттайилрүүлэхээс өөр арга байхгүй. Одоогийн байдлаар түүний түрэмгий бодлогод дургүйцсэн дээдудирдлага болон хэвлэлийнхний шүүмжлэл, том гүрний элчин сайдын яамтай үүсгэсэн таагүйхарилцаа, шинэ технологид зориулж буй төсвийн хэтрэлт зэрэг олон асуудал ахмадын толго йныөвчин болчхоод байгаа юм. Хэрэв технологийн үсрэнгүй шинэчлэлийг өөрийн ажилдаа нэвтрүүлжчадвал, тэтгэвэрт гарахдаа өндөр орлоготой өвгөн - ахмад болчхоод гэртээ тайван сууж болмоорбайдаг.

"Надад өндөр тэтгэвэр хэрэгтэйг Бурхан ч мэднэ" гэж ахмад байнга хэлнэ.

Фаашийн технологийн шинэчлэлд зориулж буй, хичээл зүтгэл түүний албан тушаал болоод, хувийн амьдралд нь сөргөөр нөлөөлж байгаа юм. Тэрээр өөрийн санааг хэрэгжүүлэхийн тулд, хувийн бүх хадгаламжаа технологийн төсөлд хөрөнгө оруулахад зориулаад, зах тай цагаан цамцавах ч мөнгөгүй болсон гэсэн цуу үг гадуур ихэд таржээ. Учир нь Фааш үнэтэй цагаан цамцаарбайнга гангарах дуртай аж.

Өнөө шөнө өнгөртөл, нэлээд хугацаа байна. Софи хэдийгээр түүнд саад хийсэн боловч, удалгүйөөрөө яваад өгсөн тул, Фаашийн гарт тоглох хөзөр үлдсэн билээ. Ландоны нэрийг шалан дээрбичсэн байсныг ахмад өөрт нь хэлээгүй юм.

Жич: Роберт Ландоныг ол.

"Ахмад аа?" гэж нэг цагдаа дуудаад, "Төвөөс бололтой. Тантай ярья гэж байна" гэв.

Ахмад харилцуурыг авангаа, анхаарлаа төвлөрүүлээд, "Хэн ярьж байгаа юм бэ?" гэж нөгөөцагдаагаас асуувал, цагдаа эр мөрөө хавчаад, "Шинжээчийн хэлтсийн дарга гэнээ".

"Тэгээд юу гэж байна?"

"Софигийн талаар ярьж байна гэнэ. Нэг алдаа гарсан юм шиг байна".

Хэсэг 15

Одоо л яг цаг нь боллоо!

Силасыг ауди машинаасаа эрч хүч дүүрэн буухад, шөнийн сэвшээ салхи түүний өмсгөлийгдэрвүүлнэ. Түүнийг хүлээж буй ажил хүч хэрэглэхээс илүү, уран ухаан шаардана гэдгийг мэдэхүчир Силас гар буугаа машинд орхилоо. Нэг дор 13 удаа үсэрдэг, Хеклир Коч USP - 40 хэмээх тэрбууг Багш түүнд өгсөн билээ.

Бурхны Сүм, ариун газарт үхэл таригч хүйтэн бууны зай олдох ёсгүй.

Шөнө болсон энэ үед Дарь эхийн Сүмээс холгүй хэсэг хүмүүс хөлхөлдөх нь саваагүй жуулчдыгөөртөө татах гэсэн насанд хүрээгүй биеэ үнэлэгчид байлаа. Бие цогцос нь аль хэдийнээ насандхүрсэн хүнийх шиг харагдах, тэдгээр охид Силасын нүдэнд эрхгүй тусна. Тэрээр хөлийнхөөбулчинг зориуд чангалж, өргөст бүс гуянд шигдэх тэр мөчид тэсгэлгүй их өвдөлт түүнд мэдрэгдэв. Оргилж байсан хуял тачаал нь ор мөргүй алга болжээ. 10 жилийн турш Силас ийм л аргаар дурхүслээ хазаарлаж, өөрийгөө захирч байгаа билээ. Энэ бол түүний замнал.

Тэрээр Опус Дейд зүтгэснээрээ их зүйлийг золиосолж байгаагаа мэдэх боловч, харин эргүүлжтүүнээс ч ихийг авч байгаагаа бас ойлгодог байлаа. Сахил хүртэн тангараг өргөх болоод, хувийнөмчөөс татгалзах нь, золиос гэж түүнд огтхон ч бодогддоггүй байв. Ядуугийн зовлонг гэтэлж, гэмтхэргийн улмаас шоронд тарчилсны дэргэд сахил хүртэнэ гэдэг хамаагүй дээр санагдана.

Харин одоо, тэр нэгэн үед Францаас Андорра дахь шоронд гутамшигтайгаар цөлөгдсөнөөс хойш, эх орондоо анх удаа ирж байгаа нь энэ боловч,

Одоо бол шал өөр хүн болж эргэж ирсэн шүү дээ гэж Силас өөрийгөө зоригжуулав. Тэр өнөөдөр Бурхны үйл хэргийн төлөө хүний амь бүрэлгэсэн нь, Силасын хувьд мөнхөд өөртөө хадгалах нууцхэвээр үлдэх байв.

"Чиний итгэл үнэмшлийн хязгаар, зовлон зүдүүрийг даах сэтгэлийн чинь хязгаараар хэмжигдэнэ" гэж Багш түүнд нэгэнтээ хэлжээ.

Тиймээс Силас зовлон, зүдүүр, өвдөлтийг үл хайхран, итгэл үнэмшлийн хязгаарлуугаа тэмүүлэн явж байлаа.

"Хаго Ла Обра Дэ Диос" гэж Силас шивнээд, сүмийн хаалга руу ойртлоо. Үүдний өмнө түр зогсож, гүнзгий амьсгал аваад, доторх бодлоо цэгцлэв. Түүнийг ямар үйл явдал хүлээж байгааг таашгүй болохоор, юу хийх тухайгаа дахин сайтар тунгааав.

Онъсон чулуу. Энэ бол бидний эцсийн зорилго.

Тэр чөтгөрийнх шиг цагаан гараараа хаалгыг гурвантаа балбав. Удалгүй түгжээ мултарч, италихийцтэй том дааман хаалга дотроосоо алгуур онгойв.

Хэсэг 16

Ахмад Фаашид өөрсдийгөө зугтсан гэдгийг яаж итгүүлэх тухайгаа Софи бодно. Ландонбалмагдсандаа, хөшчихсөн байгааг Софи харангуугаа, түүнийг өрөөний буланд аваачиж зогсоов.

Одоо би юу хийх вэ?

Өвөөгийнх нь 4 мөчөө тэлсэн нүцгэн цогцос бүсгүйн нүдэнд гэнэт харагдав. Софи овоогоо үхсэндбараг цочирдоогүй аж. Жак Сониех түүнд хөндлөнгийн хүн мэт санагдана.

Түүнийг 22 - той байх үед, 3 - р сарын тэр нэгэн үдэш болсон явдал тэднийг тангараг тасрахадхүргэсэн юм.

Энэ бол 10 жилийн өмнөх явдал шүү дээ!

Софи Англиас их сургуулийнхаа амралтаар гэртээ харьж ирээд, санаандгүй байдлаар өвөөгөө т унэтгээд зүйл хийж байхад нь, нууцаар харчихсан юм. Ийм зүйлийг харсандаа тэр одоо ч итгэдэггүй юм.

Хэрэв би нүдээр хараагүй байсансан бол.

Машид ичиж бас жигшсэн бүсгүй өвөөгийнхөө тайлбар хийх гэсэн хожмын оролдлогыг чхайхралгүй, хадгалж цуглуулсан мөнгөө аваад, гэрээсээ бүрмөсөн явжээ. Софи харсан зүйлээ хэндч ярихгүй гэж өөртөө тангарагласан юм. Өвөө нь түүнтэй холбоо, Харьцаа тогтоох гэж ил захидал,захиа явуулж, өөрийн үйлдэлд тайлбар өгөхийг цөхрөлтгүй оролдсоор байсан аж.

Юугаа тайлбарлах гэж?

Софи өвөөгөө түүн руу утасдах болон олон нийтийн газар уулзахыг тас хоригложээ. Учир ньөвөөгийнх нь хийх гээд байсан тэр тайлбар, түүний харсан зүйлээс ч илүү айж ширвээтэм байх вийгэхээс болгоомжилсондоо тэр. Өвөө нь түүнийг өсгөж хүмүүжүүлэх бүх хугацаанд хэзээ чамласнаа биелүүлээгүй тохиолдол гараагүй билээ.

Харин өнөөдөр үдийн алдад, түүний хориглосныг эс тоон, өвөө нь Софи руу залгасан аж.

"Софи!" гэх хөгшин хүний дуу автомат хариулагчаас сонсогдоод, "Би чиний хүссэнээр удаанхугацаанд утасдсангүй өдий хүрлээ. Гэхдээ энэ удаад ярихгүй байж чадсангүй. Бидэнд маш муузүйл тохиолдох гээд байна".

Софи энэ үед Парис дахь орон сууцныхаа гал тогоондоо зогсонгоо, түүний ярихыг сонсоод,цочирдох шиг болов. Өвөөгийнх нь намуухан, дөлгөөн дуу хоолой, бүсгүйн бага насныдурсамжийг сэргээв.

"Софи намайг сонс!" гэж өвөө нь англиар хэлэв.

Яг л багад нь хүмүүжүүлсэн шигээ ярьж байв. Сургуульдаа Францаар гэртээ англиар ярих ёстойгөж өвөө нь түүнийг сургажээ.

"Чи бүх насаараа уурлаж болохгүй шүү дээ. Чи миний илгээсэн захидлуудын нэгийг ч

боловуншсан уу? Чи ерөөс ухаарахгүй байна гэж үү?" гээд тэр түр азнаж, "Бид ганц удаа ч боловрилцах хэрэгтэй байна. Өвөөгийнхөө хүсэлтийг хүлээж аваач гэж би чамаас гуйж байна. Үүнийгсонссон даруйдаа Лувр руу залгаарай. Бид хоёрт маш ноцтой аюул тулгараад байна".

Софи угас руугаа зогтусан харж, Аюул гэнээ? гэж гайхав. Өвгөн юун тухай яриад байна вэ?

"Гүнж минь ..." гэж өвөө нь хэлэхэд, Софи цочин давхийв. "Би чамд хайртайдаа л чамаас заримзүйлийг нуусан юм. Энэ бүгд чиний аюулгүй байдлын төлөө байсан юм шүү! Чи одоо үнэнийгмэдэх цаг нь болсон. Би чамд гэрийнхний чинь тухай жинхэнэ үнэнийг заавал хэлэх ёстой".

Софигийн зүрх булгилах шиг болов. Манай гэр бүл гэнэ ээ?

Софиг 4 настай байхад, түүний эцэг, эх хоёр нь нас барсан юм. Тэдний сууж явсан машин гүүрэндээрээс нисч, эрчилсэн голын усан. живжээ. Бүсгүйн эмээ, эрэгтэй дүү нь бас тэнд хамт явж байсанаж. Ингэж л Софигийн гэр бүлийнхэн хормын дотор хорвоогоос арчигдсан юм. Бяцхан охин тэрүүд энэ бүхнийг дурсаж байхын тулд, сониноос эмгэнэлт явдлын тухай уншсанаа хайчилж, тэрхайчилбараа хайрцганд хийж хадгалсан ажээ.

Өвөөгийнх нь хэлсэн үг бүсгүйг голд нь ортол цочроожээ. Миний гэр бүл!

Тэр агшинд Софи багадаа байнга зүүдэлдэг байсан зүүдээ санав.

Манай гэрийнхэн амьд байгаа! Тэл гэртээ ирлээ ирлээ гэж зүүдлээд нойрноосоо сэрэхэд, бүх зүйлор мөргүй алга болчихно.

Гэр бүлийнхэн чинь үхсэн, Софи. Тэд дахин ирэхгүй.

"Софи .." гэж өвөө нь утсаар хэлээд, "Би чамд энэ тухай хэлэх гэж

олон жил хүлээлээ. Харин одоо цаг нь болжээ. Лувр руу утасдаарай. Би энд шөнөжингөө байна. Бид хоёрт аюул заналхийлж байхвий гэхээс би маш их айж байна. Чамд хэлэх зүйл их байгаа шүү" гээд яриагаа дуусгав.

Софи нам гүм дунд хэдэн хором дагжин чичирч зогслоо.

Өвөөгийнхөө хэлснийг Софи бодож бодож, ганц л зүйл санаанд нь оров.

Энэ бол өгөөш байна. Өвөө намайг харахыг, туйлын ихээр хүссэндээ л ингэсэн байх. Ингэхийнтулд тэр юуг ч хийхэд бэлэн байна шүү дээ!

Өвөөгөө жигших бүсгүйн сэтгэл улам гүнзгийрэв.

Гэвч өвөөгийнх бие доройтоод ач охиноо сүүлчийн удаа харахын тулд, эцсийн аргаа хэрэглэсэнбайж болох л юм. Хэрэв тэгсэн бол нарийн сэдэв хөндсөн байна шүү! Миний гэр бүл.

Бие засах өрөөнд зогсохдоо, Софи өвөөгийнхөө хэлсэн сүүлчийн тэр үгийг чихэндээ хэд хэдэн удаасонсох шиг болов:

"Софи! Бидэнд аюул учирсан ч байж магадгүй. Над руу залга!"

Гэвч Софи өвөө рүүгээ залгаагүй юм. Тэгье гэж огтхон ч бодоогүй аж. Харин одоо бол бүсгүйсэтгэл дотроо маш зөрчилдөж байлаа. Түүний өвөө музейд хорлогдчихсон хэвтэж байгаа. Түүнээс гадна шалан дээр код биччихсэн байгаа шүү дээ!

Тэр тусмаа түүнд зориулж бичсэн байдаг нь хачирхалтай. Софи шалан дээрх бичээсийн утгыгойлгохгүй байгаа ч, өвөө нь түүнд хандаж бичсэн гэдэг нь ойлгомжтой байв. Софигийн

шинжээчмэргэжлийг сонгож амжилттай ажиллаж байгаа явдал бол түүний Жак Сониехтэй салшгүйхолбоотой.

Өвөө нь өөрөө код, үгэн сүлжээ, таавар, оньсого зэрэгт дуртай байснаас гадна, тэд бүтэн сайн өдөрбүр тэд хамтдаа сонины үгэн сүлжээг тааж, код тайлах зэргээр цагаа өнгөрүүлдэг байсан юм.

Софи 22 настайдаа англи хэл дээрх үгийн сүлжээ, математик таавар, цифр орлуулалт зэргийг төвөггүй бөглөж, тайлдаг болоод эцэст нь Шүүх Цагдаагийн газарт код тайлагчийн ажилд орсон билээ.

Энэ шөнө өвөө нь нас барахынхаа өмнө код хийхдээ, яагаад заавал бие биенээ огт танихгүй, хөндлөнгийн хоёр хүнийг холбож чагталсныг, Софи огт ойлгохгүй байв. Учраа олохгүй, самуурсан төрхтэй Ландоноос энэ тухай асуугаад ч нэмэргүй гэдэг нь ойлгогдохоор тодорхой байв.

"Өвөө та хоёр өнөө шөнө уулзахаар товлосон байсан. Юун тухай тэр вэ?"

Ландон тэвдсэн байдалтай харагдах бөгөөд, "Уулзалтыг өвөөгийн чинь нарийн бичиг товлосон. Бинарийн учрыг нь тодруулж амжаагүй. Намайг Францын Сүм хийдэд дүрслэгдсэн шашингүйнүзлийнхний бэлгэдлийн талаар илтгэл тавихыг өвөө чинь олж мэдээд энэ талаар санал солилцох гэж дуудсан байх".

Софи үүнийг огт тоосонгүй. Үүнээс өөр шалтгаан байх ёстой.

Түүний өвөө бол шашингүй үзлийнхний бэлгэдлийн талаар хэнээс ч илүү мэдэх хүн. Тийм болохоор захын нэг Америк судлаачтай онцгой тохиолдлоос бусад үед санал солих гэж уулзахаар дурлахгүй байсан нь тодорхой.

Софи дахин тандаж, "Өвөө над руу өдөр залгаад, өвөө, бид хоёр ноцтой аюулд өртөх гэж байгаатухай хэлсэн. Энэ танд ямар нэг зүйл бодогдуулахгүй байна уу".

Ландоны Цэнхэр нүд булингартаж, "Үгүй ээ. Гэхдээ нөхцөл байдлыг..."

Софи толгой дохив. Бүсгүй бодлоо шавхан алхсаар өрөөний цонхонд ойртоод, цонхны шилэнд холбогдсон аваарын дохионы мэдрэгч туузыг олж харав. цонхоор доош харвал тэд даруй 40 футхэртэй өндөрт байлаа. Софи санаа алдангаа, цонхны цаанаас гоо үзэсгэлэнгээ гайхуулах Парисыгажиглана. Денон жигүүртэй баруун талаараа бараг залгагдсан гэмээр, Каруселлийн барилгын үзүүрхарагдав. Дунд нь нарийхан гудамж байв. Гудамжинд цонхны чанх доод талд шөнийн ээлжийнчааны машин зогсох байв. Ачааны машины дохио нь Софиг дооглох мэт хурц бөгөөд, хурдананивчина.

"Би юу гэж хэлэхээ мэдэхгүй байна" гэж хэлээд Ландон бүсгүйн ард ирж зогсонгоо, "Өвөө чинь бидэнд нэг зүйл дамжуулж хэлэх гэсэн бололтой. Гэхдээ би тус болж чадахгүйдээ харамсаж байна".

Софи Ландонг сэтгэлийнхээ гүнээс харамсаж байгааг, дууны өнгөнөөс нь ойлгож, түүн руу эргэж харав. Ландон гэгч энэ хүнийг олчихвол, хамаг зүйл тодорхой болно гэж Софи эхэндээ найдаж байсан юм.

P.S: Find Robert Langton! (Софи гүнжид, Роберт Ландонг ол!)

Өвөөгийнх бичсэн энэ өгүүлбэрт ямар ч алдаа мадаг байхгүйг, Софи мэдэж байв. Тэгэхээр энэ нууцлаг явдлыг тайлах хүртлээ, шинжээч бүсгүй Ландонтой цуг удаан хугацаанд байх хэрэгтэй. Гэвч тэдэнд тун бага хугацаа байгааг Софи сайтар ойлгож байв.

Ландон руу харсан чигтээ, Софи дөнгөж сая боловсруулсан төлөвлөгөөгөө дотроо

ЦЭГНЭНЭ.

"Бэзу Фааш чамайг баривчлах мөчийг тэсэн ядан хүлээж байгаа. Харин би чамайг эндээс зугтаахадчинь тусалъя. Үүнд чиний оролцоо л хэрэгтэй байна". Ландоны нүд орой дээрээ гарч, "Чи намайгзугатаа гэх нь үү?"

"Энэ бол хамгийн ухаалаг шийдвэр. Хэрэв таныг Фааш баривчилчихвал, Францын цагдаагийнхан, Америкийн ЭСЯ - тай маргалдаж дуустал, эндэхийн шоронд та өдөр хоногийг өнгөрөөнө. Харин түүний оронд эндээс зугтаж чадвал, танай ЭСЯ таныг хамгаалж, таныг бид хоёр аллагад буруугүйгцугтаа нотолж болно шүү дээ".

Ландон тийм ч амархан ятгагдсангүй. "Ингэж ярихаа боль. Фааш бүх гарцыг зэвсэгтэй харуулуудаар мануулсан байгаа. Бид бууных нь амнаас зайлж зугтаж чадлаа гэхэд, эцэст нь биднийг гэм буруутай гэж тэд үзэх болно шүү дээ. Харин түүний оронд, шалан дээрх бичээс чамд хандсан гэдгийг Фаашид хэлээд, миний нэр энэ бичээстэй ямар ч хамаагүйг түүнд нотолсон нь хамаагүй дээр".

"Би тэгж чадна" гэж Софи тэр дор нь хэлээд, "Гэхдээ эхлээд таныг ЭСЯ - нд чинь хүргэж өгсний хөөдараа, энэ бүхнийг хийх болно. Танай ЭСЯ эндээс ганц милийн зайтай, миний машин музейн гадаазогсож байгаа. Харин Фааштай бүгдийг шууд ярилах нь аз туршсан хэрэг болно гэдгийг та одооболтол ойлгохгүй байна гэж үү? Фаашийн өнөөдрийн хийсэн бүх үйлдэл таныг гэм буруутайг нотлоход чиглэсэн байсан шүү дээ. Түүний алгуурлаад байсан учир нь таныг өөрийгөө буруутгах үйлдэл хийж, нотолгоог нь улам хүчтэй болгохыг хүлээж байсан юм".

"Тийм байна. Намайг зугтаасай гэж тэсэн ядан хүлээж байсан байх нь л дээ" гэж Ландон сөргүүлэн хэлэв.

Софигийн халаасан дахь гар утас гэнэт дуугарч эхлэв.

Фааш утаст санаас зайлахгүй.

Тэр халаасандаа гараа шургуулж утсаа тэр дор нь унтраав.

"Ноён Ландон," гэж бүсгүй яаруу сандруу хэлээд, "Би танаас ганц л зүйлийг асууя. Үүнээс их зүйл шалтгаална. Шалан дээрх бичээс тантай холбоогүй, таныг гэм буруугүй гээд Фааш таныг гэм буруугүй хүн гэж итгүүлсэн гэсэн. Таныг сэжиглэж байгаа юм шиг зүйл танд ажиглагдсан уу?"

Ландон хэсэг зуур эргэцүүлээд, "Үгүй юм байна" гэж хариулав.

Софи санаа алдав. Учир нь Фааш худал жүжиглэхдээ гаргууд байсан байж таарах нь. Эхнээс үзэхэд, Фааш ямар ч үндэслэлээр хамаагүй Роберт Ландонг торны цаана хийхээр, сэтгэл шулуудсан нь тодорхой байв.

Софид Ландон маш их хэрэгтэй хүн болохоор, бүсгүй эцэст нь шийдвэрээ гаргав.

Би Ландоныг АНУ - ын ЭСЯ - нд хүргэж өгөх ёстой.

Аваарын дохиололтой холбогдсон, цонхоор доош харвал, 40 фут өндрөөс толгой нь эргэх шахна. Өөдрөгөөр төсөөлөөд, Ландон эндээс үсэрвэл, хоёр хөл нь зэрэг хугарах биз. Гэхдээ сайнаар бодоход шүү.

Гэвч тэр шийдвэрээсээ буцсангүй. Роберт Ландон хүссэн хүсээгүй Лувраас гарч зугтах ёстой.

"Утсаа авахгүй байна гэж юу гэсэн үг вэ?" гэж Фааш үл итгэсэн дуугаар асуугаад, "Чи түүнийдугаар луу залгасан биз дээ? Тэр утастайгаа явж байгааг, би мэдэж байна".

Дэслэгч Коле хэдэн минутын турш шинжээч Софи руу залгаж байгаа ч, огт тайван дуугаар, "Түүний цэнэг нь дууссан байгаа. Эсвэл утасныхаа хонхыг унтраасан байх".

Шинжээчийн хэлтсийн даргыг ярьснаас хойш, Фааш уур уцаартай байгааг Коле анзаарсан юм. Түүний дараа Колег бүсгүй рүү залга гэж тушаасан боловч холбогдохгүй байгаа нь, ахмадыгторонд орсон араатан мэт аашлахад хүргэжээ.

"Шинжээчийн хэлтсийнхэн ямар хэргээр утасдсан юм бэ?" гэж Коле түүнээс зүрхлэн асуув.

Фааш эргэж хараад, "Шалан дээрх бичээс ямар ч утгагүй гэдгийг бидэнд хэлэх гэж утасдсан".

"Тэгээд л гүйцээ юу?"

"Арай ч үгүй. Цифрүүдийг Фибоначийн дараалал гэдгийг тогтоосон ч энэ нь бас л хэргийнбайдалтай утга авцалдаагүй байна гэж хэлсэн".

Колегийн толгой нь эргэж, "Үүнийг хэлүүлэх гэж шинжээч Софи Нөвүг тэд өөрсдөө нааш явуулсанбиз дээ?"

Фааш толгой сэгсэрч "Үнэндээ бол тэд Нөвүг ийш явуулаагүй юм байна".

"Юу гэнэ ээ?"

"Хэлтсийн дарга нь биднээс хэргийн газрын гэрэл зургийг хүлээн авмагцаа, шинжээчдээ дуудсанбайна. Харин Софи ирж, Сониехын цогцос бүхий гэрэл зургийг хармагцаа, юу ч хэлэлгүй гар аадявчихсан гэнэ. Дарга нь түүний сэтгэлийг зовоохгүй гэсэндээ, тэр үед юу ч асуугаагүй гэнэ".

"Сэтгэл нь зовох ий? Тэр үхсэн хүний зураг өмнө нь огт хараагүй байх нь уу тэгээд?"

Фааш хэсэг дуугүй зогсож байснаа, "Би ч энэ талаар сайн мэдэхгүй байсан юм. Дарга нь бас энэталаар хамт ажилладаг хүнээс нь дуулсан гэнэ. Жак Сониех Софи Нөвүгийн өвөө нь гэнэ".

Үүнийг сонссон Колед хэлэх ч үг олдсонгүй.

"Дарга нь Софиг энэ талаар огт дурсаж байгаагүй гэж хэлсэн. Учир нь алдартай өвөөгийнхөөнөмөр нөөлөгт ажиллахыг хүсээгүйгээс болсон байх".

Харин Колегийн толгойд эргэлдэж байсан ганц бодол бол, Сониех кодыг Фаашийн анхааралдөртөхөөр зориуд бичиж, ахмад тэр кодыг тайлахаар шинжээчдийг дуудсан нь, тэнд ажилладаг ачохин Софиг энэ бүхнийг мэдэхэд хүргэсэн гэх таамаг байлаа.

Хэрэв энэ бичээсийг ач охиндоо хандаж бичсэн юм бол ямар утгатай байж болох вэ? Ландон үүндямар хамаатай юм бол?

Коле энэ тухай улам гүнзгийрүүлэн болох гэж мэрийж эхлэх тэр мөчид, музейн танхим аваарындохионд цочин чичрэх шиг болов.

Дохио Их Галерейн дотроос хангинаж байлаа.

"Аларм!" (Түгшүүр!) гэж нэг цагдаа хаа нэгтэйгээс хашхираад, "Гронде Галерий, Тойлете месьюу!"(Их Галерей, бие засах өрөөнөөс, эрхмүүд ээ!) Фааш тэр даруй Колег шавдуулж, "Ландон хаанабайна?" гэж асуув. "Бие засах өрөөнд байна" гэж Коле дэлгэцэн дээр анивчих цэгийг заан хэлэв. "Тэр өрөөнийхөө цонхыг хагалсан байх".

Гэвч Ландон зугтах боломжгүй байлаа. Хэдийгээр галын аврах гарц 2 - р давхарт байгаа ч, цонххагалж, гадагш гарлаа гэхэд, доод талаас нь шат сунгахгүй л бол тэндээ үлдэнэ гэсэн үг. Түүнээс гадна доор нь ямар нэг мод, өвсгүй хатуу хучилттай, цулгүй газар байгаа. Гагцхүү Карусселийн барилга музейгээс хэлхэн футын зайтай зэргэлдээ оршдог билээ.

"Ээ, Бурхан минь!" гэж Коле хашхираад, дэлгэц руу ширтэнгээ, "Ландон цонхны ирмэг дээр гарчихлаа!" гэж хэлэв.

Фааш сэхээ аван, Маньюрин МР - 93 маркийн бугаа сугалан гаргаад, Сониехийн өрөөнөөс тэрдаруй үсрэн гарав.

Колег анивчиж буй цэгийг харсаар байтал, нүднийх нь өмнө огт төсөөлшгүй зүйл болох нь тэр. Улаан цэг хөдөлсөөр, дэлгэцэн дээрх байшингийн хязгаарын гадна талд гарчхав.

Юу болж байна аа? гэж тэр гайхна. Ландон цонхны ирмэг дээр байна уу, эсвэл...?

"Есүс эцэг минь!" гээд ухасхийн босч харайв.

Дохио хангинах нь улам чангарч, нөгөөх улаан цэг байшингийн хязгаараас даваад, 10 ярд хэртэй газарт гэнэт зогсчхов.

Коле дамжуулах төхөөрөмжид итгэхгүй байсан учир, Парисын нарийвчилсан газрын зургийг сандран дэлгэж, цэгийн байрлалыг дахин нягтлав. Энэ үед цэг огт хөдөлсөнгүй. Карусселийн барилгын наад талын нарийн гудамжны голд огт хөдөлгөөнгүй байсаар л байв.

Ландон үсэрчихжээ!

Хэсэг 18

Фаашийг Их Галерей руу гүйж явах замд, дотуур холбоогоор анхааруулан хашхирах Колегийн дууваарын дохио хангинахтай давхцан паржигнана.

"Тэр үсэрчихжээ!" гэж Коле дотуур холбоогоор холбоогоор бархираад, "Дэлгэцэн дээр Карусселийн наана гэж харагдаад байна. Цонхоор шүү! Одоо ерөөсөө хөдлөхгүй байна. Есүс эцэг минь! Ландон амиа хорлосон юм шиг байна".

Фааш түүний хэлснийг, огт тоосонгүй, гүйсээр л байлаа. Хонгил хэзээ ч дуусахгүй юм шиг гүргэлжилнэ. Сониехийн цогцосны дэргэдүүр гүйж өнгөрөхдөө, ахмад Денон жигүүрийн төгсгөлийг голж харав. Дохио тэндээс чангаар хангинах дуулдана.

"Хүлээгээрэй!" гэх Колегийн дуу хадаж, "Тэр хөдөлж байна! Бурхан минь тэр амьд байна. Ландон хөдөлж байна".

Фааш гүйсээр л, өөрийн том том алхаагаараа хонгилын урт замыг товчлох гэж мэрийнэ.

"Ландоны хөдөлгөөн хурдасч байна!" гэж Коле сүүлдээ орилов. "Тэр Карусселийг уруудаад, цаашхолдож байна. Байз! ... Тэр улам хурдалж байна. Тэр маш хурдан хөдөлж байна".

Фааш халхавч ханыг тойрч гараад, бие засах өрөөг олж харлаа. Аваарын дохионы хангинахчимээнд Колегийн дуу бүлэг бадаг сонсогдоно.

"Тэр машинд суусан бололтой. Түүнийг машинд суусан гэж бодож байна. Би ерөөсөө үүнд..".

Колегийн дуу дарагдаж огт сонсогдохгүй болох, тэр агшинд ахмад буугаа зэхээд, өрөөндшуурхайлан оров. Дохио хангинахыг үл тоон, өрөөг тойруулан нэгжив.

Хоосон байв. Нэг ч хүн алга.

Фааш хагарсан цонх руу явж очлоо. Ахмад цонх руу очиж хараад, гаднах тавцанг ажиглав. Ландонбас л байсангүй. Ийм солиотой үйлдлийг хийнэ гэж ахмад өмнө нь төсөөлөө ч үгүй байсан юм. Хэрэв Ландон үсэрсэн юм бол нэлээд хүнд гэмтсэн байх ёстой.

Дохио хангинах нь түр завсарлаж, Колегийн ярих нь дотуур холбоогоор шажигнан дуулдана. "Өмнө зүг рүү ... хурдаллаа ... Пон ду Каруссель гүүрээр дайраад, одоо Сейнийг гаталж байна".

Фааш цонхоор зүүн тийш харвал, нэгэн ачааны тэрэг гүүр даван, Лувраас холдох бөгөөд, ачааныгэвш нийлэг брезентээр хучигдсан нь, холоос дүүжин ор шиг харагдаж байв.

Фааш айдаст автав. Хормын өмнө, энэ тэрэг цонхны доор зогсож байсан байх нь ээ.

Солиотой алхам гэж Фааш өөртөө хэлээд, брезентэн бүрхүүл дор юу байсныг Ландон лав мэдээгүйбайсан даа гэж бодов.

Хэрэв машин төмөр, цемент эсвэл өөр ямар нэг зүйл ачсан бол яах байсан бол? 40 футын өндрөөсшүү. Энэ бол тэнэг явдал.

"Цэг хөдөлсөөр л байна" гэж Коле хэлээд, "Баруун тийш Сэйнт Перес рүү эргэж байна".

Коле ачааны тэргийг хөөх тушаал өгч байх нь дуулав. Үүгээр ингээд бүх зүйл дуусгавар болохыг Фааш сайн мэдэж байв. Түүний хүмүүс хормын дотор тэргийг гүйиэж саатуулна.

Ландон хаашаа ч зугатаж амжихгүй.

Фааш буугаа далд хийж, бие засах өрөөнөөс гараад, Колег холбоогоор дуулав. "Миний машиныгавчир. Баривчилгаа эхлэхээс өмнө, би тэнд очсон байх ёстой".

Фааш Их Галерейн хонгилоор шогших зуураа, Ландоныг амьд гарсан гэдэгт эргэлзэн бодолхийлнэ.

Ахмад шогшсоор ...

Бие засах өрөөнөөс холгүй, 15 ярдын зайтай газар хоёр хүн харанхуйд нуугдан зогсож байв. Тэднийг дөнгөж нуугдаад байтал, ахмад Фааш таславч хананы дэргэдүүр буугаа барин гүйсээр, биезасах өрөө рүү шурхийн орсон билээ.

Хормын өмнөх тэр явдал Ландоны санаанд бүүр түүр орж гарна.

Ландон бие засах өрөөнд өөрийн хийгээгүй хэргийн төлөө оргож зугтахгүй хэмээн цааргалжбайхад, харин Софи цонхонд бэхэлсэн дохиоллын мэдрэгч туузыг ажиглаж байлаа. Дараа ньцонхоор доош харж, гудамжийг сайтар нягталсан аж. "Чи эндээс хялбархан аргаар зугтаж болно".

Хялбархан гэнэ ээ?

Ландон цонхоор доош харав. Цонхны чанх доор зогсох ачааны тэрэгний тэвш гадуураа
брезентэнбүрхүүлтэй байв.

Миний бодож байгааг Софи бодож олоогүй л байгаасай.

"Софи, би яасан ч үсэрч ... чадахг ..."

"Нөгөө дамжуулагчаа гаргаад ир!"

Мэл гайхсан Ландон, халаасаа тэмтэрсээр, металл дискэн гадаргуутай дамжуулагчийг гаргаж ирэв. Софи дамжуулагчийг аваад, угаалтуур руу яаран очив. Бүсгүй гоожуурын дэргэд б айх саванг авч, дээр нь дамжуулагчийг тавиад, эрхий хуруугаараа хүчтэй дарж, доош нь лав гэгч шигтгэв. Дамжуулагч савангийн гадаргууд шигдэн ороход, Софи ил гарсан нүхийг дахин битүүлээд, сайнгэгч далдалж орхив. Дараа нь тэрээр дамжуулагчтай саванг Ландонд өгөөд, угаалтуур доорх хүндтөмөр хогийн савыг гаргаж ирэв. Ландоныг эсэргүүцэхийн завдалгүй, бүсгүй хогийн савыг өмнөөбарьсан чигтээ гүйсээр, савны ёроолоор цонхны шилийг бутартал цохив.

Тэр даруй аваарын дохио хэнгэрэг хагартал хангинаж эхлэв.

"Савангаа нааш нь өг!" гэж Софи хашхирах нь дохионоос арайхийн ялгаран дуулдана. Ландонсавангаа гарт нь бушуухан атгууллаа.

Саванг авангуутаа, Софи цонхоор харагдах "18 дугуйтыг" сайтар ширтэв. Түүний харж байгаа байхангалттай том бөгөөд, барилгын хананаас 10 футын зайтай зогсож байв. Ачааны тэрэг дохиогоосааж хөдлөхөөр завдахад, Софи гүнээр амьсгаагаа аваад, саванг харанхуйн дунд машины зүгчиглүүлэн шидэв. Саванг ачааны тэвшин дээр унах тэр мөчид, машины гэрэл солигдож байв.

"Баяр хүргээрэй!" гэж Софи гэж хэлэнгээ, Ландоныг чирэн, хаалга руу зүглэж, "Ингээд л чи Лувраас зугтчихлаа шүү дээ!"

Тэндээс гарангуутаа, тэр хоёр Фаашийг харахаас өмнө, халхавч хананы сүүдэрт нуугдаж амжжээ.

Аваарын дохио хангинах нь зогсоход, тэртээ гадаах үүдэн дээр цагдаагийн машинуудын дохиозалгуулан хангинаж эхлэв.

Фааш ч бас Эндээс явсан байх. Их Галерей одоо харгалзах хүнгүй болсон.

"Энд, Их Галерейд аваарын нууц гарц байгаа. Одоо харуул, цагдаа нар явчихсан болохоор түүгээргадагш гарч болох байх" гэж Софи хэллээ.

Ландон хариу хэлсэнгүй. Энэ үдшийн турш тэр амаа хамхихаар шийджээ. Учир нь Софи бодсонооснь ч илүү, чөтгөр шиг ухаантай бүсгүй юм гэдгийг Ландон аль хэдийн ойлгожээ.

Хэсэг 19

Парисын хамгийн он удаан жилийн түүхтэй барилга бол Дарь - Эхийн сүм гэж тооцдог. Энд Баптистуудын удирдагчид болох Маркиз Де Саде, Боделаре нар нууцаар орогнож, Виктор Гюгохуримын ёслолоо хийж байсан юм. Мөн эндхийн шашны сургуулиас олон олон гаж сэтгэлгээний урсгал гарч ирсэн бөгөөд нууц, далд бүлгэмүүдийн цуглардаг гол төв нь болж байжээ.

Харин өнөө шөнө сүмийн танхим огг аниргүйн дунд нойрсох бөгөөд, оройдоо асаасан, лааны үнэрарай гарч амжаагүй байлаа.

Сандрин Биеи гэлэнмаа Силасыг сүмд оруулахаар хаалга тайлахдаа, гадна төрхөөс нь айнзогтуссанд, альбино хувраг үүнд огтхон ч гайхсангүй. Силасын төрхөөс айн цочирдоггүй хүнгардаггүй болохоор тэр.

"Чи Америк хүн уу?"

"Би уг нь Францад төрсөн. Дараа нь Испанид амьдарч байсан, харин одоо бол Америкт суралцажбайгаа".

Сандрин гэлэнмаа толгой дохив. Тэрээр намхан нуруутай, зөөлөн харцтай, номхон төрхтэй эмэгтэйбайв.

"Чи Дарь эхийн сүмд ирж байгаагүй гэж үү?"

"Харин одоо л ирж гэм нүглээ цайруулахаар шийдсэн юм".

"Өдрийн цагт бол сүм илүү сайхан харагддаг юм".

"Би бас тэгж бодож байна. Ямартаа ч болов намайг шөнө дөлөөр хүлээн авсанд баярлалаа, эгчминь".

"Эзэн ингэж хүссэн юм. Чи ч нөлөөтэй хүмүүсийг таньдаг бололтой".

Таны төсөөлснөөс ч нөлөөтэй хүмүүсийг би таньдаг гэж Силас дотроо бодов.

Силас Сандрин гэлэнмааг даган, сүм дотуур явахдаа, барилгын доторх уур амьсгал түүнд бараан, хүнд сэтгэгдэл төрүүлэхийг анзаарав. Тэрхэн мөчид сүмийн дотор байдал өнгөлөг зураг, алтадсаниндэр, дулаан өнгөтэй тавилга бүхий Дарь Эхийн сүм гэж танигдахааргүй хүйтэн хөндийхарагдана. Тавилга сэлт бараг тавиагүй нь, танхимыг өргөн цэлгэр харагдуулах бөгөөд, өндөртбосгосон таазны хөндийг ажвал, аварга усан онгоцыг хөмрүүлсэн юм шиг санагдана. Силас энэтөсөөллөө улам лавшруулж бодлоо.

Ахан дүүсийн холбоо энэ хөмөрсөн онгоцны доор бүхнийг нууж дөнгөжээ.

Силас өөрийнхөө ажлыг гүйцэлдүүлэхээр яарахдаа, гэлэнмаа түүнийг хурдан орхиж яваасай гэжтуйлаас хүснэ. Гэлэнмааг цохиж унагахад хялбар боловч, огт шаардлагагүй үед ийм аргахэрэглэхгүй гэж Силас өөртөө тангараглажээ. Эмэгтэй гэлэнмаагийн өмсгөлтэй бөгөөд, нөгөөтээгүүр ахан дүүсийн холбоо энэ сүмд Оньсон чулууг нуух болсонд, хөөрхий Сандринбуруугүй шүүдээ.

Тэр бусдын хийсэн нүглийн өмнөөс шийтгүүлэх ёсгүй.

"Надаас л болж та нойроо хагасалсан гэдэгт миний санаа их зовж байна".

"Тэгж бодоод хэрэггүй ээ. Чи Парисаас удахгүй буцна гэсэн үү? Дарь Эхийн сүмийг үзчихээдбуцна гэдэг сайн хэрэг. Чи сүмийг уран барилга талаас нь, эсвэл түүхэн талаас нь сонирхож ирсэнүү, аль нь вэ?"

"Үнэндээ, би сүсэг бишрэлдээ хөтлөгдөж ирсэн л дээ".

Гэлэнмаа тааламжтайгаар инээмсэглэж, "Тэгвэл аргагүй юм байна. Чи сүмийг хаанаас нь эхэлжсонирхмоор байна?"

Силас сүмийн мөргөлийн индэр лүү ширтэнгээ, "Тэгж үзэх шаардлагагүй байхаа. Та нададхангалттай их тус хүргэлээ. Би өөрөө эндхийг үзчихье".

"Надад энэ төвөгтэй зүйл бишээ. Би тэртэй тэргүй сэрчихсэн шүү дээ".

Силас алхахаа больж зогсов. Тэр хоёр явсаар, танхимын суудлын хамгийн эхний эгнээнд ирчихсэн,индрээс 15 ярд зайтай зогсож байв. Силас нүсэр том биеэ эргүүлж, давжаа биетэй гэлэнмаа руухаргал, тэрээр настай эмэгтэйн эсэргүүцсэн харцтай тулгарав.

"Эгч минь, би бүдүүлэг загнасан хэрэг огт биш. Би энд Бурханы сүмд зүгээр нэг орж ирээд, үзээдгарах гэж ирээгүй. Тийм болохоор би зөвхөн ганцаараа байж залбирал үйлдсэнийхээ дараа, сүмдоторхыг үзэж болох уу?"

Сандрин дотроо эргэлзэнэ. "За яахав, тэгэхээс өөр аргагүй бололтой. Би чамайг танхимын хойдхэсэгт хүлээж байя".

Силас хүнд гараа гэлэнмаагийн мөрөн дээр зөөлөн тавиад, "Эгч минь, би таныг сэрээсэндээ ихгэмшиж байна. Таныг дахин нойргүй удаан байлгахыг хүсэхгүй байна. Та орондоо орсон нь дээр.Би сүмд ганцаараа байж байгаад, өөрөө гараад явчихна". Гэлэнмаа хачин царйлж, "Таныг орхижявбал дургүйцэхгүй юм биз дээ?"

"Үгүй дээ. Залбирал бол ганц хүнд хамаатай ажил"

"Хүссэнээр чинь больё".

Силас гэлэнмаагийн мөрөн дээрээс гараа авч, "Сайхан амраарай, эгч минь. Эзэн тантай хамтбайгаа".

"Чамтай ч бас хүү минь" гээд Сандрин танхимын үүд рүү зүглэв. "Сүмээс гарахдаа гаднах хаалгыгсайн хаагаарай!"

"Тэгнэ ээ!" гээд, Силас түүнийг үдсэн харцаар харна. Дараа нь эхний эгнээнд очиж суугаад, хөлөндөх өргөст бүснийхээ өвдөлтийг мэдрэн залбирч эхлэв.

Бурхан минь, бүх зүйл танаас л шалтгаална ...

Мөргөлийн индэр дээрх тавцан дээр чимээ гаргалгүй гарч ирсэн гэлэнмаа, доор харагдах сэжигтэймөргөлчнийг нүд салгалгүй дээрээс нь ширтэнэ.

Тэрхэн агшинд гэлэнмаа альбиног нөгөө хэлээд байсан заналт дайсан юм болов уу гэж бодов.Хэрэв мөн бол олон жилийн өмнө сонссон заавраа биелүүлэх үүрэг түүнд оногдож байгаа нь тэр.Эмэгтэй сүүдэрт зогсоод, Силасын бүх үйлдлийг алдалгүй ажиглан харж байв.

“Дарь Эхийн сүм”

Хэсэг 20

Сүүдрээс ил гарч ирсэн Софи Ландон хоёр Их Галерейг хүнгүйг мэдээд хонгил өгсөн, аваарынгарцыг чиглэн алхлаа. Тэд яг эвлүүлдэг зурагтай тоглоомоор наадаж байгаа юм шиг Ландонд санагдана. Түүний хувьд, нууцлаг ээдрээт хэрэг явдлын ганц хэсгээс олж мэдсэн зүйл бол Шүүхцагдаагийн ахмад Ландоныг хүний амь хөнөөсөнд буруутгаж байгаа явдал.

"Ахмад өөрөө тэр бичээсийг хийсэн гэж чамд бодогдохгүй байна уу?" гэж Ландон шивэгнэв.

Софи эргэж ч хараагүй чигтээ, "Ингэх боломжгүй". Ландон эргэлзсэн хэвээр, "Тэр намайг гэмтэйгэж үзсээр байгаа юм чинь. Миний нэрийг шалан дээр биччихвэл, баримт нотолгоонд нь хэрэгтэйшүүдээ".

"Фибоначийн дараалал, P.S., Да Винчийн зураг, дарь эх бурхны бэлгэдэл. Энэ бүхэн тэгээд яахболж байна? Өвөөгөөс минь өөр хүн үүнийг бичиж үлдээсэн байж таарахгүй".

Бүсгүйн хэлсэн зөв гэдгийг Ландон ойлголоо.

Бүх бэлгэдэл, тэмдэгтүүд хоорондоо уялдаатай - таван хошуу, Харьцаа, Да Винчи, Дарь эх, бас Фибоначийн дараалал. Үүнийг ямар ч тэмдэгт судлаачид бэлгэдлийн цогц байдал гэж дүгнэхбайсан. Энэ бол маш нягт холбоотой бэлгэдлүүд гэсэн үг.

Ландоны хөмсөг зангидан эргэцүүлнэ.

O, DRACONIAN DEVIL! (ЭЭ, ДОГШИН ЧӨТГӨР!)

OH, LAMA SAINT! (ЭЭ, ДОГОЛОН ГЭГЭЭН!)

Үүнийг тайлбарлаж чаддаг ч бодоосой. Тэгвэл Софи, бид хоёрын аль алины нь хэрэгтэй байна шүүдээ.

"Гарц эндээс холгүй байх ёстой" гэж Софи явдал дундаа шивэгнэв.

"Чи өмнө нь энэ дарааллыг ашиглаад, бичээсийн бусад мөрүүдийг тайлж унших тухай бодож үзсэнүү?" гэж Ландон асуув.

Өмнө нь Виноний гар бичмэлийг судалж байхдаа, нэг мөр нөгөө мөрийнхөө тайлал болжуншигдаж байхыг, олж мэдсэн туршлага Ландонд бий. Тиймээс ч тэр шинжээч бүсгүйгээс ийнхүү асууж байгаа юм.

"Би цифрүүдийн тухай харсан цагаасаа эхлэн бодож байна. Нийлбэр, коэффициент, үржвэр гээд. Гэвч юу ч олж харахгүй байна. Математикийн хувьд бол дугаарууд нь хоорондоо замбараагүй байрлалттай байгаа юм". "Тэгсэн мөртлөө Фибоначийн дарааллыг агуулж байсан. Энэ бүгд утгаучиргүй юм биш үү?" "Үгүй дээ. Англиар бичээсээ үлдээж, өөрийгөө зургаар дүрслээд, Таванхошуу дүрсийг бие дээрээ зурсан шиг, өвөө миний анхаарлыг зориуд татах гэж Фибоначийн дарааллыг бичсэн. Эд бүгд миний анхаарлыг татахын тулд л байгаа юм". "Таван хошуу бас чиний хувьд утгатай гэж бодогдож байна уу?" "Тийм. Өмнө нь чамд хэлэх боломж гараагүй юм. Өвөө бид хоёр намайг бага байхад, Таротын хөзрөөр тоглодог байсан. Миний хамгийн авах дуртай мод нь дээрээ таван хошуутай дүрстэй байсан юм".

Ландон үүнд гайхна.

Тэд Таротаар тоглодог байсан гэж үү?

Ландон энэхүү дундад зуунд хамаарах Италиас гаралтай хөзрийн тоглоомын нууцлаг бэлгэдэл, тэмдэгтүүдийн талаар бүтэн нэг бүлгийг номондоо бичиж оруулсан билээ. Тарот бол Сүмийнхний шахалт хавчлагаас далдаар үлдэж чадсан, нэгэн төрлийн шашингүй үзлийнхний оюун санааны илэрхийлэл байсан юм. Харин одоо мэрэгч, төлөгч нар энэ хөзрөөр үзэж хардаг болсон.

Тэднийг гарцан дээр ирэхэд, Софи хаалгыг аажуухан онгойлгов. Дохио дуугарсангүй. Софи Ландоныг дагуулсаар доош шатаар эрчлэн буулаа.

"Өвөө чинь ..." гэж Ландон амьсгаадан хэлээд, "Чамд Таван хошууны тухай дурсахдаа, дарь эх Бурхан эсвэл католик сүмийнхэнтэй холбоотой зүйл ярьсан уу?"

Софи толгой сэгсэрч, "Би тооны хэл талаас нь илүү сонирхдог байсан. Алтан огтлолын хууль, Фитоо, Фибоначийн дараалал гээд л...".

Ландон гайхаж, "Өвөө чинь чамд Фи тооны тухай ярьж байсан гэж үү?"

"Тэгэлгүй яахав. Алтан огтлолын хуулийг ярьсан" гээд дуу нь төлөв болж, "Үнэндээ өвөө намайг Фи тоо гэж заримдаа хочилж, шоолдог байсан. Энэ нь миний нэрнээс болсон юм". Ландон дотроо эргэцүүлснээ, бүсгүй нэрийг уртаар хэлэв.

С о Фи

Ландон Фи тооны тухай эргэцүүлэн бодлоо. Үнэндээ Сониехын хийсэн үйлдлүүд түүний анхтөсөөлж байснаас ч, гүнзгий агуулгатай байлаа. Да Винчи, Фибоначийн дараалал ... Таван хошуу.

Энэ бүхэн тэгээд эцэстээ ганцхан тулгуур ойлголт болох нэгэн зүйл дээр тогтож байлаа. Ландон чэнэ сэдвийг хэдэн улирлын турш хичээлдээ жишээ болгож заадаг байсан аж.

Энэ бол Фи тоо.

Тэрээр Харвардад заадаг "Урлагийн бэлгэдэл зүй" лекцийнхээ нэгийг нэхэн дурсав.

Танхимд орж ирэнгүүтээ, самбар дээр өөрийн дуртай тоог бичив.

1,618

Ландон танхимаар дүүрэн суух оюутнууд руу эргэн харж, "Энэ ямар учиртай тоо болохыг хэлэххүн байна уу?" Математикийн 3 - р курсийн нэг оюутан гараа өргөж, "Фи тоо" гэлээ. "Сайн байна, Стетнер. Та бүгд Фи тоотой танилц" гэхэд,

"Пи тоотой андуурч болохгүй" гэж Стетнер нэмж хэлээд жуумалзав. "Математикчид бүгд П үсэг Фүсгээр солигдоход, гайхамшиг шинээр төрдөг гэж ярьдаг". Ландон үүнийг сонсоод инээсэн ч, өөрхөн ч Стетнерийн хошигнолыг ойлгосонгүй.

Стетнер чавга шиг улайчхав.

"Энэ Фи тоо буюу, 1.618 гэдэг тоо бол урлагт маш чухал үүрэг гүйцэтгэдэг. Яагаад гэдгийг хэлэххүн байна уу?"

Стетнер хэцүү байдлаас өөрийгөө гаргах гэж хичээн, "Яагаад гэвэл, энэ бол маш гоё тоо" гэж бүрэнитгэлтэйгээр хэлэв.

Үүнийг сонссон оюутнууд танхимд тэр аяараа инээлдэв.

"Үнэндээ, бас л Стетнерийн зөв. Фи тоо бол энэ ертөнц дээрх хамгийн төгс тоо".

Бүгд инээлдэхээ больж, харин Стетнер хамраа шантайлгав. Удалгүй Ландон слайдтай проектороосааж, Фи тоог Фибоначийн дарааллаас үүдэлтэй гэдгийг ярина.

Фибоначийн дарааллын аливаа цифр нь өмнөх 2 цифрийнхээ нийлбэртэй тэнцүү байхаас гадна, дараалал өгсөх тусам цифрийг өмнөх цифрт харьцуулахад, Фи тоо буюу 1,618 гэсэн тоонд хязгааргүй дөхөж очдог гэж тэрээр тайлбарлав. Фи тоо зөвхөн тооны талаасаа ч бус, байгальд чөргөнөөр тохиолдог бодит илэрхийлэл болсон тоо юм. Ургамал, амьтан, хүн гээд бүгд л Фи тоонд захирагдаж, Фи Харьцаанд оршиж байдаг.

"Байгальд байдаг Фи тооны ..." гээд Ландон гэрлийг унтрааж, "... тохиолдлыг тоочоод баршгүй. Тиймээс эрт үед хүмүүс Фи тоог Ертөнцийн эзэн зохиосон гэж хүмүүс үздэг байсан. Тэр үеийн эрдэмтэд 1,618 тоог Алтан огтлолын хууль гэж нэрлэдэг байж".

"Байзаарай," гэж урд эгнээнээс нэгэн эмэгтэй оюутан түүний үгийг таслан хэлээд, "Би биологийн чиглэлээр сурдаг. Гэхдээ Алтан огтлолын хуулийг байгаль дээр оршдог гэдгийг өмнө нь огтдуулаагүй юм байна". "Агуулаагүй гэж үү?" гэж Ландон жуумалзаад, "Чи зөгийн үүрэн дэх эр, эм зөгийн тооны харьцааны тухай мэдэхгүй гэж үү?"

"Мэдэлгүй яахав. Эм зөгий нь эрээсээ үргэлж илүү тоотой байдаг".

"Зөв. Тэгвэл чи энэ дэлхий хаана ч, аль ч зөгийн үүрэн дэх эр, эм зөгийн тоог хооронд нь харьцуулахад нэг ижил тоонд дөхөж очдогийг мэдэхгүй гэж үү?"

"Та үнэнээсээ хэлж байна уу?"

"Тиймээ. Фи тоо".

Оюутан эмэгтэй уулга алдаж "Үгүй байлгүй дээ!"

"Тийм байлгүй дээ!" гэж Ландон дор нь хариулаад, проектор дээрээ өөр нэгэн слайд

харуулж, "Үүнийг таньж байна уу?"

"Далайн залхаг. Өөрөөсөө хий ялгаруулж усан дотор хөвж явдаг".

"Зөв. Тэгвэл чи тэдний гуурсны диаметр нөгөө гуурсынхтай ямар тоогоор харьцдаг гэж бодож байна?"

Эмэгтэй будлисан төрхтэй слайд руу ширтэнэ.

Ландон толгой дохиж. "Фи тоо. Алтан огтлолын хууль. 1,61 8".

Оюутан охин бүр мэл гайхжээ.

Ландон дараагийн слайдаа тавихад, дээр нь наран цэцгийн үрийн зураг байв. "Энд бас л нэгэн Харьцаа байдаг. Та нар юу гэж бодож байна?"

"Фи тоо" гэж танхим байсан оюутнууд бүгд нэгэн зэрэг хэлэв.

"Бинго!" гэж Ландон хэлээд, слайдаа хурдтай сольж эхлэв. "Цэцгийн дэлбээ, ургамлын ишин дэхнавч, шавьжны харьцаа. Энэ бүгд Алтан огтлолын хууль". "Энэ бол гайхамшиг" гэж хойд эгнээнээснэг оюутан орилов.

"Тийм ээ!" гэж өөр нэг оюутан дэмжээд, Гэхдээ Фи тоо урлагтай яаж холбогддог юм бэ?" үргэлжлүүлэн асуув.

"Аан, тэр үү? Асуусанд баярлалаа" гээд Ландон Да Винчийн туурвисан нүцгэн хүний алдарт зургийг слайдан дээрээ үзүүлэв.

"Харьцаа". (Vitruvian Man)

Да Винчи энэ зургийг Де Архитектура хэмээх өгүүлэлдээ Алтан огтлолын хуулийн тухай анххөндөж бичсэн, Ромын уран барилагч Маркус Витрувцуст зориулсан юм.

"Хүний биеийн бүтцийн харьцааг Да Винчигээс илүү ойлгодог хүн үгүй. Гэрээр хүний ясны бүтцийг судлахын тулд хүний цогцсыг анх" задлан шинжилсэн. Ингэснээр анх хүний бие махбодбол нарийн тогтолцооноос бүтсэн, тэр тусмаа Фи тоог агуулсан гэдгийг хүн төрөлхтөнд нээж харуулсан юм".

Танхим тэр чигтээ нам гүмд автав.

"Надад итгэхгүй байгаа юм уу?" гэж Ландон тулган асуугаад, "Та нар тэгээд дараа нь шүршүүртороходоо өөрсдийгөө хэмжиж шалгаарай л даа".

Хөл бөмбөгийн багийн тоглогч, хоёр оюутан залуу пис хийтэл инээлдэв.

"Зөвхөн та хоёр ч биш" гэж Ландон сануулаад, "Та нар бүгд. Эрэгтэй, эмэгтэйн аль аль нь шалгаадүзээрэй. Шалнаас зулай хүртлээ хэмжээд гарсан тоог, хүйс хүртэл хэмжээд гарсан тоонд харьцуулаарай. Та нар ямар тоо гарахыг таа даа".

"Фи л биш шүү" гэж нэг оюутан өөртөө үл итгэсэн дуугаар хашхирав.

"Тиймээ. Фи. 1,61 8. Би өөр жишээ хэлэх үү? Мөрнөөсөө хурууны үзүүр хүртлээ хэмжээд гарсан тоог, тохойноос хурууны үзүүр хүртэлх уртад харьцуулбал, бас л Фи тоо гарна. Өөрийг бас! Ташаанаас дооших уртыг, өвдөгнөөс доошид харьцуулбал мөн л Фи тоо. Хурууны үе, хөлний хуруу. Энэ бүгд Фи, Фи, Фи. Найзуудаа! Та нар бүгд Алтан огтлолын хууль дээр бүрэлдэн оршиж байгаа гэдгээ ойлго".

Энэ үед танхим харанхуй байсан ч, Ландон оюутнуудыг гайхшралд бүрэн автсаныг зөнгөөрөөмэдэрч байв. Танхимд тэр чигээрээ дулаан уур амьсгал бүрдэж эхлэв. Ландон үүний төлөө эндзогсоод, энэ бүхнийг ярьж байгаа шүү дээ.

"Найзуудаа, энэ ертөнц дээр учир утгагүй зүйл гэж бодсон бүхэн чинь үнэндээ далд утгаагуулгатай байдаг юм. Хүмүүс Фи тоог анх нээчхээд, Бурхны өмнө өвдөг сөгдөн, Байгаль эхээшүтэн бишрэх болсон юм. Та нар яагаад гэдгийг удахгүй ойлгоно. Учир нь одоо ч шашингүй үзэлбуюу эх дэлхийгээ шүтэх үзэл оршсоор байгаа. Бид шашингүйн үзлийнхэнтэй адил зан үйл хийдэгмөртлөө тэрийгээ анзаарч мэддэггүй.

5-р сард тэмдэглэдэг Хаврын баяр бол үүний тод жишээ. Энэ бол үнэндээ эх дэлхий маань амьдралцэцэглүүлэхээр буцан ирснийг баярлан угтаж байгаа хэрэг.

Урлаг бол бүхнийг цогцлоогч эх дэлхийн бүтээсэн гоо үзэсгэлэн, төгс төгөлдрийн тусгал болохоорбид энэ улирлын турш Алтан огтлолын хуультай холбоотой маш олон зүйлийг судалж мэдэхболно".

Үүний дараа, хагас иагийн турш Ландон оюутнуудад Микеланжело, Албрехт, Аюрер, Да Винчиболон бусад алдартнуудын бүтээлд Алтан огтлолын хууль хэрхэн тусгалаа олсон тухай ярьжбайлаа.

Ландон мөн Грекийн Партеныг, Египетийн пирамид болон Нью - Йорк дахь НҮБ - ын удирдлагынтөвийн барилга Фи тоонд үндэслэсэн тухай өгүүлэв. Аебюсси, Шубертийн уран бүтээлд ч энэ тоонэвт шингэсэн гэж ярина. Хийл урлаач Страйдизарцус ч мөн адил Фи тооны Харьцааг ашигланөөрийнхөө хийлүүдийг хийж байжээ.

"Одоо гол зүйл рүүгээ оръё!" гээд Ландон самбар дээр нэгэн дүрс зурав. Огтлолцсон 5 шулуунаасбүтсэн Таван хошуу дүрс байлаа.

"Энэ бол улирлын туршид хамгийн чухалд тооцогдох дүрс, тэмдэг байгаа юм.Таван өнцөгт эсвэл,Таван хошуу гэж нэрлэдэг, энэ дүрсэд ид шид бодоод, шүтлэг бишрэл нэвт шингээстэй байдаг.Яагаад гэдгийг надад тайлбарлах хүн байна уу!

Энэ удаад Стетнер бас л гараа оргов. "Учир нь энэ дүрсийн нэг талыг зурахад, бусад аль ч шулууннь түүнийг Фи тооны Харьцаатай хоёр хэсэгт хуваадаг".

Ландон түүнийг бахархан, толгой дохиж, "Маш сайн. Тиймээ, Фи тоогоор бүх тал нь хуваагдаж,дүрс тэр чигээрээ Алтан огтлолын хуулийн илэрхийлэл болж чаддаг. Ийм л учраас, Таван үзүүртэйэнэ од гоо үзэсгэлэн, төгс төгөлдрийн дээд болсон эмэгтэй хүний бэлгэдэл болдог юм".

Оюутан охидын царай нь гэрэлтээд ирэв.

"Хүүхдүүдээ, та нарт ганц зүйл хэлье. Өнөөдөртөө би Да Винчи ганцхан бүтээлийг товчхондурдаад өнгөрлөө. Гэхдээ энэ улирлын турш түүний бүтээлийнталаар хангалттай их ярилцахболно. Леонардо бол дарь эх Бурхантай холбоотой их зүйлийг хойч үедээ үлдээсэн, гавья агай хүн.Маргааш би та бүхэнд түүний хамгийн гайхамшигтай ур чадвараар бүтэж, бас эмэгтэй хүнийгмагтан дүрсэлсэн, "Нууцат үдэш" зургийг үзүүлж тайлбарлах болно".

"Та тоглож байгаа биз дээ? "Нууцат үдэш" дээр зөвхөн Есүс болон түүний эрэгтэй шавь

нарыг лдүрсэлсэн байдаг шүү дээ".

Ландон нүдээ ирмээд "Та нарын төсөөлж байгаагүй, тэр зүйлд үнэхээр зарим нэгэн зүйлдалдлагдаж хоцорсон байдаг".

"Түргэлээрэй!" гэж Софи шивнээд, "Яасан бэ? Бид бараг ирчихлээ шүүдээ. Хурдлаач!"

Ландон бодлоосоо салж, түүн рүү харав. Тэр хоёр аль хэдийнээ шатны төгсгөл дээр ирээд, барилгаас гарахад бэлэн зогсож байв.

O, DRACONIAN DEVIL! (ЭЭ, ДОГШИН ЧӨТГӨР!)

OH, LAMA SAINT! (ЭЭ, ДОГОЛОН ГЭГЭЭН!)

Софи түүн рүү эргэж харахад, бичээс тийм хялбар зүйл биш байна гэж Ландон бодно. Луврын музейн доторх Фи тоо, Да Винчийн дүрслэл хоёр түүний бодол санаанд эргэлдэнэ. Ландон санаандгүй байж байгаад, Сониехийн кодыг тайлснаа ухаарав.

O, DRACONIAN DEVIL! (ЭЭ, ДОГШИН ЧӨТГӨР!) OH, LAMA SAINT! (ЭЭ, ДОГОЛОН ГЭГЭЭН!) Энэ чинь хялбархан код байна шүү дээ!" гээд, Ландон баярласандаа хашхирах шахав.

Софи түүн рүү сандарсан байдалтай харна.

Код гэсэн үү?

Бүсгүй бүхэл шөнийн турш бичээсийн тухай бодохдоо, тэнд код байхыг олж хараагүй билээ.

Тэр тусмаа хялбархан код гэнэ үү?

"Чи өөрөө энэ тухай надад хэлсэн шүү дээ!" гэж Ландоныг хэлэхэд, түүний дуу нь шатны хоосонхонгилоор цуурайтав. "Фибоначийн дараалал дахь цифрүүдийг зөв байрлалтай болгосон хойно л, утгатай харагддаг. Харин бусад үед утгагүй харагддаг гэж чи хэлсэн шүү дээ".

Софи түүний юу яриад байгааг ойлгосонгүй. Фибоначийн дараалал?

Дарааллыг бичсэн нь, бүсгүйг хүрч ирээсэй гэсэн өвөөгийнх нь хүсэл байсан гэж Софи бодож байсан юм. Тэр гэрэл зургийг халааснаасаа гаргаж, өвөөгийнхөө бичээсийг дахин уншив.

13-3-2-21-1-1-8-5

O, DRACONIAN DEVIL! (ЭЭ, ДОГШИН ЧӨТГӨР!)

OH, LAMA SAINT! (ЭЭ, ДОГОЛОН ГЭГЭЭН!)

P.S. Find Robert Landon! (Жич: Роберт Ландоныг ол!)

"Фибоначийн дараалал бол гол гогцоо нь" гэж хэлсэн даруйдаа, Ландон зургийг авч хараад, "Энэ цифрүүдийн тусламжтайгаар бусад мөрүүдийг тайлж уншиж болно. Өвөө чинь цифрүүдийг замбараагүй байрлалтай бичсэн болохоор, доорх мөрүүдэд байгаа үгийн үсгүүдийг мөн адил замбараагүйгээр бичсэн байж таарна. O, DRACONIAN DEVIL! (ЭЭ, ДОГШИН ЧӨТГӨР!) OH, LAMA SAINT! (ЭЭ, ДОГОЛОН ГЭГЭЭН!) Энэ үгс ямар ч утгагүй

байгаа биз. Учир ньүсэгнүүдийн байрлалыг сольсон байна".

Түүний хэлснийг Софи дор нь ойлгов. Нээрээ тун хялбар байж шүү.

"Чи тэгээд бичээсийг анаграмм гэж хэлэх гээд байна уу?" гэж Софи нягтлан асуув.

Кабеллагийн хичээлд анаграммыг "Их урлаг" хэмээн нэрлэж байсан удаатай.

Ландон Софи руу удаанаар ширтээд, "Өвөө чинь бидэнд бүхнийг тодорхой хэлээд өгсөн байна шүүдээ!"

Ландон өөр үг хэлэлгүй, үзгээ гаргаж, бичээсийн хоёр мөрийн үгэнд орсон үсгүүдийг сэлгэж эхлэв.

О, DRACONIAN DEVIL! ОН, LAMA SAINT! эцэстээ **Leonarda Da Vinci! Mona Lisa!** гэсэн үгийн төгс анаграмм байв.

Мона Лиза.

Хэсэг 21

Софи шатан дээр зогсонгоо, Лувраас гарах тухайгаа ор тас мартсан байв. Бүсгүй анаграммаар бичигдсэн үгийг тайлж чадаагүйдээ, туйлаас ичиж байлаа. Өвоогийнхөө англиар бичсэн, анаграммыг мэргэжилтэн бүсгүй олж харж болохоор байсан юм.

Өвөө нь түүнийг бага байхад нь англи үгтэй ойр болгохын тулд анаграмм зохиодог байв. Нэг удаа англиар "planets" гэж үгийг бичээд, түүнд орсон 7 үсгийг давтахгүйгээр, 62 өөр үг дахин бүтээж болохыг хэлж билээ. Софи түүнийг нь шалгаж, англи хэлний толь бичгийг бүтэн 3 өдөр эргүүлж байж, бүх үгийг олж байсан юм.

"Би ерөөсөө ойлгохгүй байна" гээд Ландон гэрэл зураг руу ширтэнгээ, "Өвөө чинь тийм давчуухугацаанд яаж ийм төгс анаграмм бүтээж чадав аа?"

Софи үүнд хариулж чадах байсан ч, өөртөө гутарч байлаа. Би үүнийг олж харж болох байсан шүүдээ. "Өвөө Мона Лизагийн энэ анаграммыг олон жилийн өмнө хийсэн байх" гэж хэлээд, бүсгүй Ландон руу ширтэв. "Өнөө орой үүнийгээ хэрэглэхээс аргагүй байдалд орсон байх".

Софигийн өвөө нь бүсгүйн араас дуудах шиг болно. "Леонардо! Мона Лиза!"

Өвөөгийн үлдээсэн гэрээс үг яагаад алдарт зургийн нэртэй холбоотой байгаа юм бол?

Ганц л бодод түүний толгойд эргэлдэнэ. Эдгээр үгийн утга зөвхөн үүгээр дуусаагүй гэдгийг Софи ойлгож байлаа.

Арай Мона Лизагийн ард ямар нэг зүйл нуусан юм биш биз? Тийм болох нь гарцаагүй байжтаарлаа.

Харин алдарт зураг Сал Дес Эта танхимын хананд өлгөөтэй байгаа. Гэвч өвөөгийнхөө цогцосныд эргэдүүр өнгөрч байж л, зурагт хүрэхээ Софи сая ухаарав.

Их Галерейн бүх гарц хаагдсан учир, ганцхан төмөр хаалтыг сөхсөн тэр хэсгээр Мона Лиза руухурч болно. Өвөө үхэхээсээ өмнө, Мона Лиза дээр очсон байх магадлалтай шүү дээ.

Софи шатны голд гацчихав. Бүсгүй Ландоныг эндээс түргэн гаргах хэрэгтэй ч, эргэлзэх нь ихсэв.

Бага байхад нь, өвөө нь түүнийг Денон жигүүрээр дагуулж явахдаа, нэгэн нууц дэлгэсэн нь, "Болзож уулзахад, хамгийн тохиромжтой газар бол Мона Лизагийн хөргийн өмнө юм шүү

дээ!" гэж аминчлан хэлж байсныг бүсгүй гэнэт санав.

"Хоёулаа удахгүй тэнд очно" гэж өвөө нь хэлээд, бяцхан охины гараас хөтлөн, хүнгүй танхимааралхална. Софи тэр үед 6 настай байсан. Өндөр тааз руу ширтсэн чигтээ, бяцхан охин сүрдсэн

төрхтэй урагш алхана. Хэдийгээр охинд хоосон музей аймшигтай санагдсан ч, энэ тухайгаа өвөөдөө мэдэгдэхийг хүссэнгүй.

"Эндээс Сал Дес Эта эхэлж байна" хэмээн, өвөө нь Луврын алдарт танхимд дөнгөж оронгуугаа ачохиндоо хэллээ.

Өвөөгийнх нь царайд баясал тодрон байхад, харин ач охин нь гэртээ харихыг тэсгэлгүй хүсчбайлаа. Бяцхан охин Мона Лизагийн зургийг өмнө нь номноос харахад, тийм ч их шохоорхлыг ньтөрүүлээгүй юм. Яагаад хүмүүс энэ зургийг гайхан шагшдагийг, бяцхан охин тэр үед ойлгоогүйажээ.

"Уйтгартай байна!" гэж Софи амандаа бувтнана.

"Уйтгартай гээч!" гэж өвөө нь залруулаад, "Гэртээ англиар, сургуульдаа Францаар" гэжанхааруулав.

"Лувр манай гэр биш шүү дээ!" гэж охин эсэргүүцэв.

Өвөө нь арайхийн инээмсэглээд, "Тийм ээ. Чиний зөв. Одоохондоо англиар ярьж болно биз дээ".

Софи хошуугаа унжуулаад, цааш дагаж алхав.

Түүний өвөө Салле Де Этатсын баруун талын хананд голлуулан өлгөсөн, тэр зураг руу чиглэночив. "Явъя. Софи. Хэр баргийн хүнд энэ зургийг ганцаараа үзэх боломж олддоггүй юм шүү!"

Айдсаа дарж ядах Софи өрөөний голоор аажуухан алхана. Софи догдлон дөхсөөр, доор нь ирээдхарвал түүний бодож байсан шиг мэдрэмж огт торсонгүй. Гайхан шагших, бишрэн хүндэтгэхмэдрэмжийн аль нь ч байсангүй. Зураг яг номон дээрх шигээ харагдана. Охин ямар нэг зүйл хүлээхмэт хэсэг зогсов.

"Чамд ямар санагдаж байна даа!" гэж өвөө нь шивэгнээд, ард нь ирчихсэн зогсож байв. "Үзэсгэлэнтэй байгаа биз?"

"Жижигхэн юм аа".

Сониех инээмсэглэж, "Чи ч бас жижигхэн, гэхдээ үзэсгэлэнтэй шүү дээ".

Би үзэсгэлэнтэй бишээ гэж охин дотроо эсэргүүцэв. Софи өөрийнхөө улаан хүрэн үсэнд үнэхээрдургүй, бас тэгээд ангийнхаа хөвгүүдээс том биетэйгээс ээ үргэлж ичдэг байв. Охин Мона Лизагхарснаа, толгой сэгсэрч, "Тэр номон дээрхээсээ ч муухай харагдаж байна. Царай нь..."

"Бүдэг" гэж өвөө нь англиар зааж хэлэв.

Софи тэр үгийг давтаж хэлэхээс нааш, яриа үргэлжлэхгүйг ойлгоод, "Бүдэг" гэж чангаар давтанхэлэв.

"Энэ бол зураг зурах аргын нэг төрөл. Үүнийг сурахад тун хэцүү. Харин Леонардо Да Винчи үүндбусдыг дагуулахааргүй сайн суралцсан байсан юм".

Софид зураг таалагдахгүй хэвээрээ байв. "Сургууль дээр хүүхдүүд юм нууц лахаараа ингэжцарайлдаг. Түүнтэй адил тэр нэг нууц зүйл мэддэг юм шиг харагдаад байна".

Өвөө нь инээж, "Ийм л учраас зураг алдартай болсон юм. Хүмүүс түүнийг яагаад инээмсэглэжбайгааг таахыг оролддог юм".

"Тэр яагаад инээмсэглээд байгаа юм бэ?"

"Магадгүй," гээд өвөө нь нүдээ ирмээд, "Би хожим чамд энэ тухай хэлэх байх" гэв.

Софи хөлөөрөө шал дэвсэж, "Та өөрөө юм нуухад дургүй гэдэг биз дээ?"

Гүнжхэн минь гээд Сониех инээмсэглэж, "Амьдрал нууцаар дүүрэн байдаг юм. Чи бүгдийг нь нэгдөр мэдэж чадахгүй шүү дээ"

"Би дээшээ буцах хэрэгтэй!" гэж Софи шатан дээрээс хүйтэн хөндий дуугаар өгүүлэв.

"Мона Лиза руу юу?" гэж Ландон айж ширвээтэн асуугаад, "Одоо юу?" гэв.

Софи гарах эрсдэлийг аль хэдийнээ тооцсон байлаа.

"Би бол сэжигтэн биш. Тийм болохоор энэ боломжоо ашиглах хэрэгтэй. Өвөө надад юу гэжхэлснийг би эцэст нь мэдэх хэрэгтэй байна".

"Элчин сайдын яам руу явах яах вэ?"

Софи Ландоныг оргож босуулчихаад, одоо болохоор орхиж явах болсондоо өөртөө гэмшиж байв. Гэвч бүсгүйд өөр сонголт байсангүй.

Софи хаалга руу зааж, "Энэ хаалгаар нэвтрээд, гарах тэмдгийг дагаад яваад байгаарай. Өвөө нададэнэ гарцыг зааж өгсөн юм. Гаднах хашааны үүдэнд чамайг очиход, хаалга нь өөрөө дотроосоонээгдэнэ" гээд Ландонд машиныхаа түлхүүрийг өгч, "Улаан өнгөтэй, жижиг оврын машин зогсоолдээр байгаа. Чи ЭСЯ руугаа яаж хүрэхээ мэдэж байна уу?"

Ландон толгой дохингоо, гарт нь атгуулсан машины түлхүүрийг харна.

"Сонс доо," гэж хэлэхдээ, Софигийн дуу зөөлөрч, "Өвөө Мона Лизагийн ойр орчимд өөрийг ньалсан хүнийг илчилсэн, зүйлийг нуусан бололтой. Эсвэл яагаад намайг аюулд өртөх гэж байгааг сануулсан байж магад. Миний гэр бүлийн талаар ч юм билүү. Би очиж үзэх хэрэгтэй байна".

"Хэрэв тийм байсан юм бол өвөө чинь яагаад шууд шалан дээр бичээгүй юм бэ? Яагаад иймтөвөгтэй код сонгосон юм бол?"

"Өвөө минь надад юу ч үлдээсэн байлаа, түүнийг нь надаас өөр хүн мэдэх ёсгүй байсан байх. Цагдаа нар ч мөн адил мэдэх ёсгүй байж. Хачин сонсогдож байж магадгүй ч, би Мона Лиза дээрөөр хэн нэгнээс өмнө амжиж очих ёстой".

"Би хамт явна аа."

"Болохгүй ээ! Их Галерейн харуул хамгаалалт удахгүй эргээд сэргэнэ. Чи эндээс явах ёстой!"

Ландон хэдийгээр бүсгүйд тусалж, хамт явмаар санагдавч, Фаашийн гарт өөрөө яваад орчих юмшиг түүнд бодогдоно.

"Одоо яв" гэж Софи дур булаам инээмсэглэн хэлээд, "ЭСЯ - н дээр уулзъя, ноён Ландон!"

ГЭВ.

Ландон үүнийг сайшаасангүй, "Би зөвхөн ганцхан нөхцөлөөр л чамтай тэнд уулзах болно" гэж хариулахад, дууны өнгөнд нь шийдмэг байдал цухалзана.

"Ямар нөхцөлөөр?" гэж Софи асуув.

"Та намайг ноён Ландон гэж дуулахаа больсон нөхцөлд!"

Софи Ландоны царай дахь итгэлтэй төрхийг сайтар ажиглаад, инээмсэглэхээ больж, "Амжилтхүсье, Роберт!" гэв.

Ландоныг "гарц гэсэн тэмдэг дээр ирэхэд, нэгэн үнэр хамарт нь цоргив. Хонгилоор доош уруудажявахдаа, тэрээр шөнийн турш өөрийгөө зүүдэлж байгаа гэдэгт итгэх шахна. Тэр Лувраас оргодол, босуул болоод зугтаж явна гэж зүүдэлж ч байгаагүй билээ. Сониехийн бүтээсэн төгс анаграммтүүний санаанд одоо ч байсаар л байв.

Софи Мона Лиза дээр хүрчихсэн болов уу, ямар нэг зүйл олсон болов уу?

Өвөө нь түүнийг Мона Лиза дээр дахин очихыг хүсч байсныг, бүсгүй эцэст нь ойлгосон юм.

Өөрөө өөртэйгөө зөрчилдөхөд хүргэсэн тэр үг Ландоны толгойд эргэлдээд байв.

P.S. Роберт Ландоныг ол!

Сониех Ландоны нэрийг бичиж үлдээгээд, түүнийг олохыг Софид сануулсан байсан. Яагаад?

Ямар боловч Ландон бүсгүйд кодыг тайлахад тусалж чадна гэж бодсон юм болов уу? Гэхдээ тэгжболох шалтгаан байгаагүй шүү дээ.

Ландоныг анаграммд мэргэжсэн гэдгийг Сониех үнэндээ мэдэхгүй шүү дээ. Түүнтэй өмнө нь огтуулзаж байгаагүйгээс гадна, Софи өөрөө ч кодыг тайлж чадах шүү дээ.

Софи л Фибоначийн дарааллыг олж, бас тэр эрчээрээ кодыг тайлж болох л байсан.

Тэгэхээр намайг яагаад энэ бүхэнд оролцуулах болов? Намайг юуг мэднэ гэж Сониех бодсон юмбол?

Тэр санаандгүйгээр гэнэт зогсож, халаасанд нь гэрэл зураг байгааг анзаарав. Сониехийн бичсэнүгийн сүүлчийн мөрийг тэр анхааралтай ширтэнэ.

P.S. Find Robert Landon! (Софи гүнжид, Роберт Ландоныг ол!)

Тэр зөвхөн 2 үсгийг дахин дахин уншиж байв.

P.S. (Софи гүнжид)

Сониехийн бичээс тэрхэн мөчид түүний санаанд тодрон үзэгдэж, өнөө шөнийн турш гарах гээдгарч ирэхгүй байсан, тэр санаа Ландоны толгойд зурсхийн үзэгдлээ. Ландон бодлоо гүйцэхээрмэрийж, санаагаа төвлөрүүлнэ. Удалгүй тэрээр ирсэн зүг рүүгээ буцаж эргэлээ.

Хугацаа алдана шүү дээ? За, энэ ямар ч хамаагүй.

Ландон эргэлзэлгүй тэр чигтээ шат өгсөн, дээш хурдаллаа.

Хэсэг 22

Мөргөлийн танхимын урд эгнээнд сөхрөн суугаад, мөргөж буй Силас худал дүр эсгэн, залбиралүйдэнгээ, сүмийн доторхыг нүднийхээ булангаар ажиглан, эргэн тойрныг чих тавин чагнаархана.

Суудлуудын голоор гаргасан өргөн чөлөө болон, эгнээний голоор хөндлөн явсан зай хоёрхоорондоо огтлолцсон нь, сүмийн гол амин сүнс, нууцлаг байдлын төлөөлөл юм. Дарь эхийнсүмийн эргэн тойронд нууц хадгалсан юм шиг санагдана.

Түүний гарт алагдсан, хүмүүсийн заасан газрыг Силас эцэст нь олж харлаа.

Тэнд байна.

Саарал чулуун шалаар хучигдсан, тэрхэн зурвас газрыг алтадмал өргөн зураас дайран өнгөрчээ. Тэрхүү зураас дээрээ хөндлөн судлуудтай байгаа нь, яг л шугамын хув Дарь шиг харагдана. Силасын дуулснаар бол, үүнийг 9 толгой гэх бөгөөд, өөрөөр шашингүй үзлийнхний нарны цаг гэж тайлбарладаг аж. Жуулчид, эрдэмтэн судлаачид, шашингүй үзлийнхэн бүгд л энэхүү зураасыг харахын тулд, Дарь Эхийн сүмийг зорьж ирдэг юм.

Сарнай судал.

Силасын өмнүүр өнгөрсөн, тэрхүү судлыг альбино баруунаас зүүн тийш төгсгөлийг нь дуустал, дагуулан харав. Мөргөлийн индрийг дайран өнгөрсөн, энэ судал сайхан царайн дээрх ташуурын сорви шиг харагдана. Судал Сүмийн барилгыг хөндлөнгөөр нь хоёр тэнцүү хуваан явсаар, нэгэн газарт тулж очсон байв. Энэ бол Египетийн дурсгал хөшөө байлаа.

Ахан дүүсийн холбоо Сарнайн судлыг дагуулж, Оньсон чулууг нуусан байх нь гэж Силас дотроободлоо. Силас Дарь эхийн сүмд Оньсон чулууг нуусан тухай Багшид хэлэхэд,

"Чи үнэн хэлж байна уу?" гэж багш эргэлзсэн байдалтайгаар асуусан билээ.

Харин дараа Сарнайн судлыг дагуулан нуусан гэдгийг сонсонгуутаа, тэрээр уулга алдсан юм.

Багш Силаст сүмийн онцлог байдлыг дэлгэрэнгүй тайлбарлаж өгсөн ажээ. Түүний одоо харж байгаа, тэр зүйлийг дурдахаас гадна, нарны туяа өдрийн цагт цонхоор нэвт тусч, сүмийн ханыг гэрэлтүүлэхэд, тэрхүү судлын тусламжтайгаар нар буцаж байгааг, эсвэл ирж байгааг мэдэж болдгийг хэлсэн юм.

Хэдэн зууны турш, Сарнайн судал газрын зурагт ертөнцийн зүгийг тодорхойлж байсан нь, саяхан мэт санагдана. Луужин Сарнайг дайрсан уртрагийг дэлхийн бөмбөрцгийн голдоч буюу хойд, өмнөд туйлыг тодорхойлоход ашиглаж байсан аж. Иймээс Сарнайн судлыг зарим хүмүүс тэгуртраг гэж нэрлэж байжээ.

Харин одоо бол голдочийг Английн Гринвич гэж тэмдэглэдэг. Үүнээс өмнө бол тэг уртрагийг Парисаар дайруулан татаж тэмдэглэдэг байсан гэсэн үг. Бүр Дарь эхийн сүмээр дайруулж татсанажээ. Үүний дурсгал болгож Сарнайн судал сүмд үлдэж хоцорсон нь одоо ч ач холбогдлоо алдалгүй, жуулчдын нүдийг хужирласаар байгаа юм.

Сониехийн хэлснээр, Прайорийнхан Оньсон чулууг Сарнайн доор нуусан гэдэг цуу үг үнэн болж таарах нь.

Силас сүмийг тойруулан, хэн ч байхгүй гэдгийг нягтлан шалгасаар ...

Гэнэт дээд талын дууллын тавцан дээр юм хөдлөх шиг болов. Тэр зүг харсан боловч хэн ч байсангүй.

Би ганцаархнаа байна.

Силас мөргөлийн индэр лүү хандаж, гурван удаа сөгдөв. Дараа нь Силас зүүн тийш эргэж, судлыгдагасаар, хөшөөг чиглэн алхлаа.

Энэ мөчид, Леонардо Да Винчийн нэрэмжит Ромын нисэх онгоцны буудал руу явж байсан, машиннь гэнэт донслоход, Арингароза зүүрмэглэж байснаа гэнэт сэрчхэв. Түр ч гэсэн нойр авсандаа, тэрээр сэтгэл ханамжтай байх аж.

"Бенвенито А Рома" онгоцны буудлын зарлагчын хоолой хангинах нь сонсогдов. Арингароза босч, кассокоо тэнийлгээд, тэр бүр тохиолдоод байдаггүй инээмсэглэлийг нүүрэндээ тодрууллаа. Энэбол түүний хувьд тааламжтай аялал байлаа.

Би удаан хугацаанд сүүдэрт дайрууллаа. Олоо харин бүх зүйл өөрчлөгдөх цаг нь болсон.

5 сарын өмнө Арингароза хэцүү байдлаас гарах гэж амь тэмцэн байсан билээ. Бурхан эцэст нь түүнийг таалан соёрхжээ. Өнөөдөр Парис дахь ажил хэрэг бүтэмжтэй болвол, Арингароза Христийн эзэнт гүрэн дэх хамгийн нөлөөтэй хүн болж чадах байлаа.

Хэсэг 23

Софи Сал Дес Эта танхимын гадна ирчихсэн зогсож байлаа. *Дотор нь Мона Лиза байгаа.*

Бүсгүй тийш орохоос өмнө, 20 - иод ярдын зайд хэвтэж байгаа өвөөгийнхөө цогцос руу төмөр торнызавсраар харна. Гэнэт түүнийг гэмшил харуусал, уй гуниг бүрхэх шиг болов.

Өнгөрсөн 10 жилийн турш өвөө нь түүнтэй холбоо тогтоож уулзахыг хүссэн захиа илгээж байсан боловч тэр бүрт нь Софи татгалзаж, захидлыг нь шүүгээнийхээ буланд аваачаад хураачихдаг байсан юм.

Өвөө намайг хуурсан! Жихүүдэс хүрэм зүйлийг нууцалж байсан! Би харин яах байсан гэж?

Ингээд л тэр өвөөгөөсөө холдсон. Бүрмөсөн.

Харин одоо түүний өвөө нь нас барсан. Гэхдээ үхсэн ч үгээ хэлсээр л байлаа.

"Мона Лиза".

Софи танхимын том хүрэн, модон хаалгыг онгойлгон дотогш оров. Өрөөнд улаан гэрэл асах учир бүх зүйл маш бүдэг харагдана. Сал Дес Эта бол Их Галерейн төв хэсгээс алслагдсан, мухар буланд байдаг танхим билээ. Зөвхөн энэ л хаалгаар танхимд нэвтэрч бас гарна. Үүдний яг өөдөөс харсан хананд Ботичеллийн зураг өлгөөтэй харагдана. Түүний доор нь II хэлбэртэй буйданг музей сонирхогчдыг амрахад зориулан тавьжээ.

Софид нэг зүйл дутуу юм шиг санагдана. Энэ бол лазер тусгалтай гэрэл.

Тэрээр Их Галерейн голд хэвтэх өвөөгийнхөө цогцсыг хараад, хэрэв өвөө нь шалан дээр үл үзэгдэх тодруулагчаар бичсэн юм бол энд ч бас түүнийгээ хэрэглэсэн л байж магад гэж болов. Гүнзгий амьсгаа аваад өвөөгийнхөө цогцос байгаа зүгт явлаа. Өвөөгийнхөө төрхийг харахаас зайлсхийн, шинжээчийн багажаар дүүрсэн дэргэдэх ширээ рүү нь дөхөж очив.

Тэндээс жижиг тусгалтай лазерүзгийг олоод, бушуухан эргэж, Сал Дес Эта руу алхлаа. Түүнийг Сал Дес Этагийн үүдэнд тулжочтол, танхим дотор хэн нэгний хөлийн чимээ сонсогдов.

Энд хүн байгаа бололтой.

Улаан гэрлийн тусгалд хүн цочирдмоор, нэгэн дүрс гэнэт гарч ирэв. Софи огло үсрэн хойш алхав.

"Чи энд байсан юм уу!" гэх Ландоны сөөнгөтсөн дуу сонсогдов.

Ландон түүний өмнө ирчихсэн зогсож байв. Софи тэр дороо тайвширч,

"Роберт, би чамайг эндээс яв гэж хэлсэн шүү дээ! Хэрэв Фааш чамайг

"Чи хаана байсан юм бэ?"

"Би лазер тусгалтай гэрэл хайгаад," гэж бүсгүй шивэгнээд, гар дахиа үзүүлэв. "Хэрвээ өвөө бичээсүлдээсэн байвал гэж бодоод ..."

"Софи, намайг сонс!" гээд Ландон бүсгүйг гүн цэнхэр нүдээрээ ширтэж, "P.S. гэсэн үсгүүд чамдөөр утгатай юм шиг санагдахгүй байна уу? Ямар нэгэн өөр зүйлийг хэлж байгаа гэж?"

Гол танхимд тэдний дуу цааш цуурайтахаас болгоомжилж, Софи Ландоныг үүднээс холдуулан, дотогш оруулаад, үүдний хаалгыг зөөлхөн хаав.

"Би чамд P.S. гэдэг бол Софи гүнж гэсэн үгний товчлол гэж хэлсэн шүү дээ!"

"Тэгсэн л дээ. Гэхдээ чи ийм үсгүүд өөр ямар нэгэн газар байхыг харсан уу? Өвөө чинь эдгээрүсгийг ямар нэг байдлаар өөр зүйлд хэрэглэж байхыг харсан уу? Хувийн тэмдэглэл, эсвэл өөр ямарнэгэн зүйлд ...?"

Энэ асуулт Софид нэгийг сануулав. Роберт энэ тухай яаж мэддэг билээ?

Софи үгийн товчлол хэлбэрээр бичсэн P.S. гэсэн дүрсийг өмнө нь харж байсан удаатай. Энэ болохины 9 насны төрсөн өдрийн өмнөх орой байлаа. Бяцхан охин гэрийнхээ бүх хогшлыг нэгжиж, өөрт нь нуусан бэлгийг олох гэж чармайж байсан юм.

Өвөө энэ жил надад юу өгөх бол? гэсээр ханын шүүгээ, шургуулга бүрийг нягтлан үзнэ.

Миний дуртай хүүхэлдэйг авсан болов уу? Хэрвээ авсан бол, хаана нуусан юм бол?

Бүх өрөөг нэгжсэний эцэст, ганц өрөө үлдсэн нь өвөөгийнх унтлагын өрөө байв. Өрөөнд охиныгтэр бүр орохыг зөвшөөрдөггүй ч, өвөө нь тэр үед доод давхрын буйдан дээр зүүрмэглэж байсан аж.

Би маш хурдан шалгаад л, өрөөнөөс гарчихна.

Охин өлмий дээрээ гэтсээр, хувцасны харанхуй өрөөг онгойлгоод, тавиурын дээрхийг сайтаражиглав. Юу ч байсангүй. Дараа нь орон доогуур шагайж үзэв. Бас л байсангүй. Шүүгээ рүү очижнүд бүрийг нь аажуухан онгойлгож үзэв.

Энд л надад зориулсан, бэлэг байх ёстой.

Хамгийн доод нүдийг үзэхэд ч, түүний хүлээж байсан хүүхэлдэй нь гарч ирсэнгүй. Оролдлого нь бүтэлгүйтсэнд, гутарсан охин доод нүдэнд байсан хар хувцсыг санамсаргүй таттал, буланд нь нэгалтадмал өнгөтэй зүйл харагдав. Гэхдээ өвөө нь ийм зүйл

хэрэглэдэггүйг охин сайн мэднэ. Юу гээчзүйл болохыг мэдэх гэхээс охин маш ихээр догдолно. Хүзүүний зүүлт байлаа. Софи зүүлтийгболгоомжтой гаргаж ирэв. Гэтэл огт санаандгүй зүйл болж, зүүлтэнд алтан түлхүүр оосорлонуяжээ. Гялалзсан өнгөтэй хүнд түлхүүр байлаа.. Тэр ийм онцгой түлхүүрийг өмнө нь огт харжбайсангүй. Ихэнх түлхүүр хавтгай хэлбэртэй, шүд нь ирмэгээ дагасан байрлалттай байдаг болхарин энэ түлхүүр гурван ирмэг бүхий, бүх талаа тойрсон хувилуудтай байв. Түлхүүрний толгой нь

хэрээс тэмдэгний дүрстэй, гэхдээ энгийн бус, тэгш хэмтэй, яг л нэмэх тэмдэг шиг харагдах аж. Хэрээсийн гол хэсэгт угалзлуулж бичсэн үсэг харагдах нь P.S. гэсэн байв.

"P.S" гэж хөмсөг зангидан, шивэгнэх шахам уншив. *Энэ юу вэ?*

"Софи!" гэх дуу охины ард, үүлний дэргэдээс сонстов.

Охин цочиж, эргэж харахдаа түлхүүр шалан дээр, тасхийтэл унагачихлаа. Тэрээр унагасан түлхүүрлүүгээ гөлрөөд өвөөгийнхөө царай руу харж зүрхэлсэнгүй.

"Би төрсөн өдрийнхөө бэлгийг хайгаад.." гэж духаараа харан хэлээд, өвөөгийнхөө итгэлийг галдсандаа гэмшсэн царайлна.

Өвөө нь үүдэнд чимээгүй зогссоор л байв. Тэгээд эцэст нь уртаар шүүрс алдаад, "Түлхүүрээ буцааж ав, Софи!"

Софи түлхүүрийг шалан дээрээс авав. Өвөө нь дөхөж ирээд, "Софи, бусдын нууцыг чи хүндлэххэрэгтэй".

Тэр охины өмнө өвдөглөн суугаад, түлхүүрийг гараас нь авав.

"Энэ түлхүүр бол маш онцгой эд. Үүнийг алдвал ..." гээд өвөө нь дуугаа хураасанд, Софи машихээр гэмшиж, "Намайг уучлаарай, өвөө! Би маш их харамсаж байна. Би үүнийг надад бэлэглэх гэж байгаа юм байх гэж бодсон юм".

Өвөө нь түүнийг хэсэг ширтэж байснаа, "Би чамд дахин хэлье, Софи. Учир нь энэ бол маш чухал. Чи бусдын нууцыг хүндэлж байх ёстой".

"Ойлголоо, өвөө".

"Энэ тухай дараа дахин ярилцана. Харин одоо цэцэрлэгийн хогийн ургамлыг түүх хэрэгтэй байна".

Ингэж хэлсэн даруй Софи дэвхцэн гүйж одов.

Маргааш өглөө нь төрсөн өдрөөрөө охин бэлгэнд юу ч авсангүй. Тэр өөрөө буруутай байсан тул, ингэнэ гэж таамаглаж байсан юм. Охин ор луугаа урамгүйхэн орохоор, хөнжлөө сөхтөл, дэрэн дээр нь ил захидал тавьсан байв. Ил захидал дээр хялбархан оньсого бичсэн байх аж. Оньсогыг уншиж эхлэнгүүтээ л, бяцхан Софи хариуг нь олчхов.

Би үүнийг мэднэ шүү дээ. Өвөө энэ оньсогыг Зул сарын баяраар таалгаж өгч байсан. Эрдэнэсийн эрэлд, урагшаа!

Онсьсогыг таангуугаа, охин байшингийн нөгөө өнцөг рүү чавхдав. Тэнд очтол бас нэгэн ил захидалолов. Ийм байдлаар байшингийн бүх өрөөг гүйцээв. Эцэст нь сүүлчийн онсьсогын хариуны дагуу, охин өөрийнхөө өрөөнд орж ирээд хартал, өрөөний голд цагаан туузаар ороосон, улаан өнгөтэй, дэгжин унадаг дугуй тавьсан байлаа. Софи баяр хөөрөөр бялхаж байв.

Өвөө нь өрөөний буланд зогсож байснаа, "Би чамайг хүүхэлдэйд дуртайг чинь мэднэ. Гэхдээ үүндилүү баярлах байх гэж бодлоо".

Дараагийн өдөр, өвөө нь ач охиндоо дугуй унахыг зааж өгсөн билээ. Тэд цэцэрлэг дотор өдөржингөө цагийг хөгжилтэй нь аргагүй өнгөрөөсөн билээ.

"Өвөө!" гээд Софи өвөөгөө хүзүүдэн тэвэрч аваад, "Би түлхүүрийн тухайд танаас дахиж уучлал хүсч байна" гэв.

"Өвөө нь мэднэ ээ, хонгорхон минь. Би чамайг уучилсан. Би чамд уурлаж чаддаггүй шүү дээ. Ачохин, өвөө хоёр бие биенийгээ хэзээд уучилдаг юм".

Софи хэдийгээр энэ тухай асууж болохгүйг мэдэх боловч, тэсэлгүй, "Өвөө, тэр түлхүүрээр юонгойлгодог юм бэ? Би тийм түлхүүр огт харж байгаагүй. Маш гоё түлхүүр байсан, өвөө" гээдасуучихлаа.

Өвөө нь хэсэг хариу хэлсэнгүйд, Софи түүн рүү хартал, тэр юу гэж хариулахаа мэдэхгүй байгаабололтой, "Түүгээр олон нууц байдаг нэг хайрцгийг онгойлгодог юм".

Софи хошуугаа цорвойлгож, "Би нууцыг үзэн яддаг".

"Тиймээ. Би мэднэ. Гэхдээ энэ бол чухал нууц байгаа юм. Хэзээ нэгэн цагт чи энэ бүхнийг надаа силүү ойлгох болно".

"Би дээр нь байсан цэцгийн дүрстэй үсгийг харсан".

"Тиймээ. Тэр бол миний дуртай цэцэг байгаа юм. Флеурделис. Манай цэцэрлэгт ч ургадаг шүү дээ.Цагаан өнгөтэй. Орчуулбал, Сараана гэж хэлдэг".

"Би ч бас мэднэ ээ. Би бас дуртай".

"Одоо тэгвэл чамтай тохиролцоно оо!" гэж өвөө нь хэлээд, охиныг туршихдаа гаргадаг байнгынзуршил болох хөмсгөө өргөснөө, "Хэрэв чи түлхүүрийг нууцалж чадаад, дахин энэ талаар юу ч,хэнд ч дахин хэлэхгүй гэвэл, өвөө нь чамд түлхүүрийг хэзээ нэгэн цагт өгч болох л юм".

Софи чихэндээ итгэсэнгүй. "Нээрээ юу?"

"Тийм ээ, өвөө нь амлаж байна. Цаг нь ирэхээр түлхүүр чинийх болно. Дээр нь чиний нэр байгаагчи анзаарсан уу?"

Софи хөмсгөө зангидан, "Тийм байх ёсгүй. Дээр нь P.S. гэж бичсэн байсан шүү дээ. Миний нэрнийтовчлол P.S. биш шүү дээ".

Өвөө нь дуугаа намсгаж эргэн тойрон харснаа, "За яахав, Софи. Энэ P.S гэдэг бол код гээд чийолгочих, энэ бол чиний нэрний нууц товчлол" гэхэд охины нүд орой дээрээ гарч, "Миний нэрнийнууц товчлол гэнэ ээ?"

"Тэгэлгүй яахав. Бүх өвөө ач охиддоо нууц нэр өгдөг юм".

"Тэгээд минийх P.S. юм уу?"

Өвөө нь охиныг гижигдэж, "Энэ чинь Софи гүнж (Princesse Sophie) гэсний товчлол байхгүй юудаа".

Охин хөхөрч, "Би гүнж биш шүү дээ!" гэж арайхийн хэлэв.

Өвөө нь нүдээ ирмээд, "Чи бол наддаа гүнж л гэсэн үг".

Энэ өдрөөс хойш ач охин, өвөө хоёр түлхүүрийн талаар ганц ч удаа дурсаагүй билээ. Харин охинөвөөгийнхөө хувьд, Софи гүнж болсон юм.

Сал Дес Эта дотор Софи чимээгүй зогсоно.

"Тэр товчлолыг чи өмнө нь харсан уу?" гэж Ландон бүсгүй рүү харангаа шивнэж асуув. Софигийнчихэнд өвөөгийнх нь шивнэх дуулдах шиг болов.

"Түлхүүрийн тухай битгий дурс, Софи!"

Софи өвөөгийнхөө итгэлийг өмнө нь нэг удаа алдсан болохоор, дахин алдаа гаргахыг хүссэнгүй.

П.С. Роберт Ландоныг ол.

Ландон надад туслахыг өвөө хүссэн шүүдээ.

Софи эцэст нь толгой дохиж, "Тийм ээ би товчлолыг нэг удаа харсан, бүр бага байхдаа".

"Хаана тэр вэ?"

Софи эргэлзэж байснаа, "Өвөөгийн чухал юмаа хадгалдаг газарт" гэж хариулав.

Ландон түүний нүд рүү харж, "Софи, энэ чинь дэндүү бүрхэг байна. Товчилсон үсгүүд ямар нэгэндүрстэй хамт байхыг чи харсан уу? Сараана цэцгийн дүрс ч юм уу?"

Софи гайхсандаа хойш ухарч, "Гэхдээ... чи энэ тухай яаж мэддэг юм бэ?"

Ландон санаа алдаж, дуугаа намсгаад, "Өвөө чинь нууц бүлэглэлийн гишүүн байсан гэдэгт биэргэлзэхгүй байна. Энэ бол маш эртний бүлэглэл буюу ахан дүүсийн холбооны бэлгэдэл байгааюм".

Софигийн зүрх донсолж байлаа. Тэр ч бас өвөөгөө ингэж боддог байсан юм. 10 жилийн турш, бүсгүй харсан, бүх зүйлээ мартахыг хичээж байсан юм. Бүсгүй тэр үед төсөөлшгүй, уучилшгүйзүйлийг нүдээр харж гэрчилсэн билээ.

"Сараана цэцгийн дүрс P.S. үсгүүдтэй цуг байвал, энэ нь Ахан дүүсийн холбооны чухал зүйл гэсэнүг. Тэдний өмсгөл, лого бүгд ийм хэлбэрээр дүрслэгддэг".

"Чи энэ тухай яаж мэддэг юм бэ?" гэж Софи асуухдаа, Ландоныг бас тэр бүлэглэлийн гишүүн ньбитгий байгаасай гэж дотроо залбирна.

"Би энэ бүлэглэлийн талаар судалж байсан юм" гэж хэлэхдээ, Ландоны нүд сэргээд ирэв. "Нууцбүлэглэлийн бэлгэдлийг судлах нь миний гол чиглэл байгаа юм. Тэр бүлэглэлийнхэн өөрсдийгөөСионий Прайори гэж нэрлэдэг. Сионий Прайоричууд энд, Парист төвлөрч, Европ даяар нэрнөлөөтэй, хүчтэй хүмүүсийг эгнээндээ элсүүлж, гишүүнээрээ авдаг. Үнэн хэрэгтээ, тэдэн шигудаан хугацаанд нууцаар оршин тогтнож байгаа, бүлэглэл дэлхийд өөр хаана ч байхгүй".

Софи энэ тухай огт сонсоогүй ажээ.

Ландон цааш дуржигнуулж, "Сионий Прайорийн гишүүдээс хамгийн алдартай нь Ботичелли,Исаак Ньютон, Виктор Гюго гэх мэт хүмүүс байсан" гээд түр зогсож, зориуд анхаарал татах гэжхэрэглэдэг тэр л аргаараа дуугаа намсгаж, "Бас Леонардо Да Винчи" гэж нухацтайгаар, үгээ зөөнхэлэв.

Софи гайхаж, "Леонардо Да Винчи нууц бүлэглэлд байсан юм уу?"

"Өвөөгийн чинь шүтдэг энэ хүн 1510 - 1519 оны хооронд Сионий Прайорийн тэргүүн байсан юм. Танай өвөө, Да Винчи хоёр түүхэн бүлэглэлтэй холбоотой гэдгээрээ ижил төстэй. Тэгээд ч тэрхоёрын сонирхдог чиглэл нь бас ижил. Дарь эхийн бэлгэдэл, шашингүйн үзэл, сүмийн эсрэг үзэл

бодол гэх мэт. Сионий Прайори бол эх хүнийг тахин шүтэх шашингүйн үзэлд тулгуурласан бүлэглэл байгаа юм".

"Өөрөөр хэлбэл, энэ бүлэглэл шашингүйн үзэл чиглэлийг баримталдаг гэж чи хэлэх гээд байна уу?"

"Тиймээ, энэ урсгалыг баримталдаг нь үнэн. Гэхдээ хамгийн гол зүйл нь тэд маш эртний, нандиннууцыг сахин хамгаалах үүрэг хүлээж анх байгуулагдсан юм. Энэ нууц нь тэд нийг хэмжээлшгүй хүчирхэг болгосон юм".

Софи эхэндээ ярьсан бүх зүйлийг тусгаж авахад, бэлэн байсан бол одоо үл итгэсэн байдал түүнээс илэрнэ.

Нууц шашны урсгал ч гэх шиг. Леонардо Да Винчи тэргүүн нь байсан ч гэх шиг.

Бүх зүйл утгагүй хийсвэр мэт түүнд санагдаад явчлав. Бүсгүй 10 жилийн өмнө харах ёсгүй байсан зүйлийн гэрч болсноо нэхэн саналаа.

Миний тэр үед харсан зүйл арай энэ бүхэнтэй холбоотой ...?

"Сионий Прайорийн гишүүд өөрсдийгөө маш нууцалдаг. Гэхдээ чиний харсан Сараана цэцгээрдүрслэгдсэн P.S. гэсэн үсгүүд Сионий Прайоритай нягт холбоотой".

Ландон өвөөгийнх нь талаар түүнээс ч илүүг мэдэж байгааг, Софи сая л ойлгов.

Түүнтэй санаа боллоо хуваалцаж болох ч, одоо, энд биш.

"Би чамайг баригдаасай гэж хүсэхгүй байна, Роберт. Бидэнд ярилцах цаг гарна. Харин одоо чиэндээс явах хэрэгтэй".

Ландон зөвхөн бүсгүйн ам хий хөдлөхийг л харав. *Би хаашаа ч явахгүй.*

Түүний сэтгэл санаа нь өөр газраар аялж байлаа. Эртний нууцыг илрүүлж болох тэр л газраас, түүний төсөөллөөс Ландоныг олж болохоор байв. Ландон маш удаанаар толгойгоо эргүүлж, улаангэрлийн дунд сүүмийн харагдах, Мона Лиза руу ширтлээ.

Сараана цэцэг. . . Лизагийн цэцэг. . . Мона Лиза.

Энэ бүхэн хоорондоо нягт уялдаатай байв.

Сионий Прайори болон Да Винчийн давтагдашгүй хослол болсон чанд нууц тэнд л байх ёстой.

Тэндээс хэдэн милийн цаана, голын эргийн зам дээр будлиж, учраа олохгүй болсон ачааныг тэрэгний жолооч цагдаагийнхны шаардлагаар зогсоод, буугаар чичлүүлэн байж, гараа өргөн машинаасаа буулаа. Цагдаа нар машиныг баахан нэгжиж, эцэст нь дамжуулагчийг саван дотроосолоод, бачимдахдаа саванг Сейн мөрөн рүү чулуудчихав.

Хэсэг 24

Силас дурсгал хөшөө рүү ойртохдоо, түүний өмнөх гантиг чулуун суурийг нүд цавчилгүй ширтэнэ. Түүний баярласан нь, байн байн зангирч буй булчингаас нь илэрхий мэдрэгдэнэ.

Тэр эргэн тойрноодахин харж, өөр хүн байгаа эсэхийг нягтлав. Дараа нь хөшөөний өмнө өвдөглөн суусан нь, биширсэндээ бус ингэх хэрэгтэй учраас тэр аж.

"Онъсон чулуу Сарнайн судал дор байгаа. Сүмийн дурсгал хөшөөний суурин дотор" гэж Ахандүүсийн тэргүүлэгч гишүүд бүгд нэгэн дуугаар баталсан билээ.

Силас өвдөг дээрээ суусан чигтээ, чулуун суурин дээр ямар нэгэн ан цав, завсар хайсан боловчбайсангүй. Тэгэхээр нь хуруугаараа чулуун хавтан бүрийг зөөлөн тогшиж, доор нь хөндий байгааэсэхийг шалгав. Бүх хавтанг шалгаж үзлээ. Гэтэл нэг нь бусдаасаа арай өөр дуутай сонсогдох ньтэр.

Энэ доор хөндий байна!

Силас инээмсэглэж, түүний гарт үхсэн хүмүүс үнэнийг хэлсэнд баярлана. Дээш босч, хавтангхагалах зүйл хайн, ийш тийш эргүүлдэн харав.

Дууллын тавцан дээр зогсох, Сандрин гэлэнмаа амьсгал нь давхцан бүхнийг дээрээс ажиглажбайлаа. Түүнийг зөвхөн харанхуй сүүдэр л Силасаас халхалж байв.

Энэ бол хуурамч дүр эсгэсэн этгээд байна! Опус Дейн мөргөлчин гээд байгаа энэ хүн өөрзорилготой ирсэн байжээ! Тэр тусмаа нууц зорилготой. Чи ганцаараа нууцтай нь биш шүү! гэжгэлэнмаа эгдүүцэн бодов.

Сандрин Биеи гэлэнмаа бод сүмийн сахиулаас гадна, өөр үүрэг хүлээсэн хүн. Харин одоо болтэрхүү далд үүрэг нь ил гарах цаг нь болсныг эмэгтэй ухаарав. Хөшөөний дэргэд ямар нэгэнсэжигтэй зүйл хийхээр завдаж байгаа, энэ этгээдийг ахан дүүсийн холбоонд мэдэгдэх хэрэгтэйгэдгийг тэр өөртөө сануулав.

Хэсэг 25

Парис дахь АНУ - ын ЭСЯ бол Чампс - Элизээс хойд зүгт, Габриэлийн өргөн чөлөөнд оршдогтомоохон цогцолбор газар билээ. 3 акр бүхий энэ талбайд зөвхөн АНУ - ын хууль үйлчилнэ.Элчингийн шөнийн ээлжийн лавлахын ажилтан Тайм сэтгүүл уншиж байтал, утас дуугарч, түүнийгтасалдуулав.

"Америкийн Нэгдсэн Улсын Элчин Сайдын яам" гэж лавлахын ажилтан эмэгтэй хариулав.

"Оройн мэнд!" хэмээн утастсан хүн хариу хэлэх нь, бага зэрэг Франц аялгатай сонсогдоно. "Би нэгзүйл лавлах хэрэгтэй байна". Ингэж хэлсэн эрэгтэй хүний дууны өнгө найрсаг гэхээсээ илүүалбаны байдалтай сонсогдоно. "Танай автомат хариулагч дээр надад зурвас үлдээсэн гэж нэг хүндамжуулсан юм. Миний нэрийг Ландон гэдэг. Харамсалтай нь би зурвасыг сонсох 3 оронтой нууцдугаараа мартчихаж. Та надад тусалбал, маш их баярлахсан".

Лавлахын ажилтан түр эргэлзэж будлиад, "Уучлаарай, ноёнтоон. Танд үлдээсэн зурвас тэгвэлнэлээд дээр үед манайд ирсэн байх. Учир нь аюулгүй байдлын үүднээс тэр үйлчилгээг манай яам 2жилийн өмнө зогсоосон шүү дээ. Тэгээд ч 3 биш 5 оронтой нууц дугаартай байсан. Танд зурвасүлдээсэн байна гэж элчингээс хэлсэн юм уу?"

"Танайд одоо автомат хариулагчийн систем байхгүй юм уу?"

"Үгүй ээ, эрхмээ. Танд зурвас байгаа бол гараар бичиж үлдээсэн хувилбар л энд байх

ёстой. Танынэрийг хэн гэлээ?"

Гэвч нөгөө хүн утсаа тасалчхав.

Бэзу Фааш Сейн мөрний эрэг дээр толгой нь эргэчихсэн зогсож байв.

Ландоныг дугаараа цуглуулж, 3 оронтой нууц дугаар хийгээд, зурвас сонсож байхыг, яах аргагүй 2нүдээрээ харсан л юм даа. Хэрвээ Ландонэлчин рүү яриагүй юм бол, өөр хааш залгасан байжтаарах вэ?

Фаашийн асуултад түүний гар утас хариулж чадахыг ахмад удалгүй анзаарав. Ландон минийутсаар гадагш дуудлага хийсэн шүү дээ!

Тэрээр утасны цэсийг нээж, Ландоны гадагш залгасан дугаар хадгалагдсаныг, жагсаалтаас олжхарлаа.

Парисын утасны дугаарын араас 454 гэсэн цифрүүд гарч ирэв. Гарч ирсэн дугаарыг дахинцуглуулж, утастлаа. Утас дуудаж эхлэнгүүт, эмэгтэй хүний дуу гарч,

"Бонжүү вү сэт бизн ше Софи Нөвү," (Сайн баана уу! Та Софи Нөвүтэй холбогдлоо) гэсэн бичлэгсонсогдсоноо, цааш нь "Же сүй сабсонт по ле момун, май" (Одоохондоо би эзгүй байна. Гэхдээ та...) гэв.

Фаашийн уур хилэн буцлан оргилж, тэр даруй 454 гэсэн нууц дугаарыг утсандаа орууллаа.

Хэсэг 26

Хэдийгээр Мона Лизагийн хөрөг зураг маш алдартай бүтээл боловч, эх хувилбар нь 31x24 инчийнхарьцаатай жижигхэн зураг юм. Энэ бол Луврын музейд худалдаалдаг хуулбар зургаасаа ч багахэмжээтэй гэсэн үг. Энэ зургийг Сал Дес Этагийн баруун хойд талын хананд хамгаалалтын зузааншилний цаана өлгөсөн байдаг. Да Винчи зургаа сфумато аргаар зурсан нь түүнийг бүдэг, тодорхойбус юм шиг харагдуулдаг юм.

Мона Лиза буюу Францчуудын нэрлэдгээр, Ла Жаконде Луврын музейд тавигдсанаасаа хойш, хоёрч удаа алдагдаж байжээ. Хамгийн сүүлд 1911 онд Луврын Де Салон Каррегаас хулгайлагдсанд, Парисчууд бүх нийтээрээ харамсаж, зургийг музейд эргүүлэн өгөхийг хулгайчаас гуйж байжээ. Үүнээс 2 жилийн дараа, Флоренцийн нэгэн зочид буудлаас Мона Лиза олдсон аж.

Ландон Софиг орхиж явахгүйгээ ойлгуулахын тулд, Сал Дес Эта дотор бүсгүйг даган алхана. МонаЛиза дээр очиход, хориод ярд хэртэй газар үлдсэн ч, Софи эртнээс лазер тусгалтай гэрлээ асааж,урьдаас бэлдлээ. Түүний асаасан, гэрэл тэдний өмнөх замыг нь гэрэлтүүлнэ. Бүсгүй гэрлийг ийшгийш тусган, өрөөний хаа нэгтээ бичсэн зүйл байх вий гэж шалган нягтлах аж.

Ландон хананд суурилуулсан зузаан шилийг эцэст нь олж харлаа. Түүний цаана дэлхий дээрхамгийн алдартай уран зураг өөрийн өнгө төрхөө илэрхийлсэн чигтээ өлгөөтэй байлаа.

Мона Лизагийн урлагийн ертөнц дэх нэр хүнд нь түүний нууцлаг инээмсэглэлд оршдог гэдгийгЛандон мэднэ.Түүний энэ нууцыг урлагийн түүх судлаачид болон сонирхогчид, олон талаартайлбарласаар л байгаа. Мона Лизагийн алдартай болсон учир нь, Леонарда Да Винчи

энэхүүбүтээлдээ өөрийн авьяас чадварыг дээд зэргээр шингээсэн гэж өөрөө дахин дахин баталснаасүүдэлтэй. Тэр энэ зургийг хаа явсан газраа авч явдаг байсан ба, энэ тухай нь асуухад, "Эмэгтэйхүний гоо үзэсгэлэнг илэрхийлсэн энэ зүйлийг биенээсээ салгаж үнэхээр чадахгүй байна" гэжхариулдаг байжээ.

Мона Лиза бол үнэндээ дэлхий дээрх хамгийн ёгт утгатай бүтээл билээ.

"Өвөө энд байсан байна" гэж Софи өвдөг дээрээ сууж хэлээд, лазер тусгалтай гэрлийг зүймэлмодон шалан дээр тусгалаа.

Ландон эхлээд юу ч харсангүй. Бүсгүйн дэргэд суугаад, доош хартал, нэгэн хатсан зүйлийн толбогэрэлд үзэгдлээ. Бэх юм болов уу гэж бодтол, үнэндээ цус байлаа.

Софигийн зөв байж, Жак Сониех үхэхээсээ өмнө, Мона Лиза дээр зочилсон байжээ.

"Өвөө энд шалтгаангүйгээр ирэх ёсгүй" гэж Софи хэлэнгээ, дээш босч, "Энд надад бичээс үлдээсэнбайх ёстой" гэв.

Бүсгүй Мона Лиза руу түргэн гэгч алхаж очоод, шалан дээр гэрлээ тусгалаа. "Энд юу ч алга!"

Тэр агшинд, Ландон хамгаалалтын зузаан шилэн дээр нэг зүйл тодорч гялбахыг анзаарав. Тийшдөхөж очингоо, Софигийн бугуйнаас шүүрч аваад, толбо харагдсан тэр зүг рүү гэрлийг тусгав.

Тэд хоёулаа зогтусав. Шилэн дээр Мона Лизагийн нүүрний яг харалдаа 6 үг бичсэн нь ягаан өнгөтөдруулаад, гялалзан үзэгдэх ажээ.

Хэсэг 27

Сониехийн өрөөнд сууж байсан, дэслэгч Коле сонссон зүйлдээ итгэсэнгүй.

Би Фаашийг зөв сонссон байгаа?

"Саван дотор байсан гэнэ ээ. Ландон яаж байгаад дамжуулагчийг олоод мэдчихдэг байна аа?"

"Софи Нөвү түүнд энэ тухай хэлсэн байна".

"Юу гэнэ ээ? Яагаад тэр вэ?"

"Харин тэрийг чинь л мэдмээр байна. Гэхдээ би сая нэг зурвасын бичлэг сонссон. Тэр бичлэг дээрСофи Ландонд заавар өгсөн байна билээ".

Колед хэлэх үг олдсонгүй. Нөвү юугаа бодож ингэсэн юм бол? Ахмад Фааш ажиллагаагаа явуулжбайгааг, Софи мэдээгүй юм байх даа! Одоо ч тэр халаглах байтугай, шоронд орох биз.

"Гэхдээ ахмад аа, Ландон одоо хаана байгаа юм бэ?"

"Аваарын дохиолол одоо ажиллаж байгаа юу?"

"Үгүй".

"Тэгвэл Их Галерейн гарцаар хэн нэг нь гарсан уу?"

"Үгүй, тэнд Луврын хамгаалагч зогсч байгаа. Та өөрөө ингэ гэж тушаасан шүү дээ!"

"За, сайн байна. Тийм бол Ландон Их Галерей дотор байх ёстой".

"Энд үү? Тэр одоо энд юу хийж байхав дээ!"

"Луврын хамгаалагч зэвсэгтэй байгаа юу?"

"Тийм ээ, эрхэм ээ. Тэр зэвсэгтэй байгаа".

"Түүнийг Их галерей руу, дотогш нь оруул" гэж Фааш тушаагаад, "Би одоохондоо наана чинь шуудхүмүүсээ явуулж чадахгүй нь. Тэр хооронд Ландон гадагш зугтахыг, би хүсэхгүй байна. Бас тэрхамгаалагчид Ландонтай цуг Софи Нөвү хамт байгааг хэлсэн нь дээр байх".

"Софи Нөвү явчихсан байлгүй дээ".

"Чи Нөвүг явахыг хоёр нүдээрээ харсан юм уу?"

"Үгүй ээ, эрхмээ. Гэхдээ ..."

"Түүний явахыг хэн ч хараагүй. Зөвхөн түүнийг орж байхыг харсан байна".

Коле, Софи Нөвүгийн гаргасан этгээд үйлдэлд гайхширч, Тэр энд байсаар л байгаа гэж үү? гэжбодов.

"Хэлснийг гүйцэтгэ!" гэж Фааш тушаагаад, "Намайг буцаж очиход Ландон Нөвү хоёрыг барьсанбайхыг, би хүсч байна".

Ачааны тэрэг цааш хөдлөхөд, ахмад Фааш хүмүүсээ цуглуулав. Нөвүгийн туслалцаатайгаар,Роберт Ландон энэ шөнө нэлээд төвөг удаж байгаа боловч, булан руу улам шигдэж байгаагаа,өөрөө ч төсөөлөхгүй байлаа. Ахмад хүмүүсийнхээ талыг Лувр руу явуулж, харин үлдсэн хэсгийг ньРоберт Ландоны орогнож болох, хэд хэдэн газруудад илгээлээ.

Хэсэг 28

Сал Дес Этагийн дотор Ландон шилэн дээрх 6 үгийг гайхшаа баран ширтэж байлаа.

"Прайори!" гэж Ландон шивэгнээд, "Өвөө чинь үнэхээр Прайорийн гишүүн байжээ".

Софи түүн рүү гайхан харж, "Чи энийг ойлгож байгаа юм уу?"

"Энэ чинь харахад л ойлгомжтой байна шүү дээ!" гэж хэлээд, Ландон толгойгоо дохингоо, "Энэбол Прайорийн үндсэн ойлголтын нэг байна".

Софи, Мона Лизагийн нүүрэн дээр сүүдэр тусган бичигдсэн тэр бичээсийг уншив.

So Dark The Con of Man! (Библийн ишлэл)

"Прайорийн гол үзэл бол эртний Христийн сүмийн хүчирхэг, нөлөө бүхий эрчүүд эмэгтэй хүнийнэр хүндийг уландаа гишгэж, эрэгтэй хүнийг тахин шүтэх үзлийг дэлхий даяар нэвтрүүлж, "хууранмэхлэлт" хийсэн гэдэгт итгэдэг".

Софи бичээс рүү ширтэнгээ, дуугүй зогссоор л байлаа.

"Константин болон түүнийг тойрон хүрээлэгч эрчүүд шашингүй н үзлийг Христийн шашнаарамжилттай сольж, Дарь эх шүтээнийг ад зэтгэрийнх гэж ухуулан сурталчилснаар, өнөөгийн шашнытүүхээс үлдэн хөөсөн гэж Прайоричууд итгэдэг".

Софи энэ бүхний учрыг ойлгосонгүй. "Өвөө минь намайг үүний төлөө энд ирүүлсэн гэж

үү дээ. Тэрүүнээс ч илүү .зүйлийг надад хэлэхийг хүссэн байх".

Ландон бүсгүйг юу гэж хэлснийг ойлголоо.

Софи бичээсийг бас нэгэн өөр код гэж бодож байгаа юм байна.

Гэхдээ энд далд утга байсан ч гэсэн, Ландон үүнд шууд хариулах боломжгүй байв.

So Dark The Con on Man!

Сүмийнхэн зальжин хуурмаг арга, жигшүүрт түүхийг бүтээж өдрийг хүрсэн юм.

Шашингүйнүзлийнхнийг дарангуйлан номхтгох, "дахин хүмүүжүүлэх" гэсэн тэдний бусармаг ажиллагаа 300жилийг дамжин өртөөлсөн юм. Католикийнхны эрүү шүүлтийн дор нэгэн ном хэвлэгдсэн нь, түүхэнд цуст үйлдэл араасаа дагуулсан, явдлын эхлэл болсон юм. "Шулмын алх" нэртэй тэрномонд чөлөөтэйгөөр сэтгэгч эмэгтэйчүүдийн аюулын хар гайг сануулж, ятган ухуулж, тэднийгхэрхэн номхтгох, шийтгэх аргыг заан сургамжилжээ. "Шулам" гэдэг ойлголт од сүмийнхэн бүхэмэгтэй эрдэмтэд, гэлэнмаа, мөргөлчид, байгаль эхийг шүтэгч эмэгтэйчүүд болон, "шашингүйнүзэлтэй ямар нэгэн байдлаар холбоотой" бүх эмэгтэйчүүдийг багтаажээ. Хижээл насны гэрийнэзэгтэй нар хүртэл хүүхэд өвдөхөд, анагааж эдгээх, эх барих зэрэг арга туршлагаасаа болж, тэрсүзэлтэнд тооцогдож, цаазлуулж байжээ. Сүмийнхэн батлахдаа, Бурхан Еваг алим идсэнээс нь болжшийтгээд, бүсгүй хүн хүүхэд төрүүлэх үйлийн үртэй болсон гэх үгийг ч тарааж байжээ.

300 жилийн туршид энэ балмад үйлдлийн бараан сүүдэрт 5 сая гаруй эмэгтэй хэлмэгдэж, "Зулынгол" болж шатаагджээ.

Эмэгтэй хүнийг хоёрдугаарт тавих, үзэл зүүн тал хэмээх ойлголтоор одоо ч илэрдэг. Франц болон Итали улсад "зүүн" гэснийг ихэнх тохиолдолд сорөг утгатай хэрэглэдэг ба харин баруун гэснийгзөв үзэл, тохиромжтой байдал гэсэн утгаар ойлгодог аж. Олоо ч гэсэн радикал үзэлтэй намыгзүүний тал; гаж сондгой үзэл бодлыг зүүн тархитай холбон тайлбарладаг шүү дээ.

Ингэж л Дарь эхийг шүтдэг байсан үе дуусгавар болж, бүх зүйл орвонгоороо эргэсэн байна. Эхдэлхий эрчүүдийн ертөнц болж, эцгийн эрхт ёс 2000 жилийг туулан ноёлжээ. Сионий Прайорийнхан үүнийг "амьдралын зохистой Харьцаа алдагдаж байна" хэмээн тайлбарлаад, үүнийилрэл нь хүйтэн зэвсгийн дайн самуун, эмх замбараагүй нийгэм, эх дэлхийгээ үл хайрлах үзэлзэргээр илрэн гарч байна гэж ярьдаг аж.

"Роберт!" гэж Софи гэнэт хэлээд, түүнийг хойш нь чангааж, "Хэн нэг нь ирж байна" гэв.

Ландон үүдний цаад талын хонгилд хөлийн чимээ гарахыг сонсов.

"Наашаа бол!" гэж Софи хэлээд, гэрлээ унтраавал, Ландон бүсгүйг олж харсангүй. Тэрхэн мөчид Ландон юу ч харахгүй болчхов.

"Наашаа болооч ээ!" гэж хэлэхэд, Ландоны нүд харанхуйд арайхийн дасч, өрөөний голд тавьсан буйдангийн өмнө бүртэлзэх Софиг олж харав. Тэр бүсгүй рүү ухасхийн очих гэсэн боловч, ард нэгхүний дуу гарч, түүнийг хөдөлгөөнгүй болгочхов.

"Бүү хөдөл!" гэж үүдний дэргэдээс нөгөө хүн түүнд тушаав.

Луврын хамгаалалтын ажилтан Сал Дес Этагийн танхимд аль хэдийнээ нэвтрээд,

Ландоны арнуруу руу буугаа чиглүүлэн зогсож байв. Ландоны хоёр гар өөрийн мэдэлгүй дээш болжээ.

"Кушеву!" гэж хамгаалагч хэлээд, цааш залгуулан "Доошоо хэвт!" гэж англиар тушаав.

Ландон нүүрээ доош харуулан, шалан дээр элгээрээ хэвтэв. Хамгаалагч эр түүн дээр яаравчлан очиж, хоёр хөлийг нь өшиглөж салгаад, сэжигтнийг "аюулгүй" болгов.

"Санахын ч хэрэггүй шүү, ноён Ландон!" гэж хамгаалагч эр хэлээд, түүний нуруунд бууныхааамыг тулгав. "Санахын ч хэрэггүй!"

Ландон доош харан хэвтэж байхдаа, "Харьцаа" зургийг гэнэт санав. Тэрээр "Харьцаа" - г дүрслэнхэвтсэн байгаа нь, зөвхөн доош харснаараа л, эх зургаас ялгаатай байгааг анзаарав.

Хэсэг 29

Силас лааны төмөр суурийг мөргөлийн индрээс аваад, хөшөө рүү буцаж ирэв.

Лааны суурь яг тохирно.

Саарал гантиган шал руу харахдаа, хэрхэн их дуу чимээ гаргалгүй хагалах тухайгаа, Силасэргэцүүлнэ.

Төмрөөр гантиг чулуу цохино гэдэг бол, сүмд тэр чигээр нь дуу хадаана гэсэн үг. Гэлэнмаа үүнийг сонсчих болов уу? Тэр одоо унтсан байх ёстой. Гэхдээ чимээ гаргаж болохгүй!

Силас дууг сарниулах зүйлийг эргэн тойрон хайгаад, индрийн бүтээлгээс өөр зүйл олж харсангүй. Гэвч тэр бүтээлгийг хэрэглэхийг хүссэнгүй.

Миний өмсгөл байгаа шүүдээ! гэж бодоод, Силас өмсгөлөө тайлж, нүцгэн биеэ ил гаргав. Түүнийг өмсгөлөө тайлахад, нуруун дээр илхэн байсан, шинэхэн шарх сорви нь хөндүүлэн өвдөв. Силас төмөр суурийг өмсгөлөөрөө ороосны дараа, шалан хавтан руу чиглүүлж байгаад, хүчтэй дэлсэв.

Чулуун хавтан хагарсангүй, дахиад цохилоо. Харин энэ удаад чулуу хагарав. Гурав дахь далайлтаар чулуун хавтан бутран унахад, доодох хөндий нь ил гарч ирэв. Силас нүх рүү харж байснаа, урт, цонхигор гараа дотогш нь хийв. Эхэндээ дотор нь юу ч байхгүй юм шиг санагдсан ч, гараа цааш явуулах тусам нүх улам гүнзгийрч, ёроолд нь хүрэхэд, нэг зүйл гарт нь мэдрэгдэв. Зузаан чулуун хайрцаг байгаа бололтой. Хуруугаараа үзүүрийг нь тэмтэрсээр, хайрцгийг дээш нь алгуур гаргаж ирэв. Дээр нь үг товойлгож, бичсэн хавтгай зүйл байх болов уу гэж бодоод, гаргажирснийхээ дараа хайрцгийг ажиглав

Гэтэл түүний гаргаж ирсэн тэр зүйл дээрээ маш энгийн үгтэй байлаа.

Иовийн 38:11.

Энэ чинь Библийн ишлэл байна шүүдээ! гэж Силас өөртөө хэлээд, түүний хайж байсан тэр нууц Библи тэй холбоотой байгааг мэдээд гайхав.

Иовийн 38:11

Энэ хэсэгт юун тухай өгүүлдгийг, Силас цээжээр мэдэхгүй боловч, Бурханд итгэх сүсэг бишрэлээ эцсийн мөч хүртэл алдаагүй нэгэн хүний тухай гардгийг, бүдэг бадаг санаж байлаа. Тэрээр Сарнайн судлыг мөрөн дээгүүрээ давуулан харж инээмсэглээд, мөргөлийн индэр дээр харагдах, алтадмал хавтастай Библийн зузаан судрыг олж харав.

Сандрин гэлэнмаа тавцан дээр чичрэн зогсоно. Хэдэн хормын өмнө тэр албиног өмсгөлөө тайлахыгхарах хүртлээ, үүргийнхээ дагуу тэндээс хурдан зайлах гэж бодож байсан билээ. Гэтэл хүн жигшим

цагаан арьстай нүцгэн Силасыг хараад, айн зогтусжээ. Түүний өргөн цагаан нуруунд цусан замтатсан байх нь тэр. Гэлэнмаа түүний шархыг шинэхэн байхыг тэр дор нь олж анзаарсан аж.

Энэ хүн өөрийгөө ташуурджээ!

Тэрээр бас гуяндаа өргөст бүс зүүсэн бөгөөд, түүнийг нь даган, хүрэн улаан цус шүүрэн урсана.

Бурхан хүнийг бас ингэж шийтгэнэ гэж байдаг аа!

Сандрин гэлэнмаа өмнө нь Опус Дейн тухай дуулсан боловч, ерөөс ойлгодоггүй байсан юм.

Опус Дей Онъсон чулууг хайж байгаа юм гэж үү? Тэд энэ тухай яаж мэддэг байна аа? гэх бодол Сандриний толгойд эргэлдэнэ.

Шархтай албино өмсгөлөө эргүүлж өмсөөд, олсон олзоо барин, индэр лүү, Библийн судар руудөхөж очлоо. Санлрин гэлэнмаа тавцангаас холдож, өрөө рүүгээ шогшлоо. Тэрээр өрөөндөө ороод, орны доор, далд хадгалсан дугтуйг онгойлгов. Үүнийг олон жилийн өмнө нуусан юм. Дугтуйг задалтал, дотор нь утасны 4 дугаар байв. Чичирсэн гараараа тэмтэчсээр, утасныхаа харилцуурыгаваад, хамгийн эхний дугаар луу залгав.

Харин энэ үед Силас доод давхарт Библийн судрыг эргүүлэн, ишлэлийг хайн зогсох ажээ. Хуудсыг эргүүлэх тусам, түүний хуруунууд хөлрөн загатнана. 38 - ын 11 - ийг олоод, Силас доторхыг уншлаа. Тэрээр 7 үгтэй, ганц өгүүлбэрийг ахин дахин уншаад, нэг зүйлд алдаа гарчээ гэж бодлоо.

Тэнд ингэж бичсэн байлаа.

Hitherto Shalt Thou Come, But No Further.

Хэсэг 30

Хамгаалагч Клоуд Груаг Мона Лизагийн өмнө сэжигтнийг хэвтүүлчхээд байв.

Энэ новш Жак Сониехийг алжээ!

Груаг болон түүнтэй хамт ажиллагсдад Сониех яг л эцэг шиг нь ханддаг байсан юм. Груаг Роберт Ландоны нуруунд Сум зоож хариугаа авахыг тэсгэлгүй хүснэ. Ахлах хамгаалагчийн хувьд, буутай явдаг, цөөн хүмүүсийн нэг нь Груаг юм. Гэвч Ландоныг алчихвал, Бэзү Фааш болон, Францынхуулийнхантай өөрийгөө сэргүүлэн тавина гэдгээ тэрээр мэдэж байлаа.

Груаг бүснээсээ радиостанц гарган, төв рүүгээ хариу өгөхөөр боллоо. Гэвч дотуур холбооныдолгион энд барьдаггүй бололтой.

Би үүд рүү дөхөж очих ёстой юм байна гэж бодоод, Ландон руу буугаа чиглүүлсэн чигтээ хойшхаалга руу дөхөв. Гурав ч алхаж амжаагүй байтал, гэнэт тэр нэг зүйл олж харлаа.

Энэ юу байсан бэ?

Бүсгүй харанхуй дунд зүүн талын ханыг налсаар гэтэж явах ажээ. Хамгаалагч хурц ёлтгор гэрлээтусгахад, Софи шал руу доош бөхийгөөд, явган суучхав.

"Энд хэн байна вэ?" гэж Груаг хэлээд, хаашаа чиглүүлэхээ мэдэхгүй тул, буугаа ийш тийшсавчина.

Гэтэл хариуд нь, "Шинжээчийн хэлтсээс явж байна. Өөрийн хүн байна" гэж бүсгүй тайвнаархариулаад, нэг зүйл хийж буй мэт лазер тусгалтай гэрлээ шалан дээр тусгалаа.

Груагийн нуруу нь хүйт оргисон байв. Бүх цагдаа нар явчихсан гэж бодсон юмсан.

Тэрээр цагдаа нарын хэрэглэдэг лазер тусгалтай гэрлийг харсан даруйдаа таньсан ч гэсэн, цагдаанар яагаад эд мөрийн баримтыг эндээс хайгаад байгааг огт ойлгосонгүй.

"Таны нэр!" гэж Груаг хашхираад, "Хариулаач!" адган шаардав.

"Намайг ..." гэж бүсгүй Францаар хэлээд, "Софи Нөвү гэдэг" гэж бүсгүй хариулав.

Груаг энэ нэрийг мэдэх юм шиг санагдав. *Энэ чинь Сониехийн ач охины нэр байна шүү дээ! Охинбага байхдаа энд ирдэг байсан гэхдээ биш байхаа. Хэрвээ үнэхээр Софи Нөвү мөн бол түүнд эндбайх шалтгаан бараг байхгүй шүүдээ!*

Учир нь Сониех ач охинтойгоо уулзахаа больсон гэх цуу үгийг Груаг нэгэнтээ дуулсан билээ.

"Та намайг мэддэг юм уу?" гэж бүсгүй асуугаад, "Роберт Ландон өвөөг минь алаагүй. Надад итгээчдээ!" гэж ятгав.

Груаг үүнд итгэсэнгүй.

Надад нэмэлт хүч хэрэгтэй байна гэж тэр өөртөө хэлээд.. станцаа дахин асааж, хариу хүлээсэн чбас л болсонгүй. Тэрээр үүднээс ердөө 10 ярдын зайд байгаа гэдгээ мэдээд, хойш ухарч, өөрийнolzолсон хүнээ шалан дээр хэвтүүлсэн чигээр нь орхихоор шийдэв. Түүнийг гарахаар завдах тэрмөчид, нөгөө бүсгүй нэгэн жаазтай том зураг барьчихсан, урд нь зогсож байлаа.

Груаг зогтусч, тэрхүү зургийг харсан дороо танив. *Ээ, Бурхан минь тэр юу хийж байна аа?*

Софи Нөвүгийн духнаас хөлс урсана. Харин Ландон түүнээс холгүй, 4 мөчөө тэлсэн чигээрээшалан дээр хэвтэх ажээ.

Тэсээрэй Роберт би удахгүй очно! гэж бүсгүй дотроо шивнээд, хамгаалагч эр тэднийг аль алиныгнь буудахгүйг мэдэх учир, нөхцөл байдлыг гартаа авахаар шийдэж, өрөөн доторхыг ажиглалал, ДаВинчийн өөр нэгэн хосгүй бүтээл түүний нүдэнд туслаа. Түүний олж харсан зураг 5 фут ор чимөндөртэй аж.

Софи багадаа, Мона Лизаг харахгүйн тулд, энд ирэх болгондоо өвөөгийнхөө гараас чирсээр, энэзураг дээр ирдэг байжээ.

"Өвөө би энд байна. Гэхдээ сайн харж чадахгүй байна аа!" гэж бяцхан ахин том зурагны доор иржзогсчхоод хэлдэг байж билээ.

Тэгтэл түүний ард хамгаалагч эр хариу хүлээн, станцаа асаах нь дуулдав.

Бүсгүй гэр мөчид Мона Лизагийн хамгаалалтын зузаан шилэн дээр бичсэн өвөөгийнхөө

үгийгсаналаа.

So dark the con of man

Гэтэл тэр өгүүлбэрийг хамгаалалтын шилний гадна талд бичээгүй нь Софид тодорхой болов. Баснөгөөтээгүүр өвөө нь хэзээ ч эх зурган дээр бичнэ гэж Софигийн толгойд буухгүй байлаа. Софи

нүдээрээ ямар нэг зүйл хайн, дээш хартал зургийг таазнаас өлгөсөн төмөр утаснууд нүдэнд нь тусав. Тэрээр зургийн жаазны ирмэгээс бариад, өөрлүүгээ чангаалаа. Зураг хананаас хөндийрөхөд ард тал нь ил гарч ирэв. Софи толгойгоо шургуулан зургийн ар талыг лазер тусгалтай гэрэл асаан харлаа. Түүний зөн совин энэ удаад алджээ гэдгийг бүсгүй ойлгов. Зургийн хойд тал цулгүй хоосон байлаа.

Ямар ч бичээс байсангүй.

Гэтэл, *Байзаарай!*

Софигийн нүд жаазны өнцөгт өлгөсөн нэгэн металл зүйл дээр очоод гацчихав. Тэр зүйл нэлээд жижиг байсан учир, жаазны ирмэгээс дөнгөж ялгаран харагдаж байв. Тэр зүйлийг гялалзсан алтангинжнээс өлгөсөн байлаа. Софид нөгөө танил алтан түлхүүр нь харагдах нь тэр. 9 настайгаасаа хойш дахиж хараагүй боловч, өргөн том бариул дээрээ хэрээс болон Прайорийн тамгыг товойлгосон дүрсэлсэн, тэр түлхүүрийг Софи огт мартаагүй билээ. P.S. гэсэн үсгүүдийг сараанацэцгийн хэлбэртэй дүрсэлсэн байсан нь, одоо ч сэтгэлд нь хадагдсан хэвээр.

Софи гэр мөчид өвөөгийнхөө шивнэхийг сонсох шиг болов. *Цаг нь болохоор энэ түлхүүр чинийх болно!*

Хэдийгээр өвөө нь үхсэн ч, түүний амлалт одоо хүртэл хүчинтэй хэвээр байгаад, бүсгүйн сэтгэлдогдолж, хоолойд нь нэг зүйл тулаад ирэв.

"Энэ түлхүүрээр олон нууц хадгалдаг хайрцгийг онгойлгодог юм" гэж өвөө түүнд олон жилийн өмнө хэлсэн билээ. Өнөө шөнийн бүх үгэн тааврууд энэ алтан түлхүүрт чиглэсэн байсныг, Софи эцэст нь ухаарлаа.

Өвөө бусдын гарт амиа алдахдаа, энэ түлхүүрийг биедээ авч явж байсан юм байжээ.

Цагдаагийнхны гарт түлхүүрийг өгөхгүй гэсэндээ, зургийн ард түүнийг нуусан юм байж. Тэгж бодоод, ганцхан надад зориулж, энэ бүх адармаатай хэргийг сэдсэн юм байна.

"Нэмэлт хүч хэрэгтэй байна!" гэж хамгаалагч холбоогоор цөхрөлтгүй дуудна.

Бас ямар ч хариу байсангүй.

Түүний холбогдож чадахгүй байгааг, Софи анзаарлаа. Учир нь музейд ирсэн жуулчид Мона Лизаг үзэж байгаагаа, гэрийнхэндээ дуулгах гэж залгах бүрт, гар утасных нь сүлжээ уначихдаг билээ. Танхимд байрлуулсан, дохиоллын олон систем сүлжээг тасалдуулж, танхимын гадна гарахааснааш, холболт хийж болдоггүй байлаа.

Хамгаалагч үүд рүү ухрах тэр агшинд, Софи амжиж хөдлөх хэрэгтэйг ухаарлаа. Тэр зургийн араас гарч ирээд, зураг руу ширтэж, хоёр дахь удаагаа тус хүргэхэд бэлэн байгаа. аварга зургийг ажиглав.

"Одоо хэдхэн алхам" гэж Груаг өөртөө шивнээд, гар буугаа барьсан хэвээр ухарна.

"Бүү хөдөл! Эсвэл, би үүнийг цөмлөчихнө шүү!" гэх бүсгүйн дуу өрөөгөөр нэг цуурайтав.

Груаг зогтусч, ухрахаа болиод, тэр зүг харангуутаа, "Бурхан минь, битгий тэг!" гэж хашхирахшахам хэлэв.

Танхимд туссан улаан гэрлийн тусгалд арайхийн харвал, бүсгүй нэгэн том зураг урдаа барьчихсанзогсч байв. Зураг 5 футын өндөртэй учир, бүсгүйг тэр чигт нь далдалж байв.

Зургийн аваарын дохио яагаад ажилласангүй вэ? гэж Груаг бодтол, өнөө шөнөдөө дохиололажиллахгүй байгааг гэнэт саналаа. Энэ эмэгтэй юу хийж байна аа?

Тэр мөнөөх зургийг харангуутаа, цус нь царцах шиг болов. Түүний өөдөөс Ариун Мэри, нялх Есүс, баптист Жон нар ширтэж байлаа.

"Битгий!" гэж Груаг хашхираад, Да Винчийн үнэлж баршгүй тэр бүтээл рүү хөшсөн чигтээ тагширтэнэ.

Харц н бүсгүй зургийн гол хэсэгт өвдгөөрөө жийхэд бэлэн байдалтай зогсч байв. Груаг түүн рүүбуугаа чиглүүлж, гохоо дарах гэсэн боловч, энэ нь бодлогогүй, гэнэн алхам гэдгийг удалгүйойлголоо.

Хэрвээ зургийг буудчихвал 6 сая ам. долларын үнэтэй бүтээлийг үгүй хийнэ гэсэн үг.

Би Да Винчийн бүтээлд Сум зоож зүрхлэхгүй!

"Буугаа дотуур холбоотойгоо хамт хая!" гэж бүсгүй өөртөө итгэлтэйгээр хэлээд, "Үгүй бол бизураг руу жийж орхино шүү! Хэрвээ өвөө минь үүнийг харсан бол яах байсныг төсөөлж байна уу?"

Груаг учраа олохоо байж, "Болиоч! Гүйж байна. Наадах чинь Мадонна шүү дээ!" гэж цөхрөнгөөбарсан хүний дуугаар хэлэв. Тэрээр буу, станц хоёроо шалан дээр хаяж, гараа толгойнхоо ард авав.

Хариуд нь бүсгүй, "Баярлалаа! Харин одоо миний хэлснийг хийвэл, бүх зүйл сайхан болно".

Хормын дараа Ландон Софигийн хамт аваарын гарцаар доош уруудаж байлаа. Тэдний хэн хэн ньзамдаа юу ч дуугарсангүй. Хамгаалагчийн гар буу Ландоны гарт орж, профессор хүйтэн төрлийнхүнд зэвсгийг нүднийхээ булангаар сэтгэл түгшин, байн байн харна.

Софи яагаад үнэ цэнэтэй тэр зургийг сүйтгэх санаатай байсныг Ландон гайхаад олсонгүй. Бүсгүйнэнэ үйлдлээс харахад, Софи лав урлагийг үл ойшоогч байж таарна. Түүний барьж байсан зураг бол Мона Лизагаас дутахааргүй алдартай бөгөөд, урлаг судлаачдын хувьд шашингүйн үзлийнхний машолон бэлгэдлийг далд хэлбэрээр өөртөө агуулсан гэж үздэг юм.

"Чи хамгаалагчийг маш үнэтэй зүйлээр сүрдүүллээ шүү!" гэж Ландон шогших зуураа хэлэхэд,

"Мадонна юу? Би ингэе гэж бодоогүй юмаа. Харин өвөө минь ингэхийг хүссэн юм. Өвөө тэрзургийн ард нэг зүйл надад үлдээсэн байсан".

Ландон түүн рүү огцом харж, "Юу гэнэ ээ? Чи тэр зургийн ард юм нуусныг яаж мэдсэн юм бэ? Яагаад заавал Мадоннагийн ард гэж?"

"So dark the son of man!" гэж Софи хариу хэлэхдээ, ялан дийлсэн, байдлаар сэтгэл

хангалуунинээмсэглээд, "Би өвөөгийн зохиосон эхний анаграммыг тайлж чадаагүй. Харин хоёр дахийг нь тайлах ёстой байсан шүү дээ!" гэв.

Хэсэг 31

"Тэд үхчихжээ!" гэж Сандрин гэлэнмаа утсаа барьсан чигтээ ээрч түгдрэн хэлэв. Тэр залгасанутсандаа зурвас үлдээв. "Утсаа ав л даа!"

Тэд бүгд үхчхээж! Холбогдох ёстой хүмүүс бүгд үхжээ!

Харин одоо гэлэнмаа дөрөв дэх рүү нь залгаж байлаа. Өмнөх 3 нь холбогдоогүй тохиолдолд л, дөрөв дэх дугаар луу залгах ёстой юм. Залгасан дугаарын автомат хариулагч ямар ч нэр хэлсэнгүй. Харин түүний оронд, зурвас үлдээх эсэхийг шууд лавлав.

"Чулуун шалыг хагалж онгойлгосон! Бусад 3 чинь бас үхсэн байна!" гэж гэлэнмаа мэдэгдэв.

Сандрин гэлэнмаа дээрх 4 хүний жинхэнэ нэрийг хэзээ ч мэдэж байгаагүй. Харин онцгойтохиолдолд тэдэнтэй холбогдох утасны дугаарыг орныхоо доор чандлан нуусан билээ. Хэрэвчулуун суурь хөндөгдсөн бол, эдгээр дугаар луу залгаж, Ахан дүүсийн холбоонд анхааруулж мэдэгдэхийг, түүнд нэгэн хүн даалгасан юм. "Биднийг битгий л баллаарай!" гэж тэр хүн гэлэнмаадаминчлан захижээ.

Хэрэв Ахан дүүсийн холбооны нэг л гишүүн илэрвэл, тэр гишүүн худал зүйл мэдүүлж, бусдыгаахаацайлаад, дараа нь өөрийнхөндөө анхааруулах ёстой байв. Гэтэл өнөө шөнө нэг дор олон хүнилэрсэн гэдэг нь тодорхой болов.

"Утсаа аваач дээ! Та нар хаана байгаа юм бэ?" гэж гэлэнмаа айсандаа шивэгнэн хэлнэ.

"Утсаа тавь!" гэж зандрах дуу үүдний дэргэдээс гэнэт сонсогдов.

Гэлэнмаа айн балмагдаад, эргэн хартал альбино зогсож байв. Тэрээр гартаа лааны төмөр суурьбарьжээ. Гэлэнмаа салганан чичирсээр, утсаа тавив.

"Тэд аль хэдийнээ үхчихсэн шүү дээ! Бүгд үхсэн. Үхэхдээ харин намайг хуурсан байна. Онъсончулууг хаана байгааг, надад хэл!" гэж Силас эмэгтэйг сүрдүүлэв.

"Би мэдэхгүй ээ!" гэж Сандрин чин сэтгэлээсээ хэлээд, "Энэ нууцыг өөр хүмүүс мэддэг юм. Тэдүхчихсэн гэж үү?"

Силас төмөр суурийг гар дээрээ өргөж далайгаад, "Та Сүмийн гэлэнмаа хирнээ, тэдэнд үйлчилдэгбайсан юм биз дээ?"

"Есүс бидэнд ганцхан зүйлийг л захисан" гэж гэлэнмаа өөдөөс нь эсэргүүцээд, "Харин Опус Дейтүүнийг хөсөрдүүлсэн!"

Силасын нүдэнд оч үсрэх шиг болж, уур хилэндээ багтарч байв. Харин Сандрин гэлэнмаасүүлчийн удаа Силас руу харахдаа, зөвхөн муу ёрлосон бодол түүний сэтгэлийг эзэмдэхийгмэдэрчээ.

Бүгд үхчхэж! Үнэлж баршгүй нууц үүрд алга болжээ.

Хэсэг 32

Денон жигүүрийн аваарын дохио хангинахад, Түйлрийн цэцэрлэгт хүрээлэнд байсан тагтаануудүргэж нисэв. Харин Ландон, Софи хоёр музейгээс зугтан гарч байлаа. Тэд гүйсээр, машины зогсоолхүрэх үед, тэртээ алсад цагдаагийн машины дохио хангинах нь үл мэдэг сонсогдоно.

"Бид ирчихлээ!" гэж Софи хэлээд, навтгар хамартай, хоёр хүний суудал бүхий улаан жижиг машинруу заав.

Софи тоглоод байгаа юм уу?

Ландоны өмнө нь хараагүй хамгийн бяцхан машин гэвэл тэр байлаа.

"Smart car" гэж Софи хэлээд, "Зууд ганц литр" гэв.

Софи машинаа асаан, Ландоныг суулгаад, тойрог хэлбэртэй засмал замыг дагаж, Каруссель руучиглэн давхих гэснээ больж, замаа товчлон зүлгэн дээгүүр шулуун гараад, чигээрээ хурдаллаа.

"Хэрэггүй ээ!" хэмээн Ландон балмагдсандаа орилоод, тэдний яг өмнөх зам дээр шилэнгадаргуутай урвуу пирамид байгааг санаж, нүдээ тас анив. Тийш зүглэсэн чигтээ явбал доошцөмрөн унахыг Ландон дотроо төсөөлөн байтал, харин Софи замаа өөрчилж, баруун тийш огцомэргээд, пирамидыг тойрч гарангуутаа буцаж зүүн рүүгээ дараад, Рью де Риволиг чиглэн хурдаллаа.

Цагдаагийн машины дохио ойрхон дуугарахыг сонсоод, Ландон толинд арагш хартал, тэднийгхөөж байгаа нь харагдав.

50 ярдын цаана анивчих гэрлэн дохиог харвал, улаанаар солигдож байв. Софи амьсгалаа түгжээд, улаан гэрлээс өрсөн, хаазаа гишгэж урагш байдгаараа бөхийв. Ландоны бүх бие нь хөшжээ.

"Софи?!"

Гэрлэн дохион дээр хүрэхээс өмнө, Софи хоёр талаа ээлжлэн түргэн гэгч хараад, шууд баруунтийш эргэж, Риволи тийш явдаг зам руу оров. Удалгүй хэсэг явж байгаад, Чампс -

Элизийн өргөнчөлөө рүү эргэв. Шулуун замд орсон хойно, Ландон толинд тусах Луврыг ширтэн догдлон суух аж.цагдаа нар тэднийг мөшгөөгүй бодолтой. Хурц гэрлүүд Луврын тэндээс олноор асах нь арынтолинд тодхон үзэгдэнэ. Ландон зүрхээ одоо л хэвийн цохилж байхыг мэдрээд, "Маш сонирхолтойзүйл болж өнгөрлөө шүү!" гэж чин сэтгэлээсээ догдлон өгүүлэв.

Софи түүний хэлснийг чихнийхээ хажуугаар өнгөрөөв. Бүсгүй Чампс - Элизийн өргөн чөлөөнийтөгсгөлтэй залган харагдах Парисын 5 - р өргөн чөлөөг ширтэж явав. Тэндээс ЭСЯ руу ганц мильяваад л хүрчихнэ.

S O DARK THE CON OF MAN

Софи үүнийг Мадонна (MADONNA OF THE ROCKS!) гэж тайлж уншиж чадсан юм.

Мадоннагийн ард ямар нэг зүйл өвөө нуусан байх нь гэж Софи кодыг тайлсан дороо ойлгожээ.Өвөөгийнх нь хийсэн бүх л үйлдлүүд өнөө шөнийн турш тэднийг Да Винчитэй ямар нэг байдлаархолбож байгаа билээ.

Да Винчийн Мадоннаг зурах болсон шалтгаан нь Милан дахь Сан Франциско сүмийнхэнтэймаргашгүй холбоотой юм. Винчи алдарт зургаа сүмийнхний хүссэний дагуу, Ариун Мэри, балчирбаптист Жон, Есүс нарыг зурсан боловч, сүмийнхэн үүнийг үзсэн даруйдаа ихэд дургүйцжээ. Зурагдээр Мэри нялх Есүсийг нэг гараараа тэвэрч, түүний дэргэд Уриел нялх Баптист Жонтой хамтсууснаар дүрсэлжээ. Хачирхалтай нь, Жон Есүсийг адислаж буй мэт зураг дээр харагдах бөгөөд,Есүс үүнийг хүлээн зөвшөөрсөн байдлаар зуржээ. Энэ зургийн өөр нэг хувилбар нь Лондон дахьҮндэсний Галерейд "Ариун" гэсэн нэртэй тавигдсан байдаг ч, Лувр дахь жинхэнэ эх бүтээлийгилүү сонирхол татам гэж Ландон үздэг билээ.

Софи Чампс - Элиз рүү өгсөж, хурдаа нэмэхэд,

"Зураг. Зургийн ард юу байсан юм бэ?" гэж Ландон асуув.

Софи зам руу ширтсэн чигтээ, "Би чамд ЭСЯ дээр очсон хойноо үзүүлье".

"Чи надад үзүүлэх гэж үү?" хэмээн Ландон баярлаад, "Өвөө чинь чамд энэ удаад таавар бишбодитой зүйл үлдээсэн байх нь ээ?"

Софи үл мэдэг толгой дохиод, "Дээрээ P.S. үсгийг сараана цэцгийн хэлбэртэй дүрсэлсэн зүйлбайсан".

Ландон үүнийг сонсоод, чихэндээ итгэсэнгүй.

Софи сая л нэг тайвшрах шиг болов. Учир нь тэд ЭСЯ руу ойртож байв. Бүсгүй хэдийгээр жолооныард сууж байгаа ч, бүх бодол нь түүний халаасан дахь түлхүүрт чиглэжээ.

Олон жилийн өмнө, бага байхдаа харсан тэр зүйл. Алтадмал ишин дээр нь тэгш хэмтэй загалмайгдүрсэлж, үзүүр нь 3 талт хэлбэртэй бөгөөд, P.S гэсэн үсгүүдийг сараана цэцгийн хэлбэртэйтовойлгож хийсэн тэр зүйл.

Софи олон жилийн турш олж мэдсэн туршлагаа ашиглан бодох юм бол, энэ түлхүүр түүнд одоотийм ч онцгой санагдахгүй ажээ. Энэ бол лазерийн технологи ашиглан хийгдсэн эд. Түүнийг дахинхувилан, хуулбарлах боломжгүй. Түлхүүр дээр гаргасан хувил нүхнүүдийг дахь цоож өөрөө лазертусгалаар нарийвчлан шалгаж, ямар ч алдаагүй тохирсон нөхцөлд онгойдог ажээ.

Софи ийм түлхүүрээр юу онгойлгодгийг үнэндээ төсөөлөхгүй байсан болохоор, Ландоныг энэталаар мэднэ гэж боджээ. Ландон энэ түлхүүрийг олоогүй байхад л дээр нь байсан тэмдэгт дүрсийг мэдэж байсан юм чинь, энэ бүхэнд хариулж чадна гэж бүсгүй найдна. Түлхүүрт байсан загалмайг

бодох юм бол ямар нэгэн сүмд хамаатай мэт санагдавч, сүмийнхэн лазераар хийгдсэн түлхүүрхэрэглэдэггүйг Софи сайн мэднэ.

Түүнээс гадна өвөө Христ шүтлэггүй шүүдээ!

Софи 10 жилийн өмнөх тэр явдлыг дурсан санав. Түүний харсан зүйл өвөөгийнх нь үнэн төрхийгбаттай илчилж чадсан юм.

Софи онгоцны буудал дээр үдийн алдад газардав. Такси барин харих замдаа, өвөө лав намайгхараад баярлана даа гэж хөөрөн догдлох ажээ. Сургуулийнхаа амралтаар эрт тарчхаад, өвөөгөөсанасандаа, бас өөрийнхөө мэдсэн зүйлээ "тайлагнаж" ярихын хүслэн болсоор, Англиас эх оронруугаа, гэр лүүгээ яарсан билээ. Гэртээ иртэл өвөө нь байсангүй. Бүсгүй сэтгэл гонсойсон ч, өвөөгөө Лувр дээр ажилтай байгаа гэж боджээ. Гэтэл тэр өдөр нь Бямба гариг гэдгийг тэр санав. Амралтын өдрүүдэд өвөө нь ажилладаггүйг, ач охин сайн мэдэх тул, өөр газарт?...

Софи дотроо инээж, гараж руу гүйн очоод хартал, түүний бодсоноор өвөө нь машинтайгаа явсанбайдаа. Өвөө нь ганц л шалтгаанаар машин авсан нь, Парисаас хойд зүгт байх Нормандийн эдлэндэх зусландаа очиход хэрэгтэй гэж үзсэндээ тэр.

Софи тархиа амраахад, хамгийн шилдэг санаа байна гэж бодоод, гэрээсээ гарч, нэг найзаасаамашиныг нь түр зээлж аваад, эдлэн рүү давхилаа. Софи өвөөгийнхөө эдлэн дээр оройн 10 цагийналдад хүрэв. Ой модон дунд хүрээлэгдсэн зуслангийн байшинг зам тойрон эргэхийн алдад олжхарав.

Софи өвөөгөө унтаж байгаа байх гэж таамагласан ч, байшингийн цонх гэрэлтэй байсанд маш ихбаярлав. Түүний баярласан сэтгэл, гайхшралаар солигдлоо. Учир нь байшингийн өмнөх зогсоолынталбайд Мерседес, BMW, Ауди, Роллс Ройс зэрэг үйлдвэрийн чамин машинууд эгнэн зогсож байхнь тэр. Софи гайхан ширтэж байснаа, гэнэт инээд алдав.

Энэ өвөө юу? Худлаа дүр эсгээж байгаад намайг эзгүйд ингээж аашилдаг байх нь ээ! Намайг эзгүйбайгааг далимдуулаад, Энд үдэшлэг зохиож байгаа юм байна. Энд зогссон машинуудыг үзвэл, өвөөлав Парисын нэр нөлөөтэй, нэлээд хүмүүсийг урьсан байж таарлаа шүү!

Софи өвөөдөө гэнэтийн бэлэг барихаар, үүд рүү ухасхийв. Очоод хаалгыг түлхтэл дотроосооцоожтой байв. Софи тогшсон боловч хэн ч онгойлгосонгүй. Тэр гайхаж арын хаалгаар орох гэсэнболовч бас л цоожтой байв. Бүсгүй бүр будлисан тул, чимээ чагнан хэсэг зогсов. Түүнд зөвхөннуулын хөндийгөөр хүүгэн шуугих, салхины дуу л сонсогдож байв.

Сонин юмаа! Ямар ч хөгжим, ая сонсогдохгүй юм. Бүр юу ч үгүй шүү!

Софи үүдний цонхонд нүүрээ наан хартал, тэнд хэн ч байсангүй. Энд хүн алга!

Доод давхар тэр чигтээ хүнгүй харагдав.

Хүмүүс нь хааччихсан юм болоо?

Софи хажуугийн саравчин доторх харцаганд илүү түлхүүр байдгийг гэнэт санав. Тэрээртүлхүүрийг олж авмагцаа, хаалгыг онгойлгож, дотогш оров. Түүнийг орж ирэнгүүт,

дохиоллын систем хангинаж, бүсгүй түүнийг унтраах гэж кодыг нь түргэн гэгч оруултал, дохио тэр дороо намдав.

Өвөө үдэшлэг зохиохдоо дохиоллоо идэвхжүүлдэг нь ямар учиртай юм бэ?

Дээд давхарт гартал бас л хэн ч байсангүй. Буцаж зочны өрөөнд орж ирээд, юу гээч болоод байгааг эргэцүүлэнгээ, түр амсхийж суулаа. Гэтэл Софид нэгэн чимээ сонсогдов. Маш бүдэг чимээ байлаа. Тэр чимээ түүний доороос гарах шиг санагдана. Софи ингэнэ гэж огт төсөөлөөгүй тул, дөрвөнхөллөж, чихээ шаланд наав.

Тиймээ. Яг энд, доороос гарч байна!

Ямар нэг дуу дуулж байгаа юм шиг түүнд сонсогдоно. Түүний дотор нь зарсхийлээ. Энэ дуунаасайж эмээсэндээ ч биш, харин энэ байшинд доод хонгил байхгүйг, Софи сайн мэдэх учир чичрэндагжив.

Бүсгүй өрөөг эргэн тойрон хартал, өвөөгийнх нь дуртай зураг нүдэнд нь тусав. Үргэлж ханандөлгөөтэй байдаг тэр зураг энэ удаад шалан дээр байж байв. Түүнийг өлгөдөг асан ханын тэр хэсэгил гарчээ. Софиг модон хана руу дөхөж очиход, нөгөө чимээ улам тод сонсогдов. Одоо хүртэл эргэлзсэн хэвээр. Тэр чихээ хананд наав. Гэтэл хүмүүс дуулж байх нь тод сонсогдов. Тэд магтуудуулж байгаа бололтой, үгийг нь ялгаж сонсох аргагүй байв. Ханын цаана хөндий байгаа нь тодорхой болов.

Софи хананы ирмэгийг дагуулан хартал, ганц хуруу орох зай үзэгдэв. Түүнээс татан чангаатал, хүнд хана хөдөлж, нэг тал руугаа гүйж онгойв. Харанхуйн тэндээс нөгөө дуу цуурайтсаар л байв. Софи хаалгыг хааж, доош хартал, түүний өмнө жижиг гишгүүртэй, мушгирсан чулуун шат байв.

Аль бага байх үеэсээ л энд ирж байсан ч, ийм шат бүхий доод хонгил байна гэж зүүдлээ ч үгүй явсан юм. Түүнийг доош буух тусам, агаар нь сийрэг, сэрүүн болж байв. Доороос дуулах нь сонсогдсон хэвээр. Эрэгтэй, эмэгтэй хүмүүс аль аль нь дуулж байхыг сонсов. Дугуйрсан шатыг дагасан хана бүсгүйг харах зүйлээс нь халхалж байв. Сүүлчийн гишгүүр үлдэхэд, хонгилын шалгалын гэрэлд улаан шаргал өнгөөр туяарч байхыг анзаарав. Амьсгалаа аажуухан авч гаргасаар, Софи доош бөхийн, хонгилыг харахад бэлдлээ. Хонгил доторх болхидуу байдалтай харагдах бөгөөд, хананд нь байрлуулсан бамбарт бүх зүйл тодорч гэрэлтэнэ. Хонгилын төв хэсэгт 30 орчим хүн тойрог үүсгэн зогсох нь бамбарын гэрэлд тодрон харагдах аж.

Би зүүдэлж байна уу даа? гэж Софи бодоод хартал, түүний гайхах нь дууссангүй.

Өрөөнд байсан хүн бүр баг зүүсэн харагдана. Эмэгтэйчүүд нь цагаан даашинз өмсөж, алтан шаргал шаахай хөлдөө углажээ. Тэд бүгд цагаан баг зүүж, гартаа алтан бөмбөрцөг барьжээ. Харин эрэгтэйчүүд нь бүгд урт хар өмсгөл өмсөж, хар баг зүүсэн байв. Тэднийг яг л шатрын хөлөгтэй зүйрлэж болохоор ажээ. Эгнэж зогссон тэдгээр хүмүүс урагш нэг, хойш нэг алхаж, тойргийн төвд байх зүйл рүү хандаж дуулсаар байв. Софи юу болохыг ялган харж чадсангүй.

Дуулал арай чангарч түргэсэн, хурдан хэмнэлтэй болов. Гэнэт дуулж байсан, хүмүүс өвдөг дээрээ доош суух тэр мөчид, Софи юунд зориулж дуулаад байгааг нь олж харав. Тэр цочихдоо, хойш оглохарайж, сая харсан зүйлээ сэтгэлээсээ авч хаяхад, нэгэнт оройтсон болохыг ойлголоо. Ханатэмтэчсээр, шатаар дээш өгсөөд, ханан хаалгыг нээж, байшингаасаа гараад, Парис руу ум хумгүй давхилаа.

Төөрөгдөл, хоосон итгэлд нэрвүүлсэн, бүсгүй тэр шөнөдөө бүх юмаа баглаад, гэрээ

орхиж нүүсэнбилээ. Тэрээр явахдаа, гал тогооны ширээн дээр нэгэн зурвас үлдээжээ.

"Би тэнд байсан. Надтай уулзах гэсний хэрэггүй".

Софи бичсэн зурвасынхаа дэргэд зуслангийн байрны илүү түлхүүрийг тавьсан байв.

"Софи!" гэх Ландоны дуу хадаж "Зогс, зогсооч!" гэв.

Бодлоосоо дөнгөж салсан Софи тоормосоо гишгэж, "Юу вэ? Яасан? Юу болсон бэ?"

Ландон тэдний өмнө харагдах гудамжны үзүүр лүү зааж байв. Тэр зүг харсан даруйдаа, Софигийннуруугаар хүйт оргив.

100 ярдын цаана, уулзварыг хааж, цагдаагийн машинууд эгнэн зогсжээ. Тэдний зорилго илэрхий. Тэд бас Габриэлийн өргөн чөлөөг хаасан байлаа.

Ландон санаа алдаж, "Өнөө шөнөдөө ЭСЯ руу нэвтрэх боломжгүй "боллоо" гэж цөхрөнгөө барсандуугаар өгүүлэв.

Тэдний өөдөөс хараад зогсож байсан, хоёр цагдаа урд гэрэл нь хагарч гэмтсэн, Софигийн машиныганзаараад, сэжиглэж байгаа бололтой байв.

За яахав! гэж Софи бодоод, машинаа ухрах араанд нь залгалаа. Түүнийг дөнгөж эргээд дуустал, тэдний ард машины дугуй шарвах чимээ сонсогдов. Араас нь залгуулаад, дохио ч хангинаад явчлав. Софи хараал урсгасаар, хурдаа нэмж давхилаа.

Хэсэг 33

Софи Шонс - Элизийн замаар буцан уруудангаа, машинуудыг сүлжинэ. Ландон хажууд нь суудалдээрээ байдгаараа цайчихсан, цагдаагийн машин хөөж байна уу гэдгийг шалган, байн байн арынтолиндоо харж явлаа. Гэнэт тэр зугтахаар шийдсэндээ харамсав.

Гэхдээ энэ бүхнийг би өөрөө шийдээгүй шүү дээ! Софи халаасан дахь дамжуулагчийг цонхооршидсэнээс л бүх зүйл эхэлсэн шүүдээ.

Хэдийгээр Софи цагдаагийнхны машинаас мултарч гарсан ч, Ландонд энэ байдал удаанүргэлжлэхгүй мэт санагдана. Жолооны ард сууж байсан, Софи халаас руугаа гараа хийж, жижигметалл зүйл гаргаж ирээд, Ландонд өгөв.

"Роберт, чи үүнийг хар даа! Өвөө үүнийг Мадоннагийн ард өлгөсөн байсан".

Ландоны таамаглаж байсан нь зөв болж, эцэст нь түлхүүрийг харлаа. Тэр эхлээд дээрх загалмайдүрсийг хараад, булшин дээрхтэй ижил гэдгийг анзаарсан аж. Үзүүр нь 3 талтай призм хэлбэртэйбайгааг бас олж харав. Тал болгон нь дээрээ олон ховил, нүхтэй байх бөгөөд, тэдгээр нь эмхзамбараагүй мэт энд тэнд байрлажээ.

"Энэ бол лазер тусгалаар хийсэн түлхүүр. Ийм түлхүүрийг электрон хэлбэрээр уншдаг юм".

Түлхүүр гэнээ?

Ландон ийм түлхүүрийг урьд нь огт харж байсангүй.

"Нөгөө талыг нь хар даа!" гээд Софи түлхүүрийг эргүүлж, харуулав.

Ландон түлхүүрийг эргүүлж харангуугаа, нүд нь орой дээрээ гарчлав. Түлхүүрийн

бариул дээрсараана цэцгийн дүртэй P.S. үсгийг дүрсэлсэн байв.

"Софи энэ чинь миний хэлсэн дүрс байна шүү дээ! Сионий Прайорийн албан ёсны бэлгэдэл дүрсбайгаа юм".

Бүсгүй хариуд нь толгой дохиж, "Би үүнийг багадаа харж байсан гэж чамд хэлсэн. Өвөө энэ тухайярих хэрэггүй гэж надаас ам өчиг тэр үед авч байсан юм".

Ландоны нүд түлхүүрээс огт салсангүй. Өнөө үеийн нарийн технологиор бүтсэн, энэ түлхүүр дээрэртний бүлэглэлийн бэлгэдэл дүрс цугтаа байгаа нь эрт, эдүгээг холбож байгаа гүүр мэт түүндсанагдана.

"Өвөө надад энэ түлхүүрээр олон нууц бүхий хайрцгийг онгойлгодог гэж хэлж байсан".

Сониех шиг хүмүүс чухам ямар нууцтай болохыг Ландон дотроо төсөөлөн, зүрх нь тэсгэлгүйдогдолно.

Эртний бүлэглэл Ахан дүүсийн холбоо орчин үеийн энэ түлхүүрийг юунд ашигладаг хэрэг вэ? Сионий Прайори бол нууц хадгалах зорилгоор байгуулагдсан бүлэглэл. Тэр нууц нь маш хүчтэй. Тэгэхээр энэ түлхүүр тэр нууцтай ямар холбоотой болж таарах вэ?

"Чи үүнийг юунд ашигладгийг мэдэх үү?" гэж Ландон асуув.

Софи сэтгэл гонсгор дуугаар, "Би чамайг мэддэг гэж бодсон юм!" гэж хариулав.

Ландон дуугүй хэвээр, түлхүүрийг эргүүлж тойруулан харна.

"Христийн загалмайг дүрсэлсэн юм биш үү?" гэж Софи саналаа хэлэв.

Ландон харин тэгж бодохгүй байлаа. Христийн загалмай бол суурь нь урт хэлбэртэй дүрслэгддэгбайхад, түлхүүр дээрх дүрс 4 тал нь тэнцүү, тэгш хэмтэй хэрээс тэмдэг байв. Энэхүү тэмдгийг Христээс 15 - р зууны өмнө хэрэглэж эхэлсэн юм. Харин Христийн загалмайг Ромчууд залхаанцээрлүүлэх зэвсгийн бэлгэдэл болгон анх хэрэглэж эхэлсэн юм. Ландоны олж мэдсэнээр болзагалмай буюу хэрээс (cross) гэж үг нь Латинаар cru - cruce гэж хэлэгддэг, тамлан тарчлаах гэсэнутгатай үг юм.

"Софи, энэ бол Есүс Христийн цовдлогдсон загалмай огт биш. Харин эр, эм хүйсийн эрх тэгшбайдлыг илтгэсэн босоо, хөндлөн хоёр зураас буюу өөрөөр хэлбэл, Сионий Прайорийн баримталдаг гол үзлийн өөр нэгэн бэлгэдэл байгаа юм".

Софи түүн рүү арга ядсан байдалтай харж, "Тэгээд ямар учиртайг нь чи мэдэж болох нь уу?"

Ландон хөмсгөө зангидаж, "Харин л дээ. Сайн мэдэхгүй юм".

"За яахав. Ямар ч байсан төв замаас гаръя" гэж Софи хэлээд, арын толиндоо машин хар ангаа, "Энэ түлхүүрийг юунд ашигладгийг олж мэдэхийн тулд бидэнд тав тухтай газар хэрэгтэй".

Ландон энэ тухай сонсонгуугаа, Рийц зочид буудлыг санав. Гэхдээ тийш очиж болохгүй.

"Намайг энд урьсан хүмүүс дээр очвол яасан юм бэ?"

"Ингэх боломжгүй. Фааш тэднийг бас мөрдөж байгаа".

"Чамд энд таньдаг хүн байгаа биз дээ?"

"Фааш миний утсыг чагнаж, надтай "холбоотой бүх хүмүүстэй холбогдсон байгаа. Надтайхолбоотой байдаг бүх хүний хаягийг Фааш олсон байх. Зочид буудалд орлоо гэхэд заавал биднээсбичиг баримт шаардана шүү дээ!"

Аль Луврт байхдаа, Фаашид баривчлагдах минь яав даа гэж Ландон бас л бодов.

"Элчин сайдын яам руу ярья. Би нөхцөл байдлыг тэдэнд тайлбарлавал, бидэнтэй уулзуулахаар, хүнявуулах байх" гэж Ландон горьдлого тээн өгүүлэв.

"уулзах гэнэ ээ?" гэж Софи хэлээд, галзуу хүн рүү харж байгаа юм шиг түүнийг ширтэв.

"Роберт, чи сэрээч. Танай ЭСЯ өөрийн эзэмшлээс өөр газар үйл ажиллагаа явуулах эрх байхгүй.Хэрэв бидэн рүү хүн илгээвэл, энэ нь Францын засгийн газрын эсрэг үйл ажиллагаа явуулж байнагэсэн үг. Ийм юм хэзээ ч болохгүй. Хэрвээ чи ЭСЯ руу нэвтэрч чадаад, улс төрийн орогнол хүсчбайгаа бол нэг хэрэг. Харин Францын засгийн газрын эсрэг хөдлөхийг хүсч байгаа бол өөр хэрэгшүү дээ!" гээд Софи толгой сэгсэрч,

"Чи ЭСЯ руугаа одоо утастаад үз! Тэд асуудалд орохыг хүсэхгүй учраас, чамайг Фааш руу буцаадоч гэж хэлнэ. Үүнийхээ дараа тэд чамайг дипломат сувгаар татан авна гэдгээ тайлбарлах болно".

Софи замын хажуугаар урсан өнгөрөх, тансаг дэлгүүрүүдийн цонх руу хараад, "Чамд одоо бэлэнмөнгө байгаа юу?" гэж асуув.

Ландон хэтэвчээ гаргаж үзээд, "100 доллар. Хэдэн евро байна. Яах гэж?"

"Төлбөрийн карт байгаа юу?"

"Мэдээж, байлгүй яахав".

Софиг хурдаа нэмэхэд, бүсгүй нэг зүйл төлөвлөснийг Ландон ойлголоо.

Шонс - Элизийн төгсгөл ойртоход, Напелеон өөрийн армийнхны, сүр хүчийг илтгэж бариулсан,Ялалтын арк харагдлаа. Аркийн их тойруу тийш дөхөх зуур, Софи арын толиндоо байн байн харна.

"Бидтэднээстүрч гэсэн мултрах шиг боллоо. Гэхдээ энэ машинаараа бид цааш удаан явахболомжгүй".

Тэгээд өөр машин хулгайлах болж байна уу? Бүрмөсөн хэрэгтэн болох нь ээ? гэж Ландон бодоод, "Чи юу хийх гэж байна?" гэж шалгаав.

Софи их тойрууд орох зуураа, "Надад итгэ!" гэж хэлэв.

Ландон хариу хэлсэнгүй. Тэр үнэндээ бусдад итгээд, хэр хол явахаа мэдэхгүй байлаа. Ханцуйгаахойш болгож, 10 насных нь төрсөн өдрөөр аав, ээж хоёр нь бэлэглэсэн, Микки Маусын зурагтай,хүүхдийн цаг руугаа харав. Энэ цаг хэтэрхий хүүхдийн гэмээр инээдтэй харагддаг ч, Ландонүүнээс өөр цаг зүүж байсангүй. Диснейн хүүхэлдэйн киног анх үзээд, өнгө будгийн ид шидтэйтанилцаж байсан болохоор, Микки хулгана үргэлжийн шинэ залуу эрч хүчийг одоо ч түүнд өгсөөрбайдаг юм.

Харин энэ агшинд Микки Маусын хос гар, маш орой болсныг илтгэн, шөнийн 2:51 гэсэн

тоог заажбайв.

"Гоё цаг байна шүү!" гэж Софи түүний бугуйн дахь цагийг нүдний булангаараа харангаа, ихгойрууг даган, цагийн зүүний эсрэг эргэж байв.

"Яривал урт түүх болно" гэж хэлээд, Ландон ханцуйгаа буулгав.

"Тийм байх гэж итгэж байна" гэж Софи хэлээд, инээмсэглэв.

Их тойруугаас гараад, хоёр уулзвар өнгөрч, гурав дахь уулзвараар баруун тийш Малешербс өргөнчөлөө рүү эргэв.

Гял цал болсон хотын хөдөлгөөнт гудамж аажмаар үйлдвэрийн дүүргээр солигдов. Софи зүүнтийш эргэхэд, Ландон хаана ирснээ ойлгов. Энэ бол Гаре Сейнт Лазаре галт тэрэгний буудалбайлаа.

Тэдний өмнө шилэн дээвэртэй, вокзалын барилга харагдлаа. Европын галт тэрэгний буудлуудадшөнөөр ч хүн тасардаггүй аж. Шөнө болсон хирнээ, хөлсний таксинууд буудлын үүлэн дээр хэдэнарваараа цувран зогсжээ. Задгай талбайн саравчин доор хачиртай талх, цэвэр ус зарж байхад, галттэрэгнээс дөнгөж бууж ирсэн бололтой хэдэн тэнүүлч хүүхдүүд гараараа ийш тийш занган ярих ньхарагдана.

Софи таксин цувааны ард тулж зогсоод, Ландоныг асуухын завдалгүй машинаасаа буучхав. Бүсгүйшууд алхсаар, урд зогсох таксины жолоочтой ярьж эхэллээ. Ландоныг машинаас бугаад хартал, Софи нөгөө таксины жолоочид боодолтой бэлэн мөнгө өгч байлаа. Таксины жолооч толгой дохиод, удалгүй давхиж олов.

"Юу болоо вэ?" гэж Ландоныг асуувал, Софи вокзалын үүд рүү алхангаа,

"Зүгээрээ! Хүрээд ир! Бид Парисаас дараачийн галт тэргээр явна".

Ландон алхаагаа хурдасгаж, бүсгүйн дэргэд очоод, Лувраас ганц милийн зайтай ЭСЯ руу очихбайснаа больж, одоо бүр урт аялал тэднийг хүлээж байгааг сонсоод эгдүүцэнэ.

Ландоны итгэл нь улам багассаар ...

Хэсэг 34

Хамба лам Арингарозаг "Леонаодо Да Винчи" нисэх онгоцны буудлаас тосож авсан, машин харэнгийн, доожоо муутай Фиат байлаа. Ватиканы сүмийнхэн машин дээрээ өөрсдийн бэлгэдлийгтодоор дүрсэлдэг байсан үеийг Арингароза нэхэн дурсав.

Тэр үе одоо нэгэнт ард хоцорчээ.

Одоо сүмийнхэн огт таних тэмдэггүй, анхаарал бага татахаар машин унаж хэрэглэдэг болсон. Үүнийгээ тэд зардал хэмнэж, үр ашигтай байдлыг нэмэгдүүлнэ хэмээн тайлбарладаг ч, үнэндээаюулгүй байдлыг бодолцсондоо тэгсэн гэдгийг Арингароза сайн мэднэ. Одоо үед дэлх ий ертөнцэмх замбараагүйгээр тэнхлэгээ тойрон эргэж байгаа тул, Европт Есүс Христийг магтан дуулдгаазарлан хэлнэ гэдэг орсон бухын өмнө улаан хувцастай зогсож байгаа, Матадороос ялгаагүй гэсэнүг.

Арингароза хар кассокныхоо хормойг ялимгүй сөхөн, машинд орж суугаад, Кастел Гандольфотийш явах урт замдаа орон хөдлөв.

5 сарын өмнө би яг энэ замаар явж байсан. Ноднин жилийн Ром дахь тэр аялал, гээд Арингарозасанаа алдав. Миний амьдралд тохиолдсон хамгийн урт шөнө.

5 сарын өмнө буюу, өнгөрсөн жилийн намар Ромоос түүн рүү утастаж, даруй хүрэлцэн ирэхийг хүссэн юм. Тэд хамбыг ямар ч тайлбаргүй урьсан билээ.

"Чиний онгоцны тийз нисэх онгоцны буудал дээр байгаа" гэхэд, Нью - Иорк дахь Опус Дейнамжилтыг сайшаахаар дууджээ гэж Арингарозагийн эхлээд таамагласан ажээ.

Арингароза хамба урилгыг дуртай дургүй ч хүлээн авахаас өөр арга байсангүй. Ромын Папынбайгуулсан, одоогийн удирдлагын бүтцийг тэрээр сайшаадаггүй ч, шинээр гарсан Папсонгогдсоноосоо хойш, жилийн дотор түүнийг Ватиканд дуудаж байгаа явдалд, хамба лам их эд ачхолбогдол өгч байв.

Папын олон нийтэд хэлсэн хамгийн сүүлийн үг болох "Католикийн шашны сургаал номлолыг шинэчлэн тодорхойлж, шинэ мянганыг угтах болно" гэснийг Арингароза анх сонсоод, ихэддурамжхан хүлээж авсан юм.

Опус Дейг одоогийн амжилтад хүргэхийн тулд, Арингароза өмнөх Пап болон түүний туслахуудтай маш нягт харилцаа тогтоож, өөрийн хичээл зүтгэл, нөр их хөдөлмөрөө зөвхөн үүнд зориулжээ.

"Сүмийнхэн хүмүүсийг чанд тогтоон барих ёстой! Эрхлүүлэн бөөцийлж, дураар нь аашлуулж, хэрхэвч болохгүй" гэж Арингароза үргэлж хэлдэг байв.

Харин тэр шөнө Арингарозагийн суусан машин Ватикан руу биш өөр зүгт, уулархаг замаар яваад байгааг, тэр анзаарчээ.

"Бид хаагуур яваад байна вэ?" гэж тэр жолоочоос асуув.

"Альпийн нуруугаар явж байна. Та Кастел Гандольфо дээр уулзалттай гэсэн биз дээ!"

Папын зуслангийн эдлэн газар уу?

Арингароза тэнд очиж үзэхийг үргэлж мөрөөддөг байсансан.

Тэнд Папын зуслангийн байрнаас гадна, 16 - р зуунд баригдсан Европын Одон орны судлалын томоохон төв болсон цайз хэрэм оршдог билээ. Харин Арингароза Ватиканы Сүм шинжлэх ухаантай холбогдсон талаарх ямарваа нэг зүйлийг сонсох тун дургүй.

Итгэл бишрэл, шинжлэх ухаан хоёрыг нэгэн дээвэр дор яахин багтааж болох билээ? Бурхандитгэдэггүй хүн шинжлэх ухааныг танин мэдэж чадахгүй шүүдээ!

Ингэж бодож байтал, өвлийн эхэн сарын тэнгэрт түгсэн оддын наана Кастел Гандольфо тодрон харагдав. Замаар хурдлан яваа машин дотроос, Кастел Гандольфо эгц халил хаднаас үсрэх гэж буйаварга мангас шиг харагдана.

Хэдийгээр цайзын зөвхөн сүүдэр тал нь харагдавч, түүний уран барилгын шийдэл нь өндөр эгцхадтай хослоод, сүр жавхлантай үзэгдэнэ. Харамсалтай нь сүүлд байгуулсан, дуран авайн хоёрбайгууламж түүний сүрийг бүр дарж орхиод, эртний хөлөг баатарт багт наадмын хос цаасан малгай өмсгөсөн мэт ажээ.

Арингарозаг машинаас буухад, "Түүн дээр нэгэн номлогч сандран гүйж ирээд, бушуухан мэндлэв.

"Хамба ламтан, тавгай морил! Намайг эцэг лам Мангано гэдэг. Би эндхийн одон орон судлаач".

"Сайн байна уу?" гэж хамба хариу мэндлээд, түүнийг дагаж цайзын барилга руу явж орлоо.

Уужим талбайтай үүдний өрөөнд сэргэн мандлын үеийн уран зураг болон, одон орны гэрэлзургуудыг ихээр өлгөжээ. Тэд өргөн, гантиг шатаар өгсөн гарахад, дээд давхар дахь уулзалтынтанхим, лекцийн танхим, жуулчдын лавлах үйлчилгээний хэсэг зэрэг газруудын таних тэмдгийг Арингароза олж харлаа. Үүнийг үзсэн Арингароза Ватиканы сүм сүсэг бишрэл, итгэл үнэмшлийн ойлголтоо улам ихээр алдаж, жуулчдад зориулсан үйлчилгээний байгууллага болж байгааг анзаарч явав.

"Хэзээнээс сүүл нь нохойгоо хөдөлгөх болсон юм бол?" гэж Арингароза номлогчоос асуув.

Номлогч түүн рүү гайхан харж, "Уучлаарай, та юу гэсэн бэ?"

Арингароза өнөө орой энэ сэдвээр дахиж ярихгүй байхаар шийдээд, гараараа дохин, цааш алхав.

Ватикан үнэхээр тэнэг алхам хийж байна даа! Яг л хүүхдийг эрх дураар нь давраадаг эцэг эх шиг. Сүмийнхэн бүх талаараа буулт хийж, өөрийн соёлыг үгүй хийсээр байгаа юм байна.

Дээд давхрын хонгил өргөн зайтай бөгөөд, зөвхөн нэг чигт хөтөлсөн замтай. Тэр нь өргөн томхаалган дээр тулж очоод зогсдог аж. Хаалган дээр "Одон орон судлалын номын сан" гэсэн хаяг байв.

Арингароза Ватиканы энэхүү номын сангийн талаар өмнө нь дуулж байсан бөгөөд, тэнд Коперник, Галилео, Кеплер, Ньютон, Сечи зэрэг суут эрдэмтдийн судалгааны бүтээл гэх мэт 25 мянга гаруйном хадгалагддаг гэсэн цуу яриаг сонссон байжээ. Үнэндээ энэ номын санд зөвхөн тусгай тохиолдолд Папын доорх өндөр тушаал бүхий хүмүүс зарим нэг зүйлийг нууцаар хэлэлцэхийн тулд цуглардаг аж.

Хамба лам Арингароза хаалга руу дөхөж очихдоо, түүнийг муу мэдээ хүлээж байгааг огтхон ч гадарласангүй. Цагийн дараа, тэрээр уулзалтаас гарч ирэхдээ сүг болохоос наагуур царайлан, шатаар бууж байсан билээ.

Тэр бол одоогоос яг 6 сарын өмнөх явдал. Бурхан минь надад туслаач!

Хамба лам Арингароза энэ уулзалтын талаар бодож байхдаа, нударгаа чанга гэгч зангидсан байлаа. Хүч чадал түүний бүх биеэр тарсныг мэдэрсэн даруйдаа, тэр сэтгэл хангалуунаар инээмсэглэв.

Бүх зүйл сайхан болно гэж тэр өөртөө хэлэх үед, Фиат машин уулын замаар өгсөн явж байв. Гэрээр тусгай дуугарахыг л хүлээн чагнах аж.

Багш яагаад над руу залгахгүй байна аа? Силас одоо Оньсон чулууг гартаа лав оруулсан байх ёстой.

Тэрээр сэтгэл хөдлөлөө дарахын тулд, бөгжин дэх ягаавгар туяатай, том алмазан шигтгээ рүүгээ ширтэн анхаарлаа сарниулж байлаа. Шигтгээний талст өнцгүүдийг хуруугаараа илэнгээ, удахгүй өөрт нь оногдох гэж байгаа, сүр хүчний дэргэд чулууны үнэ цэнэ хаана нь ч

хүрэхгүй хэмээнөөртөө байн байн сануулна.

Хэсэг 35

"Гаре Сейнт Лазаре" галт тэрэгний буудал Европын бусад буудлуудаас үнэндээ ялгарах юмгүй. Тэнд орон гэргүй хүмүүс хүзүүндээ хаяг зүүгээстэй, коллежийн оюутнууд өөрийнхөө ачааг доороо

дэвсээд, гадаах ертөнцөөс тусгаарлагдахын тулд MP3 тоглуулагч сонсоод хэвтээстэй, мөн тээшачигчид ажлаа түр завсарлаад, тамхи татан суух нь, бүхний нүдэнд ил харагдана.

Софи галт тэрэгний хуваарийн самбар луу өлийн харлаа. Самбарын хавтангууд хэдэн хоромбодоод л, эргэлдэн солигдож, дээрх мэдээлэл нь тэр дороо шинэчлэгдэж байв .

Ландон бас самбар луу харвал, хамгийн ойр байгаа галт тэрэгний хуваарь нь Лион руу 3:06минутаг хөдөлнө гэж бичсэн байлаа.

"Арай түргэн явдаг бодоосой!" гэж Софиг хэлэхэд, Ландон цагаа хараад, Түргэн гэнэ үү! гэждотроо бодлоо.

Тэр үед цаг 2:59 болж байлаа. Галт тэрэг 7 минутын дараа хөдлөх боловч, тэд одоо хүртэлтасалбараа аваагүй л байв.

Софи Ландоныг тасалбар түгээгч рүү дагуулж очоод, "Төлбөрийнхөө картаар 2 тасалбар худалдаадавчих!" гэж шууд хэллээ.

"Хэрвээ төлбөрийн карт хэрэглэвэл, биднийг илрүүлээд ...?"

"Харин тийм".

Ландон Софи Нөвүг дахин шалгаахаа болилоо. Тэр виза картаар 2 тасалбар авч, Софид өгөв. Софитүүнийг дагуулан явахад буудлын зарлагч Лион руу хөдлөх галт тэрэгний анхааруулгыгзорчигчдод эцсийн удаа өглөө. Лион руу явах галт тэрэг 3 - р зам дээр хөдлөхөд бэлэн зогсож байсанч, Софи Ландоныг шал өөр зүг рүү хөтлөн алхав.

Тэд явсаар буудлын үүдээр гарч, гудамжинд очиж зогсов. Гэтэл нэг такси тэнд зогсож байснаа,Софиг хараад, гэрлээ анивчуулж, дохио өглөө. Софиг таксины арын суудал руу ү срэн ороход,Ландон түүний араас орж суув. Такси төмөр замаас хөдлөхөд, Софи саяхан авсан тасалбараагаргаж ирээд, урж орхив. Ландон дэмий үрсэн 70 долларынхоо хойноос харамсан, санаа алдав.Тэрээр цонхоор баруун тийш харвал, Монмартр болон Сакре Көохийн үзэсгэлэнт цэнгэлдэххүрээлэн түүний нүдэнд туслаа.

Гэтэл тэдний явж байсан урсгалын эсрэг зүгт цагдаагийн машин дохиогоо хангинуулсаар өнгөрөв.Ландон, Софи хоёр цагдаагийн машиныг холдож өнгөртөл, доошоо бөхийж арын суудалдаануугдчихав.

Таксины жолоочоос бүсгүй тэр хоёрыг хотоос гадагш хүргэж өгөхийг хүссэн бөгөөд, Ландонытаамагласнаар бүсгүй дараагийн алхмаа төлөвлөх гэж цаг хожиж байгаа бололтой байв.

Ландон түлхүүрийг дахин гаргаж ирээд, цонхонд ойртуулан нүднийхээ өмнө ойрхон барингаа,түлхүүрийг хийсэн газрын хаяг дээр нь бичигдсэн эсэхийг олохоор, шимтэн ширтэнэ. Замындэргэдүүр өнгөрөх гудамжны тод гэрэлд сайтар харсан боловч, Прайорийн бэлгэдэл дүрсээс өөрзүйлийг тэр олж харсангүй.

"Учир нь олдохгүй юм" гэж тэр хэллээ.

"Ямар утгаараа?"

"Танай өвөө чинь энэ их бэрхшээлийг давж чамд түлхүүрийг үлдээчхээд байхад, чи, бид хоёр ямаручиртайг нь ойлгохгүй байна шүү дээ!"

"Тэр ч тийм шүү".

"Мадоннагийн ард ямар нэг өөр зүйл бичиж үлдээсэн эсэхийг чи сайн шалгасан биз дээ?"

"Би бүгдийг нь шалгасан. Тэнд зөвхөн энэ түлхүүр л байсан. Үүнийг зургийн ард талд өлгөсөнбайсан юм. Би түлхүүр дээрх Прайорийн бэлгэдэл дүрсийг харчхаад л, түлхүүрийг шууд авч,халаасандаа хийсэн".

Ландон түлхүүрийн үзүүр дэх мохоо хэсгийг ширтэнгээ хөмсгөө зангидна.

Юу ч алга!

Эргэн тойрон эргүүлж харав. Бас л алга.

"Энэ түлхүүрийг саяхан арчиж цэвэрлэсэн бололтой!"

"Чи яаж мэдээ вэ?"

"Эндээс спиртийн эхүүн үнэр үнэртэж байна".

Бүсгүй түүн рүү харж, "Чи сая юу гэсэн бэ?"

"Үүнийг цэвэрлэгч шингэнээр арчсан юм шиг байна" гэж хэлээд, Ландон түлхүүрийг хамартааойртуулж үнэрлэв.

"Нэг талд нь нөгөөгөөсөө илүү үнэртэж байна. Тиймээ, энэ яг спиртийн төрлийн шингэнээр арчсанюм шиг...?!" гэж хэлээд, Ландон гайхан суух аж.

"Юу гэнэ ээ?"

Ландон түлхүүрийг гэрэлд дахин ойртуулан барьж, загалмай бүхий ишний нэг талыг нягтланхарлаа. Гэтэл түүн дээр нэгэн зүйл тодорч ирэхийг Ландон анзаарав.

"Чи тэр харанхуйд түлхүүрийн нэг талд үсэг байхыг яаж харсан юм бэ?"

"Аан тэр үү? Би тэр үед яарч байсан болохоор, сайн харж амжаагүй ээ!"

Ландон түүн рүү эргэж хараад, "Чамд лазер тусгалтай гэрэл чинь байна уу?"

Софи халаасаа уудалж, лазер гэрлийг гаргаж ирлээ. Ландон түүнээс гэрлийг аваад, түлхүүр рүүтусгав. Гэтэл түлхүүрийн нэг тал дээр нэг зүйл бичсэн нь тэр дороо гэрэлд тодрон харагдлаа. Яарчсандраад бичсэн бололтой харагдавч, түүнийг нь уншиж болохоор ажээ.

"Яагаад эндээс спирт үнэртээд байсныг одоо л мэдлээ!" гэж Ландон инээмсэглэн хэлэв.

Софи түлхүүр дээр тодорч харагдах бичгийг хараад алмайрч орхив. "Рью Аксогийн 24" гэжтүлхүүр дээр бичсэн байлаа.

Энэ чинь хаяг байна шүүдээ! Өвөө чинь энд хаяг бичжээ!

"Энэ хаана байдаг юм бэ?" гэж Ландон Софигоос асуув.

Софи хаягийг сайн мэдэхгүй байсан учир, урагш бөхийж, "Кунасеvu ла Рью Аксо?" гэж жолоочоосцовоо дугаар асуув. Жолооч хэсэг бодож байснаа толгой дохив.

Тэрээр Софигийн хэлсэн хаяг бол теннисний цэнгэлдэх хүрээлэнгийн ойролцоо, Парисын баруундүүрэгт байдаг газар гэж хариулав. Бүсгүй шууд тийш явахыг жолоочид зөвлөлөө.

"Буа де Булонцагаар дайрч явбал хурдан" гэж жолооч Францаар дуржигнуула ад, "Тэр замаар явчихуу?" гэж бүсгүйгээс асуув. Софи хөмсгөө зангидаж, тэрхүү хэцүү замаар явахаас, зайлсхийхболовч, өөр сонголт байхгүй тул, аргагүй зөвшөөрч, "Уи!" гэж хариулахдаа, тэр замаар явбал, хамтяваа америк эр лав цочирдох биз гэж дотроо бодлоо.

Софи түлхүүр лүү дахин харж, түлхүүр дээрх хаягаар очвол, тэднийг юу хүлээж байгааг төсөөлөв.

Тэнд сүм байдаг юм болов уу? Эсвэл тэнд Прайорийн төв удирдлага байдаг юм болов уу?

Бүсгүй 10 жилийн өмнө байшингийн доод хонгилд харсан, нууц ёслолыг бас л дахин санаж, уртаарсанаа алдлаа.

"Роберт, чамд ярих зүйл маш их байна!" гэж Софи хэлээд, бага зэрэг түгдэрснээ, "Гэхдээ эхлээд чинадад Сионий Прайорийн талаар мэддэг бүхнээ ярьж өгөх хэрэгтэй байна" гэв.

Хэсэг 36

Сал Дес Этагаас холгүйхэн, ахмад Фааш харгалзагч Груагийн нуршиж тайлагнахыг тэвчээр заансонсож байв. Ландон, Софи хоёр түүнийг хэрхэн дөнгөсөн тухай Груаг ярина.

Яагаад зургийг нэвт буудчихаж болоогүй юм бол?

"Ахмад аа!" гэсээр дэслэгч Коле тэдэн дээр гүйхээрээ ирээд, "Ахмад аа! Саяхан шинжээч СофиНөвүгийн машиныг олсон гэж надад мэдэгдлээ".

"Хаанаас? Америкийн ЭСЯ - ны дэргэдээс үү?"

"Үгүй ээ! Вокзал дээрээс. 2 хүний тасалбар тэндээс худалдаж авсан гэнэ. Дөнгөж сая тэдний суусангалт тэрэг хөдөлсөн байна".

Фааш Груагийн яриаг сонсож дууссанаа мэдэгдэн, гараараа дохиод, Колег хүнээс зайдуу газардагуулан очив. Ахмад түүнд сонсогдохтой үгүйтэй, "Галт тэрэг аль зүгт яваа юм бэ?" гэж асуув.

"Лион".

"Энэ занга байж магадгүй!" гээд Фааш уртаар амьсгаа авангаа, төлөвлөгөө боловсруулж байгаабололтой хэсэг азнаснаа, "За тэгвэл, дараагийн буудал дээр нь юу ч гэсэн шалга! Машиныг анхбайсан газарт нь орхиод, хөндлөнгөөс хяна! Тэд буцаад ирж магадгүй. Тэр хавийн гудамж, талбайгнэгж! Одоо тэр хавьцаа шугамын автобус явж байгаа юу?"

"Зогсчихсон байгаа. Такси харин явж байгаа".

"Сайн байна. Тэгвэл таксины жолооч нараас ямар нэг сэжүүр гарч магадгүй. Тэднийг байцааж, таксины диспетчерээр нь дамжуулан, бусад жолооч нарт анхааруулга өг! Би харин Интерпол рууэнэ тухай мэдэгдье!"

Коле гайхширч, "Та гал дээр тос нэмж байгаа юм биш үү?"

Фаашид хэдийгээр энэ бүхэн ичгүүртэй байгаач, өөр сонголт үлдээгүй байлаа.

Хүндээ хөнгөнөөс өгч болохгүй шүүдээ!

Сэжигтэн, оргодлуудын хийх үйлдэл нэг цагийн дараа гэхэд, ерөнхийдөө нэг л зүйл дээртөвлөрдөг. Тэд үргэлж 3 үйлдлийг ихэр юм шиг давтдаг. Энэ нь зугтах, нуугдаж орогнох, мөнгөолох. Эдгээр үйлдлүүд бол тэдний хувьд мөнхийн гинжин хэлхээ байсаар ирсэн. Энэ хэлхээндүндэслэж, Интерпол хэрэгтнүүдийг мөрдөх арга хэлбэрээ хөдөлбөргүй хэрэгжүүлдэг юм.

Ландон, Софи хоёрын гэрэл зургийг Интерпол Парис дахь жуулчны байгууллага, зочид буудал, банк зэрэг олон нийттэй харилцдаг байгууллагуудад илгээснээр, тэд танигдахгүйгээр зугтаж босох, нуугдах, мөнгөтэй болохын алиныг ч хийх боломжгүй болно гэсэн үг.

Сэжигтнүүд заримдаа сандарч тэвдсэндээ болоод, олны нүдэн дээр тэнэг үйлдэл хийдэг нь машинхулгайлж, дэлгүүр дээрэмдэх зэргээр илэрдэг. Эсвэл төлбөрийн картаараа гүйлгээ хийж ч мэднэ. Эдгээрийн алиныг ч хийсэн, орон нутгийн цагдаагийнхны хараанд заавал өртөнө гэсэн уг.

"Зөвхөн Ландоныг сэжиглэж байгаа биз дээ? Софи Нөвү бол манай ажилтан шүү дээ!"

"Мэдээж, би Софиг сэжиглэж байгаа! Ландонд туслаад байгаа хүнийг сэжиглэхгүй байх нь утгагүй биз дээ! Түүнтэй холбоотой бүхий л хүмүүсийг хараандаа авч мөрдөх болно. Тэр одоо юу бодож байгааг хэлж мэдэхгүй ч, өөрийн ажлаар дэнчин тавиад, энэ бүх хэрэгт хутгалдчихсан байгааг л бисайн мэдэж байна".

"Та намайг арын албанд томилох уу? Эсвэл, би үүнд гар бие оролцох уу?"

"Оролцсон нь дээр байх. Хүмүүсээ аваад, вокзал руу яв. Чи ерөнхийд нь мөрдөлтийг г удирдах болно. Гэхдээ миний тушаалгүйгээр нэг ч үйлдэл хийж болохгүй шүү!"

"Гүйцэтгэе, ахмад аа!" гээд Коле гүйж одов.

Фааш өрөөний цонхоор гадагш харвал, шилэн пирамидын тустал усан оргилуурын гадаргад харагдаад, мяралзан долгиолно.

Тэд миний хамар дороос зугтчихлаа!

Тусгайлан урьдаас бэлтгэгдсэн мэргэжилтэн шинжээч бүсгүй Интерполын мөрдөх ажиллагааг хэрхэн давж гарах нь Фаашийн сонирхлыг өөрийн эрхгүй татаж байв.

Шинжээч бүсгүй, их сургуулийн болхи багш хоёр үүр цайхыг үзэж чадалгүй баригдах нь гарцаагүй гэж ахмад бодно.

Хэсэг 37

Өтгөн шигүү мод, ургамалтай энэ цэцэрлэгийг "Буа де Булониа" гэж нэрлэдэг боловч Парисынхан "Зугаа цэнгэлийн цэцэрлэг" гэдгээр нь андахгүй сайн мэднэ. Харин зураач Бош энэхүү цэцэрлэгийг дүрсэлснийг харсан хүн тэндээс зугаа цэнгэл гээчийг олж харахгүй. Бош цэцэрлэгт хэт хийсвэр нэрөгсөн гэдгийг шүүмжлэх гэж тэр зургийг зурсан гэж ихэнх хүмүүс дүгнэдэг аж.

Ландон Сионий Прайорийн талаар Софид ярьж өгөхдөө бэлдэн, өөрийн бодлыг төвлөрүүлж байххооронд, тэдний суусан такси цэцэрлэгийн үүдээр нэвтэрч, баруун тийш эргэж байв. Ландоны бодол санаа сарниж, цэцэрлэгт хөлхөх шөнийн гийчид дээр нүд нь

тусав. Өсвөр насны хоёр охинтаксины зүг цоо ширтэнэ. Тэдний ард тас хар арьстай залуу зогсож байснаа, цааш эргэж, нуруугаахаруулаад зогсчхов. Түүний хажууд нэгэн царайлаг эмэгтэй таксины зүг банзлаа сөхөөд харуултал, тэрээр бүсгүй хүн биш, харин өөр хүйстэн байв.

Бурхан минь туслаач! хэмээн Ландон залбираад, харцаа буруулж өөр тийш харж амжив.

"Надад Сионий Прайорийн тухай яриач!" гэж Софи хүсэв.

Ландонд ярих гэж буй зүйл нь одоогийн нөхцөл байдалтай огт харш мэт санагдавч, толгой дохинзөвшөөрөв.

Ахан дүүсийн холбоо бол мянган жилийн түүхтэй бөгөөд, энэ бүх хугацаанд нууцаас гаднааймшигт сүрдүүлэг, урван тэрслэлт, тамлал цээрлүүлэлтээр дүүрэн, бартаа бүхий замыг туулсан юм.

"Францын хаан Годфруа Де Буёон Иерусалим хотыг эзэлснийхээ дараа, 1099 онд Сионий Прайорийг анх байгуулсан юм".

Софи толгой дохин түүнийг анхааралтай сонсоно.

"Годфруа хаанд Христийн тооллоос хойш өвлөгдөн үлдсэн нэгэн нууц байсан аж. Тэрээр нууцыг задруулахгүйн тулд, нууц холбоо болох Сионий Прайорийг байгуулж, үеэс үе дамжин нууцыг чандлан хадгалах үүргийг тэдэнд оноожээ. Иерусалимд байх үедээ Сионий Прайорийнхан Херодотын сүмд тэрхүү нууцаа булж орхижээ. Он жил өнгөрөхийн хэрээр, нууц бичгийг сүмийн нурангаас дахин гарган авах нь, нууцыг хадгалах шилдэг арга гэж Сионий Прайоричууд үзжээ. Ингээд Сионий Прайори нууцыг буцааж гаргахын тулд, цэргийн хүч төвлөрүүлж, түүнийгээ ᠑ хөлөг баатраар удирдуулсан нь, Христийн хөлөг баатрууд гэгдэх болжээ. Одоо бол тэднийг Хөлөг Баатруудын холбоо гэж нэрлэдэг".

Софигийн мэддэг зүйл гарч ирсэнд, тэр маш их гайхаж байлаа. Ландон лекц тавихдаа, Хөлөг Баатруудын холбооны тухай амаа чилтэл дурсаж байсан бөгөөд, энэ бүгдэд хүмүүс тэдний тухаймар нэг байдлаар өмнө сонссон байдаг байв. Судлаачдын хувьд энэ сэдэв өөрөө маш ээдрээтэй, олон зүйлийг хэрэн сүлжсэн, эцсийн үнэнээс ямагт гажсан байдаг учир хөндөхөд бэрхтэй сэдэв ажээ. Ландон одоо энэ сэдвийг аль болох ярихгүй байхыг хичээдэг нь дээрхтэй холбоотой.

"Хөлөг Баатруудын холбоо нууц бичгийг олж авахын тулд, байгуулагдсан үүссэн гэв үү? Би өмнө нь тэднийг Бурхны Ариун газрыг хамгаалахын тулд анх гарч ирсэн гэж боддог байсан юм" гэж Софи цөхөрсөн дуугаар өгүүлэв.

"Харамсалтай нь бүгд л ингэж боддог. Мөргөлчдийг хамгаалах нэрийн дор Хөлөг баатрууд өөрсдийн далд үйл хэргийг хэрэгжүүлдэг байж. Ариун газрыг хамгаална гэж хэлчхээд, үнэндээ нууц бичгийг гаргаж авах зорилго дотроо агуулж байсан байна".

"Тэд нууц бичгийг олсон болов уу?"

Ландон жуумалзана, "Энэ талаар хэн ч сайн мэдэхгүй. Гэвч эрдэмтэн судлаачдын баталж байгаагаар, баатрууд тэндээс нэг зүйлийг олж авсан. Энэ нь тэдний эцэс төгсгөлгүй их эд баялаг, сүр хүчнийх нь үндэс болсон юм".

Ландон цааш ерөнхийд нь тоймлон ярьж өгөв.

"Загалмайтны 2 - р аян дайны үеэр, Хөлөг баатрууд мөргөлчдийн замыг хамгаалах саналыг 2 - р Балдуин хаанд тавьж, удалгүй түүнийг зөвшөөрүүлж чаджээ. Тэд сүмийн туурь балгасны ойролцоо орон гэртэй болохыг хүсч, тэр нь ёсоор болов. Хачирхалтай нь, тэд балгас дотор орон байраатөвхнүүлсэн нь, хэний ч гайхлыг төрүүлсэнгүй.

10 шахам жилийн турш, Хөлөг баатрууд туурь бараадан амьдарч, хад чулуу ухан нууц бичгийгэрсээр байв".

Софи яриаг тасалж, "Чи хэлэхдээ тэднийг нэг зүйл олсон гэсэн!"

"Тиймээ. Олсон. 9 жилийн турш хайж, эцэст нь хайснаа олоод, Европ руу дүрвэж гарчээ. Хөлөгбаатрууд Ватикан болон сүмийнхнийг айлган сүрдүүлсэн гэж хэн ч ярьдаггүй боловч, 2 - р Гэгээн Пап бодлогогүй шийдвэр гаргаж, баатруудын бүрэн эрхийг зарлан тунхаглаж, тэдний сүр хүчийгилт бадруулахуйц алхмуудыг ээлж дараалан хийсэн байна.

Ватиканы ивээл энэрлийг хүртсэн хөлөг баатруудын нөлөөлөл аажмаар, зугуухан өргөжиж, хөрөнгө чинээгээ олон орон дамжин, зузаатгаж амжжээ. Тэд үгүйрэн хоосорсон дээдэс язгууртнуудад зээл олгож, эргүүлэн авахдаа хүү тооцдог байсан нь одоогийн банкны зарчмын эхсуурийг тавьж, нөгөөтээгүүр тэд машид хүчирхэгжиж чадсан байна.

Хөлөг Баатруудын холбооны огцом өсөлт, амжилтыг таслан зогсоохын тулд, 1300 - аад оны үед 5 - р Пап Климент Францын тэр үеийн хаан 4 - р Филипптэй хуйвалдаж, нэгэн төлөвлөгөө боловсруулжээ. Климент Пап 1307 оны 10 - р сарын 13 - ны, Баасан гаригт Европ даяар таранбайршсан Ватиканы тусгай армийнханд нууц тунхаг тараасан байна. Тэр тунхгийн нууц илрэхэд, түүн дотор ийнхүү бичсэн байж.

"Бурхан над дээр нэгэн шөнө айлчлан ирээд, хөлөг баатруудын холбоо бол нүгэл хилэнцийн туйл, ижил хүйстнүүдийн тэнхлэг, загалмайг гутаан доромжлогчдын өлгий, хараал хүрсэн хүмүүсийн цуглаан! гээд тэднийг Бурхны эсрэг үйлдсэн нүглээ наманчлах хүртэл нь, залхаан цээрлүүлэх хэрэгтэй гэж хатуу санууллаа".

Климентийн санаснаар болж бүх зүйл маш хурдан өрнөв. Хөлөг баатрууд үй олноороо баригдаж, залхаан цээрлүүлэлт амсан, эцэст нь шонд хүлүүлэн галд шатаагдан үхэж байв. Энэ эмгэнэлийн бараан сүүдэр арилаагүй хэвээр бөгөөд одоо ч бид хар Баасан гариг гэж ярилцдаг шүү дээ".

Софи бүр будлисан бололтой, "Хөлөг баатрууд тэгээд бүрмөсөн устчихсан юм уу? Тэдний үр садодоо ч байгаа гэж би боддог байсан юмсан".

"Тэд одоо нууц нэрээр амьдарч байгаа. Климентийн хуурмаг тунхаг гарсан ч, хүчирхэг холбоотнуудынхаа туслалцаатайгаар зарим нь нуугдан дүрвэж амжсан юм. Хөлөг баатруудыг хүчтэй болгож байсан тэр нууцад нэвтрэхийг, Климент хичээсэн боловч аз нь дутсан байна.

Ватиканы сүм тэдэнд заналхийлэхийг урьдчилж харсан учир, Сионий Прайоричууд нууц баримтуудыг Ватиканаас усан онгоцоор шөнө дөлөөр зөөсөн ажээ".

"Хааш нь зөөсөн юм бэ?"

Ландон хөмсгөө зангидаж, "Хааш нь зөөснийг, зөвхөн Сионий Прайоричууд өөрсдөө л мэднэ. Тэрүүд нууц баримтуудыг цаг үргэлж мөрдөн мөшгөж, илрүүлэхийг хичээж байсан тул, хэд хэдэн удаазоож, бас нуусан гэдэг. Өнөө үед түүнийг Англид нуусан гэж таамагладаг".

Софи ихэд шаналсан байдалтай харагдана.

"Мянган жилийн турш, нууцын тухай домог амнаас ам дамжсаар өдийг хүрсэн. Нууц баримтуудыг одоо СанГрейль гэж нэрлэх болсон. Маш олон номонд түүний талаар бичиж, цөөн хэд нь л СанГрейлийг сонирхолтой талаас нь судалж хөндсөн байдаг".

"СанГрейль гэнэ ээ? Энэ үг ямар нэг байдлаар Франц хэлний Sang эсвэл Испани хэлний цус гэсэнүг болох Сангре - тай холбогдох уу?".

Ландон толгой дохив.

Цус бол СанГрейлийн нэг хэсэг гэдгийг Софи тэр үед сайн ойлгоогүй байв.

"Энэ домог түүх маш ээдрээтэй боловч Прайори угтаа бол жинхэнэ үнэнийг илчлэх мөчийг хүлээжбайгаа гэхэд хилсдэхгүй".

"Ямар үнэн? Ямар үнэн гэхээрээ ийм сүр хүчтэй байдаг юм бэ?"

Ландон уртаар амьсгаа аваад, "Софи! СанГрейль гэдэг бол эртний үг. Одоо үед энэ үг хувьсажөөрчлөгдөөд, чиний маш сайн мэдэх зүйлийн нэг болсон. Бараг хүн бүхэн СанГрейлийн түүхийгмэднэ".

Софи үл итгэсэн харцаар харж, "Би л лав ийм үг сонсоогүй юм байна".

"Чи сонссон байх ёстой доо!" гээд Ландон инээмсэглэж, "Чи Ариун Грейл гэж сонссон уу?"

Хэсэг 38

Софи Ландоныг цоо ширтэнэ. *Тэр надаар тоглож байгаа байлгүй!*

"Ариун Грейл гэсэн үү?"

Ландон өөрийнхөө хэлснийг үнэн болохыг баталж, толгой дохино. "Ариун Грейл бол СанГрейлийннутгачилсан орчуулга. Франц хэлний San - graal гэж үг хувиран өөрчлөгдсөөр, СанГрейль болж,сүүлдээ Сангреал болсон юм".

Ариун Грейл.

Софи тэрхэн үедээ үгийн уг гарвалыг олж таниагүйдээ гайхширна. Гэвч тэр одоо ч Ландондүнэмшихгүй хэвээр байлаа.

"Би Ариун Грейлийг аяга гэж боддог байсан. Гэтэл чи болохоор түүнийг нууц баримтууд агуулсанзүйл гэж яриад байх юм?!"

"Тийм ээ. Гэвч үнэндээ Сан Грейлийн нууц баримт Ариун Грейлийн зөвхөн нэг хэсэг нь байгаагүй.Дурдагдаагүй үлдсэн нөгөө хэсэг нь Хөлөг баатруудын холбоог маш хүчирхэг болгосон юм.Грийлийн жинхэнэ хүч энд л оршиж байгаа".

Грийлийн жинхэнэ хүч гэнэ ээ?

Софи бүр төөрч будлисан харагдана. Түүний бодож байснаар бол Ариун Грейл гэдэг нь Есүс шавьнартайгаа сүүлчийн зоог барьж байхдаа, хэрэглэсэн аяга гэж төсөөлнө.

"Ариун Грейл бол Бурхны аягаас өөр зүйл биш!" гэж Софи хэлэхэд, Ландон амандаа исгэрч, түүнрүү ойртоод,

"Софи! Сионий Прайорийн хувьд Ариун Грейл аяганаас ч гүнзгий утга агуулгатай юм шүү!Хүмүүсийг төөрөгдүүлэх гэсэн тэдний санаа эцэстээ ийм ойлголтод биднийг хүргэсэн юм.Грийлийн түүхэнд аяга хэмээх ойлголтыг ашигласан нь үнэндээ түүний дийлэгдэшгүй хүч чадлыгбэлгэдсэн хэрэг байсан" гээд Ландон түр азнаснаа, "Өнөөдрийн өвөөгийн чинь бидэнд хэлж үлдээхгэсэн санаатай энэ бас нягт холбоотой гэж би бодож байна".

Одоо болтол эргэлзээнээсээ салаагүй байгаа Софиг харж, Ландон инээмсэглээд, түүний байдлыг ойлгож байгаагаа илэрхийлэн нухацтай ширтэнэ.

"Тэгээд Ариун Грейл аяга биш юм бол юу болж таарах вэ?"

Ландон хэдийгээр ийм асуулт гарч ирэхийг эртнээс мэдэж байсан боловч, үүнд хэрхэн хариулахаргаа олохгүй байсан юм. Хэрэв энэ асуултад Ландон хариулж чадахгүй бол, хэдэн сарын өмнөномын редактортаа өөрийн гар бичмэлийг өгөх үед түүнийг бөөн асуултаар булаад үлдээсэн шиг,Софиг төөрөгдүүлж орхих байв.

"Гар бичмэл чинь ямар утга агуулгатай гэнэ ээ?" гэж түүний редактор хахан цацан байж хэлээд,хундагатай дарсаа ширээн дээр тавьж, дутуу идсэн өдрийн хоол руугаа нэг харав. "Чи надаартоглоод байна уу?"

"Бүтэн жилийн турш бичсэн юм чинь тоглоом болгоод яахав дээ!"

Нью - Йоркийн алдартай редакторуудын нэг Жонас Фокман ямаан сахлаа зулгаан байж, бодолддарагдав. Фокман маш олон шинэлэг, галзуу гэмээр агуулгатай номуудыг урьд нь хянаж байсанболовч, ийм гар бичмэлтэй анх учирч байгаа нь энэ. Ландон түүнийг бодолтой нь цуг түр хүлээхээсөөр арга байсангүй.

"Роберт," гэж Фокман сая л ам нээж, "Намайг уучлаарай, би чиний номыг дуртайяа хүлээн авахсан.Даанч хэрэв би номыг хэвлэлтэд өгчихвөл, хүмүүс намайг хараан зүхэж, би гэдэг амьтан ажлынхааөрөөнөөс шагайх аргагүй болох байх. Харин чиний хувьд нэр хүндэд чинь халтай биш үү! Чи болХарвардын сургуулийн түүх судлаач. Гэтэл уулын бугыг хараад, унасан морио мартав гэгч болохюм биш биз? Энд бичсэн нотолгоо гаргалгаануудыг чи хаанаас олоо вэ?"

Ландон уруулдаа инээмсэглэл тодруулсаар, ноосон цамцныхаа халааснаас нэг цаас гарган түүндөглөө. Тэнд бичигдсэн номуудын ихэнх нь гарсан даруйдаа олон хувиар борлогдож байсан түүхэнсэдэвт судалгааны номууд байв. Бүгд л Ландоны хөндөж бичсэн сэдвийг агуулсан аж. Фокманномын жагсаалтыг уншиж дуусчхаад, дэлхий хавтгай гэдэгт итгэсэн хүний дүртэй болчихсон суужбайлаа.

"Би эдгээр номын зохиогчдын заримыг нь мэднэ. Тэд ч алт шиг хүмүүс

Ландон хариуд нь жуумалзаж, "Ганц миний бодол санаа биш гэдгийг чи өөрөө харж байгаа биз дээ!Би зөвхөн гаргасан жимээр нь явж байгаа судлаач хүн. Гэвч өмнө нь нэг ч удаа тэмдэгт судлалынчиглэлээр Ариун Грейлийг ингэж нарийвчлан судалж байгаагүй. Номонд оруулсан миний ихэнхнотолгоонууд нэлээд ул суурьтай болсон шүү".

Фокман жагсаалтыг ширтсэн чигтээ "Ээ Бурхан минь! Энд бас Английн алдарт түүхч ЛейТийбиний ном байна шүү дээ!"

"Тийбин Ариун Грейлийг судлахад өөрийн амьдралын ихэнхийг зориулсан хүн. Би түүнтэй нэг бусудаа уулзаж байсан. Тийбин миний урам зоригийг тэр үед сэргээсэн шүү!"

Тэр надтай адил бодол санаатай хүмүүсийн тоонд лав орно".

"Тэгэхээр чи энэ жагсаалтад байгаа түүхчид бүгд үүнд итгэдэг гэж хэлэх гээд байна уу?" гэжФокман өөрийн санааг бүрхэгдүүлэн асуув.

Ландон бас л жуумалзах бөгөөд, "Ариун Грейл бол хүн төрөлхтний түүхэн дэх мөнхийн

эрэлхайгуул болсон үнэт зүйл. Грийлийн нөлөөгөөр түүхийг бичиж, дайн тулаан хийж, эрэл хайгуул ньодоо ч үргэлжилсэн хэвээр байна. Ариун Грейлийн зөвхөн аяга гэж төсөөлөөд л зогсох нь зөв гэжүү? Бүх түүхийн дотроос Ариун Грейлийн түүх давтагдашгүй онцлогтой. Яагаад гэдгийг чи мэдэх

үү?" гэхэд, Фокман толгой сэгсрээд, "Ийм олон номонд энэ тухай бичээд байхад, яагаад хүмүүс тэрбүр мэддэггүй юм бэ?" гэж асуув.

"Яагаад гэвэл олон зууны турш хүмүүсийн сэтгэхүйд гүн гүнзгий ойлголт суухад хөдөл шгүйнөлөөлөл үзүүлсэн, бүх цаг үед хамгийн их уншигдсан тэр номтой эдгээр номууд эн зэрэгцэж чадахгүй л дээ".

Фокманы нүд орой дээрээ гарах шахаж, "Харри Поттер л гэж битгий хэлээрэй!" гэв.

"Би Библийн судрын тухай ярьж байна".

Фокман бантсандаа, худал инээж "Би ч мэдээд байсан юм аа!"

"Леселю!" гэж Софи гэнэт хашхирав. "Тавь наадахаа!"

Софи арын суудлаасаа үсрэн босч, таксины жолооч руу дахин ориллоо. Ландоныг хартал, жолоочрадио станцынхаа харилцуурыг амандаа барьчихсан хариу өгч байв. Софи эргэж, Ландонхалааснаас бууг шалмаг гэгч аваад, жолоочийн ар нуруунд тулгав.

Жолооч тэр дороо харилцуурыг унагаж, гараа дээшээ өргөв.

"Софи!" гэж Ландон хахаж цацан хэлээд, "Чи чинь юугаа хийж...?!" гэтэл,

"Бүү хөдөл!" гэж Софи чанга дуугаар жолоочид тулган хэлэв.

Жолооч удалгүй зогсоол дээр очоод, машинаа тавив. Тэр мөчид такси баазын диспетчер нэгэнхэмээр харилцуурын цаанаас хариу шаардах нь, радио станцаар тодхон сонсогдоно.

"... Ки сапелье агон Софи Нөвү," (Софи Нөвү гэгч хүний...) гээд шад падхийн дуугарч, цаашүргэлжлүүлэн, "Энэ Американ, Роберт Ландон .." (Америкийн иргэн Роберт Ладон) гэж хэлэх ньгэр.

Үүнийг сонссон даруйдаа, Ландоны яс хавгалзана. Тэд биднийг олчихжээ?

"Лисонди!" (Буу) гэж Софи хэлэв.

Жолооч хоёр гараа дагзандаа аваад, машинаасаа дагжин чичирсээр буув. Софи цонхоо буулгаж,буугаа жолооч руу шагайсан чигтээ, "Роберт!" гэж хэлээд, "Жолооны ард суу! Чи жолоо баринашүү!"

Зэвсэг барьсан эмэгтэйн үгнээс зөрж болохгүйг, Ландон мэдэх учир жолооны ард шилжин суув.Харин жолооч гадна гараа өргөөтэй, хараал урсган зогсоно.

"Роберт, чи эндхийн хэцүү байдлыг сайн мэдэж авсан биз дээ?" гэхэд Ландон толгой дохиж,

"Хангалттай сайн" гэж хариулав.

"Тэгвэл эндээс түргэн хөдөлье!"

Ландон хянах самбар болон хөдөлгүүрийг харж түр тээнэгэлзэв. Арааны бариулыг

арайхийнтэмтэчсээр олж атгаад, "Софи! эсвэл чи ..." гэхэд,

"Яваач!" гэж Софи зандрав. цэцэрлэгт байсан хэрэгт дуртай хүмүүс юу болж байгааг сонирхох аж.Нэг эмэгтэй гар утсаараа дуудлага хийж эхлэх нь харагдав.

Ландон 1 - р араа гэж бодсон тал руу бариулыг түлхээд, хааз өгч хүчийг нь шалгав, Хөдөлгөх гэжоролдсон ч хөдөлгүүр нь хий дүнгэнээд, удалгүй утаа суунаглалатал шарвасаар, олны анхаарлыгбүрмөсөн татчихав. Нөгөө гар утастай эмэгтэй цааш мод руу ороод алга болчхов.

"Болгоомжтой!" гэж Софиг хэлэх үед машин замаар шааригдан уруудаж байв. "Чи юу хийж байнаа?"

Би чамд хэлэх гээд ..." гэж Ландон учирлаад, "Би автомат араатай машин жолооддог гэж чамдхэлэх гээд ..."

Хэсэг 39

Рью Ла Бруех дэх өрөөндөө Силас сэтгэл үймрэн суух зуур, бие махбодынх нь өвчин шаналалдавхар түүнийг ниргэжээ.

Би мэхлэгдчихлээ шүүдээ! Олоо бүх зүйл өнгөрсөн.

Силас хууртагджээ. Ахан дүүсийн холбоо түүнд нууцаа илчилсэнгүй, харин ч хоосон чулуухөөлгөсөн аж. Силас багш руу холбоо барих тэнхэл байсангүй. Онъсон чулууг авахын тулд тэ рээр4 хүн алсан нь багадаад, гэлэнмааг бас цааш харуулсан.

Гэхдээ гэлэнмаа Бурхны эсрэг үйлчилж байсан шүүдээ!

Опус Дейн үйл хэргийн жигшин зэвүүцсэн нь гэлэнмааг үхэлд хүргэсэн. Харин гэлэнмаагийн үхэлбүх хэргийг төвөгтэй болгож орхисон юм. Хамба Арингароза Эзэн рүү ярьснаар, Дарь Эхийн сүмднэвтрэх боломжтой болсон учир, энэ бүхний эцэст гэлэнмааг үхсэн гэдгийг Эзэнд юу гэжтайлбарлах вэ?

Силас гэлэнмаагийн толгойг дэлсчхээд, тэр даруйдаа оронд нь хэвтүүлсэн боловч, эмэгтэйнтолгойдоо авсан шарх нь сэжиг төрүүлэхүйц байсан юм. Мөн эвдэрсэн суурийн хавтанг байранд ньбуцааж тавьсан ч хүний нүдэнд өртөхүйц харагдаж байсан. Тэнд хэн нэг хүн байсан гэдэг нь илтмэдэгдэхээр байв.

Үг нь хэрэг явдал бүтэмжтэй болчихвол, Силас Опус Дейн дотуур байрандаа орогнохоор төлөвлөжбайжээ. Түүний авран хамгаалагч нь Хамба лам Арингароза байв. Силас Нью - Йорк дахь ОпусДейн төвд л өөрийн дураар авирлаж болдог байв. Түүнд хэрэгтэй бүх зүйлийг гадагш гарахгүйгээршийдэж болно. *Хэн ч намайг дурсахгүй, үгүйлэхгүй!*

Харин хэрэг буруугаар эргэвэл, олонд танигдсан хүний хувьд хамба Арингарозад амаргүй байхболно. Би Арингарозаг баллачихлаа!

Силас шал руу гөлрөнгөө, өөрийн өнгөрсөн амьдралаа цэгнэнэ. Энэ бүхний эцэст түүнийгхаламжлан, сургаж, зорилготой болгосон хүн бол яах аргагүй Арингароза.

"Анд минь, чи альбино болж төрсөн. Гэхдээ үүнээсээ огт ичиж зовох хэрэггүй. Энэ төрх чинь лчамайг бусдаас онцгой болгож байгаа юм. Нөвү хүртэл альбино байсныг чи мэдэх үү?" гэхэд,

"Нөвү юу даа?" гэж Силас үнэн голоосоо гайхан суув.

Арингароза хариуд нь инээмсэглэж, "Тиймээ. Үнэн хэрэгтээ, Нөвү яг чам шиг альбино байсан юм. Тэрээр энэ гариг дээрх амьд бүхнийг аварсан сахиусан тэнгэр юм шүү дээ! Тэр бол альбино -сахиусан тэнгэр. Чи ч гэсэн түүн шиг агуу үйлсийн төлөө төрсөн, Силас! Эзэн тэнгэр чамайгөөрийн үйл хэрэгт туслуулах гэж энэ ертөнцөд илгээсэн юм".

Үүнээс хойш Силас өөрийгөө өөр өнцгөөс харах болов.

Би бол ариун, цагаан, бас үзэмж төгс! Яг л сахиусан тэнгэр шиг гэж өөрийгөө төсөөлнө.

Тэрхэн мөчид эцгийнх нь хэлсэн үгс Силаст өр өвтгөн, сонсогдох шиг болов.

Чи бол гай зовлон! Сүнс!

Силас модон шалан дээр өвдөглөн суугаад, өршөөл эрэн залбирлаа. Тэгээд удалгүй хувцсаа тайлж, ёслолоо үйлдэхээр биеэ бэлдэв.

Хэсэг 40

Ландон машиныхаа араатай ноцолдсоор, Буа де Булонцагаас холдохдоо, хөдөлгүүрийг г нь 2 ч удааунтрааж амжжээ. Такси баазын диспетчер үүнийг ч үл ажран, харилцуурын цаана үгээ давгантасралтгүй шулганана. "Хаана байна? Хариу!"

Ландон цэцэрлэгээс гарахын өмнө, эр хүний бардам зангаа умартаад, тоормос гишгэн зогсов. "Софи, чи жолоодсон нь дээр юм байна" гэж тэр эцэст нь хэлэв.

Софи түүний хэлснийг дуртайяа зөвшөөрч, жолооны ард суув. Бүсгүй хормын дотор машиныгасааж, цэцэрлэгээс гараад, баруун гар тийш Алле Де Лоншамыг зүглэн давхив.

"Бид Рю Аксо руу аль замаар явах вэ?" гэж Ландон асуухдаа, нүднийхээ булангаар харвал, хурдзаагч аль хэдийнээ 100 миль/цаг гэсэн тоон дээр гозойж байв.

Софи урдах замаасаа нүдээ салгалгүй, "Таксины жолооч хэлэхдээ, Роланд Гаррос цэнгэлдэххүрээлэнгээс холгүй гэсэн. Би цэнгэлдэх рүү хүрэх замыг мэднэ".

Ландон түлхүүрийг халааснаасаа гаргаж ирэхдээ, түүний хүндийг гайхна.

Энэ түлхүүр хэргийн учгийг тайлж чадна!

Софид нууц бүлэглэлийн талаар тайлбарлаж байхдаа, энэ түлхүүр дээрх Сионий Прайорийнбэлгэдэл дүрсийг хараад, нууцад хүрэхэд ойрхон байгаагаа, Ландон зөнгөөрөө мэдэрсэн билээ. Тэгш хэмтэй энэ хэрээс тэмдэг Хөлөг баатруудын бэлгэдэл байсан юм.

Хөлөг баатруудын цагаан нөмрөг дээрээ улаан хэрээс дүрсэлсэн байдгийг, бараг бүхэл хүн мэднэ.

Яг л энэ түлхүүр дээрх шиг дүрс байдаг шүүдээ.

Ландон өөрийнхөө төсөөлөлдөө бүрмөсөн автаад, эргэн тойрныг ч анхаарах сөхөөгүй боджээ.

"Ариун Грейл!" гэж тэр өөртөө хэлээд, золтой л инээд алдчихсангүй.

Грийлийг аль 1500 - аад оны үед ямар нэгэн сүмд нуусан гэдэг яриа гарснаас хойш, Англид байгааг таамагласаар иржээ. Энэ бол их мастер Да Винчийн амьдарч байсан үетэй яг давхацна. Прайорийн бүлэглэл нууцыг хадгалахын тулд, хэд хэдэн удаа байршлыг шилжүүлсэн байна. Түүхчид Грейлийн байж болох хамгийн өндөр магадлалтай 6 газрыг тодорхойлсон байдаг. Хамгийн сүүлд, 1447 онд Грейлийг нүүлгэн шилжүүлж байхыг, олон

хүмүүс нүдээр харсан бөгөөд,үүнээс хойш Грейлийн сураг ганц ч удаа сонсогдоогүй юм. Гэвч олонх хүмүүс түүнийг Англидбуюу өөрөөр хэлбэл, Хөлөг Баатруудын дугуй ширээ байдаг Артур хааны өлгий нутагт байгаа гэжүзсээр ирсэн юм.

Хамгийн сонирхолтой баримт бол: нэгд, Леонардо Да Винчи Грейлийг хаана байсныг мэдэжбайсан явдал, хоёрт, түүнээс хойш Грейлийг байршлыг өөрчлөөгүй байх магадлалтай гэсэнтаамаглалууд байгаа юм.

Эдгээр шалтгааны учраас Да Винчийн зураг, тэмдэглэлд олон хүмүүс анхаарал хандуулж,Грейлийн байгаа газрыг олохын төлөө, амь тавин зүтгэсээр байгаа. Зарим нь түүний "Мадонна"хэмээх зургийн ар талд зурагдсан уул, хад бол Грейлийг нуусан газар, тэр дотроо Шотландын хадасгатай уулыг дүрсэлсэн гэж баталдаг бол, "Нууцат үдэш" хэмээх Есүс өөрийн шавь нарын хамтзоог барьж буй зурагт далд утга бий гэж өөр зарим нь үздэг. Харин үлдсэн хэсэг нь "Мона Лиза" - гзурахдаа, давхарлаж зурсан нь, далд байгаа зургаас бүгдийг мэдэж болно гэцгээдэг. Энэ тухайинтернет хуудасн уудад ихээр тавьж, чаталж, зурвас солилцож байдаг нь үргэлж сонирхол татахсэдэв болсоор л байна.

Нууцад дурладаггүй хүн байхгүй шүүдээ!

Хамгийн сүүлд чих дэлссэн, нэгэн сонин тохиолдол бол Да Винчийн "Маггийн дур хүсэл" хэмээхзургийг давхарлаж зурсныг илрүүлж нээсэн явдал байв. Үүнийг Италийн урлаг судлаач МаурициоСерачини анх судалж, Нью - Иорк таймс сэтгүүлд "Леонардогийн нууцлал" нэрээр нийтлэлхэвлүүлснээр, жинхэнэ шуугиан тарьж байсан нь саяхан. Харамсалтай нь, Да Винчийн далдалсанзураг юуны тухай гэдгийг одоо ч таамаглаж амжаагүй л байна. Үүнд нарийвчилсан шинжилгээхийж байгаа юм.

Грейлийг хайгчид Леонардо Да Винчийн зохиосон оньсого таавар дунд төөрөх нь элбэг. Тэрээрнэгийг хэлээд байгаа юм шиг мөртлөө, ёгт утгатай зүйл хэлнэ, эсвэл тэр нь з аримдаа ямар ч утгагүймэт санагдана.

Магадгүй тэрээр Мона Лиза шиг оньсого тааварт нь тархиа гашилган, толгойгоо шаах хүмүүсийгхэдэн зууны тэртээгээс тавлан инээж ч байгаа юм билүү!

Софи Ландон руу эргэж, "Наад түлхүүр чинь Ариун Грейлийг нуусан газарт нэвтрэхэд хэрэг болохболов уу?"

Ландон хүчээр инээмсэглэж, "Мэдэхгүй юм даа. Грейлийг Францад биш Англид байгаа гэжтаамагладаг шүү дээ".

"Тэвч энэ түлхүүр дээр Сионий Прайорийн бэлгэдэл дүрс байгаа. Тэгээд ч зогсохгүй, түлхүүрПрайорийн нэг гишүүнээс бидний гарт шилжиж ирсэн шүү дээ!"

Ландон түүний бодлыг хүлээн зөвшөөрмөөр байсан боловч, нөгөөтээгүүр өөрийн зөн билэгт итгэхучир бүсгүй бодлыг зөвшөөрч үл чадна. Худал цуу үг тараагчид хэзээ нэгэн цагт, Ариун Грейлийгөлгий нутаг болох Францад нь буцааж авчирна гэдэг ч, түүхэн эх сурвалжийн алинд ч энэ талаардурсаагүй байдаг юм. Грейлийг буцааж авчирсан байлаа ч, теннисний цэнгэлдэхийн дэргэдэхгазарт авчирна гэдэг Ландоны санаанд буухгүй байв.

"Софи! Энэ түлхүүр Грейльтэй холбоотой гэдэгт би нэг л итгэлгүй байна" гэж Ландон хэлэв.

"Яагаад? Грейль Англид байгаа гэсэн болохоор уу?"

"Ганц энэ ч биш. Ариун Грейл бол түүхэн дэх хамгийн нууцлагдмал зүйлийн нэг. Прайорийнгишүүд өөрсдийгөө итгэлтэй хүн гэдгийг батлахын тулд, хэдэн 10 жил үнэнчээ харуулж, удаанхугацааны дараа тэдний цөөн хэд нь Грейлийн байгаа газрыг мэдэж чаддаг. Мэдлэгийн цогц,

төвөгтэй бүтцийн дор нууцыг хадгалдаг нүсэр том энэ бүлэглэлийн толгой - удирдлага нь болсондөрөвхөн гишүүн л Грейлийн нуусан газрыг мэдэх ёстой. Нэг тэргүүн, тэргүүлэгч гурван гишүүн.Өвөө чинь тэдний нэг байсан гэдгийг батлах хэцүү шүү дээ!"

Софи машиныхаа хурдыг сааруулж, *Миний өвөө тэдний нэг байсан!* гэж бодов.

Бүсгүй өвөөгөө Сионий Прайорид өндөрт байр суурьтай байсанд эргэлзэлгүй итгэнэ.

"Өвөө чинь өндөр зэрэгтэй гишүүн байсан юм бол, Ахан дүүсийн хүрээнээс гадуур байгаа хэнд чнууцыг дамжуулах ёсгүй шүү дээ. Тэр өөрийнхөө үүргийг умартан, чамайг үүнд оролцуулна гэдэгбайж болшгүй зүйл" гэв.

Би тэр үед бүхнийг харсан шүүдээ! гэж Софи бодоод, тэр нэгэн мөргөл ёслолыг нэхэн саналаа.

Нормандийн эдлэнд тохиолдсон, мартагдашгүй шөнийн тухай Ландонд ярих үгүйгээ бүсгүйшийдэж ядна. 10 жилийн турш, тэрээр энэ дурсамжаа өөрөөсөө ч тас нуусаар байсан юм. Энэ тухайболох тоолонд, түүний үстэй толгой нь арзайдаг байв.

Тэртээ алсад яндан дуугарах чимээнээр, Софи бодлоосоо салж, ядарснаа дөнгөж сая л мэдрэв.

"Тэр байна!" гэж Ландон баярласандаа хашхирах шахан хэлээд, Роланд Гаросын цэнгэлдэххарагдах тэр зүг гараараа заав.

Софи чиглэлээ өөрчилж, тэр зүг жолоогоо мушгилаа. Удалгүй Рью Аксо гэсэн бичигтэй хаягтудамжинд харагдахад, тийш орж, дээш өгсөв.

"Бидэнд 24 гэсэн дугаар хэрэгтэй!" гэж Ландон өөртөө хэлээд, тэнгэрийн хаяанд үзүүр нь цоройнүзэгдэх сүмийг нүдээрээ хайж эхлэв.

Энэ хавьд сүм байх юм гэж үү! гэж Ландоныг бодох зуур,

"Тэнд байна!" гэж хэлээд, Софи хуруугаараа заав.

Ландон тэр зүг дагуулан харав. Ямар гайхалтай юм бэ?

Орчин үеийн загвартай тэр барилга намхан бөгөөд, дээвэр дээрээ тэгш хэмтэй хэрээс тэмдгийгдүрсэлсэн байв. Загалмайн доорх хаягийг уншвал, "Цюрихийн Хадгаламжийн Банк" гэж томоорбичсэн байв.

Ядаж нэг ч гэсэн алхам ойртсон нь чухал!

Тэр хоёрт Швейцарын банкин дахь хадгаламжийн хайрцагны түлхүүр байгаа нь тодорхой болов.

Хэсэг 41

Уулын жихүүн салхинд жиндсээр, Арингароза Фиат машинаасаа буув. Айж сүрдсэнээсээ болоод, *Нью - Иоркоос гарахдаа, кассокноос өөр зүйл сүр бараатай хувцас өмсөж ирэхгүй яав аа?* гэжтэрээр өөрийн эрхгүй халаглан бодно. Уулан дахь шилтгээний дээд давхрын цонхнууд муу ёрлосонмэт, өдийд бүдэг гэрэл цацруулах нь Арингарозад харагдана.

Номын сан л байгаа байх гэж дотроо тэр тааварлав. Тэд унталгүй, намайг хүлээж байгаа юм байна!

Хамба лам толгойгоо ялимгүй тонгойлгож, салхи сөрөхийг оролдоно. Түүнийг угтаж авсан, нойрмог царайтай номлогч 5 сарын өмнө, Арингарозаг угтаж авч байсан хүн дүрээрээ мөн байлаа. Гэвч номлогч түүнийг үл тоомсорлосон байдлаар, "Бид танд санаа зовлоо шүү, хамбатан!" гээд, цагруугаа хяламхийх нь, харин ч өөртөө санаа зовж байгаа нь илт.

"Уучлаарай! Онгоцны хуваарь ингэж таарчихлаа".

Номлогч амандаа үл мэдэг бувгнаснаа, "Тэд таныг дээд давхарт хүлээж байгаа! Би танд замчилья" гэв.

Номын сан маш уужим бөгөөд, таазнаас бусад хэсгийг хүнд бараан өнгийн, нягт модоор хийжээ. Дээрээс өнгийх өндөр, сүрлэг номын тавиурууд танхимын эргэн тойронд харагдана. Хув чулууны өнгөтэй, улбар шар гантиган шал нь нэгэн цагт энэ барилга шилтгээн байсныг илтгэнэ. "Тавтайморил, хамбатаан!" гэж номын сангийн танхимд байсан хүн хэлэв.

Арингароза түүний хэн болохыг харах гэсэн боловч, танхим харанхуй байсан тул, чадсангүй. Энэ үед үүр дөнгөж цайж байв. Өнөөдөр энэ хүмүүс түүнтэй ийм байдлаар түүнтэй уулзаж байгаа нь, тэд хийж буй зүйлээсээ ичиж, нуугдаж буй хэрэг байв.

Арингароза дуу гарсан зүгт алгуур дөхсөөр, удалгүй өрөөний захад байх, урт модон ширээний ардсуусан 3 хүнийг олж харав. Тэр гурвын дундах нь Ватикан дахь бүхий л хэргийг хамаардаг, Ватиканы сүмийн нарийн бичиг байв. Харин нөгөө хоёр нь өндөр хэргэмтэй их хамба ламтнууд байлаа.

Арингароза номын сан дотуур алхсаар, тэдэнд тулж очих зуур, "Намайг уучлан хэлтрүүлээрэй! цагийн зөрөөнд л хамаг учир байна. Та нар намайг хүлээсээр алжаав уу?"

"Үгүй дээ!" гэж хоёр гараа элгэндээ зөрүүлэн суусан нарийн бичиг хэлээд, "Энэ хол замыг туулж бидэн дээр ирсэнд харин ч талархаж байна! Чамтай уулзахын тулд, нойроо хагаслах нь бидний хувьд хийх л ёстой зүйл. Чамайг кофе, эсвэл халуун цайгаар дайлах уу?"

"Та бүхэн энэ уулзалтыг жирийн гэж битгий ойлгоорой. Миний нислэгийн хуваарь шахуу байгаа. Ажил хэрэгтээ шууд оръё!"

"Өө, тэгэлгүй яахав" гээд нарийн бичиг, "Чи ч бидний бодсоноос түргэн хөдөлсөн байна шүү!" гэв.

"Тийм гэж үү?"

"Чамд дахиад сарын хугацаа үлдсэн байгаа шүү дээ!"

"Та нар надад бүтэн 5 сарын өмнө анхааруулсан байхад, би юугаа хүлээж, зүгээр суух ёстой гэж?"

"Үнэндээ бол чамайг бид маш их үнэлж байгаа шүү!"

Арингарозагийн нүд урт ширээг дагуулан явсаар, хар цүнхэн дээр очиж тогтоод, "Энэ миний захисан зүйл мөн үү?" гэж асуув.

"Тиймээ. Чиний хүсэлтийн дагуу бид ..." гээд нарийн бичиг үгээ дутуу орхисонд, "Маш аюултай зүйл хийснийг чи мэдэх ёстой!" гэж дэргэд нь сууж байсан их хамбын нэг нь түүнийг

үгийггүйцээв.

"Бид үүнийг чамд дансаар хаа нэг тийш гуйвуулж болохгүй байсан юм уу? Үүнийг биедээ авч явахнь, их аюултай шүү дээ!"

"Бурхан надтай хамт байгаа цагт, надад аюултай зүйл гэж байхгүй".

Нөгөө гурав түүний үгэнд илт эргэлзсэн байдалтай байгаа нь мэдрэгдэнэ.

"Миний анх захисан хэмжээгээр байгаа юу?"

Нарийн бичгийн толгой дохиж, "Ватиканы банкны нэр дээр бичигдсэн бондууд байгаа. Бэлэнмөнгөнөөс ялгаагүй, дэлхийн хаана ч үүнийг хэрэглэж болно".

Арингароза цүнх рүү дөхөж, түүнийг онгойлгов. цүнхэн дотор Ватиканы тамгыг товойлгож дарсан, 2 том багц бонд хийсэн байлаа.

Нарийн бичиг нухацтайгаар, "Хамбатаан! Энэ бондын оронд мөнгөн дэвсгэрт бэлнээр авсан болдээр байсан юм". гэж өгүүлэв.

Би тийм их мөнгийг яаж дийлж, авч явахав дээ! гэж Арингароза дотроо бодоод, цүнхийг хаав. "Бонд бэлэн мөнгөнөөс ялгаагүй гэж та өөрөө хэлсэн биз дээ!"

Тэд бие бие рүүгээ нэг харц солилцоод, эцэст нь нэг нь, "Тэр үнэн. Гэхдээ бүх бондууд Ватиканыбанканд хаяглагдсан байгаа".

Арингароза үнэн сэтгэлээсээ дотроо инээж байв. Учир нь багш Арингарозад бүх мөнгийг бондоорав гэж анхнаас ухуулсан юм.

"Энэ бол хуулийн дагуу ямар ч гэм буруугүй зүйл" гэж Арингароза өөрийгөө хамгаалаад цааш, "Опус Дей бол Ватиканы сүмийн салбар байгууллага учраас, хэрэгтэй үедээ з охистой зүйлд мөнгөөзарцуулах болно. Энд хууль бус үйлдэл нэг ч зүйл байхгүй".

"Тиймээ!" гээд нарийн бичиг урагш бөхийн суудлаа засан, дороо займчсанд, сандал нь чийхрандуугарав. "Гэвч одоо болтол энэ мөнгийг юунд зориулахыг чинь бид мэдэхгүй л байгаа шү ү дээ! Хэрэв чи хууль бус. ..."

"Таны санааг би ойлголоо. Гэхдээ энэ мөнгийг юунд зарцуулахаа та нарт хэлэх, үгүй нь минийхэрэг шүү!"

Номын сан хэсэгтээ нам гүм болов.

Миний хэлсэн үг зөв гэдгийг тэд өөрсдөө мэдэж байгаа! гэж Арингароза бодно.

"Та нар надаар гарын үсэг зуруулмаар байгаа юм биз дээ?" гэхэд 3 хэргэмтэн бүгд хөдөлгөөнд орж, түүн рүү нэгэн цаас дөхүүлэв. Арингароза түүнийг нь гүйлгэж хартал, дээр нь Папын тамгадараастай байхыг олж үзэв.

"Энэ та нарын над руу илгээсэнтэй адил баримт уу?"

"Яг тийм".

Арингароза баримтад гарын үсэг зурж байхдаа, өөрийгөө ийм тайван байдалтай байгаад маш ихгайхав. Харин нөгөө 3 гарын үсэг зуруулсандаа баярлаж, сэтгэл хангалуун инээмсэглэн сууна.

"Баярлалаа, хамбатаан! Сүмийн төлөө хийж буй бүх үйл хэрэг чинь үүрд арилахгүй

байхболтугай!"

Амлалт, үүрэг хариуцлага, эрх мэдэл гурвыг цугт нь тээсэн хар цүнхийг барьсаар,
Арингарозахаалга руу эргэв. Арингарозаг босго давахын өмнөхөн тэдний нэг нь түүний араас
дуудав.

Эргэж харвал, "Чи хаа хүртэл явна гэж?" хэмээн асуух дуулдав.

Энэ асуулт Арингарозад давхар утгатай мэт санагдсан боловч, тэрээр зориуд ойлгоогүй дүрүзүүлж, "Парис хүртэл!" гэж хариулаад гарч одов.

Хэсэг 42

Цюрихийн Хадгаламжийн Банк бол бусад Швейцар банкнуудын адил нэргүй үйлчилгээг олонтөрлөөр үзүүлдэг, 24 цагийн байнгын ажиллагаатай банк байлаа. Цюрих, Куала Лумпур, Нью-Йорк, Парист салбартай энэ банк компьютерын сүүлийн үеийн ололт дэвшлийг үйлчилгээндэээргөнөөр нэвтрүүлж, нэргүй үйлчилгээнийхээ чанарыг ихээр нэмэгдүүлж байгаа юм. Энэхүүбанкны орлогын үндсэн хэсэг нь сохор үйлчилгээ гэгддэг хадгаламжийн хайрцагны үйлчилгээнээсолдог орлого ажээ. Энэ бол үйлчлүүлэгчийн хүссэнээр, үнэт цаас, уран зураг гээд ямар ч эдзүйлийг нэр усгүйгээр банканд хадгалж, өндөр зэрэглэлийн нууцлалаар тэдгээр зүйлийг ха мгаалжбайдаг гэсэн үг.

Софи машинаа банкны барилгад дөхүүлэх хооронд, Ландон барилгын содон төрхийг ажиглав.Барилга хав дөрвөлжин хэлбэртэй, нэгэн хэвийн ган хавтанцрыг давтаж, гаднах ханыг бүрсэн байв.Тэр нь яг л төмрөөр хийсэн, том тоосго шиг харагдах бөгөөд энэ барилгын дээвэр дээр 15 футынөндөртэй хэрээс тэмдэг байрлуулжээ.

Швейцар улсын хувьд нэргүй төрлийн үйлчилгээ экспортынх нь ихэнх хувийг эзэлдэг.

Гэвч нөгөөтээгүүр, энэ төрлийн үйлчилгээ урлагийн байгууллагуудын зүгээс хүчтэй эсэргүүцэлтэйтулгардаг нь урлагийн бүтээлийн хулгайч нар хулгайн эд зүйлээ нуух хамгийн тохиромжтой газарболдогтой холбоотой юм. Бас эдгээр банкнууд хувь хүний нууцын тухай хуулийн заалтадүндэслэж, үйл ажиллагаагаа явуулдаг учир, цагдаагийн нэгжлэг хийж болдоггүй, мөн н эр усаарбиш тоон дансаар үйлчилгээ үзүүлдэг тул, хууль хүчний байгууллагуудын толгойн өвчин болдогаж.

Тэр хоёр луу хяналтын камер чиглэсэн байхыг, Ландон хараад, Луврынхыг бодвол жинхэнээсээажилладаг байх гэж бодов. Софи машиныхаа цонхыг онгойлгож, жолоочийн тал руу харсанэлектрон самбар луу ойртов. Самбарын 7 хэлээр зааварчилгаатай, LCD дэлгэц дээр хамгийн эхниймөрөнд англиар "INSERT KEY" гэсэн байв.

Софи халааснаасаа алтадмал түлхүүрийг гаргаж, самбар луу дахин харвал, дэлгэцийн доод талджижиг гурвалжин нүх байлаа.

“Энд лав түлхүүр таарах байх аа!” гэж Ландон нүх рүү харангаа хэлэв.

Софи түлхүүрийг ишинд нь тултал нүхэнд хийв. Түлхүүр эргэдэггүй бололтой, харин тэр дороогаднах хашааны хаалга нээгдэх нь тэр.

Тэд дотогш орж, хоёр дахь хаалга болон самбар дээр тулж очив. Энэ үед ард нь, өнөөх нээгдсэнхаалга эргээд хаагдаж байв. Хоёр хаалганы хооронд түгжигдсэн мэт эвгүй сэтгэгдэл Ландондзурсхийв.

Хаалга онгойно л гэж найдахаас!

Самбарын дэлгэц өмнөхтэй адил зааварчилгаатай байв. "INSERT KEY".

Софиг түлхүүрээ дахин шургуултал, хаалга тэр дороо нээгдэв. Тэд банкны барилга руу уруудсан замаар урагшиллаа. Барилгын доод хонгилын гарааш 10 - аад машин багтахаар давчуу зайтай, бүдэггэрэлтэй газар байв.

Ландон тэндээс банк руу нэвтрэх хаалгыг нүдээрээ хайлаа. Гараашийн голд тавьсан тансаг улаанхивс банк руу нэвтрэх том хаалга руу зочдыг урин залах мэт нүдэнд тусна. Улаан хивсний төгсгөлдээр "Тавгай морил, Бүү ойрт!" гэсэн бичигтэй төмөр хаалгыг Ландон харсан даруйдаа гайхшрав.

Софи хаалганы ойролцоо таксигаа тавиад, хөдөлгүүрээ унтраав.

"Буугаа энд орхисон нь дээр байх!" гэхэд, Ландон бууг суудал доогуур дуртайяа шургуулав.

Машинаас буугаад, тэд бариулгүй хаалга руу дөхөж очив. Хаалганы хажууд гурвалжин нүх байх боловч, энэ удаад ямар заавар, зааварчилгаа байсангүй.

"Удаан сурцтай хүмүүсийг бүү ойрт гэж анхааруулсан юм байна л даа" гэж Ландоныг хошигнонхэлэхэд, Софи инээсэн боловч, царайнаас нь сэтгэл түгшсэн байдал илэрхий байв.

"Ингээд л болчихно!" гээд Софи түлхүүрийг нүхэнд шургуултал, хаалга дотогш удаан хэмээронгойв. Тэд харц солилцон, бие бие рүүгээ харсаар, дотогш оров. Харин ард нь хаалга хав хийтэлхаагдаж байлаа.

Банкны үүдэн хэсгийн засал чимэглэл давтагдашгүй өвөрмөц шийдэлтэй байгааг, Ландон орсон даруйдаа анзаарав. Ихэнх банк өнгөлсөн гантиг, боржин чулуугаар доторхоо тохижуулдаг бол, энд харин бүх хана нь өнцөг болгондоо тав бүхий, дөрвөлжин, металл хавтанцраар хийгджээ. Софи чмөн адил үүдний өрөөг сүрдсэн байдалтай ажиглаж байв. Нэг хэвийн саарал гадаргуутай металлууд шал, лангуу, хаалга, сандал гээд бүх хэсэгт нь оролцсон байлаа.

Та төмөр зооринд орчихлоо гэж сануулах мэт!

Өндөр, чийрэг биетэй үүдний ажилтан залуу ширээний араас тэр хоёрыг хараад зогсч байв. Тэрээр инээмсэглэл тодруулан, эелдгээр мэндлэхдээ, үзэж байсан телевизороо унтрааж харагдав. Томханхар биетэй түүнээс жингэнэсэн нарийхан дуу гарч, Швейцар аялгаар ярих аж.

"Сайн байна уу! Бонжүү! Та бүхэнд юугаар туслах вэ?"

Хоёр хэлээр нэгэн зэрэг мэндчилэх нь, Европчуудын сэдсэн шинэ заль мэхний нэг юм.

Мэнд асуулгаж байгаа хүнд аль хэл нь илүү тааламжтай сонсогдоно, түүгээр нь мэндчилж буйхэрэг. Харин Софи алинаар нь ч хариу мэндэлсэнгүй. Оронд нь алтадмал түлхүүрийг түүний ширээн дээр тавив.

Залуу түүн рүү хараад, тэр дороо цэх болж, "Тэгэлгүй яахав. Та хоёр хонгилын төгсгөл дэх цахилгаан шатанд суугаарай. Би та нарт замчлах хүнийг дуудчихъя!" гэв.

Софи ойлгосноо илтгэж, толгой дохиод түлхүүрийг эргүүлэн авав. "Аль давхарт вэ?"

Залуу түүн рүү гайхсан харцаар харж, "Хэдэн давхарт гарахыг түлхүүр өөрөө заадаг юм" гэж хариуллаа.

Бүсгүй инээмсэглээд, "Өө, нээрээ тийм л дээ".

Үүдний ажилтан залуу тэднийг цахилгаан шатанд ортол нь, хойноос нь ажиглав. Шатны хаалгахаагдмагц, залуу утасныхаа харилцуурыг шүүрэн авч, шөнийн ээлжийн менежер рүү утастав. Утасдуудаж эхэлмэгц, залуу зурагтаа асааж, түүн рүү анхааралтай ширтэнэ. Түүний үзэж байсан мэдээхэдийгээр дуусч байсан ч, энэ түүнд огтхон ч хамаагүй байлаа. Харин дэлгэцэд гарах хоёр хүнийцарайд тэр хамаг анхаарлаа төвлөрүүлнэ.

Менежер утсаа авч, "Уи?" хэмээн хариулав.

"Энд нэг асуудал үүслээ!"

"Юу болоо вэ?"

"Цагдаа нар хоёр сэжигтнийг эрэн сурвалжилж байгаа гэнэ".

"Тэгээд юу гэж?"

"Тэр хоёр сэжигтэн манай банканд саяхан нэвтэрчихлээ".

Ээлжийн менежер харилцуурын цаана хараал тавьж байгаа бололтой, хэсэг азнаснаа, "За ойлголоо.Би ноён Вехнед одоохон мэдэгдье!" гэлээ.

Үүдний ажилтан утсаа таслаад, дахин өөр газар луу залгалаа. Интерпол руу!

Цахилгаан шат өгсөхөөсөө уруудаж байгаа мэт Ландонд санагдана. Хэдэн давхарт гарснаа чмэдэлгүй явсаар, хаалга гэнэт онгойв. Ландон тэндээс гарсандаа сэтгэл нь уужирна.

Зочломтгой, хариуцлагатай байдлын илрэл болсон банкны ажилтан цахилгаан шатны үүдэн дээрал хэдийнээ ирчихсэн, тэднийг хүлээгээд зогсож байв. Тансаг хилэн өмд, хүрэмтэй түүнийгхарахад, технологийн эрин дэх дундад зууны хүнтэй адилтгаж болмоор.

"Сайн байна уу, оройн мэнд! Та бүхэн намайг дагаад явна уу? Сил вү плэ?"

Тэрээр хариу хүлээж тэвдэлгүй, шууд цааш эргээд, хонгил даган хурдан хурдан алхлав.

Ландон, Софи хоёр түүнийг даган хамт алхахдаа, дэргэдүүр нь өнгөрөх компьютерын том дэлгэцбүхий хэд хэдэн өрөөг гүйлгэн харав. Нөгөө ажилтан нэг хаалган дээр зогсч, "Буаши! Ийшээ!" гэжхэлээд, том ган хаалгыг нээв. Тэр хоёр хаалгаар нэвтрэн, тийш оров. Зочид буудлын тансаг ороошиг тохижуулсан, жижиг зайтай, төмөр өрөө байв.

Өнөөх саарал металл хавтан, үслэг хилэн эдлэлүүдийн оронд зузаан хивс, сайн чанарын нарс модонтавилга, зөөлөн сандлууд тавиаастай харагдана. Өрөөний голд байх өргөн ширээн дээр болорхундага хосоор нь тавьж, хажууд нь Перриер хэмээх оргилуун дарс он гойлгон орхисон нь, гааз ньбүрмөсөн гарч амжаагүй байлаа. Цагаан тугалган гүцэнд кофе буцалгаастай байв.

Шуурхай байна шүү! гэж Ландон бодлоо. *Швейцаричуудаас өөр хүмүүс ингээж амжуулж чаднагээж үү.*

Ажилтан залуу сэргэлэн цовоо байдлаар инээмсэглээд, "Та бүхэн анх удаагаа ирж байна уу?"

Софи түр эргэлзээд, дараа нь толгой дохив.

"Ойлголоо. Түлхүүр ихэнх тохиолдолд өв уламжлагдаж, гар дамжиж байдаг болохоор, заримүйлчлүүлэгчид анх ирэхдээ манай дотоод журмыг сайн мэддэггүй юм. Энэ өрөө бол та бүхниймэдэлд байгаа гэж хэлэхийг зөвшөөрнө үү?" гээд, засч тавьсан ширээ рүү заан хэлэв.

"Чи сая түлхүүр өвлөгдөж хоцордог гэж хэлэв үү?"

"Тийм ээ. Манай дүрмээр түлхүүрийг үе залгамжилж хадгалж болдог юм. Манай "алтан" дансээзмшигчид хадгаламжийн хайрцгийг дор хаяж 50 жилийн хугацаатай эзэмшдэг. Бүх төлбөрийг нэгдөр нь, хадгаламж эзэмшиж эхлэхдээ хийдэг юм. Тийм болохоор бид үйлчлүүлэгчдийн түлхүүрийгөвлөн хоцорсон үр хүүхдүүдтэй харьцах нь энгийн үзэгдэл".

Ландон түүнийг цоо ширтэж, "Чи 50 жил гэж хэлсэн үү?"

"Хамгийн багадаа 50 жил. Мэдээж хүсвэл түүнээс ч урт хугацаагаар үйлчлүүлж болно. Гэхдээ 50жил дотроо хайрцгаа эргэж тойрч үзэхгүй бол, хайрцаг дахь эд зүйлс өөрөө автоматаар устдаг. Бита бүхэнд хайрцгаа хэрхэн нээх талаар товчхон тайлбар өгч болохсон болов уу?"

Софи толгой дохиж, "Тэг л дээ".

"Энэ бол үйлчлүүлэгчийн өрөө. Намайг эндээс гарсны дараа та бүхэн хэчнээн ч удсан хамаагүй,хайрцгийг нээтлээ, өөрийн дур хүслийн дагуу юу ч хийж болно" гэж ажилтан залуу хэлээд,өрөөний булангаас тахиралдан гарч ирсэн, нарийхан зам руу дөхөж очоод, түүний эсрэг талд байхтом электрон самбар луу зааж, "Та нар энд түлхүүрээ хийнэ.

Түлхүүрийг компьютер таньж дуусахад, та бүхэн дансны дугаараа оруулна. Дугаараа оруулсныдараа, хайрцаг энэ замыг дагаж, та бүхэн дээр ирэх болно. Хайрцгийг нээж дууссан бол, буцаажтавиад, өмнөх үйлдлээ давтан гүйцэтгэнэ. Бүх үйлдэл автоматчилагдсан болохоор, та бүхнийнууцлал аль ч тохиолдолд гадагш задрахгүй. Хэрэв туслалцаа хэрэгтэй бол, тэр ширээний голдбайгаа дуудлагын товчийг дарж, биднийг дуудаарай!"

Софи түүнд асуулт тавих гэтэл, өрөөнд суурилуулсан утас жингэнэн дуугарав. Ажилтангайхасхийж, эрээ цээргүй, гэнэтийн энэ явдлын өмнөөс ичиж байгаа нь илт байв.

"Өршөөгөөрэй!" гээд, ширээн дээрх утас руу очиж, харилцуурыг авав.

"Уи?"

Тэр хөмсөг зангидангаа, утас чагнан зогсоно. "Уи ... уи! Дакко?" гэж хэлээд, төд удалгүй тэрээрутсаа тавиад, сэтгэл зовсон төрхөө нууж, инээх аядав.

"Уучлаарай! Танаас дахиад нэг зүйл тодруулж болох уу? Таны хэлснээр бол, бидэнд дансны дугаархэрэгтэй гэсэн үү?" гэж Софи асуув.

Залуу хаалганы өмнө зогсонгоо гагцчихаад, царай цонхийчихсон чигтээ, "Тэгэлгүй яахав. БусадШвейцар банкнуудын адил манай хайрцгууд нэр дээр бус тоон дугаар дээр хадгалагддаг юм. Табүхэнд түлхүүрээс гадна, дансны дугаар байх ёстой. Түлхүүр бол хайрцгийг нээхэд, зөвхөн талүүргийг гүйцэтгэнэ. Харин дансны дугаар үлдсэн талыг нь хариуцдаг юм. Үнэндээ түлхүүрээалдчихвал, олсон хэн боловч таны түлхүүрийг ашиглах боломжтой шүү дээ!"

Софи огт эргэлзэлгүйгээр, "Надад түлхүүрийг өвлүүлсэн хүн дансны дугаараа

Үлдээгээгүй бол яахвэ?"

Залуу ажилтны зүрх нь амаараа гарах шахав. Тийм бол энд юугаа хийж ирсэн юм бол?! гэж бодохзуур, залуу тайвнаар инээмсэглэхийг оролдож, "Та бүхэнд тус болж чадах нэг хүнийг би дуудъя. Тэр удахгүй ирнэ" гэв.

Ажилтан тэднийг өрөөний гаднаас цоожлон, гарч одлоо.

Хотын нөгөө хэсэгт, галт тэрэгний зогсоол дээр дэслэгч Коле байж байтал, гар утас нь дуугарав. Фааш ярьж байв.

"Интерпол сураг гаргасан байна. Галт тэргээ орхи. Ландон, Софи хоёр Цюрихийн хадгаламжийнбанкн дээр саяхан очсон бололтой. Хүмүүсээ аваад, тийшээ бушуу яв!"

"Тэр хоёрт Сониех ямар утгатай үг хэлж үлдээснийг та гадарлаж байна уу?"

Фааш хөндий хүйтэн өнгөөр, "Эхлээд та тэр хоёрыг барьчих! Тэгсний чинь дараа, би танд зориулж, байцаалт явуулъя, эрхэм ээ!"

Хэсэг 43

Коле ахмадаас тушаал авангуугаа, "За ойлголоо. Рью Аксогийн 24. Гүйцэтгэе, ахмад аа!" гэж хэлэв. Утсаа таслангуугаа, Коле дотуур холбоогоор хүмүүсээ дуудан, тушаал өгөв.

Цюрихийн Хадгаламжийн банкны Парис дахь салбарын захирал Андре Вехне өөрийн тох илогсууцандаа тэр бүр сэтгэл ханадаггүй хүн бөгөөд, Лиле Сэйнт - Льюис дүүрэг дэх голын эргийнтансаг харшид тааваараа амьдрахыг үргэлж мөрөөднө.

Би халагдмагцаа өөрийн цуглуулгад ховор, үнэтэй Бордо дарсыг нэмэрлэж, өрөөнийхөө ханыг Фрагонард, Бушегийн зургаар чимэглээд, эртний тавилга болон Латин хэл дээрх ховор номуудынараас ангуучлан хөөцөлдөх болно гэж Вехне байнга бодно.

Харин өнөө шөнө, Вехне банкны хонгилоор яаран алхах зуур, өөрийн хослол, гутал нь цэмцгэрбайгаа эсэхийг явдал дундаа доош бөхийнгөө шалгаж амжив. Цэвэр торгон бос даавуун хослолөмссөн, тэрээр явдал дундаа үнэр дарагчийг ам руугаа цацаад, тэр дороо уруулаа жимийв. Цагийнзөрүүгээр аялж буй, гадаад үйлчлүүлэгчээс өөр хэн ингэж Вехнег орноос нь шөнө дөлөөр босгох вэдээ?

Африкийн Мазай овгийн дайчид гаднаас гэнэтийн довтолгоон болоход, ямар ч бөх бат нойрсожбайсан тэр дороо босч, эрэлхэг зориг, хурдан шалмаг байдлыг хослуулсаар, өөрсдийн овгийгхамгаалж гардаг тухай Вехне нэгэнтээ уншсанаас хойш, тэднээс үлгэр дууриалал авахаар шийдсэнэж.

Тулаанд бэлтгэж байна гэж тэр өөрийгөө төсөөлөв.

Шүүх цагдаагийнхны эрэн сурвалжилж буй хоёр этгээд банкны "алтан" данс эзэмшигчид байсаннь, Вехнегийн хувьд байдлыг улам төвөгтэй болгож байв. Банк тэртэй тэргүй зарим хэрэгтнийгхаацайлж, хувь хүний нууцын тухайн хуулиар түрүү барьдаг тул, хуулийн байгууллагуудтайтаарамж муутай байдаг юм.

Цагдаагийнхныг ирэхээс өмнө тэднийг явуулах хэрэгтэй 5 минут гэж Вехне өөртөө хэлэв.

Хэрэв тэр энэ бүхнийг түргэн зохицуулж чадвал, бэрхшээл хүндрэлийг холдуулж болохоор байв. Вехне цагдаа нарт сэжигтнүүдийн талаар мэдээлэл өгч болох хэдий ч, тэд хууль ёсны дансээзмшигчид биш тул, хөөж явуулахаас өөр аргагүй.

Хараал идсэн үүдний ажилтан Интерпол руу ярьчихаагүй байгаасай! гэж Вехне өөртөө итгүүлэхийг оролдоно.

Харамсалтай нь, хариуцлагатай алба хашдаг, үүдний ажилтан залуу цагийн 15 еврогийн цалиналдгаа, ёс төртэйгээр ухамсарладаг нэгэн байв.

Вехне үүдний өмнө очиж зогсоол, түр азнаж, гүн амьсгал аваад, бүх биеэ судлав. Нүдэнд дулаахан инээмсэглэл царайдаа тодруулсаар, урьхан хаврын салхи мэт өрөөнд ороод явчлав.

"Оройн мэнд" гэж үйлчлүүлэгчдийг харангаа хэлээд, "Намайг Андре Вехне гэдэг. Би та бүхэнд ..." гээд хэлэх гэсэн үг нь юу ч үгүй таг болчхов. Чанх урдаас нь ширтэн зогсох бүсгүйг Вехне харангуугаа, хэрхэх учраа олсонгүй үүдэнд гагцхав.

"Та, бид хоёр бие биенээ мэдэх билүү?" гэж Софи асуухдаа, Вехнегийн гөлөрсөн нүд рүү цооширтэж байв.

"М...Мэдэхгүй ээ" гэж банкны захирал намуухан дуугаар, итгэл муутайхан хариулав. "Би таныг мэдэхгүй. Манай банк нэрийг нууцалдаг" гээд Вехне санаа алдаж, дараа нь инээмсэглэхийг оролдов.

"Манай ажилтан та бүхэнд түлхүүр байгаа боловч, дансны дугаараа мэдэхгүй байна гэж надад хэлсэн. Та бүхэн энэ түлхүүрийг хаанаас авсан юм бэ?"

"Өвөө надад өгсөн юм" гээд, Софи Вехнед дөхөж ирээд, түүний сэтгэл түгшсэн байдлыг нүднээс нь олж анзаарлаа.

"Тийм үү? Өвөө чинь түлхүүрийг чамд өгчхөөд, харин дансны дугаарыг хэлэхээ мартчихаа юу?"

"Түүнд хэлэх боломж гараагүй юм. Өвөө маань өнөө орой алагдсан".

Энэ үгийг сонссон, Вехне алгуур хойшилж, "Жак Сониех үхчихсэн гэнэ ээ?" гэж мэгдэн хэлээд, түүний нүд айдсаар бүрхэв.

Гэхдээ ... яаж ... яагаад?!

Гэтэл түүний энэ байдалд Софи цочирдсондоо бас хөшиж орхив. "Та өвөөг мэддэг байсан юм уу?"

Андре Вехне хариуд нь мэл гайхаж, цэл хөхөртөл ингэж хэлэв. "Жак, бид хоёр дотны найзууд байсан юм. Яг хэзээ ийм юм болчихов?"

"Орой болохын алдад. Луврын музейд ийм юм болчихлоо".

Вехне сандал дээр нугдайтлаа шигдэн суув.

"Би та хоёроос нэг л зүйлийг олж мэдмээр байна" гээд Ландон, Софи хоёр луу ээлжлэн ширтэж, "Та хоёр түүний үхэлтэй холбоотой юу?" гэж асуув.

"Огтхон ч үгүй. Үгүй" гэж Софи эрс чангаар хэлэв.

Вехнегийн харц нь догширч, дотроо нэгийг эргэцүүлнэ. "Та хоёрын гэрэл зургийг Интерползурагтаар дугуйлчихаад байгаа. Тийм болохоор л би та хоёрыг харсан даруйдаа таньсан юм. Тахоёр хүн амины хэрэгт сэжиглэгдэж байгаа" гэв.

Ахмад Фааш эцэст нь Интерпол руу холбогдсонд, Софи гайхаж цочирдлоо. Ахмадыг ингэжхөдөлнө гэж Софи огтхон ч таамаглаагүй байсан юм.

Софи өнгөрсөн орой болсон, бүх явдлыг Вехнед товчхон ярьж өгөв.

Вехне машид гайхаж, "Тэгээд өвөө чинь үхэхдээ, ноён Ландоныг ол! гэж чамд гэрээс бичижүлдээсэн хэрэг үү?"

"Тийм. Бас энэ түлхүүрийг..." гээд Софи түлхүүрийн бэлгэдэл дүрстэй талыг доош харуулан, Вехнегийн өмнө ширээн дээр тавилаа.

Вехне түлхүүр лүү ширтэх боловч, түүнд огт хүрсэнгүй. "Чамд зөвхөн энэ түлхүүрийг л үлдээсэн юм уу? Өөр зүйл үлдээгээгүй юу? Бичигтэй цаас ч юм уу, өөр ямар нэг зүйл?"

Софи хэдийгээр Луврын музейд яарч тэвдсэн байдалтай бүх зүйлийг амжуулсан ч, Мадоннагийн ард өөр юу ч байгаагүйг сайн санаж байв.

"Үгүй ээ. Зөвхөн энэ түлхүүр л байсан".

Вехне чин үнэнийг хэлж, "Түлхүүр зөвхөн 10 орон бүхий дансны дугаартай цуг хайрцгийг нээж чадна. Нууц үг буюу дансны дугааргүйгээр, түлхүүр ямар ч хэрэгцээгүй".

10 оронтой дансны дугаар гэнэ ээ?

Софи энэ чиглэлийн шинжээч мэргэжилтний хувьд зөв дугаарыг олох магадлалыг тооцож үзэв. Дор хаяж 10 - аад тэрбум хувилбар гарч ирнэ. Хүч, хурдтай код тайлагч компьютер ашиглан дугаарыг хайлаа ч гэсэн, бүтэн долоо хоног элбэг зарцуулахаар байв.

"Эрхэм ээ, та бидэнд тусалж чадах юм шиг санагдах юм!"

"Уучлаарай. Би юу ч хийж чадахгүй. Үйлчлүүлэгчид дансны дугаараа компьютерт өөрсдөө сонгож оруулдаг тул, өөр бусад хүн мэдэх боломжгүй. Ийм замаар л бид нэргүй үйлчилгээний хээ баталгааг хангадаг юм. Нөгөө талаас ажилтнуудын аюулгүй байдалд ч энэ нь чухал хэрэгтэй шүүдээ".

Софи үнэн байдлыг ойлгов. Том дэлгүүрүүдэд ч мөн адил хадгалах хайрцагны түлхүүрийг ажилчид нь биш, худалдан авагчид өөрсдөө авч ордог шүү дээ! Банкны ажилтныг барьцаалан, дансны дугаарыг хэлүүлж аваад, түлхүүрээр хайрцагт нэвтэрчихвэл, юу болох билээ.

Софи Ландоны дэргэд суугаад, түлхүүр рүү харж байснаа, Вехнед хандаж, "Манай өвөө танай банканд юу хадгалсан талаар танд ямар нэг таамаг байна уу?"

"Ямар ч таамаг алга даа. Энэ нууц чинь өөрөө манай банкны оршиж байгаа гол тулгуур нь байхгүй юу".

"Ноён Вехне, бидэнд хугацаа бага байгаа. Тиймээс сэдэвтээ шууд оръё!" гээд түлхүүр дээр дүрсэлсэн бэлгэдэл дүрсийг Вехнед харуулаад, "Энэ дүрс танд ямар нэг зүйлийг санагдуулж байна уу?"

Вехне сайтар ажигласан боловч, ямар нэг хариу урвал царайдаа тодруулсангүй.

"Ихэнх үйлчлүүлэгчид түлхүүр дээрээ дуртай зүйдээ дүрсэлж, эсвэл үг, нэр зэргийг бичүүлсэн лбайдаг шүү дээ".

Софи түүнээс харцаа салгасангүй чигтээ, "Энэ бол Сионий Прайорийн бэлгэдэл дүрс" гэжнухацтай өгүүлэв.

Вехне үүнийг сонсоод, огтхон ч тоосонгүй. "Тийм үү? Би энэ талаар мэдэхгүй юм байна.

Өвөөтэй чинь би найз байсан хэдийн ч, ажил хэргийн талаар голдуу ярьдаг байсан" гэж хэлээд, сэтгэл түгшсэнээ нуухыг оролдон, зангиагаа засна.

"Ноён Вехне! Өвөө маань үхэхийнхээ өмнө над руу ярихдаа, намайг болон өөрийгөө их аюултай байдалд орсон гэж хэлсэн байсан. Өвөө надад нэг зүйл өгөхийг хүсээд, тэр нь танай банкнытүлхүүр байж таарлаа. Тэр одоо үхсэн. Харин одоо таны мэдэх зүйл чинь бидэнд маш их тус болохболно шүүдээ!"

Үүнийг сонссон Вехнегийн хар хөлс нь цувна.

Бүсгүй эцсийн дайралтаа хийж, "Өвөө надад манай гэр бүлийнхний тухай чин үнэнийг хэлэхийг хүссэн гэсэн. Энэ танд нэгийг бодогдуулахгүй байна гэж үү?"

"Хатагтай! Танай гэрийнхэн чинь чамайг бага байхад, авгын ослоор нас барцгаасан. Үүнд би маших харамсаж явдаг, Өвөө чинь чамд маш их хайртай байсныг ч би мэднэ. Чамаас холдож салсандаа, сэтгэл нь ихэд өвддөгөө, хэд хэдэн удаа надад ярьж байсан".

Софи хариуд нь юу гэж хэлэхээ мэдэхгүй таг болчхов.

"Энэ дансны дугаар СанГрейльтэй ямар нэг байдлаар холбоотой юм биш биз?" гэж Ландон тэднийярианд оролцов.

Вехне хачирхаж, "СанГрейль гэж юу юм бэ?"

Гэнэт Вехнегийн гар утас дуугарахад, тэрээр утсаа авч, "Уи?" гэж хариулав.

Тэрээр хэсэг сонсч байснаа, "Ла Полице?"

Тэр хараал тавин, Францаар заавар өгч байснаа, удахгүй гарч дээшээ очно гэдгээ утсаар хэлэв.

Вехне ярьж дуусчхаад, Софи руу эргэж хараад, "Цагдаа нар бодсоноос түргэн хөдөлж шүү! Одоонаашаа ирж байгаа гэнэ".

"Цагдаа нарт бид хоёрыг энд ирээд, аль хэдийнээ явчихсан гэж хэлээрэй. Хэрэв нэгжлэг хийнэгэвэл зөвшөөрөл шаардаарай! Ингэж л тэднийг түр саатуулж, хугацаа хожиж чадна".

"Сонс! Нэгд, Жак миний найз байсан, хоёрт, банканд маань элдэв төвөг учрахыг би хүсэхгүйбайгаа учраас, би та хоёрыг тэдэнд барьж өгөх бодолгүй байна. Надад боломж олго. Тэгвэл би тахоёрыг сиймхий ашиглаад, эндээс нууцаар гаргая. Гэвч би энэ бүхэнд оролцоогүй шүү!" гээд босчхаалга руу зүглэлээ. "Эндээ байж - байгаарай. Би бүгдийг зохицуулчихаад, эргээд ирье".

"Гэхдээ хайрцгаа яах вэ? Бид хайрцгийг орхиод, эндээс шууд явчхаж болохгүй шүүдээ!"

Цагдаа нар гэнэ ээ?

"Би үүнд тусалж чадахгүй гэдгээ хэлсэн шүүдээ. Уучлаарай!"

Софи түүний араас харсаар хоцрохдоо, олон жилийн турш өвөөгийнх нь ач охиндоо илгээсэнтөөлж баршгүй ил захидлуудын нэгэнд нь дансны дугаар байгаа юм болов уу гэж бодож амжив.

Ландоны нүд нь гэрэлтэн, нүүрэндээ мишээл тодруулсаар, суудлаасаа босохыг, Софи анзаарав.

"Роберт? Чи инээж байна уу даа?"

"Өвөө чинь жинхэнэ ухаантан байж!"

"Чи юу яриад байна аа?"

"10 оронтой дугаарын тухай ярьж байна".

Софи үнэхээр учрыг нь ухаж ойлгосонгүй.

"Дансны дугаар" гээд Ландоны царай гэрэлтэж, "Өвөө чинь бидэнд дансны дугаараа үлдээсэнгэдэгт би багтай итгэж байна".

"Яаж тэр вэ?"

Хэсэг 44

Ландон өвөөгийнх цогцос бүхий хэргийн газрын гэрэл зургийг гаргаж ирээд, ширээн дээр дэлгэнтавив. Зурган дээрх бичээс кодын эхний мөрийг харангуутаа, Софи бүгдийг ойлгов.

13-3-2-21-1-1-8-5

"10 оронтой тоо" гэж Софи хэлээд, шинжээч хүний хувьд гэрэл зургийг дахин сайтар ажиглав.

13-3-2-21-1-1-8-5

Өвөө Дансны нууц дугаарыг Луврын музейн шалан дээр бичсэн гэж үү?

Анх энэ тоог харахдаа, өвөө нь зориуд цагдаагийнхны анхаарлыг татаж, тэр нь Софиг хүрч ирээд кодыг тайлахаар бодож бичсэн байна гэж бүсгүй эргэцүүлсэн аж. Дараа нь энэ кодыг зөв дараалалд оруулсан нь, бичээсийн бусад мөрийн утгыг тайлахад хэрэг болсон юм.

Гэтэл одоо хүртэл энэ цифрүүд хэргийн учгийг тайлах түлхүүр болсоор байгаад, Софи үнэхээргайхаж биширчээ. Энэ дугаар өвөөгийнх нь хадгаламжийн хайрцгийг онгойлгох түлхүүр болж байв.

"Өвөө маань утгын цаана утга гаргаж чаддаг хүн байсан юм. Олон давхар далдлагдсан зүйлд дуртай байсан. Кодын дотор код ч гэх юм уу"

Ландоныг электрон самбар луу дөхөж очих хооронд, Софи гэрэл зургийг барьсаар түүний араас дагав.

Электрон дэлгэц банкны АТМ шиг дээрээ мэдрэгч товчлууруудтай байв. Дэлгэцэн дээр бас лхэрээс тэмдэг дүрслэгдсэн харагдана. Дэлгэцийн доод талд өнөөх танил, жижиг, гурвалжин нүх байв. Софи эргэлзэж тээнэгэлзэлгүй, түлхүүрийг нүхэнд шууд шургуулав.

Дэлгэц тэр дороо анивчин өөрчлөгдөөд, "Дансны дугаараа оруулна уу!" гэсэн бичиг гарч ирэв.

10 оронтой тоо.

Софи Гэрэл зураг дээрх цифрүүдийг уншиж, харин Ландон түүний хэлсэн дагуу самбар дээр бичижоруулна.

Дансны Дугаар: 1332211185

Ландоныг бичиж дуусахад дэлгэц дахин өөрчлөгдөж, нэгэн анхааруулга англи хэл дээр ийнхүүгарч ирэв.

"Анхааруулга: Та Нэвтрэх (enter) товчлуурыг дарахын өмнө нууц дугаараа сайтар шалганауу! Хэрэв таны оруулсан дугаар буруу байвал, систем тэр дороо унтрах болно!"

"Фонкшон тэминье" (Өөрөө унтардаг систем) гэж Софи Францаар хэлээд, "Бидэнд зөв дугаарыгоруулах ганц боломж байгаа бололтой".

Ердийн АТМ машинууд ихэнх тохиолдолд гурван удаа алдаатай оруулахыг зөвшөөрдөг бол, энэудаад ердийн бэлэн мөнгөний машинтай зүйрлэж болохгүй аж.

"Дугаар зөв бичигдсэн байна" гэж хэлэнгээ, Ландон дэлгэцэн дээрх тоо болон зураг дээрх тоогээлжлэн харьцуулж, нягтлан шалгав. Тэгээд "enter" товчийг зааж, "Дараарай!" гэж Софигшавдуулав.

Софи долоовор хуруугаа товчлуур луу сунгаснаа, эргэлзэж байгаа бололтой түр саатах нь тэр.

"За алив!" Вехне удахгүй хүрээд ирнэ" гэж Ландон бүсгүйг яаруулна.

"Үгүй ээ!" гээд Софи сунгасан гараа эргүүлэн татаж, "Энэ дансны дугаар биш байна".

"Мөн шүү дээ! Үүнээс өөр ямар дугаар байх ёстой гэж? 10 оронтой өөр дугаар бидэнд олдох чүгүй !"

"Энэ тоо хэтэрхий замбараагүй юм шиг санагдаад байна!"

Замбараагүй гэнэ ээ?

Ландон бүсгүйд үнэн голоосоо эгдүүцэж байв. Бүх банкнууд үйлчлүүлэгчээ PIN кодоо өөрийндураар сонгохыг зөвшөөрч, тэр нь хэн ч бодож олохооргүй, тийм замбараагүй хэлбэртэй байдагшүү дээ!

Софи дэлгэцэд бичсэн бүх тоог арилгаад, "Дансны дугаар Фибоначчийн дарааллаар байгаа юм шигсанагдаад байна" гэж хэлэнгүүтээ, дугаарыг шинээр цуглуулан бичиж эхэллээ.

"Өвөө код. Бэлгэдэл зэрэгт дуртай байсан шигээ, өөрөө санахад хялбар дансны дугаарт дурлаж,сонгосон байх ёстой" гээд Софи бичиж дуусаад, залирхагаар инээмсэглэлээ. Түүний оруулсандугаар замбараагүй юм шиг мөртлөө, үнэндээ тийм биш байв.

Дансны дугаар: 1123581321

Ландонд Софигийн зөв юм шиг санагдав. *Фибоначчи дараалалд орсон цифрүүд!*

1-1-2-3-5-8-13-21

Фибоначчийн дарааллын дагуу цифрүүдийг 10 оронтой тоо болгон бичихэд, үнэндээ хэн

Ч тэндээсдараалал гэхээр зүйл олж харахааргүй байв.

Санахад хялбар бас, замбараагүй байдалтай шүү!

Шижир алт шиг давтагдашгүй 10 оронтой тоог Сониех хэзээ ч мартхааргүй байлаа.

Софи дугаарыг бичиж дуусаад, Enter товчлуурыг дарав. Гэтэл хүний урманд юу ч болсонгүй, юу чөөрчлөгдсөнгүй .

Энэ мөчид банкны доод хонгилд хөдөлгөөн ид өрнөж байв. 3 хэмжээст тохиргоотой, тээвэрлэхтөхөөрөмж таазнаас зүүгдсэн чигтээ өгөгдсөн командын дагуу, хайсан зүйлийнхээ байгаа цэг рүүдавшила. Цементэн шалны доор оньсон хөдөлгүүрийн дээд хөгжлийн илрэл болсонтөхөөрөмжүүд график, чиглэлийнхээ дагуу ажиллаж байлаа

Сонгосон цэг дэх хайрцагны кодыг лазер гэрлээр таниулан шалгаж дуусангуутаа төмөр саварбайрандаа аажуухан буцаж очив. Түүнийг буцангуут зам ажиллаж эхлэн, хайрцгийг тээсэн чигтээцааш хөдлөв.

Харин чанх дээр нь Софи, Ландон хоёр автомат зам хөдөлж эхлэхийг ажиглан зогсож байв. Замындэргэд ойрхон зогссон, тэр хоёр онгоцны буудал дээр, нууцлаг чухал тээшээ хүлээн зогсохоялагчид шиг харагдана. Хананд далдлагдсан байсан, жижиг хаалга онгойж, нарийхан завсраар ньтом гэгчийн хуванцар хайрцаг багтаж ядсаар гарч ирэв.

Хар өнгөтэй, хүнд жинтэй тэр хайрцаг Софигийн төсөөлснөөс хамаагүй том байв. Яг л тэжээвэрамытныг агаараар тээвэрлэдэг тусгай зориулалтын хайрцаг шиг боловч, торон нүхгүйгээрээялгаатай байв. Хайрцаг дөхсөөр, яг тэдний өмнө ирээд зогсов.

Софи, Ландон хоёр хөдлөлгүй зогссон чигтээ, хайрцгийг харсаар байв, Софид хайрцаг яг л томгэгчийн багажны сав шиг санагдана. Бүсгүй бариулаас нь шууд татангаа, Ландон руу харвал, тэрээр сэхээ авч, хайрцгийг хамтдаа чангаан доош буулгав. Онгойлгож үзтэл, эхэндээ хоосон юмшиг харагдав. Сайтар лавлан харвал, хайрцагны ёроолд нэг зүйл байлаа. Гоёмсог чамин нугасбүхий, тагтай модон хайрцаг гутлын хайрцагны хэмжээтэй аж. Гөлгөр тэгш гадаргуу, хүрэн ягаанөнгөтэй тэр хайрцагны модонд өргөн бараан судлууд бидэртэн үзэгдэнэ.

Сарнайн хайрцаг байна гэж Софи тэр дор нь танив. Хайрцаг өвөөгийнх нь дуртай зүйлийн нэгбайсан юм. Хайрцагны таган дээр гоёмсог хэлбэртэй сарнайн дүрс шигтгэж урласан байлаа.

Ландон, тэр хоёр бие бие рүүгээ хэсэг ширтэв. Софи жижиг модон хайрцгийг том хайрцаг дотроосшүүрч аваад гаргах гэтэл, "Бурхан минь! Ямар хүнд юм бэ?" хэмээн дуу алдав.

Софи хайрцгийг болгоомжтой зөөж гаргаад, ширээн дээр тавив. Өвөөгийнх нь зааж өгсөн, эрдэнэмэт тэр зүйлийг Софи, Ландон хоёр нүд салгалгүй ширтэнэ. Ландон хайрцган дээрх Сарнайндүрстэй шигтгэмлийг алмайран харна. Тэр өмнө өь ийм дүрсийг олонтаа харсан билээ.

"Ариун Грейлд зориулсан Сионий Прайорийн бэлгэдэл бол таван талт сарнай юм шүү дээ!" гэжЛандон хэлэв.

Софи түүн рүү харав. Ландоны бодож байгааг, Софи мөн адил бодож байгаа гэдэгт профессор эргүнээ итгэнэ. Энэ хайрцагны овор хэмжээ, хүнд байгаа зэрэг нь эцэстээ дотроо ганц зүйлийгагуулж байгаа гэх дүгнэлтэд хүргэж байлаа.

Энэ бол Христийн аяга. Энэ бүхэн байж болигүй! гэж Ландон өөртөө давган хэлэх аж.

"Дотор нь яг л аяга багтааар хэмжээтэй юм" гэж Софи хэлэв.

Аяга байж таарахгүй!

Софи хайрцгийг онгойлгохын тулд, өөр лүүгээ ойртуулав. Тэгтэл хайрцаг дотор шингэн зүйлцэлгэх шиг болов.

Ландон гайхаж, "Дотор нь шингэн зүйл байгаа хэрэг үү?"

Софи ч бүр гайхаж "Чи сая сонсов уу?"

Ландон толгой дохиж, "Шингэн бодис".

Софи хайрцгийг өөртөө аяархан ойртуулж, эцэст нь тагийг нээв. Дотор нь байсан зүйлийг Ландонанх удаа харж байгаа нь тэр байлаа. Тэдэнд нэг л зүйл тодорхой болов.

Хайрцаг дотор Христийн аяга байсангүй.

Хэсэг 45

"Цагдаа нар банкиг бүсэлчхэж!" гэсээр Вехне сүр сархийн орж ирэв. "Та хоёрыг нууцаар гарганагэдэг одоо амаргүй боллоо" гээд тэрээр хаалгаа хаав.

Хадгаламжийн хайрцаг өрөөнд ороод ирчихсэн, бас түүнээс гадна нээгдсэн байхыг Вехне хараадзогтусав. *Бурхан минь! Тэд Сониехийн хайрцгийг гаргаад ирж!*

Софи, Ландон хоёр түүний орж ирэх дуунаар ширээний өмнө гарч зогсоод, "эрдэнэсийн" хайрцгаардаа халхалж амжив.

"Бидэнд дансны дугаар байсныг сая л мэдлээ" гэж Софи хэлэв.

Вехнегээс дуу огт гарсангүй. Бүх зүйл өөрчлөгджээ. Тэрээр нүднийхээ булангаар модон хайрцгийгхараад, дараагийн үйлдлээ цэгнэх гэж оролдоно.

Би тэднийг нууцаар гаргах ёстой!

Гэвч цагдаа нар банкиг бүсэлсэн болохоор, түүнд ганцхан арга зам байлаа.

"Хатагтай, Нөвү. Хэрэв би таныг эндээс гаргачихвал, та наадхаа энд нь үлдээх үү, аль эсвэл авчявах бодолтой байна уу?" гэж Вехне модон хайрцаг руу заан асуув.

Софи Ландон руу нэг харснаа, Вехне рүү эргэж хараад, "Бид үүнийг авч явна!" гэв.

Вехне зөвшөөрч, "Сайн байна. Ямар ч гэсэн наад зүйлээ юмаар ороочих. Бусдад анзаарагдахаар авчявах дэмий байх".

Ландон ноосон хүрмээ тайлж, Вехне зам руу очиж, товчлууур дараад, том хайрцгийг буцааж доошоруулав. Тэгээд алтадмал түлхүүрийг самбараас сугалж, Софид өглөө.

"Ийшээ яваарай! Түргэлээрэй!"

Тэднийг гараж руу хүрч, хаалганд ойртох үед, цагдаа нар банкны гаднах талбайг хурц гэрлээр гялбуулан, хаа сайгүй зогсох нь үзэгдэв.

Би энэ бүхний ард гарч чадах юм гэж үү?

Вехнегийн нуруугаар хүйт оргиж, үс нь арзасхийв. Вехне хуягласан жижиг машин руу чиглэнэлхав. Машины жолооч өөр тийш ажилтай явсан тул, машин эзгүй байв.

"Ачаан дотор нь ороод суучих!" гэж Вехне нөгөө хоёрт хэлээд, хойд хаалгыг нь хүчлэн нээв. "Биудахгүй ирнэ!"

Тэр хоёрыг ачаанд суух хооронд, Вехне харуулын өрөөнд нэвтэрч, машины түлхүүрийг аваад, тэндээс жолоочийн дүрэмт хувцас, малгайг ч бас олов. Өөрийнхөө өмссөн хүрэм, зангиаг тайлаад жолоочийн хүрмийг өмсөв. Хүрэмний дотор талд байсан бууны гэрийг олж анзаараад, өрөөний тавиур дээр ил байсан гар бууг шүүрэн авч, суган дахь бууны гэртээ түүнийг шалмаг гэгч хийв.

Машин руу очихоосоо өмнө, Вехне жолоочийн саравчтай малгайг доош нь дарж өмсөөд, Софи, Ландон хоёр дээр очив.

"Та хоёрт энэ нь дээр!" гээд ачааны бүхээг дэх бүлэг гэрлийг асаав. "Тэгээд бас доошоо суусан нь дээр байх. Чимээ огт гаргаж болохгүй шүү!"

Тэр хоёр Вехнегийн хэлсэн дагуу, төмөр шалан дээр доош болж суув.

Ландон хүрмээрээ хайрцгийг бөх гэгч өлгийдөн ороожээ. Вехне ачааны хүнд төмөр хаалгыгхаагаад, тэднийг гаднаас нь түгжив. Дараа нь жолооны ард сууж, машинаа асаалаа. Түүний хөлссаравчтай малгайнх нь саравчин дороос зам татуулан урсана.

Банкны гадаах ил зогсоол дээр түүний төсөөлснөөс хамаагүй олон цагдаа иржээ. Хоёр давхархаалгыг өнгөрч, эцэст нь хашааны гадаа гарч ирэв. Вехне хөмсгөн дээрээ тогтсон хөлснийхөө дуслыг ханцуйгаараа шудраад, алгуур урагшлав.

Өндөр, туранхай цагдаа түүнийг дахин зогсооход, түүнээс хэдэн алхмын цаана эргүүлийн 4 машинзам хаан, хөндлөн зогсжээ.

Вехне зогсов. Малгайгаа улам доош духдуулсан боловч, суудлаасаа ер хөдөлсөнгүй. Хаалгаангойлгож, цонхигор шар боловч хэрсүү төрхтэй цагдаа руу ширтэнгээ, "Кэсце ки се пас?" (Юуболоо вэ?) гэж Вехне бүдүүн хадуун дуугаар асуув.

"Же сүй Жером Коле" (Миний нэр Жером Коле.) гэж цагдаагийн ажилтан хэлээд "Льютенант Полице жулишах" (Шүүх цагдаагийн газрын дэслэгч).

Нөгөө цагдаа ачааны бүхээг рүүдохин, "Кэсце ки ла дэдно?" (Юу ачиж яваа юм вэ?) гэж асуув.

"Чөтгөр ав гэж! Би мэддэг ч болоосой" гэж Вехне хайнгадуухан хариулав. "Би чинь зүгээр л нэгжолооч шүү дээ".

Коле түүний хэлснийг тоосон шинжгүй, "Бид гэмт хэрэгнүүдийг эрж байна".

Вехне инээд алдаад, "Та нар зөв газраа ирсэн байна. Намайг хөлсөлдөг энэ газрын бүх хүмүүс иххэмжээний мөнгө луйвардсан гэмт хэрэгтнүүд гэдэгт би итгэдэг юм".

Дэслэгч түүнд Роберт Ландоны зургийг үзүүлээд, "Та энэ хүнийг өнөө шөнө банканд байхыг харсан уу?"

Вехне мөрөө хавчиж, "Хараагүй ээ. Би чинь ажлын харх байхгүй юу! Тэд намайгүйлчлүүлэгчтэйгээ ойр байлгана гэж бодоо юу? Та нар дотогш ороод, өөрсдөө асуусан дээр байхаа" гэв.

"Танай банкны удирдлага нэгжлэг хийх зөвшөөрөл биднээс шаардаад байна".

Вехне жигшсэн байртайгаар, "Энэ удирдлагын хархнуудуу? Дахиад л намайг бухимдуулаадэхэллээ".

"Та бидэнд ачаагаа үзүүлнэ үү!" гэж Коле арын бүхээг рүү заан хэлэв.

Вехне дэслэгч рүү харцаа чиглүүлж, зэвүүнээр инээгээд, "Та ачаагаа үзүүл гэсэн үү? Та намайг түлхүүртэй гэж бодож байна уу? Тэд надад итгэнэ гэж та бодоо юу? Надад хялайлгадаг хэдэнзоосыг нь та тоолдог ч болоосой".

Дэслэгч түүний хэлснийг эргэцүүлэн, бодлоо дэнсэлж байгаа бололтой, толгойгоо гилжийлгэнэ. "Танд тэгээд ачааны бүхээгийн түлхүүр байхгүй гэж үү?"

Вехне толгой сэгсэрч, "Би зөвхөн машинаа асааж, унтраах үүрэгтэй. Харгалзагчид бүгдийг ачиж, лацдаад, ачааг хүлээн авах хүнд түлхүүрийг илгээчихдэг юм. Түлхүүр хүрэх ёстой газраа, эзэндээ очсон цагт л биднийг дуудаж, жолооны ард суухыг зөвшөөрдөг юм. Би тээвэрлэж байсан зүйлээхээ ч мэдэж байгаагүй".

"Тэгвэл энэ машиныг хэзээ лацадсан юм бэ?"

"Цагийн өмнө лацадсан байх. Би өнөө шөнө Гэгээн Турцасын гудамж руу явах ёстой. Ачааны түлхүүр тэнд л байгаа байх".

Дэслэгч хариу дуугарсангүй, харин Вехнегийн нүд рүү ширтэж, бодлыг нь уншихыг оролдоно. Вехнегийн хамрыг даган дусал хөлс явсаар, юу юугүй доош унах гэж байв.

"Та зөвшөөрвөл ..." гээд Вехне хамрынхаа үзүүрт тогтсон хөлсийг ханцуйгаараа шудраад, замхөндөлдсөн машинууд харж, "Би яарч байгаа юмсан!" гэв.

"Тан шиг жолооч нар бүгд Ролекс зүүдэг юм уу?" гэж Вехнегийн бугуйн дахь цагийг ширтэнгээ, дэслэгч асуув. Вехне доош хараад, нэлээд үнэтэй, гялалзсан оосортой бугуйн цагаа ханцуйнаас нь цухуйсныг олж үзмэгцээ, "Энэ хог уу?! Тайвань хорооллын захаас 40 еврогоор авсан юм. Танд болби 20 еврод өгчихнө шүү!"

Дэслэгч хойш ухарч цааргалаад, "Үгүй дээ. Баярлалаа! Замдаа сайн яваарай!"

Вехне тэндээс 50 метр хэртэй холдтолоо, амьсгаагаа ч бүрэн авч чадсангүй.

Одоо түүнд нэг асуудал үлдсэн. Энэ бол түүний тээж яваа ачаа.

Тэднийг хааш нь аваачих вэ?

Хэсэг 46

Силас өрөөндөө гудас дэвсээд, нуруун дахь шинэхэн шархаа хатахыг хүлээн, түрүүлгээ х аранхэвтэнэ. Өнөө шөнийн "өөрийгөө тарчлаах" ёслол түүнийг туйлдтал нь ядраажээ. Саяхан өргөстбүсээ тайлснаас, гуяын дотор талыг нь даган, шингэн улаан цус алгуур урсана.

Би сүмийнхээ итгэлийг хөсөрдүүлчихлээ! Түүнээс долоон дор юм болж, хамба ламыг балл ачихлаа!

Өнөө шөнө Арингарозагийн хувь заяа үхэл сэхлийн ирмэг дээр тулж ирчхээд байсан юм.

5 сарын өмнө хамбыг Ватикан дахь төв удирдлагаас буцан ирэхэд, бүх зүйл өөрчлөгдөж, Силасүүнээс үүдэн их зүйлийг ухаарсан юм. Олон өдөр дуугүй байсны эцэст Арингароза Силастайшаналсан сэтгэлийнхээ шалтгааныг хуваалцжээ.

"Ийм байж болохгүй!" гэж Силас хашхирна. "Би үүнийг тэвчихгүй".

"Гэхдээ энэ бол үнэн. Тааварлашгүй үнэн. Бидэнд зөвхөн 6 сарын хугацаа өгсөн".

Хамба ламын хэлсэн үг Силаст аймшигтай санагджээ. Тэр энэ бараан өдрүүдийн турш, Бурхнаасаврал эрэн, мөргөл үйлдэж байхдаа, Бурхны хүч чадалд өчүүхэн ч эргэлзэж байгаагүй юм.

Удалгүй сарын дараа гай зовлонгийн үүл сарниж, нарны туяа хурц гэрлээ тэр хоёр дээр тусгасанбилээ. Арингароза үүнийг "Бурхан тэнгэрийн ивээл" гэж нэрлэжээ.

Хамба лам тэр үед найдвар, итгэл өвөрлөн Силаст ингэж хэлжээ. "Бурхан бидэнд "Замналыг" үргэлжлүүлэг гэж ивээлээ хайрлажээ. Бидний тэмцэл бол бусад тэмцэлтэй адил төлөөс шаардана. Чи Бурхны дайчин болж, төлөөсийг үл хайхран тэмцэж чадах уу?"

Силас Арингарозагийн өмнө сөхрөн суугаад, авран хамгаалагч хамбатанд бүхнийг даатган, "Би болбурхны өмнө хурга л гэсэн үг. Намайг Бурхан өөрийнхөө дураар хурга мэт хариулахыг би хүсчбайна".

Арингароза хариуд нь өөрийн төлөвлөснийг Силаст ярихад, тэр боломж нь зөвхөн Бурхныоролцоотойгоор биелэх юм гэдгийг альбино гадарлажээ.

Ид шидийн хүчээр шүү!

Арингароза өөрийгөө Багш гэж нэрлэдэг нэг хүнийг Силаст танилцуулжээ. Силас, Багш хоёрхэдийгээр нүүр тулж уулзаагүй ч, утсаар байнга харьцаатай байдаг байж. Силас багшийн гүн итгэлбишрэл болон нэр нөлөөнөөс заримдаа айж сүрддэг байв. Багшид сонсоогүй мэдээ, хараагүй явдалгэж байдаггүй байлаа. Багш мэдээллийг хэрхэн, хаанаас олдгийг, Силас ихэд сэжиглэх боловч, Арингароза багшид үнэн голоосоо итгэдгийн нэгэн адил Силасыг ч мөн итгэхийг шаарддаг байв.

"Багшийн хэлснийг хий! Тэгвэл бид ялагдашгүй байж чадна!" гэж Арингароза байнга хэлнэ.

Ялагдашгүй!

Силас шал руу гөлрөн, тэднээс нүүрээ буруулан, тэр ялалтын тухай бодно.

Онъсон чулуу олдохгүй! Бүх найдвар талаар өнгөрлөө!

Силас гэнэт Арингароза руу ярьж, бүхнийг урьдаас анхааруулмаар санагдавч, Багш Арингароза тэрхоёрыг хоорондоо харьцах бололцоогүй болгосон юм. Аюулгүйн байдлын үүднээс тэр аж.

Сэтгэл догдлолоо дарахын тулд, тэрээр мөлхсөөр, өмсгөл дотроо байсан гар утсаа гаргаж, гадагшзалгалаа. Силас толгойгоо гудайлгасан нь, түүний ичгүүрт ялагдлын илрэл байлаа.

"Багш аа!" гэж дорой дуугаар аядуухан хэлээд, "Бүх зүйл талаар болсон" гэж Багшид хэлэв.

"Чи туйлбаргүй хүн юм. Би саяхан нэг мэдээлэл олж сонслоо. Санаанд оромгүй боловч, таатаймэдээ шүү! Жак Сониех үхэхээсээ өмнө нууцыг хэн нэгэнд дамжуулсан байна. Би чамтай эргээдярина. Өноолрийн ажил дуусаагүй байгаа шүү!"

Хэсэг 47

Давчуу зайтай, бүдэг гэрэлтэй ачааны бүхээгт суусан нь агуйн мухарт даяанч хийж байгаа юм шиг Ландонд санагдана. Ландон хязгаарлагдмал орон зайд байж чаддаггүй мэдрэмжтэйгээ тэрсэлдэн, тэмцэлдэж байлаа. Вехне тэднийг аюулгүй газар хотын захад аваачина гэж хэлсэн ч яг хаашаа, хэрхөл явахыг хэн ч мэдэхгүй байв.

Ландон төмөр шалан дээр нэг байрлалдаа удаан суусан тул, хөл нь хөшсөнд, байрлалаа өөрчилж, биеэ жаал хөдөлгөв. Түүний гарт банкнаас авч гарсан, "эрдэнэс" атгаастай байв.

"Бид хурдны замаар явж байгаа бололтой" гэж Софи шивэгнэв.

Ландон ч бас тэгж бодож байлаа. Сарнай хайрцагт анхаарлаа хандуулж, боодолтой хайрцгийг гараасаа чөлөөлж, шалан дээр эвтэйхэн тавиад, гадуур нь ороосон хүрмээ задалж, хайрцгийг өөртөө ойртуулав. Софигийн түүнд ойртож суухыг хөндлөнгөөс харах юм бол, тэр хоёр зул сарынбаяраар бэлгээ задлах гэж байгаа балчир хүүхдүүд шиг харагдана.

Хайрцагт шигтгэсэн цайвар өнгийн Сарнайн дүрс бүдэг гэрэлд тодрон үзэгдэх аж.

Сарнай.

Нууц бүлэглэлийн бэлгэдэл болсон энэ дүрсийг Хөлөг баатрууд нэгэнтээ хэрэглэж байсан юм.

"За алив. Наадхаа онгойлгооч!" гэж Софи хэлэв.

Ландон уртаар амьсгаа авч, хайрцагны чамин ур хийцийг сонжингоо, тагийг нээхэд, доторх нь илхарагдав. Хүрэн торгоор доторлож эмжсэн, Ландоны хувьд огтхон ч танил бус зүйл хайрцаг дотор байх аж. Өнгөлсөн боржин чулуугаар хийсэн, цилиндр хэлбэртэй энэ зүйл яг л теннисний бөмбөгний сав шиг харагдана. Зүгээр ч нэг тууш цилиндр биш, хэд хэдэн талст хэсгээс бүрдсэн чулуун эд байв.

Боргоцойн дайтай өргөнтэй 6 хэсгээс бүрдсэн, энэ зүйлийг нэлээд хугацаа зарцуулж, бас ур ухаан зарж хийсэн бололтой байв. Цилиндрийн хоёр үзүүрийг битүү боржингоор урлаж, доторх зүйлийг далдлан нуусан байлаа. Шингэн бодис залгасныг бодоход, цилиндр дотроо хөндийтэй гэдгийг Ландон таамаглав.

Түүнээс гадна 6 талст бүр дээр цагаан толгойн үсгүүдийг тойруулан сийлсэн нь, Ландоны анхаарлыг эрхгүй татаж байв.

Ландон багадаа иймэрхүү тоглоомоор янз бүрийн үг бүтээж, тоглодог байснаа санав.

"Гайхалтай биш гэж үү?" хэмээн Софи шивэгнэв.

"Хэлж мэдэхгүй юм. Энэ тэгээд юу юм бэ?"

Софигийн нүд нь гялалзаж, "Өвөө маань үүнийг хийх их дуртай байсан юм. Леонардо Да Винчи үүнийг зохиосон шүү дээ!"

Ландоны гайхсаныг, Софи бүдэг гэрэлд ч тодоос тод харж байв.

"Да Винчи юу?" гээд, Ландон цилиндр лүү дахин харав.

"Тиймээ. Үүнийг криптекс гэдэг юм. Өвөө Да Винчийн нууц тэмдэглэлийн хуулбараас

үүнийг анхолж харсан гэсэн".

"Үүнийг тэгээд юунд ашигладаг юм бэ?"

"Энэ бол авдар. Нууцыг хадгалдаг авдар".

Ландоны нүд орой дээрээ гарав.

Өвөө нь Да Винчийн зохиосон элдэв зүйлийг туршиж хийх дуртай байсан тухай Софи ярьж эхлэв.

Да Винчи өөрийнхөө хэдэн зуун бүтээл, нээлтийг тэмдэглэлдээ зурж, бичиж үлдээсэн юм. ЖакСониехийн хамгийн дуртай байсан зүйлүүд бол түүний зохиосон цаг, усны насос, криптекс бодоод, Францын хөлөг баатрын иж бүрэн өмсгөлийн загвар зэрэг байсан юм. Тэрхүү өмсгөлийн загварыг Сониех өрөөндөө байрлуулсан аж.

1495 онд Да Винчийн бүтээсэн төмөр робот энгийн үйлдэл, тэр дотроо суух, гараа даллах, толгойгоо хөдөлгөх, эрүүгээ ангалзуулах зэргийг хийж чаддаг байсан нь гайхалтай явдал юм. Да Винчийн тэмдэглэлийн дагуу өвөөгийнх нь угсарсан хөлөг баатрын өмсгөлийг Софи хамгийн ихээр бишрэн шагшдаг байжээ.

Гэвч одоо криптекс гараад ирлээ.

"Өвөө үүн шигийг намайг бага байхад хийж өгсөн юм. Гэхдээ ийм чамин хийцтэйг анх удаагаа харж байна" гэж Софи хэлэв.

Ландон хайрцгаас нүд салгалгүй ширтэнгээ, "Би криптекс гэж өмнө нь огт сонсоогүй юм байна" гэв.

Софи үүнд гайхсангүй. Да Винчийн ихэнх нээлтүүд сайтар судлагдаагүй, зарим нь бүр нэрлэгдэж чамжаагүй байдаг юм. Криптекс гэж нэрийг хүртэл өвөө нь өөрөө зохиож өгсөн байж магадгүй бөгөөд, криптологи хэмээх шинжлэх ухаан шинээр хөгжиж байгаа нь, оньсого, ёгт таавар мэтээр бичигдсэн мэдээллийг тайлах гэсэн утгатай үг юм.

Софид хэн ч тэгж хэлээгүй боловч, Да Винчиг криптологийн шинжлэх ухааныг үндэслэгч гэдэгт бүсгүй итгэдэг байв. Софигийн их сургуулийн багш нар криптологийн үндсийг тавьсан хүмүүсийг дурдахдаа, Зиммерман, Шнайер нарыг нэрлэдэг боловч, хэдэн зууны өмнө энэхүү шинжлэх ухааныг үндсийг суулгасан Да Винчийн нэрийг хэлэлгүй өнгөрдөг байсан юм. Харин энэ тухай түүний өвөө нь аль хэдийн түүнд ярьж өгсөн аж.

Хуягласан машин хурдны замаар давхих зуур, криптексийг холын замд зурвас хүргүүлэхэд ашиглах зорилготойгоор анх бүтээгдсэнийг Софи Ландонд тайлбарлаж явав.

Одоогийнх шиг утсан харилцаа, и - мэйл байгаагүй болохоор хэн нэгэнд мэдээ дуулгахын тулд цаасан дээр бичээд, элчээр довтолгодог байж. Гэтэл зарим элч нар түүнийг чухал нууцлалтай гэдгийг мэдчихвэл, өөр бусдад илүү үнэ хүргэж мэдээлдэг явдал ихээр гардаг байж. Үүнээс урьдчилан сэргийлэхийн тулд, үе үеийн суу билигтнүүд олон санаа сэджээ. Жишээ нь: Юлий Цезарь "Цезарийн хайрцаг" гэгчийг бүтээж, Шотландын хатан хаан Мэри урвуулсан цифрашиглан, шоронгоос нууцаар бүлгэмээ удирдаж, Арабын агуу эрдэмтэн Абу Юсуф Исмайл аль - Кинди өөрийн зохиосон цагаан толгойн тусламжтайгаар нууцаа хадгалж чаддаг байжээ.

"Бидэнд нууц үг хэрэгтэй!" гэж үсэг бүхий талст дээр хараа бэлчээнгээ, Софи хэлэв.

Криптексийн зарчим нь дугуйны араатай ижил. Үсгүүдийг зөв дарааллаар байрлуулбал, араанышүднүүд хоорондоо амсаж, талстууд тэр дороо бие биенээсээ сална.

"Энэ криптекст 5 үсэгтэй нууц үг хэрэгтэй!"

"Тэгээд онгойвол дотор нь...?"

"Цилиндрүүд салж онгойход, доторх хөндийд нь хуйлсан цаастай баримт бичиг байх болно".

Ландон үл итгэсэн байдалтай, "Өвөө чинь ийм зүйл өмнө нь чамд хийж өгсөн гэж чи хэлсэн үү?"

"Тийм. Гэхдээ арай жижиг байсан. Миний төрсөн өдрөөр, хоёр ч удаа ийм криптекс бэлэглэхдээ, оньсого дагалдуулж таалгасан юм. Оньсогын хариу нь криптексийг онгойлгох нууц үг байсан. Би оньсогыг тааж, криптексийг онгойлгоход, дотроос нь ил захидал гарч ирж билээ".

Ганц ил захидлын төлөө юун ч олон үйлдэл вэ дээ!"

"Тэгж бүү бодоорой! Ил захидалд бас өөр оньсого бичсэн байдаг байв. Өвөө маань гэрийн бүххэсэгт хэд хэдэн зүйлийг урьдаас бэлтгэн нуучихдаг байсан Оньсогыг таавал, жинхэнэ бэлэгний байгаа газар нь тодорхой болдог байлаа. Гар хөдөлбөл, ам тосодно гэдгийг багад минь ийм аргаарнадад ухааруулсан хүн дээ! Одоо бодоход, мөн ч хэцүү санагддаг байж билээ".

Да Винчийн зохиосон энэхүү криптекс дотор нууц зүйлийг хийсэн л бол, эзнээс нь өөр хүн нууцыг мэдэх боломжгүй. Ландон нууцлаг авдар луу ширтсэн чигээр эргэлзэнэ.

"Тэгвэл үүнийг хагалаад, доторхыг салгаж авч болдоггүй юм уу? Боржин бол зөөлхөн хэврэг чулуушүү дээ!"

Софи инээмсэглэж, "Да Винчи үүнийг ч бас бодолцсон. Тэрээр криптексийг бүтээхдээ хэрэвхагарч, үрэгдвэл доторх мэдээлэл нь устаж үгүй болохоор сэдэж хийсэн байна. Хар даа!" гээд хайрцгийг болгоомжтой өргөөд, "Доторх мэдээллийг папирус цаасан дээр бичиж хийсэн байдаг юм".

"Тостой цаасан дээр биш үү?"

Софи толгой сэгсэрч, "Папирус. Тэр үед тостой цаасан дээр бичдэг байсныг би сайн мэдэх боловч, энэ доторх бол яах аргагүй папирус байх ёстой. Нимгэн болоод хэврэг учраас хамгийн тохиромжтой".

"Ойлголоо".

"Папирус дээр бичсэн мэдээлэл бэлэн болмогц, хуруу шилийг тойруулан цаасыг хуйлаад, криптекс дотор хийдэг юм" гээд Софи криптексийг зөөлөн сэгсэрвэл, шингэн зүйл цалгих дуу гарав. "Шингэн бүхий хуруу шилтэй шингэн бодистой хамт хийчихдэг юм" гэв.

"Ямар бодис вэ?"

Софи хариу инээмсэглэж, "Цуу" гэв.

Ландон түр тээнэгэлзээд, удалгүй ойлголоо. "Ёстой гайхамшиг!!!"

Цуу, папирус хоёрын тухай Софи дотроо эргэцүүлэн бодов. Хэрэв криптексийг эвдлэх гэж оролдовол, доторх хуруу шил хагарч, цуу папирусыг өөртөө уусгаж орхино. Ингээд л

зажилсан цаасшиг зүйл криптексээс үлдэж, нууц ор мөргүй арилна гэсэн үг.

"Чиний харж байгаагаар, үүнийг онгойлгохын тулд, 5 үсэгтэй ганц зөв үгийг оруулах хэрэгтэй. Талст бүр дээрх цагаан толгойн 26 үсэг, 5 талст гэдэг чинь 26 - ийн 5 зэрэгтэй тэнцэх олон хувилбарбайгаа гэсэн үг" гээд түр азнаж байснаа, "Өөрөөр хэлбэл 12 сая орчим хувилбар" гэж хариуг нь гаргав.

Бүсгүйг ингэж хэлэхэд, Ландоны толгойд даруй 12 сая асуулт эргэлдэж байлаа.

"Чи тэгвэл энэ дотор ямар мэдээлэл байгаа гэж бодож байна?"

"Энд ямар ч л байлаа гэсэн, өвөөгийн чандлан нууцалсан зүйл байгаа" гээд хайрцган дээрх таванталт Сарнайн дүрсийг хараад, Софигийн сэтгэл санаа нь үймэрнэ.

"Тийм шүү! Сионий Прайорийн хувьд Грейл, Сарнай хоёр ижил утгатай илэрхийлэгддэг юм".

Софи хөмсгөө зангидаж, "Сонин юмаа! Өвөө надад Сарнай бол нууцыг бэлгэддэг гэж хэлдэгбайсан. Тэр өрөөндөө утсаар ярьж байхдаа, намайг саад бүү болог гэсэндээ хаалганыхаа гаднаСарнай өлгөчихдөг байсан. Намайг ч өөр шигээ тэгж өлгөж болно гэж хэлдэг байлаа. "Хонгорминь, өрөөнийхөө хаалгыг түгжихийн оронд ийм зүйл хийгээд сурчихвал бид бие биенээ хүндэлж,бас итгэдэг болно".

Ингэж сарнай өлгөх нь Ромын үеэс эхлэлтэй аж.

"Sub Rosa, Сарнайн дүрс дор!" гэж Ландон хэлээд, "Ромчууд чухал уулзалт хурлыг найдвартайгэдгийг илтгэлийн тулд, сарнайн дор хурлаа хуралдуулдаг байсан. Хуралд оролцогсод тэндхэлэлцсэн асуудал тэндээ л нууц хэвээр үлдэнэ гэдгийг үүгээр дамжуулан ойлгодог байжээ".

Ландон цааш, "Сионий Прайоричууд, сарнайн дүрсээр нууцыг бэлгэддэг ганц энэ чанарт ч биш,бас өөр шинжид нь үндэслэн, түүнийг Грейлийн бэлгэдлээр сонгож авсан юм. Сарнайн хамгийнанхдагч төрөл болох "Ругоза" сарнай тэгш хэм бүхий 5 талт хэлбэртэй бөгөөд, Сугар гаригийндүрсэлдэг зам шиг хэлбэртэй ижил тул, дарь эх бурхны бэлгэдлийг дотроо давхар агуулдаг юм".

Ландон тайлбараа хийж дуусчхаад, харц нь сонин болчхов.

"Роберт, чи зүгээр үү?"

Түүний нүд Сарнайн хайрцаг дээр тусчээ. "Sub Rosa!" гэж хэлээд царайд нь үл итгэсэн дүр төрхгдорно. "Байж боломгүй юм!"

"Юу тэр вэ?"

Ландон харцаа дээшлүүлж, "Сарнайн дүрс дор (Sub Rosa) энэ криптекс байсан. Тэгэхээр энэ доторюу байгааг би мэдчих шиг боллоо."

Хэсэг 48

Ландон өнөө орой болсон бүх явдлыг санаа бодолдоо нэгтгэн дүгнэх гэж оролдоно. Цилиндрийгүлдээгээд, өөрөө үхсэн эрхлэгч Жак Сониехийн сэдсэн арга ухаан, тааврууд, шигтгэмэл сарнайбүхий модон хайрцаг, энэ бүгдийг эцэст нь дүгнэхэд, нэг л хариулт гарч байлаа.

Бид Онъсон чулууг олжээ!

Энэ тухай домог бол маш сонирхолтой. Онъслогдсон чулууг сарнайн дүрс дор байдаг гэж эхсурвалжид өгүүлдэг.

"Роберт?" гэж Софи дуудаад, "Юу болоо вэ?" гэж гайхан асуув.

Бодлоо төвлөрүүлэхийн тулд, Лондонд хэдэн хором хэрэгтэй байв.

"Өвөө чинь чамд Clef de Voûte гэж зүйлийн талаар дурсаж байсан уу?"

"Авдрыг онгойлгох түлхүүр?" гэж Софи үгийг хөрвүүлэв.

"Үгүй ээ! Наадах чинь үгчилсэн орчуулга байгаа юм. Clef de Voute гэдгийн Voute бол авдар бишхарин таазны хөндий гэдгээр орчуулагдана".

"Гэхдээ таазны хөндийд түлхүүр (Clef) байдаг гэж үү?"

"Үнэндээ бол байдаг юм. Бүх таазанд таазны хавтангуудыг хооронд нь нэгтгэсэн нэгэн оньсонтүлхүүр буюу чулуу байдаг. Түүнийг л түлхүүр гэж хэлээд байгаа юм".

Софигийн нүднээс ойлгож таньсан байдлыг Ландон олж харав. Гэвч Софи мөрөө хавчин, криптексрүү хараад, "Гэхдээ энэ бол оньсон чулуу яавч биш байх!"

Ландон яриагаа хэрхэн эхлэхээ мэдэхгүй хэсэг суув.

Оньсон чулууг анх Мэйсоны ах дүүсийн холбоо нууцаа хадгалахын тулд сэдэ ж нэвтрүүлсэн нь, Мэйсоны арга гэж олонд гайхагдсан юм. Уран барилга, Арк, Оньсон чулуу энэ бүгд хоорондоосалшгүй холбоотой. Оньсон чулууг анх сэдсэн нь Мэйсоныхныг баян чинээлэг болгож чадсан аж. Тэр үед Оньсон чулууг ярихад хүрвэл, нууцын тухай заавал яригддаг болсон байна.

Харин энэ чулуун цилиндр Оньсон чулуунаас арай өөр, түүнтэй холбогдохгүй байлаа. Ландонытөсөөлснөөс Прайрорийн Оньсон чулуу огт өөр байлаа.

"Прайорийн Оньсон чулууны талаар би сайн мэдэхгүй л дээ" гэж Ландон өөрийгөө хүлээнзөвшөөрөв. "Би Ариун Грейлийг эрж хайх чиглэлээр бус, харин тэмдэгтийн чиглэл талаас ньсудалсан".

"Ариун Грейлийг хайх ий?" гэж Софи гайхав.

Ландон толгой дохиж, үгээ цэгнэн болгоомжтой ярьж эхлэв. "Софи чи сонс! Прайорийн амин зүрхболсон, Оньсон чулуу Ариун Грейлийг нуусан газрыг дотроо агуулдаг юм".

Софи учраа олоогүй чигтээ, "Чи үүнийг тэгээд Оньсон чулуу мөн гэж бодож байна уу?" гэжшалгаав.

Ландон юу гэж хариулахаа мэдэхгүй байв.

Гэвч үнэндээ энэ криптекс Оньсон чулуу байж таарах нь гарцаагүй байв. Тэгээд ч С арнайн дүрсдор байсан юм чинь! Сионий Прайорийн тэргүүн байсан, Леонардо Да Винчийн зохиосон энэкриптекс Оньсон чулуунаас өөр зүйл байж таарахгүй. Түүний зохиосон зүйлийн хуулбар зургийгПрайорийн өөр нэг гишүүн хожим олж аваад, криптексийг гараараа урлажээ. Дэндүү ойлгомжтойбиш гэж үү?

Түүхчид сүүлийн 10 жилийн турш Оньсон чулууг Францын сүмүүдээс эрж хайж байсан юм.Грейлийг хайгчид ч мөн адил Оньсон Чулууг уран барилгатай холбон үзэж, түүнийг сүмүүдээс эржхайсаар байсан аж.

Сарнайн дүрс дор гэж үзвэл сүмд сарнайн дүрс ороогүй газар гэж ховор байдаг. Сарнайн дүрстцонх, Сарнайн дүрст хээ угалз гэх мэт. Гэвч энэ бүхэн хэтэрхий хялбар санагдахаар байдаг байв.

"Энэ криптекс Онъсон чулуу байж таарахгүй!" гэж Софи хэлээд, "Энэ тийм ч эртний эд шигхарагдахгүй байна. Бодвол өвөө минь үүнийг өөрөө хийсэн байх ёстой. Энэ ерөөсөө Грейлтэйхолбоогүй гэж би бодож байна" гэв.

"Гэвч үнэндээ Сионий Прайорийнхан Оньсон чулууг 20 жилийн өмнө сэдсэн гэж ихэнх судлаачидүздэг" гэж Ландон хэлэхдээ, нүдэнд нь баярын оч гялтганана.

Софи чихэндээ итгэсэнгүй. "Энэ криптекс хэрэв Ариун Грейлийн байгаа газрыг нууцалж байгааюм бол өвөө надад ямар учраас үүнийг үлдээсэн юм бол? Би үүнийг яаж онгойлгох, юу хийхээсайн мэдэхгүй шүү дээ! Ариун Грейлийн талаар бүр юу ч сонсоогүй юм чинь!"

Софигийн хэлсэн зөв гэдэгт Ландон итгэнэ. Бүсгүйд Ариун Грейлийн тухай чин үнэнийг ярих тэрмөчийг Ландон түр хүлээхээр шийдлээ.

Тэр хоёрын аль аль нь Оньсон чулууг ажиглаж байлаа.

Доор нь эргэлдэх машины хөдөлгүүрийн дуунаас давахыг оролдон, Ландон Софид Оньсончулууны талаар мэдэх бүхнээ хашхирах шахам чангаар ярина. Прайорийн нууц болсон АриунГрейлийг хаана байсныг олон зууны турш хэн ч бичиж үлдээсэнгүй. Харин өнгөрсөн зуундПрайорийн баримтлах бодлого чиглэл нь өөрчлөгдсөн гэх яриа олны чихэнд цуу үг болон таржээ.Магадгүй чагнах төхөөрөмжийн дээд зэргийн хөгжил тэдэнд нэгийг бодуулж, Прайоричууд нуусангазрынхаа талаар нэг ч үг хоорондоо солилцохоо больсон байх ёстой. "Тийм бол нууцаа яаждамжуулах юм бэ?" гэж Софи асуув.

"Прайорийн бүлэглэлийн удирдлагын дөрвөн гишүүний нэг нь нас барахад, үлдсэн гурав нь доодшатны хүмүүсээс нэг гишүүнийг сонгон шалгаруулдаг. Шинэ гишүүнд Грейлийн нуусан газрыгхэлэхээс өмнө, олон шалгуур тавьж сорьдог шиг байгаа юм".

Софи яриан дундуур бодолдоо дарагдан сууна. Ландоны ярьсан зүйл өвөөгийнх нь ач охиноо нуужхадгалсан зүйл олуулахаар туршдаг байсан, өвөөгийнх нь тухай дурсамжийг гэнэт сэргээжээ.

Яг л намайг туршдаг шиг хэмээн Софи бодно.

Мэйсоны шалгуур ч мөн үүнтэй л ижил. Итгэл хүлээх хүнийг сорьж, туршсаар, шат ахих тусамулам хэцүү сорилт тулгаж, эцэст нь дээд удирдлагад хүрэхэд, 32 шат дамждаг нь, Мэйсоны шатлалгэж нэрлэгджээ.

"Өөрөөр хэлбэл, шинээр сонгогдсон дээд удирдлагын гишүүн Оньсон чулууг онгойлгож чадвал,нууцыг хадгалах эрхтэй болно гэсэн үг үү?"

Ландон толгой дохиж, "Би чамайг энэ талаар туршлагатай гэдгийг мартжээ" гэв.

"Ганц өвөө ч биш, криптологийн шинжлэх ухаанд үүнийг "өөрөө суралцах хэл" гэж нэрлэдэг юм.Хэрэв чи уншиж чадаж байгаа бол, доторх утга агуулгыг аяндаа өөрөө ойлгоно гэсэн зарчим юм уудаа".

Ландон түр эргэлзсэнээ, "Софи! Хэрвээ энэ криптекс Оньсон чулуу мөн байгаад, өвөө чинь үүнийгчамд үлдээсэн юм бол, тэр лав Сионий Прайорид нөлөөтэй хүн байсан байж таарна. Бараг лтэргүүн нь байсан байх" гэв.

Софи шүүрс алдаад, "Өвөө нууц бүлэглэлд нөлөөтэй хүн байсныг, би мэдэж байна. Харин тэр нууцбүлэглэл нь Сионий Прайори болж таарлаа".

Ландон улам лавшруулж, "Чи түүний нууц бүлэглэлд байсныг мэддэг байсан юм уу?"

"10- аад жилийн өмнө би харах ёсгүй нэг зүйлийг харчихсан юм.

Тэрнээс хойш би өвөөтэй ер уулзаагүй. Гэхдээ манай өвөө тэргүүлэгч байсан гэдэгт би итгэдэг".

Ландоны нүд нь бүлтрэх шахан томорч, "Тэргүүн гэнэ ээ? Гэхдээ үүнийг чи мэдэх боломжгүй шүүдээ!"

Софигийн сэтгэл эмзэглэх тул, "Би цааш нь яримааргүй байна" гээд харцаа буруулчлав.

Ландон чимээгүй болов. Жак Сониех Сионий Прайорийн тэргүүн?!

Энэ бүлэглэлийн өмнөх тэргүүнүүдийн тухай бичигдсэн "Les Dos -siers"- н нууц хэмээх баримтсаяхан олонд ил болсныг үзвэл, Сионий Прайорийн ихэнх гишүүд урлагийн суутнууд байсан аж.

Прайорийг судалдаг түүхчид болон хорхойтнууд бүгд л энэ баримтыг уншсан байх ёстой. Баримтад бичигдсэн гишүүдийн нэрс түүнийг уншсан, хэн бүхний анхаарлыг зүй ёсоор татдаг юм. Үүнд: Леонардо Да Винчи, Ботичелли, И.Ньютон, Виктор Гюго, тэгээд хамгийн сүүлд Францыналдарт зураач Коктү.

Жак Сониехийн нэр Энд яагаад байж болохгүй гэж? Гэхдээ яагаад Жак Сониех өнөөдөр надтайуулзхаар товлосон юм бол? Зөвхөн урлагийн талаар ярихын тулд гэж үү?

Хэрэв Ландон зөн совиндоо итгэх юм бол, Сионий Прайорийн тэргүүн Онъсон чулууг ач охиндооүлдээгээд, Роберт Ландоныг олохыг бүсгүйд даалгасан болж таарахаар байв.

Гэхдээ л ойлгомжгүй юм.

Сониехийн хийсэн үйлдэлд Ландон ямар нэгэн тайлбар хийж үнэндээ чадахгүй байв. Хэдийгээр тэрүхлээс айн балмагдсан байж болох ч, тэргүүлэгч 3 гишүүн нь үлдсэн байхад, энэ их эрсдэлийгсөрөн байж, ач охиндоо Онъсон чулууг яагаад үлдээсэн юм бол? Түүнээс гадна огт хөндлөнгийнхүн Роберт Ландоныг Энд оролцуулаад? Яах аргагүй нэг зүйл дутуу байна даа! гэж Ландон дотроободов.

Энэ бүхэнд хариу олохын тулд жаахан азнаж, хүлээх хэрэгтэй. Машины хөдөлгүүр удаашрах чимээсонсогдоход, тэд дээш өндийв. Машины дугуй хайрган дээр явах нь мэдрэгдэж, ачааны бүхээгдэржигнэнэ.

Энэ хуртэл явж яах гэж байгаа юм бол? Вехне биднийг аюулгүй газарт аваачина гэсэн биз дээ!

Эцэст нь машин бараг мөлхсөөр нэг юм зогсов. Тэр хоёр бие бие рүүгээ харж, түргэн гэгчхайрцгийг онгойлгон, криптексийг дотор нь хийгээд, Ландоны хүрмээр гадуур нь ороов.

Хаалга аажмаар онгойход, замаас зайдуу нэгэн модтой газар ирснээ, тэд сая л мэдэв. Вехне гартаабуу барьчихсан, нүдээ цавчилгүй тэднийг ширтэнэ.

“Намайг уучлаарай! Өөр арга надад байсангүй”.

Хэсэг 49

Ландоны бодож байгаагаар бол гартаа буу барьсан банкны захирал Вехне юунаас ч буцахааргүйтөрхтэй болжээ.

"Би шаардахаас өөр аргагүй юм шиг байна" гээд тэр нөгөө хоёр луу буугаа ээлжлэн чиглүүлж, "Хайрцгийг доош тавь!" гэж тушаав, Софи хайрцгийг цээжиндээ шахан наажээ.

"Өвөө та хоёрнайзууд байсан биз дээ?"

"Би өвөөгийн чинь эд зүйлийг хамгаалах үүрэгтэй. Түүнийгээ л хийж байна. Одоо хайрцгийг доошгавь!"

"Өвөө үүнийг зөвхөн надад гэрээсэлсэн юм шүү!" гэж Софи шазуур зуун хэлэв.

"Тавь!" гэж хэлээд, Вехне буугаа бүсгүй рүү чиглүүлэв.

Софи хайрцгийг хөлийнхөө дэргэд, доош алгуур тавилаа.

Бууны ам Ландон руу чиглэж, "Ноён Ландон!" гэж Вехне дуугараад, "Та хайрцгийг надад авчир. Болгоомжтой л байгаарай! Би буудахаас ер айхгүй шүү!"

Ландон үл итгэсэн харцаар Вехнег харж, "Та яагаад ингэж байгаа юм бэ?"

"Харин та намайг яана гэж бодоо вэ? Би үйлчлүүлэгчийнхээ эд зүйлийг хамгаалж байна".

"Бид ч таны үйлчлүүлэгч шүү дээ!" гэж Софи эрс шийдмэг хэлэв.

Вехнегийн хүүхэн хараа нь томроод, төрөл арилжсан юм шиг болжээ.

"Хатагтай Нөвү, Та түлхүүрийг хэрхэн олсон, дансны дугаарыг яаж мэдсэнийг, би төсөөлөх ч үгүй байна. Гэхдээ энд шударга биш үйлдэл шургалсан гэдгийг би мэдэж байгаа. Би хийсэн хэргүүдийнчинь талаар өмнө нь сонссон бол, та хоёрт тусалж, банкнаас орлуулахгүй байх байсан юм".

"Би танд өвөөгийн үхэлтэй бид ямар ч холбоогүй гэж хэлсэн шүү дээ!"

Вехне Ландон руу хандаж, "Та хоёрыг зөвхөн Жак Сониехийн ч биш, бас дахиад 3 хүний үхэлтэй холбон сэжиглэж байгаа гэж радиогоор зарласан".

"Юу гэнэ ээ!" гэж хэлээд, Ландоны толгойд цахилгаан цахих шиг болов.

Дахиад 3 хүн амины хэрэг!

Үхлийн тоо түүнд ганц л зүйлийг санагдуулна.

Тэргүүлэгч 3 гишүүн. Ийм зүйл байж болохгүй!

Ландоны нүд хайрцаг дээр тусав.

Хэрэв 3 гишүүн бүгд алагдсан юм бол, Сониехт өөр арга үлдээгүй юм байна. Өөр хэн нэгэнд Онъсончулууг дамжуулан өвлүүлэхээс өөр аргагүй байжээ!

"Би та хоёрыг цагдаа нарт тушаасан хойно, тэд юу хийхээ өөрсдөө мэдэх биз. Харин би гэж нэг хүнбанкны нэр төрийг дэмий юманд хутгачихлаа".

Софи Вехне рүү ширтэж, "Та биднийг буцааж авч явахгүй! Учир нь авч явах байсан бол, замындундаас эргэж, цагдаагийнхан дээр очих байсан. Харин тэгэхийн оронд, биднийг буугаар сүрдүүлж байгаа чинь ямар учиртай юм бэ, хэлээч?"

"Өвөө чинь хайрцагтай зүйлийг найдвартай хадгалахыг надад захисан. Энэ хайрцаг ямар боловч, цагдаа нарын хувьд эд мөрийн баримт болохыг би хүсэхгүй байна. Ландон! Наад хайрцгаа надавчир!"

Софи эсэргүүцэж, "Битгий өг!"

Бууны нүргэлэх чимээ чих дөжрүүлж, исгэрэн гарсан сум ачааны бүхээгийн таазанд тусав. Тэрмөчид ачааны машин доргихтой зэрэгцэн, сумны хонгио шалан дээр уналаа.

Чөтгөр ав гэж! Ландон хөшчихөв.

Вехне сая л итгэлтэй дуугарч, "Ноён Ландон, хайрцгийг ав!"

Ландон хайрцгийг авч өргөөд, байрандаа зогсов.

"Над руу одоо аваад ир!"

Ландон хайрцгийг тэвэрсээр, онгорхой хаалга руу дөхөв.

Ямар нэг зүйл хийх ёстой! гэж Ландонд бодогдоно. Прайорийн Онъсон чулууг хамар доороосоохарсаар байгаад алдах гэж үү!

Тэр машины бүхээгт зогсож байгаа учир, Вехнегээс давуу байрлалтайгаа мэдэрлээ. Харамсалтай ньтүүний санааг гадарласан бололтой, Вехне хойш ухраад, 6 фут орчим зайд холдов.

Амжиж хөдлөхөд хэтэрхий хол зай.

"Хайрцгийг хаалганы дэргэд тавь!" гэж Вехне дахин тушаав.

Ландон өөр аргагүй тул, доош тонгойж, хайрцгийг онгорхой хаалганы дэргэд тавилаа.

"Одоо бос!"

Ландон алгуурхан босохдоо, хөл доор нь Сумны хонгио хэвтэж байхыг анзаарав.

"Хойшоо ухар!"

Ландон түр азнаж, хонгиог улаараа алгуур өнхрүүлэн, хойш ухрахдаа, хаалганы нугасанд ойр байхүүдний ховил руу эвтэйхэн түлхчэв. Ингэснийхээ дараа хойш ухарч зогслоо.

"Анх байсан хана дагуу очиж, цаашаа харж зогс!"

Ландон үгэнд нь орж, ёсоор болгов.

Вехнегийн зүрх түг түг цохилж, сэтгэл догдлолоо дарж ядна. Бар уун гартаа буугаа барьж, зүүнгараа хайрцаг руу сунгана. Хайрцаг нэг гарт хэтэрхий хүнддээд байсан тул, Вехне хоёр гараарааөргөхөөс аргагүй болов. Нөгөө хоёрыг нүд салгалгүй ширтэнгээ, Вехне гарах эрсдэлийг тооцов. Тэр хоёрын аль аль нь түүнээс 15 футын зайтай зогсох учир, Вехне зориг шулуудан, буугаамашины хойд буфер дээр тавиад, хайрцгийг хоёр гараараа өргөж, газар тавингуугаа, буугаа шалмагтэгч шүүрэн авав.

Сэжигтнүүд тэр хооронд огтхон ч хөдөлсөнгүй. Одоо зөвхөн хаалгыг хаагаад, түгжих л үлдлээ. Хаалганы үзүүрийг түлхэж, чагт түгжээнээс бариад хаах гэсэн боловч болсонгүй. Нэг юмандтээглээд байгаа бололтой гацаад байв.

Юу болчхов?

Вехне дахин түлхсэн ч хаагдсангүй. Дутуу л хаагдаад байгаа бололтой. Вехне хүчтэй мөрлөхөөрзэхэн, зай аваад зогсож байтал, хаалга дотроосоо хүчтэй савагдан, түүний нүүрэнд цохив. Тэр хойшүсрэн газарт уналаа. Түүний хамар нь хугарсан бололтой, тэсэхийн аргагүй өвдөж, барьж байсанбуу нь хол шидэгдээд, хамрыг нь даган бүлээн цус урсахыг мэдрэв.

Роберт Ландон хаалга түлхсэн хүчиндээ доош газар унасан ч, Вехне түүний олж харж чадсангүй. Вехнегийн нүд бүрэлзэж, босох гэсэн боловч хойш хэвтэв. Софи Нөвү энэ мөчид хашхирч байв.

Хормын дараа Вехнегийн ухаан балартахыг тэр өөрөө мэдрэв. Хайрга шажигнуулан холдохдугуйны чимээ түүнд сонсогдоход, тэр өндийх гээд чадсангүй. Машин эргэх гэж байгаад хамраараамод мөргөж, мөргөсөн мод нь хугарч унав.

Урд гупер нь нэг талаараа санжиж, чирэгдэн байлаа. Машин засмал замд орж, хурдаа авахад, санжсан гупер замтай харшин оч үсэргэн байх ажээ.

Тэнд Вехне орь ганцаараа хоцорлоо.

Хайрцгийг алдчихлаа!

Хэсэг 50

Альпын нурууны салбар уулсын хөндийг дагасан замаар Фиат маркийн машин КастелГандольфогоос гарч, хурдлан давхина. Машины арын суудалд тухалсан, хамба лам Арингароза авчяваа цүнхнийхээ хүндийг байн байн хэмжихэд, Багш, тэр хоёрын хамтын шаргуу зүтгэл эрхгүй бодогдоно.

20 сая евро!

Энэ хэмжээний мөнгөтэй харьцуулшгүй үнэ цэнэтэй зүйлийг Арингароза өөрийн болгохоор сэтгэлшулуудсан билээ. Ром руу буцаж явах замын турш, Багш түүн рүү залгаагүйд, Арингароза ихэдгайхна. Кассокныхоо халааснаас гар утсаа гаргаж, сүлжээг нь шалгав. Сүлжээ нь уначихсан байв.

"Энэ хавьд сүлжээ дандаа унадаг юм" гэж жолооч арын толиндоо Арингарозаг харангаа хэлээд, "5 минутын дараа биднийг уулын бүсээс гарахад, сүлжээ орж ирнэ байх" гэлээ.

"Баярлалаа!" гэж хэлээд, Арингароза ийн бодов. Ууланд сүлжээ барьдаггүй байх нь ээ? Энэхооронд Багш над руу залгасан байх даа!

Арингароза утасныхаа дуут шууданг шалгаж үзэв.

Зурвас бас л алга. Багш болсон хойно, түүнд дуут шуудан үлдээхгүй л дээ.

Угаасаа Багш энэ тал дээр тэрээр маш хянуур ханддаг хүн. Утсаар нээлттэй ярихын, аюулэрсдэлийг түүнээс өөр хүн ингэж их ойлгодоггүй болов уу! Учир нь тэр хүмүүсийн энэ сул талыг ашиглан, мэдээллийн эх сурвалжаа олж авдаг "Их Багш" юм чинь.

Багш Арингарозад өөртэй нь холбогдохыг үл зөвшөөрч, зөвхөн өөрөө л түүн рүү залгая хэмээн хэлжээ. "утсаа өөртөө ойрхон байлга!" гэж бас түүнд захисан юм.

Гэтэл одоо Арингарозагийн утас нь горимдоо ажиллахгүй байх хооронд, багш дахин дахин залгасан байх болов уу? гэхээс түүний яс хавталзана.

Багш ямар нэг зүйлийг буруугаар эргэлээ гэж бодвол яах вэ? Эсвэл намайг бондыг авч чадаагүй юм байна гэж бодвол яах вэ?

Хамбын хүйтэн хөлс урсана.

Хамгийн муухай нь намайг мөнгөө аваад, мөр буруулан зугтсан гэж бодвол яана.

60 милийн хурдтай явах, хуягт машины урд гупер санжиж, үзүүр нь замаар шүргэхдээ, түмэн очүсэргэн ойр хавийг гэрэлтүүлэн алдана.

Бид замаас гарах хэрэгтэй! гэж Ландон бодлоо.

Тэрээр аль зүг чиглэн яваагаа ч сайн мэдэхгүй байв. Машины асч буй нэг талын гэрэл ньховилоосоо ховхроод, урдах замаа гэрэлтүүлэхээсээ илүү хажуу дахь ойн мод руу туссаар явах аж.

Софи энэ бүхнийг үл анзааран, анхаарал нь зөвхөн түүний өвөр дээрх хайрцаг дээр төвлөрчээ.

"Чи зүгээр үү?"

Софи дагжин чичирнэ. "Чи Вехнегийн үгэнд итгэсэн үү?" гэж Софи хариуд нь арай ядан асуув.

"3 хүний үхлийн тухайд уу? Тийм ээ, итгэсэн. Танай өвөө бидэнд Онъсон чулууг дамжуулж, Фаашбидний араас мөр даран хөөцөлдөж байгаа зэрэг нь үүнтэй л холбоотой!"

"Үгүй ээ, түүний банкаа аварна гэсэн үгэнд итгэж байна уу?"

"Өөр яана гэж?"

"Онъсон чулууг өөрийн болгох гэж байсан юм биш үү?"

Ландон энэ тухай огт бодож амжаагүй юм. "Гэхдээ хайрцганд юу байсныг тэр мэдэхгүй байсаншүү дээ".

"Хайрцгийг банканд хадгалж байсан. Тэр өвөөг таньдаг байсан. Тийм болохоор Грейлийг өөрийнболгохоор эцэст нь шийдсэн ч юм билүү?!"

Ландон Вехнег тэгж огт бодохгүй байгаа тул, толгой сэгсэрч "Миний мэдэхээр, Грейлийг хоёр лшалтгааны улмаас хүмүүс хайдаг. Эхнийх нь болох сониуч зантай хүмүүс эртний түүхт "Христийнаягыг" эрж байна хэмээн өөрсдийгөө боддог. Харин үлдсэн хэсэг нь, жинхэнэ үнэн илрэхээс айж,эмээдэг учир, олон зууны турш хайж ирсэн. Маш олон үеийн турш, Грейлийг хайж одоо л, устгаххүсэлтэй хүмүүс дийлэнх нь байсан юм".

Тэд яриагаа түр завсарлахад, урд гуферын чирэгдэх чимээ тасралтгүй сонсогдоно. Ландон урдцонхоороо дээш өндийж харвал, оч хангалттай их цайрах тул, өөр машин зөрж өнгөрвөл, анхааралтатах аюултайг анзаарлаа.

"Би зогсож, энэ гуферыг засаадхая!" гэж Ландон хэлээд, машинаа зогсоов.

Эргэн тойрон нам гүм болох нь тэр. Ландон гарч, машины урдуур тойрон доош тонгойн хартал,сэрүүн салхинд гэнэт цохиулсан тул ухаан нь хэсэгтээ балартав. Хүн амины хэрэгт сэжиглэгдэнхөөгдөж байгаагийн зэрэгцээ, түүнд бас хариуцлага ногдож буйг тэр ойлгов.

Олон зуун жилийн турш хүн төрөлхтний их өв болсон тэрхүү нууцыг хадгалж буй, бүсгүй хүнийгхамгаалах үүрэг түүнд оногджээ. Энэ тийм хүндрэлтэй биш боловч, Прайорийн бүлэглэл одоонэгэнт нуран унасан учир, Онъсон чулууг хэнд буцааж өгөх вэ гэдэг хамгийн хачирхалтай зүй лбайлаа. 3 хүний үхэл дахин илэрсэн нь байдлыг улам ч хурцатгана.

Прайори ямар нэг байдлаар илэрчхэж! Тэд ам тангараг өргөсөн хүмүүс тул, гуравдагч этгээдийнхараанд орсон байх. Эсвэл мэдээлэгч “харх” бүлэглэлд шургалсан байж. Тиймээс чулууг бүлэглэлдэргүүлэн өгч болохгүй!

Прайорийн аль нэг гишүүнийг олох аргыг Ландон сэдэж болох ч, чулууг эргүүлэн авахаар иржбайгаа хүн бол тэдний дайсан байх бодно. Энэ мөчид ганц үнэн зүйл бол Софи, Ландон хоёртОнyson чулуу байгаа явдал байв.

Ландоны төсөөлснөөс машины урд хэсэг нэлээд хэцүү байдалтай болжээ. Зүүн талын гэрэл нь бүрмөсөн хагараад, баруун талынх нь ховилоосоо мултарч гараад, утаснаасаа унжсан харагдана.

Ганц сайн зүйл бол гупер машины их биеэс бүр мөсөн унахад бэлэн болчихсон байв. Ландонтүүнийг хүчтэй өшиглөж, унагахыг оролдов. Тэрээр тасралтгүй, нэг хэмээр гуперийн төмрийгөшиглөж байхдаа, Софигийн ярьсныг нэхэн санав.

"Өвөө надад утсаар зурвас үлдээсэн байсан. Гэр бүлийнхний маань талаар жинхэнэ үнэнийг хэльегэж байсан. Тэр үед нь би анзаараагүй ч, одоо бодоход Сионий Прайоритой холбоотой байж!"

Гупер дуу чимээтэй доош унахад, Ландон амьсгаагаа даран хэсэг харж зогсов. Түүнийг одоо хуягтмашин гэж нэрлэхэд хэцүү болжээ. Ландон гуперийг шүүрч аваад, замаас холдуулан чирч хаяхдаа, цааш хэрхэх тухайгаа бодож байв.

Криптексийг хэрхэн онгойлгохоо тэр мэдэхгүй байв. Харамсалтай нь зөвхөн энэ асуултын хариуголсон цагт, тэд цааш юу хийхээ сайтар эргэцүүлж болохсон.

Бидэнд тусламж хэрэгтэй. Зүгээр ч нэг тусламж биш, мэргээжлийнх шүү!

Энэ дэлхий дээр Ариун Грейл болон, Сионий Прайорын талаар туслах ганцхан хүний нэр түүнийсанаанд орж ирнэ. Гэхдээ эхлээд Софитой энэ талаар зөвлөе гэж бодлоо.

Машины урд бүхээгт суусан Софи Ландоныг хүлээнгээ, өвөр дээр нь буй модон хайрцгийг харжэгдүү нь хүрнэ.

Өвөө надад үүнийг яана гэж үлдээгээ вэ? Би үүгээр хэрхэхийг ч мэдэхгүй юм чинь!

Сайн тунгааж бод, Софи! Тархиа ажиллуул! Өвөө чинь чамд ямар нэг зүйл хэлэхийг хүссэн байна!

Бүсгүй хайрцгийг нээж, криптексийн талстыг ажиглалаа. Өвөөгийнх нь урласан зүйл түүний гартбайна.

Онyson чулуу бол нууцад хөтлөх газрын зураг юм шүү! Өвөөд чинь хүргэх тэр гэгээн зам! гэж хэннэг нь хэлэх шиг болов.

Софи криптексийг хайрцгаас гаргаж, талстуудыг хуруугаараа тэмтрэв.

5 үсэгтэй үг.

Талстуудыг алгуур эргүүлэхэд, тэд маш зөөлнөөр хөдөлнө. Софи 5 үсэгтэй үг эвлүүлэв. Гэвч энэбол огт санаандгүй үг байв.

C-R-A-I-L

Үзүүр дэх 2 тагнаас зөөлхөн татаж үзсэн боловч, талстууд бие биенээсээ салсангүй.

Харин доторхцуу нь цалгихад, тэрээр чангаахаа болив. Дахиад өөр үг эвлүүлээ.

V-I-N-C-I

Болсонгүй.

V-O-U-T-E

Бас л хэвээрээ. Криптекс онгойсонгүй.

Софи хөмсгөө зангидаад, криптексийг хайрцагт нь буцааж хийв. Урд цонхны шилэнд тусах Ландоны царайг харахдаа, тэр учиргүй баярлан уужрав. Учир нь тэр энэ мөчид ганцаараа бус, Ландонтой хамт байлаа.

P.S. find Robert Langdon! (Жич: Роберт Ландоныг ол!)

Өвөө энэ бүхэнд яагаад Ландоныг оролцуулсныг тэр сая л ойлгов. Софи өвөөгийнхөө сонирхожсудалдаг зүйлийг ойлгодоггүй байсан болохоор, Ландоныг түүнд туслуулахаар эхнээс нь бодсон нь тэр байж. Гэвч Ландон бүсгүйд туслахаас гадна, ахмад Фаашийн онилсон бай нь болчхоод байгаабилээ.

Грейлийн хэрэг яаж ч эргэсэн бай, Софид муу юм бүү болоосой! гэж Ландон жолооны ардэргэцүүлэн суух аж.

Ландон хөдөлгүүрээ асаагаад, хөдөлтөл машин өмнөхөөсөө хамаагүй эвтэйхэн болсон байв.

"Чи Версаль руу яаж хүрэхийг мэдэх үү?" Софи гайхаж, "Зугаалах нь уу?"

"Үгүй дээ. Надад нэг танил бий. Шашны түүхийг судалдаг юм. Версаль хавьцаа амьдардаг. Яг сайн санахгүй байгаа ч, гэрийг нь олж болох байх. Би түүний эдлэнд хэд хэдэн удаа очиж байсан юм. Нэрийг нь Лей Тийбин гэдэг. Английн алдарт түүхч цолтой хүн".

"Тэр энд Парист амьдардаг юм уу?"

"Тийбин бол Грейлийн төлөө төрсөн хүн. 15 жилийн өмнө Прайорийн талаар чих дэлсэхэд л, энд Францад нүүж ирээд, эндхийн сүмүүдээр хэрэн хэсэх болсон. Тэр Грейл болон Онъсон чулуутай холбоотой хэд хэдэн ном бичсэн. Тийм болохоор бидэнд тусалж юуны магад". Софи хаширлаж, "Чи түүнд итгэж байгаа юм уу?"

"Юунд итгэх гэж? Криптекс доторх баримтыг хулгайлахгүй гэдэгт үү?"

"Үгүй ээ. Биднийг цагдаа нарт мэдээлбэл яах вэ?"

"Хоёулаа түүнд биднийг мөрдөж байгаа тухай хэлэхгүй байх болно. Бидний асуудал шийдэгдтэл, тэр биднийг

"Роберт, бидний гэрэл зургийг одоо бүх сувгаар цацаж байгаа! Фааш хэвлэл мэдээллийнхнийгөөрийнхөө талд ажиллуулж чаддаг хүн. Бид хоёрыг харсан хэн бүхэн танихын тулд, тэр бүхнийг хийж байгаа!"

Аймшигтай юм! Францын телевизээр гарах миний төрх "Эрэн сурвалжилж байна" гэсэн гарчигтай болчих ч гэж дээ! За яахав, ядаж намайг зурагтаар гарсанд, номын маань борлуулалт нэмэгдэнэгээд Жонас Фокман баяр хөөр болж байгаа байлгүй. "Тэр итгэж болох хүн үү?" гэж Софи шалгаав.

Ландон Тийбинийг ийм оройн цагаар зурагт үзээд сууж байхгүй гэж бодовч,
нөгөөтээгүүр бас энэбодолдоо эргэлзэж байв. Тэрээр зөн совингоороо Тийбинд итгэж болох
юм шиг санагдана. Нөхцөлбайдлыг үзэхэд, Тийбин тэдэнд боломжоороо туслахаар юм шиг
бодогдоно. Тийбин хэдийгээр

Ландонд сэтгэлээрээ өргүй ч гэсэн, нэгд Грейл судлаач, хоёрт, Софигийн өвөө Сионий Прайорийнтэргүүн байсан гэдэг хоёр том шалтгаанаар тусалж болох юм.

Хэрэв Софигийн талаар үнэнийг дуулчихвал, Тийбиний шүлс нь асгараад, ямар хариу барих бол?

"Тийбинийг итгэлтэй хүн гэж ойлгож болно. Гэхдээ чамайг юу гэж ярихаас их зүйл шалтгаална".

Софи харанхуй татах зам руу харсаар, "Бид түүн дээр очлоо гэж бодоход, чи түүнд хэр их зүйлярих вэ?"

Ландон хайхрамжгүй байдлаар, "Надад итгээрэй! Тэр бол Леонардо Да Винчи, Ариун Грейл, Сионий Прайорийн талаар хэнээс ч илүү мэдэх хүн гэж би чамд хэлээд байна шүү дээ!"

"Манай өвөөгөөс ч илүү ихийг үү?"

"Би Прайорийн бүлэглэлийн хүрээнээс гадуур ярьж байна".

"Чи Тийбинийг Прайорийн гишүүн биш гэдэгт итгэлтэй байна уу?"

"Тийбин Ариун Грейлийн үнэн түүхийг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр ярихадамьдралынхаа талыг зориулсан. Харин Сионий Прайорийн хувьд Грейлийг нуух нь тэднийзорилго". "Сонирхлын зөрчил шиг сонсогдож байна!"

Ландон түүний санааг ойлгов. "Бид Тийбинийд очсон хойноо, Оньсон чулууны талаар шуудярихгүй. Бүр ярихгүй ч байж болно. Харин түүний гэр бидэнд орогнож нуугдаад, бүгдийггэргэцүүлэхэд яг тохирох газар байх болно. Магадгүй Грейлийн талаар яриа өрнөхөд, өвөө чиньОньсон чулууг яагаад чамд үлдээсэн учир нь гарч ирэх ч юм бил үү!"

"Бидэнд үлдээсэн гээч" гэж Софи залруулав.

Ландон тэр мөчид маш баярлаж, Сониех түүнийг яагаад энэ бүхэнд оролцуулсан тухайд гай хажбайв.

"Чи Тийбиний гэрийг тодорхой санахгүй байна уу?"

"Түүний эдлэнг Шатү Виллет гэдэг шиг санаж байна. Тиймээ. Яг тийм нэртэй байсан".

"Тэгвэл сайхаан!"

"Чи хаана байдгийг нь мэддэг юм уу?"

"Би тэнд очиж байсан. Тэр чинь шилтгээн дүүрэгт байдаг юм. Эндээс 20 - иод миль яваад хүрэхгазар".

Ландон хөмсөг зангидан, "Тийм хол гэж үү?"

"Харин тиймээ. Ариун Грейлийн тухай надад ярьж өгөхөд яг тохирох хугацаа".

Ландон гацаж, "Би чамд Тийбинийд очсон хойно ярьж өгье".

"Тийбин бидний тухай Фаашид мэдээлэх юм бол, түүнийг их шан харамж хүлээж байгаа даа!"

Ландож инээж, "Надад итгээрэй, түүнд хэрэгцээтэй зүйлсийг жагсаавал, хамгийн сүүлд нь мөнгөбичигдэнэ".

Тийбин бол Английн хамгийн анхны тайж болох Ланкастрын үр хойч бөгөөд, өвөг эцгээсээхөрөнгийг нь өвлөн авсан юм. Парисаас гадна өөр нэг эдлэн газар нь 17 - р зууны үеийнх бөгөөд 2нуур бүхий эдлэн дэх шилтгээн байшинтай ажээ.

Ландон хэдэн жилийн өмнө BBC телевизийн шугамаар Тийбинтэй анх танилцаж байсан юм.Тийбин Ариун Грейлийн талаар хүмүүсийн нүдийг бүлтийлгэж, чихийг дэлдийлгэм түүхийгөгүүлсэн баримтат кино хийх саналыг BBC - д дэвшүүлж, тэдэнд ханджээ.

BBC - ийн найруулагчид Тийбины хурц сэдвийг дор нь өлгөн авч, цааш судалсан боловч, сэтгүүлзүйн нэр хүндэд нь сөргөөр нөлөөлж магадгүй юм гэж үзээд сүүлд нь татгалзсан байна. ГэвчТийбин бууж өгөлгүй, дахин санал дэвшүүлж, энэ талаар гүнзгийрүүлэн судалсан хамгийнналдартай 3 түүх судлаачийг нэвтрүүлэгтээ урьж оролцуулах тухай яриаг хөнджээ. Тэр 3судлаачийн нэг нь Ландон байсан юм.

BBC - ийн зардлаар Ландон Тийбиний эдлэн рүү нисч очоод, зураг авалтад орсон байна. ТэрТийбиний урлангийн ороонд тухалж байгаад, түүнийг Ариун Грейлийн түүхийн талаарх сэжигэргэлзээ, олон жилийн судалгааны дараа гарч ирсэн түүхийн үнэн мөнийг дэлгэрэнгүй тайлбарлаж,баримтат кинонд оролцжээ. Эцэст нь Ландон өөрийн судалгааны чиглэлээр Тийбиний нотолгооггүнзгийрүүлэн баталсан аж. Энэ баримтат кино Англид цацагдахад, алдартай судлаачдын баталгаанотолгоо тус болсонгүй. Харин Христийн номлолыг гутаан доромжилсон гэх олон нийтийн сөрөгхандлага ихээр гарсан байна. Америкт энэхүү баримтат киног огт гаргаагүй боловч, Их Британийнарлаас Атлантын далайг гатлан ирсэн, дэлгэцийн бүтээлийн шуугиан одоо ч намжаагүй байгаабилээ.

Тун ч удалгүй Филадельфийн Католик сүмийн хамбаас Ландонд нэгэн ил захидал иржээ. Захидлынар дахийг унштал:

"Эт тү, Роберт!" (Роберт, чамайг даа!) гэсэн байжээ.

"Роберт, чи түүнд итгэж болно гэж бодож байна уу?"

"Тэгэлгүй яахав. Бид найзууд. Нөгөөтээгүүр түүнийг Францын төр засгийнханд таагүй ханддагийгби мэднэ. Түүнийг түүхэн дурсгалт газрыг эдлэн газраа болгосон гээд, Францын засгийн газарутгагүй татваруудаараа булчихдаг гэсэн. Тийм болохоор, Тийбин Фааштай холбоо тогтооно гэж билав бодохгүй байна".

"Тийбин, бид хоёр Грейлийн түүхийг өөр өөр талаас нь судалдаг тул, хамтдаа яривал, чамдбүтнээрээ ойлгогдох болно" гээд, Ландон инээж, "Тийбин Ариун Грейлгүйгээр амьдралаа төсөөлжчаддаггүй тул, түүнээс Грейлийн түүхийг сонсоно гэдэг Эйнштейнээр Харьцангуй онолыг ньтайлбарлуулахтай адил байх болно",

"Лей Тийбин тэгвэл шөнийн гийчдийг хүлээн авна гэж л найдахаас!"

Ландон нэг зүйлийг гэнэт санав. "Тийбин их этгээд зантай хүн. Түүнээс гадна Ниоркийнбайшингийн түүхийг судалснаараа, Британий хатан хаанаас тайж цолоор шагнуулсан гэдэг юм".

Софигийн нүд нь томорч, "Чи үнэнээсээ хэлж байна уу? Бид тэгээд тайжийн гэрт очиж

байгаа юмуу?"

Ландон инээмсэглэж, "Бид зөвхөн Грейлийн асуудлаар л явж байгаа. Түүнээс гадна, бидэнд тайжхүн туслахгүй бол, өөр хэн туслах билээ?".

Хэсэг 52

Версаль орчимд байдаг, 185 акр талбайтай Шатү Виллет эдлэн бол Парисын төв хэсгээс баруунхойш 25 миль хэртэй яваад хүрэх газар юм. 1668 онд Франсуа Монсахын Оффлей дүүрэгт зориуланбарьсан, энэ шилтгээн эдлэн бол түүхэн ач холбогдолтой газар ажээ. Хажуудаа тэгш өнцөгтхэлбэртэй хиймэл 2 нуур, Ле Нотре өөрийн гараар чимэглэсэн цэцэрлэгтэй Шатү Виллет эдлэнгхэн ч харсан том орд харш гэхээсээ, энгийн шилтгээн гэж хэлэхээр аж. Энэхүү эдлэнг ВиллетийнПетит гэж хүмүүс нэрлэх болжээ.

Хол замд төвөгшөөж ядарсан, Ландон машинаа эдлэнгийн хашааны гадаа зогсоов .

Тэртээ цаана, шилтгээний барилга бухал өвсөн дээр ургасан сарнай мэт тодрон үзэгдэнэ. Хашаандээр нь англиар "Хувийн өмчид зөвшөөрөлгүй нэвтрэхийг хориглоно!" гэсэн бичиг өлгөсөн байв.Өөрийн вант улсыг Францын нутаг дэвсгэр дээр байгуулсан, Тийбин зөвхө н Англиар бичиг өлгөөдзогссонгүй, бас хашааны хаалганы дэргэд дохиолол дамжуулагч систем суурилуулжээ. Британисэтгэлгээгээр сэтгэж, зориуд жолоочийн эсрэг тал буюу баруун гар талд дохиоллын хүлээнавагчийг тавьсан байв.

Софи түүнийг харан гайхаж, "Жолооч ганцаараа явж байвал яах юм бол?"

"Битгий ингэж асуу! Тийбин эдлэндээ эх орондоо байгаа юм шиг аашилдаг юм" гэв.

Софи хаалганы цонхыг буулгаж, "Роберт чи өөрөө хариулсан нь дээр байх!" гэлээ.

Ландон өндийж, Софигийн дээгүүр гараа явуулан, дохиоллын хонхыг дарлаа. Софигийн түрхсэнүнэртэй ус түүний хамрыг цоргиход, тэр бүсгүйд маш ойрхон байгаагаа тэр мөчид мэдэрлээ. Тэрбараг хөндлөн хэвтсэн байдалтайгаар, шилтгээн дотроос хариу өгтөл нэлээд хүлээв. Удталхүлээсний эцэст хариу өгч, Франц аялгаар уцаарлангуй дуу гарах нь сонсогдов. "Шатү Виллетийнэдлэн байна. Хэн бэ?"

"Би Роберт Ландон байна" гээд бараг хашхирах шахам хариулахдаа,

Ландон Софигийн өвөр дээр уначхав. "Би ... Би Лей Тийбиний найз байна. Тусламж хүсч явна".

"Манай эзэн, бид хоёр амарч байна. Ямар хэргээр явж байгаа юм бэ?"

"Энэ бол бидний хэрэг! Гэхдээ энэ түүнд маш чухал зүйл байгаа юм".

"Тийм бол эзэн маргааш өглөө тантай уулзахдаа баяртай байх болно".

Ландон дороо займчиж, "Энэ түүнд маш чухал хэрэг байгаа юм" гэж давган хэллээ.

"Ноён Лей одоо амарч байгаа.Та найз нь л юм бол, түүний бие муутайг эрх биш мэднэ биз дээ!"

Лей Тийбин багадаа саа өвчинд нэрвэгдэж, одоог хүртэл хөлдөө бэхэлгээ зүүн, суга таягтай явдагболсон юм. Гэхдээ тэрээр огт өвчинд автсан шинжгүй, эрч хүчтэй байсан явдал Ландоныг гайханбишрэхэд хүргэсэн юм.

"Хэрэв та дургүйцэхгүй бол, Грейлийн талаар намайг шинэ зүйл олж мэдсэн гээд эзэндээдамжуулчихгүй юу? Маргааш гэж хойшлуулшгүй шинэ мэдээ байгаа юм".

Хариулагч алга болчхов. Бүтэн минут өнгөрлөө.

Арайхийн нэг хүн утасны цаана дуугарах нь сонсогдов. "За, сайхан залуу минь! Харвардын цагийг баримжаалж ирлээ л гэж битгий хэлээрэй!"

Түүний хоолой нь шингэн, царгиа мэт дуулдах аж.

Ландон түүний Британи аялгыг ялган таньж "Лей, чамайг тохиромжгүй үед сэрээсэндээ, гүнээхүлцэл өчье!" гэв.

"Манай гэрийн үйлчлэгч чамайг зүгээр ч нэг Парист ирээгүй, бас Грейлийн тухай ярьж явна гэхюм".

"Ингэж дуудахгүй бол, чи өөр шалтгаар орноосоо сугарахгүй л дээ!"

"Хүссэнээр чинь болж би сугарчихлаа, сайхан залуу минь!"

"Чи эртний анддаа үүдээ нээх бодолтой байна уу?"

"Үнэний эрэлд цуг гарсан, хүмүүс бол андууд биш харин ахан дүүс байдаг юм".

Ландон Софи руу харц шидэж, Тийбиний өвөрмөц яриаг бүсгүй анзаарч сонссон эсэхийг шинжив.

"Үнэндээ, би үүдээ нээнэ л дээ. Гэхдээ эхлээд чиний сэтгэл чин үнэн байгаа эсэхийг шалгаххэрэгтэй байна. Нэр төрийн шалгуур болсон, 3 асуултад чи хариулах ёстой!"

Ландон шогширч, Софи руу шивэгнэнэ. "Сайн сонсоод байгаарай! Миний хэлснээр этгээд зантайгэдэг нь удахгүй чамд мэдэгдэх болно".

"Эхнийх нь энгийн асуулт" гэж Тийбин анхааруулаад, "Чи кофе уух уу, цай уух уу?"

Ландон Тийбиний залиг мэдэх тул, "цай" гэж хариулав.

"Онц сайн! Хоёр дахь асуулт. Сүүтэй юу, элсэн чихэртэй юу?"

Ландон эргэлзэв.

"Сүү" гэж Софи чихэнд нь шивнэв.

"Англичууд цайндаа сүү хийж уудаг шиг санаж байна" гэж Ландон хэлэв.

Тийбин хариуд нь юу ч дуугарсангүй.

"Элсэн чихэр?" гэвэл, Тийбин бас л хариу өгсөнгүй.

Хүлээгээрэй!

Ландон тэднийд өмнө нь зочилж байхдаа, цайгаар дайлуулж байснаа гэнэт санаад, Тийбиний бяцхан заль хэрэглэснийг мэдэв.

"Нимбэгтэй!" хэмээн Ландон залруулж хариулав.

"Яг зөв!" гэж Тийбин хэлэхдээ, сэтгэл хангалуун байгаа нь мэдрэгдэнэ.

"Одоо эцсийнх нь. Хамгийн хэцүү асуултаа тавья!"

Тийбин бодол болсон дуугаар үгээ зөөж, "Аль онд Хэндийд цомын тэмцээний завины төрөлд Харвардын сургуулийн баг Оксфордынхоос өмнө барианд орсон бэ?"

Ландон хариуг мэдэхгүй байв. Гэвч тэр байж болох хариултыг "буудахаар" шийдэв.

"Ийм зүйл хэзээ ч болоогүй байх ёстой!"

Гэтэл хашааны хаалга онгойж, "Чиний сэтгэл чин үнэнээрээ байгаа юм байна, анд минь. Тавтайморил!" гэх үг сонсогдов.

Хэсэг 53

"Ноён Вехне!" хэмээн менежер захирлыгаа утагсанд баярлаж, хашхирах шахам ярина. "Та хаанабайсан юм бэ? Цагдаа нар гадаа ирчхээд, таныг хүлээгээд байна!"

"Надад энд нэг асуудал гарчихлаа. Чиний тусламж яг одоо хэрэгтэй байна" гэж Вехне доройдуугаар өгүүлэв.

Таныг энд асуудлаас ч их зүйл хүлээж байгаа! гэж менежер дотроо бодов.

Цагдаагийнхан банкиг бүсэлчхээд, ахмад нэгжих зөвшөөрлийн бичигтэйгээ байгаа гэж тэндхийнажилчдыг сүрдүүлж байгаа билээ.

"Бид танд юугаар туслах вэ?"

"3 дугаартай хуягласан машин! Бид түүнийг эрэн сурвалжилж байна".

Менежер машинуудын хуваарийг шалгаад, "Тэр машин энд байгаа шүү дээ! Доод давхрынгараашид".

"Үгүй дээ. Тэнд байхгүй. Сэжигтнүүд танай машиныг хулгайлж зугтсан".

"Юу гэнэ ээ? Зугтсан гэнэ ээ?"

"Утасны цаанаас тодорхой зүйл яримааргүй байна. Гэхдээ танай банканд маш хэцүү нөхцөл байдалүүсч байгааг л би мэдэж байна".

"Та тэгээд биднээр юу хийлгэхийг хүсч байгаа юм бэ?"

"Та нар одоохон хуягласан машиныхаа байршил илрүүлэгчийг идэвх жүүлэх хэрэгтэй байна!"

Менежер өрөөндөө байсан хянах самбар луу харлаа. Банкны бүх хуягласан машин байршилилрүүлэгчээр тоноглогдсон бөгөөд, тэрхүү илрүүлэгчийг банкнаас шууд идэвхжүүлэх боломжтойбайдаг аж. Эл илрүүлэгч төхөөрөмжийг өмнө нь ганц удаа хэрэглэсэн тохиолдол гарахад, ямар чалдаа мадаггүйгээр хулгайлагдсан хуягт машины байршлыг координатаар нь олж тогтоож байжээ.

Менежер захирлаасаа энэ тухай шийдийг сонсохоор, харилцуурын цаанаас Вехнегийн хариултыгхүлээнэ. "Эрхэм ээ, бид илрүүлэгчийг идэвхжүүлбэл, цагдаагийнхан болон манайханд асуудал арайхялбар болох байх? Та юу гэж бодож байна?"

Вехне хэсэг зуур дуугүй байснаа, "За. Байдлыг ойлголоо. Наадахаа идэвхжүүл! Хуягт машин, дугаар 3. Би утсаа барьж байя! Надад машины байршлыг яг одоо хэлээд өг!"

"Ойлголоо, эрхэм ээ!"

30 секундйн дараа, тэндээс 40 км - ийн тэртээ байсан, хуягласан машины байршил илрүүлэгчанивчин ажиллаж эхлэв.

Хэсэг 54

Софи, Ландон хоёр замын хоёр талаар эгнэх жигд зассан, өндөр моддыг өнгөрөн явах хооронд,Софигийн сэтгэл түр ч гэсэн тайвшрах аядна. Төв замаас холдож, Британи хүний хувийн эдлэндирсэн нь, халдашгүй цайзад нэвтэрсэн мэт түүнд санагдана. Тэд тойрог замаар эргэж ортол, баруунгар талд нь Шату Виллет шилтгээн харагдав.

Уртаашаа 60 гаруй метр, 3 давхар шилтгээнийг саарал өнгийн хүрмэн чулуугаар барьжээ. Болхигэмээр харагдах шилтгээний барилгын нүүрэн тал гоёмсог цэцэрлэг, толигор цөөрөмтэй энгүйсайхнаар хосолж, нүд булаах аж. Шилтгээний доод давхрын гэрэл дөнгөж асах нь харагдав.

Ландон шилтгээний үүдэнд зогссонгүй, харин өтгөн ургасан цэцэрлэгийн мод руу шурган орж,машинаа тавив.

"Хүний нүдэнд өртүүлэхгүй гэсэндээ, бас Тийбин харчихвал, хуягласан машины тухай түүндтайлбарлах хэрэг бас гарна" гэж Ландон Софид тайлбарлав.

Софи түүний хэлснийг зөвшөөрч, толгой дохиод, "Криптексээ яах вэ? Машинд орхиж болохгүй.Бас Лей харчихвал, учрыг нь тайлбарлах хэрэг гарна".

"Санаа зоволтгүй!" гээд Ландон хүрмээ тайлж, дахин өлгийдөж ороогоод, криптексийг тэвэрсэн нь,хүүхдээ бүүвэйлж байгаа эцэг хүн шиг харагдав.

Софи инээмсэглэнгээ, "Бас зальтай!" гэв.

"Тийбин зочдоо хэзээ ч үүдэндээ угтаж авдаггүй юм. Тийм болохоор гэрт нь орсон хойноо,бидэнтэй уулзахаас өмнө нэг газар үүнийг нуучихъя. Лей бол маш сонин этгээд зантай хүн гэдгийг,эхлээд чамд анхааруулъя!"

Энэ шөнийн турш этгээд содон, итгэмээргүй явдлууд хангалттай тохиолдсон юмсан гэж Софибодов.

Софи түрүүлж үүдэнд очоод, хаалгыг тогших гэсэн боловч, хаалга дотроосоо нээгдэв.

Хээнцэр, ихэмсэг төрхтэй гэрийн үйлчлэгч эр тэдний өмнө цагаан зангиа, цагаан хослолоо дөнгөжсая өмссөн бололтой, нойрмог царайлан зогсож байв. 50 эргэм насны тэр үйлчлэгч, тохиромжгүйцагт ирсэн, этгээд зочдод тааламжгүй байгаа бололтой нэвт шувт сонжиж харна.

"Эзэнтэн удахгүй бууж ирнэ! Тэр хувцаслаж байгаа. Унтлагын хувцастайгаа байхдаа, хүн зочлохдургүй хүн л дээ" гэж үйлчлэгч эр Франц аялгатай хэлээд, "Таны хүрмийг авч болохсон болов уу?"гээд, Ландоны гар дахь бөөрөнхий хүрмийг ширтэн асуув.

"Зүгээр, зүгээр. Хэрэггүй!"

"Ойлголоо, эрхмээ. Ийшээ явна уу!"

Үйлчлэгч эр тэднийг дагуулан, үүдний хонгилоор явсаар, Викторын үеийн хийцтэй

бүдэг гэрлэнчимэглэл бүхий, дотроо дүүрэн ханын зурагтай тансаг өрөөнд оруулав. Тэндэх агаар нь яг л эртнийхаадын ордонд байгаа гэмээр дагтаршсан хуучин үнэрийг санагдуулна. Үүдний эсрэг талын хананд

нас бие гүйцсэн үхрийн бүхэл махыг ч шарж болохуйц, өргөн, том пийшин байх бөгөөд, түүнийхоёр талд хос бамбай, сэлмийг зэрэгцүүлэн өлгөсөн байх аж.

Үйлчлэгч эр задгай пийшин рүү очиж, чүдэнз зуран, гал ноцоов. Гал дорхноо асч, удалгүйдүрэлзэж эхлэв.

Тэрээр босч, хормогчоо тэгшлээд, "Манай эзэн та бүхнийг гэртээ байгаа юм шиг тухлаарай гэсэн!" гэж хэлэнгүүтээ, тэр хоёрыг орхиж, өрөөнөөс гарлаа.

Пийшингийн эсрэг талд эртний хийцтэй олон сандлууд эгнүүлэн тавьсныг, Софи хараад алин дээрнь суухаа мэдэхгүй шийдэж ядан хэсэг зогсов. Сэргэн мандлын үеийн тансар хилэн буйдан, энгийнвандан сандал, Византийн сүмээс авчирсан гэмээр түшлэгтэй чулуун сандал, энэ бүгд байв.

Ландон хүрмээ задалж криптексийг гаргаад, тансар хилэн буйдангийн доогуур лав гэгч ньшургуулав. Дараа нь хүрмээ сэгсрээд, түүнийгээ өмсөж, Софи руу харж инээмсэглэнгээ, "эрдэнэсээ" нуусан буйдан дээрээ тухлан суув. Софи буйдан руу очиж, түүний дэргэд суулаа.

Софи илч дулаанаа ойр тойронд харамгүй илгээх гал руу харангаа, *Өвөөд лав ийм газар таалагдахбайсан даа!* гэж бодов.

Бараан өнгийн модон хаалган дээр эртний мастеруудын зураг өлгөөтэй харагдана. Түүниймэддэгээс Пуссен (өвөөгийнх нь дуртай зураачийн нэгэн) - ий зургийг бүсгүй олж танив. Пийшингийн тавцан дээр Изис бурхны цээж баримал өрөөг нэвт шувт харах шиг санагдана.

Гэнэт Софигийн нүдэнд хэрцгий балмад байдалтайгаар үхсэн өвөөгийнх нь дүр зураг тодров.

Өвөө үхчихсэн!

Софи буйдан дор нуусан криптексийг онгойлгоход, Лей санаа өгч чадах эсэхийг бодолхийлнэ.

Эсвэл түүнээс криптексийн тухай шууд асуух уу? Өвөөгийн сүүлчийн үг Ландоныг ол гэсэн байсаншүү дээ! Өөр хэн нэгний тухай огт дурдаагүй байсан.

Криптексийг одоохондоо ил гаргахгүй байсан нь дээр гэсэн Ландоны шийдвэрийг Софи дагахаар болов.

"Ноён Роберт!" гэж тэдний араас хүнгэнэх нь дуулдав. "Таныг нэг хатагтайтай цуг ирснийг харсаншүү!"

Ландон босч, Софи ч түүнийг даган, үсрэх шахам бослоо. Нөгөө хүний дуу дээд давхраасмушгиран доош эрчилсэн шатны тэндээс сонсогдох бөгөөд, харанхуйд зөвхөн сүүдэр нь сүүмэлзэхаж.

"Оройн мэнд!" гэж Ландон мэндлээд, "Ноён Лей, энэ хатагтайг Софи Нөвү гэдэг юм".

"Таатай байна!" гэж хэлэнгээ, Тийбин гэрэлд ил гарч ирэв.

"Биднийг хүлээж авсанд баярлалаа!" гэж Софи хэлээд, түүний хөл дэх төмөр бэхэлгээ, суга таягийголж харлаа.

Энэ мөчид Лей шатнаас бууж тэдэн дээр ирж байлаа.

"Бид нэлээд оройтчих шиг боллоо".

"Тийм шүү! Нэлээд орой, эсвэл бүр эрт ирсэн ч байж магадгүй, хонгорууд минь" гэж хэлээд, Тийбин инээв.

"Бу не пас американ?" (Та арай Америк хүн биш биз дээ?)

Софи толгойгоо сэгсэрч, "Парисиан" (Парисийнх) гэж хариулав.

"Та Англи хэл сүрхий сурчээ".

"Баярлалаа! Би Роял Холлоуэйг төгссөн юм"

"Тэгвэл ч аргагүй юм байна. Намайг тэр сургуулиас холгүйхэн Оксфордыг төгссөн гэж Робертчамд хэлсэн байх" гээд Тийбин Ландон руу ирмэлээ.

Тийбин Ландоноос дэмжлэг эрж, түүн рүү ёжтойгоор харан инээмсэглэнэ.

"Мэдээж хэрэг, Оксфордыг төгссөнийхөө дараа, өөрийгөө дахин батлахын тулд, Харвардад бассурсан л даа".

Сүрлэг том биетэй, улаан царайтай, өтгөн улаан үстэй, бор нүдтэй Лей Тийбиний нүд нь үргэл жгялалзах аж. Тэрээр хуниастай өмдөн дээр цагаан торгон цамц өмсөж, гадуур нь цоохор хээтэйхантаазтай явах ажээ. Хөлөн дэх төмөр бэхэлгээ нь түүний хөнгөн шингэн байдалд огтхон ч саадболоогүй мэт харагдах бөгөөд, энэ байдлаараа одоогийн амжилтад хүрсэн байх гэж бодогдохоор аж.

Тийбин тэдэн дээр тулж ирээд, Ландоны гарыг атгангаа, "Роберт, чи жин хассан бололтой!"

Ландон жумалзаж, "Харин чи жин нэмсэн бололтой!" гэв.

Тийбин чин сэтгэлээсээ инээгээд, гүзээгээ алгадан байж, "Манай тогооч Тушегийн ач гавьяа! Сайнтогоочийн гарын хоол идсэнийх" гээд, Софи руу эргэж, толгойгоо бөхийлгөөд, түүний хуруугзөөлхөн үнсэнгээ, бүсгүй рүү харж, "Хатагтай!" гэж хэлэв.

Софи хариуд нь хэрхэхээ мэдэхгүй, дэмий л Ландон руу харна.

Гэрийн үйлчлэгч цай авчирч, пийшингийн өмнөх, намхан ширээн дээр тавив.

"Энэ бол Реми Легалудек. Манай гэрийн үйлчлэгч байгаа юм" гэж Тийбин танилцуулав.

Үйлчлэгч эр үл мэдэг толгой дохиод гарч одов.

"Реми Лионоос ирсэн юм" гэж Лей бараг шивэгнэх шахам хэлээд, "Гэхдээ тэр зууш сайн бэлтгэдэгл дээ!" өөрийнхөө хэлснийг тэр дор нь цайруулав.

Ландон Тийбинийг тавлаж, "Чамайг Англиас гэрийн үйлчлэгчээ импортолдог байх гэж бодсон юмсан?"

"Ээ тэнгэр минь! Би юу боллоо гэж Англи тогооч авчраад, эндхийн балай татварт нь өргөж байх вэдээ" гээд гэнэт Софи руу харж, "Пардонемуа, хатагтай Нөвү! Миний Францад дургүйн голшалтгаан зөвхөн улс төр, хөл бөмбөг хоёроор хязгаарлагддаг юм шүү! Танай засгийн газар миний мөнгийг боловсон аргаар дээрэмдэж, харин хөл бөмбөгийн баг чинь

манайхныг гутаандоромжилсон доо".

Софи хариуд нь гэмгүй инээмсэглэнэ.

Тийбин бүсгүйг хэсэг ширтээд, дараа нь Ландон руу эргэж, "Та хоёрт юу тохиолдсон юм бэ? Хоёулаа л чичрээд байх юм" гэж асуув.

Ландон толгой дохиж, санаа алдаад, "Өнөө шөнө бид хоёр их сонирхолтой зүйл тохиолдоод бай на, Лей!" гэж хэлэв.

Тэгж мэдсэн юм. Шөнө дунд манай үүдийг тогшиж, Грейлийн тухай мэдээтэй явна гэхээр чиньсонин санагдаад явчихсан шүү. Надад хэлээч! Энд та хоёр Грейлийн тухай ярих гэж ирсэн үү? Эсвэл үүнээс өөр шалтгаар намайг босгож дөнгөхгүй гэсэндээ ингэсэн юм уу?"

Аль аль нь гэж Софи дотроо хэлээд, буйдан доорх криптексийн тухай бодолхийлнэ.

"Лей, бид чамтай Сионий Прайорийн тухай ярилцах гэж ирлээ" гэж Ландоныг хэлэхэд, Тийбинхөмсгөө өргөж,

"Сахин хамгаалагчдын тухай юу! Тэгэхээр Грейлийн тухай байх нь ээ. Чи надад нэг мэдээтэй ирсэнгэсэн. Тэр чинь юун тухай вэ, Роберт?"

"Бид энэ тухайд сайн итгэлгүй байгаа болохоор, эхлээд чамаар Грейлийн тухай яриулмаар байна".

Тийбин хуруугаа хурдан хурдан хөдөлгөөд, "Муу зальт Америк уу, чамайг! За яахав. Би бэлэн байна. Чи надаар юу яриулмаар байна?"

Ландон шүүрс алдаад, "Ариун Грейлийн үнэн түүхийг хатагтай Нөвүд ярьж өгнө үү гэж би чамаас хүсч байн

Тийбиний нүд нь сэргэж, "Бүсгүй энэ талаар мэдэхгүй гэж үү?"

Ландон толгой сэгсрэв.

Тийбин нүүрэн дээр ичгүүр сонжуургүй инээмсэглэл тодроод ирэв. "Роберт, чи надад онгон охиначраа юу?"

Ландон ярвайж, Софи руу хараад, "Онгон гэдэг нь Грейл судлаачдын хувьд Грейлийн жинхэнэтүүхийг сонсоогүй хүнийг тэгж хэлдэг юм" гэж бүсгүйд учирлав.

Тийбин Софи руу шимтэнгүй харж, "Чи Грейлийн тухай хэр их зүйл мэдэх вэ, хонгор минь?"

Софи Ландоноос сонссон зүйлээ товч өгүүлэв. Сионий Прайори, Хөлөг Баатруудын холбоо, Сангрийлийн баримтууд, Ариун Грейл. Бас Грейль үнэндээ аяга биш харин хүчирхэг нөлөө бүхий нууцлаг зүйл гэдэг тухай яриу.

"Ингээд л болоо юу?" гээд Тийбин Ландон руу зэмлэл дүүрэн харц чулуудаж, "Роберт, би чамайг жентельмен гэж боддог. Гэтэл чи охиныг тэнгэрлэг оргилоос нь унагаад хаячихсан байна шүү дээ!"

"Тиймээ, гэхдээ чи, бид хоёр ..." гээд Ландонд үг орж ирсэнгүй.

Тийбин Софиг ховстох мэт цоо ширтээд, "Чи бол Грейлийн хувьд онгон охин. Харин одоо надад итгээрэй! чи анхныхыгаа хэзээ ч мартажгүй байх болно, хонгор минь".

Хэсэг 55

Цай ууж, гамбир идсэн, Софид тааламжтай мэдрэмж төрж байлаа. Харин гэрийн эзэн ноён ЛейТийбин пийшингийн эсрэг талд суугаад, гал өрдөнө.

"Ариун Грейл гэж хэлэхээр, олон хүн надаас түүний хаана байгааг л асуудаг юм. Би энэ асуултад хариулахаас үргэлж татгалзсаар ирсэн" гэж тэрээр яриагаа эхлээд, Софи руу эргэж, "Харинхамгийн чухал асуулт бол Ариун Грейл гэж чухам юу вэ гэдэгт л байгаа юм" гэв.

Түүнийг энэ тухай дөнгөж хэлэнгүүт, бүсгүйн дэргэд сууж байсан, хоёр эрийн амьсгаа дээрдэжэхлэхийг Софи өөрийн эрхгүй анзаарав.

"Грейлийг бүрнээр нь ойлгохын тулд, бид эхлээд Библийн тухай мэддэг байх хэрэгтэй. Чи Шинэгэрээг хэр сайн мэдэх вэ?"

Софи мөрөө хавчиж, "Тийм ч их мэдэхгүй. Леонардо Да Винчийг тахин шүтдэг байсан хүн намайгөгсгөсөн юм".

Тийбиний царай гэрэлтэж, үүнд илт таашааж байгаа бололтой, "Гэгээрсэн хүн байсан байх нь ээ. Маш сайн! Хэрэв тийм бол, чи Леонардо Да Винчи Ариун Грейлийн сахин хамгаалагч байсныг мэдэх байх. Тэр өөрийн бүтээлдээ ч энэ тухайгаа шигтгэж оруулсан байдаг шүү дээ!"

"Роберт бас тэгж хэлсэн".

"Тэгвэл Шинэ гэрээний талаарх Да Винчийн үзэл бодол ямар байсныг чи мэдэх үү?"

"Үгүй ээ, мэдэхгүй".

Тийбиний нүд баяр хөөрөөр дүүрч, өрөөний ханан дахь номын тавиур луу хараагаа бэлчээлээ. "Роберт, чи хамгийн доод талын тавиураас "Ла Стория Ай Леонардо" гэсэн нэртэй ном аваад өгөхгүй юу?"

Ландон босч, тэрхүү том хавтастай номыг олоод, тэдний өмнө авчирч тавив. Тийбин номыг Софируу харуулан, хавтсыг эргүүлж, хойд талаас нь гарчгийг харна. Тэрээр "Да Винчийн дэвтрээс олдсон бодол эргэцүүлэл, шүүмжлэл" гэсэн гарчгийг зааж, "Чи үүнийг уншаад ерөнхийд нь ойлгож эхэлнэ" гэв.

Софи гарчгийн дагуу хуудсыг олоод, доторхыг уншив.

Олон хүн ов мэх, худал хуурмаг гайхамшгийг мэдсэнээр, дүйнгэ бусдыгаа нийтээр нь дөнгөсөөр байдаг.

ЛЕОНАРДО ДА ВИНЧИ.

"Бидний өнөөдрийн мэддэг Библи судар бичигдэх болсон шалтгааныг шашингүй үзэлтэй байсан, Ромын эзэнт гүрний их хаан Константинтай холбож үздэг".

"Би Константиныг Христийн шашин шүтдэг гэж бодож байсан юмсан".

"Харин л дээ" гээд Тийбин бүсгүйг тохуурхан инээж, "Тэр үхэн үхлээ, шашингүйн үзлийг баримталдаг байсан. Константиний хаанчлалын үеийн Ромын эзэнт гүрэн Нарыг тахин шүтдэг байсан. Хаан өөрөө шашны тэргүүн нь байлаа. Харамсалтай нь өөр шашны нөлөөлөл Ромд хүчээ авч, Есүс Христ загалмайд цовдлогдсоны дараа, түүнийг шүтэн

бишрэгчдийн тоо огцом өсжээ.Христийн болоод шашингүйн үзлийнхэн хоорондоо тэмцэлдэж, сүүлдээ Ромын эзэнт гүрэн хоёрхэсэгт хуваагдахад хүрсэн байна. Константин энэ бүхнийг шийдвэрлэхээр зориглон хөдөлж,нийтийн тооллын 325 онд Ромыг нэг шашны туган дор нэгтгэхээр болжээ. Энэ бол Христийншашин байлаа".

Софи гайхаж, "Шашингүйн үзлийг баримталдаг байсан улс яагаад гэнэт Христийн шашныг голшашнаа болгодог байна аа?" гэж шалгаав.

Тийбин инээд алдаж, "Константин маш овсгоотой, бас ухаантай хүн байсан. Тэрээр Христийншашны гэрэлт ирээдүйг урьдчилан харж, эрсдэлтэй алхмаас зайлж чадсан юм. Түүхчид одоо чКонстантиныг шагшин магтахаа дуусаагүй л байна. Гэхдээ тэрээр Христийн шашинд шашингүйнүзлийнхний бэлгэдэл, тэмдэглэлт өдөр, мөргөл ёслолыг аажмаар уусган нэвтрүүлж, завсрынсаармаг шашныг үүсгэснээр, эхийг нь эцээж, тугалыг нь тураагаагүй явдал болсон нь хамгийнчухал алхам байж л дээ".

"Энэ бол трансмогрификай" гэж Ландон тодруулж хэлээд, "Христийн шашны бэлгэдэлдшашингүйн үзлийнхний ул мөр өдийг хүртэл арилшгүйгээр үлдсэн байдаг. Жишээ нь:Египетчүүдийн нарны цацраг дүрс Католик шашны гэгээнтнүүдийн гэрэлт цагираг / толгой дээрх/болон дүрслэгдэж, одоогийн дарь эх Мэри нялх Есүсийг тэвэрч байгаа нь, Изис бурхан хүүХорусыгаа хөхүүлж байгаатай маш төстэй байдаг. Үнэндээ Католикийн маш олон мөргөл ёслол,зан заншил болох хандив цуглуулах, сүмийн мөргөлийн индэр, магтуу дуу зэрэг нь шашингүйнүзлийнхнээс санаа авсан юм".

Тийбин шогширч, "Тэмдэгт судлаачдыг Христийн бэлгэдлийн талаар яриулж ингээд болдоггүй юм.Тэртэй тэргүй Христэд нэг ч өөрийн гэх юм байхгүй".

"Үүнийг бас хар даа!" гээд Тийбин номон дээрх өөр нэг үгийг заав.

Үл ойшоох явдал биднийг төөрөгдүүлэн, нүдийг маань сохолж байна.

Эгэл золгүй хүмүүс минь, нүдээ нээгээч!

ЛЕОНАРДО ДА ВИНЧИ

* * *

Софи бүр цөхөрч, "Да Винчи Библийн тухай энд хэлсэн гэж үү?" хэмээн асуув.Тийбин толгойдохиж, "Леонардогийн Библийн тухай хэлсэн үг Ариун Грейлтэй шууд холбоотой. Үнэндээ бол ДаВинчи Грейлийг бодитоор зурж үлдээсэн. Би чамд удахгүй түүнийг үзүүлнэ. Харин эхлээдБиблийн тухай яриагаа үргэлжлүүлье".

Тийбин хоолойгоо засан, инээмсэглээд, "Библийн судар бидэнд факсаар ирээгүй юм шүү!"

"Өршөөгөөрэй? Та юу гэсэн бэ?"

"Библийг бурхан бичээгүй. Харин эгэл хүн бичсэн юм, хонгор минь. Библийн судар үүлэн дээрээсид шидээр ч унаагүй. Хүн түүнийг тэмдэглэн зохиож, түүнийг нь тоо томшгүй олон хэлээрорчуулан, засварлаж хэвлэсээр өдийг хүрсэн. Түүхийг тэр чигт нь болсноор нь буулгасан ном гэжбайдаггүй юм. Тийм ээ, Есүс Христ бол хүн төрөлхтний түүхэнд алгуур аажим хугацаанд ихээхэнтөм байр суурийг эзэлж, нөлөөллөө үзүүлсэн нууцлаг, эрч хүчтэй суут удирдагч хүн байсан юм.Зөнч бурхан болсон тэрээр хаад ноёдыг өмнөө сөхрүүлэхүйц гүн утгатай философийг үүсгэнсанаачилсан эгэл хүн байсан. Соломон хаан болоод, Давидын хааны үр хойч байсан тэрээр Еврейүндэстний хаан ширээг өөрийн болгосон. Түүнийг сүслэн дагалдагчдын тоо тэр үед мянга мянгадхүрч байсан юм".

Тийбин түр завсарлаж, цайгаа балгаад, буцааж ширээн дээр тавив. "Шинэ гэрээнд анхандаа 80гаруй сургаал номлолыг оруулах ёстой байсан ч, цөөн хэдэн хүний номлол сургаалийг л эцэст ньбагтаасан юм. Үүнд: Мэтью, Марк, Льюк, Жон нарын нэр ордог юм".

"Библийн сударт хэний номлол сургаалыг оруулахыг хэн мэдэж шийдсэн юм бэ?"

"Сайхан асуулт байна!" гээд Тийбин цааш улайрч, "Христийн гол учиг зангилаа нь энд л байгаа юм. Христээс өмнө Бурхны хүү гэгддэг байсан Митрас бурхан буюу Ертөнцийн гэрэл хэмээх бурхныг 12 - р сарын 25 - нд мэндэлсэн гэж ярьдаг. Мөнхүү энэ өдрөө үхэж, чулуун авсандоршуулагдаад, 3 хоногийн дараа дахин амилсан гэж Митрас бурхныг үздэг байжээ. 12 - р сарын 25 -нд мөн л Осирий, Адоний, Лионисий бурхад мэндэлсэн гэж үздэг. Кришна бурхан бас төрөхдөө алт, арц, хүж барьсаар ертөнцөд мэндэлсэн гэдэг. Христийнхний нэрлэсэн Ариун өдөр буюу мөргөлийн өдөр угтаа бол шашингүйн үзлийнхнээс гаралтай зүйл".

"Юу гэнэ ээ? Арай үгүй байлгүй дээ!"

"Христүүд эхэндээ Бямба гаригийг мөргөлд зориулахаар сонгосон байсан ч, сүүлд Константиннарыг бишрэн хүндэтгэдэг тэр өдөр мөргөл хийхээр өөрчилсөн байна" гээд Ландон жуумалзаж, "Тэр өдөр буюу Ням гаригийн өглөө мөргөлчид, сүсэгтнүүд сүм рүү явахдаа, яагаад заавал энээдрийг товлох болсныг үл хайхран мөргөл үйлдэхээр, тийш зүглэсээр л байгаа юм".

Софи бүр толгой нь эргэж, "Энд тэгээд Грейлтэй холбоотой зүйл байгаа гэж үү?"

"Яг тийм". гэж Тийбин хариулаад "Хоёр шашныг хооронд нь нэгтгэж байх завсраа, Константи нхаан Христийн урсгалыг улам хүчтэй дэлгэрүүлэхийн тулд, нэгэн алдартай зөвлөл байгуулсан нь Никагийн зөвлөл юм".

Софи энэ зөвлөлийн тухай сонссоноо, бүүр түүр санаж байв.

"Энэ зөвлөлийн хуралдаан дээр Христийн дахин мэндэлсний өдрийг тэмдэглэх тухай, хам ба ламнарын үүрэг хариуцлагын тухай, дээд шатны удирдлагын зан үйл, дэг журмын тухай, мэдээж бас Христийг тэнгэрийн элч бурхан гэж зарлах эсэх тухай хэлэлцсэн байна".

"Би ойлгосонгүй. Тэнгэрийн элч гэж зарлах ий?"

"Хонгор минь, түүхэнд Есүсийг энэ хуралдаанаас өмнө тойрон хүрээлэгч, дагалдагчид нь бүгдтүүнийг хүчирхэг, боловч жирийн зөнч хүн гэж итгэдэг байсан. Жирийн эгэл хүн гэж итгэдэг байсан юм шүү!"

"Бурхны хүү гэж итгэдэггүй байсан хэрэг үү?"

"Яг тийм. Есүсийг тэнгэрийн элч, бурхны хүү хэмээн Никлайн зөвлөлөөс анх баталсан юм".

"Байзаарай! Тэгэхээр та Есүсийг бурхны хүү гэдгийг зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж, гар өргөн баталсан гэх гээд байна уу?"

"Есүсийг бурхны хүү гэж баталснаараа, Константин түүнийг хүн төрөлхтний бурхан шүтээн болгон залж, хүч чадлыг нь бусадтай эгнэшгүй болгосон юм. Хэдийгээр Христийн шашин хүчтэйд тооцогддог ч, одоо бол Христийн шүтлэгтнүүд шашнаа өмгөөлөн хамгаалах ганц гогцоо байдаг. Тэр нь Ромын католик сүм" гэж Тийбин өгүүлэв.

Софи Ландон руу харахад, Ландон Тийбиний ярьсныг дэмжиж, толгой дохив.

"Энд зөвхөн сүр хүчний тухай ярьж байна. Олонх эрдэмтэн судлаачид эртний Христийн сүм хийд Есүсийг тойрон хүрээлэгчдээс нь булаасан гэж үздэг. Сүмийнхэн түүний хэлсэн эгэл жирийн мэт санагдах үгсийг нуун далдалж, тэнгэрлэг мөн чанарыг нь алдагдуулахгүйг хичээн, өөрсдийн сүрхүчийг өсгөж байсан юм. Би энэ сэдвээр хэд хэдэн ном бичсэн л дээ".

"Тэгвэл Христийн олон шүтлэгтнүүд танд хараалын үгтэй захиа, зурвас ихээр илгээсэн байх даа!"

"Харин ч үгүй. Христийн ихэнх боловсорсон шүтлэгтнүүд бүх үнэнийг дэндүү сайн мэддэг. Есүсүндээ агуу, хүчирхэг хүн байсан. Константины улс төрийн далд санаа бодлого ч Христийнхувийн амьдралын жинхэнэ сүр хүчийг бууруулж чадаагүй. Хэн ч өнөөдөр Христийг хуурамчбайсан гэж хэлдэггүй, бас олон сая хүний амьдралыг шинээр өөрчилж, сайн сайхан болгосныг ньняцаадаггүй. Гол нь түүний энэ чанарыг Константин өөртөө ашигтайгаар эргүүлсэн хэрэг. Ингэж лөнөөгийн бидний шүтдэг Есүсийн бурханлиг дүр төрх анх мэндэлсэн юм даа".

Софи ном руу шимтэн харж, Ариун Грейлийг зурсан Леонардо Да Винчийн зургийг сонирхоно.

"Гол зангилаа нь энд л байгаа юм" гээд Тийбин цааш яриагаа улам түргэсгэж, "КонстантинЕсүсийн нас барснаас бараг 4 зууны дараа, түүний шинэ дүр төрхийг хүч түрэн тодорхойлсон ч,Есүсийг жирийн хүн байсныг нотлох жинхэнэ түүх сайтар хадгалагдаж, хөндөгдөөгүй хоцорччаджээ. Константин түүхийг шинэчлэн бичихийн тулд, өөрийнхөө зүгээс ихээхэн эрсдэлийг үүрсэнаж.

Бүх зүйл ингэж эхэлсэн юм. Константин Библийн судрыг зохиож бичих зарлиг гарган, түүнийгсанхүүжүүлж, Христийг бурханлиг талаас бичсэн сургаал номлолыг сайшааж, харин эгэл жирийнхүн байсныг нь дурдсан сургаал номлолыг няцааж, өмнөх сургаал номлолыг нь хуулиар хориглож,цуглуулан шатаажээ. Бас нэг зүйлийг нэмэхэд, Константиний зохиосон хувилбар аас өөр номлол,сургаалыг дагах юм бол тэр хүнийг тэрс үзэлтэн гэж ялладаг байв. Гэвч түүхчдэд аз болоход,Константин бүх тэрс номлол сургаалыг устгаж чадаагүй юм. 1950 - иад онд Сөнөсөн тэнгисийнжагсаалт хэмээх номлол Еврейн цөл дэх Кумраны агуйгаас олджээ. Мөн Коптикийн баримт,номлол 1945 онд Наг Хаммадигаас олдсон юм. Грейлийн түүхийг ярихтай холбогдож, эдгээрномлол баримтуудын аль аль нь Христийг жирийн хүн байсныг тодорхой байдлаар гэрчилдэг юм.Харин эдгээрийг олон нийт мэдэхээс эмээж, тэр үед Ватиканы сүм нийтэд зарлахыг хориглох гэжоролджээ. Учир нь баримтуудыг уншихад, одоогийн Библи судрыг зохиосон нь илт мэдэгдэхээрбайсан бөгөөд, жинхэнэ болон зохиомол түүхүүдийн хоорондох зөрчил, хоосон орон зай Но эрхгүйялгарч харагддаг аж".

"Ватикан үүнийг худал нотолгоо гаргаж ирлээ гэж эсэргүүцэхийг одоо хүртэл оролддог" гэжЛандон нэмж өгүүлэв.

Тийбин Софигийн Өөдөөс харж сууснаа, инээд алдаад, "За тэр, чи харж байгаа биз! Манайпрофессор Ромд мөн ч зөөлөн ханддаг хүн шүү. Эсэргүүцэхийг оролддог байхдаа яахав дээ.Ватикан ингэж эсэргүүцэх нь ч аргагүй. Константиний зохиосон Библи олон зууны турш Ватиканышүтдэг цор ганц зүйл болж байсан юм чинь. Ятган сэнхрүүлэгч хүн өөрийнхөө ятгалгад бүрэнавтсан байдаг гэсэн үг байдаг шүү дээ! Түүнээс өөрцгүй".

"Лейгийн хэлэх гээд байгаа гол санаа бол, бид өмнөх үеийнхнийгээ сохроор дууриаж, шашиншүтдэг". гэж Ландон тайлбарлав.

"Тиймээ. Миний хэлэх гээд байгаа санаа бол өмнөх үе маань бидэнд Христийн тухай худал зүйлзааж сургажээ. Ариун Грейлийн түүхийн хувьд ч мөн адил".

Софи Да Винчийн хэлсэн үгийг дахин уншив.

Үл ойшоох явдал биднийг төөрөгдүүлэн сохолж байна!

Эгэл золгүй хүмүүс минь, нүдээ нээгээч!

Тийбин номынхоо хуудсыг голд нь ортол эргүүлээд, "Би чамд Ариун Грейлийг дүрсэлсэн ДаВинчийн зургийг харуулъя. Үүнийг түрхэн зуур хар даа!" гээд, хуудсын хоёр нүүр эзэлсэн том, өнгөт зургийг үзүүлэв. "Чи үүнийг мэдэх байх?"

Тэр надаар тоглоом хийж байна! гэж Софи бодонгоо, "Нууцат үдэш" хэмээх алдарт зургийг гайханширтэв. Зураг дээр Есүсийг өөрийн шавь нартай хамт байгаагаар дүрсэлж, тэрээр өөрөөс ньурвасан хүнийг зарлаж байгаа тухай утгатай байдаг шиг Софи санана.

"Тиймээ. Би зургийг мэднэ".

"Тийм бол миний бяцхан тоглоомонд оролцоно уу?! Та нүдээ анигтун!"

Софи гайхсан боловч, нүдээ анив.

"Есүс хаана сууж байна вэ?"

"Голд нь".

"Сайн байна! Тэгвэл тэд юу идэж байна вэ?"

"Талх". Мэдээж хэрэг өөр юу идэх гэж.

"Онц сайн! Юу ууж байна?"

"Дарс. Тэд дарс ууж байна".

"Гайхамшигтай! Одоо сүүлчийн асуулт. Ширээн дээр хэдэн аяга байна вэ?"

Софи түр азнаж, сэжигтэй асуулт тавьсныг гадарлав.

Оройн хоолны дараа Есүс аягатай дарсыг авч, өөрийн шавь нартаа хувааж ууж байгааг зурсанбайдаг.

"Ганц аяга. Энэ бол Христийн аяга. Ариун Грейл байх нь. Есүс аягаа дамжуулан бусдадаа дарсөгдөг. Яг л одоогийн Христийн шашинтнууд шиг".

Тийбин хариуд нь санаа алдаад, "Нүдээ нээ!" гэж хэлэв.

Бүсгүй нүдээ нээлээ. Тийбин бах нь ханасан байдалтай жуумалзана.

Софи зураг руу хартал, хачирхалтай нь Христийн нэгэн адил бүх шавь нар нь ширээнийхээ өмнөхундага тавьчихсан байв. 13 хундага!

Хундаганууд бүгд жижиг хэмжээтэй, бариулгүй байх бөгөөд шилээр хийсэн аж.

Бурхны аяга харин тэнд байсангүй. Ямар ч Ариун Грейл тэнд байсангүй.

Тийбиний нүд гялалзаж, "Сонин санагдахгүй байна уу? Эсвэл Да Винчи Ариун Грейлийг зурахаамартчихсан юм болов уу?"

"Урлаг судлаачид л үүнийг тайлбарлах байх" гэж Софи урам хугарсан байртай өгүүлэв.

"Ихэнх судлаачдын олж харахааргүй эсвэл анзаарахааргүй тэр зүйлийг Да Винчи энэ зурагторуулсан гэвэл, чи лав итгэхгүй дээ! Энэ зураг бол Ариун Грейлийн нууцыг тайлах

оньс байгааюм. Аа Винчи Грейлийг гэдгийг хүмүүст мэдүүлэхийн тулд, "Нууцат үдэш" - ийг зурсан юм".

Софи зургийг сайтар нарийвчлан үзээд, "Энэ зурагт Грейлийг юу болохыг тодорхой өгүүлдэг гэжүү?"

"Нууцат үдэш"

"Юу болохыг бус харин хэн бэ гэдгийг энэ зурагт өгүүлдэг юм. Ариун Грейл бол үнэндээ хүнбайгаа юм" гэж Тийбин шивнэв.

"Нууцат үдэш" (The last supper)

Хэсэг 56

Софи Тийбинийг бараг цоо ширтээд, дараа нь Ландон руу харав.

"Ариун Грейл тэгээд хүн юм уу?"

Ландон толгой дохиж, "Үнэндээ тийм. Тэр тусмаа эмэгтэй хүн".

Ландон Софигийн царай зэвхий даахыг хараад, бүсгүйн бодол одоо хаагуур тэнүүчилж байгааг мэдэхэд хэцүү гэдгийг ойлгов. Ландон ч мөн адил ил түүхийг анх сонсохдоо ингэж лцочирдсонсон. Учир холбогдлыг нь нарийн судалсны дараа л, Грейлийн жинхэнэ үнэни йг тэрээр бүрнээ ухаарч билээ. Тийбин ч бас Ландонтай адил бодолтой байлаа.

"Роберт, одоо чи тэмдэгтийн талаас тайлбарласан нь дээр байх?"

Тийбин ширээний захад очиж, цагаан цаас аваад, Ландоны өмнө авчирч тавив.

Ландон халааснаасаа үзэг гаргаж, "Софи, одоо хэрэглэж байгаа эрэгтэй, эмэгтэй хүйсийгилэрхийлсэн дүрсийг чи мэднэ шүү дээ!" гээд тэрээр эрэгтэй хүйсийн дүрсийг зурав.



Дараа нь эмэгтэйнхийг бас,

♀

"Тэгэлгүй яахав. Би үүнийг мэднэ".

"Эдгээр дүрс бол үнэндээ эрэгтэй, эмэгтэй хүйсийг дүрслээгүй юм. Анх Эртний одон оронсудлаачид Ангараг, Сугар гаригуудыг эдгээр дүрсээр төлөөлүүлдэг байсан. Хүйсийг илэрхийлсэнжинхэнэ дүрс бол энэ" гээд Ландон цаасан дээр дахин зурав.

∧

"Энэ бол эрэгтэй хүнийг бэлгэдсэн дүрс. Өөрөөр хэлбэл эр бэлэг эрхтэнг бэлгэдэж байгаа юм".

"Тийм юм шиг байна".

Ландон цааш нь, "Энэ дүрс бас сумны зэвийг бэлгэддэг бөгөөд, эрэгтэй хүний дайчин түрэмгийбайдлыг илтгэдэг. Одоо ч зарим хүчний байгууллагууд энэ дүрсийг ашиглан, тушаал зэргээтодорхойлдог".

"Яг тийм шүү!" гээд, Тийбин жуумалзаж, "Олон бэлэг эрхтнийг мөрөндөө зүүсэн бол өндөртушаалтай гэсэн үг. Үнэндээ эрчүүд л бол эрчүүд шүү дээ!"

Ландон Тийбиний цаашлуулахыг сонсоод, ярвайж, "Эмэгтэй хүнийг бэлгэдсэн дүрсийг ч лавтөсөөлж байгаа байх. Үүний яг эсрэг дүрс байгаа. Өөрөөр бас аяга ч гэж нэрлэдэг"

∨

Софи гайхаж, Ландон руу өлийн харлаа. Дараа нь бүсгүй учрыг олсон бололтой харагдана.

"Аяга гээд байгаа энэ дүрс шингэн агуулах сав гэсэн утгатайгаар бидний толгойд буудаг ч, хамгийнчухал нь эмэгтэй хүний умайг илтгэдэг. Энэ дүрс бол эм хүйс, эмэгтэйлэг чанар, үр тогтолт гэсэнойлголтыг дотроо агуулдаг" гэж Ландон нямбай нь аргагүй тайлбарлав.

Тэгээд Ландон Софи руу ширтэж, "Софи! Ариун Грейлийн Аяга гэж түүхэн сурвалжид өгүүлдэг ч,энэ бол түүний жинхэнэ мөн чанарыг нуун далдалсан, ёгт утгатай үг байсан юм. Аяга хэмээхойлголтоор дамжуулан зүйрлэл хийснээрээ, түүний амин чухал зүйл гэдгийг ийнхүү нотолсонбайна".

"Эмэгтэй хүн гэдгийг нотолсон байх нь ээ!" гэж Софи хариуд нь уулга алдав.

"Тиймээ" гэж Ландон инээмсэглэн хэлээд, "Грейл гэдэг нь эмэгтэй хүний бэлгэдэл эртнээс болж, харин Ариун Грейл гэдэг нь дарь эх бурхныг төлөөлж байсан байна. Үүнийг сүмийнхэн нуундарагдуулж, эмэгтэй хүний амьдрал тэтгэгч чанарыг үл ойшоож, түүний оронд эмэгтэй хүнтэй холбоотой бүхэнд ад чөтгөрийн, бузар хэмээх тодотгол зүүсэн юм. Тэд амьдралыг тэтгэгч шүтээн болсон эмэгтэй хүнийг дайснаа хэмээн номлож, "нүгэл хилэнц" хэмээх тэр ойлголтыг Еваг алимнууцаар идсэн тэр цагаас эхлэлтэй хэмээн тодорхойлсон".

"Нэмж хэлэхэд," гээд Тийбин ярианд оролцож, "Эмэгтэй хүнийг амьдрал тэтгэгч гэдгийг эртний шашны урсгалууд анх гаргаж ирсэн. Хүүхэд төрүүлэх нь эмэгтэй хүнд хүчирхэг нууцлаг байдлыг бий болгодог байж. Харин Христийн гүн ухаанд эмэгтэй хүний амьдрал тэтгэгч чанарын ач холбогдлыг илт бууруулж, биологийн зүй тогтлыг няцаагаад, эрэгтэй хүнийг Амьдрал тэтгэгч болгосон нь инээдтэй бас эмгэнэлтэй хэрэг шүү! Тэгээд ч гарал үүслийн хувьд Адамын хавирганаас Ева гарсан гэж Библийн сударт бичсэн байдаг. Өөрөөр хэлбэл, эмэгтэй хүнэрэгтэйгээсээ гарсан утга Библи нэвт шингээстэй. Ингэж л гарал үүслийн онолд дарь эх бурхныг үлхэрэгссэн юм даа".

Ландон Тийбиний яриаг залгуулж, үндсэн сэдэв рүүгээ орлоо. "Грейл бол мартагдсан дарь эх бурхны бэлгэдэл байгаа юм. Христийн шашин, шашингүйн үзэл хоёр хамт оршоор өдийг хүрсэн. Алдагдсан Грейлийн ариун эрэл хайгуулын тухай домог бол чухамдаа мартагдсан дарь эх бурхныг эрлийн тухай байсан юм. Аягыг хайж байсан гэх Хөлөг Баатрууд үнэндээ бол эмэгтэйчүүдийг дарлаж байсан, дарь эх бурхныг гутаасан, тэрс үзэлтнүүдийг галд ан шатаасан, шашингүйн үзлийнхнийг шахан гадуурхсан сүмийнхнээс өөрсдийгөө хамгаалахын тулд, оршин тогтнож байсан бүлэг хүмүүс юм".

Софи толгой сэгсэрч, "Байзаарай! Ариун Грейлийг хүн гэж чи хэлсэн шиг санагдах юм".

"Тиймээ. Энэ үнэн" гэж Ландон хариулав. Тэрээр, "Тэр бол зүгээр ч нэг тохиолдлын хүн биш" гээд хөлөөрөө шал товшиж, "Тэр бол хүчирхэг нууцыг өөртөө хадгалсан бүсгүй хүн байсан юм. Хэрэв тэр нууц гадагш задарвал, Христийн сүмийнхэн үндсээрээ нуран унах хүчтэй нууц!" гэв.

Софи туйлын ихээр цочирдож, "Тэр бүсгүйг түүхэнд гардаг гэж хэлээч?"

"Тэгэлгүй яахав" хэмээн Тийбин ам нээж, таягаа авангаа, "Та хоёр миний "Сургалтын" өрөөнд зочилбол, би тэр эмэгтэйг зурсан Да Винчийн зургийг үзүүлье!" гээд өрөөнөөс гарахаар зүглэлээ.

Тэднээс хоёр өрөөний цаана, гэрийн үйлчлэгч Реми Легалулек зурагтаа ширтэн дуугүй зогсоно. Мэдээний сувгаар эрэгтэй, эмэгтэй хоёр хүний гэрэл зургийг гарган үзүүлэх аж. Реми зурагтаар гарч буй хоёр хүнд саяхан цай зөөсөн билээ.

Хэсэг 57

Цюрихийн Хадгаламжийн банкны гадна, ахмад Фаашийг нэгжих зөвшөөрөл авчрахыг, дэслэгч Коле хүлээн зогсохдоо, түүний удаж байгаад гайхна. Колед банкныхан их л сэжигтэй

санагдаадбайв. Тэдний баталж байгаагаар, Ландон, Нөвү хоёр банканд ирээд, дансны дугааргүй байсан тул,буцсан гэж цагдаагийнханд мэдэгджээ.

Хэрэв тийм бол яагаад биднийг дотогш нэвтрүүлэхгүй байгаа юм бэ?

Гэтэл түүний утас ашгүй эцсийн мөчид дуугарав. Лувр дахь цагдаагийн хэлтсээс түүн рүү утастажбайв.

Коле утсаа авангуутаа, "Нэгжих зөвшөөрөл байгаа биз дээ?" гэж шаардан асуув.

"Дэслэгч ээ, наад банкаа зөнд нь орхи!" гэж харилцуурын цаанаас нэг цагдаа хэлээд, "Бидэнд өөрмэдээ ирсэн. Ландон, Нөвү хоёрын байгаа газрыг олж тогтоосон байна" гэв.

Коле машиныхаа хамар дээр пидхийтэл суугаад, "Чи тоглоод байна уу?" гэж хоолойгоо шаханасуув.

"Хотоос зайдуу, Версалийн ойролцоо байна гэнэ".

"Ахмад үүнийг мэдэж байгаа юу?"

"Мэдэж амжаагүй байгаа. Тэр утсаар чухал зүйл ярьж байгаа бололтой энд байна".

"Би тэгвэл хөдөллөө. Түүнийг ярьж дуусахаар нь над руу залга гэж дамжуулаарай!"

Коле хаягийг бичиж аваад, машиндаа үсрэн суув.

Банкнаас холдох зуураа, Коле Ландоны байршлыг хэн мэдээлснийг, асуухаа мартсанаа сая санав.

За, энэ ямар хамаатай билээ!

Колед гаргасан алдаагаа засах, сайхан боломж олдож байхад, аманд орсон шар тосыг хэлээрээтүлхэж болохгүй шүү дээ! Тэрээр хамгийн дуулиан тарьж болох, баривчилгааг хэрхэн гардажявуулахаа, дотроо нарийн төлөвлөж эхлэв.

Тэндээс 40 км - ийн тэртээ, хар өнгийн Ауди машин модны сүүдэрт халхлагдсан, талбайн захадочиж зогсов.

Силас машин дотроос гарч ирээд, хашааны завсраар харагдах шилтгээний барилгыг шимтэнсонирхоно. Сарны гэрэлд тодрон үзэгдэх, тансаг орд харшийг тэрээр холоос ажигласаар зогсох аж.

Байшингийн доод давхрын гэрэл бүгд асжээ. Өдийд гэрэл асаалттай байгаа нь хачирхалтай боловч, Силас түүнийг хараад харин ч инээмсэглэнэ. Түүнд өгсөн Багшийн мэдээлэл тодорхой бөгөөдодоогийн харж байгаагаас нь огт зөрсөнгүй.

Би эндээс Онъсон чулуугүйгээр хаашаа явахгүй! гэж Силас өөртөө тангараглав. Би Хамба лам, Багш хоёрынхоо итгэлийг дахин хөсөрдүүлэхгүй!

Силас дайзандаа 13 сумтай Хеклер Коч буугаа шалгаад, хашааны завсраар шидэнгүүтээ, өөрөөдээш авиран гарч, хашааны нөгөө талд үсрэн буув. Өргөст бүснийхээ өвчинг ч үл огоорон, Силасбуугаа шүүрэн авч, өвстэй налуу газар өөд мацан гүйлээ.

Хэсэг 58

Тийбиний "Сургалтын" өрөө бусад судалгааны өрөөтэй огтхон ч төсгүй байв. Хамгийн томдтооцогдох оффисын өрөөнөөс даруй 6 - 7 дахин том байж болох, тайжийн кабинет

лаборатори,архив, номын сан, шавьжны цуглуулга зэрэг олон хэсгээс бүрдэх аж.

Гурван том лааны суурийн тусламжтайгаар гэрэлтэх танхимд ном, бүтээл, зураг болон компьютерын бүхий л хэрэгслүүд, мөн процессор, микроскоп, хувилагч машин, том сканер гэхмэтэд бүрэн дарагдаж, хөглөрсөн байдалтай харагдах том ширээнүүд байлаа.

"Би танхимын зориулалтыг өөрчилсөн юм" гэж гэрийн эзэн хөлөө чирч явангаа, даруу төлөвбайдлаар өгүүлээд, "Надад идэвхтэй бүжиглэж, хөдлөх зав гардаггүй болохоор хүлээн авалтын танхимаа ингэж өөрчилсөн юм" гэв.

"Энэ тэгээд таны ажлын өрөө чинь юм уу?" гэж Софи асуув.

"Үнэнийг судлах үйлс бол миний хувьд анхны хайр л гэсэн үг. Харин Сангрийль бол миний аргагүй амраг юм уу даа".

Ариун Грейл бол бүсгүй хүн! гэж Софи дотроо бодоод, урьд дуулсан зүйлтэйгээ энэ бүхнийг нэгтгэн дүгнэх гэж оролдоно.

"Та Ариун Грейлийг бүсгүй хүн гэж баталсан зургийг надад үзүүлнэ гэсэн байх аа?"

"Тиймээ. Гэхдээ би тэгж батлаагүй. Христ өөрөө тэгж баталсан юм".

"Тэгвэл тэр зураг хаана байгаа юм бэ?" гээд Софи танхимын ханыг эргэн тойрон харлаа.

"Аан, тэр үү?" гээд Тийбин мартсан дүр үзүүлэнгээ, "Ариун Грейл! Сангрийль! Аяга!" гэж хэлснээ, тэртээ хана руу гэнэт заав.

Софи тэр зүг харвал саяхан үзчихээд байсан, нөгөө л "Нууцат үдэш" дахин харагдах нь тэр. Гэхдээ өмнөхөөс ялгаатай нь 18 футын урттай, том хуулбар байлаа.

"Тэр байна!" гэж Тийбин хэлэв.

"Энэ чинь таны түрүүнд үзүүлсэн зураг байна шүү дээ!"

Тийбин нүдээ ирмэж, "Тэгэлгүй яахав, гэхдээ том хувилбар нь илүү сонирхолтой харагдаж байна гэж чи бодохгүй байна уу?"

Софи Ландон руу аврал эрсэн харцаар хараад, "Би бүр будлиж гүйцлээ". гэв.

Ландон инээмсэглээд, "Нууцат үдэш дээр Ариун Грейлийг дүрсэлсэн байгаа. Леонардо Да Винчитэр бүсгүйг энэ зурагт үзүүлсэн нь үнэн!"

"Байзаарай! Та хоёр Ариун Грейлийг бүсгүй хүн гэж хэлсэн. Гэтэл энэ зурагт 13 эрэгтэй зурсан байдаг шүү дээ".

"Тийм гэж үү?" гэж Тийбин хөмсгөө нумартал нь өргөөд, "Чи тэгвэл, ойртоод сайн хар даа!" гэв.

Софи зураг руу дөхөж, 13 хүний дүрсийг нэг бүрчлэн ажиглалаа. Есүс Христ тэдний голд нь сууж, 6 шавь нь баруун гар талд нь, үлдсэн 6 нь зүүн талд нь суусан байв.

"Тэд бүгд эрэгтэй хүн байна шүү дээ!" гэж Софи батлан хэлэв.

"Өө, тийм үү? Тэгвэл эзний баруун талд зэрэгцэн суусан хүний тухайд юу гэж хэлэх вэ?"

Софи түүнийг сайтар шалгаж харав. Тэрээр нөгөө хүний царай, биеийг сайн ажиглаж харсныхадараа, нэг хэсэгтээ алмайрчхав. Түүний харж байгаа хүн бол хүрэн улаан үстэй, туяхан гараатойгоороо нугалан суусан, цээж нь үл мэдэг түхийсэн, яах аргагүй эмэгтэй хүн байв.

"Эмэгтэй хүн байна" гэж Софи хашхирав.

Тийбин инээж, "Гэнэтийн бэлэг! Гэнэтийнх! Гэхдээ энд ямар ч алдаа байхгүй гэдэгт итгэ. Леонардохүйсийн ялгааг гаргаж зурахдаа, гаргууд байсан юм шүү!"

Софи Есүс Христийн дэргэд суух эмэгтэйг нүд салгалгүй ширтэнэ. Уг нь 13 эрэгтэй байдаг гэжбодсон юмсан! Энэ эмэгтэй хэн юм бол?

Софи хэдийгээр сонгодог зургуудыг олонтаа харж байсан авч, энэ эмэгтэйн төрх т үүний харсанзургууд дахь эмэгтэйчүүдийн алинтай ч төсгүй санагдана.

"Бүгд л үүнийг анзааралгүй өнгөрдөг юм. Урьдаас бодсон бидний төсөөлөл хэтэрхий хүчтэй байдагтул, нүд зөв харсан ч, төсөөлөл нь харах мэдрэхүйгээ боомилж орхидог. Үүнийг өөрөөр скитомагэдэг. Тархи үүнд онцгой үүрэг гүйцэтгэдэг юм. Чамайг төөрөгдүүлсэн шалтгаан бол уран зургийнномуудын ихэнх гэрэл зургийг 1954 онд авсан байдагтай холбоотой. Тийм учраас удаан хугацаандөнгө нь гандаж, хир тортог болсон, гэрэл зургийг дахин сэргээж байна гээд болхи гараар засварлансэргээж дээр нь зурдаг. Ийм замаар эцэст нь Да Винчийн эх зураг танигдах аргагүй болтлооөөрчлөгдсөн байдаг" гээд, Тийбин гэрэл зураг руу зааж,

"Et voila" гэв.

Софи дахин зураг руу ойртож харав. Зураг дээрх залуухан эмэгтэй ёс журамтай, намбалаг харагдахбөгөөд, улаан хүрэн үс нь сул асгараад, гараа нугалан цэх суужээ.

Энэ эмэгтэй Христийн сүмийг бусниулах сүр хүчтэй байсан гэж үү?

"Түүнийг хэн гэдэг юм бэ?"

"Энэ бол, хонгор минь, Мэри Магдалин".

Софи сэрдхийж, "Тэр чинь биеэ үнэлэгч биз дээ?"

Тийбин амьсгалаа түгжиж, Софигийн хэлсэн саяхь үгэнд ихэд эмзэглэв. "Мэри тийм эмэгтэйбайгаагүй. Эртний сүмийнхний ичгүүргүй явуулгаар түүний талаар ийм толботой ойлголт хүмүүстбий болсон юм. Сүмийнхэн Ариун Грейл буюу Мэри Магдалиний нууцыг нуун дарагдуулахынтулд, бүсгүйг гутаан доромжилсон".

"Түүний нууц гэсэн үү?"

"Би түрүүнд сүмийнхэн Есүсийн тэнгэрлиг байдлыг алдаршуулж, эгэл хүн байсныг далдалж,хүмүүсийг итгүүлэхийг оролдож байсан тухай ярьсан. Тийм болохоор түүний бодит амьдралыгөгүүлсэн, эсвэл цухалзуулсан номлол сургаалыг Библийн судраас үндсээр нь хассан юм. Гэвч аль чномлол сургаалд үргэлж давтагдсан нэгэн нэр байсныг судрыг хянан засварлагчид яаж ч хөндөжчадаагүй гэдэг. Нэр нь дурдагдсан тэр хүн бол Мэри Магдалин байсан юм. Тэр тусмаа бүсгүй ЕсүсХрист хоёр гэрлэсэн байсан юм".

"Юу?" гэж Софи асуугаад, Ландон, Тийбин хоёр луу ээлжлэн харна.

"Энэ бол түүхэнд тэмдэглэгдсэн үйл явдал. Да Винчи үүнийг бүтээлдээ тусгасан байгаа. Нууцатүдэш зурагт Есүс, Магдалин хоёрыг хосууд байсныг дэндүү тод илэрхийлсэн юм шүү

дээ?

Софи зураг руу харна.

"Есүс, Магдалин хоёр толины тусгал шиг өнгө солбиулж хувцсаа өмссөн байгаа биз. Анзаарч байнау!"

Энэ байна. Софи ховстуулсан юм шиг хөдлөлгүй зогсонгоо, зургийг ширтэнэ. Нээрэн тийм байлаа.

Тэд өнгө сөөлжиж хувцсаа өмсжээ. Есүс улаан өмсгөл, хөх нөмрөгтэй, Мэри Магдалин хөх өмсгөл, улаан нөмрөгтэй байх аж. Яг л арга, билэг хоёр мэт харагдана.

"Илүү гүнзгийрвэл, тэр хоёрын сууж буй зайд эмэгтэй хүний бэлгэдэл дүрс харагдах бөгөөд, тэрзайг ойртуулж, хосуудын байрыг солих юм бол, бие биеэ түшиж суусан байдалтай болдог".

У үсэг хэлбэртэй нөгөө дүрс зургийн яг голд байрлах аж.

"Хамгийн сүүлд хэлэхэд, хэрэв чи сайн харвал, бас нэгэн өөр тэмдэгт гарч ирэх болно. Цагаантолгойн үсэг!"

Софи зургийг харлаа. Тэрээр үсгийг олж харсан бололтой, зургийн голд яах аргагүй М үсэг тодронгарч ирэх нь тэр.

"Энэ гайхалтай тохиолдол биш гэж үү?" гэж Тийбин асуув. Софи гайхширч ядна. "Яагаад М үсэгдүрсэлсэн юм бол?" Тийбин мөрөө хавчиж, "Зарим хоосон онолчид үүнийг Мэри Магдалинийнэрний эхний үсэг гэж хэлэх байх. Гэвч одоогоор энэ талаар ямар ч тодорхой тайлбар байхгүй. Хамгийн тодорхой зүйл гэвэл М үсгийг зурагт дүрсэлсэн нь үнэн. Грейлтэй холбоотой дурсгалтзүйлс ил болон далд хэлбэрээр М үсгийг дүрсэлсэн байдаг л даа. Гэхдээ олны өмнө хамгийн ил тоддүрслэгдсэн нь, Парисын Дарь Эхийн сүмийн индэр дээрх М үсэг юм. Үүнийг Сионий Прайорийнтэргүүн байсан алдарт зураач Жон Кокту урлаж үлдээсэн гэдэг".

Софи Тийбиний хэлсэн бүгдийг цэгнэж үзсэнийхээ дараа, "Би лав Есүсийг Магдалинтай гэрлэсэнгэдгийг М үсгээр баталж нотолсон зүйл харахгүй л байна даа!" гэж Тийбинд хэлэв.

"Байз, байз. Хараахан болоогүй байна!" гээд Тийбин ширээ рүүгээ очиж, "Есүс, Магдалин хоёрынгэрлэлт түүхэн бодит байсныг би өмнө хэлсэн" гэв.

Тийбин ширээн дээр хөглөрсөн олон номоо онгичиж, "Есүсийг ганц бие хүн байсан гэхээс илүү гэрбүлтэй байсан нь түүхэн сурвалжид тодорхой гардаг".

Яаж тэр вэ?" гэж Софи шалгаав.

"Учир нь Есүс бол еврей хүн байсан" гэж Тийбинийг номоо хайх зуур Ландон хэлээд, "Тэр үеийнэс заншлаар бол Еврей хүн ганц бие байх нь зохисгүй хэрэг байсан юм. Еврейн ёсоор бол сахилхүртэхийг зэмлэн буруушааж, еврей хүний гол үүрэг нь сайн хүүтэй болохын тулд, өөртөөтохирсон эмэгтэйтэй гэрлэх явдал байв. Хэрэв Есүс гэрлээгүй байсан бол, Библийн сударт түүнийгяагаад ганц бие байсан талаар заавал тайлбарлах ёстой байсан юм. Гэвч тэгээгүй".

Тийбин том гэгчийн номыг ширээн дээрээсээ олоод, өөртөө ойртуулж өнцгөөс нь чангаав. Савхингадар хавтастай, зурагт хуудасны хэмжээтэй, яг л атлас шиг том ном байв.

Нэрийг нь харвал "Гностийн сургаал" гэсэн байв.

Тийбинийг номоо сөхөн онгойлгоход, нөгөө хоёр дэргэд нь очив. Софиг харсаар байтал папирусцаасан дээр гараар бичигдсэн эртний баримтуудыг томруулсан байдлаар, тодорхой хэсэгчлэнүзүүлсэн, гэрэл зургууд номонд хэвлэгдсэн байв. Софи эртний үсгийг уншиж чадахгүй боловч, нөгөө талын нүүрэнд нь тэдгээр баримтуудын хадмал орчуулга хэвлэгдсэн байхыг олж харав.

"Энэ бол Наг Хаммади болон Сөнөсөн тэнгисийн баримтуудын хуулбарууд. Христийн хамгийнэртний түүхэн баримт. Харин хамгийн ээдрээтэй зүйл бол эдгээр баримтуудын аль нь ч Библийнсургаалтай авцалддаггүй юм".

Тийбин номын гол хүртэл хуудсыг эргүүлснээ, нэг хуудас дээр зогсож, "Энд байгаа Филиппийнишлэлээс эхлэхэд их тохиромжтой байдаг юм" гэв.

Софи хуудсан дээрх мөрүүдийг уншив. Тэнд,

Есүс Христийн анд найз нь Мэри Магдалин. Христ бүсгүйг бусад шавь нараасаа илүүдотночилж, түүний уруул дээр нь үнсдэг байв. Үүнд нь бусад шавь нар ихэд дургүйцэж, эсэргүүцдэг байсан аж. Тэд Есүст, "Та яагаад түүнд биднээс илүү дотно байдаг юм бэ?" гэж асуудаг байжээ.

Софи үүнд мэл гайхсан ч, тэр дор нь дүгнэлт хийж, "Энд гэрлэлтийн талаар огт бичээгүй байнашүү дээ!"

"Эн контгай," гэж хэлэнгээ, Тийбин инээмсэглээд, эхний мөрийг зааж, "Судлаачид анд найз гэдэгбол тэр үед хань ижил гэсэн утгатай хэрэглэгдэж байсан гэдгийг чамд хэлээд өгнө".

Ландон ч түүний хэлснийг дэмжиж, толгой дохилоо.

Софи эхний мөрийг дахин уншив.

Есүс Христийн анд найз нь Мэри Магдалин.

Тийбин хуудсыг дахин эргүүлж, бусад өгүүлбэрийг Софид үзүүлэхэд, Есүс, Магдалин хоёр дотнохарьцаатай байсан нь улам тодорхой болов. Тэдгээр ишлэлийг уншсан, Софи түүнийг дундсургуульд байхад, уурлан догширсон нэгэн ламтан өвөөг нь сураглаж гэрт нь ирснийг санав.

Софиг хаалгаа тайлангуут, "Энэ Жак Сониехийн гэр мөн үү?" гэж тэр ламтан шууд асуусан аж. "Саяхан нийтэлсэн өгүүллийнх нь талаар өвөөтэй чинь ярилцах гэж ирлээ" гээд гартаа базсансононоо охинд ууртайгаар үзүүлсэн аж.

Софи өвөөгөө дуудаж, өвөө нь ламтныг дагуулан өрөөндөө орсон юм.

Өвөө сонинд өгүүлэл бичсэн юм байх даа? гэж бодоод, Софи тэр даруй гал тогооны өрөө рүүгээгүйж ороод, өглөөний сонинг гарчиглан харлаа. Сонины 2 - р нүүрэн дээр саяхан Америкчуудынхийсэн "Есүсийн сүүлчийн хүсэл" хэмээх киног Есүс Мэри Магдалин гэгч эмэгтэйтэй үүлэнборооны ажил хийж байгаа хэсгээс нь болж, сүмийнхний дарамт шахалтаар Францын засгийн газартус киног гаргахыг хориглосныг, өвөө нь эсэргүүцэж, нийтлэл бичсэн байлаа. Өвөө нь киногаргахыг хориглож байгаа сүмийнхний шийдвэрийг утгагүй явдал гэсэн байв.

Ламтан уурлах нь аргагүй л юм гэж Софи бодлоо.

"Энэ чинь шүтээнийг бузарласан порно кино шүү дээ!" гэж ламтан хашхираад, үүд рүү дөхөнгөө. "Та ийм зүйлийг яаж хүлээн зөвшөөрч чадаж байна аа! Энэ Мартин Скорзес гэгч Америк хүн болбурхан шүтээнээ бузарлагч амьтан. Сүмийнхэн түүнийг Францад нэвтрэхийг

хэзээ чзөвшөөрөхгүй!" гээд хаалга саван гарч одсон юм.

Өвөө нь гал тогоонд орж ирэхийг ч анзааралгүй, Софи сониныг уншиж байв.

"Сэргэлэн шаламгай охин шүү!" гээд өвөө нь ач охиноо өхөөрдөв.

"Есүст найз охин байсан юм уу?" гэж бяцхан Софи өвөөгөөсөө асуув.

"Үүнд гол учир нь байгаа юм биш. Харин би сүмийнхэн юуг хязгаарлаж болохгүйг л анхааруулжсануулсан юм.

"Есүст тэгээд найз охин байгаагүй юм уу?"

Өвөө нь хэсэг чимээгүй байснаа, "Найз охинтой байсан бол муу хэрэг гэж үү?"

Софи мөрөө хавчаад, "Би л лав тэгж бодохгүй байна, өвөө".

Лей Тийбин ярьсаар л байв. "Би чамайг Есүс, Магдалин хоёрыг холбоотой байсныг нотолсон өөрбаримтуудаар булж, залхаамааргүй байна. Энэ бол өнөө үеийн түүх судлаачдын хийх ёстой ажил. Харин түүний оронд үүнийг чамд үзүүлмээр байна" гээд, нэгэн хуудас дээрхийг хуруугаараа заав. "Энэ бол Мэри Магдалиний тухай юм".

Софи хуудсыг уншив.

Эзэн биднээс ухаан мэдлэг дутуу, тэр өчүүхэн эмэгтэйтэй дотночлон ярилаа гэж үү? Бидэмэгтэйг дагаж, түүний хэлснийг сонсох гэж үү? Эзэн түүнийг биднээс илүү үздэг гэж үү? гэжПетрийг асуухад, Леви хариуд нь,

Петр, чи дандаа л оволзож байх юм. Чи эмэгтэй хүнийг дайснаа гэж үзэх ямар хэрэг байна! Эзэн түүнийг таалсан бол, чи түүнийг ад үзэх хэрэг байна уу? Эзэн түүнийг сайн мэддэгболоод л түүнд биднээс илүү дотно байдаг биз.

"Тэдний ярианд гарч буй эмэгтэй бол Мэри Магдалин. Харин Петр түүнд өс санадаг байсан байна".

"Есүс Мэриг дотночилдог болохоор тэр үү?"

"Ганц үүнд ч биш. Сургаал дээр Есүс өөрийгөө баригдаж, цовдлуулна гэдгээ мэдэж байсан тухай өгүүлдэг. Тиймээс түүнийг үхсэний дараа сургаал, сүмийн үйл хэргийг нь цааш хэрхэнүргэлжлүүлж авч явах зааврыг Есүс Мэри Магдалинд өгсөн байна. Петр мэдээжээр үүнддургүйцэж, шударга бус явдлыг хоёр удаа гаргасан байна. Зүрхэлж хэлэхэд, Петр бол гаж донтонбайсан".

Софи түүний яриаг тасалж, "Петр гээд байгаа чинь Есүсийн сүмийг босгосон Гэгээн Петр бишбиз?"

"Тиймээ. Мөн. Гэхдээ үнэнээс гажуудсан нэг зүйл бий. Есүсийн сүмийг гардан барих зааврыг Петрөгөлгүй, харин тэр үүргийг Мэри Магдалинд хүлээлгэсэн байж".

Софи түүн рүү ширтэн, "Христийн сүмийг эмэгтэй хүн барьсан гэх гээд байна уу?"

"Энэ бол анхнаасаа төлөвлөгдсөн зүйл. Есүс эмэгтэй хүнийг шүтдэг байсан. Тиймээс түүнийбайгуулсан сүмийг цааш Мэри Магдалиний мэдэлд өгөхийг эрмэлздэг байсан" гээд Тийбин түрзнав.

"Гэтэл Петр үүнд саад болохоор байв" гээд Ландон тэдний ярианд орж, "Нууцат үдэш

рүү" заагаад, "Петр тэр байна. Магдалинд ханддаг байсан Петрийн уур хорслыг Да Винчи дүрслэхээ мартаагүй".

Софи мэл гайхан, цэл хөхөрнө. Зураг дээр Петр Мэри Магдалиний зүг хараад, бүсгүйн хүзүүний харалдаа гараа өндөрт өргөсөн байв.

"Өөр бас нэг эвгүй, ёрын зүйл наана чинь бий" гэж Ландоныг хэлэхэд, Софи тэр хэсэгт нүдээнийлгон харав.

"Тэр чинжаал хутгатай юм шиг гар уу?"

"Тиймээ. Сонин байгаа биз дээ. Хэрэв зураг дээрх гарыг тоолоод үзвэл, энэ гар үнэндээ хэнийх чбиш. Эзэнгүй гар. Тааварлашгүй сонин байгаа биз?"

Софигийн дотор нь эвгүйтэж, агдасхийв. "Уучлаарай! Энэ бүхэн тэгээд Мэри Магдалинийг АриунГрейл байсныг илэрхийлж байгаа юм уу?"

"Аа, нээрээ тийм!" гэж Тийбин хашхираад, "Энд гол хүндрэл нь оршиж байгаа юм!"

Тийбин ингэж хэлээд, ширээн дээр том цаасыг дэлгэн тавьж, Софид үзүүлэв.

Энэ бол маш дэлгэрэнгүй хөтөлсөн угийн бичиг байлаа.

"Маш цөөхөн хүн Мэри Магдалинийг Есүсийн баруун гарын хүн байсны зэрэгцээ, хүчирхэгнөлөөтэй эмэгтэй байсныг мэддэг юм".

Софи угийн бичгийн гарчгийг уншаад, тэр дор нь ухаж ойлгосонгүй. Тэнд "Бенжаминий овог" гэсэн байлаа.

"Мэри Мадгалин энд байна" гээд Тийбин угийн бичгийн дээд хэсэгт заав.

Софи гайхширч дууссангүй. "Мэри Магдалин Бенжаминий гэр бүлээс гаралтай байх нь ээ?"

"Яг зөв. Мэри Магдалин бол язгууртны удам угсааны хүн байсан юм".

"Магдалинийг ядуу гэр бүлээс гаралтай гэж боддог байсан юмсан".

Хариуд нь Тийбин толгойгоо сэгсрээд, "Магдалинийг биеэ үнэлэгч болгож өөрчлөхийн тулд, түүнийг ядуу гэр бүлээс гаралтай гэж худал зохиосон юм".

Софи Ландон руу хартал, тэрээр бас л толгой дохиж байв.

Софи Тийбин рүү хандаж, "Тэгвэл яагаад язгууртны удам угсаа болсон Мэри Магдалинийг сүмийнхэн харж хандаагүй юм бэ?"

Англи эр инээмсэглээд, "Хонгорхон минь, ганц Мэри Магдалин ч биш, бас түүний нөхөр Есүс Христ өөрөө язгууртны үр удам байсан юм. Мэттюгийн бичсэнээр бол Есүсийг Давидийн гэрбүлээс гаралтай гэдэг. Давид бол Соломон хааны үр сад байгаа юм. Хүчирхэг гэр бүлүүдийн үр садхоорондоо гэрлэснээр, Есүс Соломон хааны угсааг таслалгүй цааш үргэлжлүүлж, бат бэх хаанширээний үндэс суурийг тавихаар эртнээс бодож боловсруулсан байсан юм".

Софи Тийбинийг гол санаандаа орох гэж байгааг түүний нүүрнийх нь хувирлаас анзаарав. Тийбиний нүд баяр хөөртэй харагдана.

"Ариун Грейлийн тухай түүх бол, язгууртнуудын угсааны тухай түүх юм. Хүмүүс

Грейлийн тухайдурсахдаа, "Христийн цус бүхий аяга" гэж ярилцдаг нь, Есүсийн цусан удам угсааг авч хадгалсанМэри Магдалиныг битүү утгаар хэлж буй хэрэг юм".

Тийбиний хэлсэн үгс танхимаар нэг цуурайтаж, тэр тоолонд Софигийн сэтгэлд гүн гүнзгий шингэхаж.

Есүс Христийн цусан угсааг залгамжилсан Мэри Магдалин гэв үү!

"Гэхдээ Есүс Христ цусан угсаагаа яаж ...?" гэвэл, Ландон зөөлнөөр инээмсэглэж, "Тэдний дундаасхүүхэд төрсөн" гэж дор нь хариулав.

Софигийн бие тэр дороо хөшчихөв.

"Сэрцгээ!" гэж Тийбин хашхираад, "Энэ бол хүн төрөлхтний түүхэн дэх хамгийн гайхамшигтайнууц. Есүс зөвхөн нөхөр биш, бас эцэг хүн байсан, хонгор минь. Мэри Магдалин бол дарханухаантай эмэгтэй байсан юм шүү! Тэр бүсгүй үнэхээр Есүсийн хойч үеийг үргэлжлүүлж чадсан. Тэр бол Есүсийн залгамж, хойч үеийг үүрч гарсан, асар гавьяатай ариун эмэгтэй байсан юм".

Софигийн ар дагзны ус босох шиг болж, "Ийм онцгой үйл явдал энэ олон жил яаж нууцалж чадаваа?" хэмээн арайхийн асуув. Тэнгэр минь!

"Есүс Христийн хойч үе өөрөө Ариун Грейлийн түүхийн эх сурвалж байсан. Магдалиний түүхолом зууны тэртээгээс зүйрлэл болон ёгт утгаар, бүх хэлэнд хөрвүүлэгдэн нэвтэрч, бидний эргэнтөйронд хаа сайгүй оршсоор ирсэн. Бид зөвхөн нүдээ нээхэд л хангалттай".

"Сангрийлийн баримтууд яасан юм бэ? Тэдгээр баримтуудад Есүсийн хойч үеийн тухай өгүүлсэнбайдаг уу?"

"Тийм ээ".

"Тэгэхээр Ариун Грейлийн түүх бол язгууртнуудын хойч үеийн тухай түүх болж таарах нь ээ?"

"Яг зөв. Сангрийль гэх үг San Greal эсвэл Ариун Грейлээс гаралтай үг. Гэхдээ эртний бичлэгторуулбал, ийм хоёр үгнээс бүтсэн юм шүү дээ!" гээд Тийбин цаасны тасархай авч, дээр нь бичээд, Софид өгөв. Бүсгүй түүнийг нь авч уншвал, "Sang Real гэсэн байлаа.

Софи тэр үгийг уншсан дороо утгыг нь ойлгов.

Нээрээ Sang Real гэдэг чинь язгууртны цус гэсэн утгатай шүүдээ!

Мэри Магдалин, Петр хоёр

Хэсэг 59

Нью - Йоркийн Лексинтоны өргөн чөлөө. Опус Дейн удирдлагын төв.

Хүлээн авахын ажилтан хамба лам Арингарозаг гэнэт утагтсанд ихэд гайхав.

"Оройн мэнд, эрхмээ!"

"Намайг сураглаж хүн утагтсан уу?" гэж хэлэхдээ, хамба ламын дуу түгшүүртэй сонсогдоно.

"Тиймээ, эрхэм ээ! Та залгасан нь сайн болжээ. Би тантай холбогдох гээд чадахгүй байлаа. Тандхагас цагийн өмнө яаралтай дуудлага ирсэн".

"Тэгээд?" гэж асуухдаа, хамба арай сэтгэл амарсан бололтой, "Хэн гэдгээ хэлсэн үү?"

"Үгүй ээ, эрхмээ. Зөвхөн утасны дугаараа үлдээсэн" гээд хүлээн авахын ажилтан дугаарыг түүнддамжуулж хэлэв.

"Францын код 33 байдаг байх аа?"

"Тиймээ, эрхэм ээ. Шууд Паристай холбогдох код. Тан руу ярьсан хүн маш яаралтай хэрэг гэсэншүү!"

"За, Баярлалаа! Би ярихыг нь хүлээж байсан юм" гээд Арингароза утсаа шууд тасалчхав.

Хүлээн авахын ажилтан утсаа тавихдаа, Арингарозагийн дуу нь яагаад тасалдаж дуугараадбайсныг ойлгосонгүй. Ойрын үед хуваарь ёсоор Арингароза гадагш гарахгүй гэж байсан боловч, сая болохоор харь гаригийн шугамаар ярьж байгаа юм шиг паржигнаад байсанд, хариулагчгайхсаар хоцорлоо. Арингарозагийн сүүлийн үед гаргаж буй ааш араншин түүнд их л сонин, хачирхалтай санагдах болжээ.

Миний утас болохгүй байсан юм байна? гэж Арингарозаг бодох зуур, түүний хөлөглөсөн фиатмашин ромын "Чиапино чартр" нисэх онгоцны буудал дээр ирлээ. Багш надтай холбогдох г эжоролджээ.

Багш Арингарозатай гар утсаар нь холбогдож чадаагүй болохоор, Дей руу ярьсан байх нь гэж хамба таамаглаад, сэтгэл нь арай хөнгөрчээ.

Парис дахь өнөө шөнийн төлөвлөгөө бүтэмжтэй болсон юм байна!

Авсан дугаарыг цуглуулан, утсаар залгангаа, Парист очих тухайгаа бодохоос дотроо ихэдбаярлана.

Би үүр цайхаас өмнө тэнд газардчихсан байх болно.

Тээш ачигчид шөнийн цагаар ажилладаггүй тул, Арингароза хүнд цүнхээ өөрөө барихаас өөраргагүй болов. Утас дуудаж эхэллээ. Гэтэл эмэгтэй хүний дуу сонсогдож,

"Францын Шүүх цагдаагийн газрын лавлах таныг сонсож байна!" гэх нь тэр.

Арингароза тэр дороо тулгамдчихав. Ингэж төсөөлөө ч үгүй байсан юм чинь!

"Аа, за. Намайг энэ утас руу залга гэж дамжуулсан байсан?"

"Күй эгевү?" "Таны нэр?"

Арингароза хариулах эсэхээ мэдэхгүй, түр тээнэгэлзэв. *Францын Шүүх цагдаа гэнэ үү!*

"Таны нэр, эрхэм ээ?" гэж эмэгтэй дахин шалав.

"Хамба лам Мануэль Арингароза".

"А момун!" (Түр хүлээгээрэй) гээд товчлуур дарах дуу сонсогдож, шугам түр тасалдав.

Удтал хүлээсний дараа нэг хүн харилцуур дээр ирээд, хүнгэнэсэн дуугаар, "Хамба ламтан уу?Тантай ярьж байгаадаа таатай байна. Бид сайтар ярилцах хэрэгтэй болоод байна".

Хэсэг 60

Сангрийль ... Sang Real ... Sang Creal ... Язгууртны удмын цус ... Ариун Грейл.

Эд бүгд хоорондоо нарийн уялдаа холбоотой байлаа.

Ариун Грейл гэдэг нь Мэри Магдалин. Өөрөөр хэлбэл Христийн удмыг үргэлжлүүлсэн эх хүнбайсан.

Софи сүүлдээ бүр төөрөлдөж гүйцээд, Роберт руу харав. Тэд Софид олон зүйл дэлгэж, нарийнтайлбарлах тусам, бүсгүйд улам л төвөгтэй, ээдрээтэй болоод байх аж.

"Хонгор минь," гээд, Тийбин номын тавиур луу хазганасаар очихдоо, "Леонардогоос гадна АриунГрейлийн үнэн түүхийг хүмүүст хүргэхийг хүссэн өөр хүмүүс бас байсан юм шүү! Есүс Христийнудмын залгамжийг бичиж үлдээсэн хэд хэдэн түүхчид байдаг" .

Тэрээр тавиур дээрх номуудыг хуруугаараа гүйлгэн, тэмтэрч харна. Софи толгойгоо тэдгээрномуудын ар дахь нэрийг гүйлгэж уншив.

ОЛОНД ИЛ БОЛСОН ХОЛБОО :Есүс Христийн жинхэнэ дүрийг сахин хамгаалагчид

ШОХОЙН ХӨШИГНИЙ ЦААДАХ ЭМЭГТЭЙ :Мэри Магдалин,Ариун Грейл

СУРГААЛД БИЧИГДЭЖ, ТҮҮХЭНД ҮЛДСЭН ДАРЬ ЭХ :Ариун шүтээнийг эргүүлэн залах нь ГЭХ МЭТ ...

"Энэ боть ном бол хамгийн алдартай нь" гээд, Тийбин хуучирч, үзүүр нь салмарсан, хатуухавтастай том ном гаргаж, бүсгүйд өглөө. "Ариун цус, Ариун Грейл" гэсэн нэртэй ном байлаа."Дэлхий даяар хамгийн ихээр борлогдсон ном" гэж хавтсан дээр нь бичсэн байв.

Софи гайхаж, "Дэлхийд хамгийн ихээр борлогдсон гэнэ үү? Би энэ номын тухай ерөөс дуулаагүйюм байна?"

"Чи тэр үед балчир охин байсан байх л даа. Учир нь энэ бол 1980 - аад онд хамаарах бүтээл байгааюм. Зохиогчид дүгнэлт шинжилгээндээ баахан дулимаг загнасан боловч, ерөнхий санааныхаа чигхандлагыг зөв тийш нь залж чадсан ном доо, наадах чинь".

"Сүмийнхэн энэ номонд яаж хандсан бол?"

"Уур хилэн цухалзуулахгүй өөр хаачхав. Ингэх л ёстой юм чинь Нийтийн тооллын 4 - р зуундВатиканчуудын нуун далдалсан, нууцыг ил гаргаж бичсэн анхны ном бол энэ байгаа юм.

Энд Загалмайтны аян дайны тухай өгүүлдэг. Баримтуудыг цуглуулан хурааж, устгаад л. Харин Мэри Магдалины Есүсийн захиасын дагуу сүмийг хөгжүүлж, түүний үр ач нарыг өсгөн бойжуулж байсан цаг. Гэтэл сүмийнхэн өөрсдийгөө хамгаалахын тулд Магдалины сүр хүчийг бууруулж, түүний дүрийг янхан болгон хувиргаж, түүний Есүстэй холбоотой байсан бүх нотолгоо, баримтуудыг далдалсан юм".

Тийбин цааш, "Үүний баталгаа өөрөө маш аймаар. Гэхдээ эхлээд Сүмийнхэн тэр нууцыг хэрхэндалдлан хадгалсан тухай мэдэх хэрэгтэй. Христийн цусан удмынхны тухай хүмүүс мэдэж байгаацагт, сүмийнхэн хэзээ ч аврагдахааргүй байсан юм. Есүсийн төрсөн хүүхэд Христийн тэнгэрбурхан хэмээх шүтлэгийн ойлголтыг нураах байсан учир, Христийн сүмийнхэн диваажин руухүрэх замыг ганц тэднээр дамждаг хэмээн олонд зарлахад хүрчээ".

"Таван талт сарнай байна!" гэж Софи хэлээд Тийбиний нэг ном руу заав. Номон дээр х сарнайндүрс модон хайрцган дээр байсантай адил байв.

Тийбин Ландон руу харж, жуумалзан "Хатагтай ч нүдтэй юм аа!" гээд, Софи руу эргэж, "Зм з бол Грейлийг сахин хамгаалагч бүлэглэл - Сионий Прайорийн бэлгэдэл Мэри Магдалинийг басилэрхийлж байгаа гэсэн үг. Учир нь сүмийнхэн түүний нэрийг бичиж тэмдэглэх, мөн дурдажхэлэхийг хатуу хориглодог байсан. Иймээс бүсгүйг нууц нэрээр дууддаг болсон юм. Аяга, Ариун Грейл, бас Сарнай гэх мэт" гээд. Тийбин түр азнаснаа, "Сарнай бас Таван хошуу дүрсийг илтгэдэг юм. Мен сарнай нь Сугар гариг болон Луужин Сарнайтай нягт холбоотой. Нөгөө талаар олонхэлэнд (Англи, Франц, Герман гэх мэт) сарнайг нэг л үгээр хэлдэг. Rose гэж! Бас Сарнай (Rose) бол Грекийн дур хүсэл, дурлалын бурхан Eros гэдэг үгийн анаграмм байгаа юм".

Софи Ландон руу гайхан харахад, Тийбин бүсгүйн анхаарлыг татах гэж оролдон, "Сарнай болэмэгтэй хүний дур хүслийг байнга илтгэсээр ирсэн. Эртний шашны урсгалуудад таван талт сарнайгэмэгтэй хүний амьдралын 5 үе шатаар төлөөлүүлж үздэг байв. Төрөх үе, шилжилтийн (өсвөр) үе, эххүн болох үе, цэвэрших үе, үхэх үе. Гэвч одоо үед сарнайг оюун санааны хүрээнд илүүтэй авчүздэг болсон байна".

Тийбин Ландон руу харж, "Тэмдэгт судлаач гуай энэ талаар илүү тайлбарлах байх?!" гэлээ.

Роберт тулгамдаж, нэлээд улаан дуугүй зогсов.

"Ээ тэнгэр минь!" гэж Тийбин эгдүүцээд, "Америкчууд та нар шиг бүдүүлэг хүмүүс энэ дэлхийдбайхгүй" гээд Софид хандаж, "Роберт чамд юу хэлэх гэж дүлэгнээд байна вэ гэвэл, дөнгөждэлбээлж буй сарнай нь эмэгтэй хүний умайг бэлгэддэг юм. Ертөнцийн бүх эр хүн тэр сүржавхлангийн орон руу нэвтэрч ордог шүү дээ! Хэрэв чи Жоржиа О'Кифийн зургуудаас нэгийг нь ч болов харсансан бол, миний юу гэж хэлэх гээд байгааг бүрэн ойлгох болно".

"Энэ номын тавиур дээрх бүх номууд нэг л зүйлийг нотлох гэж энд байгаа юм" гэж хэлээд, Ландонномын тавиур луу эрүүгээрээ заав.

"Есүс эцэг хүн байсан гэдгийг нотлох гэж" хэмээн Софи өөрийнхөө дүгнэлтийг итгэл муутайханхэлэв.

"Тиймээ. Мэри Магдалинийг Есүсийн удам угсааг авч явсан гэдгийг нотлох гэж одоог

хүртэлСионий Прайори түүнийг Дарь эх, Ариун Грейл, Сарнай, Тэнгэр ээж хэмээн бишрэн шүтсээр лбайгаа".

Софид өнөөх нууцлаг ёслолын тухай дурсамж дахин сэргэв.

Тийбин яриагаа үргэлжлүүлж, "Есүсийг цовдлогдох үед, Мэри Магдалин бие давхар байсан гэдэг. Хэвлий дэх хүүхдээ аварч гарахын тулд, бүсгүй Ариун газар (Иерусалим) - г орхиж зугтсан гэдэг. Есүсийн авга ах Жозефийн (Иосиф) тусламжтайгаар Мэри Франц руу дүрвэж, тэндээ Еврей айлдамьдрах болжээ. Бүсгүй энд, Францад нярайлж, охинтой болсон юм. Ингээд охиндоо Сара гэдэгнэр хайрлажээ".

"Охины нэр бас тодорхой байдаг юм уу?"

"Тэгээд ч зогсохгүй, Магдалин, Сара хоёрын түүхийг тэднийг сахин хамгаалагч Еврей нардэлгэрэнгүй бичиж үлдээсэн. Магдалиний төрүүлсэн охины судсаар Еврейчүүдийн их хаад болох Соломон, Давид хоёрын цус гүйж байсныг санаарай! Иймээс Францад байсан Еврейчүүд Магдалинийг язгууртны цэвэр удмын үндсийг тавигч хэмээн ихэд бишрэн хүндэлж байсан аж. Маш олон түүхчид Мэри Магдалиний Франц дахь өдөр тутмын аж амьдрал болоод, угийн бичгийг хөтлөн, бичиж үлдээсэн байдаг".

Софигийн царай гэрэлтэж, "Есүс Христийн угийн бичиг байдаг юм уу?"

"Тэгэлгүй яахав. Сангрийлийн баримтуудад үүнийг нотолсон байх ёстой. Тэнд л Христийн удмынхныг бүгдийг нь багтаасан угийн бичиг байгаа".

"Христийн угийн бичгийг тэнд байгаа гэж хэн нотолж байгаа юм бэ? Энэ чинь яг нотлогдоогүй зүйл шүү дээ! Түүхчид ч үүнийг жинхэнэ гэж нотолж чадахгүй".

Тийбин хүд хүд инээж, "Библийн судрыг жинхэнэ гэж нотолж бас чадахгүй шүү дээ!"

"Учир нь?"

"Учир нь ялан дийлэгчид л түүхийг бичдэг юм. Хоёр өөр соёл иргэншил хоорондоо мөргөлдөхөд, ялагдсан тал сүйрэн унаад, ялагчид түүхийг өөртөө ашигтайгаар бичиж үлдээдэг. Наполеон ч гэсэн "Түүх бол үнэмшилтэй худал яриа" гэж хэлсэн байдаг шүү дээ!" гээд инээмсэглэж, "Түүх үргэлжнэг талд үйлчилсээр ирсэн гэдэг л бүхнээс үнэн" гэв.

Софи өмнө нь энэ талаар огт эргэцүүлж байгаагүй юм.

"Сангрийлийн баримтууд Христийн түүхийг өөр талаас нь өгүүлдэг. Аль түүхийг нь хүмүүс илүүмэдэж байна, тэр л итгэл үнэмшлийн чиг хандлага болж байсан. Гэхдээ Сангрийль өдийг хүртэл үлдэж хоцорсон нь чухал. Сангрийлийн баримт бол олон мянган хуудсаар тоологдох маш их мэдээлэл агуулсан баримт. Нүдээр харсан гэрчүүдийн ярьснаар, дөрвөн том авдраар дүүрэн баримт байсан гэдэг. Үүнд олон мянган хуудас нь огт өөрчлөгдөөгүй, хэвээр байгаа Пуристийн баримтууд, Есүсийн дагалдагчдын бичсэн, Константинаас өмнөх үеийн баримтууд багтдаг. Мөн цуу үг байж болох ч, Q хэмээх баримт гар бичмэл хэлбэрээр хадгалагдсаар байгаа гэж ярьдаг. Бараг үнэний ортой ч байж болох нэг зүйл бол Есүс үүнийг өөрийн гараар бичсэн гэж хүмүүс ярьдаг".

"Христийн өөрийнх нь бүтээл гэж үү?"

"Тийм. Есүс яагаад өөрөө бичсэн байж болохгүй гэж? Илүү шуугиан тарихаар зүйл бол Мэри Магдалиний өдрийн тэмдэглэлийн гар бичмэл нь Сангрийлийн баримтуудтай хамт байгаа гэдэгт хүмүүс итгэдэг. Мэри Магдалин Есүс Христ хоёрын хувийн нууц ч энд байгаа".

Софи удаан гэгч дуугүй суув.

"Тэгвэл тэдгээр 4 авдар нууц баримтыг Хөлөг Баатрууд Соломон хааны сүм дороос олж гаргасан юм уу?"

"Яг тийм. Хөлөг баатруудыг хүчирхэг болгосон зүйл бол тэр баримтууд.

Тэр баримтуудын төлөөх эрэл бүх түүхийн цаг үеийн турш Грейлийн эрэл хайгуул нэрийн дорүргэлжилсээр байна".

"Гэхдээ та Ариун Грейл өөрөө Мэри Магдалиин гэж хэлсэн шүү дээ! Хүмүүс баримтыг хайжбайхад, та яагаад Ариун Грейлийн эрэл хайгуул хийж байгаа гэж яриад байгаа юм бэ?"

Тийбиний харц зөөлөрч, "Ариун Грейлийн нуусан газарт бунхан байдаг юм".

Энэ үгийг хэлэх үед, шилтгээний цонхны цаана, салхинд ганхах модны мөчрүүд шуугин улих ньсэтгэл сэрдхийм сонсогдож байв.

Тийбин дуугаа улам намсгаж, "Үнэндээ Ариун Грейлийг эрж байгаа нь, Мэри Магдалиний бунхандмөргөж, адис авах гэсэн хүсэл эрмэлзэл байгаа юм. Мартагдсан Ариун шүтээнийхээ өмнөнаманчлан мөргөх гэсэн тэр хүсэл, тэмүүлэл!"

Софи маш ихээр цочирдож, "Ариун Грейлийг нуусан газар тэгээд... үнэндээ... булш байх нь ээ?"

Тийбиний нүдийг гуниг бүрхэх шиг болов. "Тиймээ. Мэри Магдалиний булш - түүний үнэн түүхийгагуулсан бунхан. Ариун Грейлийн эрэл хайгуул бол хилсээр гүтгэгдсэн, Магдалиин хатан үнэнтүүхтэйгээ цуг булшлагдсан тэр л сүр хүчний төлөөх эрэл хайгуул юм".

Тийбинийг эргэж хэвэндээ орох хүртэл, Софи хэсэг зуур хүлээхээс аргагүй болов.

Софи эцэст нь, "Прайорийн гишүүд өнөөдрийг хүртэл Сангрийлийн баримт, Мэри Магдалинийбунхныг сахин хамгаалж байгаа юу?"

"Тийм. Гэхдээ бүлэглэлийн гол үүрэг бол Христийн цусан удмыг таслахгүй цааш үргэлжлүүлэн авчявах. Христийн үр удам мөнхийн аюул занал дор байсаар ирсэн. Учир нь Христийн үр хойч үржинолширвол, Католикийн хоосон онол үндсээрээ замхарч, Тэнгэр бурхны эмэгтэй хүнтэй нийлдэггүй, дур тачаалыг огоордог гэсэн явуургүй үзэл нуран унахаас сүмийнхэн маш их эмээсээр ирсэн. Тиймхэдий ч түүний үр сад Францад аажмаар өсч өндийсөөр, нийтийн тооллын 5 - р зуунд онцгойтүүхийг эхлүүлсэн юм. Энэ нь тэд Францын язгуур угсааныхантай ураглаж, Меровингийн овгийгбий болгосон явдал юм". Түүний хэлсэн үг Софиг гайхшруулав.

Францын дунд сургуулийн бүх сурагчдад "Меровингийн удам Парисаас гаралтай" гэж заадаг юм.

"Тиймээ. Ийм л учраас Францад Грейлтэй холбоотой олон зүйл байдаг юм. Грейлийг хайсанВатиканы бүх эрэл хайгуул язгууртны удмыг таслах, ор мөргүй болгоход чиглэж байсан. ЧиДагоберт хааны тухай урьд нь сонссон уу?"

Софи тэр нэрийг сайн санахгүй байгаа ч, зэрлэг балмад явдалтай холбоотой гэж түүхийн хичээлдээр зааж байсныг бүдэг санав.

"Дагоберт Меровингийн хаан байсан юм уу? Унтаж байхдаа хүнд хорлогдож, нүдээ сохлуулсангэж ярьдаг?"

"Яг тийм. Ватиканы Пепин д'Херисталын явуулгаар хорлогдсон юм. Лагобертийг 7 - р зуунысүүлээр нас барахад, Меровингийн удам тасрах шахсан юм. Азаар түүний бага хүү Сигисбертнууцаар зугтаж, өөрийн удмыг аварсан гэдэг. Тэрээр сүүлд Годафрой Булон хэмээх нууц нэрээр Сионий Прайорийн бүлэглэлийг үүсгэн байгуулсан юм. Тэрээр Хөлөг баатруудад Соломон хаанысүмээс Сангрийлийн баримтуудыг олж авчрах үүрэг өгч, Есүс Христийн үр удам гэдгээ өөрийн

биеэр батлах боломжийг өөртөө гаргасан юм" гэж Ландоныг хэлэхэд, Тийбин толгой дохиж, удаанаар шүүрс алдаад,

"Сионий Прайорийн одоогийн үүрэг бол тодорхой. Нэгд, Сангрийлийн баримтыг хадгаланхамгаалах; хоёрт, Мэри Магдалиний бунхныг хамгаалах; гуравт, өнөөдрийг хүртэл хэлх ээ ньгасраагүй, Христийн удмын хойч үеийг нүдний цөцгий мэт хайрлан хамгаалах".

Эдгээр үгс Софид хоногшиж, жинхэнэ үнэнийг яс махандаа тултал ойлгосон мэт бүсгүйдсанагдана. Софигийн чихэнд өвөө нь шивнэх шиг болно. "Би чамд гэр бүлийн тухай үнэнийг хэлэхгэсэн юм!"

Бүсгүй голдоо ортол айн жихүүцэв.

Язгууртны удмын цус. Итгэмээргүй юм!

Софи гүнж!

"Ноён Лей?" гэх үйлчлэгчийн дуу ханан дахь дохиоллын системээр паржигнах нь дуулдав.

Софи цочин давхийж, огло үсрэв.

"Та гал тогооны өрөөнд түр хүрээд ирэхгүй юу?"

Тийбин зохисгүй үед төвөг удсан, гэрийн үйлчлэгчдээ уурлан, хөмсөг зангиджээ. Тэр дохиоллынхарилцуур луу очиж, товчлуурыг дарснаа, "Реми, би зочидтой уулзаад завгүй байгааг чи мэдэжбайгаа. Гал тогоонд асуудал гарсан бол, тэнд нь тэгээд орхичих. Баярлалаа! Баяртай!"

"Та зөвшөөрвөл, би халагдсан ч хамаагүй. Танд хэлэх ганц зүйл байна".

Тийбин улам уцаарлаж, "Тэгээд хэлээч дээ, Реми! Би сонсож байна".

"Энэ бол гэр доторх асуудал байгаа юм. Зочдын дэргэд хэлж зүрхлэхгүй байна".

Тийбин огт эргэлзэлгүйгээр, "Өглөө болтол хүлээж болохгүй юу?"

"Үгүй ээ, эрхмээ. Миний хэлэх зүйл тун удахгүй".

Тийбин нүдээ эргэлдүүлж байснаа, Ландон, Софи хоёр луу ээлжлэн харж, "Би заримдаа хэн ньхэндээ үйлчлээд байгааг ойлгодоггүй юм" гээд товчлуурыг дахин дарангаа, "Би удахгүй очлоо. Очихдоо танд ямар нэгэн зүйл аваачих уу, эрхэм ээ?"

"Битгий намайг шахамдуул л даа, эрхэм ээ!"

"Реми, чиний хийдэг амттай стейк л чамайг энд торгоож байгааг, чи мэдэх хэрэгтэй".

"Тиймээ. Би маш сайн мэднэ. Маш сайн мэднэ, эрхэм ээ!"

Хэсэг 61

Софи гүнж!

Тийбиний таягны дуу алгуур бүдгэрэн бүдгэрсээр цааш холдоход, Софигийн бие

зарсхийв. Хамагбие нь хөшсөн чигтээ, Ландон руу эргэн харвал, америк эр түүний бодлыг тааж мэдсэн бололтой, хариуд нь толгойгоо сэгсэрнэ.

"Үгүй дээ, Софи" гэж тэр шивнээд, "Би ч бас нэрийг чинь анх сонсоод, тийм бодол төрсөн. Гэхдээийм зүйл байж болохгүй. Яагаад гэвэл Сониех гэдэг бол Меровингийн удмын нэр биш".

Софи сэтгэл тайвшрах, эсвэл зовнихын алиныг үзүүлэхээ мэдэхгүй болжээ. Ландон бүсгүйнээжийнх нь овгийг Шавель гэдэг байсныг, Софигоос олж мэджээ.

"Шавель овгийн тухайд?" хэмээн бүсгүй Ландоноос догдлон асуув.

Тэр бас л толгой сэгсэрч, "Уучлаарай! Би чиний асуултад тэр бүр хариулж чадахгүй шүү дээ! Гэхдээ Меровингийн удмынхнаас одоо зөвхөн 2 овог үлдээд байгаа. Плантард, нөгөөдөх нь Санткай. Аль аль нь одоо Сионий Прайорийн нууцлал доор амьдарч байгаа байх" гэв.

Софи тэдгээр овгийг амандаа дахин дахин давтан хэлсэн ч, үнэндээ тэдний гэр бүлийнхэн дотортийм овогтой ганц ч хүн байхгүйг мэдэж байв. Луврт байхад, өвөөгийнхөө нууцад ойрхон юм шигтүүнд санагдаж байсан бол, одоо бүр холдчихсон мэт бодогдов.

Өвөө үхэхээсээ өмнө, гэр бүлийнхний минь талаар дурсахгүй байх нь яав даа! Тэд аль хэдийнүхчихсэн шүүдээ. Буцаад ирэхгүй.

Бүсгүйг бага байхад, ээж нь бүүвэйлж унтуулдаг байсан, аав нь мөрөн дээрээ суулгаад явдаг байсан, дүүтэйгээ харцаараа тулгарч тоглоод, инээлдэн хөгжилддөг байсан тэр дурсамжууд түүндбүдэг бадаг санагдана. Гэтэл түүний гэр бүлийнхэн бүгд гэнэт алга болж, өвөөгөөс нь өөр хүнтүүнд үлдээгүй юм.

Одоо өвөө үхчихсэн юм чинь би орь ганцаараа гэсэн үг!

Софи "Нууцат үдэш" дээр нууц байдлаар зурагдсан, Мэри Магдалинийг харахдаа, тэр эмэгтэйхайртай хүнээ алдах гэж байгаа мэт сэтгэгдэл төрүүлж байгааг сая л анзаарав. Софи ч бас тийм л мэдрэмжийг өөртөө тээж яваа билээ.

"Роберт!" гэж намуухан хэлээд, бүсгүй Ландон руу дөхөв.

"Лей Тийбин хэлэхдээ Грейлийн түүх бидний эргэн тойронд, хаа сайгүй оршдог гэсэн. Гэхдээминий хувьд Грейлийн үнэн түүхийг анх удаа л сонсож байна".

Ландон бүсгүйн мөрөн дээр гараа тавьж, тайтгаруулах гэснээ больж, "Чи энэ түүхийг өмнө ньсонссон л байгаа. Бүгд л сонсож байсан. Хүмүүс ганцхан хэзээ сонссоноо л санадаггүй юм".

"Би ерөөсөө ойлгохгүй байна".

"Грейлийн түүх бидний эргэн тойронд далд байдлаар оршиж байдаг. Гутаан доромжлогдсон МэриМагдалиний тухай ярихыг, Сүмийнхэн хориглоход, түүнийг хүмүүс тойруу замаар, ёгт утгаарилэрхийлэх болсон юм. Энэ нь зүйрлэл, бэлгэдэл тэмдэгтийн хэлбэрээр байдаг гэсэн үг. Мэдээжэнэ бүхэн урлагт бас тусгалаа олсон".

Ландон Нууцат үдэш рүү зааж, "Хамгийн төгс жишээ нь энэ байна. Урлаг, утга зохиол, хөгжмийнсонгодог түүхүүд Мэри Магдалин болон Есүсийн түүхийг тойруу замаар өгүүлдэг юм шүү!"

Да Винчи, Вотирами, Пуссин, Моцарт, Бернини, Виктор Гюго хүртэл дарь эх шүтээнийгэрэлхийлсэн бүтээлүүдийг туурвиж байсан. Хүн төрөлхтний аль ч үед хэзээ хуучиршгүй "Ногоонхөлөг баатар", "Артур хаан", "Нойрсож буй гоо бүсгүй" зэрэг үлгэр домгууд бол Грейлийг ёгтутгаар илэрхийлсэн аман зохиолууд юм. Виктор Гюгогийн "Нотр Дамын бөгтөр", Моцартын "Увидаст лимбэ" зэрэг бүтээлүүд Мэйсоны дүрс бэлгэдэл болоод, Грейлийн нууц утга агуулгаар

бялхсан байдаг. Чи Ариун Грейлийг олж харахыг хүсвэл түүнийг хаанаас ч олж харж болно. Уранзураг, Хөгжим, Ном, бүр хүүхэлдэйн кино, алдартай киноноос ч олж мэдэж болно".

Ландон Микки Маустай бугуйн цагаа түүнд харуулж, "Уолт Дисней бол Грейлийн түүхийг хойчүеийнхэндээ өвлүүлж үлдээхийн тулд, бүх л амьдралаа зориулсан хүн".

Диснейг тэр үеийн хүмүүс "Орчин үеийн Леонардо Да Винчи" гэж нэрлэдэг байж.

Да Винчи, Дисней хоёрын аль аль нь цаг үеэсээ хол түрүүлсэн Сэтгэлгээ, хосгүй авьяастнуудбайсан бөгөөд, нууц бүлэглэлийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог, этгээд зантай хүмүүс байсан юм.

Дисней Леонардогийн нэгэн адил нууц дохио, зурвасын бэлгэдэл зэргийг өөрийн бүтээлдээ нэвтшингээдэг байжээ.

Тэмдэгт судлаачийн хувьд түүний хийсэн хүүхэлдэйн киног Ландон нэгэнтээ үзэхдээ, маш олонзүйрлэл, бэлгэдлээр булуулж гүйцсэн юм. Түүний бүтээсэн кинонуудад шашны, шашингүйнүзлийн, дарь эх бурхны түүхийг нэг бүрчлэн үзүүлж илэрхийлсэн байдаг аж.

"Цасан цагаан" хүүхэлдэйн кинонд охин хортой алим идэж гардаг нь, цаад утгаараа Эденийцэцэрлэгээс алим идсэн Еваг дүрсэлсэн байна. Бас "Нойрсож буй гоо бүсгүй", "Аврора гүнжийн" нэрс бол Сарнай гэсэн утгатай бөгөөд, гол дүрийг өтгөн шугуйд нуугдсанаар дүрсэлсэн нь, Грейлийн түүхийг далд хэлбэрээр бяцхан үзэгчдэд үзүүлэхийг зорьжээ.

Тийбиний таягны чимээ хонгил даган наашлах нь сонсогдож эхлэв. Түүний алхаа нь өмнөхөөсөөхурдан байх аж. Гэрийн эзэн танхимд орж ирэхдээ, хахир хүйтэн төрхтэй болсон нь илт мэдэгдэнэ .

"Чи надад өөрөө тайлбарла, Роберт!" гэж Тийбин хүйтнээр хэлээд, "Та нар надад худлаа ярьсан байна" гэж хашхичив.

Хэсэг 62

"Бид хоёрыг цагдаа нар мөшгөж байгаа, Лей!" гэж Ландон тайвнаар хэлэхийг оролдоод, "Чи намайг хүн алах хүн биш гэдгийг мэднэ шүү дээ !"

Тийбиний харц огт зөөлөрсөнгүй. "Роберт, чамайг зурагтаар үзүүлж байна. цагдаа нар чамайг мөрдөж байгааг, та хоёр мэдэж байсан биз дээ?"

"Тиймээ. Би сая хэлсэн шүү дээ!"

"Чи миний итгэлийг эвдлээ. Чи Грейлийн тухай сэдвээр ярилцах санал тавьж намайг хуураад, гэрт минь нэвтэрч орогнох, санаа агуулсан чинь надад аюулд учруулж байна".

"Би хэнийг ч алаагүй!"

"Жак Сониех алагдсан. цагдаа нар чамайг алсан гэж ярьж байна". гээд Тийбиний дуу нь гунигтай болж, "Ийм ч юм болох гэж дээ ...?!"

"Эзээн?" гэж үйлчлэгч эр гэнэт хэлээд, Тийбиний ардаас гарч ирэнгээ, "Би тэднийг

хөөгөөдгаргачих уу?" гэж эрдүү дуугаар асуув.

"Түр хүлээ!" гэж Тийбин хариулаад, танхимын голоор хазганан явсаар, цонхны түгжээг мултланнээж, "Машинаа аваад эндээс явцгаа!" гэж хуягт машиныг бутан дотроос ялгаж харангаа хэлэв.

Софи байрнаасаа хөдөлсөнгүй, түүнийг харж байснаа, "Бидэнд Онъсон чулууны тухай мэдээлэлбайгаа!"

Тийбин түүн рүү удаанаар ширтсэнийхээ дараа, доогтой нь аргагүй инээгээд, "Эцсийн аргаахэрэглэж байна уу? Намайг Онъсон чулууг хайж байгааг, Роберт сайн мэднэ шүү дээ!"

"Софи худал хэлээгүй шүү! Бидний энд ирсэн учир нь ганцхан үүнтэй л холбоотой. Чамтай бидОнъсон чулууны талаар ярилцах гэж ирсэн юм".

Үйлчлэгч эр тэдний ярианд хөндлөнгөөс оролцож, "Эзэн! Тэднийг хөөх үү, эсвэл цагдаа дуудчихуу?"

"Лей!" гэж Ландон шивэгнэх шахам хэлээд, "Онъсон чулууг хаана байгааг бид мэднэ".

Тийбиний сэтгэл илт хөдөлж байгаа бололтой харагдана. Реми танхимын гол руу алхалсаар, тэлэндээр дөхөж очоод, "Та нар явцгаа! Эсвэл би хүч хэрэглэж ..." хэмээн хэлтэл,

"Реми!" гэж Тийбин түүнийг хориглоод, "Биднийг түр орхи!" гэв.

Үйлчлэгч эр гайхаж, "Эзэнтээн! Би ингэх ёстой. Эд нар бол ..."

"Үүнийг надад даатга!" гээд Тийбин хонгил тийш хуруугаараа заав.

Реми хормын дараа эзнээсээ хөөгдсөн нохой шиг чимээ гаргалгүйгээр танхимыг орхин гарлаа.

Тийбин нөгөө хоёр луу эргэж хараад, "Энэ ч өөр хэрэг шүү. Онъсон чулууны талаар юу мэдэжбайгаагаа надад яриач!"

Шөнийн гүн харанхуйн сүүдэр дунд, Тийбиний лабораторийн танхимын үүдний дэргэд Силасбуугаа барьсан чигтээ танхим доторхыг ажиглаж байв.

Түүнийг анх энд ирэхэд Ландон, нэг бүсгүйтэй ярилцаж байхыг хараад, дотогш нэвтрэх гэтэл, таягтулсан өөр нэг эрэгтэй танхимд орж ирэнгүүтээ, Ландон руу хашхичаад, хаалгыг цэлийтэл нээн,зочдыг явахыг шаардсан юм. Гэтэл зочин эмэгтэй Онъсон чулууны тухай дурсахад, бүх зүйлөөрчлөгджээ. Түрүүхэн л хашхичих шахам ярьж байсан, тэд одоо хоорондоо шивэгнэх аж.Нээлттэй байсан танхимын хаалга ч тэр дороо хаагдчихав.

Силас сүүдэрт гэтсээр, хаалганы цонхоор доторхыг харахыг оролдов.

Онъсон чулуу энд хаа нэгтэй байгаа юм байна!

Силас үүнийг зөнгөөрөө мэдэж байв. цонхонд бараг чихээ наах шахам суугаад, танхимын доторболж буй яриаг шимтэн сонсоно. Силас 5 секунд хүлээхээр шийдэв. Хэрэв тэд энэ хугацаандОнъсон чулууны байгаа газрыг дурсаж ярихгүй бол, Силас дотогш нэвтэрч ороод, хүч хэрэглэнэгэж Силас төлөвлөжээ.

Гэрийн эзнийг эргэлзээнд бүрэн орсон байгааг, Ландон бэлхнээ харж байв.

"Тэргүүн гэнэ ээ!" гэж Тийбин хахаж цацан байж хэлээд, "Жак Сониех гэсэн үү?"

Түүний балмагдсан байдлыг харангаа, Софи толгой дохив.

"Гэхдээ чи энэ тухай мэдсэн байх боломжгүй шүү дээ!"

"Жак Сониех бол миний өвөө!"

Тийбин таягаа тулж хойш гэдийгээд, Ландон руу харахад, цаадах нь бас л толгой дохиж байв. Тийбин Софид хандаж, "Хатагтай Нөвү, би юу гэхээ мэдэхгүй байна. Хэрэв хэлсэн чинь үнэн бол, би танд гүнээ харамсал илэрхийлж байна. Сионий Прайорийн гишүүд байж болох, хүмүүсийн нэрийг би судалгааны бүтээлдээ оруулсан юм. Жак Сониехийн нэр ч энэ жагсаалтад байсан. Гэхдээчи сая түүнийг тэргүүн байсан гэж хэлэв үү? Байж боломгүй юм" гээд Тийбин дуугүй болж, дараань толгойгоо сэгсрэв.

"Гэхдээ л сонин юм даа! Өвөө чинь Сионий Прайорийн тэргүүн байгаад, Оньсон чулуут өөрөөбүтээсэн гэхэд, чамд энэ тухайгаа хэзээ ч хэлэх ёсгүй. Оньсон чулуу бол Ахан дүүсийн холбоонынүдний ганц цөцгий нь байхгүй юу! Чи ач охин нь байлаа гээд, үүнийг чамд мэдэгдэх ёсгүй".

"Сониех үхэхээсээ өмнө энэ бүхнийг бидэнд бичиж үлдээсэн байсан. Түүнд өөр сонголт байгаагүй юм" гэж Ландон Софигийн өмнөөс хариулав.

"Түүнд ганц л сонголт байсан" гэж Тийбин сөргөөд, "Бүлэглэлийн тэргүүний доор тэргүүлэгч 3 гишүүн байдаг. Энэ бол тэдний нарийн зохион байгуулалтын нэг хэсэг. Тэднээс нэг нь шинээртэргүүн болж сонгогдоод, Прайори нууцаа цааш хадгалж үлддэг юм".

"Та зурагтын мэдээг бүтнээр нь үзээгүй бололтой" гэж Софи хэлээд, "Өвөөгөөс гадна, нэр нөлөөбүхий 3 хүн өнөө шөнө алагдсан. Бүгд л төстэй байдлаар хорлогдсон байсан. Бас бүгд алагдахаасаа өмнө алуурчинд ам өчиг өгсөн бололтой".

Тийбиний нүд орой дээрээ гарч "Тэднийг ...?"

"Бид хоёр тэднийг тэргүүлэгч гишүүд гэж бодож байгаа" гэж Ландон шууд хариулав.

"Гэхдээ яаж тэр вэ? Алуурчин тэдний бүх нэр, хаягийг нь мэдэх бололцоогүй. Намайг хар л даа! Битэднийг 10 - аад жил судалж байгаа гэхэд, Сионий Прайорийн жинхэнэ гишүүдийн нэрийг одооболтол, яг таг мэдэхгүй л байна шүү дээ. Тэргүүн, тэргүүлэгч 3 гишүүнийхээ хамт илэрч, бас нэгөдөр алагдана гэдэг байж болохгүй хэрэг".

"Алуурчин тэдний тухай мэдээллийг нэг дороос олж мэдсэн байх гэж би бодож байна. Үүнийг машэртнээс нарийн төлөвлөсөн байж таарна. Ийм арга ажиллагааг цагдаагийнхан ээдрээтэй, хүнд гэмтхэрэгтэй тэмцэхэд ашигладаг. Цагдаа нар хэсэг бүлэг хүмүүсийг сэжиглэж байгаа бол, тэднийгхэдэн сарын турш тагнаж чагнаад, хэргийн гол буруутныг тодруулсныхаа дараа, нэг дор нэг мөчидбаривчилж хорьдог. Бүлэг хүмүүс удирдлагагүй болчихвол, юу хийхээ ойлголцохгүй байсаармэдээллээ алддаг. Үүний нэгэн адил Прайорийг эртнээс тандаж ажиглаад, дараа нь цохилт хийж, тэргүүнийг нь айлган сүрдүүлснээр, Оньсон чулууны байгаа газрыг хэлүүлнэ гэж бодсон байх".

Тийбин үүнийг огт тоосон шинжгүй, "Гишүүд хэзээ ч нууцаа дэлгэж ярихгүй. Тэд тангараг өргөсөнбайдаг. Үхсэн ч тэр тангаргаасаа няцаж чадахгүй шүү дээ!"

"Яг тийм. Тэд нар бүгд нууцаа дэлгээгүй болохоор л үхсэн юм ..."

Тийбин гэнэт зогтусаж, "Нээрээ, тийм бол Оньсон чулууны байршил мэдэгдэлгүй чигээрээ үүрдбулшлагджээ!"

"Түүнтэй хамт Ариун Грейл ч бас булшлагдана гэсэн үг".

Ландоны хэлсэн энэ үг Тийбиний зүрхийг донсолгов. Тэрээр цааш тэвчихгүй бололтой, сандалдаалагхийтэл суучхаад, цонхоор гадагш харлаа .

Софи түүн рүү дөхөнгөө, зөөлөн дуугаар, "Өвөө маань гарцаагүй байдалд орсон болохоор ахандүүсийн холбооноос гадагш хүрээнд нууцыг дамжуулахаар шийдсэн байна. Энэ нь түүний ганцнайдвар байсан. Өвөө гэр бүлийнхээ хүнд тэр нууцаа дамжуулах гэж хичээсэн бололтой".

Тийбиний царай цонхийсон хэвээр, "Хэн нэг нь Ахан дүүсийн холбоог олж мэдээд ингэж довтолно гэдэг чинь!" гээд, айдаст бүрэн автсан дуугаар, "Нууцад нэвтэрч чадах тэр хүч бол Прайорийн эртний дайснаас гарцаагүй" гэж ноцтойгоор өгүүлэв.

Ландон цочиж, "Сүмийнхэн үү?" хэмээн өөрийн эрхгүй асууж орхив.

"Өөр хэн гэж?! Ром олон зууны турш Грейлийг хайж байгаа шүү дээ!"

Софи үүнд итгэсэнгүй. "Өвөөг сүмийнхэн алсан гэж та бодож байна уу?"

"Сүмийнхэн өөрсдийгөө аврахын тулд, хүн алж байгаа нь анх удаагийн явдал биш юм. Ариун Грейлийн баримтууд Сүмийнхэнд маш их аюул тарих учраас, тэд Грейлийг устахыг олон жилийн турш оролдсоор байгаа" гэж Тийбин нотлов.

Ландон Тийбиний ийнхүү ярихыг огт таашаасангүй. Саяхан шинээр сонгогдсон Пап болон түүний удирдлагын хүмүүстэй хэд хэдэн удаа уулзсаны хувьд, тэднийг аллагыг өөгшүүлэн, далдаар дэмжих хүмүүс биш гэдгийг Ландон ойлгож мэджээ.

Софи ч бас тийм л бодолтой байв. "Прайорийн гишүүдийг сүмийнхнээс өөр хүн алсан байж болохгүй юу? Грейлийн тухай ойлгодог өөр хэн нэгэн ч юм уу? Христийн аяга гэдэг утгаараа ихүнэ хүрэх эрдэнэс болохоор, эрдэнэсийн ангуучид алсан байж магадгүй юм биш үү?"

"Хүмүүс хүсч буй зүйлээ өөрийн болгохын тулд айдас, ичгүүрээ ч уландаа гишгээд бүхнийг ор тасмартдаг гэж би боддог. Энэ байдлаас болж хохирсон тал нь, Прайорийн бүлэглэл гэж надад бодогдоод байна".

"Лей, энэ чинь их маргаантай асуудал шүү дээ! Сионий Прайорийн баримтуудыг хуурамч зохиомол гэж үздэг Католик сүмийнхэн Сионий Прайорийн гишүүдийг алах үндэслэл байхгүй шүүдээ!"

Тийбиний хөх инээд нь хүрч байгаа бололтой, "Роберт, Харвард чамайг бүр мохоож орхижээ. Ромитгэл үнэмшлийн туйл болсон газар гэдгээрээ, нууц баримтуудыг устгах хүч чадал хангалттай байгаа. Гэвч итгэл үнэмшилгүй үлдсэн хэсэг хүмүүс яах болж байна аа? Итгэл үнэмшилд бүрэн автаагүй тэр хэсэг яах вэ? Хэрцгий, балмад байдлыг нүдээр үзэж байгаа, Бурхныг үгүйлж, Бурхан байдаг эсэх тухай ам асууж байгаа тэр хүмүүсийг яах вэ? Роберт, чи төсөөл дөө! Христийн түүхээрөө худал байсныг хүмүүс шинжлэх ухааны үндэслэлтэйгээр олж мэдвэл, юу болох вэ?"

Ландон хариу хэлсэнгүй.

"Би тэгвэл хэлээд өгье! Үүнийг тэд мэдэх юм бол, сүмийнхэн 2000 жилийн түүхэндээ байгаагүйгээр, маш том хохирол амсах болно".

Тэд нэлээд удаан дуугүй байсны эцэст, "Яагаад сүмийнхэн энэ аллагад холбоотой гэж

байгаа юмбэ? Сионий Прайори хэдийгээр Сангрийлийн баримтуудыг нууж байсан нь үнэн боловч, сүмийнхэнд айлгаж, заналхийлээгүй байсан шүү дээ!" гэж Софи өгүүлэв.

Тийбин гүнээ шүүрс алдаад, Ландон руу харж, "Роберт, одоо чи Сионий Прайорийн тухайрианыхаа төгсгөлийг хийсэн дээр байх?" гэлээ.

Ландон амьсгалаа удаанаар гаргаж, "Тэгье!" гэв.

"Хатагтай Нөвү, сүмийнхэн болоод Сионий Прайоричууд олон жилийн турш, тогтсон нэг лхарилцаатай байсан юм. Сүм Прайорид халдахгүй, харин Прайори Сангрийлийн баримтаанууцалсаар байх ёстой байсан. Гэвч үнэндээ Прайоричууд түүхийн туршид нууцыг задруулахтөлөвлөгөөг боловсруулсаар ирсэн. Тэдний товлосон өдөр ирэхэд, бүх нууцаа задалж, дэлхийдахинд Есүсийн түүхийн үнэн байдлыг Сангрийлийн баримтаар нотолж мэдүүлэх зорилготойбайжээ" гэж Тийбин яриаг эхлүүлэв.

Софи Тийбин рүү ширтэж байснаа, "Тэр өдөр нь дөхөж байгаа юм уу? Сүмийнхэн үүнийг мэдэжбайсан уу?" гэж асуув.

"Сүмийнхэн мэдээж ийм уршгийг урьдчилан харж, түрүүлж довтлохоос өөр аргагүй болсон гэж чиэргэцүүлээд үз дээ!"

"Прайоричуудын товлосон өдрийг сүмийнхэн олж мэдсэн гэж хэлэх гээд байна уу?" гэж ЛандонТийбинээс шалгаав.

"Яагаад болохгүй гэж?! Бидний таамаглаж байгаагаар, сүмийнхэн Прайорийн гишүүдийн нэрсийголж мэдэж чадсан юм чинь, төлөвлөгөөг нь мэдсэн байж болно шүү дээ. Тэр өдрийг яг нарийнмэдээгүй байж болох ч, тэдний мухар сүсэг үүнд нөлөөлсөн байж болох юм".

"Мухар сүсэг ий?"

"Зурхайн он тоомоор бол бид шилжиж буй хоёр эриний зааг дээр амьдарч байгаа. Зурхай судлалаарбол хумхын ордын эрин үе 2000 жил үргэлжлээд, одоо төгсөл нь ойртож байна. Энэ эринд хүнтөрөлхтөн хүчний нөлөөнд орж, өөрсдийгөө удирдаж чадахаа болино гэж зурхайд үзсэн байдаг.Өөрөөр хэлбэл шашны нөлөөнд гүн автана гэсэн үг. Харин одоо бол Загасны ордын эрин үе эхэлжбайна. Энэ эринд хүмүүс жинхэнэ үнэнийг ухаарч, өөрсдөө сэтгэж оюунлаг байдлаар амьдарна гэжзурхайд бичсэн байдаг. Одоо энэ үйл явц өрнөх гээд байна шүү дээ!"

Ландон цочин давхийв. Хэдийгээр тэр зурхай судлалыг ойшоодоггүй ч, Сүмийнхэн зурхайнтаамгийг дагасан нь ойлгомжтой болов .

“Сүмийнхэн шилжилтийн энэ үеийг Ертөнцийн төгсгөл гэж нэрлэсэн”.

"Дэлхийн төгсгөлийг хэлж байна уу? Апокалипсог хэлээд байна уу?" гэж Софи эргэлзсэн байдлааршалгаав.

"Үгүй ээ! Наадах чинь түгээмэл төөрөгдөл байгаа юм. Олон шашинд Ертөнцийн төгсгөлийн тухайбичсэн байдаг. Энэ нь дэлхийн төгсгөл гэсэн үг биш, харин хумхын ордны төгсгөлийг хэлж байгаажүм. Есүсийг мэндэлсэн цагаас эхлэн, энэ ордын тооллыг эхлүүлж, 2000 жил үргэлжлээд, одоодуусч байгааг, Ертөнцийн төгсгөл гэж хэлж байгаа юм шүү дээ! Маш олон түүх судлаачид энэүеийг Сионий Прайоричуудын хувьд түүхийн үнэнийг мэдэгдэх хамгийн тохиромжтой хугацаа гэжүздэг. Энэ хугацаа нь болчхоод байхад, сүмийнхэн ч тэр, Сионий Прайоричууд ч тэр одоо хүртэлямар нэгэн үйлдэл хийгээгүй л байна. Гэхдээ ганц үнэн зүйл бол Сүмийнхэн Ариун Грейлийголсон даруйдаа устгана" гээд Тийбиний харц нь бүүдийж, "Тэгэхээр, хонгорууд минь!Сангрийлийн баримтууд алга болсон гэсэн үг. 1000

жилийг дамжиж үргэлжилсэн тулаандсүмийнхэн ямаа гэсэн үг. Өнгөрсөн үе баларч, мартагдлаа гэсэн шүүдээ!"

Софи халааснаасаа хэрээс тэмдэг бүхий түлхүүрийг гаргаж ирээд, Тийбинд өгөв. Тийбинтүлхүүрийг авч ажиглана.

"Ээ, бурхан минь! Энэ чинь Прайорийн тамга байна. Чи үүнийг хаанаас аваа вэ?"

"Өвөө надад үлдээсэн байсан".

Тийбин хэрээс тэмдгийг хуруугаараа илээд, "Энэ түлхүүр аль сүмийнх вэ?" гэж асуув.

Бүсгүй хариуд нь гүнзгий амьсгал авч, "Энэ түлхүүрээр Оньсон чулууг олж авах боломжтой".

Тийбины нүд нь эргэлдээд, "Тийм байх боломжгүй! Би аль сүмийг анзааралгүй өнгөрсөн юм бол? Би Франц даяар бүх сүмийг нүхэлсэн шүү дээ" гэж байж ядан хэлэв.

"Оньсон чулуу сүмд байгаагүй. Харин Швейцарын Хадгаламжийн банканд байсан".

Тийбиний сэргэсэн байдал нь оргүй арилж, "Оньсон чулуу банканд байсан гэнэ ээ?" "Доод хөндийдбуюу банкны доод хонгилд" гэж Ландон хариулав.

Тийбин толгойгоо сэгсэрч, "Энэ байж болшгүй хэрэг. Оньсон чулууг Сарнайн дүрс дор нууцландалдлагдсан байх ёстой шүү дээ!"

"Тиймээ. Яг тийм байдалтай байсан. Түүнийг таван талт Сарнайн дүрс бүхий хайрцган доторхийсэн байсан".

Тийбин цочин давхийж, "Та нар Оньсон Чулууг харсан юм уу?" Софи толгой дохиж, "Бид банкандээр очсон". Тийбиний харц айсандаа байдгаараа бүлтэлзээд, тэдэн рүү дөхөж очингоо, "Найзуудминь. Тэгвэл бид ямар нэг зүйл хийх ёстой. Оньсон чулуунд одоо аюул заналхийлж байна. Бидтүүнийг аврах ёстой! Банканд нэвтрэх өөр түлхүүр байхгүй биз дээ? Алагдсан гишүүдийн нэгнээсөөр илүү түлхүүрийг авчихсан байж болно шүү дээ! Сүмийнхэн ийш банканд нэвтрээд..."

"Хэзээ ч тэгж чадахгүй. Бид Оньсон Чулууг тэндээс авчихсан".

"Юу? Та нар Оньсон чулууг нуусан газраас нь хөдөлгөсөн хэрэг үү?"

"Санаа зоволтгүй. Оньсон чулууг найдвартай газарт нуусан".

"Ямар ч алдаа мадаггүй нуусан гэж л надад хэлээрэй!"

Ландон уруулдаа инээмсэглэл тодруулангаа, "Танайх буйдан доорх хогоо хэр их цэв эрлэдгээс лболно доо!"

Гадаах салхи Шатү Виллетийн барилгыг нэвт салхилахад, Силасын өмсгөл нь дэрвэх ажээ. Тэрээртанхимд байгаа хүмүүсийн яриаг сайн сонсохгүй байлаа.

Оньсон чулуу гэсэн үг түүний чихний үзүүрээр өнгөрөхийг олж сонсов. *Оньсон чулуу энд байгааюм байна!*

Багшийн заавар түүний чихэнд тодоос тод сонсогдоно. "Шатү Виллетэд нэвтэрч, Оньсон чулууг ав! Хэний ч амийг бүү хөнөөгөөрэй!"

Ландон болон нөгөө хоёр хүн танхимаас гарч, өөр өрөө рүү орох нь цонхоор харагдав.

Силас ан руугаа мяраан гэтэх ирвэс мэт хаалгыг зөөлхөн онгойлгоод, танхимд нэвтэрч,

хаалгыгболгоомжтой гэгч эргүүлж хаав. Цаад талын өрөөн дэх хүмүүсийн яриаг там тум сонсоно. Силасбуугаа гаргаж, бэлэн байдалд ороод, цааш хөдлөв.

Хэсэг 63

Дэслэгч Коле Лей Тийбиний эдлэнгийн хашааны гадна зогсонгоо, шилтгээний барилгыг ажиглана. Хашааны дагуу таран зогссон, 6 - 7 өөрийн цагдаа нарыг харав. Колег тушаал өгвөл, тэд хашаагдаваад, байшинг бүслэхэд бэлэн зогсох аж.

Ландон үүнийг гадарлах ч үгүй байгаа даа!

Коле ахмад руу ярихаар завдтал, түүний утас нь дуугарав.

Фааш утасны цаанаас дурамжхан янзтай дуугарч, "Ландоны мөрөөр орсноо, яагаад надад хэлээгүй юм бэ?".

"Таныг утсаар чухал хэрэг яриад байна гэж байсан. Тэгээд би ..." "Чи хаана байна, дэслэгч Коле?" Коле байгаа газраа ахмадад мэдэгдэв.

"Энэ эдлэнгийн эзэн нь Английн иргэн Тийбин гэж хүн гэнэ. Ландон ийшээ ирэхийн тулд холзамыг туулсан бололтой. Ирсэн машин нь хашаан дотор байгаа бололтой. Тэр хүч хэрэглэж, дотогш нэвтэрсэн байдал харагдахгүй байна. Ландон гэрийн эзнийг таньдаг бололтой".

"Би удахгүй очно. Одоохондоо ямар нэг үйлдэл битгий хийгээрэй! Би очсон даруйдаа, ажиллагаагудирдаж явуулна".

Коле ихэд гайхаж, "Та наашаа ирэхдээ, бүтэн 20 минут зарцуулна шүү дээ, ахмад аа! Бид одоодаруй хөдлөх хэрэгтэй байна. Би түүнийг гавлахдаа л гавлана. Би өөрийн 8 хүний цуг энд байна. 4 мэргэн бууч, бусад нь зэвсэгтэй энгийн цагдаа нар".

"Намайг хүлээж бай!"

"Ахмад аа! Ландон хүн барьцаалсан бол яах вэ? Биднийг мэдчихээд, эндээс зугтвал яах вэ? Бид түргэн хөдлөх хэрэгтэй байна. Манай хүмүүс бүгд бэлэн болчихсон байгаа".

"Дэслэгч Коле, намайг очтол, юу ч хийлгүй наанаа хүлээж бай! Энэ бол тушаал" гээд Фааш утсаатасалчхав.

Дэслэгч Коле утсаа барьсан чигтээ зогсож байснаа, удалгүй цэнэгийг нь салгав.

Фааш намайг хүлээж бай гэдэг нь ямар учиртай юм бэ?

Коле ахмадын санааг ойлгов. *Фааш зөн билэгтээ итгээд, Үүндээ бардаж байгаа нь тэр. Фааш баривчилгааг удаашруулахыг хүсч байгаа юм байна. Үүнийгээ телевизээр цацаж, нэр хүндээ эргүүлэн авахыг хүсч байгаа бололтой.*

Колед бас өөр нэгэн бодол орж ирэв. Сэжигтнийг гэм буруугүй гэдэг нь бараг тодорхой болсон үед баривчилгааг түр хойшлуулж болдог гэсэн хуулийн заалт байдаг аж.

Фааш Ландоныг энэ хэрэгт холбоогүй гэж бодсон юм болов уу?

Энэ бодол түүнд айдас хүйдэс төрүүлнэ. Учир нь Фааш алдар хүндтэй энэ Америк эрийг голсэжигтэн хэмээн Интерполд болон телевизийн сувгаар олонтаа мэдэгдчихээд, сүүлд нь буруугүй гэж хэлээд, өөрийн байр сууринаасаа татгалзахад хүрвэл, түүний нэр хүндэд улам л муугаар нөлөөлнө.

Фааш алдаа гаргаснаа, өөрөө ойлгож байсансан бол, Колед зөвхөн түр хүлээх тушаал өгч болох лбайсан. Тийм болохоор Фаашийн бодол бол Англи эрийн эдлэнд нэвтэрч, Лондоныг баривчлах юмбайна гэж Коле эцэст нь дүгнэлээ. Коле бас өөр зүйлийг огтхон ч ойлгохгүй байв.

Хэрэв Ландон ямар ч гэм буруугүй юм бол, хохирогчийн ач охин Софи Нөвү түүнд яагаад тусалсан юм бол?

Софи өвөөгийнхөө их хэмжээний өв хөрөнгийг нь эзэмшихийн тулд, нууц амраг, дурлалт хархүү Ландоныгаа ятгаж, аллага хийлгэсэн байх гэж Фааш бодож байв. Түүнийг нь Сониех сэжиглэжмэдээд, "Роберт Ландоныг ол!" гэх зурвасыг бичиж үлдээсэн юм байж.

Колед энэ бүхний цаана ямар нэг учир шалтгаан байгаа юм шиг санагдана. Яагаад гэвэл Софи иймжигшүүртэй үйлдэл хийхээр хүн биш гэдэгт тэр хатуу итгэж байв.

"Дэслэгч ээ!" гэсээр нэг цагдаа хүрч ирээд, "Бид нэг сэжигтэй машин олж харлаа".

Коле цагдааг даган, тэндээс 50 ярд хэртэй газар яваад, зам дагуу хартал, бутан дотор хар Аудимашин зогсож байв. Дээр нь түрээсийн машин гэсэн тэмдэг тавьсан байв. Нэг л сэжигтэй болоодявчхав.

Халуухан ч юм болох нь дээ! гэж Коле дотроо бодлоо.

"Ландон энэ машинаар наашаа ирсэн байх. Түрээсийн үйлчилгээний компаниуд руу залгаж, хулгайд алдагдсан машин байгаа эсэхийг нь тогтоо!" гэж Коле нөгөө цагдаад үүрэг өглөө.

"Мэдлээ, эрхэм ээ!"

Өөр нэгэн цагдаа Колег хашааны дэргэдээс дуудав. "Дэслэгчээ, та хар даа!"

Цагдаа түүнд шөнийн тусгалтай дурангаа өгөөд, "Замын дэргэдэх шугуй руу хараарай!" гэв.

Коле тэр зүг хартал, дурангийн тусгалд хуягласан машин ногоон өнгөтэй дүрсээр тодрон харагдаж байв. Цюрихийн банкны гадаа түр саатуулаад явуулсан, тэр хуягт машинтай маш ижилхэн байх ньтэр.

Ийм байх боломжгүй! хэмээн Коле өөртөө шивнэж байв.

"Ландон, Нөвү хоёр энэ машинаар банкнаас гарч зугтсан гэдэг нь тодорхой байна" гэж нөгөөцагдаа хэлэв.

Коле дуугарсангүй. Түүний саатуулсан хуягт машины жолооч Ролекс цаг зүүсэн байсныг тэрээр гэнэт санав. *Би тэр үед ачааны бүхээгийг шалгахгүй яав аа?*

Итгэмээргүй боловч, банкныхан цагдаа нарт худал мэдүүлж, тэднийг зугтахад тусалсныг Колеэцэст нь ухаарлаа.

Гэхдээ яг хэн тусалсан юм бол? Яагаад? Ахмад надад хүлээхийг даалгасан нь, үүнтэй холбоотой чбайж магад. Энэ хоёроос гадна, хэрэгт өөр хүмүүс оролцсон гэж ахмад сэжиглэсэн юм болов уу? Хэрэв Софи, Ландон хоёр хуягт машинаар ирсэн юм бол хар Ауди ямар учиртай юм бол?

Тэндээс хэдэн 100 - аад милийн тэртээд, Тирений тэнгисийн дээгүүр дүүлэх онгоцонд

Хамба ламАрингароза дотор нь муухайрсандаа, өвөр дээрээ цаасан уут барьчихсан сууж байв. Парис рууярьсан боловч, түүний төсөөлснөөс өөр зүйл болсон байжээ.

Арингароза жижиг кабинд дотор давчдах агаад, хуруун дахь бөгжөө илж, айдас цөхрөлөөилааршуулахыг оролдоно.

Парист бүх зүйл буруугаар эргээжээ. Бээү Фааш энэ бүхнийг засч залруулаасай! хэмээн тэрээрнүдээ анин залбирна.

Хэсэг 64

Тийбин түшлэгтэй сандал дээр суугаад, өвөр дээрээ модон хайрцгийг тавьчихсан, таган дээрхСарнайн дүрсийг нүд салгалгүй ширтэнэ. Түүний хувьд өнөө шөнө маш онцгой, ид шидийн мэтсанагдах аж.

"Тагийг нээгээч!" гэж Софи түүнд шивэглэв.

Тийбин тааламжтайгаар инээмсэглээд, "Намайг бүү шавдуул!" гэх шиг бүсгүй рүү харав.

Олон жилийн турш, Оньсон Чулууг хайсан хүний хувьд, Тийбин энэ мөчийг сэтгэлдээ гүнзгиймэдэрч, таашаахыг юунаас ч илүүтэй хүсжээ. Тэр тагийг алгаараа илбээд, товгор дүрсийг нэгбүрчлэн мэдэрч байв.

"Сарнай бол," гэж тэрээр хэлээд, "Сарнай бол Магдалин. Магдалин бол Ариун Грейл. Сарнай ямагтзам заагч болдог" гэв.

Тийбин өмнө нь бүр цөхөрчхөөд байсан ажээ. Тэрээр хэдэн жилийн турш Францын бүх сүм,дуганыг үзэж нягтлахын тулд, тусгай зөвшөөрөл авч, сарнайн дүрстэй цонхны доорх бүхтавцангуудыг шалгаж, Оньсон чул ууг хайсаар ирсэн юм.

Сарнай дүрс дор орших Оньсон чулуу!

Тийбин тагийг алгуур нээв. Тэрээр доторх зүйлд нь бүх анхаарлаа төвлөрүүлжээ.

Өөр юу байх вэ? Оньсон чулуу л байгаа юм чинь.

Тэрээр чулуугаар хийсэн цилиндр болон, түүн дээрх үсэгтэй цагиргуудад хараа тавин ширтэнэ.Цилиндрийн юу болохыг тэр мэдэж байлаа.

"Да Винчийн тэмдэглэлийн дагуу хийсэн байгаа биз. Өвөө үүнд дурлаж, үүнийг өөрөө урлажхийдэг байсан юм".

Мэдээж Тийбин үүнийг таньж байв. Тэр энэхүү цилиндрийн эх зураг болон хуулбарыг нь харжбайсан юм. Тийбин криптексийг хайрцгаас болгоомжтой гаргаад, хэрхэн онгойлгохыг мэдэхгүй ч,түүний хувь заяа криптекс дотор нуугдаж байгааг, маш сайн ойлгож байв.

Тэр бүтэлгүй эрлийнхээ явцад, түүний энэ бүх хичээл чармайлтын дараа, хариу шагнал ирдэггүйюм байх даа гэж цөхөрч байсан удаатай.

Гэтэл одоо тэр бодол нь аль хэдийн замхраад, Грейлийн домогт гардаг эртний нэгэн үг чихэнд ньсонстох шиг болов.

"Чи Грейлийг хайгаад олохгүй байж болно. Харин Грейл чамайг өөрөө олно!"

Тэр ёсоор болж, өнөө шөнө Ариун Грейлд хүргэж өгөх Оньсон чулуу түүний гэрт өөрөө ороодирчихсэн байв.

Софи, Тийбин хоёр криптексийн талаар ярилцаж байх хооронд, Ландон модон

хайрцгийгнарийвчлан харахаар, хурц гэрэл бараадан, ширээ рүү очив. Түүний толгойд Тийбиний хэлсэн үгсорж ирнэ. "Грейл хүрэх түлхүүр Сарнайн дүрс дор нуугдсан байгаа".

Ландон хайрцгийг гэрэлд ойртуулж Сарнайн дүрсийг анхааралтай ажиглав.

Сарнайн дүрс доорх (Sub Rosa) нууц!

Писхийх чимээ ард гарахад, Ландон эргэж харлаа. Түүний нүднийх нь буланд нэгэн сүүдэрхарагдах шиг болов.

Тийбиний гэрийн үйлчлэгч л биз! гэж бодоод, хайрцаг руугаа буцаж эргэв. Тэрээр Сарнайндүрсийн товгорыг хуруугаараа илэнгээ, шигтгэсэн дүрсийг тагаас нь мултлах тухай бодно. Гэвчтүүнийг маш бат бөх тогтоосон нь илт байв. Шигтгээг сахлын хутган ы ир ч багтахааргүй, нягтбайдалтайгаар таганд суурилуулсан байлаа. Хайрцгийг нээж, доторхыг нь ажиглав. Тансар хилэндотортой мэт үзэгдэх хайрцгийг өргөж, тагны доод талыг ажиглалал, голд нь жижиг нүх үзэгдэв.Ландон тагийг хааж, гадна талаас нь харвал, тэр нүх огт харагдсангүй. Хайрцгийг ширээн дээртавьчхаад, цаасны хавчаарыг олж харав. Хавчаарынхаа үзүүрийг нүхэнд маш болгоомжтойгоорамсуулаад, цааш нь зөөлхөн түлхэв. Гэтэл нэг зүйл ширээн дээр торхийн унах нь тэр.

Ландон хайрцгийг хааж, унасан зүйлийг харвал, Сарнайн дүрстэй шигтгэмэл ширээн дээр хэвтэжбайв. Таган дээрх ховхорсон суурийг эргэж харвал, тэнд үл мэдэх нэгэн хэлээр 4 мөр шүлэг бичсэншиг байлаа. Үсгүүд нь Семит хэлнийхтэй төстэй харагдавч, танил бус хэлээр бичсэн нь удалгүймэдэгдэв.

Гэнэт ард нь юм хөдлөх шиг болж, эргээд харвал, хүнд зүйлээр толгойд нь цохих шиг болоод,Ландон өвдөг дээрээ сөхрөн унав. Тэрээр унаж байхдаа, буу барьчихсан нэгэн сүнс дэргэд ньзогсож байхыг, нүднийхээ булангаар харж амжив.

Удалгүй түүний нүд харанхуйлаад явчхав.

Хэсэг 65

Софи Нөвүг хууль хүчний байгууллагад ажиллаж байх хугацаанд хэн нэг хүн түүнд хэзээ ч буутулгаж байсангүй. Гэтэл энэ шөнө аварга биетэй, урт цагаан үстэй альбино цонхигор гартаа буубарьчхаад тэдэн рүү шагайж байв. Түүний нүд нь улаанаар эргэлдэн бүсгүйг харах бөгөөд зэвүүцэмтөрхтэй ажээ.

Зузаан ноосон өмсгөл өмсч, түүнийгээ олсоор бүсэлсэн зандалчин хувраг хүнтэй төстэй мэтбүсгүйд харагдана. Софи түүний хэн болохыг огт төсөөлөхгүй байсан ч, сүмийнхний талаархТийбиний сэжиг таамгийг тэр мөчид санаад, түүний бодлыг машид үнэлж байв.

"Та нар намайг ямар учиртай энд ирснийг мэдэж байгаа!" гэж хувраг хүйтэн дуугаар өгүүлэв.

Софи, Тийбин хоёр буйдан дээр суунгаа, түүний тушаалаар гараа дээш өргөсөн байх аж. Ландонширээний дэргэдэх шалан дээр хөсөр хэвтэнэ.

Хуврагийн нүд Тибийний өвөр дээрх Оньсон чулуун дээр тусав.

Тийбин эгдүүцсэн байдалтайгаар, "Чи үүнийг яаж онгойлгохыг мэдэхгүй шүү дээ" гэв.

"Манай Багш их ухаантай хүн" гэж хувраг хариулаад, тэр хоёр луу буугаа ээлжлэн чиглүүлэнгээ,ажмаар дөхсөөр байв.

Тийбиний үйлчлэгч хаана байгаа юм бол? гэж Софи бодов. Робертийг шалан дээр унахыгсонсоогүй юм байх даа?

"Багш гэж хэн юм бэ? Танай Багштай бид тохиролцож болох ч юм билүү!"

"Грейлд тохиролцоо гэж байдаггүй юм" гэсээр хувраг улам дөхнө.

"Чамаас цус гараад байна" гэж Тийбин хэлээд, хуврагийн баруун хөлийн шагай руу дохиод, "Басхазганаад байна" гэв.

"Чи ч бас хазганадаг биз дээ, хөгшин төгцөг минь!" гэж хувраг хариулаад, Тийбиний төмөр таягруу дохив. "Одоо надад Оньсон чулууг өгөөдөх!"

"Чи Оньсон чулуу гэж мэддэг юм уу?" гэж Тийбин гайхсан дуугаар асуув.

"Миний мэдэх үгүй нь чамд хамаагүй. Дээшээ босоод, наадахаа өг!"

"Миний хувьд босно гэдэг ч хэцүү дээ!"

"Тэр тусмаа. Би ямар нэг цочмог хөдөлгөөн хийлгэмээргүй байна".

Тийбин өрөөсөн таягаа аваад, Оньсон чулууг зүүн талдаа барив. Тэгээд дээш арайхийн өндийж, баруун гартаа хамаг хүчээ төвлөрүүлэхэд, түүний гар нь чичрэн салганах аж. Хувраг түүн рүүхэдэн алхам ойртонгоо, Тийбиний толгойд буугаа чиглүүлсэн байв.

Софи юу ч хийж чадахгүй тул, хуврагийг Оньсон чулуунд дөхөхийг дэмий л ажиглан сууж байв.

"Чи амжилт олохгүй шүү дээ! Зөвхөн сонгогдсон хүн л чулууг онгойлгож чадна" гэж Тийбинийг хэлэхэд, *Бурхан тэр хүнийг өөрөө сонгодог юм* гэж Силас дотроо бодов.

"Энэ надад хүнддээд байна" гэж таягтай өвгөнийг хэлэхэд, түүний гар нь чичирч байв.

"Чи үүнийг түргэн авахгүй бол, унагах вий гэж би айж байна".

Өвгөн унахад бэлэн, найган ганхаж байв. Силас ухасхийн чулууг авахаар очсон боловч, тэр агшиндхөл муутай өвгөн тэнцвэр алдан унаж байв. Түүний таяг суганаас нь мултарч, өвгөн баруун талруугаа сунайн ойчиход, Силас Оньсон чулууг барьж авахын тулд, онилсон буугаа доошлуулав. Гэвч Оньсон чулуу түүнээс холдож, өөр тийш шидэгдээд, өвгөний гараас ниссээр буйдан дээрчөөд уначхав.

Энэ мөчид төмөр таяг гялсхийх нь үзэгдэж, Силасын баруун хөл нь янгинаад явчихлаа. Силасын өргөст бүсэнд онож цохих чимээ тасхийн дуулдахад, альбиногийн гуянд төмөр өргөснүүд улам гүншигдэж, тэсэхийн аргагүй өвдөлт мэдрэгдэв. Силас шалан дээр эвхрэн унахдаа, хий буудахад, азаар сум нь шаланд тусав.

Тэр буугаа өргөн дахин буудахаар шагайх тэр үед, Софи түүний эрүүнд хүчтэй гэгч нь өшиглөөд, аюулыг зайлуулж амжив.

Эдлэнгийн гадна зогсож байсан, Коле байшингаас буун дуу гарахыг сонсов.

Тэнд буу тасхийж байхад, би энд юугаа хүлээж зогсоо юм бол?

Коле хашааны үүдийг ширтэж байснаа, эцсийн шийдээ гаргав. Хаалгыг эвдэл!" гэж тэрээр эцэст ньтушаалаа.

Роберт Ландон ухаан балартсан байдалтай шалан дээр хэвтэж байхдаа, буун дуу гарахыг бүүр түүрсонсов. Тэрээр чангаар ёолох дууг бас сонсов. Түүний ойролцоо, хүмүүс ярилцаж байх шиг санагдав.

"Чи хаана байсан юм бэ? Чөтгөр алгадмар!" гэж Тийбин хашхирна.

Үйлчлэгч сандран, "Юу болоо вэ? Ээ, бурхан минь. Энэ хэн юм бэ?"

Би цагдаа дуудлаа шүү!"

"Үхсэний чинь цагдаа. Тийм юм ярих хэрэггүй. Өөрийнхөө хэргийг гаргаж, энэ мангасыг хүлэх уяацаанаасаа аваад ир! Түргэлээч!"

"Бас мөс!" гэж Софи үйлчлэгчийн араас хэлэв.

Ландоныг буйдан дээр өргөж авчраад, хэвтүүлсэн байв. Софи түүний толгой дээр мөс тавиад, дэргэд нь сууж байлаа. Түүний гавал яг хагарах гэж буй мэт Ландонд санагдана. Ландоны нүдбүрэлзэхээ болиход, шалан дээр хэвтэх хүнийг олж харав.

Би эсвэл хий юм хараад байна уу?

Хүнд биетэй альбино наалттай туузаар хүлүүлчихсэн хэвтэж байв. Түүний ам нь ангайчихсан, гуяны дагуу өмсгөлийнх нь хормойд нь цус нэвчсэн харагдана. Тэр одоо л сэргэж байгаа бололтой байв.

Ландон Софи руу харж, "Энэ хэн бэ? Юу болсон юм бэ?"

Тийбин хазганасаар дөхөж ирээд, "Чи тайж хүний хүчээр аврагдлаа анд минь!"

Ландоныг босох гэж оролдоход, Софи түүнийг чичирсэн гараараа татаж суулгаад, "Жаахан хүлээ, Роберт!" гэв.

Ландон буйдан дээр суунгаа, хувраг руу харж, юу болсныг дотроо төсөөлөхийг хичээнэ.

"Тэр өргөст бүс зүүсэн байсан" гэж Тийбин хэлэв. "Ямар бүс гэнэ ээ?"

Тийбин шалан дээр тайлж хаясан, өргөстэй ширэн бүс рүү зааж, "Тэр мөргөлийн бүс зүүсэн байсан".

Ландон энэ өргөст бүсийг мэдэх учир, толгой сэгсэрч, "Гэхдээ чи зүүснийг нь яаж мэдсэн юм бэ?"

Тийбин жоготойгоор инээж, "Христ бол миний судалдаг сэдэв, Роберт. Тийм болохоор зарим нэгурсгал чиглэлийнхэн ханцуйдаа зүрх дүрсэлсэн байдгийг би бас мэднэ" гээд таягаараа хувраг руузаахад,

"Опус Дей" гэж Ландон шивэглэнээд, Опус Дейн зарим нэг гишүүдийн дотор Бостоны нэртэй бизнесменүүд байсан тухай мэдээг зурагтаар саяхан үзсэнээ санав.

Тийбин цус болсон өргөст бүсийг ойроос харангаа, "Ямар учраас Опус Дей Грейлийг хайх болов!" гэж өөрөөсөө асуув.

Ландонд энэ талаар эргэцүүлэх чадал байсангүй.

"Роберт!" гэж Софи хэлээд хайрцаг руу очиж, "Энэ юу вэ?" гэх нь ширээн дээр байсан, Сарнайндүрсийн ховхорсон шигтгэмлийг барьчихсан зогсож байв.

"Хайрцагны таган дээр бичсэн үгийг наадахаар чинь далдалж байсан байна. Сарнайн дүрс доорх үгОнъсон чулууг онгойлгоход хэрэг болж магадгүй гэж би бодсон юм" гэв.

Софи, Тийбин хоёр энэ тухай эргэцүүлж байтал, цагдаагийн машины хөх т усгалтай гэрлүүдэдлэнгийн гаднаас олноороо тусаад, байшин руу чиглэн наашилж байв.

Тийбин бодол болж, "Найзууд минь, бид шийдээ түргэн гаргах хэрэгтэй боллоо!" гэв.

Хэсэг 66

Коле болон түүний хүмүүс Лей Тийбиний гэрийн үүдэнд ирээд, буугаа бэлдэн дотогш нэвтрэв. Доод давхрын бүх өрөөг нэгжиж үзлээ. Тэд танхимын шалан дээрх сумны нүх, дусал цус болон өргөстэй ширэн бүс, бас хэрэглэсэн бололтой наалттай туузаас өөр зүйл олсонгүй.

Доод давхарт нэг ч хүн байсангүй.

Коле хүмүүсээ хувааж, тэдэнд доод хонгил, байшингийн ар талыг шалгуулахаар, үүрэг өгч дуусангуут, дээд давхарт чимээ гарах нь дуулав.

"Тэд дээр байна!"

Шатаар дээш өгсөн, өрөө болгоныг шалгасаар, чимээ гарсан хэсэгт улам ойртсоор байв. Чимээ дээд давхрын хонгилын төгсгөл дэх унтлагын өрөөнөөс гарч байгаа бололтой. Цагдаа нар тэр зүгдөхсөөр, зугтах гарцыг урьдчилан хааж, байрлалаа эзлэн явна. Өрөөний үүдэнд очтол, хаалга нь нээлттэй байв. Чимээ гарах нь зогсоод, моторын нижгэнэх дуугаар сонсогдов. Коле буугаачиглүүлэн, дотогш нэвтрээд унтраалгыг дарж, гэрэл асаагаад, тушаал өгөн хашхираад, буугаа онилсон боловч, тэнд хэн ч байсангүй.

Нижгэнэх чимээ орны дэргэдэх нэг төхөөрөмжөөс гарах ажээ. Коле ийм зүйлийг байшингийн доод давхарт харсан шиг санана. Тэр нь дохиоллын системтэй төстэй юм шиг харагдах аж. Төхөөрөмжрүү очиж хартал, дээр нь нэр бичсэн 10 гаруй товчлуур байв.

"Сургалтын" өрөө, Гал тогооны өрөө, Угаалгын өрөө, Зоорь ...

Машины мотор нижгэнэх чимээ хаанаас гарсан юм бол?

... Унтлагын өрөө, наран шарлагын өрөө, саравч, номын сан ...

Саравч!

Коле тэр дороо сэхээ авч доош уруудаад, замд таарсан нэг цагдаатай хамт арын хаалгаар гарч, саарал өнгийн модон саравчинд хүрэв. Тэднийг саравчинд орохоос өмнө, моторын дууны чимээ алслан холдлоо. Тэр буугаа шагайж, саравчинд нэвтрээд, гэрлийг асаав.

Саравчны баруун талаар баахан багаж, тоног хэрэгслүүд байх аж.

Өвсний хадуур, түлхүүр, цэцэрлэгийн багажууд. Тэдгээрийн ойролцоо, хананд нөгөө дохиоллын системийг байрлуулсан байх бөгөөд, хэн нэг нь дамжуулах товчлуурыг нь дарж, асаасан байв.

Колегийн хор шар нь хөдлөв.

Тэд биднийг чулуу хөөлгөж, дээд давхар гарган, цаг хожоод зугтаажээ.

Коле саравчны зүүн талыг хартал нь морины жүчээ байв. Гэхдээ гэрийн эзэн өөр

төрлийн хүлэгморь сонирхдог нь илт байв. Учир нь морины жүчээг төмөр хүлгийн "жүчээ" болгон өөрчлөөд ,ховор нандин цуглуулгаа эгнүүлэн тавьсан байв.

Гялалзсан хар өнгөтэй Ferrari, цэмцгэр загвартай Rolls - Royce, эртний загварын Astin Martin, нилягаан өнгийн Porsche 356 зэрэг загварууд жүчээнд эгнэн зогсоно.

Жүчээнд хэн ч байсангүй. Коле шалан дээр дуссан моторын тосыг олж харав.

"Эрхэм ээ!" гэсээр дэргэдэх цагдаа нь жүчээний нөгөө тал руу заав.

Жүчээний арын хаалга бүтэн онгойж, цаана нь лаг шавар бүхий хэвгий газар ил харагдах ажээ. Коле тийш гүйж очоод, харанхуйн дунд ямар нэг хөдөлж буй зүйл олж харах гэж хичээнэ. Түүнийнүдэнд хөндий даган шуугих ой мод бараантан үзэгдэнэ.

Энд тоо томшгүй олон зам, жим байгаа боловч, Коле үүнд огтхон ч санаа нь зовсонгүй. "Цаадхэддээ ийшээ доош урууд гэж хэл! Тэд нар ойрхон газар гацчихсан зогсож байгаа. Иймэ рхүү спортзагвартай машинуудын аль нь ч эндхийн замыг туулж чадахгүй" гэв.

"Харин л дээ, дэслэгч ээ!" гэж нөгөө цагдаа хананд өлгөсөн машины түлхүүрлүү зааж хэлэхэд, танил машинуудын нэрсийн доор түлхүүрийг өлгөсөн нь нүдэнд тусна.

Daimler, Rolls Royce, Artin Martin, Posche.

Харин сүүлчийн өлгүүр дэх түлхүүр нь алга байв. Өлгүүрийн дээр бичсэн машины нэр дэслэгчийгарга мухардахад хүргэв.

Хэсэг 67

Хар сувд шиг гялалзсан өнгөтэй Range Rover баруун талдаа жолоотой байхыг анзаарсан даруйдаа, Ландон жолоо бариагүйдээ дотроо баярлана. Реми эзнийхээ тушааснаар, Шату Виметийг орхиж, сарны туяанд урдах замаа харан, машиныг төвөггүйхэн жолоодно. Урд гэрлээ асаалгүйгээр, уруугазар луу хурдлан явсаар, өмнө нь бараантах ой мод руу дөтлөн ойртож байв.

Ландон Онъсон чулууг барьчихсан чигээрээ, урд суудлаас Тийбин, Софи хоёр луу эргэж харахад, "Толгой чинь яаж байна?" гэж Софи санаа нь зовсон янзтай асуув.

Ландон хүчээр инээмсэглэж, "Арай дээрдэж байна!" гэж хариулав.

Үнэндээ тэсгэлгүй их өвдөж байгаагаа, бүсгүйгээс тас нуужээ.

Софигийн дэргэд суусан Тийбин "хонины хонхорт" хэвтэх хувраг руу мөрөө давуулан харна. Тийбин хуврагийн авч явсан бууг өвөр дээрээ тавиад сууж байгаа нь, яг л Англи анчин эр ээлжитангаа хийх гэж байгаа дүртэй харагдана.

"Та хоёр над дээр ирсэн нь ямар сайхан хэрэг вэ?" гэж Тийбин инээмсэглэн хэлээд, олон жил адалявдалтай учраагүй хүн шиг догдлон сууж байв.

"Чамайг энэ бүхэнд хутгасанд уучлаарай, Лей!"

"Битгий тэгж ярь! Би энэ мөчийг насан туршдаа хүлээж байсан юм".

Тэдний өмнө өргөн жалга байхыг Тийбин урд цонхоор анзаарч харангуутаа, Ремигийн мөр лүүцохиж, "Тоормос гишгэж болохгүй шүү! Хэрэгтэй бол гар тоормосоо татаарай! Бид эхлээд ой модруу орох хэрэгтэй. Тэр хүртэл гэрлээ асааж, хойноосоо анзаарагдмааргүй

байна".

Жалга өнгөрөхөд, Ландон урдах замаа харахаа болив. Түүний урдаас түнэр харанхуй ширтэх аж. Ой модны зах руу орж ирэхэд, баруун гар талаар нь модны мөчир шүргэж эхлэв. Реми жолоогоозасч нөгөө тийш залав.

"Реми, чи ч сайн жолоодож байна шүү! Үүнээс илүү жолоодно гэж юу байхав. Роберт, чи дэргэдэххавхлагаа онгойлгоод, хөх товчлуурыг дараадхаач! Харж байна уу?"

Ландон товчлуурыг олж дарахад, шар ёлтгор гэрэл асч, урдах замыг нэвт гэрэлтүүлэх нь тэр.

Манангийн гэрэл! гэж Ландон гадарлав.

"За, Реми!" гэж Тийбин хашхираад, "Одоо гэрэл асчихсан. Бидний хувь заяа чиний гарт байна" гэв.

"Бид хаашаа явж байгаа юм бэ?" гэж Софи шалгаав.

"Бид энэ замаараа цааш 3 км газар ой модыг туулаад, эдлэнгийн захад очингуутаа, хойд зүг рүүэргэнэ. Замд унасан мод, ус шалбааг тааралдахгүй гэж найдвал, бид эндээс эсэн мэнд гараад, 5 - рзасмал зам руу орно доо".

Ландон эсэн мэнд гэдэг үгийг сонсоод, доош бөхийж өвөр дээрхээ харав. Түүний өвөр дээрхайрцагтай Онсон чулуу байлаа. Тагаасаа ховхорсон байсан Сарнайн дүрсийг байранд буцаажхийснийг ажиглаад, түүнийг буцаан авч, нөгөө үгийг дахин харах тухай там тум бодов.

Түүнийг хайрцгаа онгойлгох агшинд, Тийбин мөрөн дээр нь гараа тавиад, "Хүлээ! Роберт. Энддонсолгоотой, бас харанхуй байна. Чи гэрэлтэйд уншиж чадаагүй юм чинь, одоо бараг дэмий биз. Эхлээд эндээс гарахаа бодье! Чи зөвшөөрч байна уу? Бидэнд хугацаа байгаа шүү дээ".

Тийбиний хэлсэн зөв гэдгийг Ландон ойлголоо. Тэр толгой дохиод, хайрцгийг хаав.

Ард байсан хувраг ам нь бөглөөтэй чигээрээ ёолон гингэнээд, хүлгээ тайлахыг оролдоно. Дараа ньарын суудлыг гэнэт өшгичиж эхлэв. Тийбин өвөр дээрх буугаа авч, түүн рүү эргэж хараад, "Бичиний өвчин шаналлыг үнэндээ тоох ч үгүй байна. Чи миний гэрт нэвтрэн орж, миний андынгавлын ясыг цөмлөх шахсан болохоор, одоо чамайг буудаад, ой модонд хаячхад хэн ч намайгболиулж зүрхлэхгүй".

Түүний үгийг сонссон даруйдаа, альбино дуугүй болов.

"Бид түүнийг авч явах нь зөв байсан юм уу?" гэж Ландон Тийбинээс асуув.

"Цусаараа тангараглая! Зөв байлгүй яахав" гэж Тийбин хариу хашхичаад, "Цагдаа нар чамайгаллагад сэжиглэж байгаа. Энэ зандалчин бол чамайг эрх чөлөөнд хүргэх тасалбар байхгүй юу. Харин цагдаа нар манай гэрт зөвшөөрөлгүйгээр нэвтрэхийг бодоход, тэд чамайг барихаарулангасаж байгаа нь илт байна".

"Энэ бүхэн миний буруу. Хуягт машин дамжуулагч төхөөрөмжтэй байсныг би гадарлах ёстойбайсан юм" гэж Софи харамсан өгүүлэв.

"Энэ ч яахав. Цагдаа нарыг ирсэнд би нэг их гайхахгүй байна. Харин Опус Дейн энэ

араатан яаж тахоёрыг олж ирснийг, би бодоод олохгүй юм. Та нарын ярьснаас үзэхэд, энэ араатан Цюрихийнбанк, эсвэл цагдаа нартай холбоо сүлбээгүй л юм бол, манай гэрийг олж ирэх боломжгүй байсаншүү дээ!" гэж Тийбин шогшров.

Ландон ч бас энэ тухай эргэцүүлэв.

"Энэ хуврагийн цаана өөр хүн байгаа, Роберт! Хөшигний цаадах хүнийг олж мэдэх хүртлээ, та хоёраюул заналд өртөх боломжоор дүүрэн байна гэсэн үг. Гэхдээ та нарт нэг сайн мэдээ дуулгахад, бигэж нэг сүр хүч дэргэд чинь байгаа шүү!" гэж Тийбин өөрийгөө дөвийлгөн хэлэв.

Тэд шулуун замд орж, Реми машиныхаа хурдыг нэмэв. Тэд шалбааг усыг гатлаад, толгод руу өгсч, дараа нь доош уруудав.

"Роберт, чи наад утасныхаа харилцуурыг надад аваад өгөхгүй юу?" гэж Тийбин хэлээд, машиндсуурилуулсан утсан харилцуурыг заав. Тийбин Ландонаас харилцуурыг авсныхаа дараа, нэг дугаарлуу залгаж эхлэв. Залгасан дугаарын эзэн нэлээд удсаны эцэст, утсаа авсан бололтой,

"Ричардуу?" гэж Тийбин асуугаад, "Би чамайг сэрээчихэв үү дээ? Би шал тэнэг зүйл асуучихлаа. Өршөөгөөрэй! Мэдээж сэрээсэн байлгүй яахав. Надад бяцхан асуудал гараад байна. Бие жаахан тавгүйрхээд! Реми, бид хоёр эмчилгээндээ явахаар боллоо. Тиймээ! Яг тийм. Тулгаж хэлсэндөршөөгөөрэй! Чи Элизабетыг 20 минутын дараа бэлэн байлгаж чадах уу? Ойлголоо. Хичээгээрэй! Удахгүй уулзъя" гэж хэлэнгүүтээ утсаа тавив.

"Элизабет гэж хэн юм бэ?" гэж Ландон асуув.

"Аа, тэр үү. Миний хувийн онгоц байгаа юм. Наддаа л хамгийн үнэтэй эд".

Ландон түүний үгийг сонсонгуугаа, суудлаасаа бүтэн эргэж, Тийбинийг цоо ширтэв.

"Яасан?" гэж Тийбин түүний өөдөөс гайхан хэлээд, "Цагдаа нар мөрдөж байгаа цагт та хоёр Францад байх боломжгүй. Харин Лондонд оччихвол, байдал хамаагүй дээрдэх болно. Найзууд аа! Францын нутаг дэвсгэрээс бусад газарт бол би ч бас нөлөө ихтэй хүн шүү! Тэгээд ч Грейлийг Англид байгаа гэж нотолдог болохоор, Онyson чулууг нээснийхээ дараа, бид зөв газар луузүглэснээ ухаарах ч юм билүү".

"Та ч том эрсдэлийг сөрж байх шив дээ! Цагдаа нарт тус хүргэхийн оронд, бидэнд туслахааршийдээ юу?" гэж Софиг сонжиж асуухад, Тийбин жигшсэн дуугаар,

"Би одоо Франц улстай салах ёс хийж байна. Анх зөвхөн Онyson чулууны төлөө л энд ирсэн юмшүү дээ. Миний энд эхэлсэн ажил ингээд дуусгавар болж байх шиг байна. Би дахиад ШатүВиллетэд очихгүй" гэв.

Софи үл итгэсэн байдлаар, "Бид нар тэгвэл онгоцны буудлын хяналт шалгалтынхныг яаж өнгөрөөх юм бэ?" гэж асуув.

Тийбин нүдээ ирмэж, "Би Ле Бурге гэдэг хувийн жижиг нисэх онгоцны буудлаар үйлчлүүлдэг юм. Франц эмч нар миний тэвчээрийг барчихдаг тул, би бараг шөнө болгон Англи руу биеэсувилуулахаар нисэх хэрэг гардаг. Нислэгийн тусгай зөвшөөрлийг олж авахын тулд, зарим нэгнэмэлт төлбөр хийдэг болохоор, АНУ - ын ЭСЯ - тай холбогдох үгүйгээ бид агаарт хөөрснийхөө дараа шийдье!" гэж Тийбин хэлэв.

Гэвч энэ мөчид Ландон ЭСЯ - тай холбоо барих ямар ч сонирхолгүй байв. Харин түүний сонирхол Грейлд хүргэх Онyson чулуу болон далд бичигдсэн үгс рүү тэмүүлэх аж. Ландон Тийбиний Англируу явах санааг битүүхэндээ дэмжинэ. Учир нь Сангрийлийг Англид байгаа

гэж олон эрдэмтэнүздэг. Гэвч тэрээр зүүдэндээ ч Грейлийг хайх тухай огт бодоогүй явсан болохоор, ихэд догдолжбайлаа.

Сангрийлын баримтууд! Энэ бол Христийн түүхийн үнэн өчиг. Мэри Магдалиний бунхан!

Гэвч Ландон өөрийгөө бодитоор сэтгэж байна уу, эсвэл төсөөлөлдөө хэт автаад, төөрөлдчихсөнявна уу гэдгээ үнэндээ хэлж мэдэхгүй байв.

"Эзэнтээн!" гэж Реми хэлээд, "Англи руу буцсан нь дээр гэж та үнэхээр бодож байна уу?"

"Реми! Санаа зоволтгүй" гэж Тийбин батлан хэлээд, "Би буцаж байгаа нь чамайг орхиж явна гэсэнүг биш. Чи тэнд надтай цуг байх болно. Би Дерошехийн эдлэнг худалдаж авах бодолтой байгаа. Бүх хогшлоо тийш зөөж, жинхэнэ адал явдал эхлэх болно. Жинхэнэ адал явдал, Реми!"

Ландон инээхээс өөр аргагүйд хүрэв. Тийбиний "аугаа их ялалтын" туган доор орж, Их Британируу явахын тулд, түүнийг "дагаж намирахаас" өөр яах билээ!

Ландон дэргэдүүр өнгөрөх моддыг цонхоор харна. Машины хажуугийн толинд мод шүргээддотогш толь эргэжээ. Толины тусгалд арын суудал дээр суусан Софи харагдав. Бүсгүйг удаанаараажиглаж байхдаа, Ландоны сэтгэл хангалуун болох шиг санагдав. Өнөө шөнийн бэрхшээлийг эстооцвол, Ландон ийм сайн хамтрагчтай болсондоо туйлаас баярлаж байв.

Удалгүй өөрийг нь ажиглаж байгааг мэдэрсэн гэлтэй, Софи урагш бөхийж, түүний мөрөн дээргараа тавиад, "Чи зүгээр биз дээ?" гэж дахин асуув.

"Зүгээр ээ! Дажгүй".

Софи түшлэгээ эргэж налаад, инээмсэглэж байхыг Ландон толинд харав. Тэр ч бас инээмсэглэж байв.

Range Rover - ийн "хонины хонхорт" шигдсэн, Силаст амьсгалахад төвөгтэй байв. Түүний гарыг арднь чангаар хүлсэн тул, бугуй нь чинэрч өвдөөд, машин донслох бүрт, мөр нь шаланд цохигдоод, мөн ч эвгүй байлаа. Өргөст бүсийг яагаад ч юм гуянаас нь тайлчихжээ. Амыг нь туузаар наажтагласан тул, хамраараа амьсгалахаас аргагүй байсан ч, арын хонхорт боссон хамаг тоос шороогуушгиндаа хам хийснээс болж, байн байн найтаалган байв.

"Амьсгал нь бөглөрчихвий дээ!" гэж санаа нь зовсон Франц үйлчлэгчийг хэлэхэд, түүнийг таягаараа цохиж унагасан айхтар өвгөн Силас руу эргэж хараад, хөмсгөө зангидан хүйтэн өнгөөр,

"Аз чинь болж дээ! Англичууд хүний мөсийг найз нөхдөдөө үзүүлж буй энэрэл өршөөлөөр биш, харин дайсандаа үзүүлж буй өршөөлөөр нь хэмждэг юм" гэж хэлээд, түүний аманд наасан туузыг нь авч хаяв.

Угз татан авсан тул, Силасын уруулд оч авалцах шиг болж, чимчгэнэн өвдөв. Гэвч аманд нь орохагаарыг тэнгэр Бурхны хишигтэй зүйрлэн шуналтайгаар сорон амьсгалав.

"Чи хэний талд ажилладаг вэ?" гэж Англи өвгөн түүнээс тулган асуув.

"Бурханы талд!" гэж хэлэхдээ, залуу бүсгүйд өшиглүүлснээсээ болж хөндүүрлэх эрүүгээ аажиггнуулан хариулав.

"Чи Опус Дейн хүн байна".

"Чи миний хэн болохыг мэдэхгүй".

"Яагаад Опус Дей Онъсон чулууг хөөцөлдөх болов?"

Силас огт хариулах янзгүй байв.

Онъсон чулуу бол Ариун Грейлтэй холбогдож, харин Ариун Грейл бол итгэл үнэмшлийг хамгаалахгол үндэс суурь нь юм гэж Силас бодох аж.

Би Бурханд үйлчилдэг. Гэвч миний итгэл үнэмшил аюулд өртөөд байна шүүдээ!

Багш, Хамба хоёрын итгэлийг бүрмөсөн хөсөрдүүлсэндээ, Силас сэтгэл гутарна. Тэдэнтэйхолбогдох ямар ч боломжгүй байлаа. Юу болж өрнөж байгааг ч тайлбарлах аргагүй байв.

Эд нар Онъсон чулууг гартаа оруулжээ. Тэгэхээр биднээс өрсөж, Грейлд хүрнэ гэсэн үг.

Силас хойд хонхрын харанхуй сүүдэрт, залбирал үйлдэв.

Гайхамшиг. Бурхан минь! Надад гайхамшигийг бүтээхэд туслаач дээ!

"Роберт!" гэж Софи Ландон руу харан хэлээд, "Чи их догь харагдаж байна" гэв.

Ландон түүн рүү эргэж харахдаа, боолттой байгаа толгойгоо гэнэт санав.

"Надад гар утсаа түр өгөөч, Софи?"

"Одоо юу?"

"Би нэг зүйл саналаа".

"Юу тэр вэ?"

"Би удахгүй хэлье. Эхлээд утсаа өгчих?"

Софи сэрэмжилсэн янзтай, "Фааш утасны шугамыг чагнаж байж магад. Ганц минутын доторамжиж ярихыг бодоорой!" гээд утсаа өглөө.

"Би Америк руу яаж залгах билээ?"

"Чи төлбөрийг нь цаад талдаа шилжүүлэх хэрэгтэй. Миний гар утасны үйлчилгээний эрх Америкруу хязгаартай байдаг юм".

Ландон "0" гэж залгаад, 60 секундэд багтааж авах ёстой хариу нь энэ шөнийн турш ээдрээтэйбайсан бүх асуудлыг нэг мөр тодорхой болгоно гэдэгт найдаж байв .

Хэсэг 68

Утас дуугарах мөчид Нью - Йоркийн хэвлэлийн редактор Жонас Фокман дөнгөж орондоо орчхоод,унтах гэж байсан ажээ. Фокман шөнө дөлөөр утастсанд бухимдан, амандаа гүвтнэнгээ, утсаа авав.

Залгагч хариулж, "Та ноён Роберт Ландоны ярианы төлбөрийг өөрийнхөө талаас хийх үү?" гэжасуув.

Жонас гайхсан боловч, гэрлээ асааж, "Аа, нээрээ. Тэгье! За" гэж түгдрэн хариулав.

Шугам өөрчлөгдөж, "Жонас уу?" гэх дуу хадав.

"Роберт! Чи намайг шөнө дунд сэрээчхээд, ярианыхаа төлбөрийг надаар хийлгэж байгаа

юм уу?"

"Жонас, намайг уучлаарай! Би удаан ярьж болохгүй байна. Чамд өгсөн миний гар бичмэлийг чи ..."

"Роберт, намайг бүр ч уучлаарай! Би энэ долоо хоногт түүнийг чинь хянаж арай амжсангүй. Ирэхдаваа гаригт гэж би чамд амлаж байна".

"Би хянах тухай яриагүй байна аа! Харин чи надад хэлэлгүйгээр, миний номын танилцуулгынхуулбарыг ийш тийш хүмүүст явуулаагүй биз?"

Фокман түр эргэлзэв.

Ландоны шинэ номыг уншаад нүд нь орой дээрээ гарах шахсан, Жонас хэвлүүлэх эрх авахын тулд,заавал бичгэн дэмжлэг хэрэгтэй гэж үзээд, энэ чиглэлээр алдартай 10 судлаачид элэгсэг үгтэйзахианы хамт, номын танилцуулгыг явуулж, хавтсан дээрх магтаалын үгийг бичихийг хүсжээ.Фокманы туршлагаар бол хүмүүс номын хавтсан дээр нэрээ гарсан байхыг ихэд таашаадаг аж.

"Жонас? Чи номын хуулбарыг хэн нэгэнд явуулсан уу?" гэж Ландон шахамдуулан асууна.

Жонас хөмсгөө зангидаад, Ландон үүнд бухимдаж байгаа юм байна гэж таамаглалаа.

"Гар бичмэл чинь сайн болсон байсан. Тийм болохоор номонд чинь галзуу сайн танилцуулга,магтаалын үг хэрэгтэй гэж би бодсон юм" .

Ландон түр азнаад, "Чи Луврын музейн эрхлэгчид хуулбарыг илгээсэн үү?"

"Харин чи энэ талаар юу гэж бодож байна? гар бичмэлд Луврийн хэд хэдэн үзмэрийг дурдсанбайсан болохоор, бас чи ашигласан номынхоо жагсаалтад Луврийн эрхлэгчийн номын нэрийгбичсэн байсан болохоор, би Сониехт хуулбарыг явуулсан юм".

Харилцуурын цаана Ландон хэсэг дуугүй байснаа, "Чи хэзээ явуулсан юм бэ?"

"Сарын өмнө байхаа. Бас чамайг Парист очихыг түүнд хэлээд, уулзахыг зөвлөсөн юм. Тэр чамтайуулзья гэж холбоо бариагүй юу?" гэж асуув.

Фокман нүдээ нухаад, "Байзнаарай! Чи энэ долоо хоногт Парист байх ёстой биш билүү?"

"Би Парист байна".

Фокман орноосоо өндийж, "Чи Парисаас над руу ярихдаа, утасныхаа төлбөрийг нааш ньшилжүүлж байгаа юм уу?"

"Хүлцэл өчье, эрхэм Жонас! Сониех чамтай эргэж холбоо барьсан уу? Гар бичмэл таалагдсан эсэхгалаар ярьсан уу?"

"Би мэдэхгүй байна. Тэр над руу огт яриагүй".

"За, тэгвэл битгий гайхаарай! Би яриагаа дуусгах хэрэгтэй байна. Гэхдээ чамд маш их баярлалаа!"

"Роберт...?"

Гэвч Ландон утсаа тасалжээ. Фокман утсаа бас таслаад, толгойгоо сэгсэрч, "Энэ зохиолчид уу?"гэж бодов.

Гэхдээ тэд бол хэзээ ч олдохгүй эрдэнэс шиг үнэтэй хүмүүс!

Range Rover - ийн арын суудалд сууж явсан Лей Тийбин яриа өдөж, "Роберт, чи нууц бүлэглэлийнтухай ном бичээ юу? Тэгээд тэр номын хуулбарыг редактор чинь нууц бүлэглэлийн хүнд илгээсэнболж таарах нь уу?"

"Яг тийм" гэж Ландон түс тас хариулав.

"Шал дэмий юм болж дээ, найз минь".

Ландон үүнийг хэлүүлэлтгүй мэдэж байлаа. Жак Сониехээс Дарь эх шүтээний талаар номондоотуслалцаа хүснэ гэдэг бол Тайгр Вүүдээс гольфын ном бичих талаар туслалцаа хүсэхтэй агаар нэгюм.

Нөгөөтээгүүр Сионий Прайорийнхан тэртэй тэргүй ийм номыг анхааралдаа авах л байсанишүүдээ!

"Би эрдэнэс шиг чухал нэг асуулт чамд тавья!" гээд Тийбин нүдээ ирмэж, "Чи СионийПрайорийнхныг эерэг, сөрөг аль талаас нь бичив дээ?"

Ландон түүний асуултын цаад санааг тодорхой ойлгов.

Зарим нэг түүхчид Прайори ямар учраас одоо болтол Сангрийлийн баримтыг нуун далдалжбайгааг номондоо хөндөж бичдэг. Үлдсэн зарим нь баримтуудыг аль эрт задлах ёстой байсан гэжүздэг.

"Би Прайорийн талаар ямар нэг байр суурь илэрхийлээгүй".

"Байр суурь илэрхийлэхэд хангалтгүй гэж үзэв үү?"

Ландон мөрөө хавчив.

Харин Тийбин бол тэр баримтуудыг ил гаргах ёстой гэж үздэг хүн.

"Ахан дүүсийн холбоо гэж юу болох, өнөөгийн нийгэмд ч оршин тогтносоор буй дарь эх шүтээнийурсгалынхан ямар учиртай болох, Грейлийг хадгалан хамгаалагчид болон нууцыг чандлан сахидагталаар л номондоо бичсэн".

Софи Ландон руу харж, "Чи Оньсон чулууны талаар бичсэн үү?" гэж асуув.

Ландон давхийв. Тэр үнэндээ энэ талаар номондоо хэд хэдэн удаа бичиж оруулсан юм.

"Оньсон чулууг Сионий Прайорийнхан Сэнгрийлийг нуухдаа ашигладаг талаар цухас дурдаадөнгөрсөн".

Софи тэр даруй ухаарч, "Ийм болохоор л, Роберт Ландоныг ол гэж өвөө надад бичиж үлдээсэн юмбайна л даа!" гэж шүүрс алдан хэлэв.

Ландоны бичсэн зүйл үнэхээр Жак Сониехийн анхаарлыг зүй ёсоор татсан байх гэж Америк эр басөмнө нь бодож байжээ. Гэхдээ энэ бодлоо Софитой хоёулхнаа байхдаа ярилцсан нь дээр гэж бодожбайсан юм.

"Тэгэхээр чи Бэзү Фаашид худал мэдүүлсэн байх нь ээ?"

"Яалаа гэж".

"Чи өвөөтэй нэг ч удаа харьцаж байгаагүй гэж хэлсэн гэсэн биз дээ?"

"Би үнэхээр харьцаж байгаагүй. Манай редактор л номын хуулбарыг өвөөд чинь

явуулчхаж".

"Роберт, чи бод доо! Ахмад Фааш хэрэв редакторын чинь үсэгтэй захиаг олохгүй бол, чамайг өвөөрүү номынхоо хуулбарыг илгээсэн гэж бодох болно шүү дээ! Бүр муугаар бодвол, чамайг өөрийнбиеэр тэр орой гар бичмэлээ аваачиж өгсөн гэж сэжиглэх болно".

Тэднийг нисэх онгоцны буудал дээр хүрч ирэхэд, Реми онгоцны саравч руу чиглэн давхив. Машиныг ойртон очих бараанаар, онгоцны саравчнаас арзгар үстэй, ажлын ногоон хувцастай хүндалласаар гарч ирээд, саравчны төмөр том хаалгыг нээв. Саравчин дотроос дэгжин цагаан онгоцхарагдах нь тэр. Ландон онгоцыг ширтэж, "Элизабет мөн үү?" гэж Тийбинээс асуув.

Тийбин жуумалзаж, "Өөр хэн байх вэ?" бахадсан дуугаар хариулав.

Нөгөө ногоон хувцастай хүн тэдэн рүү дөхөж ирээд, "Бараг бэлэн болсон, эрхэм ээ!" гэж хэлэх нь Британи аялгатай дуулдах аж. "Жаахан удаж байгаад уучлаарай! Гэхдээ та мөн ч тулгаж хэлсэншүү..." гээд цааш ярих гэснээ, машин доторх бусад хүмүүсийг харангуутаа, бүлх залгисан юм шиг дуугаа хураачхав.

"Эд бол миний танилууд байгаа юм. Бид Лондон руу нисэх ёстой. Бидэнд цаг алга. Хурданхөөрөхөд бэлдээрэй!" гэж Тийбин арзгар үстэд даалгав.

Ингэж хэлээд, Тийбин өвөр дээрээ байсан бууг Ландонд өгөөд, машинаас буув. Ногоон хувцастай нисэгч хүйтэн амтай зэвсгийг хараад, нүд нь орой дээрээ гарчхав.

Тэрээр Тийбин рүү дөхөж очоод, "Эрхэм ээ, өршөөгөөрэй! Гэхдээ миний нислэгийн эрх зөвхөн таболон таны үйлчлэгч хоёрт л хамаатай. Би өөр хүмүүсийг тээвэрлэх эрхгүй" гэж бараг шивэгнэх шахам учирлав.

"Ричард!" гэж Тийбин эелдгээр инээмсэглэн хэлээд, "2000 фунт Стерлинг, цэнэгтэй буу хоёрбиднийг бүгдийг онгоцондоо тээвэрлэ гэж чамд тушааж байна" гээд машин руу зааж, "Бас нэгэзгүй залуугийн хамт" гэв.

Хэсэг 69

Хокер 731 - ийн хос хөдөлгүүр нижгэнэн асаад, захгүй тэнгэрийн зүг цойлон дүүлэв. Цонхоор доошхарвал, Ле Бургегийн нисэх онгоцны буудал тээр доор жижигрэн жижгэрсээр хоцрох аж.

Софи зөөлөн суудалд шигдэнгээ, эх орноосоо явж байгаагаа бодож эргэцүүлэв. Энэ мөчийг хүртэл бүсгүй Бэзү Фааштай муур, хулгана болон хөөцөлдөж байсан юм.

Гэхдээ би гэм буруугүй хүнийг хамгаалах гэж, өвөөгийнхөө захиасыг биелүүлэх гэж, энэ бүхни йгхийсэн шүү дээ!

Гэтэл ингээд зугтана гэдэг Софигийн үлдсэн бүх боломжийг үгүй хийж байгаа юм. Бүсгүйсэжигтэн хүнийг дагуулаад ямар ч бичиг баримтгүйгээр, бас барьцааны хүний хамт эх орноо орхиж байгаагаа ойлгож байв. Хэрэв шалтгийн хязгаарын шугамыг татсан байсан бол, Софи өдийд альхэдийн шугамыг давж гишгэжээ. Бүр нүд ирмэхийн зуур шүү!

Реми гартаа буу барьчхаад, эзнийгээ тушаавал, өмнө нь хүлээстэй хэвтэх хуврагийг яахад ч бэлэнсууж байв. Хувраг альбино Ремигийн хөл доор боодолтой ачаа шиг нумран хэвтэнэ.

"Онъсон чулуу руу анхаарлаа хандуулахаас өмнө би нэг зүйл хэлмээр байна!" гэж Тийбин хэлэв. Түүний дуунд эргэлзсэн байдал илт тодрох нь эцэг хүн хүүхдүүддээ эр эмийн ёсны талаартайлбарлах гэж байгаа юм шиг харагдана.

"Найзууд минь, миний аз болж, би та хоёртой хамт байгаадаа маш их баяртай байна. Гэхдээ Грейлийг хайгчийн хувьд, та нарыг хэцүү бэрх, ээдрээтэй, буцах эрхгүй, уртаас урт зам хүлээж байгааг урьдчилан анхааруулах хэрэгтэй. Грейл хайгчийн замын хүзүү аюул эрсдэл, аймшиг, адалявмаар дүүрэн байдаг юм шүү!" гээд Софи рүү харж, "Нөвү авхай! Ариун Грейлийг цааш хадгалжүлдээхийн тулд, өвөө чинь криптексийг чамд өгсөн".

"Тиймээ".

"Тэгэхээр, чи хүссэн хүсээгүй энэ замаар явах үүрэг хүлээсэн гэсэн үг"

Софи дотроо маш их зөрчилдөж байсан ч, дуугүй л толгойгоо дохив.

Бүсгүйг түүний гэр бүлийнхнийх нь тухай бодол шаналгах аж. Ландон хэдийгээр Оньсон чулуу Софигийн гэр бүлтэй ямар ч холбоогүй гэж батлах боловч, олон жилийн турш сэтгэлд нь харанхуйнүх шиг онгойж байсан, тэр л зүйлд өвөөгийнх өөрийн гараар хийсэн криптекс хариулах болов уугэж бүсгүй битүүхэндээ горьдоно.

"Өнөө шөнө өвөөтэй чинь хамт нөгөө 3 нь алагдсан. Тэд сүмийнхнээс Оньсон чулууг нууж байсан. Гэтэл Опус Дейгийнхэн гарч ирээд, криптекст хүрэхэд ганц алхам дутсан. Харин энэ бүхний эцэс тчамд маш их үүрэг хариуцлага ирж байгааг, чи лав ойлгож байгаа байх. Галт бамбарыг гарданавсантай адил гэсэн үг. Тийм болохоор 2 мянган жилийн турш унтраагүй, тэр галыг чи цаашүргэлжлүүлэн асаах ёстой! Энэ галт бамбар буруу хүмүүсийн гарт орж хэрхэвч болохгүй" гээд Тийбин Сарнайн дүрст модон хайрцаг руу харангаа, "Нөвү авхай! Миний бодлоор, чи үүрэг хариуцлагыг үүрч гарах, эсвэл өөр хэн нэгэнд түүнийгээ шилжүүлэх ёстой".

"Өвөө надад криптексийг гэрээсэлж үлдээсэн болохоор, би бүхнийг нуруундаа үүрэх болно".

Тийбин үүнд урамшсан боловч, түүний үгэнд бүрэн итгэхгүй байв. "Сайн байна! Гэрээслэл бол яахаргагүй чухал зүйл. Гэхдээ Оньсон чулууг нэгэнт нээчих юм бол, улам хүнд сорилтууд биднийг хүлээж байгаа гэдгийг чи эхлээд ойлгоорой!"

"Ямар сорилт?"

"Хонгор минь, Ариун Грейлийн байгаа газрыг заасан газрын зургийг чи өөрийнхөө гарт байна гээд төсөөл дөө! Энэ бол хүн төрөлхтний түүхийг бүрмөсөн өөрчлөх тэр сүр хүч чамд байна гэсэн үг. Энэхүү үнэн түүхийг хүн төрөлхтөнд мэдүүлж ойлгуулах үүрэг хүлээсэн хүн бол чи. Үүнийг залруулж, ил гаргасанд талархан хүлээж авах хүн ч олон, үүний төлөө чамайг жигшиж, үзэн ядах хүн нь илүү олон байх болно. Гэхдээ энэ бүхний эцэст чи зорилгоо бүрэн гүйцэлдүүлж чадах уу? гэсэн асуудал хамгийн чухал нь юм".

Софи түр тээнэгэлзэж, "Би энэ бүхнийг ганцаараа хийж чадахгүй шүү дээ?" Тийбин хөмсгөө өргөж, "Чадахгүй гэнэ ээ? Оньсон чулууг эзэмшиж байгаа хүн л үүнийг чадахгүй юм бол өөр хэн чадах юм бэ?"

"Нууцыг олон жил хадгалснаараа Ахан дүүсийн холбоо шийдвэрийг гаргах биз" .

"Прайори юу?" гэж Тийбин эргэлзээд, "Гэхдээ яаж тэр вэ? Ахан дүүсийн холбоо өнөө шөнө бүрмөсөн сүйрсэн. Чи ч өөрөө үүнийг мэдэж байгаа. Бид яг юу болсныг мэдэхгүй ч, хэн

нэг нь Сионий Прайорийн тэргүүлэгч гишүүдийн нэрийг олж чадсан байна. Би л байсан бол Ахандүүсийн холбооны хэнд нь ч итгэхгүй байх байсан даа!"

"Чиний бодлоор бид тэгээд яах ёстой вэ?" гэж Ландон асуув.

"Сионий Прайорийнхан үнэн түүхийг хумхийн тоос болох хүртэл нь, энэ олон жилийн туршнуугаагүй гэдгийг чи, бид хоёр сайн мэднэ. Тэд тохиромжтой мөчийг хүлээж байсан.

"Үнэн түүхийг дэлгэж болох тохиромжтой цаг, хугацаанд урьдаас тэд бэлтгэж байсан".

"Тэр хугацаа нь болчихсон гэж бодож байна уу?" гэж Ландон асуув.

"Яг тийм. Үүнээс илүү тодорхой зүйл гэж байхгүй. Бүх шинж тэмдэг нь бүрдээд, СионийПрайоричууд үүнийг, урьдаас төлөвлөсөн байгаагүй бол, Сүмийнхэн юу боллоо гэж иймжигшүүртэй үйлдэл хийх вэ дээ?"

Софи үүнийг эрс эсэргүүцэж, "Хувраг бидэнд одоо болтол зорилгоо хэлээгүй байгаа шүүдээ!"

"Хуврагийн зорилго бол Сүмийнхний зорилго. Тэд баримтуудыг устгахад ганц хуруу дутсан. Харин Прайорийн гишүүн байсан өвөө чинь чамд итгэл хүлээлгэсэн байна, Софи. Ариун Грейлийгхадгалж хамгаална гэдэг бол эцэст нь хүн төрөлхтөнд нууцыг мэдүүлэх зорилго дотроо агуулжбайгаа юм".

Ландон түүний үгийг сөрж, "Лей, чи Софиг битгий шахаач! Тэр хэдхэн цагийн өмнөөс лСангрийлийн тухай мэдэх болсон шүү дээ!"

Тийбин санаа алдаад, "Намайг тулгаж байгаад өршөөгөөрэй, Софи авхай! Би нууц баримтуудыг олон нийтэд дэлгэх ёстой гэж үздэг ч, энэ удаад таны шийдвэрээс бүх зүйл х амаарна шүү дээ. Гэхдээ эхлээд Онъсон чулууг бид нээх хэрэгтэй гэдгийг надаар хэлүүлэлтгүй, та нар мэдэж байгаабиз дээ".

"Эрхмүүдээ!" гэж Софи эрс шийдмэг дуугараад, "Та нарын хэлсэнчлэн *Грейлийг чи олохгүй бол, Грейл чамайг өөрөө олно* гэсэн үгийг би одоо ойлгож байна. Грейл над дээр өөрөө ирсэн болохоор, цаг нь болоход, би бүгдийг өөрөө шийдэх болно" гэв.

Түүнийг хэлсэн үгэнд нөгөө хоёр нь давхийн цочих шиг болов.

"Тийм болохоор," гээд Софи өмнөх модон хайрцаг руу дохиж, "Ажилдаа орьё!" гэв.

Хэсэг 70

Шатү Виллетийн танхимын задгай пийшин дэх галыг харж зогсохдоо, дэслэгч Коле цөхрөнгөөбарсан байдалтай харагдана. Ахмад Фааш дөнгөж түрүүхэн ирсэн бололтой, хажуугийн өрөөндRange Rover - ийн байршлыг тогтоолгох гэж утсаар хашхична.

Машин хаана ч байж болно гэж Коле бодов.

Фаашийн тушаалыг зөрчиж, Ландоныг хоёр дахь удаагаа хамар доороосоо алдсан боловч, шинжээчийн багийнхны шалан дээрээс илрүүлсэн сумны нүх Колегийн түргэдэж хийсэн алхмыгзөвтгөж байв. Гэвч ахмад түүнд уурласан хэвээр бөгөөд, маш ээдрээтэй асуудлууд шийдэгдээгүйхэвээр байгааг, Коле мэдэж байв. Гадаа байсан хар Аудиг хуурамч нэр дээр түрээсэлж авсанбололтой, бас машин доторх хэвлэмэл хуудаснууд Интерполын мэдээллийн санд огт байхгүй байв.

Нэг цагдаа гүйхээрээ орж ирээд, сандарсан дуугаар, "Ахмад Фааш хаана байна?" гэж

асуув.

Коле унтарч буй галаас нүдээ салгалгүйгээр, "Утсаар ярьж байна" гэж хариулав.

"Би яриад дуусчихлаа!" гээд танхимд дөнгөж орж ирсэн Фааш хэг ёг хэлээд, "Юу болоо вэ?" гэжнөгөө цагдаагаас асуув.

Цагдаа хариуд нь, "Эрхэм ээ! Төвөөс ярьж байна. Цюрихийн Хадгаламжийн банкны захирал АндреВехне гэдэг хүн мэдүүлгээ өөрчлөөд, тантай аминчлан уулзмаар байна гэж ярьсан гэнэ".

"Өө тийм үү?" гэж Фааш хэлэв.

Коле тэдэн рүү анхаарлаа хандуулав.

"Өнөө шөнө Софи, Ландон хоёрыг банканд байсныг Вехне нотолж байгаа гэнэ".

"Тийм л байх ёстой. Вехне яагаад өмнө нь худал хэлсэн юм бол?"

"Тэр тантай зөвхөн нэг нөхцөлөөр илэн далангүй бүхнийг ярилцана гэж байна".

"Ямар нөхцөлөөр?"

"Тэдний банкиг олон нийтийн хэвлэл мэдээллээр гаргахгүй байхыг, бас хулгайлагдсан зүйлийгэргүүлж авахад тусалбал ярилцана гэнэ. Бодвол Софи, Ландон хоёр ямар нэг зүйл түүнээсбулаагаад, тэр даруй зугтсан бололтой".

"Юу гэнэ ээ? Яаж тэр билээ?" гэж Коле тэднийг цочтол, яриан дундуур нь орж асуув.

Фааш түүнийг огт хайхарсангүй чигтээ, цагдаа руу ширтээд, "Тэд юу хулгайлсан гэж байна?"

"Вехне энэ тухай хэлээгүй гэнэ. Гэхдээ тэр зүйлээ буцааж авахын тулд, амиа ч өгөхөд бэлэн байгаабололтой".

Коле хэрхэнийг дотроо төсөөлнө.

Тэр хоёр банкны захиралд буу тулгасан байх, тэгээд Сониехийн хайрцгийг нээхийг шаардаж, Дараа нь хуягт машинаар зугтаасан байх нь.

Гэвч Колегийн энэ бодолд Софигийн дүр огтхон ч тохирохгүй байв.

Гал тогооны өрөөнөөс бас нэг цагдаа ахмад руу орилж, "Ахмад аа! Би ноён Тийбиний байнгазалгадаг утасны дугааруудыг жагсаалтаас нь шалгалаа. Саяхан Ле Бурге рүү утсаар холбогдсончинь, маш муу мэдээ сонсогдлоо".

Хагас минутын дараа Фааш Шатү Виллетийг орхиж явахад бэлэн болсон байв. Тийбинийг ЛеБургед хувийн онгоцтой гэдгийг, бас хагас цагийн өмнө тэндээс хөдөлж, онгоцоор хөөрсөн гэдгийг ахмад олж мэджээ. Бургегийн ажилтан утсаар түүнд хэлэхдээ, түүнтэй хамт хэн ниссэнийг, басхаашаа ниссэнийг огт мэдээгүй гэсэн ажээ. Түүний хэлснээр, энэ бол хуваарьт нислэг биш байсанаж. Энэ нь хувийн нисэх онгоцны буудлын хувьд хууль зөрчсөн үйлдэл байлаа.

Фааш бүрэн эрхээрээ далайлган сүрдүүлж байгаад, хүссэн асуултдаа хариу авна даа гэж бодожамжив.

"Дэслэгч Коле!" гэж Фааш орилоод, "Би чамайг шинжээчийн багтай цуг энд үлдээлээ. Нөхцөлбайдал өөрчлөгдвөл, ухаантай л хөдөлж үзээрэй!" гэж аминчлан захисаар тэндээс хөдөллөө.

Хэсэг 71

Хокер онгоц чиглэлээ алгуур өөрчилж, Англи руу залуураа хазайлгахад, Ландон өвөр дээрх модонхайрцгаа гулсах вий гэж гар дээрээ өргөв. Ландон өөрийг нь хүлээж ядсан харцаар харах Софи, Тийбин хоёрын өмнө хайрцгийг ширээн дээр тавив. Тэрээр тагийг нь нээж байхдаа, хамаг

анхаарлаа криптикст биш, харин тагны доорх жижиг нүхэнд төвлөрүүлнэ. Үзэгний хошуугаар нүхрүү нь чичиж, Сарнайн дүрстэй шигтгээг дахин ховхолж унагаад, доод талд нь байх үгийг гаргажирэв.

"Sab Rosa" гэж сэтгэл хангалуунаар хэлээд, бүх эрч хүчээ төвлөрүүлэн байж, тэрхүү үл мэдэгдэххэлээр бичигдсэн үгийг ширтэв.

Удалгүй дахиад л тэрээр үсгүүдийг мэдэхгүй юм шиг санагдсан тул, "Лей, би үүнийг уншиж чадахгүй юм байна" гэв.

Софи ширээний нөгөө талд суусан учир үгийг сайн хараагүй боловч, Ландоныг уншиж чадахгүйбайгааг сонсоод ихэд гайхна. Тэмдэгт судлаачийн мэддэггүй хэлээр өвөө бичсэн гэж үү?

Гэвч энэ гайхшрал бол Софигийн хувьд өвөөгийнхөө нууцыг мэдэж буй анхны тохиолдол биш ю м.Ширээний эсрэг талд суусан, Софи, Тийбин хоёр тэр үгийг харахаас тэсвэр алдан, доороохавчигнана. Гэвч Ландон баясал тодруулсан харцаар, урагш бөхийнгөө хайрцгийг ажигласанхэвээр, тэр хоёрыг анзаарахтай манатай байв.

"Би мэдэхгүй юм байна" гэж Ландон шивэгнээд, "Би анх хараад Семит хэлээр бичсэн гэж бодожбайсан юм. Гэтэл одоо үүндээ ч итгэлгүй болчихлоо. Семит хэлэнд неккудот орсон байдаг. Харинэнд нэг ч алга" гэв.

"Эртний хэлээр бичсэн байж магадгүй" гэж Тийбин түүнд зөвлөв. "Неккудот гэж юу вэ?" гэж Софиасуув.

Тийбин хайрцгаас харцаа салгалгүйгээр, "Семит хэлний цагаан толгойд эгшиг үсэг байдаггүй юм. Тийм болохоор эгшгийн оронд жижиг цэг эсвэл зураас тавьж тэмдэглэдэг. Түүхэн талаасаанеккудот сүүлд гарч ирсэн юм".

Ландон бичгийг харсан хэвээрээ, "Сефардын цагаан толгойгоор бичсэн ч юм уу?"

Тийбин цааш тэвчсэнгүй, "Магадгүй, би ..." гээд гараа сунгаж хайрцгийг татаад өөртөө ойртуулав.

Ландон бичээсийг Грек, Латин, Ром хэлний аль нэгээр бичсэн гэдэгт эргэлзэхгүй байв. ГэвчТийбин дөнгөж харангуугаа, шал өөр зүйл олж мэдэх ч шиг. Раши үсэг эсвэл СТА'М - ээр бичсэнюм шиг харагдаж байв.

Гүн амьсгал авсан дороо, Тийбиний нүд бичээс дээр тогтов. Тэрээр нэлээд удаан хугацаанд юу чхэлсэнгүй. Хугацаа өнгөрөх бүр түүний итгэл найдвар нь багасах тул, "Би бүр гайхаж хоцорлоо. Ийм үсэг анх удаагаа л харж байна" гэв.

Ландон бас цөхрөв.

"Би үзье дээ!" гэж Софи хэлэв.

Тийбин бүсгүйн хэлснийг сонсоогүй дүр үзүүлээд, "Роберт, чи түүрүүнд ийм үгийг хаа нэгтээхарсан гэж хэлээгүй билүү?"

Ландон цухалдангүй байдалтай, "Харин тэгж бодоод байна. Гэхдээ сайн мэдэхгүй байна. Нэг л танил үсэг шиг санагдаад байх юм".

"Лей!" гэж Софи ярианд оролцуулаагүйд, дурамжхан байгаагаа илтгэн, чангаар дуугараад, "Биөвөөгийнхөө хийсэн хайрцгийг үзэж болно биз дээ?!"

"Тэгэлгүй яахав, хонгор минь!" гээд Тийбин түүн рүү хайрцгийг дөхүүлэв.

Английн нэрт түүхч, Харвардын тэмдэгт судлаач хоёрын аль аль нь тайлж уншиж чадахгүйбайхад, энэ бүсгүй яав л гэж.

"Аан!" гэж Софи хайрцгийг хэсэг ажигласныхаа дараа, нүд нь гэрэлтээд, "Би үүнийг мэдчих шигболлоо" гэж хэлэв.

Тийбин, Ландон хоёр түүн рүү харж, нэгэн дуугаар, "Юу мэдсэн гэж?" хэмээн шалгаав.

Софи мөрөө хавчаад, "Өвөө ийм үсгээр зарим нэг зүйл бичиж тэмдэглэдэг байсныг, би санах шигболлоо".

"Чи үүнийг уншиж чадна гэж хэлэх гээд байна уу?" гэж Тийбин хашхичив.

"Үүн шиг амархан зүйл байхгүй" гэж Софи сэтгэл хангалуун өгүүлээд, "Өвөө намайг 6 - тайд энэхэлийг зааж өгсөн юм. Би ч гаргууд сурсан" гээд Тийбин рүү зэмлэсэн харцаар харж, "Та титэмөмссөн, тайж хэргэмтэй, алдарт түүхч байтлаа үүнийг мэдэхгүй байна гэж үү?"

Тэр мөчид Ландон бичгийг олж мэдэх шиг болов. *Үсэг их л танил юм шиг харагдаад байсан нь, иймучиртай байжээ!*

Хэдэн жилийн өмнө Ландон Харвардын сургуулийн дэргэдэх Фоггийн музейг үзэж сонирхсон юм. Харвардын сургуулийг дундаас нь хаясан алдарт тэрбумтан Билл Гейтс тэр музейд нэгэн үзмэрийгбэлэглэсэн байсан нь, Арманд Хаймерийн дуудлага худалдаанаас авсан, 18 хуудас бичээс байсан юм. Түүнд Гейтс 30,8 сая долларын үнэ хэлж, дуудлага худалдаанаас авч байжээ. Энэ бол Леонардо Да Винчийн гар бичмэлүүд байсан юм. 18 хуудас бүхий тэр тэмдэглэлийг Леонардогийн Кодекс Лайсестр гэж нэрлэдэг бөгөөд, түүн дотор Да Винчийн одон орон судлал, геологи, археологи, ус судлалын гайхамшигт онолууд бичигдсэн байдаг.

Ландон тэр хосгүй үнэтэй хуудаснуудыг харахын тулд, музейн урт цуваанд удаан хүлээсэн юм. Маш цэвэрхэн, гаргацтай юм шиг харагдах тэр бичгийг шаргал цаасан дээр, ягаан бэхээр бичжээ. Гэвч түүнийг уншихад төвөгтэй байж. Ландон эхэлж хараад, Да Винчи

тэдгээр тэмдэглэлээ эртний Итали хэлээр бичсэн байна гэж боджээ. Гэвч улам ойртоод хартал, Итали хэлний цагаан толгойннэг ч үсэг тэнд үзэгдээгүй аж.

"Та ийшээ харна уу?" гэж үзмэр хариуцагч эмэгтэйг хэлэхэд, үзмэрийн шилэн хоргоны дотор нэгэнжижиг толь байрлуулсан байв. Ландон толь руу хартал, бүх зүйл тодорхой болох нь тэр. Ландонсуут сэтгэгчийн бас нэг гайхамшигт нууц авьяасыг ор тас мартсанаа ойлгож, урвуулж бичсэн гарбичмэлийг нь шимтэн харсан юм.

Зарим түүхчид үүнийг Да Винчи өөрийнхөө санааг хүнд уншуулахгүй, гадагш алдахгүй гэсэндээингэж бичдэг байсан гэж үздэг ч, үнэндээ тэрээр зүгээр л ингэж бичих дуртай байсан ажээ.

Ландоны ойлгож байгааг Софи хараад, сэтгэл хангалуунаар инээмсэглэж, "Би энэ хэдэн үгийгуншаадахъя. Энд Англиар бичсэн байна" гэв.

Тийбин амандаа бувтнан, бүр будлисан байртайгаар, "Энэ чинь юу болоод байна аа?"

"Урвуулсан бичиг" гэж Ландон хэлээд, "Бидэнд толь хэрэгтэй" гэв.

"Хэрэггүй ээ! Энэ их хялбархан" гээд Софи хайрцгийг гэрэлд ойртуулан уншив.

Өвөө нь үнэндээ урвуулж бичихгүйгээр, хүний толгойг эргүүлэхийн тулд, зөв талаар нь бичээд, дараа нь цаасаа доош харуулан, гэрэлтсэн хэсгийг дахин хуулж бичдэг байж.

Бүсгүй бодсон нь яах аргагүй зөв байлаа.

Хэсэг 72

"Англиар," гэж Тийбин толгойгоо гудайлган паржигнаад, "Миний төрөлх хэл дээр гэнэ ээ" гэжгутарсан байдалтай гоншгонов.

Ландон толгой дохино. Сүмийнхнээс ямагт ялгарч байхын тулд, Сионий Прайоричууд Европ хэлдотроос илүү цэвэр үлдсэнээр нь, Англи хэлийг илүүд үзэж суралцдаг байжээ. Франц, Испани, Итали хэл бүгд л латин хэлнээс гаралтай бөгөөд, энэ нь цааш гүнзгийрвэл, Ватикантай салшгүйхолбоотой гэсэн үг. Харин Англи хэл Ромын дарангуйллын савраас салангид байж чадсан учраас, Ахан дүүсийн холбооны гишүүд энэ хэлийг сурч, өдөр тутмын амьдралдаа хэрэглэдэг байжээ.

"Энэ шүлэгт зөвхөн Грейл ч биш, бас Хөлөг баатруудын холбоо, болон Мэри Магдалинийг гэрбүлийн тухай хөндсөн шиг байна. Онъсон чулууны нууц үг нь ..." гээд Софи шүлэг рүү дахин харж, "Эртний хэлээр оюун ухаан гэсэн утгатай үг юм шиг байна" гэв.

"Тэгвэл АБРАКАДАБРА байх нь" гэж хэлээд Тийбиний нүд гялалзав.

5 үсэгтэй, бас тийм утгатай үгийн жагсаалт төгсгөлгүй үргэлжилж болох юм шиг Ландондсанагдана.

Магтуу дууны үг, зурхайн хэл, нууц бүлэглэлийн хэллэг, Египетийн дүрс тэмдэгт, шашингүйнүзлийнхний сударт бичигдэж үлдсэн ямар ч үг байж болно шүүдээ!

"Нууц үг нь бас хөлөг баатруудтай уялдаж байх шиг байна" гээд Софи шүлгийг чангаар уншив.

"Холбооныхны байрлуулсан толгой чулуу бол түүнд хүрэх гол түлхүүр".

"Лей, чи чинь Хөлөг баатруудын холбоог судалдаг биз дээ? Санаа алга уу?".

Тийбин хэсэг дуугүй сууж бясалгаснаа, санаа алдаж, "Толгой чулууг Грейлтэй холбож ойлгожболно. Учир нь Мэри Магдалиний бунхан дээр тэр чулууг байрлуулсан юм. Гэхдээ Магдалинийбулш хаана байгааг бид мэдэхгүй байна шүү дээ!"

"Сүүлийн мөрөнд..." гээд Софи цааш уншив. "Атбаш үнэнийг илчилнэ" гээд гэнэт сэрдхийж, "БиАтбашийн тухай сонссон юм байна. Атбаш!"

"Үүнд гайхах зүйлгүй" гэж Ландон хэлээд, "Мэргэжлийн хичээл дээр чинь заасан байх ёстой.Атбашийн цифр бол одоогоор хүн төрөлхтөнд мэдэгдээд байгаа хамгийн эртний код юм".

Тэгэлгүй хаачхав! гэж Софи энэ тухай бодов.

Бас өөрөөр Хебрюгийн хөрвөх систем гэж нэрлэдэг. Энэ цифр бол нийтийн тооллын өмнөх 500онд анх гарч ирсэн бөгөөд, орлуулалтын схемийн хичээлд байнга жишээ болж заагддаг юм. Энэ ньХебрюгийн цагаан толгойн 22 үсэг дээр үндэслэсэн орлуулах аргаар код хийх арга юм.

Атбашийн кодоор бол цагаан толгойн эхний үсэг нь сүүлээсээ эхний үсгээр орлуулагддаг, эхнээсээхоёр дахь үсэг нь сүүлээсээ хоёр дахь үсгээр орлуулагддаг гэх мэт цааш үргэлжилдэг.

"Атбаш бол тэнгэрлиг зүйл. Атбашаар бичигдсэн олдвор, баримтуудын дотор Каббали, СөнөсөнТэнгисийн баримт, мөн Хуучин Гэрээ ч ордог юм. Еврей судлаачид одоо хүртэл, Атбашаардамжуулан далд утгатай олдворуудыг тайлж, нээн илрүүлсээр байгаа. Тэгэхээр СионийПрайоричууд бас Атбашид суралцдаг байх нь ээ?" гэж Ландон гайхшрав.

"Гэхдээ Атбаш ашиглан унших зүйл одоохондоо бидэнд алга байна шүүдээ!" гэж Софи хэлэв.

Тийбин санаа алдаад, "Тэгвэл толгой чулуун дээр кодыг бичсэн байх нь. Бид түүнийг олох ёстой!"

Тэр чулууг оллоо гэхэд юу ч өөрчлөгдөхгүй гэсэн янзтай байхыг, Софи Ландоны царайнаас олжанзаарав.

Атбаш бол хүрэх түлхүүр. Харин бид хаалгыг нь мэдэхгүй байгаа.

3 хормын дараа, Тийбин хүндээр шүүрс алдаад, толгой сэгсэрч "Найзууд минь, Би бүр гацчихлаа!Та нарт идэх юм авчрангаа, урилгагүй зочин болон Ремин хоёр дээр очиж, байдлыг шалгаад ирье"гэв.

Тэр босч онгоцны арын хэсэг рүү зүглэв. Софи түүний хазганан явахыг, араас нь хараад, өөрийнэрхгүй ядарснаа мэдрэв. Онгоцны цонхоор харвал үүр хаяарахын өмнөх тас харанхуй болж байлаа.

Онгоцноос ямар ч бодол тээлгүйгээр доош үсрээд, зөөлөн газардах юмсан! гэж Софи мөрөөднө.

Бага байхаасаа л өвөөгийнхөө тааврыг тааж байсан хирнээ, одоо бол энэхүү хэцүү бэрх тааврыгтаах ямар ч бололцоогүй мэт түүнд санагдана. Тааврын цаана ямар нэг утга байгаа нь мэдээжболовч, одоохондоо толгойд нь юу ч орж ирсэнгүй.

Бүсгүйг шаналгаж буй өөр нэг бодол бол, криптексийг нээлээ гэхэд дотор нь зүгээр ч нэг АриунГрейл тэнд байгаа гэсэн газрын зураг гарч ирэхгүй байх гэдэгт хатуу итгэж байв.

Өвөө нь хялбар аргаар нууцаа үлдээж, гэрээслэх хүн биш гэдгийг Софи нөгөө хоёроосоо илүүмэднэ.

Тэмээ хариулсан хүн, буурныхаа занг андахгүй ээ гэж!

Хэсэг 73

Ле Бурегегийн нисэх онгоцны буудлын хяналтын ажилтан хоосон эргэлдэх радарын самбарынхаа өмнө зүүрмэглэж байтал, цагдаагийн ахмад хаалга зад түлхсээр, өрөөнд нь орж ирэв.

"Тийбиний онгоц хаашаа явсан?" гэж Бэзү Фааш сүр бадруулсаар орж ирэв. Хяналтын ажилтан үйлчлүүлэгчийнхээ эрхийг хамгаалах үүднээс, хариу өгөхгүй дуугүй суугаад, ахмадыг энэ авирыгогт хайхарсангүй.

"За тэгвэл чамайг хуваарьт нислэгийг зөвшөөрсөн гэсэн үндэслэлээр баривчиллаа!" гээд Фаашхамт ирсэн гавтай цагдаа руу эргэж харахад, хяналтын ажилтан барьц алдаж, маш ихээр сандрав.

Гавны гинж харжигнах чимээнээр, "Хүлээгээрэй, би танд бүгдийг хэлье! Ноён Лей Тийбин Лонд онруу эмчлүүлэхээр явахдаа эндээс чөлөөтэй нисдэг юм. Тэр онгоцныхоо саравчийг Лондон дахь Биггин Хилл буудалд байршуулсан гэсэн. Тэр нь Лондоны захын дүүрэгт байдаг гэнэлээ".

Фааш дөхөж ирэх гавтай цагдааг болиулаад, "Тэд өнөө шөнө тийшээ ниссэн үү?"

"Би мэдэхгүй байна" гэж хянагч үнэнээсээ өчөөд, "Онгоц нисдэгээрээ нисч, радарын самбарт харахад, Англи руу чиглээд явж байсан. Биггин Хилл рүү байхаас зайлахгүй".

"Тэр өөр хүмүүстэй цуг явж байсан уу?"

"Би тангараглая! Энэ талаар би үнэндээ мэдэх боломжгүй. Манай үйлчлүүлэгчид энд ирэнгүүтээ, өөрсдийн саравч руугаа шууд очиж хүссэн зүгтээ тааваараа нисдэг юм. Зорчигчид нь ямар хүмүүс байсныг гаалийн ажилтан хариуцаж мэдэх үүрэгтэй".

Фааш цагаа хараад, энд тэндгүй зогссон гадаах онгоцнууд руу ширтсэнээ, "Хэрвээ тэд Биггин Хилл рүү ниссэн бол, хэдийн үед тэнд газардах вэ?"

Хянагч дотроо тооцоолж байснаа, "Маш ойрхон газар шүүдээ! Онгоц лав 6:30 гэхэд тэнд газардчих байх. Өөрөөр хэлбэл 15 минутын дараа гэсэн үг".

Фааш хөмсгөө зангидаад, нэг цагдаа руу эргэснээ, "Нэг онгоц эндээс аваадах! Би Лондон руу нислээ. Тэгээд бас Биггин Хиллийг хариуцдаг Лондонгийн цагдаагийн хэсэгтэй холбогд! Английн цагдаагийн төв газар биш шүү! Би үүнийг чимээгүйхэн хиймээр байна. Тийбиний онгоцыг газардахыг зөвшөөр гэж тэндхийн цагдаа нарт дамжуул! Дараа нь би юу хийхээ өөрөө мэднэ. Намайг очтол хэн ч хөдөлж болохгүй шүү гэж хэлээрэй!"

Хэсэг 74

"Чи яагаад дуугаа хураачхав аа?" гэж Ландон Софигоос асуув.

"Ядраад л тэр байх. Бас энэ шүлэг. Би үнэндээ юу гэхээ мэдэхгүй байна".

Ландон ч бас туйлдсан байлаа. Онгоцны хөдөлгүүрийн жигд нижгэнэх чимээ түүнийг ховстох мэт болоод, хувраг альбинод цохиулсан толгой нь одоо ч өвдсөн хэвээрээ тул, тэрээр дэн дун явж байлаа. Тийбин онгоцны араас одоо болтол ирээгүй байгаа учир, Ландон энэ сиймхийг ашиглаж, Софид өөрийн бодлыг хэлэхээр сэтгэл шулуудав.

"Өвөө чинь ямар учраас чи, бид хоёрыг нэг дор байлгах болсны учрыг би мэдчих шиг боллоо. Надаар чамд нэг зүйлийг тайлбарлуулах хэрэгтэй гэж үзсэн бололтой!"

"Ариун Грейл, Мэри Магдалинаас гадна тайлбарлах өөр зүйл үлдсэн гэж үү?"

Ландон юу гэж хэлхээ мэдэхгүй тээнэгэлзэнэ. "Чиний дотор нуугдаж байгаа тэр ангал, цав.Өвөөтэйгөө харьцалгүй 10 гаруй жил болсон явдал. Энэ бүгдийг тэр надаар тайлбарлуулахыгхүссэн байх" гэлээ.

Софи суудал дээрээ өндөлзөж, "Би чамд яагаад өвөөгөөсөө салсан учраа яриагүй шүү дээ!"

Ландон түүнийг анхааралтай ширтэж, "Чи тэр үед эр, эмийн ёслолыг харсан. Тийм үү?"

Софи огло үсрэн давхийж, "Чи яаж мэдсэн юм бэ?"

"Софи, чи өөрөө өвөөгөө нууц бүлэглэлд хамаатай байсан гэдгийг итгэлтэй х элээд, бас тэр нэгявдлыг харснаас хойш өвөөгөөсөө харьцаагаа бүрмөсөн тасалсан гэсэн шүүдээ! Би нууцбүлэглэлийнхний талаар нэлээд зүйл мэднэ".

Софи түүн рүү харц салгалгүй ширтэх аж.

"3- р сарын дундуур, хавар цаг байсан уу?"

Софи цонх руу ширтэж, "Би сургуулиа дөнгөж тараад, амралтаараа ирсэн байсан. Би тэр үедамралтаасаа арай эрт ирчихсэн байсан".

"Чи энэ тухай ярих хүсэлгүй байна уу?"

"Үнэндээ бол яримааргүй байна" гээд Софи Ландон руу эргэж харахад бүсгүй сэтгэл хөдлөлөөарайхийн барьж байгаа нь илт мэдрэгдэнэ. "Би тэр үед юу харснаа одоо ч ойлгодоггүй юм".

"Чи эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг харсан уу?"

Софи толгой дохив.

"Цагаан болон хар хувцсаар ижилссэн байсан уу?"

Бүсгүй нүдээ аниад, бас л толгой дохив. "Эмэгтэйчүүд нь цагаан торгон даашинзтай, алт ан шаргалгуталтай, бас гартаа алтан бөмбөрцөг барьсан. Харин эрэгтэйчүүд нь хар нөмрөг, хар гуталтайбайсан уу?"

Ландон энэ асуултыг асууж байхдаа, сэтгэл хөдлөлөө бүсгүйгээс нуухыг хичээнэ. Учир нь СофиНөвү 2000 жилийн түүхтэй ариун ёслолыг харсан болж таарав.

"Багтай байсан уу?" гэж тайван дуугаар асуухыг хичээнэ. "Андрогений баг байсан уу?"

"Тийм. Бүгд ижилхэн баг өмссөн байсан. Эмэгтэйчүүд цагаан, эрчүүд нь хар өнгөтэй баг зүүсэнбайсан".

Ландон энэ ёслолын тухай тайлбарыг өмнө нь уншаад, уг ёслолын шалтгаан гарлыг ойлгож мэдсэнбилээ.

"Энэ бол Гиерос Гамос" гэж Ландон намуухнаар хэлээд, "2000 жилийн турш энэ ёслолыг үйлдсээрирсэн. Эртний Египетийн шашныхан эм хүйсийн нөхөн үржихүйн хүч чадлыг бишрэн хүндэлж,энэ ёслолыг үйлддэг байсан юм" гээд бүсгүй рүү дөхөж, "Чи хэрвээ Гиерос Гамосын талаар огтмэдээгүй байхдаа, энэ бүхнийг харсан юм бол, маш их цочирдож балмагдсан байж таарна".

Софи хариуд нь юу ч хэлсэнгүй.

"Гиерос Гамос гэдэг үг Грек хэлнээс гаралтай. Энэ бол ариун гэрлэлт гэсэн утгатай үг".

"Миний харсан тэр ёслол гэрлэлттэй огтхон ч төстэй байгаагүй".

"Нэгдмэл байдлыг бэлгэдсэн гэрлэлт байгаа юм, Софи".

"Нэгдмэл байдал гэж чи бэлгийн ажлыг хэлж байна уу?"

"Үгүй дээ!"

"Үгүй гэнэ ээ?" гээд бүсгүй түүнийг цоо ширтэв.

Ландон аргагүйдэж, "За яахав. Тэгж ярьж болох л юм. Гэхдээ өнөөгийн ойлголтоор хэрхэвч тусгажавч болохгүй".

Энэ ёслол хэдийгээр бэлгийн хавьтал шиг харагдсан байж болох ч, дур тачаалтай огтхон чхолбоогүй гэдгийг Ландон хичээнгүйлэн тайлбарлана. "Энэ бол оюун санааны утга агуулгатай ёслол байгаа юм. Эр хүн эмэгтэй хүнтэй ойртоогүй байхдаа, бүтээлч байж чаддаггүй. Бүр Изисбурхны үеэс л эр хүн бэлгийн ажил хийснээр, эх газраас хөндийрч, диваажинд хүрч чаддаг гэжүздэг байжээ. Эр хүн эмэгтэй хүнтэй ойртсоноор, сэтгэлдээ юуг ч үл огоорон, орчноосоо бүрмөсөнтасрахдаа, Бурхныг оюун ухаандаа олж харах бололцоо бүрддэг гэж үздэг".

"Дур тавьснаар, Бурханд мөргөж байгаа юм уу?"

Ландон мөрөө хавчсан боловч, үнэндээ Софигийн хэлдэг зөв байлаа.

Физиологийн үүднээс авч үзвэл, дур тавих мөчид хүн ямар ч бодлоосоо бүрмөсөн ангижирдаг. Үүнийг хэзээ ч төгсөшгүй таашаал буюу Нирвана гэж нэрлэдэг аж.

"Софи, эр эмийн ёсыг үзэх эртний хүмүүсийн үзэл өнөөдрийнхөөс хавьгүй ондоо байсан гэдгийг санах хэрэгтэй. Бэлгийн ажил хийснээр шинэ амьдралыг бүтээдэг. Энэ бол ид шид. Тэр тусмаа Бурхнаас бидэнд заяасан ид шид. Эмэгтэй хүн умайдаа шинэ амьдралыг цогцлоох чадвартай байдаг нь, тэднийг ариун дагшин гэж үзэхэд хүргэдэг. Чиний харсан тэр зүйл бол бэлгийн ажилбиш, харин оюун санааны үйлдэл, ёслол байгаа юм. Энэ бол садар самуун зүйл биш. Маш гүнхүндэтгэл агуулсан ариун ёслол юм".

Ландоны хэлсэн үг Софигийн зүрхэнд тусах шиг болов. Шөнийн турш бүсгүй олон зүйлд цочирдсон ч, харин энэ удаад тэвчиж чадахгүй болсныг нь, Ландон эрхгүй анзаарав. Софигийн анхны сагыг нулимс бүрхэхэд, бүсгүй ханцуйгаараа шудран арчив.

Ландон түүний тайвшрахыг хүлээн хэсэг суув.

"Эртний сүмийнхний хувьд," гэж Ландон намуухан дуугаар эхлээд, "Бурхантай ойртохын тулд, эрэмийн ажил хийдэг гэсэн ойлголт маш аюултай санагдсан тул, сүмийнхэн зөвхөн өөрсдөөр нь дамжуулж, Бурхантай харьцах ёстой хэмээн үзээд, эр эмийн ёсыг ад зэтгэрийн үйлдэл гэж нэрлэн, энэ үйлдэл жигшмээр нүгэл хилэнцийг араасаа дагуулж байдаг гэж хүмүүст итгүүлжээ. Мөн бусад шашин ч ийм үзэл баримталсаар ирсэн".

Софи түүнийг чимээгүй сонсох боловч, өвөөгөө өмнөхөөсөө улам илүү ойлгож эхэлж байгааг, Ландон гадарлаж байв.

Ландон өнгөрсөн хичээлийн улиралд энэ тухай оюутнуудад ярьж байснаа санах.

"Манай өвөг дээдэс болон бидний физиологи өөрөө дур тачаалыг оюун санааны дээд таашаал гэдгийг хэлээд байхад, өнөөдрийн шашны урсгалд түүнийг ичгүүртэй, бузар самуун явдал гэж хуульсаар л байна".

Ландон олон баримт жишээгээр оюутнуудыг цочроож, гайхуулахыг хүссэнгүй. Харин ТомКрузийн тоглосон, "Нүдээ тас ань!" кинонд гол дүрийн эрэгтэй нэгэн нууц цуглаанд

санамсаргүйгээр оролцож, Гиерос Гамосын гэрч болж байгаа тухай гардаг. Харамсалтай нь киноныуран бүтээлчид нарийн ширийн зүйлийг буруугаар үзүүлсэн ч, ёслолын үндсэн агуулгыг ерөнхийдөө гаргаж чадсан байлаа.

"Профессор оо?" гэж нэгэн эрэгтэй оюутан гараа өргөөд, найдвар тавьсан дуугаар, "Тэгвэл табиднийг сүмд очиж мөргөхийн оронд, хүнтэй их унт гэж хэлэх гээд байна уу?"

Ландон үүнд эгдүүцэж, хариу үг хэлсэнгүй. Учир нь эдгээр дүрсгүй оюутнууд үдэшлэг зохиохбүрдээ хүнтэй унтах нь хэрээс хэтэрчхээд байгаа юм.

"Эрчүүд ээ! Би та нарт нэг зүйлийг захъя! Гэрлэхээсээ өмнө хүнтэй унтаж, бодлогогүй алхамхийхгүйн тулд хэрхэхийг би та нарт хэлж өгье".

Бүх эрэгтэй оюутнууд урагш бөхийж, түүнийг анхааралтай сонсов.

"Та нар дараагийн удаа бэлгийн ажлыг оюун санааны хувьд маш хүндэтгэлтэй үйлдэх ёстой. Зөвхөн эмэгтэй хүн байгаа болохоор л, эрчүүд бид энэ их тэнгэрлиг таашаалыг бие сэтгэлээрээ амсдаг юм шүү дээ!"

Эмэгтэй оюутнууд үүнийг сонсоод, сэтгэл хангалуунаар инээмсэглэн, толгой дохино. Харин эрэгтэйчүүдийн зарим нь бие биеэ нударч, тоглоом тохуу хийж байв.

Ландон санаа алдаж, тэднийг одоо хүртэл ухаан суугаагүй байсанд, сэтгэл дундуур байсан юм.

Софи цонхны шилэнд духаа наагаад, Ландоны хэлсэн бүхнийг сайтар эргэцүүлнэ. Түүнд цөхрөлгуниг дахин төрнө .

10- аад жил өвөө боодол дүүрэн ил захидал цөхрөлтгүй илгээж байсансан. Би Робертод бүхнийг ярих ёстой!

Цон х ноос духаа салгалгүй чигтээ, Софи дурсамжаасаа ярьж эхлэв.

Бүсгүйд чийг үнэртэж байв. Энэ бол 3 - р сар байсан юм. Тэр хананы цаана нуугдаад, гартаа улбаршаргал лаа барьсан үл таних хүмүүсийн дуулал дуулж байхыг ажиглан ширтэж байв.

Би зүүдэлж байна! гэж Софи өөртөө хэлэв. *Зүүднээс өөр юу байхав.*

Эрэгтэй, эмэгтэй хүмүүс хар, цагаан хувцас өмсөөд, сөөлжиж зогсоосон байв. Эмэгтэйчүүд нь цагаан даашинзтай байх бөгөөд, гар дахь бөмбөрцгөө дээш өргөж, нэгэн дуугаар ийнхүү хэлнэ.

"Ариун гэгээн бүхэн эхлэх тэр мөчөөс л би чамтай цуг байсан. Тэр өдрийг эхлэхээс ч өмнөхөвчлйдээ би чамайг тээж байсан".

Ингэж хэлээд, бөмбөрцгөө доош буулган, урагш хойш алхална. Тэд тойргийн төвд байх нэгэнзүйлд сүсэг бишрэл дүүрнээр ёслох аж.

Тэд юунд ёслоод байгаа юм бол?

Тэдний дууны хэмнэл улам түргэсч, дуу нь чангарна.

"Чиний харж буй эмэгтэй хүн бол хайр энэрэл" гэж бүсгүйчүүд дахин бөмбөрцгөө өргөн хэлнэ. Хариуд нь эрчүүд, "Эмэгтэй хүн мөнхөд бидний орон гэр байсан".

Дуулал дахин түргэсч улам чангарсаар, гэнэт таг чимээгүй болов. Бүгд дотогш тойрогтоохумигдаад, доош сөхөрч суужээ. Софи тэр мөчид тэдний юунд ёслоод байгааг олж харав.

Засч чимэглэсэн зурвас талбайд нэгэн эрэгтэй дээш хараад, чармай нүцгэн хэвгэж байв. Тэр эрэгтэйнүүрэндээ хар баг зүүсэн аж. Гэвч Софи түүнийг харангуугаа дор нь танив.

Бүсгүй золтой л хаширчихсангүй. Өвөө!

Софи энэ дүр зургийг харсан даруйдаа, нүдэндээ ч итгэхгүй байв. Цагаан баг зүүсэн эмэгтэ йөвөөгийнх нь дээр гарчихсан, бас л чармай нүцгэн сууж байв. Эмэгтэйн урт цагаан үс ар нуруу руунь асгарчээ. Тэрээр махлаг тарган бөгөөд, дууны хэмнэлийг даган хөдөлж, өвөөтэй нь "дурлалынажил" хийж байв.

Софи нүүрээ буруулж, тэндээс гарах гэсэн ч хөдөлж чадсангүй. Тойргоор эгнэн суусан, хүмүүсодоо харин дуулж байв. Софи хананы цаана, амьсгалж ч чадахгүй цурхиран уйлж суув.

Эцэст нь бүсгүй шатаар дээш чимээгүй өгсөөд, байшингаас гарч, тэр эрчээрээ Парист очсон билээ.

Хэсэг 75

Түүний суусан онгоц Монакогийн гэрэлт гудамж дээгүүр өнгөрөх үед, Арингароза ахмад Фааштайутсаар яриад, дуусч байв. Гэнэт түүний дотор муухайрахад, цаасан уут өмнөө барьсан ч, эцэжтуйлдсандаа болоод, хий огиулаад байв.

Энэ бүхэн дуусгавар болж, надаас түргэн салаасай!

Арингароза Фаашийн утсаар хэлсэн үгийг сонсоод, чихэндээ итгээгүй юм.

Юу болоод байна аа! Бүх зүйл орвонгоороо эргээд байх юм. Би Силасыг юунд хутгачхав аа? Өөрийгөө ч мөн адил.

Хөл нь салганасан чигтээ, Арингароза нисэгчийн бүхээг рүү очоод, "Би чиглэлээ өөрчилмөөрбайна!" гэв.

Нисэгч түүн рүү эргэж харснаа тохуурхан инээж, "Та тоглож байгаа байлгүй дээ? гэв.

"Үгүй ээ! Би Лондон руу даруй нисмээр байна".

"Эцэг минь, энэ чинь чиглэлтэй нислэг. Хөлсний такси биш!"

"Мэдээж би чамд нэмэлт төлбөр хийнэ шүү дээ! Хэдийг өгөх вэ? Лондон эндээс хойд зүгт, 1цагийн зайд байгаа, тэгээд ч бидний чиглэл бараг өөрчлөгдөхгүй".

"Энд мөнгөний тухай асуудал яриагүй ээ, эцэг минь! Өөр бас олон шалтгаан бий",

"Яг одоо, бэлнээр 10 000 евро өгье".

Нисэгч давхийн цочиж, "Хэд гэнэ ээ? Ямар ламтан гэхээрээ ийм их бэлэн мөнгөтэй явдаг байнааа?" гэж дуу алдав.

Арингароза цүнхээ онгойлгоод, нэг багцыг нисэгчид өгөв. "Энэ чинь юу вэ!" гэж нисэгч асуувал,

"Ватиканы банканд бүртгэлтэй 10 000 еврогийн өрийн бичиг буюу бонд".

Нисэгч бүр мэл гайхсан байдалтай түүнийг харна.

"Энэ бол бэлэн мөнгөнөөс ялгаагүй эд" гэж Арингарозаг хэлэхэд,

"Бэлэн мөнгө л бол бэлэн мөнгө!" гээд нисэгч өрийн бичгийг түүнд буцааж өгөв. Арингароза аргамухардахдаа, "Энэ бол үхэл, амьдралын зааг болчхоод байна. Чи надад т услах ёстой! Би Лондонруу явах ёстой байна".

Нисэгч түүний алтан бөгж рүү хараад, "Жинхэнэ чулуу байж чадах уу?" гэж асуув.

Арингароза хуруун дахь бөгжөө харснаа, "Би үүнийгээ өгмөөргүй байна" гэв.

Нисэгч мөрөө хавчаад, урагш цонх руугаа ширтэв.

Арингароза бөгжиндөө машид харамсана. Өөрийнх нь сүр хүчийг илтгэж байсан, зүйлээсээхагацахад, түүнд үнэхээр хэцүү байв. Хэсэг бодсоны эцэст, бөгжийг хуруунаасаа салгаж, нисэгчийн суудлын дэргэдэх тавцан дээр зөөлөн тавилаа. Арингароза бүхээгээс тэр даруй гарч, суудалдаа эргэж суув.

15 секундйн дараа, онгоцны их бие хойд зүг чиглэн хазайж байхыг тэр мэдрэв. Түүний баярбахдал аль хэдийнээ замхарчээ. Уг нь ариун нандин гэсэн үзэлдээ хөтлөгдөж, энэ бүхнийг эхнээснь нарийн төлөвлөсөн юм.

Гэтэл одоо тэр нь хөзрөөр барьсан тоглоомон байшин шиг нуран унахад, бэлхэн болжээ.

Хэсэг 76

Софи Гиерос Гамосын тухай сонссоноосоо болоод, одоо хүртэл чичирсээр байв. Учир нь Софизөвхөн тэр ёслолыг харсандаа ч биш, харин түүний өвөө тэр ёслолд оролцож байсан нь, түүнд машхэцүү байв.

Тэр тусмаа Жак Сониех бол Сионий Прайорийн гишүүн байсан явдал.

Да Винчи, Ботичеми, Ньютон, Виктор Гюго, Жон Коктью гэсэн нэрс явсаар эцэст нь Жак Сониех.

"Би цааш юу гэж үргэлжлүүлэхээ мэдэхгүй байна!" гэж Ландон намуухнаар дуугарав.

Софигийн харцанд гуниг дүүрээд, нүдэнд нь нулимс цийлгэнэсэн хэвээр, "Өвөө намайг төрсөнохин шигээ хайрлаж өсгөсөн".

Софигийн царай гэмшил харууслаар дүүрэн харагдаж байв. Бүсгүй өвөөгөөсөө үргэлж зугтааж, түүнийг жигшиж байсан бол, одоо бүхнийг өөр өнцгөөс харах болжээ.

Үүр хаяарч, тэнгэр гүн улбар улаан өнгөтэй болсон ч, газар дэлхий тэр доор харанхуй хэвээрдүнсийнэ.

"Унд! Хонгорууд минь, өглөөний унд!" гэсээр Тийбин тэдэн дээр баясал тодруулан ирээд, хэдэнлааз ундаа, хайрцагтай хуучин жигнэмэг авчирсан байв.

"Манай хувраг найз одоохондоо юу ч яриагүй л байна" гээд нүдээ ирмэн, "Түүнд бодох хугацааөгөх хэрэгтэй!" гэв.

Тийбин авчирсан жигнэмгээсээ нэг хазаад, шүлэг рүү харж, "За тэгэхээр, хайртууд минь, ямарнэгэн юм олов уу?" гээд Софи руу ширтэж, "Өвөө чинь энд юу гэж бичсэн байна вэ? Энэчөтгөрийн толгойн чулуу гэж юу юм бол? Хөлөг баатруудын суурилуулсан чулуу гээд

байгаа шүүдээ, бас".

Софи толгой сэгсэрч, дуугүй л суув.

Ландон лаазтай ундаанаас нэгийг авч онгойлгоод, цонх руу ширтэнгээ, нууцлаг ёслол, тайлагдаагүй код зэргийн талаар эргэцүүлж тунгаана.

Ундаанаасаа томоор балгатал, газтай бүлээн Кола ам руу нь цоргиод орчихлоо.

Харанхуй улам хумигдсаар гэгээ алгуурхан ороход онгоцны цонхоор далайн ус мэлтэлзэнхарагдав.

Энэ бол Английн суваг. Одоо л удахгүй газардах ёстой доо.

Гэгээ орох тусам, Ландон үнэнд ойртож байгаа юм шиг санагдана. Онгоцны хөдөлгүүрийн жигднижгэнэх дуунаас, тэрээр Гиерос Гамосын магтуу дууллыг олж сонсох шиг болов.

Хөлөг баатруудын байрлуулсан толгой чулуу бол түүнд хүрэх гол түлхүүр.

Гэнэт түүнд нэгэн санаа орж ирэхэд, Ландон ундаагаа ширээн дээр огцом тавиад, "Танар үүндитгэхгүй дээ!" гэж нөгөө хоёртоо хэлэв. "Толгойн чулуу гэдгийг би олчих шиг боллоо!"

Тийбиний нүд том болж, "Чи толгой чулууг хаана байгааг мэдэж байгаа юм уу?"

Ландон инээмсэглэж, "Хаана байгааг нь биш, юу гэдгийг нь мэдлээ" гэв.

Софи түүнийг сайн сонсохын тулд, урагш бөхийв.

"Лей!" гэж Ландон хэлээд, түүнд хандаж, "Сүмийнхэн Хөлөг баатруудыг тэрс үзэлтэн хэмээнхилсээр яллаж, эрүү шүүлт тулгаж байсан. Тийм биз дээ?"

"Яг тийм, Тэдэнд ижил хүйстэнтэй явалдсан, шүтээнээ бузарласан, ад зэтгэрийг шүтсэн гэх мэтээрхилс зэмлэл тулгаж байсан".

Гэрээслэл дотор бас тэрс үзлийн бурхныг шүтсэн гэж ялладаг байсан байх даа. Ялангуяа Хөлөгбаатруудын нууцлаг мөргөл, ёслол үйлдэж, нэгэн бурхны толгойн чулуу бүхий барималд мөргөдөгбайсан гэж буруутгасан байдаг байх аа?"

"Тэр бол Бафометт бурхан" гэж Тийбин шууд хариулаад, "Тэнгэр минь, Роберт, чиний зөв. Хөлөгбаатруудын байрлуулсан толгой чулуу нь тэр байж шүү дээ!"

Ландон нөхөн үржихүйн илэрхийлэл болсон, "шашингүйн үзлийн бурхан Бафометтийн тухайСофид товчхон тайлбарлав. Бафометт бурхныг ихэвчлэн аргалынх шиг эвэртэй толгойтойгоордүрсэлдэг бөгөөд, энэ нь үржил шим, шинэ эрч хүчийг илтгэж байгаа юм. Хөлөг баатруудБафометтийн эргэн тойронд ижил дүрстэй жижиг толгойг тавиад, тойрог үүсгэн тахиж мөргөдөгбайжээ.

"Бафометт!" гэж хэлэхдээ, Тийбин хөхөрч, "Ид шидэт бэлгийн харьцааг энэ бурхнаар дүрсэлжүзүүлдэг байсан ч. Пап лам Клемент Бафометт бурхны толгой чөтгөрийн толгой хэмээн хүмүүститгүүлж дөнгөсөн юм. Пап ламын Хөлөг баатруудын холбоотой тэмцсэн гол том хөзөр ньБафометтийн толгойн дүрс байсан юм" гэж тайлбарлав.

Үнэндээ одоог хүртэл Бафометтийг анзаараагүй хэрнээ, түүнийг дүрсэлж үзүүлдэг тохиолдол олонбайдаг. Жишээ нь хүмүүс зураг авахуулахдаа, хэн нэгний толгойн ард 2

хуруугаа гозойлгодог ньБафометгийн эврийг дүрсэлж буй хэрэг юм.

"Яг тийм" гэж Тийбин нүүр дүүрэн инээмсэглээд, "Шүлгийн утгатай! Бафометт бурхан үнэхээр авцалдаж байна шүү."

"За тийм байж" гээд Софи, "Хэрэв Бафометт бурхан үнэхээр зөв юм бол, нэг зүйл сонин санагдаад байна. Бидэнд Оньсон чулууг онгойлгоход 5 үсэгтэй үг хэрэгтэй. Гэтэл Бафометт гэдэг чинь 8 үсэгтэй байна шүү дээ!"

Тийбин жуумалзаж, "Хонгор минь, энд л Атбаш цифрийн утга учир оршиж байгаа юм" г эв.

Бафометт бурхан

Хэсэг 77

Ландоны сэтгэл хөдөлнө.

Тийбин Хебрюгийн цагаан толгой үсгийг дарааллын дагуу цээжээр бичив.

A, B, G, D, H, V, Z, Ch, T, Y, K, L, M, N, S, O, P, Tz, Q, R, Sh, Th

Тэгээд дараа нь, бичсэн үсгүүдээ дуудлагаар нь төвөггүйхэн уншив. "Алеф, Бэйт, Гиммел, Далет, Хей, Вав, Зайн, Чэт, Тэт, Юуд, Каф, Ламед, Мэм, Нан, Самеч, Айн, Пей, Цадик, Куф, Рейшь, Шин, Тав".

"Хебрюгийн дүрмээр эгшиг үсгийг бичилгүй орхидог. Тийм болохоор бид Бафометт гэж үгийг Хебрюгийн дүрмээр бичвэл түүнд орсон 3 эгшгийг нь хаяж бичнэ гэсэн үг".

"Тэгвэл 5 үсэгтэй болно" гэж Софи тэр дор нь хэлэв.

Тийбин толгой дохиж, дахиад бичиж эхлэв.

"За! Одоо энд Бафометтийг Хебрюгээр бичсэн байгаа. Би толгойг чинь эргүүлэхгүйн тулд, эгшгийгнь жижиг үсгээр биччихлээ".

Ба - Фо - Ме - Т - Т (Ba -Pyo-Me-Th)

"Мэдээж, Хебрюгийн код юм болохоор араас нь урвуулж бичсэнийг бас санаарай. Одоохондооингээд биччихье. Харин дараа нь цагаан толгойг араас нь орлуулж, шинэ үг бүтээх ёстой".

"Ингэвэл хялбар байх" гээд Софи үзэг авч, "Би үүнийг сургуулиасаа сурсан юм" гээд Хебрюгийнцагаан толгойн үсгийг эхнээс тал хүртэл нь зүүнээс баруун тийш бичээд, үлдсэн хагасыг доод талднь баруунаас зүүн тийш нь бичив.

A B G D H V z Ch T Y KTh Sh R Q Tz P o s N M LТийбин бүсгүйн бичсэнийг үзээд дуу алдав. "Яг зөв! Холлоуэйн банди нар юу заахаа мэддэг л юмбайна".

"Бид ч тун ойрхон байна даа" гэж сэтгэл хөдлөлөө дарж ядан, Ландон шивэгнэв.

"Хэдхэн инчийн ойрхон зайд байна, Роберт!" гээд Тийбин Софи руу харж инээмсэглээд, "Чи бэлэнүү?" гэв.

Бүсгүй толгой дохив.

"За тэгвэл Бафометтийг Хебрюгээр эгшиггүй бичихэд, BPVMTh болно. Одоо чиний урвуулжбичсэн мөрүүдийг ашиглаад, 5 үсэгтэй үгээ ольё!"

Ландоны зүрх түргэн түргэн цохилно.

BPVMTh.

Энэ мөчид нарны гэрэл цонхоор нэвт тусч байв. Тэрээр Софигийн бичсэн үсгүүдийг харангаа, удаан боловч өөртөө итгэлтэйгээр хөрвүүлэг хийж байв.

В бол Sh... P бол V.

Тийбин яг л Зул сарын баяраар бэлэг авах гэж байгаа хүүхэд шиг баярлан сууна. "Ээ бурхан минь" гээд түүний царай нь цайчхав. Ландон тэр дороо өндийв. "Яасан бэ?" гэж Софи түүнээс асуув.

"Та нар итгэхгүй дээ!" гэж Тийбин хэлээд, Софи руу харж, "Ялангуяа, чи".

"Юу гэнэ ээ?"

"Энэ бол гайхалтай!" гэж Тийбин шивэгнээд, "Бүр маш гайхалтай гээч!" гээд Тийбин цаасан дээрүг бичээд, "Бөмбөрөө нижгэнүүлээрэй! Би энд нууц үгийг биччихлээ" гэв.

Тийбин нөгөө хоёрт цаасаа харуулав.

ShVPYA

Софи хөмсгөө зангидан, "Энэ юу вэ?" хэмээн асуув. Ландон ч бас учрыг олсонгүй.

Тийбиний дуунд биширч сүрдсэн өнгө илэрч, "Энэ бол, найзууд минь, эртний хэлээр оюун ухаангэсэн утгатай үг!"

Ландон үсгүүдийг ахин уншаад, удалгүй учрыг ойлгов бололтой. Тэрээр өмнө нь ийм зүйлтэй хэзээч учирч байсангүй.

Эртний хэлээр оюун ухаан гэсэн үг!

Тийбин чангаар инээгээд, "Маш тодорхой байна".

Софи бичсэн үг рүү нь нэг рүү харж, криптексийн үсэг рүү нэг харснаа, Ландон, Тийбин хоёрынтөөрөлдсөнийг ухаарав.

"Байзнаарай. Энэ нууц үг биш байна" гэж бүсгүй маргаад, "Криптекс дээр Sh гэсэн үсэг байхгүй. Үүн дээр зөвхөн Ром үсгийн цагаан толгой байгаа".

"Үгээ уншдаа!" гэж Ландон хэлээд, "Энд 2 зүйлийг санах хэрэгтэй. Хебрюгээр бичсэн Sh үсгийг заримдаа S - ээр дууддаг. Бас P үсгийг F - ээр дууддаг тохиолдол ч бий".

"SVFYA?" гэж хэлээд, бүсгүй түр эргэлзэв.

"Гайхалтай!" гэж Тийбин харин нэмж өгүүлээд, "Вав (V) үсэг бас заримдаа O эгшгээр дуудагддаг юм".

SOFYA.

Софи үсгүүд рүү дахин харж, холбож уншихыг оролдов.

SOPHYA.

Тэр өөрийнхөө уншсан зүйлд итгэсэнгүй. "София? Энэ чинь София гэж байна шүү дээ?"

Ландон маш итгэлтэйгээр толгой дохиж, "Тийм ээ. Грекээр София гэдэг бол оюун ухаан гэсэн утгатай үг. Чиний нэр чинь, Софи, оюун ухаан гэсэн утгатай юм шүү дээ!"

Софи тэр мөчид өвөөгөө сэтгэлдээ маш их хайрлав.

Өвөө миний нэрээр Прайорийн Онсон чулууг чагталжээ?!

Бүсгүйн хоолой нь зангираад ирэв. Бүх зүйл түүнд маш гайхалтай санагдана. Гэвч Софиг криптексрүү хартал, дахин нэг асуудал гарч ирэв.

"Гэхдээ, хүлээгээрэй! SOPHYA гэж үгэнд 6 үсэг байна шүү дээ!"

Тийбин инээмсэглэсээр л байв. "Чи өвөөгийнхөө бичсэн шүлгийг хардаа! Эртний хэлээр оюун ухаан гэсэн үг гэж бичсэн байгаа биз?"

"Тийм ээ".

Тийбин нүдээ ирмэж, Грекээр оюун ухааныг SOFIA гэж бичдэг юм".

Хэсэг 78

Софи криптексийн үсгүүдийг эвлүүлж байхдаа, баяр баяслаар бялхаж байв. Ландон,

Тийбин хоёртүүн рүү ширтээд, амьсгалж байгаа нь ч мэдэхгүй шахам, чулуун хөшөө шиг сууна.

S...O...F

"Болгоомжтой!" Тийбин бүсгүйд сануулаад, "Маш болгоомжтой!" гэж шивэгнэнэ.

I... A

Софи сүүлийн үсгийг эвлүүлэнгүүтээ, "За болчихлоо!" гэж шивнээд, нөгөө хоёр луугаа харав. "Биодоо салгалаа".

"Доторх цууг нь битгий мартаарай!" гэж Ландон маш сүрдсэн байдалтай шивнээд, "Болгоомжтойбайгаарай!" хэмээн нэмж хэлэв.

Хэрвээ энэ криптекс Софигийн багадаа онгойлгож байсантай адилхан л бол, цилиндрийн хоёрталаас барьж байгаад, зөөлхөн татах ёстой. Тэгээд зөв үг хийсэн бол, криптексийн нэг тал ньсугарч, шилтэй цууг ороож хуйларсан, папирус дээрх баримт гарч ирэх ёстой. Харин нууц үгийгбуруу оруулсан бол, чанга татахад л цуутай шил хагарч, бүх зүйл нэг хормын дотор дуусна гэсэнүг.

Зөөлхөн татна шүү! гэж Софи өөртөө сануулав.

Софи цилиндрийн хоёр талаас гараараа барихад, нөгөө хоёр нь урагш өн дийн, босох шахан суужбайв. Нууц үгийг олсон баяр хөөртөө авгаад, Софи криптекс дотор юу байгааг ч мартажээ. Энэ бол Онсон чулуу.

Тийбиний хэлснээр, Мэри Магдалиний бунхныг Сангрийлийн үнэт баримтын хамт агуулсан АриунГрейлийг байгаа газрыг энэ дотор өгүүлсэн байгаа. Чулуун цилиндрийг барьсан чигтээ, Софиүсгүүдийг дахин нягталж шалгав. Дараа нь маш удаанаар, аажуухан татлаа.

Юу ч болсонгүй.

Тэрээр арай хүчтэй чангаав. Гэтэл Онсон чулуу яг л сунадаг дуран шиг аажмаар салж онгойх ньтэр. Түүний нэг гарт нь цилиндрийн их бие үлджээ. Ландон, Тийбин хоёрыг суудлаасаа үсрэнбосоход, криптексийн их биений доторх руу Софи нүд салгалгүй ширтэж байв. Хуйлсан цаасүзэгдэнэ. Тэрхүү хуйлсан цаас дотор нэг зүйл байхыг, Софи хараад, шилтэй цуу байна гэжтаамаглалаа.

Хачирхалтай нь хуйлсан цаас папирус биш, ус үл нэвтрэх тостой цаас байлаа. Бүсгүй дахинлавшруулж хартал, цаасан доторх зүйл цуу биш өөр зүйл байх нь тэр.

"Яасан бэ?" гэж Тийбин адган хэлээд, "Цаасыг сугалаад авчхаач!"

Софи хөмсгөө зангидсан хэвээрээ, цилиндр дотроос хуйлсан цаасыг доторх зүйлтэй нь цуг гаргажирэв.

"Энэ папирус биш байна. Маш зузаан юм" гэж Тийбин цаасыг харангуутаа яаран хэлэв.

"Би харж байна. Зөөлөвч шиг зузаан юм байна".

"Ямар учраас энд хийсэн юм бол, цууг асгахгүй гэж тэр үү?"

"Үгүй ээ!" гээд Софи цаасыг задалж, "Харин үүнд зориулж хийсэн юм байна" гэв.

Ландон түүнийг нь харангуугаа зүрх нь зогсох шиг болов.

"Бурхан минь өршөө!" гэж Тийбин хэлээд, суудалдаа лагхийгтэл суучхав. "Өвөө чинь "бузар шиг" бурхан гартай хүн байж дээ!"

Ландон алмайран харсаар л байв. Сониех үүнийг хийхэд ч мөн хэцүү байсан байх даа!

Ширээн дээр хоёр дахь криптекс хэвтэж байв. Жижигхэн хэмжээтэй түүнийг хар өнгийн гартаамчулуугаар хийсэн байв. Эхний криптекс түүнийг дотроо багтаасан байжээ.

Хоёр криптекс гэдэг бол хос зүйлийн бэлгэдэл. Давхар утга санаа агуулсан юм байна.

Цагаан гантиг чулуун дотор хар өнгийн гартаам багтаажээ.

Цагаан нь харыг төрүүлсэн гэсэн үг гэж Ландон дотроо бодов. Бүх эрчүүд эмэгтэй хүнээс төрсөн. Цагаан бол эмэгтэй. Хар бол эрэгтэй.

Ландон жижиг криптексийг барьж үзтэл, дотроос нь танил чимээ гарах нь тэр. Бодвол нөгөөшилтэй цуу нь энд л байгаа бололтой.

"За, Роберт!" гээд Тийбин хуйлсан цаасыг дэлгээд ингэж хэлэв.

"Чи үүнийг сонсоод, бид лав зөв зүгт нисч байгаа гэдэгт итгэлтэй болж болох юм".

Ландон зөөлөвч шиг зузаан цаасан дээрх үгийг уншив. Тэнд гараар 4 мөр бүхий шүлэг бичжээ. Далд утгатай бичигдсэн боловч, эхний мөрийг нь уншингуут, Тийбиний хэлсэн зөв гэдгийг Ландонойлгов.

Папын оршуулсан хөлөг баатар, Лондонд буй.

Шүлгийн үлдсэн мөрүүд нь Хөлөг баатрын бунхан дээр очвол, нууц үгийг мэдэх болно гэсэн утгатай байв.

Ландон Тийбин рүү харж инээмсэглээд, "Чи энд хэн гэдэг Хөлөг баатрыг хэлж байгааг тааварлаж байна уу?"

Тийбин жуумалзаж, "Багцаалж л байна. Гэхдээ аль бунхан гэдгийг нь яг таг мэдэхгүй л байна".

Энэ мөчид, орон нутгийн цагдаагийн газрын 6 машин засмал зам дээрх ус туучсаар, Биггин Хиллрүү хурд мэдэн давхих байв.

Хэсэг 79

Цангаж туйлдсан дэслэгч Коле хөргөгчөөс уух юм аваад, танхимд буцаж оров. Тэрээр Фаашийгдагаж, Лондон оролгүй, энд шинжээчийн багийнхны ажлыг хариуцаж үлджээ. Гэвч үнэндээ эдмөрийн баримт илрүүлэлт олигтой ахицгүй л байв. Учир нь шалан дээр гарсан сумны ганц нүх, хэдэн цаасан дээр зурсан ир, болон аяганы дүрс, мөн цусан өргөст бүс, энэ бүхэн тийм ч сонирхолтатмаар зүйлс байсангүй.

Хонгил даган явсаар, танхимд очвол, ахлах шинжээч хурууны хээ хайн, шаргуу гэгч ажиллаж байв. Тэрээр мөрөвчтэй өмд өмссөн тарган эр байлаа. "Ямар нэг зүйл олов уу?"

Шинжээч толгой сэгсрээд, "Шинэ соргог юу ч олсонгүй".

"Өргөст бүсэн дээрх хурууны хээ яасан бэ?"

"Интерпол руу явуулсан. Тэд тэндээ хайж байгаа байх".

Коле ширээн дээр байсан лацтай хоёр уут руу харж,

"Энэ юу вэ?" Шинжээч эр мөрөө хавчаад, Гаж зуршил ч юм уу, нэг тийм зүйлийг гэрчлэх эд байналээ". "Гаж зуршил гэнэ ээ?"

"Энэ англи эр их этгээд хүн бололтой Үүнийг хар даа!" гээд нэг уутыг авч, Колед үзүүлэв.

Уутан дотор Готикийн сүмийн төв хаалганы гэрэл зураг байв.

Коле зургийг хараад, "Энэ тэгээд гаж зуршил юм уу?" гэж хачирхан асуув.

"Нөгөө тал руу нь эргүүлээд хар даа!"

Коле ард нь бичсэн зургийн тайлбарыг унштал, сүмийн үүдний хэсэг эмэгтэй хүний умайгдүрсэлсэн гэж бичсэн байв. Хачин юм!

Энэ тайлбар Колег гайхшруулж орхив.

"Тайлбарыг нь уншаад, сүмрүү явмаар санагдаж байна уу?" гэж ахлах Шинжээч егөөдөн ас ув.

Коле өөр нэг уутыг авч харвал, дотор нь эртний баримтыг буулгасан бололтой том гэрэл зурагхийсэн байв. Гэрэл зураг дээрх гарчгийг нь уншвал:

Les Dossiers- н нууцууд - Дугаар 4, Lm 249 гэсэн байв.

"Энэ юу вэ?" гэж Коле асуув.

"Сайн мэдэхгүй байна. Наадах шиг чинь хуулбар зургууд энд хаа сайгүй байсан болохоор, хэрэгболж магадгүй гээд нэгийг нь ууталчихсан юм".

Коле баримтыг уншив.

PRIEURE DE SIGN — LES NAUTONIERS/GRAND MASTERS

JEAN DE GISORS

MARIE DE SAINT-CLAIR

GUILLAUME DE GISORS

EDOUARD DE BAR

JEANNE DE BAR

JEAN DE SAINT-CLAIR

BLANCE D'EVREUX

NICOLAS FLAMEL

RENE D'ANJOU

IOLANDE DE BAR

SANDRO BOTTICELLI

LEONARDO DA VINCI

1188-1220

1220-1266

1266-1307

1307-1336

1336-1351

1351-1366

1366-1398

1398-1418

1418-1480

1480-1483

1483-1510

1510-1519

CONNETABLE DE BOURBON

FERDINAND DE GONZAQUE

LOUIS DE NEVERS

ROBERT FLUDD

J. VALENTIN ANDREA

ROBERT BOYLE

ISAAC NEWTON

CHARLES RADCLYFFE

CHARLES DE LORRAINE

MAXIMILIAN DE LORRAINE

CHARLES NODIER

VICTOR HUGO

CLAUDE DEBUSSY

JEAN COCTEAU

Prieuré de Sion? (Сионий Прайори?)

хэмээн Коле уншаад, учрыг нь олохгүй хачирхана.

1519-1527

1527-1575

1575-1595

1595-1637

1637-1654

1654-1691

1691-1727

1727-1746

1746-1780

1780-1801

1801-1844

1844-1885

1885-1918

1918-1963

"Дэслэгч ээ?" гэсээр нэг цагдаа хүрч ирээд, "Төвөөс нэг хүн ахмад Фааштай яаралтай ярих хэрэггарсан гэнэ. Гэтэл түүнтэй холбогдож болохгүй байна гэнээ. Та өмнөөс нь ярьчих уу?"

Коле галын өрөө рүү орж, утас авав. Андре Вехне ярьж байв.

Тэрээр аялгаа өөрчилж ярихыг оролдох боловч, дууны өнгө нь огт хэвээрээ байв.

"Ахмад Фааш надтай холбогдоно гэж бодсон юм. Гэтэл ахмад надруу ярьсангүй".

"Ахмад ажилтай, завгүй байгаа! Та ямар хэргээр ярьж байна?"

"Өнгөрсөн шөнө та бүхний ажилд төвөг удсандаа маш их харамсаж байна".

Түүний дууг өмнө нь сонссон юм шиг Колед санагдавч, яг сайн танихгүй байв.

"Эрхэм Вехне, би ахмадыг орлож байгаа хүн байна. Намайг дэслэгч Коле гэдэг".

Харилцуурын цаана нэлээд удаан дуугүй байснаа,

"Дэслэгч ээ! Надад өөр шугамаас дуудлага ирлээ. Намайг өршөөгөөрэй! Би танруу дараа залгая"гээд Вехне утсаа тавьчхав.

Коле хэдэн секунд харилцуураа тавилгүй барьсаар л байв. Дэслэгч түүний хоолойг гэнэт саналаа. Вехнегийн хоолойг нь таньсандаа, Коле өөрийн эрхгүй уулга алдав.

Хуягласан машины жолооч байна шүү дээ! Бас хуурамч Ролекс цаг зүүчихсэн байсан.

Вехнег яагаад тэр дороо утсаа тавьсныг, Коле эцэст нь ойлгов. Учир нь Вехне бас дэслэгчийннэрийг сонсонгуутаа, өнгөрсөн шөнө хуурч дөнгүүлсэн дэслэгчийн царайг лавтай санасан биз. Колед зарим нэг зүйлийн сэжүүр орж ирэх шиг болов.

Энэ хэрэгт Вехне бас оролцжээ. Ахмад Фааш руу утастаж энэ тухай хэлэх хэрэгтэй.

Хэрвээ энэ бүхэн үнэн байх юм бол Колегийн аз нь гийлээ л гэсэн үг.

Дэслэгч тэр даруй Интерпол руу ярьж, Цюрихийн Хадгаламжийн банк болон тус банкны захирал Андре Вехнегийн талаарх мэдээллийг нэн даруй явуулахыг хүслээ.

Хэсэг 80

Онгоц алгуур доошлох мөчид, "Суудлын бүсээ бэхэлнэ үү!" гэж нисэгч дотуур холбоогооранхааруулаад, "Бид 5 минутын дараа газардах болно!" гэв.

Тийбин эх орондоо ирсэндээ баярлан, доошлон буух онгоцны цонхоор манан будан татсан, арлынуулсын оргилыг өндөлзөн харсаар явна. Шинэ өглөөтэй уралдан эх нутагтаа ирэхэд, "Тавтайморил, Тийбин!" гэж түүнд хэлж байх шиг санагдана.

Миний Франц дахь ажил хэрэг дууссан. Би Англидаа ялалтын туг мандуулсаар ирж байна!

Учир нь Онсон чулуу олдсон. Гэвч Онсон чулуу цааш тэднийг хааш нь чиглүүлэхийг хэн чтаашгүй.

Ямар ч л байсан, Английн нутаг дэвсгэрээс гадагш гарахгүй байгаасай! гэж Тийбин дотроозалбирна. Грейлийн хаана байгааг мэдэхээс нааш, Тийбиний санаа амрахгүй ч, одоохондоо тэрээр сэтгэл тэнэгэр байгаа билээ. Ландон, Софи хоёрыг харсаар байтал, Тийбин суудлаасаа босч, нисэгчийн бүхээгийн хойд ханан дахь далд сейфний кодыг хийж онгойлгов. Дотроос нь хоёрширхэг паспорт гаргаж ирэв.

"Реми, бид хоёрын баримт бичиг байгаа юм".

Тэрээр бас зузаан боодолтой 50 - тын дэвсгэрт бүхий фунт Стерлинг гаргаж ирээд, "Та хоёрын баримт бичиг!" гэв.

Софи хаширлаж, "Хахууль өгөх юм уу?" гэв.

"Бүтээлч дипломат арга гэж хэлээч! Гаалийн ажилтныг онгоцонд орж ирэхээс өмнө, Францыналдар цуутай эмэгтэй аялж байгаа тул, хэнд ч мэдэгдэхгүй гэж хүсч байгаа юм гэж түүнд хэлээд, энэхүү бяцхан зүйлийг санал болгоод л гүйцээ!"

Ландон гайхаж, "Гаалийн ажилтан хүлээж авах болов уу?"

"Өөр хүнээс бол авахгүй. Харин надаас бол өөр хэрэг. Би чинь захын наймаачин биш шүү дээ! Бибол тайж хүн" гээд Тийбин инээмсэглэж,

"Зарим үед эрх дархаа эдлэх хэрэгтэй шүү дээ!" гэв.

Реми гар буу барьсаар, тэдэн дээр хүрч ирээд, "Эрхэм ээ, миний туслалцаа хэрэгтэй байна уу?"

Тийбин түүн рүү харж, "Чи биднийг эргэж иртэл, урилгагүй зочинтой цуг эндээ байж бай! Түүнийг Лондонгийн гудамжаар чирээд яваад байж болохгүй шүү дээ".

Софи болгоомжилж, "Лей, намайг сонс! Францын цагдаа нар биднийг эргэж ирэхээс өмнө, чинийонгоцыг олчхож магадгүй юм шүү"

Тийбин хөхөрч, "Тийм ээ! Магадгүй. цагдаа нар энд орж ирээд, Ремиг харвал мөн ч гайхна даа!"

Софи түүнийг тоглоом шоглоом хийж байгаад хачирхаж, "Лей! Бид нар олон улсын хилийгзөрчиж, барьцааны хүн зөөсөн шүү дээ! Энэ бол ноцтой үйлдэл".

"Тэр ч тийм шүү! Хуульч бүсгүй минь" гээд, Тийбин тэдний өмнө хэвтэх хувраг руу харснаа, "Энээдгуус миний гэрт нэвтэрч, намайг алах дөхсөн. Үүнийг Реми ч гэрчилнэ" гээд, шүүхийн тангарагуншиж байгаа аятай, "Хүндэт шударга иргэд ээ! Хуучинсаг үзлийн тасархай болсон миний бурууүйлдлийн өчгийг Английн шүүх засаглалын өмнө өршөөн соёрхоно уу. Би гэмт хэргийг илчилж, Францын хуулийн байгууллагыг дуудах ёстой байснаа ухааравч, "Laissez - faire" гэж тунхагладаг Француудад тэр бүр итгэдэггүй нь миний алдаа болжээ. Гэхдээ энэ хүн намайг алах шахсан ньтуйлаас үнэн. Тиймээ! Би түргэдэж, гэрийн үйлчлэгчдээ бүхнийг тушааж, Англи руу энэ хуврагийгавж явах шийдвэр гаргасан. Энэ бол миний бие маш цочирдсон байхдаа гаргасан, үйлдэл болсныгтунгааж үзнэ үу. Миа Кульпа!"

Ландон үл итгэсэн янзтай харж, "Чиний зүгээс ийм алхам хийх юм биз дээ, Лей?"

"Эрхэм ээ!" гэж нисэгч Тийбинийг дуудав. "Цамхгаас дуудаж байна. Биггин Хилл дээр буухад, саатал гарсан бололтой. Манай онгоцыг шууд төв гарцан дээр буугаарай гэж байна".

Тийбин 10 гаруй жил Биггин Хиллд онгоцоор бууж, нисэхдээ, анх ийм зүйл сонсож байгаа нь энэбайв.

"Тэд яг ямар саатал гарсныг хэлсэн үү?"

"Цамхагаас тодорхой хариу хэлсэнгүй. Хий алдаад байна гэж хэлэх шиг болсон. Тэд биднийг шуудтөв гарц дээр буугаад, дохио өгтөл, онгоцноос битгий гараарай гэсэн. Аюулгүй байдлын үүднээстэр гэнэ.

Бид буудлын удирдлагын зөвшөөрөлгүйгээр ямар нэг тодорхой зүйл хийж болохгүй гэнэ".

Тийбин үүнийг сэжиглэнэ. *Хий алдлаа гэхэд, хоолой манай саравчнаас бараг хагас милийн зайтайбайдаг шүүдээ!*

Ремигийн сэтгэл бас түгшиж, "Эрхэм ээ, энэ надад нэг л сонин санагдаад байх юм" гэжанхааруулав.

Тийбин Софи, Ландон хоёр луу эргэж хараад, "Найзууд аа! Биднийг талархан хүлээж байгаа, хүмүүс энд бас байгаа бололтой" гэв.

Ландон санаа алдаад, аргаа барсан дуугаар, "Фааш одоо болтол намайг баривчлах бодлоо тээсээр ляваа юм байна" гэв.

"Ингэснээрээ Фааш өөрийнхөө алдааг улам их болгож байгаа юм" гэж Софи өгүүлэв.

Тийбин тэдний үгийг сонссонгүй. Тэрээр Фаашийн тухай ярихаас илүү, өөр зүйлд санаа

НЬ ЗОВЖБАЙВ. *Гол зорилгоо бүү мартаарай! Ариун Грейл. Бид түүнд маш ойрхон байгаа.*

"Лей!" гэж Ландон гэмшингүй дуугаар хэлээд, "Би энэ бүхнийг хуулийн дагуу шийдүүлмээр байна. Та нарыг үүнд дахиж хутгахыг хүсэхгүй байна" гэв.

"Ээ, тэнгэр минь! Роберт" гээд, Тийбин гараа савчиж, "Одоо тэд биднийг зүгээр л тавиадорхичихно гэж чи бодоогүй биз дээ? Би хууль зөрчиж, чамайг онгоцондоо авч суусан. Нөвү авхайчамайг Лувраас зугтахад тусалсан. Бас бид онгоцондоо нэг хүлээстэй хүнийг барьцаа болгон эндхэвтүүлж байгаа шүү дээ! Бид бүгдээрээ энэ бүхэнд хамаатай".

"Өөр онгоцны буудал руу явах уу?" гэж Софи санал болгов.

Тийбин толгой сэгсэрч, "Хэрэв бид чиглэлээ өөрчилж, өөр газар буухаар болбол, тэд бидэн рүүтанкны их буу чиглүүлж ч магадгүй".

Софи таг болчхов. Английн хуулийн байгууллагынхныг аргалж дөнгөхийн тулд, маш зоримогшийдвэр гаргах хэрэгтэйг Тийбин ойлгож байв.

"Намайг трр хүлээж бай!" гээд Тийбин нисэгчийн бүхээг рүү зүглэн хазганав.

"Чи яах гэж байна?" гэж Ландон аргаа барсан дуугаар түүнээс асуув.

"Худалдааны гэрээ хийе" гэж, Тийбин хэлэхдээ нисэгчийг ятгахын тулд, хэдий хэр зоос хэрэгтэйгдотроо эргэцүүлсээр холдов.

Хэсэг 81

Хоокер эцсийн чиглэлээ тогтоолоо.

Биггин Хилл онгоцны буудлын үйлчилгээний ажилтан Эдуард, буудлын хяналтын цамхаг доторнааш цааш холхингоо, цонхоор нислэгийн зурвас руу байн байн хяламхийн харна. Тэр өмнө ньБямба гаригийн өглөө ажилдаа огт дуудагдаж байсан удаагүй болохоор, дотроо ихэд унтууцна.Гэвч үүнээс ч илүү түүний цухал төрүүлсэн зүйл бол, онгоцны буудлын хамгийн нэр хүндтэйүйлчлүүлэгчийг цагдаа нар баривчлах гэж байгаа явдал юм.

Лей Тийбин саравчныхаа түрээсийг төлөөд зогсохгүй, буудлаас явж, ирэх бүрдээ "газардсаньтөлбөр" гэж тэдэнд гар цайлгах мөнгө байнга өгдөг байсан юм. Хариуд нь түүний саравчин дахьЯгуар маркийн лимузиныг байнга бэлэн байлгахыг шаардаж, бензинээр банкийг нь дүүргэж,арчиж, цэвэрлэх, мөн Лондон Таймс сонины шинэ дугаар бүрийг арын суудал дээр тавьсан байхыгТийбин буудлынханд захидаг байжээ.

Гаалийн ажилтнууд түүний тээвэрлэж авчирсан тансаг хүнс болох Францын эмгэн хумс, Рокфордсоортын шүүслэг жимс гэх мэтийг хараагүй мэт дүр үзүүлснийхээ төлөө, түүнээс гар цайлгахмөнгө хангалттай авдаг юм. Тийбин энэ буудлаас авах юмаа авч, буудал ч бас түүнээс авахаа авчявсаар өдий хүрчээ.

Эдуардад цагдаа нар чухам ямар хэрэг гарсныг хэлээгүй ч, тэр өөрөө хэргийг ноцтой гэдгийгзөнгөөрөө мэдэрч байлаа. Францын цагдаа нарын хүссэний дагуу, Английн орон нутгийнцагдаагийнхан хяналтын цамхгийн ажилтныг нисэгчид гол гарц дээр бууж ир гэж хэлэхийгдаалгасан юм. Нисэгч худал зохиосон шалтагт үнэмшээд, тэдний хэлснээр, төв гарц дээр буухаарболсон юм.

Английн цагдаа нар ихэнхдээ буу зэвсэгтэй явдаггүй боловч, энэ удаад онцгой тохиолдол байсанболохоор, зэвсэглэсэн тусгай багийнхныг дуулжээ. Онгоц газардаж, хөдөлгүүр нь унтрахыг хүлээн,гол гарцын үүдэн дээр буутай 8 цагдаа бэлэн байдалтай зогсоно. Хөдөлгүүр

унтрах агшинд, буухзурвасын ажилтан онгоцны дугуйнд хөдөлгөөн саатуулагч зүйлийг ивж, онгоцыг хөдлөхөөсурьдчилан сэргийлэх ёстой.

Ингээд сэжигтнүүдийг онгоцноос огт гаргахгүйгээр, Францын цагдаа нарыг иртэл, байдлыгхяналтад авч, Фашийг хүлээх ёстой.

Онгоц доошлон доошилсоор, цамхгийн цонхоор харагдахгүй болоход, Саймон Эдуард онгоцгазардахыг нүдээрээ үзэх гэж доод давхар луу яаран буув. Буугай цагдаа нар нуугдаж, хөдөлгөөнсаатуулагч барьсан ажилтан онгоцыг хүлээн гарцан дээр зогсоно.

Хоокерийн хошуу нь өлийж, сүүл нь үл ялиг доошилсон чигтээ дугуйгаараа зам дээр угаасуунаглуулан газардав.

Онгоц тэр эрчээрээ гол гарцын өмнүүр өнгөрөөд, хурдаа ч саалгүй явсаар, туслах зам руу орж, Тийбиний саравч руу зүглэх нь тэр.

Цагдаа нар бүгд Эдуард руу эргэж хараад, "Чи нисэгчийг гол зам дээр бууна гэж хэлсэн биз дээ!"

Эдуард учраа олохгүй будлиж, "Тэгж л хэлсэн шүү дээ!"

Хэдхэн хормын дараа цагдаа нар цамхгаас хөдөлж, Тийбиний саравч руу давхиж байхад, харинонгоц аль хэдийн саравчинд орж харагдахгүй болов. цагдаагийнхан хаалга нь онгорхой харагдахтэр саравч руу хурдалсаар очоод, машинаасаа шуурхайлан бууж, агшин зуурт тэр зүг буугааониллоо. Эдуард ч бас тэдэнтэй хамт байв.

Чих дүлийрэм дуу шуугиан нүргэлэх нь Хоокерийн хөдөлгүүр одоо болтол унтраагүйг илтгэнэ. Онгоц саравчин дотор бүтэн эргэлт хийж дараагийн нислэгтээ бэлдэж, байрлалаа тохируулж байгаабололтой байв.

Онгоцны хошуу 180 хэм бүтэн эргэж, үүд руу харахад, онгоцны бүхээг дэх нисэгчийн царайхарагдаж, тэрээр олон цагдаа нарыг харсандаа, цочирдож гайхсан төрх үзүүлэх аж.

Нисэгч онгоцны хөдөлгүүрийг унтраав. цагдаа нар тэр даруй онгоцыг бүсэлж, байрлалаа эзэллээ. Эдуард саравчны үүд рүү очиж буй, ахлах байцаагчтай алхаа нийлүүлэх зуур, онгоцны хаалгаторхийн нээгдэв.

Үүдний шат алгуур доошлох агшинд, хаалган дээр Лей Тийбин харагдав. Тэрээр өөр лүү нь чиглэххэдэн 10 бууны амыг хараад таягаа түшин зогсож, толгойгоо гилжийлгэнгээ, "Саймон! Би арайцагдаагийн "лоттонд" оролцоод, хонжвор хожчихоогүй? байгаа даа?" гэж хэлэхдээ түгшсэнгэхээсээ будлиж төөрөлдсөн хүн шиг харагдана.

Саймон Эдуард тийш дөхөнгөө, хоолойд юм тээглэсэн юм шиг шүлсээ залгиад, "Өглөөний мэнд, эрхэм ээ! Саад учруулсанд хүлцэл өчье. Хий алдсан тул гол гарцан дээр буухыг бид танай нисэгчидтушаасан шүү дээ!"

Тиймээ, тийм! Гэхдээ би түүнийг энд буу гэж тушаасан юм. Товлосон цагаасаа би хоцорч байна. Энэ саравчны төлөө би мөнгө төлдөг. Тэгээд ч тэр хий алдлаа гэдэг чинь хэтэрхий сүржигнэсэнгэмээр сонсогдоод байсан юм.

"Таныг түр саатуулахаас аргагүй болох нь дээ, эрхэм ээ!"

"Би мэдэж байна. Гэхдээ би хуваарьт цагаасаа хоцорчхоод байна. Эмчилгээндээ очихгүй бол тунгорьгүй болчхоод байна."

"Эрхэм ээ!" гэж ахлах байцаагч урагш алхаж хэлээд, "Таныг онгоцноосоо буулгүй, эндээ хагас цагхүлээхийг зөвлөж байна."

Тийбин шатаар хазганаж буугаад бүр алмайрчихсан, "Ийм зүйл байж болохгүй шүү дээ! Би одооэмчилгээндээ явах ёстой" гээд, "нэгэнт бууж ирсэн хойноо, Эмчилгээгээ алгасах эрх нададбайхгүй" гэлээ.

Байцаагч бас мөчөөгөө өгсөнгүй, Би энд Францын цагдаагийн газрыг төлөөлж байна. Тэд таныг онгоцондоо сэжигтнүүд авч яваа гэж мэдээлсэн.

Тийбин байцаагч руу удаанаар ширтэж байснаа, чангаар инээж, Энэ чинь арай нөгөө зугаатайдуран энэ тэр гээд телевизийн хөтөлбөр биш биз? Мөн л гэж битгий хэлж үзээрэй!

Байцаагч түүнийг огт тоосонгүй, Энэ үнэн, эрхэм ээ! Францын цагдаагийнхан таныг барьцааны хүнбас авч яваа гэж хэлсэн.

Тэгтэл гэнэт Тийбиний үйлчлэгч Реми онгоцны хаалга дээр гарч ирээд, Би ч эрхэм Лейд барьцааныхун шиг л үйлчилдэг шүү! Гэхдээ тэр намайг өөрөө хүсвэл явж болно л гэдэг гээд цагаа харж, Эзэнтээн, бид үнэхээр хожигдож байна шүү дээ!

Реми саравчны буланд зогсох, Ягуар лимузин руу дохиж, Би машинаа авчирья д аа гээд шатаардоош буув.

Та нарыг явуулахгүй! гэж байцаагч хэлээд, Онгоцондоо буцаж суухыг та хоёрт зөвлөж байна. Удахгүй энд Францын цагдаа нар ирнэ.

Тийбин Саймон Эдуард руу хараад, Саймон, тэнгэр минь! Энэ чинь инээдтэй хэрэг биш үү? Биднээс өөр хүн онгоцонд байхгүй шүүдээ. Яг л нөгөө бүрэлдэхүүнээрээ. Нисэгч, Реми, бид гурав. Чи нүдээрээ гэрчилсэн ч болно шүү дээ. Онгоцонд ороод хар! Тэгээд энд хэн ч байхгүй гэдэгт бүгдигтэй болно.

Эдуард өөр аргагүй болсон тул, Ойлголоо, эрхэм ээ. Би очиж харья.

"Чөтгөр аваг! Чи л биш шүү" гэж байцаагч эр тэдний хуйвалдааныг урьдаас таамаглан хэлээд, "Би өөрөө очиж харна" гэв. Тийбин толгой сэгсэрч "Байцаагч аа та тэгж болохгүй шүү! Онгоц бол миний хувийн өмч тул, та нэгжих зөвшөөрөлгүйгээр, миний онгоцонд нэвтрэх эрх байхгүй. Харинч би та нарт боломж гаргаж, Эдуардыг шалгах зөвшөөрөл өгч байгаа шүү дээ".

"Харин би зөвшөөрөхгүй" гэж байцаагч зөрүүдлэв.

Тийбиний ядуу байдал гэнэт алга болж, хүйтэн дуугаар, "байцаагч аа! Та намайг энэ тоглоом шоглоомоороо залхааж байна. Би хоцорчихлоо. Тийм болохоор эндээс шууд явна. хэрэв та намайг саатуулахыг үнэхээр хүсч л байгаа бол, буудахаас өөр замгүй".

Ингэж хэлээд Тийбин, Реми хоёр лимузин рүү алхлаа. ахлах байцаагч дэргэдүүр нь өнгөрөх тэрхүү эрх ямбаган хүнийг хараад зэвүү нь хүрнэ .

Хуулийг иймэрхүү хүмүүс л уландаа дэвсдэг нь гарцаагүй!

Байцаагч Тийбиний араас хашхирч, "Зогс! Эсвэл би буудлаа шүү".

"Тэгээд буудаач дээ," гээд Тийбин эргэж ч харахгүй урагшаа алхсаар.

"Манай өмгөөлөгч чамайг өглөөний хоолондоо зооглох байлгүй. Бас чи миний онгоцыг зөвшөөрлийн бичиггүй нэгжсэн байвал, дэмий л юм болно шүү!"

Тийбиний хэлснээр зөвшөөрөлгүй бол, онгоцыг нэгжих эрхгүй ч гэсэн, Бэзү Фаашийн нэр нөлөөнднаалдах гэсэн ахлах байцаагч, тэнд хэн нэгнийг нуугдаж байгаа гэдэгт маш их итгэж байв .

"Тэднийг саатуул!" гэж байцаагч тушаагаад, "би онгоцыг нэгжиж шалгана" гэв. Цагдаа нар нөгөөхоёрыг машиндаа хүрч очихоос нь өмнө, замыг нь хааж, тэдэн рүү буу чиглүүлэн зогсов.

Тийбин эргэж хараад, "Байцаагчаа! Би сүүлийн удаа анхааруулья. Та онгоцонд н эвтрэх тухайбодсоны ч хэрэггүй. Эс бол ингэсэндээ харамсах болно шүү!"

Түүний сүрдүүлгийг ч үл хэрэгсэн байцаагч буугаа барьсаар, онгоц руу шурхийн оров. Хормындараа нисэгчийн бүхээгт орсон хойноо, байцаагч дотроо хараан зүхэв. Бүхээгт суугаад, нүд ньбүрэлзэх нисгэгчээс өөр хүн онгоцонд байсангүй. Бие засах өрөө, сандал тээшийн өрөө гээдбүхнийг шалгахад, хүн нуугдаж болохоор зай тэнд байсангүй.

Бэзү Фааш юу бодож, бидэн рүү ингэж мэдээлсэн бол? Тийбин аргагүй л үнэн хэлсэн байж шүү!

Байцаагч нүүр нь улайсан чигтээ, онгоцноос гарч ирээд, өөрийн хүмүүстээ, "Тэднийг явуул!Бидэнд буруу мэдээлэл өгсөн байна" гэв.

Тийбин нүд нь эргэлдэж байснаа, "Чи манай өмгөөлөгчийн утастахыг хүлээж байгаарай. ХаринФранцын цагдаа нарт хэзээ ч итгэж болохгүй гэдгийг чамд нэмж хэлье".

Тийбиний үйлчлэгч лимузины хаалгыг онгойлгоод, эзнийгээ машинд суухад туслав. Үүнийхээдараа тэрээр жолооны ард сууж, машиныг асаалаа. Ягуарыг саравчнаас гарч явахад, буутай цагдаанар зам тавин хоёр тийш ярагдав.

"Сайхан жүжиглэлээ шүү, үнэнч албат минь!" гэж Тийбин Ремиг арын суудлаас магтаалын үгээрбулаад, арын бүдэг гэрэлтэй хэсэг руу эргэж харснаа, "Та нарт тухтай байна уу?" гэж асуув.

Ландон толгой дохино. Ландон, Софи хоёр хүлээстэй альбиногийн дэргэд шаланд бараг наалдахшахан хэвтэнэ .

Хэдэн хормын өмнө ийм зүйл болж өнгөрчээ.

Хоокер хоосон саравч руу орох мөчид, Реми онгоцны хаалгыг явдал дунд нь онгойлгож, цагдаанарыг ирэхээс өмнө, Софи Ландон хоёрыг хуврагийн хамт тэндээс гаргаад, лимузины ард нуужамжжээ. Тэр хооронд онгоцныхоо хөдөлгүүрийг унтраалгүйгээр эргэлт хийж, цагдаа нарынханхарлыг сарниулсан аж.

Софи, Ландон хоёр альбиног орхин босч, Тийбиний өөдөөс харсан суудал дээр суув. Тийбинтэднийг харан ёжтойгоор инээмсэглээд, лимузин дэх жижиг хөргөгчийг онгойлгож, "Та нар ундаауух уу? Эсвэл юм идмээр байна уу? Самар, чипс аль нь вэ" хэмээн найрсгаар асуув.

Нөгөө хоёрын аль аль нь толгойгоо сэгсрэв.

Тийбин жуумалзаад, хөргөгчийг хааж, "Одоо тэгвэл Хөлөг Баатрын бунхныг л санал

болгохоос!"

Хэсэг 82

"Флийт гудамж гэсэн үү?" гэж Ландон асуув.

Тийбин хариуд нь жуумалзаж, Софи руу хараад, "Нөвү авхай, та наад Харвардын жаалдаа шүлгийгдахиад нэг уншаад өгөхгүй юу?" гэв.

Софи халаасаа уудалж, жижиг хар криптексийг цаастай нь хамт гаргаж ирэв. Тэд том криптексийгхайрцгийн хамт онгоцны сейфэнд үлдээсэн нь дээр гэж үзээд, тэнд нь орхисон юм.

Софи цаасыг дэлгээд, Ландонд өгөв. Ландон шүлгийг онгоцон дотор хэд хэд дахин уншсан боловч,байршил нарийвчлан заасан утгыг тэндээс олж хараагүй юм. Одоо тэр шүлгийг тодорхойхэмнэлээр, удаан, нухацтай уншихаар шийджээ.

Папын оршуулсан Хөлөг баатрын бунхан Лондонд буй

Тэр баатрын ажлын үр шим Ариун бүхнийг хилэгнүүлжээ

Та нар түүний бунхан дахь бөмбөрцгийг эрж хайна

Энэ бол бүхний эхлэл болсон үрт улаан жимсний тухай ...

Энд байгаа бүх үг тодорхой байна. Нэгэн Хөлөг баатрыг Лондонд оршуулсан юм байна. Түүнийхичээл чармайлтаар бий болгосон, зүйл нь сүмийнхнийг уурлуулсан байна. Түүний бунханд нэгэнбөмбөрцөг байгаа ажээ. Харин сүүлчийн мөр нь Есүсийн үрийг тээсэн эмэгтэй Мэри Магдалинийгхэлж байх шиг байна.

Ландон ийнхүү утгыг гаргасан ч тэрхүү хөлөг баатар хэн болох, булш хаана байгааг огтгадарлахгүй байв. Бунхныг оллоо гэхэд, дотор нь байгаа бөмбөрцгийг яаж гаргаж авах вэ?

"Ямар нэгэн санаа алга уу?" гэж Тийбин урамгүйхэн асуугаад, "Нөвү хатагтай танд?" гэж бас дахинасуув. Софи толгой сэгсэрнэ.

"Надгүйгээр та хоёр чинь одоо яах хүмүүс вэ? За яахав. Би хэлэхээс. Энэ бол их хялбархан зүйл юмшүү дээ. Хамгийн эхний мөр бол гол гогцоо нь байгааг анзаарахгүй байна гэж үү? Та нар нэг уншдаа!"

Ландон чангаар уншив. "Папын оршуулсан Хөлөг баатрын бунхан Лондонд буй"

"Яг тийм. Пап Хөлөг баатар байсан хүнийг түүхэнд ер нь оршуулсан юм болов уу?"

Ландон мөрөө хавчаад, "Пап хөлөг баатрыг оршуулсан гэдэг үү? Эсвэл Пап хөлөг баатрыгоршуулгыг удирдаж явуулсан гэсэн утгатай юм уу?"

Тийбин хөхөрч, "Ээ, чааваас даа! Чи ч гэнэхэн чигээрээ дуусах хүн бололтой, Роберт. Хоёр дахьмөрийг хар! Хөлөг баатрын хийсэн үйлдэл сүмийнхнийг хилэгнүүлсэн гэсэн байна шүү дээ. Сайнбод! Хөлөг баатар, Сүмийнхэн хоёр хоорондоо ямар харилцаатай байсныг сана. Пап хөлөг баатрыгоршуулсан байна уу?"

"Тэгэхээр Пап хөлөг баатрыг хөнөөсөн байх нь ээ?" гэж Софи асуув. Тийбин өвдгөө алгдан,инээгээд, "Маш сайн байна, хонгор минь! Пап хөлөг баатрыг булшилсан, эсвэл хөнөөсөн гэсэн үг" .

1307 онд болсон тэр аймшигт яргаллын тухай Ландон саналаа. "Хар Баасан гаригт Климент Папынтунхаг гарч, олон хөлөг баатрын амийг тэр үед тонилгосон шүү дээ!"

"Аан, тэр арай бишээ. Тэр үед олон хөлөг баатрыг шатааж, үнсийг Тибр мөрөн рүү

урсгасанболовч, энэ шүлэгт бунхны тухай гарч байна. Лондонд байгаа бунхан. Лондонд цөөн хэдэн Хөлөгбаатрыг бунхалсан юм" гээд, Тийбин Ландоныг санах болов уу гэж түр хүлээгээд, түүнийгхариулсангүйд эцэст нь унтууцаж, "Роберт, чи минь дээ! Лондонд Сионий Прайорийнхны Хөлөгбаатруудын барьсан нэг л сүм байдаг".

"Дуган сүм уу?" гэж Ландон сэргээд, "Тэнд бунхан байдаг юм уу?" гэж шалгаав.

"Тэнд айж сүрдэм төрхтэй 10 бунхан байдаг юм".

Ландон энэ тухай судалж байсан боловч, Дуган сүмд өмнө нь огт очиж үзээгүй байжээ.

"Дуган сүм Флийт гудамжинд байдаг юм уу?"

"Бараг тийм. Тэндээс тун ойрхон байдаг" гэж Тийбин хариулав. "Та хоёрын аль нь ч тэнд очижүзээгүй юм уу?" гэж түүнийг асуухад, тэр хоёр толгойгоо зэрэг сэгсрэв.

"Энэ ч гайхах зүйл биш. Одоо сүмийг тойроод өндөр барилгууд сүндэрлэсэн байдаг болохоор, цөөхөн хүн л тэнд Дуган сүм байдгийг мэдэх байх. Маш эртний сүм л дээ. Барилгын шийдэл нь шашингүйн урсгалтай нягт холбоотой".

Софи гайхаж, "Шашингүйн урсгалынх гэсэн үү?"

"Бараг л тийм!" гэж Тийбин хариулаад, "Сүм дугуй хэлбэртэй. Хөлөг баатрууд сүмийг Христийнхээс ялгахын тулд, нарны хэлбэрийг бэлгэдэж, дув дугуй хэлбэртэй барьсан юм" гээд хөмсөг нь чөтгөрийнх шиг нумрангаа, "Бас болоогүй ээ! Тэднийг Стоун Хенжийг засварлан сэргээсэн гэж хүмүүс одоо хүртэл ярьдаг юм".

Тийбиний баяр хөөртэй яриа нь гэнэт замхарч, "Гэхдээ би сайн ойлгохгүй байна, Энд нэг зүйл дээргадчихаад байна. Ямар ч байсан 10 бунхныг бүгдийг сайтар нягталж үзэх хэрэгтэй. Аз болжнэгнийх нь дотор бөмбөрцөг байх ч юм билүү!"

Ландон Сангрийльд улам ойртож байгаагаа мэдэрнэ. Хэрвээ тэд бөмбөрцөг гээд байгаа зүйлийг голчихвол, жижиг криптексийг нээж чадна гэсэн үг. Харин дотор нь юу байх бол гэдгийг тэрээртөсөөлж ч чадахгүй байв.

Ландон шүлгийг дахин уншина. Грейлийг илэрхийлсэн 5 үсэгтэй ямар үг байж болох вэ?

Онгоцонд байхдаа, Ландон өмнө нь хувилбар байж болохоор үгсийн тухай бас л бодож байсан юм. Грейл, Граал, Грийл, Мариа, Ийсүс гээд л ... "Гэвч ийм хялбар үгс байж хэрхэвч таарахгүй" гэсэн Тийбиний угийг Ландон дотроо зөвшөөрч байв.

"Эзэнтээн!" гэж Реми эргэж харан хэлээд, "Та Флийт гудамжийг Блэкфрайэр гүүрний ойролцоо байдаг гэсэн үү?"

"Тийм ээ. Викториагийн даланг дагаад яв!"

"Уучлаарай! Би даланг хаана байдгийг мэдэхгүй шүү дээ. Зөвхөн эмнэлэг рүү явах замыг л мэднэ".

Тийбин нүдээ эргэлдүүлэн, нөгөө хоёр луу харснаа, амандаа бувтнаж, "Заримдаа нялх хүүхэд асарч байгаа юм шиг л санагдах юм. Намайг өршөөгөөрэй!" гээд тэднийг орхиж, Ремид зам зааж хэлэхээр, урагш тонгойн босов.

Софи тэр мөчид Ландон руу харж, "Роберт! Одоо чи, бид хоёрыг Англид байгааг хэн ч мэдэхгүй байгаа шүү дээ" гэж намуухан дуугаар өгүүлэв.

Софигийн хэлдэг үнэн байлаа.

Английн цагдаа нар онгоц хоосон байсныг Фаашид хэлж, Фааши үүнийг сонсоод, тэр хоёрыг Францад байгаа гэж бодох болно. Бид одоо ор сураггүй алга болсон.

Тийбиний найруулсан жүжиг тэдэнд хангалттай хугацаа хожих боломжийг олгожээ.

"Гэхдээ Фааш тийм ч амархан бууж өгөхгүй байх. Биднийг баривчлахын тулд, тэр юугаа чхайрлахгүй зүтгэсээр байх болно" гэж Софи хэлэв.

Ландон Фаашийн тухай бодол болов. Софи Ландоны буруугүйг эцсээ хүртэл батлах болно гэжтүүнд хэлсэн ч, үнэндээ энэ нь тайвшрахад хангалттай шалтаг биш байв. Ландон Францынцагдаагийн газрын ахмадыг Ариун Грейлтэй холбоотой гэж сэжиглэхгүй байгаа ч, Фааш бол машшүтлэгтэй хүн гэдэг нь алхам тутмаас нь мэдрэгдэж байсан билээ. Мөн Ландоны эсрэг эд мөрийнбаримт, нотолгоо ахмадад хангалттай их байгаа. Түүний нэр Луврын шалан дээр бичигдэж, Сониехийн дэвгрээс олдсон, мөн өөрийнхөө номын гар бичмэлийн тухай худал мэдүүлэг өгсөнгээд олон шалтгийг ахмад тоочиж болно.

"Роберт, чамайг энэ бүхэнд хэтэрхий их орооцолдсонд, өмнөөс чинь харамсаж байна" гээд Софитүүний өвөр дээр гараа тавив. "Гэхдээ чи надтай хамт байгаад, би их баярлаж байгаа шүү" гэжбүсгүй түүнийг тайвшруулав.

Түүний хэлсэн үгэнд романтик гэхээсээ илүү үнэн сэтгэл шингэсэн байв.

Ландон түүн руу харж, муухан инээмсэглээд, "Унтаж амарсан бол мөн ч зугаатай байхсан".

Софи хэсэг чимээгүй байснаа, "Өвөө намайг чамд итгээсэй гэж хүссэн. Би түүний хүслийгдагасандаа, сэтгэл хангалуун байна" гэв.

"Өвөө чинь намайг огт мэдэхгүй шүү дээ".

"Тэгсэн ч гэсэн, түүний хүссэнээр болж, чи түүний бүх шалгуурыг

амжилттай давж гарсан. Надад Онъсон чулууг олоход тусалж, Сангрийлийн тухай тайлбарлаж, доод хонгилд харсан этгээд мөргөл ёслолын тухай надад учирлаж ойлгуулсан хүн бол чи. Биөнгөрсөн шөнө зарим талаар өвөөтэйгөө маш нягт холбоотой байснаа мэдэрсэн. Өвөө үүнийгмэдсэн бол их л баярлах байсан даа".

Тэнгэрийн хаяанд улайран харагдах Лондоны захын дүүргүүд нүдэнд ил гарч ирэв.

Биг Бен, Цамхаган гүүр зэрэг алдартай газрууд энэ хотод олон бий.

Ландон өвдгөндөө хүртэл тонгойн найтаагаад, эргэж өндийтөл, Софи түүн рүү ширтэж байв. Бүсгүй түүнтэй чухал зүйл ярих гэж байгааг Ландон ойлгов.

"Хэрвээ бид нар Сангрийлийн баримтыг олчихвол цааш хэрхэх талаар чи бодож үзсэн үү?" гэжСофи шивэгнэн асуув.

"Миний юу гэж бодох чухал биш шүү дээ. Өвөө чинь зөвхөн чамд л гэж криптексийг дамжуулсанболохоор, түүний юу гэх байсныг чи сайн тунгааж бодоод, өөрийнхөөрөө шийдэх хэрэгтэй".

"Би чиний саналыг асууж байна. Өвөө чиний гар бичмэлийг уншаад л, чамд итгэж болохыгойлгосон байсан. Тэгээд ч чамтай уулзахаар, цаг товлосон байсан шүү дээ. Энэ бол маш чухалзүйл".

"Өвөө чинь миний гар бичмэлийг алдаатай, буруу байсныг хэлэх гэж байсан ч юм билүү!"

"Чиний ном өвөөд таалагдаагүй бол, чамайг ол гэж надад даалгахгүй байх байсан юм.

Чи номондоо Сангрийлийг ил, эсвэл далд байлгах тухай хөндөж бичсэн үү?"

"Би энэ тухай огт хөндөж бичээгүй. Тэр ч байтугай Грейлийг хаана байдаг тухайд ч хөндөөгүй".

"Гэхдээ чи энэ тухай номондоо бичсэн болохоор, өөрийн гэсэн үзэл бодол байгаа биз дээ?"

"Шинэ түүхийг хөндөж бичих эсвэл..." гээд Ландон гацчихав. "Эсвэл юу гэж?"

"Эсвэл Шинэ гэрээг хуурамч түүх гэдгийг шинжлэх ухаанчаар нотолно гэдэг маш ялгаатай зүйлгэх гэсэн юм".

"Тиймээ. Шинэ гэрээг зохиомол гэж чи хэлж байсан".

"Софи! Дэлхий дээрх бүх итгэл үнэмшил зохиомол зүйл дээр үндэслэдэг юм".

"Чи тэгвэл Сангрийлийн баримтууд үүрд нууц хэвээр үлдээсэй гэж бодож байна уу?"

"Би бол түүх судлаач. Тийм болохоор энэ баримтуудыг ор мөргүй устаж алга болохыг мэдээжхүсэхгүй байна. Тиймээс ч Есүс Христийн бодит амьдралын тухай баримт нотолгоог шашны талыгбаримталдаг түүх судлаачид хэрхэн хүлээн авахыг хармаар байна". "Чи асуудлыг бөөрөнхийлөөдбайна шүү дээ!"

"Тийм гэж үү? Библи бол Коран, Тора, Пали, Канон гэх мэт сургаалуудтай адил энэ гариг дээрхолом сая хүний итгэл үнэмшлийнх нь гол үндэс суурь болсоор ирсэн. Тиймээс чи төсөөлөөд үз лдээ! Ислам, Жүүд, Будда, Шашингүйн үзлийнхний сүсэг бишрэлийг уландаа гишгэж өөр баримтнотолгоо гаргаж ирвэл юу болох вэ? Хэрэв бурхны шашныг шүтэгчдэд Будда бадамлянхуа цэцгийндэлбээнээс мэндлээгүй гэж хэлвэл яах бол? Эсвэл Есүсийг онгон эмэгтэйгээс төрөөгүй гэвэл яахвэ? Тийм болохоор хүмүүсийн сүсэг бишрэлийг хүндэлж үзэх хэрэгтэй".

"Манай найзууд Христийг шүтдэг. Тэд Христийг усны гадарга дээр явж, усыг дарс болгож, басонгон эмэгтэйгээс төрсөн гэдэгт үнэхээр итгэдэг".

"Би үүнийг чинь л хэлээд байгаа юм. Шашин шүтлэгийн зохиомол түүх бидний амьдралд бодитзүйл болж тусгалаа олдог. Харин энэ бодит зүйлийнхээ ачаар олон хүн гэгээлэг, өөдрөгөөр сэтгэжамьдардаг юм".

"Гэхдээ тэдний бодит гэж итгээд байгаа зүйл үнэндээ худал хуурмаг шүү дээ".

Ландон дотроо инээж, "Тэгвэл математикчид "i" тоонд (комплекс тоо) итгэснийхээ ачаар л кодыгтайлдаг шүүдээ".

Софи хөмсгөө зангидаад, "Энэ чинь шударга биш байна гэж зөрүүдлэв.

Хэсэг хугацаа өнгөрлөө.

"Чи түрүүнд юун тухай ярьж байлаа?" гэж Ландоныг асуухад, "Би санахгүй байна" гэж Софихариулав.

Ландон инээмсэглэж, "Би чамайг залхаачихав уу даа?" хэмээн аргадах гэж оролдов.

Тэднийг Дуган сүмийн ойролцоо ирэхэд, Ландоны Микки Маустай бугуйн цаг 7.30 гэсэн тоог заажбайв. Тэд байшингуудыг сүлжсээр сүм рүү ороход, сүмийн чулуун хана нь бороонд норсон тул, өглөөний гэрэлд гялалзан харагдаад, оройд нь цагаан тагтаанууд олноороо суусан байв. Энэхүүэртний Дуган сүмийг тэр чигт нь Кайн чулуугаар барьжээ.

1185 оны 2 - р сарын 10 - нд Иерусалим хотын тэргүүн хамба Гераклиусын санаачлалаар баригдсан, энэ сүм 800 зуун жилийн турш Лондоны их түймэр, дэлхийн 1 - р дайн зэрэг нийгэм улс төрийн нүймээн самуунд тэсч үлдсэн боловч, 1940 онд Люфт - Ваффын довтолгооны тэсрэх бөмбөгд ихээхэн сүйдэж эвдэрсэн юм. Харин дайны дараа түүнийг сэргээн засварласан ажээ.

Ландон дугуй хэлбэртэй баригдсан, барилгыг бахдан биширсэн байдалтай харна. Барилгын загвар нь энгийн боловч Ромын сэргэн мандлын үеийг санагдуулахаар ажээ.

"Өнөөдөр чинь нээрээ бямба гариг юм байна шүү дээ" гэж Тийбин хэлээд, үүд рүү хазганан очсоноо, Тийм болохоор, өнөөдөртөө нийтэд үйлчлэхгүй бололтой гэв.

Сүмийн үүдийг том хос дааман хаалгаар хийж, баруун талынхад нь цагийн хуваарь, анхааруулга, заавар гэх мэтийг өлгөсөн байв.

Тийбин тэрхүү хуваарийг уншаад хөмсөг зангидаж, "Эд нар 2 цагийн дараа л үүдээ нээх юм байна даа" гэж хэлээд, хаалгыг гараараа түлхэв.

Хаалга онгойсонгүй. Гэвч тэр шантарсангүй, чихээ хаалган дээр нааж чимээ гарахыг хүлээнхөдлөлгүй зогсоно. Хэдэн хормын дараа тэр хаалганаас холдоод, самбар руу зааж, "Роберт, чи энэхуваарийг дахиад шалга даа! Энэ долоо хоногт сүмийг ямар лам хариуцаж байгааг бичсэн зүйл энд байна уу?"

Сүмийн тахилч хөвгүүн танхимын хивсийг соруулж байтал, гаднах хаалгыг хэн нэг нь тогшихыг сонсов. Гэвч тэр тоосонгүй. Учир нь эцэг ламтан Харви Ноулз сүмд орж ирэхдээ өөрөөтүлхүүрддэг бөгөөд ирэх цаг нь болоогүй байлаа.

Учраа мэдэхгүй жуулчин эсвэл гуйлгачдын хэн нэг нь тогшсон биз гэж хөвгүүн бодоод огтхайхарсангүй. Гэвч хэн нэг нь хаалгыг тогшсоор л байв.

Уншиж чаддаггүй юм байх даа! Хаалганы гаднах хуваарь дээр бямба гаригт 9.30 - д онгойно гэж бичсэн байгаа шүүдээ.

Тогшиж байсан чимээ балбах дуугаар солигдов. Хэн нэг нь хаалгыг төмөр саваагаар цохиж буй бололтой. Тахилч хөвгүүн үүд рүү ууртайгаар очоод, түгжээг мулталж хаалгыг онгойлгов. Үүдэнд зогсох этгээд 3 хүнийг хараад, "Жуулчид!" гэж амандаа бувтнангаа, "Манайх 9.30 - д онгойно" гэж хэлэв.

Нөгөө хоёр хүнийгээ дагуулан явж байгаа бололтой, хүнд лагс биетэй тэр хүн төмөр таягаа тулан байж түүн рүү ойртоод, "Намайг Лей Тийбин гэдэг" хэмээн хэлэх нь цэвэр англо - саксон аялгатай байв. "Би ноён Кристофер Рений гэр бүлийг дагуулан явж байна" гээд нөгөө хоёр хүн рүү гараараа дохин заав.

Эхнэр нь бололтой бүсгүй нүдэнд дулаахан харагдах бөгөөд, улаан хүрэн үстэй ажээ. Харин нөхөр нь өндөр нуруутай, хар үстэй, маш танил царайтай хүн байлаа.

Тахилч хөвгүүн юу гэж хариулахаа мэдэхгүй алмайран зогсоно. Учир нь ноён Кристофер Рений өвөг эцэг нь сүмийнхний хувьд хамгийн нэр хүндтэй хүн байсан юм. Ноён Кристофер их түймрээс болж, эвдэрч сүйрсэн сүмийн барилгыг засч сэргээхэд, өөрийн хөрөнгөө харамгүй зориулсан ажээ. Харин 18 - р зууны эхээр тэр өөд болжээ.

"Аан... За... Тантай уулзсандаа таатай байна, ноёнтоон!" гэж хөвгүүнийг арай ядан хэлэхэд, нөгөөтаягтай хүн хөмсгөө зангидаад,

"Чи ч их хөшүүн хойрго загнаж байх шив дээ, залуу минь! Эцэг ламтан Ноулз хаана байгаа вэ?"

"Өнөөдөр Бямба гариг болохоор эцэг ламтан 2 цагийн дараа ирнэ". Нөгөө таягт эр улам унтууцаж, "Сонин юм болж байх шив дээ! Ирнэ гэж өөрөө хэлсэн юмсан. Гэвч бид түүнгүйгээр л бүгдийг зохицуулахаас. Нэг их удахгүй гэж найдаж байна".

Тахилч хөвгүүн хаалгаа алдлан зогсоод, "Уучлаарай! Юу удахгүй гэж?"

Зочны харц ширүүсэж, түүний нүүрэнд тултал ойртоод, ямар нэг нууц зүйл хэлэх гэж байгаа юмшиг шивэгнэв.

"Залуу минь чи шинэ хүн бололтой. Рений үр удам болсон энэ хүмүүс жил бүр түүний бунхандирж хүндэтгэл үзүүлдэг юм. Энэ бол бурхан болоочийн сүүлчийн хүсэл. Хэн ч үүнийг тэр бүр хийгээд байхыг хүсэхгүй шүү дээ. Гэвч өөр яалтай билээ".

Тахилч жаал хэдийгээр энд ирээд, 2 жил болж байгаа боловч, ийм уламжлалын тухай огтсонсоогүй байсан аж.

"Та нар 9.30 хүртэл хүлээсэн нь дээр байх. Сүм арай онгойх болоогүй байна. Тэгээд ч бицэвэрлэгээгээ хийж дуусаагүй байгаа".

Таягтай эр дүрсхийтэл уурлаж, "Залуу минь! Бидний энд ирсэн ганц шалтгаан бол энэ эмэгтэйн халаасанд байгаа тэр зүйлээс өөр юу ч биш".

"Та сая юу гэсэн бэ?"

"Хатагтай Рен! Та энэ зөрүүд залууд чандрууг үзүүлэхгүй юу?"

Бүсгүй хэсэг эргэлзэн зогсож байснаа, цамцныхаа халааснаас нэгэн цилиндр хэлбэртэй хайрцаггаргаж ирэв.

"Харж байна уу, чи?" гэж нөгөө хүн омогдоод, "Одоо чи биднийг дотогш нь оруулж, үхсэн хүний хүслийг амирлуулах хэрэгтэй болж дээ. Эсвэл яаж аашилсныг чинь эцэг ламтанд хэлэх хэрэгтэй юу?"

Тахилч банди хэсэг эргэлзээд, *магадгүй эцэг ламтан тэдний ирэхийг хэлэхээ мартчихсан юм байх* гэж бодоод, тэднийг явуулснаас оруулсан нь дээр юм байна гэж эцэст нь шийдэв.

Тэгээд ч энэ хүмүүс удахгүй гэсэн шүү дээ! Юу л болов гэж хэмээн бодоод сүмийн хаалгыг нээж, эхнэр, нөхөр Ренийг цуг яваа хүнтэй нь дотогш оруулав. Хөвгүүн тэднийг хулгайн нүдээр сэмажиглан араасаа дагуулж явлаа.

Сүм рүү орсон цагаас эхэлж, Ландоны царайд баяр хөөр тодроод нүд нь гялалзаж,

"Чи ч хулхин дээр цэцэг ургуулахдаа гарамгай юм аа." гэж тэр шивэгнэв.

"Оксфордын жүжгийн дугуйланд явдаг байсных. Миний тоглосон Юлий Цезарийн дүрийг хүмүүсодоо ч дурсдаг гэнэлээ. Жүжгийн эхний үзэгдлийн 3 - р хэсэгт над шиг үнэмшилтэй жүжиглэсэн хүний тухай би одоо болтол олж сонсоогүй л байна". Ландон түүн рүү харж, "Тэр хэсэг дээр чинь Цезарь аль хэдийн үхчихсэн байдаг шүү дээ!" хэмээн гайхав.

Тийбин инээж, "Тийм ээ. Би өмнөх үзэгдэл дээр нь үхэж байгаа дүр үзүүлээд, тайзны дээрээсүсэрсэн боловч, миний өмссөн нөмрөг тавцанд тээглээд, тэндээсээ өлгөгдөөд гацчихсан юм. Барагхагас цаг үхсэн хүн болж, хөдөлгөөнгүй дүүжлэгдсэн шүү! Тийм ээ, би мундаг байсан".

Ландон хөхөрч, "Аан, нээрээ би ийм үзэгдэл гардгийг нь мартчихаж".

Сүмийн доторх байдал хүйтэн хөндий, цулгуй хоосон юм шиг харагдана.

"Энэ бол Англи сүмийн онцлог. Англичууд шашныг бараг авч хэрэгсдэггүй юм. Бидний харамчнарийн занг эндээс тодорхой харж болно" гэж Тийбин өгүүлэв.

Софи, сүмийн дугуйрсан ханыг тойруулан хараад, "Энэ яг л цайз хэрэм шиг харагдаж байна" гэжшивэгнэв. Ландон ч үүнийг зөвшөөрч байлаа.

Сүмийн ханыг зузаан чулуугаар барьжээ.

"Хөлөг баатруудын холбооныхон цэрэг дайчид байсан юм шүү!" гэж Тийбин сануулаад, "Шашин,цэргийн зориулалт хосолсон барилгын загвар гэвэл үүнийг л хэлнэ. Тэдний барьсан сүм басхүүтэдний цайз хэрэм болж байсан юм".

Ландон гол дугуй танхимд орж ирээд, хөшиж орхив. Танхимын дотор талд дүрсэлсэн хэрээ, бугчөтгөр, мангас, зовж шаналсан хүний царай, энэ бүгд танхимд дөнгөж орж ирсэн тэдэн рүү ширтэхнь сүрдмээр харагдана.

"Дугуй тайзтай театр шиг юм гээч" гэж Ландон шивнэв. Тийбин таягаа өргөж баруун зүүн талруугаа ээлжлэн заахад, Ландон тэр зүг дагуулж харлаа.

Тэр бол Хөлөг баатруудын бунхнууд байлаа.

Таван бунхан зүүн талдаа, үлдсэн нь баруун талд байв. 10 хөлөг баатар хуяг дуулга, сэлэм бамбайнхамт дээш харан хэвтэх нь Ландоны нүдэнд даруй танигдав. Тэднийг унтаж байхад, дээрээс ньзуурмаг асгасан юм шиг эвгүй харагдана.

Бүгд хоорондоо ялгаатай, нэг ч давтагдсан зүйл бунхнуудад байсангүй.

Папын оршуулсан хөлөг баатрын бунхан Лондонд буй.

Танхимын гол руу дөхөх тусам, Ландоны хамаг бие нь хөлөрнө. *Үүнээс өөр газар байх ёсгүй!*

Хэсэг 84

Реми Легалудек Ягуар лимузинээ мухар гудамжны төгсгөл дэх хогийн саванд бараг тулгах шахамзогсоов. Хөдөлгүүрээ унтраагаад, эргэн тойрноо шалгалаа. Машинаасаа бууж, арын хаалгааонгойлгоод, хуврагийг гаргаж ирэв. Альбиногийн нүдэнд айсан гэхээсээ илүү, сониучирхсанбайдал тодорно. Өнгөрсөн шөнийн турш хувраг бүх зүйлийг хүлцэн тэвчиж, тэсвэртэйгээрөнгөрөөсөнд, Реми түүнийг дотроо бахдаж байв. "Хонины хонхорт" шидэгдэж явахдаа, альбиноөөрийн гэсэн тэсвэр тэвчээрийг хангалттай харуулсан билээ.

Реми зангиагаа суллаж, цамцныхаа дээд товчийг тайлаад, ойрд ингэж чөлөөтэй амьсгалаагүйгээгэнэт санав. Тэр лимузинийхээ хөргөгчөөс Смирнофф архи авч, нэг амьсгаагаар хөнтрөөд, дараа ньдахиад нэг балгав.

Удахгүй би эрх чөлөөтэй хүн болно.

Реми хөргөгчөөс хутга олоод, Силас руу эргэн харж, хутгаа дээш өргөв. Хуврагийн нүд

айдастүгшүүрээр дүүрчээ. Реми түүн рүү очиж инээмсэглээд, "Тэвчээртэй бай" гэж шивэгнэнгээ, хутгаатүүн рүү чиглүүлэх нь тэр. Тэр мөчид Силас Бурхан түүнийг орхиогүй гэдэгт итгэсээр л байв.

Хутга доошилсоор түүн рүү ойртоход, Силас нүдээ тас анилаа. Тэр байдгаараа орилж байх зуураа, өөрийгөө хамгаалж чадалгүй үхчихнэ гэж бодохгүй байлаа. *Би Бурхны төлөө бүгдийг зориулсан! Хэрэгтэй үед намайг бурхан хамгаална гэж Багш өөрөө ч хэлсэн шүү дээ.*

Гэнэт түүний гар нь халуу оргиж эхлэхийг, Силас мэдрэв. Түүний бүх булчин нь зангирч, нүдээулам чанга аниад, Хамба лам Арингароза болон Испани дахь жижиг сүмийнхээ тухай дурсав. Энэ сүмийг Арингароза, тэр хоёр гар биеэ оролцуулан байж барьсан билээ.

Эндээс л миний амьдрал эхэлсэн.

Силасын бүх бие галд шатаж байгаа мэт халуу дүүгэнэ.

"Юм уух уу?" гэж хар хослолтой нөгөө хүн Франц аялгаар хэлээд, "Шингэн чинь нөхөгдөнө шүүдээ!" гэв.

Силас гайхан нүдээ нээвэл, сүүтгэнэсэн дүрс түүн рүү тонгойгоод, шилэн аягатай зүйл барьж байв. Түүний хажууд наалттай тууз хэдэн хэсэг болоод, тасарчихсан хэвтэж байхыг, Силас олж харав.

"Үүнийг уу!" гэж нөгөө эр давтан хэлэв.

Силас шилтэй архийг амстал, маш гашуун амттай байсан боловч, хэд хэд балгаж орхив.

Сайхан мэдрэмж төрж байна шүү!

Өнгөрсөн шөнө түүнд золгүй явдал тохиолдож бүтэлгүйтсэн боловч, одоо тэр эсэн мэнд үлдэж чаджээ.

Бурхан намайг мартаагүй л юм байна. Арингароза үүнийг дээд тэнгэрийн ивээл гэж хэлэх байсан биз.

"Би чамайг арай эрт суллая гэж бодож байсан юм. Гэхдээ ингэх боломж надад олдоогүй л дээ. Харин сая л ийм завшаан гарлаа. Чи намайг ойлгож байна уу, Силас?"

Силас огло үсрэн цочиж, "Та намайг мэддэг юм уу?"

Үйлчлэгч хариуд нь инээмсэглэж байв. Силас дээш босч хөшсөн биеэ тэнийлгээд, хүндэтгэл бишрэл, бас эргэлзээ дүүрэн харцаар түүнийг харж, "Та тэгвэл Багш байх нь ээ?"

Реми толгойгоо сэгсэрч, түүнийг шоолон инээгээд, "Надад түүн шиг сүр хүч байдаг ч болоосой. Би Багш биш. Яг л чам шиг түүнд үйлчилдэг. Гэхдээ Багш чиний тухай надад ярьсан. Намайг Ремигэдэг".

Силас гайхаж, "Би ойлгохгүй байна. Хэрэв чи Багшид ажилладаг юм бол, Ландон танай гэрт яагаад Онъсон чулууг авч очсон юм бэ?"

"Тэр бол манай гэр биш. Харин Грейлийн алдарт түүхч Лей Тийбиний гэр байгаа юм".

"Гэхдээ чи тэнд амьдардаг биз дээ? Хачин юм аа".

"Энэ бүхнийг эртнээс маш нарийн төлөвлөсөн байсан. Роберт Ландон Онъсон чулууг гарта оруулмагцаа, түүнд туслалцаа хэрэгтэйг ойлгосон. Тэр Лей Тийбин рүү очих магадлал

хамгийнөндөр байсан болохоор, Багш намайг анхнаас нь тэнд ажиллуулсан юм байж".

Силас сая л бүхнийг ойлголоо.

Багш Лей Тийбиний хөдөлгөөн бүрийг тандахын тулд, гэрийн үйлчлэгчийг ашиглаж байжээ! Гайхалтай юм.

"Би чамд их зүйл яримаар л байна" гэж хэлээд, Реми Силаст гар буу өгөв. "Гэхдээ бид хоёртдуусгах ёстой нэг ажил бий".

Ахмад Фааш Биггин Хиллийн онгоцны буудал дээр буунгуутаа, байцаагчийн хэлснийг сонсоодчихэндээ ч итгэсэнгүй.

"Би Тийбиний онгоцыг өөрийн биеэр шалгасан. Дотор хэн ч байгаагүй" гэж ахлах байцаагчучирлаад, удалгүй дууных нь өнгөнд хорссон байдал тодорч, "Хэрвээ Лей Тийбин миний эсрэгмэдүүлэг өгвөл би ч өнгөрөх байлгүй" гэв.

"Нисэгчийг байцаасан уу?"

"Мэдээж үгүй. Тэр чинь Франц хүн байсан. Эндхийн хуулиар түүнийг байцаах эрх бидэндбайхгүй".

"Надтай хамт онгоц руу яв!"

Фааш минутын дараа, Тийбиний онгоц руу орж байв. Нисэгчийн бүхээгийг чангаар балбаж, "Францын цагдаагийн ахмад байна. Хаалгаа нээ!"

Айж цочирдсон нисэгч хаалгаа онгойлгов.

3 минутын дараа гэхэд, ахмад Фааш балмагдсан нисэгчийг далайлган дарамталж байгаад, бүхзүйлийг мэдэж авлаа. Мөн түүнээс гадна, нисэгчийг харж байхад, нөгөө 3 Тийбиний төмөр сейфэнднэгэн модон хайрцаг үлдээгээд явсныг хүртэл, тэрээр олж мэдэв.

"Сейфийг онгойлго!" гэж Фаашийг тушаахад, нисэгч айж мэгдсэн харцаар

"Би онгойлгож чадахгүй шүү дээ".

"Энэ ч муу хэрэг шүү. Би л чиний оронд байсан бол, нисэгчийн үнэмлэхээ хураалгахгүй байх аргабодох байсан юм".

Нисэгч гараа саваад, "За ойлголоо. Би онгойлгож чадах хүмүүсийг мэдэх юм шиг байна. Сейфийгөрөмдөж онгойлгохоос өөр аргагүй".

"Чамд хагас цагийн хугацаа өгье!"

Нисэгч сандран, тэр даруй радио станцаа гарган, ярьж эхлэв.

Фааш онгоцны хойд хэсэгт очиж, тэнд байсан архинаас өөртөө аягалав. Дөнгөж үүр цайж байгаа ч, тэр нойргүй хоносон учир тархиа ингэж сэргээхээс өөр аргагүй байв. Фаашийн утас дуугарахад, тэрээр "Хором зуур ч гэсэн тайван байдаг болоосой!" гэж бодоод утсаа авлаа,

"Алло" (Байна уу?)

"Би одоо Лондон руу нисч байна".

Энэ бол Арингароза байлаа. "Би цагийн дараа очих байх".

"Би таныг Парис руу явж байгаа гэж бодсон юмсан".

"Би энэ бүхэнд маш их санаа зовж байна. Тийм болохоор төлөвлөгөөгөө өөрчилчихлөө".

"Тэгэх хэрэггүй байсан юм".

"Та Силасыг олов уу?"

"Чадсангүй. Түүнийг барьцаалсан хүмүүс эндхийн цагдаа нарыг аргалаад, зугтаж амжсан байна".

Арингарозагийн уур хилэн дүрэлзэж, "Та тэр онгоцыг саатуулна гэж өөрөө амласан биз дээ?"

Фааш дуугаа намсгаад, "Хамбатан, би таны байдлыг ойлгож байгаа тул, та бас миний тэвчээрийг барахгүй байхыг хүсч байна. Би Силас болон бусдыг нь чадах ядахаараа олох болно. Та хаанагазардах гэж байна?"

"Түр хүлээгээрэй!" гээд Арингароза харилцуураас хөндийрч, хэсэг хугацааны дараа эргэж ирээд,

"Манай нисэгч Хебрюгийн онгоцны буудал дээр буухыг хичээж байна. Надаас өөр зорчи гчбайхгүй болохоор нь нислэгийн чиглэлийг би өөрчилчихсөн юм".

"Та наад нисэгчдээ Биггин Хилл онгоцны буудалд буу гэж дамжуул! Энд буух зөвшөөрлийг бихариуцъя. Таныг энд ирэхэд, би энд байхгүй байвал, миний үлдээсэн машинаар яваарай".

"Баярлалаа".

"Би танд анхнаасаа л хэлээд байгаа шүү дээ. Бүх зүйлээ алдахын ирмэг дээр байгаа гэж та өөрийгөө хэрхэвч бодож болохгүй. Бүх зүйл сайхан болно".

Хэсэг 85

Та нар түүний бунхан дахь бөмбөрцгийг эрж хайна.

Хөлөг баатруудын бунхан баримлууд бүгдээрээ толгойн дороо дэр чулуутай байх ажээ. Шүлэгтгарч буй бөмбөрцөг өвөөгийнх нь тэр шөнө оролцсон, мөргөл дээр харсан бөмбөрцөгтэй адилхан юм шиг Софид санагдана.

Гиерос Гамос. Бөмбөрцгүүд.

Софи энэхүү Дуган сүмд тэр мөргөл ёслолыг харсан гэж андуурахаар байв. Үнэндээ энэ сүмийг тиймэрхүү ёслолд яв цав тохируулж барьсан мэт санагдана. Танхимын голд дугуй хэлбэртэй чулуун сандал үзэгдэнэ. Шөнө гэж бодоод, бамбарын гэрэлд багтай хүмүүс тойргоор зогсоод, ариун цуглааныг энэ танхимд хийж байгаагаар Софи төсөөлөв.

Софи сэтгэлдээ хураасан жавартай бодлоо үлдэн хөөж, Хөлөг баатрын бунхны нэг талын хэсэг рүү нь зүглэж буй нөгөө хоёрынхоо араас дагав. Тэдгээр бунхнуудыг нягталж хараад, Софи тэдний хоорондоо төстэй болон ялгаатай байдлыг нь шинжин зогсоно. Таван хөлөг баатрын аль аль нь нуруугаараа дээш харан хэвтэх боловч, гурав нь хөлөө шулуунаар жийж,

харин үлдсэн хоёр ньхөлөө зөрүүлжээ. 2 хөлөг баатар нь хуяг дуулганыхаа гадуур нөмрөгтэй байхад, үлдсэн 3 ньшагайгаа хүрсэн урт өмсгөлтэй байх аж. Эдгээр шинжийн аль нь ч бөмбөрцөгтэй холбогдохгүйбайв.

Софи тэдний гарт анхаарлаа шилжүүллээ. 2 баатар нь гартаа сэлэм барьж, 2 нь залбирал үйлдсэнбайдалтай байхад, харин үлдсэн нэг 1 нь гараа цээжиндээ авчээ. Бас л аль алинд нь бөмбөрцгийг

агуулсан утгатай зүйл харагдсангүйд, Софи мөрөө хавчин ярвайв. Бүсгүй нөгөө хоёр луугаа эргэжхарсан ч, тэд бас л юу ч олоогүй бололтой дэмий ширтэж байв. Тэрээр хүлээж тэвчсэнгүй, нөгөөталын үлдсэн хэсэг рүү очихоор эргэлээ. Тийш очих замдаа ой тойнд нь гүн шингэсэн, 4 мөртшүлгийг цээжээр уншина.

Папын оршуулсан Хөлөг баатрын бунхан Лондонл буй

Тэр баатрын ажлын үр шим Ариун бүхнийг хилэгнүүлжээ

Та нар түүний бунхан дахь бөмбөрцгийг эрж хайна

Энэ бол бүхний эхлэл болсон үрт улаан жимсний тухай...

Софи нөгөө талд очиход, адилхан дүр зураг харагдав. Гэвч хамгийн сүүлчийн 10 дахь бунханбусадтайгаа огт адилгүй, онцгой байдалтай байв. Дэр чулуу, хуяг дуулга, нөмрөг, сэлмийн аль нь чтүүнд байсангүй.

"Роберт, Лей!" гэж бүсгүйг дуудахад, түүний дуу нь танхимаар нэг цуурайтна. "Энд нэг зүйл байхшиг байна" гэв. Нөгөө хоёр тэр зүг яаравчлан очлоо.

"Бөмбөрцөг байна уу?" гэж Тийбин баясал тодруулсаар хазганан ирэв. Түүний таягны товшихчимээ сүмийн танхимд цуурайтаад, Ирландын товшуур бүжгийг санагдуулна.

"Арай ч биш" гэж Софи бунхан руу ширтэнгээ хэлээд, "Үүнийг Хөлөг баатар гэж хэн ч хэлэхээргүйхарагдаад байх юм".

Ландон, Тийбин хоёр түүн дээр ирээд хартал, тэр нь үнэндээ бунхан биш, харин битүүмжилсэнчулуун авс байв. Тэр авс хөлөөсөө толгойн хэсэг рүүгээ өргөссөн хэлбэртэй байх бөгөөд, яг лдоошоо харсан лийр шиг харагдах ажээ.

"Энд яагаад Хөлөг баатар байдаггүй билээ?" гэж Ландон хачирхав. "Сонирхолтой юм" гээд Тийбинхацраа маажив. "Би үүнийг мартчихаж. Учир нь би олон жилийн өмнө ирсэн шүү дээ".

"Үүнийг бусадтай адил нэг хүний гараар урласан байна. Гэхдээ яагаад заавал авс байгаа юм бол?"

Тийбин толгой сэгсэрч, "Энэ сүмийн бас нэг оньсого юм байлгүй. Үүнд тайлбар өгсөн байхыг билав олж уншаагүй юм байна".

"Хөөе гэж хэлээд, тахилч хөвгүүн хачирхсан байдалтай тэдэн дээр дөхөж ирээд, "Өршөөгөөрэй! Бибүдүүлэг загнахыг хүсээгүй л дээ. Гэхдээ та нар энд чандруу асгахаар ирсэн гэж хэлчхээд, сүмдоторхыг сонирхоод байх шиг санагдлаа".

Тийбин хөмсгөө зангидсанаа, Ландон руу хараад, "Ноён Рен! Таны өвөг эцгийн нэр хүнд энэ хүүдхамаагүй бололтой. Чандрууг асгаад эндээс явах уу даа?" гээд Софи руу эргэж, "Хатагтай Рен?" гэв.

Софи түүний үгийг үнэмшилтэй болгохын тулд, криптексийг дахин гаргаж ирэв.

"Харин одоо", гээд Тийбин тахилч руу харж хэлээд, "Биднийг түр орхино уу"

Тахилч огтхон ч хөдөлсөнгүй. Харин Ландоныг ойроос хараад, "Та нэг л танил хүн шиг харагдаад байна" гэв.

"Тийбин унтууцаж, "Аргагүй шүү дээ! Ноён Рен жил бүр энд ирдэг юм чинь".

Ватиканы цуглаанд оролцсон Ландоны бичлэгийг тахилч хөвгүүн үзсэн байх гэж Софи таамаглажбайв.

"Би ноён Рентэй огт тааралдаж байгаагүй" гэж хөвгүүн эсэргүүцэв.

"Үгүй дээ. Би чамтай өнгөрсөн жил тааралдаж байсан шүү дээ. Тэгэхэд эцэг Ноулз биднийг танилцуулаагүй өнгөрсөн юм. Гэхдээ би түрүүнд чамайг үүдэнд хараад л таньсан. Төвөг удсан болуучлаарай! Гэхдээ бид чандрууг эдгээр бунхны дэргэд асгах гэж хол замыг туулсан болохоор, чибиднийг түр орхихгүй юу?" гэж Ландон хөвгүүнээс эелдгээр хүсэв.

Хөвгүүн улам сэжиглэсэн байдалтайгаар хараад, "Эд чинь бунхан биш шүү дээ!" гэх нь тэр.

"Уучлаарай! Юу гэнээ?"

"Мэдээж, бунхан байлгүй яахав" гэж Тийбин хэлээд, "Чи юугаа яриад байна аа?"

Тахилч хөвгүүн толгойгоо сэгсэрч, "Бунхан бол дотроо цогцостой байдаг. Гэтэл эд бол зүгээр л зормол дүрс. Жинхэнэ хүнийг дууриаж хийсэн баримлууд байхгүй юу. Эдгээрийн дотор алинд нь ч шарил байхгүй" гэв.

"Энэ бол бунхан" гэж Тийбин давган хэлэв.

"Үеэ өнгөрөөсөн хуучны номуудад л тэгж бичсэн байгаа. Харин 1950 онд үүнийг шинжлээд, дотор нь шарил байхгүйг тогтоосон" гээд Ландон руу ширтэж, "Ноён Рен ч үүнийг мэдэх ёстой. Учир нь тэрхүү шинжилгээг өвөг эцэг нь удирдаж явуулсан юм".

Тэд бүгд чимээгүй болчхов.

Гэнэт нам гүмийг эвдэж, хаалганы чахрах чимээ танхимд сонсогдов.

"Эцэг Ноулз ирж байх шиг байна" гэж Тийбин хэлээд, "Чи түүнийг угтаж авсан нь дээр байх" гэв.

Тахилч хөвгүүн тэднийг сэжиглэж байсан ч чимээ гарсан зүг ухарсаар тэднээс холдов.

"Лей!" гэж Ландон шивнээд, "Ямар ч шарил байхгүй гэж энэ жаал юу яриад байгаа юм бэ?"

Тийбин бүр будлисан байдалтай, "Би ч бас ойлгохгүй байна. Би энэ газрыг л гэж бодож байсан юм. Жаал хүүгийн сая хэлснийг үнэндээ мэдэхгүй юм байна".

"Надад шүлгээ харуул даа" гэж Ландон хэлэв.

Софи криптекстэй цуг шүлэгтэй цаасыг Ландонд өгөв. Ландон криптексийн гадуур ороосон цаасыг дэлгээд,

"Мөн л байна даа. Энд бунхны талаар бичсэнээс биш, зормол дүрстэй баримал гэж огт бичээгүй байна".

"Шүлэг өөрөө алдаатай юм болов уу?" гэж Тийбин асуугаад, "Магадгүй Жак Сониех надтай адилбуруу ойлголттой байсан байж болох шүү дээ".

Ландон үүнийг дотроо эргэцүүлж үзээд, толгой сэгсрэв. "Лей, чи наад үгээ өөртөө л хэл. Хөлөгбаатрууд энэ сүмийг байгуулсан болохоор, Сионий Прайоричууд энэ тухай буруу зүйл мэдсэнбайна гэж үгүй. Харин Жак Сониех нууцаа өөр зүйлээр өнгөлөн далдалж, чулуу хөөлгөхдөөгаргууд хүн байж дээ".

Лей мэл гайхсан дүр гаргаж, "Гэхдээ үүнээс өөр хаана гэж?" гээд, зормол дүрсүүд рүү дөхөжочоод, "Бид нэг зүйл дээр алдсан шиг байна" гэв.

Тахилч хөвгүүн хаалга руу очсон боловч хэн ч тэнд байсангүй.

"Эцэг Ноулз уу?" гэж дуудахдаа, хаалга дуугарахыг яах аргагүй сонссон доо гэж хөвгүүн өөртөөхэлж байв. Гэтэл онгорхой хаалганы дэргэд хар хослолтой туранхай эр ийш тийш харчихсан зогсчбайв.

Жаал хүү хаалгыг түгжилгүй мартсандаа, өөрийгөө зүхэж, Бодвол хуримд оролцох гээд төөрчбудлисан хүн биз гэж таамаглаад, "Уучлаарай. Манайх одоохондоо ажиллаагүй байна" гэв.

Гэтэл ард нь нэг юм сүүтгэнэх шиг болоход, жаал хүү эргэж харах гээд амжилгүй, хойш хүчиндавтагдаад, амыг нь нэг гар таглачхав. Түүнийг хашхирахаас нь өмнө амжиж, амыг нь хаасан тэр гарцав цагаан зүстэй бөгөөд, жаал хүүгийн хамарт архины үнэр сэнхийж байв.

Нөгөө туранхай эр эсэргүүцэх чадалгүй болсон жаал хүү дээр дөхөж ирээд, чихэнд нь уруулааойртуулж ийнхүү хэлэв.

"Анхааралтай сонс! Чи сүмээс чимээгүй гарна. Тэгээд зугтана. Замдаа огт зогсохгүй гүйнэ. Ойлгомжтой юу?"

Амаа таглуулсан жаал хүү толгой дохив.

"Хэрвээ чи цагдаад мэдэгдвэл ..." гээд нөгөө эр хүрэмэнийхээ хормойг ярж, буугаа харуулаад, "Бичамайг олно".

Жаал хүү нэг л мэдэхэд сүмээс гарчихсан, хар хурдаараа гүйж байв. Хөл нь эцэж, биеэ даахгүйболтлоо, тэр гүйсээр л ...

Хэсэг 86

Силас танхим дундуур өд шиг хөвөн ниссээр, бүсгүйн ард дөхөж очив. Харин Софи түүнийг хожууанзаарчээ. Бүсгүй эргэж харах гэсэн боловч, Силас буугаа түүний нуруунд тулгаад, бүсэлхийгээр нь тойруулж хойноос нь тэврээд, бүсгүйг ханхар цээжиндээ хормын зуур нааж орхив. Софигийнхашхирах дуугаар, Тийбин, Ландон хоёр эргэж хараад, машид гайхсан, бас эмээсэн байдалтайболчих нь тэр.

"Чи яаж гээд" Тийбин гайхаад, "Чи Ремийг яасан бэ?" гэв.

"Би ганц зүйл хэлье" гэж Силас тайвнаар өгүүлээд, "Эндээс би Оньсон чулууг авч гарна".

Реми энэхүү төлөвлөгөөг Силаст дэндүү тодорхой тайлбарласан юм.

"Сүм рүү орж, Оньсон чулууг аваад, буцаж гарна. Ингэхдээ хүн алахгүй, буудахгүй".

Силас Софигийн бүсэлхийнээс тэвэрсэн чигтээ, түүний халаасыг тэмтрэв. Бүсгүйн үснээс сэнгэнэхүнэртэй ус, түүний амнаас гарах архины үнэр холилдонгоо, Силас Софигийн чихэнд нь ийнхүүшивэгнэв. "Хаана байна?"

Бүсгүйг өмнө нь Оньсон чулууг халаасандаа хийж байхыг, тэр харсан боловч, одоо хэнд

байгааг ньмэдэхгүй байв.

"Энд байна" гэх Ландоны дуу танхимаар хүнгэнэн цуурайтав.

Силас түүн рүү харвал, Ландон криптексийг барьчихсан, яг л орсон бухаар наадаж байгаа матадоршиг түүнийгээ урагш хойш нь савчуулан зогсох аж.

"Наадхаа доош нь тавь!" гэж Силас шаардав.

"Тэгвэл Софи, Лей хоёрыг эхлээд эндээс гарга! Чи, бид хоёр энүүхэндээ асуудлыг зохицуулж дөнгөнө шүү дээ" гэж Ландон хариулав.

Силас гэнэт Софиг гараасаа чөлөөлөн түлхэж орхиод, Ландон руу буугаа чиглүүлсээр дөхөж очив.

"Надад ойртож болохгүй шүү! Энэ хоёрыг сүмээс гартал, чи надад нэг ч алхам ойртож болохгүй" гэв.

"Шаардлага тавих хүн нь чи биш" гэж Силас буугаа өргөн, түүнд өгүүлэв.

"Үгүй шүү!" гээд Ландон криптексийг толгой дээрээ далайв. "Би үүнийг шалан дээр хэдэн хэсэг болгон тарааж, доторх цууг нь асгаж дөнгөнө шүү".

Силас сүрдүүлэгт нь итгээгүй ч, айж эмээх мэдрэмж төрж байв.

Гэвч тэр Ландоны цохонд буугаа чиглүүлээд, тайван дуугаар "Чи Онъсон чулууг эвдэлж чадахгүй ээ. Чи надтай л адил Грейлийг олж мэдэхийг хүсэхгүй байгаа гэж үү?"

"Чи буруу ярьж байна. Харин ч чи үүнийг надаас илүү хүсч байгаа. Онъсон чулууг гартаа оруулахын тулд, чи хүн алахаас ч буцахгүй байна шүү дээ".

Тэндээс хэдэн алхмын зайд, сэтгэл түгшсэн Реми Легалудек тэднийг сүүдрээс ажиглан зогсоно. Үйл явдлыг харсаар байтал, түүний төлөвлөснөөс өөрөөр өрнөж байгааг хараад, бас Силас Нөхцөлбайдлыг эргүүлж чадахгүй мунгинаж байхыг харахад түүнд хэцүү байв. Багшийн заавраар, Реми Силаст буу хэрэглэхийг нь хориглосон юм. Гэтэл Силасын нүд улаанаараа эргээд, удахгүй тэсрэхгэж буй бөмбөгтэй адилхан харагдаж, Ландоныг юу юугүй буудах нь гэж санагдахаар б айв.

Ландоныг буудчихвал криптекс газар унана. Ийм юм болох ёсгүй шүүдээ! Хэрвээ Ландон үүнийгунагачихвал, бүх зүйл өнгөрнө гэсэн үг. Би тэдэнд жинхэнэ нүүр царайгаа харуулахаас, өөр аргагүй болох нь ээ.

Үг нь өөрийнхөө хэн бэ гэдгийг бусдад мэдэгдэж болохгүй гэж Багш түүнд хатуу сануулсан юм. Учир нь багшийн хэн гэдгийг мэдэх цорын ганц хүн бол Реми байлаа.

"Силас Онъсон чулууг ганцаараа авч дөнгөнө гэдэгт та итгэлтэй байна уу?" гэж Реми багшаас хагасцагийн өмнө шалгаагаад, "Би ч бас үүнийг хийж чадна шүү дээ!" гэж учирласан юм.

Багш эрс шийдэмгий хариулж, "Силас үүргээ сайн гүйцэтгэж, 4 хүнийг цааш харуулсан. Онъсончулууг ч бас олж авчирч чадна. Чи тэдэнд жинхэнэ төрхөө ил гаргах ёсгүй.

Хэрэв тэд чамайг харчихвал, гэрч үлдээхгүйн тулд, тэднийг заавал тонилгох хэрэг бас гарна. Царайгаа харуулна гэж бодсоны ч хэрэггүй шүү!"

Реми царайгаа хувиргаж болно гэж дотроо бодох аж.

"Та надад амласан их мөнгөө өгвөл, би төрөл арилжиж, шинэ хүн болж болно. Мэс заслын аргаархурууны хээгээ ч өөрчилж дөнгөнө. Ингэснийхээ дараа бол эрх чөлөөгөө мэдэрсэн шиг, далайнэргийн наранд биеэ ээн тайван хэвтэж болно шүү дээ".

Гэвч хэсэг хугацааны дараа түүний бодол өөрчлөгдөж, "Ойлголоо би Силасыг далдаас ажиглан,хөндлөнгөөс харж байх болно" гэж Реми Багшид өчив.

"Реми! Чамд л гэж хэлэхэд, Дуган сүмд бунхан байдаггүй юм. Тэд буруу газарт очсон болохоор,тэднээс айж сүрдэх хэрэггүй шүү" гэж багш захижээ.

Реми гайхаж, "Бунхныг хаана байгааг та мэдэж байгаа юм уу?" "Мэдэлгүй яахав. Гэхдээ энэ тухайчамд дараа хэлье. Одоо бид түргэн хөдлөх хэрэгтэй байна. Хэрвээ өөр хүмүүс бунхны байгаажинхэнэ газрыг мэдчих юм бол, бид хожимдож, Грейл үүрд бусдын гарт байх болно".

Реми үнэндээ тэр Грейл гэгч огтхон ч хамаагүй байв. Гэтэл Багш Грейлийг олохоос нааш, хөлсийгнь өгөхгүй гэж байгаа учраас, хараал идсэн тэр Грейлд анхаарал хандуулахаас өөр арга Реми байсангүй.

6 сая евро ч их мөнгө шүү!

Түүнийг авчихвал, Реми үүрд алга болоход хангалттай их мөнгө юм. Хэрвээ ажил нь бүтэмжтэйболбол, тэрээр далайн эргийн Коте д'Азур луу явахаар төлөвлөж, тэнд бусдаар үйлчлүүлж, сэтгэлтайван байх тухайгаа бодож амжжээ. Гэвч энэ бүх төсөөллийг нь нурааж болох алхмыг хийхээр,Ландон түүний өмнө криптексийг хагалахад бэлэн зогсож байв.

Реми эцэст нь ухаалаг бус шийдвэр гаргахаас, өөр аргагүй болсноо ойлголоо. Тэр нуугдаж байсангазраасаа ил гарч, Тийбин рүү дөхөнгөө, толгойд нь буугаа чиглүүлэв.

"Хөгшин төгцөг минь, энэ мөчийг би мөн ч удаан хүлээсэн шүү!"

Өөр лүү нь буу шагайн зогсох Ремиг харангуугаа, Багшийн зүрх нь амаараа гарах дөхөв.

Тэр юу хийж байна аа, чөтгөр ав?

Машиныхаа урд суудлын жижиг хайрцагт хэрэг болж магадгүй гээд хадгалчихсан байсан буугааРемигийн гарт байгааг, Тийбин тэр дор нь анзаарав.

"Реми?" гэж Тийбин бувгнаад, "Чи юу хийж байна аа?"

Ландон, Софи хоёр ч мөн адил мэл гайхан зогсох аж. Реми Тийбинийг тойрч ард нь гараад,нурууны нь дээд хэсэгт буугаа чанга тулган барив.

Тийбиний хамаг бие нь хөшөөд, "Реми! Би ..."

"Би бүхнийг хялбар шийдээд өгье!" гээд Силас Тийбиний мөрөн дээгүүр Ландон руу ширтэнгээ,"Онъсон чулууг газар тавь! Үгүй бол би гохоо дарчихна шүү!"

Ландон хэсэг тээнэгэлзэж байснаа, "Чамд энэ Онъсон чулуу ямар ч хамаагүй. Чи ядаж үүнийгонгойлгож ч мэдэхгүй шүү дээ".

"Биеэ тоосон тэнэгүүд!" гэж Реми тэднийг доромжлоод, "Би та нарыг өнгөрсөн шөнийн туршажигласан. Шүлгийг сонссон, бас цааш нь дамжуулсан. Миний ард бүхнийг мэдэх хүн бий. Та нарбуруу газраа түүнийг хайж байгаа шүү дээ! Та нарын хайгаад байгаа бунхан шал өөр газар байгаа".

Тийбин сандран балмагдав. Тэр юугаа яриад байна аа!

"Чи Грейлээр яах гэж байгаа юм бэ? Ертөнцийн төгсгөлөөс өмнө түүнийг устгах нь уу?" гэж Ландон асуув.

Реми Силасыг дуудаж, "Ноён Ландоноос Онъсон чулууг ав!" гэж тушаав.

Силас тэр даруй дөхөж очих гэсэн ч, Ландон хойш ухраад, Онъсон чулууг улам дээш өргөнхагалахаар завдав.

"Би үүнийг бут үсэргэчихэж чадна шүү! Та нарын гарт оруулснаас ингэсэн нь дээр".

Тийбиний царай нь хувхай цайжээ. Түүний амьдралын гол зорилго болсон зүйл нүднийх нь өмнөөрд устан алга болоход, тун ойрхон байв.

"Роберт, битгий тэгээч!" гэж Тийбин хашхираад, "Битгий! Чиний гарт Грейлийн хувь заяа байна. Реми намайг буудаж чадахгүй. Бид хоёр 10 жилийн турш ..."

Гэтэл Реми буугаа өргөөд дээш хий буудав. Жижиг буунаас гармааргүй чанга дуу танхимаар нэгнүргэлэв. Бүгд хөшиж орхилоо.

"Би та нартай тоглоогүй байна шүү! Дараагийн сум нь өвгөний нуруунд шигдэнэ гэдгийг сануулчихъя. Одоохон наад Онъсон чулуугаа Силаст өгөөдөх!"

Ландон тэр дороо криптексийг доош буулгаж, Силаст өглөө. Силас Онъсон чулууг өмсгөлийнхөөхалаасанд хийгээд, Ландон, Софи хоёр луу буугаа чиглүүлсэн чигтээ ухрав. Харин Реми өвгөнийхүзүүг боож, арагш нь чирээд, буугаа нуруунаас нь салгалгүй явна.

"Түүнийг тавь!" гэж Ландоныг хэлэхэд,

"Бид түүнийг авч явна. Цагдаад мэдэгдвэл, өвгөн үхэх болно. Ойлгов уу?" гэж Реми сүрдүүлэв.

"Намайг оронд нь аваад яв!" гэж Ландон сэтгэлээ барьж дийлэлгүй хэлээд, "Харин түүнийг тавьчихл даа" гэв.

Реми инээж, "Бодсоны ч хэрэггүй. Өвгөн, бид хоёр бие биенээ эртнээс мэдэх хүмүүс".

Силас, Реми хоёр гадагш гарах зуураа, Софи Ландон хоёр луу буугаа чиглүүлсээр байх бөгөөд, өвгөний таяг шалан дээр тачигнан чирэгдэх нь сонсогдоно.

"Чи хэний талд ажиллаж байгаа юм бэ?" гэж Софиг асуухад, Реми худал дүр эсгэн инээмсэглэж, "Хатагтай Нөвү! Та төсөөлөхгүй л дээ" хэмээн бүсгүйг тавлан хариулав.

Хэсэг 87

Шатү Виллетийн шилтгээн байшинд Коле Интерполоос ирсэн факсыг уншаад зогсож байв. Түүний бодож байсан шиг зүйл болсонгүй. Учир нь Андре Вехнегийн намтарт ямар нэгэн сэжиглэхтолботой зүйл огт байсангүй. Тэрээр хэрэг төвөгт орооцолдож байгаагүй, бүр жижиг гэхээр зөрчилч гаргаж байгаагүй ажээ. Сорбон дахь дунд сургуулийг дүүргээд, дараа нь олон улсын санхүүгийн мэргэжлийг эзэмшжээ. Одоо тэрбээр Цюрихийн Хадгаламжийн банкны захирлын алба хашиж байгаа.

Өндөг шиг өөгүй, цэвэрхэн хүн юм биз дээ гэж хэлээд Коле санаа алдав.

Өнөө шөнө шинжээчдийн анхаарлыг хамгийн ихээр татсан зүйл бол Тийбиний гэрийн үйлчлэгчийнхурууны хээ байлаа. Ахлах шинжээч өрөөн дотуур холхингоо, дэслэгч Колед

тайлангаа чангааруншиж дуусгав.

Коле түүн рүү харж, "Өөр зүйл байна уу?"

Шинжээч мөрөө хавчаад, "Хурууны хээний эзэн нь Реми Легалудек. Тэр жижиг сажиг хэрэгтхолбогдож байсан ч, тэдгээр нь ноцтой хэргүүд биш байсан байна. Бас тэр хушган самрынхаршилтай юм байна" гэв .

Коле үүнийг сонсоод, нэгэнтээ хамт ажиллаж байсан цагдаа ийм харшилтайгаасаа болоод насбарсан тухай санав. Тэр цагдаа нэг ресторанд орж хоол идэхдээ, цэсэн дээрх орцыг нь харалгүй,хушга орсон хоолыг захиалж идээд, суудал дээрээ өөд болсон ажээ.

"Легалудек ч бас тэдэнтэй цуг эндээс явсан бололтой" гэж шинжээч өгүүлэв.

Коле санаа алдаад, "За ойлголоо. Энэ тайлангаа ахмад Фааш руу давхар явуулаарай!" гэв.

Ахлах шинжээчийг явахад, өөр нэгэн шинжээч гүйхээрээ ирээд "Дэслэгч ээ! Саравчнаас нэг зүйлолдлоо" гэв.

Коле шинжээчийн сэтгэл түгшсэн царайг хараад, "Цогцос уу?" гэж асуув.

"Үгүй ээ, эрхэм ээ. Өөр зүйл" гэж түгдэрснээ, "Юу гэдгийг нь сайн мэдэхгүй байна" гэв.

Коле нүдээ нухалсаар, шинжээчийг даган саравч руу гэлдэрлээ. Тэднийг нүсэр том гэмээр нөгөөсаравчинд орж ирэхэд, дээврийн хөндий рүү босгон түшүүлж тавьсан, урт модон шат харагдав."Энэ шат өмнө нь байгаагүй биз дээ" гэж Колег асуухад, "Тиймээ. Би өөрөө ийш нь авчирч тавьсан юм. Машинуудаас хурууны хээ хайж байтал, энэ шат шалан дээр байхыг олж харсан юм. Гэтэлшатны гишгүүрүүд нь шавар болсон байхыг хараад, шатыг байнга ашигладгийг анзаарсан юм.Шатны уртыг баримжаалаад харсан чинь, дээврийн хөндий рүү гарахад, яг тохирох юм шигсанагдаад, шатыг босгож, дээш шалгахаар гарсан юм".

Коле шатыг доороос нь дээш өгсүүлэн хараад, дээврийн хөндийг ажиглалаа. Тэнд юу л байв гэжхэн хүнд бодогдохоор боловч, доороос үнэндээ тэгж таамаглах аргагүй шүү дээ.

Дээврийн хөндийгөөс өөр нэгэн шинжээч тонгойж харснаа,

"Дэслэгчээ! Таны үзэх зүйл ч энд их байна даа" гээд, резинэн бээлийтэй гараараа түүнийг дээшурьж даллав.

Коле ядарч сульдсан гараараа шатны гишгүүрээс атгаж, дээш өгслөө. Модон шат эртний, хуучинхийцтэй байсан учир, түүнийг гишгэх тоолонд гишгүүрүүд нь хотолзон найгана. Тавцан дээргарахын өмнө, Коле доош харвал, түүний толгой нь эргээд унах дөхөв. Гэтэл нөгөө шинжээч гараасунгаж, түүнийг дээш татан гаргав.

"Тэнд байгаа" гэж шинжээч хэлээд, дээврийн хонгилын мухар луу заалаа. "Нэг хувь хэвлэмэл цаасэндээс олдсон. Бид удахгүй юу болохыг нь тодруулчихна".

Коле бүдэг гэрэлтэй харагдах ханын мухар луу дөхөж очоод, гайхан зогтусав.

Учир нь тэнд бүхэл бүтэн компьютерын лаборатори байгаа юм шиг хавтгай том дэлгэц, дууөсгөгчийн хамт, бас 2 процессор, дуу хураагуурын иж бүрдэл хэсгүүд цөм тусгай тэжээлийнүүсгэвэртэйгээ хамт байлаа.

Ямар хүн гэхээрээ заавал ийм газар ажилладаг байна аа? гэж Коле бодов.

Тэр тийш очингоо, "Та нар үүнийг ямар зорилготой байсныг нь тогтоосон уу?"

"Чагнах төхөөрөмж".

Коле эргэж хараад, "Тагнах зорилготой юм уу?"

Шинжээч толгой дохиж, "Маш өндөр хүчин чадалтай чагнах тоног төхөөрөмж" гээд, ширээн дээрэмх замбараагүй хөглөрөх холбогч утас, багаж, цахилгаан үүсгүүр зэргийг заав. "Үүнийг суурилуулсан хүн энэ талаар хангалттай мэддэг хун байсан шиг байна. Энд байгаа тоног төхөөрөмжүүд, манайхаас огт ялгаагүй, маш нарийн зориулалттай гэдэг нь харагдаж байна. Жижиг микрофон, өөрөө цэнэглэгддэг зай өндөр чадалтай RAM, чипүүд, бас хэд хэдэн нано эх хавтангууд байх жишээтэй".

Коле үүнд гайхширна.

Шинжээч тооны машин шиг зүйл гаргаж харуулаад, "Энэ бол өөрийгөө цэнэглэх чадвартай, өндөр чадалтай дуу хураагч" гэв.

Коле үүнийг мэдэх учир, "Долгионоо хаанаас, яаж хүлээж авдаг юм бол?" гэв.

Шинжээч компьютерын араас залгасан кабел утас дээврийн дээд хэсэг рүү явсаар дуусах, тэр зүгт зааж, "Энгийн радио долгионыг ашигладаг бололтой. Дээвэр дээр жижиг антен суурилуулсан байсан" гэв.

Коле иймэрхүү төхөөрөмж ямар горимоор ажилладгийг нь гадарлаж байв.

Төхөөрөмж өдрийн турш ямар нэгэн албан тасалгаан дахь дууг хатуу дискэнд бичиж хадгалсныхаадараа, шөнө дөлөөр бичлэгийг ийш дамжуулж, дамжуулалт дуусахад, хатуу дискэн дэх бичлэг автоматаар устаж, маргаашийн бичлэгтээ урьдчилан бэлтгэгдэнэ. Харин дамжуулагдсан бичлэгэндээ хадгалагдаж үлдэнэ. Хэдэн зуугаар тоологдох соронзон хальс бүхий ханын тавиур дээр Колегийн харц өөрийн эрхгүй тусав.

Үүнийг хийхэд, нэлээд цаг хугацаа шаардсан бололтой!

Хуурцгууд бүгд дугаар болон, огноогоор тэмдэглэгджээ.

Коле шинжээч рүү хараад, "Энэ бүх бичлэг ямар учиртайг таамаглаж байна уу?"

"Харин л дээ, дэглэгч ээ!" гээд, шинжээч компьютерын өмнө байсан нэг зүйл рүү зааж, "Үүнд лхамаг учир байгаа юм" гэв.

Хэсэг 88

Ландон сүмээс гарч явах замдаа, өөрийгөө буруутгасаар байх аж.

Би Лейг энэ бүхэнд оролцуулснаас болж, одоо түүнд аюул учраад байна шүүдээ!

Ремигийн хийсэн үйлдэл Ландоныг эхэндээ цочирдуулсан ч, сайн ухаж бодвол, Грейлийг хайсантар үл мэдэгдэх хун Ремиг нүд, чихээ болгож, тагнах зорилгоор Тийбиний гэрт эхнээс байлгаж байсныг ойлголоо.

Түүхийн туршид Грейлийг судалдаг хүмүүс ямагт судлаачид, түүхчид болоод хулгайчдын анхаарлыг үргэлж татсаар ирсэн юм. Ингэж бодохоор Ландонд буруу байхгүй юм шиг санагдана. Гэхдээ Лей Тийбинийг олж, түүнд даруй туслах хэрэгтэй. Тэр хоёр төв гудамж руу орж, Софи Ремигийн хэлсэн сүрдүүлгийг үл ойшоон, буудлын таксофоноос цагдаа руу залгахаар, харилцуурыг авав. Ландон түүний хажууд урт вандан сандал дээр цөхрөнгөө

барсан төрхтэй сууна.

Софи дугаар цуглуулангаа, "Бид Лейд тусалъя гэвэл, Лондоны цагдаа нарт мэдэгдэх хэрэгтэй. Үүнээс өөр замгүй гэдэгт итгэ" гэж Ландонд учирлав.

Ландон өмнө нь Софигийн энэхүү санааг зөвшөөрөхгүй байсан юм. "Тийбин энэ мөчид аюулгүйбайгаа. Реми болон түүний цаадах хүмүүс Хөлөг баатрын бунхныг оллоо гэхэд Лейгүйгээр юу чхийж чадахгүй".

Гэвч Грейлийн газрын зураг олдчихвол, Лей маш том барьцаа болж хоцорно шүүдээ!

Хэрвээ Ландон Лейг олж суллаад, Онъсон чулууг дахин харах аз тохивол, бунхныг шууд зорьжочих байсансан.

Гэвч түүнээс урьтаж, Реми хөдөлчихлөө.

Ремийг аюулгүй болгох үүргийг Софи хүлээж, харин бунхныг олох үүргийг Ландон хариуцахаарболж, төлөвлөгөө боловсруулжээ. Софи Лондоны цагдаа нарт Реми Силас хоёрыг оргодол хэмээнитгүүлж, тэднийг ямарваа нэг алхам хийхийг хязгаарлах ёстой, бүр бүтвэл тэднийг баривчлуулахёстой байлаа. Харин Лондоны хувьд арай төвөгтэй, Кинг коллежид очиж, хоосон криптексийгшинжлээд, гарах хариунд нь "Папын оршуулсан Хөлөг баатрын бунхан" гэсэн үгстэй холбоотойзүйлийг шүүж хайх явдал байлаа.

Галт тэрэг ирэхийг хүлээх зуур, Ландон тогтож сууж үл чадна. Харин Софи цагдаагийн утастай нэгюм холбогдов.

"Снөү Хиллийн цагдаагийн хэсэг байна. Танд юугаар туслах зэ?" гэж лавлах асуув.

"Би хүн барьцаалсан хэргээр ярьж байна" гэж Софи хариуд нь итгэлтэй өгүүлэв.

"Та нэрээ хэлнэ үү?"

Софи түр эргэлзэж байснаа, "Францын цагдаагийн газрын шинжээч Софи Нөвү".

Ингэж хэлэхэд лавлах маш түргэн хариулж, "Аа за. Та байсан юм уу? Одоохон таныг мөрдөнбайцаагчтай холбоод өгье" гэв.

Лавлахын ажилтан шугамаа шилжүүлэх завсар, Софигийн үгэнд цагдаа нар итгэх болов уу гэжбүсгүй эргэцүүлнэ,

Хослолтой эрэгтэйн тухай дүрслэн яривал, түүнээс содон хүн байхгүй биз. Хэрвээ Реми хувцсаасольчихвол, цайвар зүст альбинотой цуг яваа юм чинь олны дунд танигдахгүй байхын аргагүй. Түүнээс гадна, тэд Лейг барьцаалсан юм чинь, нийтийн тээврээр хэзээ ч явахгүй. Бас Лондонызамаар хэр олон Ягуар лимузин явдаг билээ дээ.

Софи мөрдөгчид хэлэх үгээ бэлдэн, түүнийг хүлээж үл чадна.

15 секунд өнгөрлөө. Эцэст нь харилцуурыг авч,

"Софи Нөвү мөн үү?" гэж нэг хүн асуув.

Софи зогтусан, түүний сөөнгө боргил хоолойг таних шиг болов.

"Шинжээч Нөвү!" гэж Бэзү Фааш дуугараад, "Чи хаана байгаа юм бэ, чөтгөр ав!" гэв.

Софигийн амнаас үг ч гарсангүй.

Ахмад Фааш Лондоны цагдаад мэдэгдэж, Софиг яривал, түүнтэй шууд холбоорой гэж лавлахаасхүссэн байжээ.

"Намайг сонс!" гэж Фааш Францаар хэлээд, "Өнгөрсөн шөнө би маш том алдаа гаргасан байна. Роберт Ландон ямар ч гэм буруугүй. Түүний эсрэг явуулж буй мөрдөх үйл ажиллагааг одоозогссон. Түүнээс гадна та хоёр маш аюултай нөхцөлд байгаа учраас, энд даруй ирэх хэрэгтэй байна".

Софи бүр мэл гайхав. Бүсгүй юу гэж хариулахаа мэдэхгүй байв. Учир нь тэрээр Бэзу Фаашийнуучлалт гуйж байхыг нэг ч удаа хараагүй юм.

Фааш цааш нь үргэлжлүүлж, "Чи өөрөө Жак Сониехийг өвөөгөө гэж надад хэлээгүй шүү дээ! Чиний сэтгэл маш хүнд дарамтад байгааг би ойлгож байна. Гэвч одоо та хоёр Лондоны цагдаагийн аль нэг хэсэг дээр очиж, хамгаалалтад орох хэрэгтэй байна".

Фааш намайг Лондонд байгааг мэдэж байна. Фааш өөр бас юу мэдэж байгаа бол?

Харилцуурын цаана нэг төхөөрөмж ажиллаж байгаа юм шиг жигд хэмээр шар шархийн дуулдана.

"Ахмад аа, та утасны яриаг бас чагнаж байгаа хэрэг үү?" Фаашийн дуу нь чангарч, "Нөвү сонс! Бидхамтрах ёстой. Эс бол бидний аль аль тал нь хохирно. Би дахиад сануулья! Хэрвээ Америксудлаач, Франц шинжээч хоёрыг үхсэн талаарх мэдээ зурагтаар цацагдвал, миний ажил, амьдралцугтаа сүйрнэ гэсэн үг. Та хоёрыг хэсэг хугацаанд ч болов аюулгүй газарт байгаасай гэж би хүсч байна".

Бүлээн салхи үлээх шиг болж, галт тэрэг ирж буй чимээ сонсогдов. Софи үүнийг л хүлээж байсан юм шиг Ландон руу харахад, профессор аль хэдийнээ явахад бэлэн, түүнийг хүлээн зогсож байв.

"Та нарын олох ёстой хүн бол Реми Легалудек. Тэр бол Тийбиний гэрийн үйлчлэгч байгаа юм. Тэр Тийбинийг Дуган сүмд барьцаалаад, тэгээд ..." гэхэд Фааш түүний үгийг тасалж,

"Нөвү! Аан гэж бай" гэж хэлэх тэр агшинд галт тэрэгний дохио хангинаж, ахмадын хэлэх үг тэрчимээнд дарагдлаа. "Энэ тухай утсаар ярьж болохгүй байна. Та хоёр одоохон энд ир! Энд тахоёрын амь настай холбоотой асуудал яригдаж байна. Би тушааж байна!" гэв.

Софи тэр хооронд утсаа тавьчихаад, Ландонтай цуг галт тэрэг рүү гүйж байв.

Хэсэг 89

Хоокер онгоцны цэмцгэр шалан дээр төмрийн зордос энд тэндгүй үзэгдэнэ. Бэзу Фааш ганцаараа үлдээд, төмөр сейфэнд байсан модон хайрцгийг ажиглан харж байв. Хайрцаг дээрх сарнайншигтгэмэл дүрсийг тэр хуруугаараа илээд, тагийг нь сөхөж, дотор нь байх чулуун цилиндрийг олжхарав.

Цилиндрийн үсгүүд нийлж, СОФИА гэсэн үгийг бүрдүүлсэн байх агаад, ахмад үгийг удаан гэгчширтэж байснаа, хайрцагас цилиндрийг гаргаж ирээд, эргүүлж тойруулан шинжиж үзэв. Дараа нь цилиндрийн нэг үзүүрээс татаж онгойлговол, дотор нь юу ч байсангүй. Фааш

цилиндрийг хайрцагтнь буцааж хийгээд, онгоцны цонхоор гадагш харангаа, Софитой утсаар ярилцсан тухайгаа бодлоо.Түүнээс гадна ахмад Шатү Виллетээс авсан мэдээний тухай эргэцүүлж бодно. Утас чичирчдуугарах чимээнээр Фааш цочиж, бодлоосоо тэр даруй саллаа.

Төвөөс ярьж байгааг лавлах мэдсэн байртай өгүүлнэ.

Цюрихийн банкны захирал ахмадтай холбогдохыг хүсч, маш олон удаа залгасан тухай түүндхэллээ. Фааш банкны захирал руу шууд холбож өгөхийг лавлахаас хүсэв.

"Мүсюү Вехне!" гэж хэлээд, Фааш хариу хүлээлгүй залгуулан, "Би тан руу ярьж чадсангүйдчихлаа. Уучлаарай! Завгүй байлаа л даа. Таны хүссэнээр, хэвлэлийнхэнд танай банкны талаарогт цухуйлгаагүй юмсан. Өөр ямар нэг хэрэг гараа юу?"

Вехне модон хайрцгийг Ландон, Софи хоёр банкнаас гаргаж аваад, түүнээс зугтахад нь туслахыггүйсан тухай Фаашид ярив.

"Харин дараа нь радиогоор тэднийг гэмт хэрэгтнүүд гэдгийг сонсоод, туслахаас татгалзаж,хайрцгийг эргүүлж авах гэсэн боловч, тэд надад хүч хэрэглэж, хуягласан машинаар оргосон".

"Та тэгвэл модон хайрцгийн төлөө санаа зовоод байгаа юмуу?" гэж Фааш асуугаад, хайрцгийгонгойлгож, доторх цагаан цилиндрийг хараад, "Та дотор нь юу байгааг мэдэж байсан уу?" гэжасуув.

"Доторх нь надад чухал биш" гэж Вехне шууд хариулаад, "Энэ бол Банкны нэр хүндийн асуудал.Бид хэзээ ч дээрэмдүүлж байгаагүй юм.

Хэрэв энэ тухай үйлчлүүлэгчид маань мэдвэл, манай банк сүйрнэ гэсэн үг" гэв.

"Тэр хоёрыг түлхүүр, нууц үгтэйгээ ирсэн гэж та өөрөө хэлсэн шүү дээ. Тийм болохоор хулгайлсангэж хэлж болох уу?"

"Тэд хүн алсан. Жак Сониехийг хүртэл. Тийм болохоор түлхүүр, нууц үгийг шударга бус аргааролж авсан гэсэн үг".

"Ноён Вехне, би таныг мэднэ. Таныг өндөр ухамсартай, үнэнч шударга хүн гэдэгт би эргэлзэхгүйбайна. Та ч намайг бас тэгж бодож байгаа байх. Францын цагдаагийн газрын ахмадын хувьдхэлэхэд, танай банкны өмч болох тэр хайрцаг бидний гарт, аюулгүй газарт байгаа гэдгийг тандалбан ёсоор мэдэгдэж байна".

Хэсэг 90

Шатү Виллетийн саравчны дээврийн хонгилд Коле компьютерын дэлгэц рүү нүд салгалгүй ширтэжзогсоно.

"Чагнах төхөөрөмжийг олон газарт тавьсан байна шүү!"

"Харин тийм. Энэ байдлаараа мэдээллийг маш олон жил цуглуулсан байж таарна".

Коле дэлгэцэн дэх нэрсийн жагсаалтыг уншив.

1. Колберт Состаки - Үндсэн Хуулийн цэцийн тэргүүн
2. Жон Шафи - Жо дэ Пом музейн эрхлэгч
3. Эдуард Дерошех - Миттеранд номын сангийн архивын дарга
- 4 . Жак Сониех - Луврын музейн эрхлэгч

5. Мишель Бретон - Францын ДАС холбооны тэргүүн.

"Дээрээсээ 4 дэх нэр нь сонирхол татаж байгаа биз" гэж шинжээч дэлгэц рүү заан, хэлэв. Колетолгой дохиод, Жак Сониехийг тагнаж байсныг ойлгов. Тэр бусад нэрийг уншингаа, ийм нөлөөтэй хүмүүсийг яаж тагнаж байсан юм бол гэж гайхна.

"Чи ямар нэг бичлэгийг авч сонсож үзэв үү?"

"Хэд хэдийг үзсэн. Энд хамгийн сүүлд бичигдсэн шинэ бичлэгүүдээс нэгийг сонсье!" гээд, шинжээч хэдэн товчлуурыг тогшиход, дуу өсгөн ажиллаж эхлэв.

"Ахмад аа! Шинжээчийн хэсгээс хүн ирсэн байна".

Коле өөрийнхөө дууг сонсоод чихэндээ итгэсэнгүй. "Энэ чинь би байна шүү дээ!"

Тэрээр Жак Сониехийн өрөөнөөс ахмадруу залгаж, Софи Нөвү ирснийг мэдэгдэж байснаа эргэнсаналаа.

Шинжээч толгой дохиж, "Өнгөрсөн шөнө Луврын музейд ярьсан бүх зүйлийг хэн нэг нь мэдэж болохоор байжээ" гэв.

"Чи чагнах төхөөрөмжийг Лувраас хайх арга хэмжээ авсан уу?"

"Ингэх шаардлагагүй л дээ. Төхөөрөмж хаана байгааг би яг таг мэдэж байна" гээд шинжээч ширээндээр байсан хуучин ноорог цаасыг авч, Колед харуулав.

"Үүнийг таньж байна уу?"

Коле түүнийг хараад зогтусав. Цаасан дээр Итали хэлээр тайлбарлаж бичсэн боловч, хуягдуулгатай хөлөг баатрын өмсгөлийн зураг өмнө нь зурайж байв.

Энэ чинь Жак Сониехийн ширээний өмнө байсан шүүдээ!

Коле зураг дээрх улаан цэгийг хараад, тэр дороо учрыг нь ойлгов. Өмсгөлийн дотор талд, альхэсэгт төхөөрөмжийг байрлуулбал, илүү тохиромжтой вэ гэдгийг зурагт заасан байв.

Хэсэг 91

Силас Дуган сүмийн гадна зогсох Ягуар лимузиний урд суудалд суув. Реми Тийбинийг хүлэн, машины хойд хэсэгт түүнтэй ноцолдох зуур, альбино гартаа Онъсон чулууг атгасан чигтээ, шинэхамтрагчаа хүлээж ядна.

Реми Тийбинийг хүлж дуусчхаад, жолооны ард сая л суухад,

"Сайн хүлсэн үү?" гэж Силас догдлон асуув.

Реми нүдээ ирмээд, мөрөн дээгүүрээ давуулан хойш харж, "Тэр хаашаа ч зугтахгүй" гэв. Тийбинийамыг хуучин туузаар таглаж наасан бололтой, түүний орилох нь, тэр хоёрт бүдэгхэн дуулдана.

"Ферм тагеме!" (Дуугүй болооч!) гэж Реми хүлээстэй хэвтэх Тийбин рүү зандраад, нэг товчлуурыг дартал, машины тусгаарлагч хана хаагдаж, Тийбиний дуу урд бүхээгт сонсогдохоо болив.

Реми Силас руу харж, "Хөгшин төгцгийн чихэнд чийртэй дууг хангалттай удаан

сонссон" гэв.

Ягуар хөдөлж, гудамжаар хурдлан явах тэр үед, Силасын гар утас дуугарав.

Багш ярьж байлаа. Силас илтэд баярласан дуугаар, "Байна уу?" гэж хариулав.

"Силас уу?" гэж Багш танил болсон Франц аялгаараа хэлээд, "Би чамайг утсаа авсанд баяртай байна. Тэгэхээр чи зүгээр байх нь ээ?"

Силаст ч мөн адил Багшийн дууг сонсоход таатай байв.

Хэдэн цагийн өмнө бүх зүйл хэцүү болчихоод байсан ч, одоо бол буцаад голдиролдоо орчихоод явжбайгаа шүүдээ.

"Миний гарт Оньсон чулуу бий".

"Маш сайхан мэдээ байна. Реми чамтай цуг байна уу?" гэж Багш асуув.

Багш Ремигийн нэрийг хэлсэнд Силас гайхаж, "Тийм ээ. Реми надад тусалсан юм" гэв.

"Би тусал гэж түүнд тушаасан юм. Чамайг маш удаан зовоосондоо, их харамсаж байна" гэлээ.

"Бие мах бодийн зовлон бол юу ч биш. Гол нь бид Оньсон чулууг гартаа оруулчихлаа шүү дээ!"

"Тиймээ! Чиний зөв. Харин одоо Оньсон чулууг надад авчрах хэрэгтэй байна. Бидэнд цаг багаүлдэж байна".

Силас Багштай нүүр тулж уулзана гэхээс маш ихээр догдолж байв.

"За, эрхэм ээ! Би танд өөрийн биеэр аваачиж өгнө"

"Реми надад авчирч өгсөн нь дээр байх".

Реми гэнээ? Силасын урам хугарав.

Багшийн төлөө хийсэн бүхнийхээ хариуд, Оньсон чулууг өөрийн биеэр аваачиж өгөхийг, Силастуйлаас хүсч байсан юмсан. *Гэтэл багш Ремиг сонголоо гэж үү?*

"Би чиний сэтгэлийг ойлгож байна. Харин чи намайг сайн ойлгоогүй бололтой" гээд Багш дуугаанамсгаж, "Би чамаас Оньсон чулууг авахыг хүсэлгүй яахав. Чи бол Бурхны хүү, харин тэр бол гэмтхэрэгтэн. Миний зааврыг тэр нэгэнт зөрчсөн болохоор, түүнийг залхаах хэрэгтэй байна. Түүнийхийсэн үйлдэл биднийг аюулд хүргэж магадгүй болчихоод байна".

Силасын уур хилэн дүрэлзэж, Реми рүү харав. Нээрээ л Тийбинийг барьцаалж авч явах тухайтэдний төлөвлөгөөнд ороогүй байсан бөгөөд, цааш яах ёстойг Реми өөрөө ч сайн мэдэхгүй байсан юм.

"Чи, бид хоёр бол Бурхны үр сад. Бид зорилго чигээсээ хазайж болохгүй" гээд түр тээнэгэлзсэнээ, "Ийм л учраас би Ремигээр Оньсон чулууг авчруулах гээд байгаа юм.

Чи ойлгов уу?" гэв.

"Ойлголоо!" гэж Силас хариулав.

"Сайн байна. Одоо чи машинаас бууж, гудамж руу ороод, алхах хэрэгтэй. цагдаа нар удахгүйлимузиныг хайж эхэлнэ. Би чамайг баригдахыг хүсэхгүй байна. Опус Дейн салбар сүм Лондондбайдгийг чи мэднэ шүү дээ".

"Тэгэлгүй яахав. Би мэднэ".

"Тэнд чамайг очиход, дуртайяа хүлээн авна".

"Яг л ах дүү шигээ".

"Чи тийш очоод, хэд хоногтоо гадагш гаралгүй бүгэх хэрэгтэй! Би Онъсон чулууг авч, асуудлыгшийдсэнийхээ дараа, чам руу өөрөө залгая".

"Та Лондонд байгаа юм уу?"

"Миний хэлснийг л хий! Бүх зүйл сайхан болно".

"Ойлголоо, эрхэм ээ!"

Багш гүнээр шүүрс алдаад, "Одоо утсаа Ремид өг!" гэв.

Силас утсаа Ремид өгөхдөө, үйлчлэгч эрийн амьдралын сүүлийн мөчүүд тоологдож байгаагзөнгөөрөө мэдрэв. Харин Реми түүнээс утсыг авангаа, толгой нь эргэсэн хөөрхий альбиног өрөвдөнбодов.

Силас, чамайг багш залилсан. Чиний тэр Хамба ламтан чинь ч Багишийн үгээр шатрын хүү шигхөдөлж байгаа!" гэж үйлчлэгч эр дотроо бодлоо.

"Намайг анхааралтай сонс! Силасыг Опус Дейн сүмийн ойролцоо буулга! Дараа нь Биг Бенийойролцоо байдаг Гэгээн Жеймсийн цэцэрлэгт хүрээлэнд оч. Машинаа Гаард Парэйдийн өмнөхталбайд тавиарай. Тэнд уулзъя".

Ингэж хэлээд Багш утсаа тасалчхав.

Хэсэг 92

1829 онд 4 - р Жорж хааны санаачилснаар, Кингийн коллеж анх үүсэн байгуулагдаж түүх, шашнычиглэлээр судалгаа шинжилгээ хийх болсон юм. 150 жилийн турш явуулсан эрдэм шинжилгээ, судалгааны туршлагаас гадна, 1982 онд түүхийн системчилсэн судалгааны хүрээлэн байгуулсанявдал нь дэлхий дээрх хамгийн орчин үеийн электрон номын сан үүсэх эхлэлийг тавьсан юм.

Софи, Ландон хоёр хүйтэн бороонд норсон чигтээ, номын сан руу ороход, Ландон даарсандаачирсээр л байв. Эндхийн үүдний танхим 6 талт хэлбэртэй бөгөөд, голдоо дугуй, том ширээтавьсан нь, Артур хааны хөлөг баатруудын түүхийг нэг талаар санагдуулах боловч, дээр нь тавьсанхавтгай дэлгэц бүхий хайлтын 12 компьютер орчин үеийн хэлбэр төрхийг даруй илтгэнэ.

Танхимын нөгөө талд, номын сангийн лавлах ажилтан савгай цай аягандаа хийгээ д, өнөөдрийнажлаа эхлэх гэж байгаа бололтой зогсч байв.

"Сайхан өглөө байна шүү!" гэж лавлахын ажилтан эмэгтэй Британи аялгаар уянгалуулан хэлээд, "Та бүхэнд юугаар туслахсан бол?" "Өглөөний мэнд!" гэж Ландон хариулаад, "Миний нэрийг ..."гэхэд,

"Роберт Ландон" гэж нөгөө эмэгтэй эелдгээр инээмсэглэн өмнөөс нь хариулаад, "Би таныг мэднэ"гэв.

Тэр агшинд Ландон Английн телевизээр өөрийг нь эрэн сурвалжилж байгааг мэдсэн юм бишбайгаа гэж хар буусан боловч, номын санчийн инээмсэглэл түүний бодлыг няцаав. Лан

дон өдийгхүртэл өөрийг нь таних хун гарч ирнэ гэж боддоггүй байсан юм. Тэр тусмаа таньж байгаа хүн ньэнэ номын санд байгаа нь түүнийг бүр ч гайхшрууллаа.

"Намайг Памела Гэттум гэдэг" гэж номын санч эмэгтэй хэлээд, түүн рүү гараа сунгав.

Тэр эмэгтэй нэлээд мэдлэгтэй гэмээр төрхтэй харагдах бөгөөд, шингэн цовоо дуутай ажээ. Түүнийзузаан хүрээтэй нүдний шил нь бараг тал нүүрийг нь эзэлж байв.

"Таатай байна! Харин энэ бол миний найз Софи Нөвү" гэж Ландонг танилцуулахад, хоёр эмэгтэйбие биетэйгээ мэндлэв.

Гэттум Ландон руу харж, "Би таныг ирнэ гэж ерөөсөө бодсонгүй шүү"

"Би ч бас. Хэрвээ танд төвөг удахгүй бол, бидэнд зарим нэг мэдээлэл олж өгч туслахгүй юу?"

Гэттум тээнэгэлзсэн байдалтай харж байснаа, "Уг нь манайх тусгай захиалга, эсвэл гишүүнчлэлийнзарчмаар үйлчилгээ үзүүлдэг юм л даа. Гэхдээ та манай коллежийн хэн нэгний урилгаар энд ирсэнбол, үйлчилж бололгүй яахав" гэлээ.

Ландон толгойгоо сэгсрэн, "Харамсалтай нь биднийг хэн ч уриагүй. Гэхдээ манай нэг найз эндхийнталаар надад байнга ярьдаг юм. Та Английн их түүхч Лей Тийбиний талаар сонссон уу?" гэхэд,Гэттумын царай гэрэлтэн инээмсэглээд,

"Ээ, бурхан минь! Сонсолгүй яахав. Тэр энд байнга ирдэг юм. Ирэх болгондоо нэг л зүйл хайдаг.Тэр нь Грейл, Грейл, бас дахин Грейл. Тэр ч үхэн үхтлээ энэ сэдвээсээ салж хагацахгүй байх гэдэгтби итгэдэг Шүү".

"Та бидэнд тусалж чадах уу? Энэ маш чухал хэрэг байгаа юм" гэж Софи хэлэв.

Гэттум огт хүнгүй харагдах уншлагын танхим руу эргүүлж тойруулан харснаа, тэр хоёр луу нүдээирмэж, "Та хоёрт завгүй байна гэж хэлэхээр харагдахгүй байгаа биз дээ. Хэрэв та хоёрын аль нэг ньэнд гарын үсгээ зурчихвал, би та нарыг гомдоож, гар хоосон буцаамааргүй байна. Та нар юу хайжяваа юм бэ?"

"Лондонд байдаг нэг бунхныг хайж байгаа юм" гэхэд, Гэттум тэдэн рүү харж, "Лондонд бараг 20мянган бунхан байдаг шүү дээ! Нарийн тодруулж болохгүй юу?"

"Энэ бол нэгэн Хөлөг баатрын бунхан байгаа юм. Гэхдээ нэрийг нь хараахан мэдэхгүй байна".

"Хөлөг баатар юм биз дээ? Энэ нь хайхад арай л амар болж байна. Гэхдээ л олоход хэцүү дээ".

"Бидэнд Хөлөг баатрын нэр нь мэдэгдэхгүй байгаа юм. Гэхдээ бидэнд энэ байгаа" гэж Софи хэлээд,цаасны тасархай дээр бичсэн шүлгийнхээ эхний 2 мөрийг түүнд үзүүллээ.

Ландон, Софи хоёр шүлгийг бүтэн байдлаар өөр хэн нэгэнд алдахгүй гэсэндээ, 4 мөр шүлгийгталаар нь хувааж, тус тусдаа авч билээ. Ингэж сэрэмжлэх нь тэдний хувьд илүүц ажил байв.

Номын санч 4 мөрт шүлгийг бүтнээр нь уншаад, Хөлөг баатрын бунхныг олж мэдлээ ч гэсэнкриптекс байхгүй бол, юу ч хийж чадахгүй! шүү дээ!

Гэттум яаран адгасан харцтай Америк судлаач эр болон, түүнтэй хамт яваа эмэгтэйн сэтгэлтүгшсэн дүр төрхийг сайтар ажиглана. Гэттум эцэст нь ойрын харааны шилээ зүүж,

шүлэгтэйцаасыг авч уншив.

Папын оршуулсан Хөлөг баатрын бунхан Лондонд буй.

Тэр баатрын ажлын үр шим Ариун бүхнийг хилэгнүүлжээ

Номын санч зочид руу хараад,

"Энэ чинь одоо юу вэ?" Харвардын сургуулийн судалгааны арга барилын нэг хэсэг үү?" гэхэд, Ландон дуртай дургүй инээж,

"Бараг л тийм юм уу даа".

Гэттум энэ шүлгийн утга бүрэн гүйцэд гарч ирээгүйд гайхаж, "Энд өгүүлснээр бол нэгэн Хөлөгбаатар бурханд таалагдаагүй зүйл хийсэн бололтой. Харин Пап түүнийг Лондонд оршуулсан бололтой"

Ландон толгой дохиж, "Таны толгойд ямар нэг юм бууж байна уу" гэж асуув.

Гэттум хайлтын систем рүү дөхөж очингоо, "Сайн мэдэхгүй л байна. Гэхдээ мэдээллийн сангаасхайгаад үзье л дээ" гэв.

Сүүлийн 20 жилийн турш, Кингийн коллежийн судалгааны институт шашны нэвтэрхий толь бичиг, түүх зэрэг энэ чиглэлийн маш олон ном товхимол, судалгаа шинжилгээний ажлыг электронжуулж, хайлтын мэдээллийн сандаа багтааж чадсан юм. Эдгээр мэдээллийн санг хуудсаар биш байт (byte) -аар хэмждэг аж.

Гэттум шүлгийг харангаа, компьютер дээр бичиж эхлэв.

"Эхлээд бид хайлтыг илүү нарийвчлалтай болгохын тулд, эндээс хэд хэдэн үгийг сонгож оруулах хэрэгтэй" гэж хэлээд, "Лондон, Хөлөг баатар, Пап" гэсэн 3 үгийг хайлтын талбарт оруулав.

Түүнийг "Хайх" гэсэн товчлуурыг дарахад, компьютер секундэд 500 мегабайт хэмжээтэй мэдээллийг хайх хурдаар ажиллаж эхэллээ.

"Би эдгээр 3 үгийг зэрэг агуулсан текстийг хайх тохируулга хийчихлээ. Энэ дагуу олон хайлтын үрдүн гарч ирнэ. Гэхдээ л бид ингэж эхлэх нь зүйтэй байх".

Хайлтын үр дүн дэлгэцэн дээр эхнээсээ харагдлаа.

[ПАПЫГ ЗУРАГЛАХУЙ. ЖОШУА РЕЙНОЛДСЫН ХӨРӨГ

ЗУРГИЙН ЦУГЛУУЛГА. ЛОНДОНЫ ИХ СУРГУУЛИЙН ХЭВЛЭЛ].

Гэттум толгойгоо сэгсрэн, "Энэ та нарын хайж байгаа зүйл биш бололтой" гээд дараагийн үр дүнг харав.

[АЛЕКСАНДР ПАПЫН (заримдаа Поп ч гэдэг)

ЛОНДОНЫ ТУХАЙ ӨГҮҮЛЛҮҮД. УИЛСОН НАЙТ]

Номын санч үүнийг хараад бас л толгойгоо сэгсрэв. Систем цааш ажилласаар, үр дүнгүүд олширсоор л байв. Александр Папын тухай бичсэн шашны эсрэг өгүүллүүдийн талаарх нэлээд олон үр дүн гарч ирлээ.

Гэтэл дэлгэц дээр гарч ирсэн хайлтын үр дүн 2692 гэсэн тоо зааж байхыг, Гэттум олж хараад түразнав.

"Бид нар хайлтыг улам нарийвчлах хэрэгтэй байна. Та хоёрт бунхны талаар өөр ямар нэг

м эдэхзүйл байна уу?"

Ландон Софийг ажиглавал бүсгүй эргэлзсэн байдалтай харагдана. Гэттум бүсгүйг ажигласандаруйдаа, энэ бүхэн Харвардын судалгаатай ямар ч холбоогүй гэдгийг ойлголоо.

Өнгөрсөн жил Роберт Ландоны Ромд тарьсан шуугианыг Гэттум олж сонссон билээ. Тиймээс ч энэ Америк өөрийн хүссэн зүйлээ хаанаас олж мэдэж чадахыг Гэттум мэдэж байв. Олон жилийн туршномын санчаар ажилласан хүний хувьд, Лондонд хөлөг баатрыг сураглаж ирсэн, ихэнх хүмүүсэцэстээ ганц зүйлийг эрж хайдаг гэдгийг Гэттум сайн мэднэ.

Энэ бол Грейл.

Гэттум инээмсэглэж, том хүрээтэй нүдний шилээ засаад, "Та нар Лей Тийбиний найзууд гэсэн. Бас Английг зорьж ирсэн. Түүнээс гадна Хөлөг баатрыг хайж байна" гэж хэлээд, тэрээр алгаа үрж, "Тийм болохоор, та хоёр Грейлийн хэргээр явж байгаа юм байна. Тийм үү?"

Ландон, Софи хоёр бие бие рүүгээ гайхан харав. Гэттум хариуд нь инээж,

"Найзууд минь! Энэ газар бол Грейл хайгчдын гол төв нь болсон газар байгаа юм. Лей Тийбин ч гэсэн тэдний л нэг нь. Би тэдэнд Сарнай, Мэри Магдалин, Сангрийль, Меровингийн овог, Сионий Прайори гэх мэт үгийг хайж өгөх болгондоо, нэг шиллинг авдагсан бол, өдийд аль хэдийн тэрбумтан болох байсан юм" гээд шилээ авч, тэдэн рүү ширтээд надад нэмэлт тодорхой мэдээлэл хэрэгтэй байна" гэж тулгав.

Зочид чив чимээгүй зогсох боловч, хайсан зүйлээ олох хүсэл нь Маш их байгааг, Гэттум бэлхнээ харж байв.

"Энэ л бидний мэдэх зүйл" гэж Софи эцэст нь тэсгэл алдан хэлээд, Ландоноос үзгийг нь авч, үлдсэн 2 мөр шүлгийг цаасан дээр бичээд, Гэттумд өглөө.

Та нар түүний бунхан дахь бөмбөрцгийг эрж хайна

Энэ бол бүхний эхлэл болсон урт улаан жимсний тухай ...

Гэттум түүнийг уншаад инээмсэглэж, "Би та нарт тусалж чадах юм байна. Гэхдээ та хоёроос энэ шүлгийг хаанаас олсныг чинь асууж болох уу?"

Хариуд нь Ландон нөхөрсгөөр инээмсэглэж, "Мэдээж болно. Гэв. Үүнийг яривал их урт түүх болно. Тэгээд ч бидэнд цаг бага байгаа юмсан".

"Бусдын хэрэгт хошуу бүү дүр гэж эелдгээр хэлж байгаа юм биз дээ?" "Памела, бид танд өртэй боллоо. Та бидэнд Хөлөг баатрыг хэн болох, бунхан хаана байгааг олж өгч туслах юм бол, бид танд хязгааргүй талархах болно".

"Ойлголоо" гэж Гэттум хэлээд, хайлтын түлхүүр үгийг дахин бичих зуураа, "Хэрэв энэ бүхэн Грейлтэй холбоотой юм бол, би Грейл гэсэн түлхүүр үгийг нэмж оруулаад, хайлт хийвэл арай дээр байх" гэж хэлээд, "Хөлөг баатар, Лондон, Пап, бунхан, Грейл, Сарнай, Сангрийль, аяга" гэсэн үгсийг дахин нэмж бичлээ.

"Хэр удах бол?" гэж Софиг асуухад, Гэттум хайлтын товчлуурыг дөнгөж дарангуутаа,

"15 минут орчим болох байх" гэж хариулав.

Ландон, Софи хоёр юу ч хэлээгүй боловч, тэдэнд 15 мянган жил шиг сонсогдож байгааг, Гэттум гадарлаж байв.

"Цай уух уу?" гэж Гэттум асуугаад, савтай цай руугаа очих зуураа, "Лей миний чанасан

цайг уухдуртай байдаг юм" гэв.

Хэсэг 93

Кенсингтоны цэцэрлэгт хүрээлэнгээс чанх хойд зүгт энгийн загвартай тоосгон барилга үзэгдэх нь Лондон дахь Опус Дейн салбар сүм юм. Силас энд өмнө нь ирж байгаагүй боловч, сүмийн барилгатүүнд нэг л танил дотно санагдаж байв. Реми түүнийг машинаас буулгаад, ширүүн асгарах бороондунд үлдээсэн ч, Силас үүнийг огтхон ч тоосонгүй.

Тэрээр сүмийн барилга руу алхаж очихоор болов. Ремигийн зөвлөснөөр, Силас гар буугаа хашааны завсраар хаячхав. Түүний бие хөнгөрсөн боловч, хамаг бие нь хөндүүрлэн өвдсөөр байв. Силасын ингэж өвдөх нь, машины хойд суудал дээр хүлээстэй хэвтэж байсан Тийбинийг өрөвдөхөд хүргэнэ.

Реми түүнийг машинаас буулгахын өмнө, "Чи одоо түүнийг яах бодолтой байна" гэж Силасыг асуухад, Реми мөрөө хавчаад,

"Багш л мэдэх хэрэг" гэж хариулсан боловч, түүний дууны өнгөнд эргэлзсэн байдал илэрч байсан юм.

Силасыг байшинд дөхөж очих зуур, бороо улам ширүүсэв. Гэвч тэр энэ бүгдийг анзаарч тоосонгүй.

Миний хийх ёстой ажил одоо дууссан.

Хаалгаар орж, үүдний ширдэг дээр гишгэх тэр агшинд, хонх жингэнэж, дээд давхраас хэн нэг нь бууж ирэв.

"Та ямар хэргээр явна вэ?" гэж дөнгөж бууж ирсэн сүмийн шавь Силасын гаднах төрхийг ч үлэнгээр эелдгээр асуухад,

"Сайн байна уу! Намайг Силас гэдэг. Би Опус Дейн шавь".

"Та Америк хүн үү?" гэхэд, Силас толгой дохиж,

"Би энд нэг их удахгүй. Түр хугацаанд энд байж болно биз дээ?"

"Та асуух шаардлагагүй. Дээр 3 - р давхарт сул өрөө байгаа. Танд цай, талх хүргэж өгөх үү?"

Өлссөн Силас дор нь хариу барьж, "Тэгье! Баярлалаа!"

Силас дээш гарч, өрөөнд ороод, нэвт норсон өмсгөлөө тайлж, доош өвдөглөн суугаад, залбирал үйлдэхээр зэхэв. Доод давхраас түүнд унд авчирч, хаалганы гадна орхихыг, Силас сонсоод, залбирлаа дуусгаж авчруулсан ундаа уугаад амрахаар хэвтлээ.

Харин энэ зуур доод давхарт Силасыг угтаж авсан хүн утас дуугарах чимээнээр, харилцуурыг очиж авлаа.

"Лондонгийн цагдаагийн газраас ярьж байна. Бид нэгэн альбино хуврагийг хайж байна. Танайхандотроос түүнийг харсан хүн байна уу?" гэхэд, нөгөө шавь,

"Тийм ээ. Тэр энд байгаа. Ямар нэг юм болоо юу?" гэж гайхан асуув.

"Тэр одоо наана чинь байна уу?"

"Дээд давхарт залбирал үйлдэж байгаа. Юу болсон юм бэ?"

"Удахгүй эндээс танайх руу хүн очно. Түүнд өөрт нь юу ч хэлж болохгүй шүү!"

Хэсэг 94

Гэгээн Жеймсийн цэцэрлэгт хүрээлэн бол Уэстминстерийн болоод Бакингемын ордонтой хилзалгадаг, Лондоны төвд орших, үргэлж ногооноороо байдаг цэцэрлэг билээ. Цэцэрлэгт хүрээлэнг 8 -р Генри хааны санаачилгаар буга үржүүлж, агнах зорилгоор анх байгуулж байсан бол, одоо олоннийгэд үйлчилдэг газар болжээ. Нартай өдрүүдэд Лондончууд энд зугаалангаа, цөөрмийн усандхөвөх хотон шувууг хооллож зугаацуулдаг билээ. Харин өнөөдөр нэг ч хотон шувуу үзэгдсэнгүй.

Багшийг урд хаалга руу очиход, Реми түүнд хаалгаа онгойлгов Багш машинд орохоосоо өмнө, дашмагтай коньяк онгойлгож, дотогш орсон хойноо түүнээс балгав. Реми Онъсон чулууг аваргынцом шиг гар дээрээ өргөөд, "Бараг л алдах шахсан шүү!" гэж хэлэв.

"Чи сайн ажилласан шүү!" гэж Багшийг хэлэхэд,

"Бид сайн ажилласан" гэж Реми хариу хэлээд, Багшийн гар дээр Онъсон чулууг тавив

Багш Онъсон чулууг удаан гэгч бахархан хараад, эцэст нь инээмсэглэж, "Бугаа яасан бэ? Чиаюулгүй болгосон уу?" гэхэд,

"Суудлын хажуугийн хайрцагт буцаагаад хийчихсэн".

"Маш сайн байна!" гэж Багш хэлээд, коньякнаас дахин балгаж дараа нь Ремид өгөв. "Амжилтаатэмдэглэх хэрэгтэй. Нохойн дуу ч ойртож байна даа!" гэж өгүүлэв.

Реми дашмагтай коньякийг уриалагхан аваад балгатал, шорвог амттай байсан боловч, тэрээрүүнийг нэг их анзаарсангүй. Одоо тэд хамтрагчид болсон шиг Ремид санагдав.

Ремигийн хувьд амьдрал нь нэг шатаар ахиж, дахин хэзээ ч гэрийн үйлчлэгч хийхгүй гэхээс сэтгэл нь хөөрнө. Дашмагаас дахин нэг балгатал, түүний цус буцлах шиг халуу дүүгээд явчхав. Түүнийхоолой халуу оргиж, сүүлдээ хорсон өвдлөө. Тэр зангиагаа суллаж, дотор нь эвгүйтсэнд, коньякийгБагшид эргүүлэн өглөө.

"Би хэтэрхий их уусан бололтой" гэж Реми сул дуугаар арайхийн хэлэв.

Багш түүнээс дашмагийг авах зуураа, "Реми, чи бол намайг хэн гэдгийг мэдэж байгаа цорын ганцхүн. Би чамд итгэл хүлээлгэсэн" гэхэд, үйлчлэгч эр зангиагаа улам суллаад, "Тиймээ, таны хэнболохыг би торны цаана суусан ч хэлэхгүй".

Багш удаан чимээгүй суугаад, эцэст нь "Би чамд итгэж байна" гэв.

Дараа нь Онъсон чулуу, дашмаг хоёроо халаасандаа хийгээд, суудлын дэргэдэх хайрцгаас гар бууггаргаж ирэв. Тэр агшинд Реми маш их айсан боловч, Багш бууг халаасандаа хийчхэв.

Тэр юу хийгээд байна аа? гэж Реми дотроо бодох зуур, түүний хамаг бие нь хөлөрчээ.

"Би чамд эрх чөлөө амласныг чи мэдэж байгаа" гэж Багш харууссан байртай хэлээд, "Гэхдээнөхцөл байдлыг авч үзвэл, ингэхээс өөр арга байсангүй".

Ремигийн хоолойд гал авалцаж, 2 гараараа хоолойгоо бариад, бөөлжих гэж байгаа юм шиг хяхтнандуугарлаа. Гэвч түүний энэ дуу машины бүхээгээс гадагш сонсогдсонгүй. Коньяканд байсаншорвог амтны учир одоо л тайлагдлаа.

Би хүнд хорлогдчихлоо! гэж Реми бодож амжив.

Тэрээр дэргэд нь суугаад, урдах цонхоор тайван харах Багшийг ажиглаж амжлаа. Тэр мөчид Ремигийн нүд нь бүрэлзээд, амьсгал нь давчдана.

Энэ бүхний эцэст Багш яагаад намайг хорлов? Би түүний хэлснээр, бүгдийг гүйцэтгээгүй гэж үү?

Түүний сэтгэлийг уур хорсол, гомдол цөхрөл зэрэг эзэмдэж, Багшийг багалзуурдах гэж оролдсон ч, хөшсөн бие нь хөдөлж болохгүй байв. *Би танд эцсээ хүртэл итгэж байсан шүүдээ!*

Реми машиныхаа дохиог хангинуулах гэсэн боловч амжсангүй. Багшийн өвөр дээр хоолойг ообарьсан чигтээ нумран гулдайв.

Зүсэрч байсан бороо улам ширүүсэв. Харин Реми Легалудект борооны шаагих чимээ түүний мөрөөдөл болсон газрын далайн эргийн усны түрлэг шиг сонсогдсоор, аажимдаа замхарчдуудахаа болив. Тэр нэгэнт амьсгал хураажээ.

Багш машинаас буугаад, өөрийг нь харж ажигласан нэг ч хүн байгаагүй тул, дотроо баярлав.

Надад өөр сонголт байгаагүй.

Багш сая хийсэн үйлдэлдээ огт харамсахгүй байгаадаа, өөртөө гайхав. Реми өөрийнхөө нууцыг өөртөө лацдаад үхчихлээ. Энэ бүхнийг дуусгавар болсны дараа, Багш түүнийг чимээгүй болгохыг, маш их хүсч байсан нь, одоо ингээд бүтчихлээ.

Шату Виллетийн эдлэнд Роберт Ландон очсоноос л, бүх зүйл үүдэлтэй. Багш тэр үед ацан шалаандорж, яг ямар шийдвэр гаргахаа сайн мэдэхгүй байсан юм. Ландон хэрэг явдлын халуун цэг болсон, Шату Виллетэд Онъсон чулууг өөрөө авчирч, харин түүний араас цагдаа нар мөрдөн мөшгөсөөр ирсэн юм.

Тэр үед Ремигийн хурууны хээ байшингийн хаа сайгүй байснаас гадна, чагнах төхөөрөмж саравчинд байсан явдал түүнд маш их аюулыг дагуулж болохоор байв. Гэвч Багш анхнаасаа хаширхянуур загнаж, Ремитэй харьцах харьцаагаа шууд бус хэлбэрээр гүйцэтгэдэг байсан нь, түүнд эрсдэлийг багасгах том боломж олгожээ. Реми, Багш хоёрыг хоорондоо харьцаатай байсныг батлах баримт, нотолгоо бүр сэжиг таамаг ч байхгүй байв.

Багш машины арын хаалгыг онгойлгоод, ийш тийш харсан ч, нэг ч хүн байгаагүй тул, дотогш орчхов. Багш Гэгээн Жеймсийн цэцэрлэгт хүрээлэнгээс гарахаар явж байлаа.

Одоо зөвхөн хоёр л хүн үлдсэн.

Тэр нь Ландон, Нөвү хоёр байв.

Тэднийг аргалахад төвөгтэй ч сайн хичээвэл болох байх.

Түүнээс гадна Багшийн гарт Онъсон чулуу байгаа нь чухал. Багш цэцэрлэгээс гарангаа, нүдэнд илхарагдаж байгаа, очих ёстой газар луугаа чиглэн, тайван алхана.

Папын оршуулсан Хөлөг баатрын бунхан Лондонд буй.

Багш шүлгийг анх сонсмогцоо, хариуг нь олсон юм. Бусад хүн үүнийг мэдэхгүй байгаа

нь, тийм чгайхалтай зүйл биш. Учир нь тэрээр харьцуулшгүй давуу талтай байсан юм. Тэрээр ЖакСониехийн өрөөн дэх дуулгат баатрын өмсгөл дотор суурилуулсан, чагнах төхөөрөмжийнтусламжтайгаар нэлээд зүйлийг олж мэдсэн явдал нь Багш "тамга хөзрийг" атгахад хүргэсэн юм.

Та нар түүний бунхан дахь бөмбөрцгийг эрж хайна.

Багш тэр алдарт бунхны гэрэл зургийг тод санаж байв. Гайхамшигтай уран гоё урласан бөмбөрцгийг бунхны дээд талд маш томоор дүрсэлсэн байдаг. Гэхдээ Багшид нэгэн эргэлзээ байгаань, үлдсэн 2 мөрөнд тэрхүү том бөмбөрцгийн тухай биш, харин бунхан доторх бөмбөрцгийг гүүж байгаа юм шиг санагдана.

Бороо улам ширүүсэхэд, Багш криптексийг хорохоос хамгаалж, баруун халаасныхаа гүнд шургуулав. Түүний зүүн халаасанд Medusa Revolver буу байв.

Нэг л мэдэхэд, тэрээр Лондон хотын алдарт 800 жилийн түүхтэй барилга руу явж орчхов.

Багшийг борооноос зайлж, барилгад нэвтэрч байх хооронд, Хамба лам Арингароза хүчтэй бороонд цохиулж явав. Биггин Хилл нисэх онгоцны буудал дээр буунгуутаа, тэрээр кассокныхоо хормойгноргохгүйн тулд, дээш өргөн шогших нь хэн хүний нүдэнд содон харагдахаар байв.

Түүнийг ахмад Фааш угтах байх гэж бодсон ч өөр нэгэн цагдаа, шүхэр бариад буудлын өмнө зогсож байв.

"Та Хамба лам Арингароза юу? Ахмадад ажил гарсан тул таныг угтаж аваарай гэж надад даалгасан юм. Би таныг Шотландын талбай руу хүргэж өгнө. Тэнд та аюулгүй байх болно гэж ахмад дамжуулсан".

Аюулгүй! гэж бодох зуур, Арингароза өрийн бичгээр дүүрсэн хар цунхээ хараад, ахмадын хэлсэн үгийн учрыг сая л ухаарч, "За Баярлалаа!" гэж уриалагхан хэлэв.

Арингароза машинд суух үедээ, Силасын тухай бодов. Машин доторх богино холбоогоор ярих хамбад тодхон сонсогдоно: "Ормегийн шүүх 5 - р гудамж"

Арингароза сонссон даруйдаа хаягийг танив. Энэ бол Лондон дахь Опус Дейн салбар сүмийн хаяг байлаа. Арингароза тэр даруй жолоочид хандаж, "Намайг тийш нь хүргээд өгөөч!" гэв.

Хэсэг 95

Хайлт эхэлсэн цагаас хойш, Лондон компьютерын дэлгэцээс нүдээ салгасангүй. Бүтэн 5 минут өнгөрч байхад, хоёрхон үр дүн гарч ирсэн ч хайсан зүйлтэй огт уялдаа холбоогүй байв. Түүний санаа нь зовж эхлэв.

Харин Памелла Гэттум цаад өрөөнд орчихсон, цай бэлдээд зогсож байв. Ус буцалгагчийн дохиодуугарахад, тусламж хүссэнийхээ хариуд, "Нескафе" уулгах гэсэн Гэттумын найрсаг саналыг нь хүлээн авах мөч ирснийг, тэр хоёр ойлгов.

Компьютер бас тэр мөчид дуугарч дохио өгөв.

"Бас нэг үр дүн гарсан бололтой" гэж Гэттум цаад өрөөнөөс хэлээд, "Ямар гарчигтай байна?" гэж асуув.

Лондон дэлгэц рүү харж, гарчгийг уншив.

"ГРЕЙЛИЙН ЁГТ ЗОХИОЛ ДУНДАД ЗУУНЫ УРАН ЗОХИОЛ ТУСГАЛАА ОЛСОН НЬ:

ГАВАЙН БОЛОН ГРИЙН НАЙТЫН ЗОХИОЛ БҮТЭЭЛҮҮД".

"Грийн Найтын (орчуулбал Ногоон Хөлөг баатар гэсэн утгатай хүний нэр) ёгт зохиол юм шиг байна".

"Тэгвэл биш байна. Лондонд тийм ч олон ногоон хүнийг бунхлаагүй юм шүү" гэв.

Удалгүй Гэттум найруулсан кофегоо барьсаар гарч ирэв.

"Тэсч үзээрэй! Наадах чинь тоон тоглоом л гэсэн үг. Машин өөрөө уншихыг, тэвчээртэй хүлээххэрэгтэй" гэж хэлэв.

4 минутын өнгөрөхөд, Ландон эцэст нь хайсан зүйлээ олохгүй байхаас эмээж, ихэд түгшиж байв. Тэр агшинд өөр нэг үр дүн дэлгэц дээр гарч ирлээ.

"СУУ БИЛЭГТ ХҮН БУЮУ ОРЧИН ЦАГИЙН ХӨЛӨГ БААТРЫН НАМТАР.

"Суу билэгтэн гэнэ үү" Ландон хэлээд "Орчин цагийн Хөлөг баатрын намтрын тухай бололтой"

Гэттум хариуд нь, "Хэр орчин үеийнх гэж байна?"

"Одоохон хараадахья!" гэж Ландон хэлээд, тайлбар текстийг нь уншив.

..... **"Хөлөг баатар"** Исаак Ньютон.....

.....1727 онд, **Лондон** хотод.....

....түүний **бунхан** Уэстминстерийн ордонд....

....Александр **Пап** болон түүний найз нөхөд....

"Орчин үеийн баатар гэдэгтэй тохирч байна" гэж Софи хэлээд, "Исаак Ньютоны тухай бичсэннэлээд дээр үеийн ном байна" гэв.

Гэттум толгой сэгсэрч, "Биш байна. Ньютоныг Уэстминстерийн ордонд үнэн алдартны шашныёслолоор оршуулсан юм. Харин Католик сүмийн Паптай энэ бүхэн ямар ч холбоогүй. Чихэр, сүүний алиныг нь цайндаа хийх вэ?"

Харин Ландоны зүрх түргэн түргэн, хүчтэй цохилж байв. Тэр дэлгэцээс нүдээ салгангуугаа, суудлаасаа огцом босч, "Исаак Ньютон бол бидний хайж байсан "Хөлөг баатар" мөн байна" гэв.

Софи суудалдаа суусан хэвээр, "Чи юу яриад байна аа?"

"Ньютоны бунхан энд, Лондонд бий. Түүний нээсэн шинжлэх ухааны бүтээлүүд сүмийнхнийгуурлуулан хилэгнүүлж байсан. Түүнээс гадна тэр Сионий Прайорийн гишүүн байсан шүү дээ. Өөрбидэнд юу хэрэгтэй юм бэ?"

"Өөр гэж үү?" гээд Софи шүлгийг дахин харж, "Папын оршуулсан Хөлөг баатар гэдгийг юу гэж тайлбарлах вэ? Ньютоныг оршуулахад Папыг оролцоогүй гэж Гэттум түрүүнд тодорхой хэлсэншүү дээ".

Ландон компьютерын маус руу гараа явуулж, "Энд католик сүмийн Папын талаар огт дурдаагүй" гээд Пап гэсэн үгийг дартал,

"ИСААК НЬУТОНЫ ОРШУУЛГАН ДЭЭР АЛЕКСАНДР ПАПААР

АХЛУУЛСАН ДОТНЫН НӨХӨД, АНД НАЙЗУУД ХҮРЭЛЦЭН ИРСЭН ЮМ"

гэж бичсэн байв.

Софи үүнийг хараад мэл гайхав. Тэрээр өвөөгийнхөө зохиосон давхар утгатай шүлгийг эцэст ньойлгоод, түүний хэнд ч гүйцэгдэшгүй их ухааныг бишрэн бахадлаа.

Хэсэг 96

Силас гэнэт сэрчхэв. Тэр юунаас болж сэрснээ огт мэдэхгүй байв. Босч суугаад чагнавал, дооддавхраас тайвшруулж амирлуулах ёстой боловч, Силас өөр зүйлээс болж сэтгэл нь түгшсэн хэвээрбайв.

Тэрээр өмдөө өмсчхөөд цонх руу очиж харав. *Намайг мөрдөж байгаа юм болов уу?*

Цонхоор гадаахыг хартал, нам тайван байдалтай байв. Тэрээр дахин чих тавин чагнаатахвал, бас лнам гүн хэвээр байв.

Би юунд түгшээд байна аа?

Силас Марселийн шоронд байхаасаа л зөн совиндоо итгэж сурсан билээ. Энэ бол МануэльАрингарозатай учрахаас өмнө түүний эзэмшсэн ганц сайн чанар.

Гаднах байдлыг дахин ажиглавал, байшингийн буланд цагдаагийн дохиотой машин зогсож байв.Гэтэл тэр мөчид доод давхарт чимээ гарч хаалга онгойх нь сонсогдов.

Силас зөн совингоо дагаж, хаалга онгойхоос урьтаж, Нуугдаж зогсов.

Орж ирсэн эхний цагдаа өрөөг нэгжин, зүүнээс баруун тийш ажиглан харлаа. Силасыг амжижхарахаас өмнө, альбино өрсөж хаалгыг хүчтэй түлхэн, цагдаагийн мөрийг цохиход, хоёр дахьцагдаа мөн л савагдсан хаалгыг мөргөн шалан дээр ойчив.

Мөрөндөө цохиулсан цагдааг гохоо дархаас нь өмнө, Силас доош бөхийж, түүний хөлийг давхархамж унгахад, сум нэгэнт шунгинан гарч, Силасын толгойн дээгүүр нисэн өнгөрөв. Силас түүнийхөлийг барьсан чигтээ, шалан дээр нөгөө цагдаагийн нүүрлүү нь өвдөглөөд дээш шалавханөндийж, шатаар уруудан зугтлаа. Силас бараг нүцгэн шахуу хувцасгүй чигтээ шатаар гүйж байв.Түүнийг доод давхарт бууж ирэхэд, бас хэдэн цагдаа гаднаас гүйлдэн орж ирэв. Силас зүгээөөрчилж, 1 - р давхрын мухар, гарцгүй хэсэг рүү улам гүн шигдэв. Гэвч тэр зүгт зөвхөн гэлэнмаанарын орж гардаг өөр нэг үүд бий.

Опус Дейн барилгууд бүгд л ийм хаалгатай байдаг болохоор, Силас гал тогооны өрөөгөөр туучиндамжин гүйсээр, хайж байсан гарцаа олж харав. Хар хурдаараа давхисаар, асган цутгах хүчтэйборооноор гадагш гарвал, нэгэнт хожимджээ. Түүний өөдөөс замыг нь тосон, хоёр цагдаа ирэв.Силас гүйсэн хар эрчээрээ эхний цагдааг мөрлөж унагахад цагдаагийн барьж байсан б уу нь замдээр шидэгдэв. Альбино бууг авч нөгөө цагдаагаас урьтаж, буудах гэсэн боловч, түүний хавиргабууны суманд нэвт сүлбүүлэх шиг болов. Уур хилэндээ шатсан, Силас араас нь гарч ирсэн Зцагдааг нэг дор нь буудахад, тэдний цус борооны устай холилдон агаарт үсчиж байв.

Гэтэл ард нь нэг хүний сүүдэр тусах шиг болж, ширүүн бахим гар түүний мөрнөөс угзрахад, Силастэр гарыг ад зэтгэрийнх мэт төсөөлөн бодов. Нөгөө хүн түүний чихэнд, "Хэрэггүй ээ, Силас!" гэжорилоход, сандарсан альбино эргэж харангуутаа, гохоо дарчхав.

Хамба лам Арингарозаг зам дээр хөсөр унахад, Силас түүнийг харангуутаа, амь тэмцэн

муухайхашхирлаа.

Хэсэг 97

3000 гаруй хүний шарил багтаасан Уэстминстерийн бунханд, хаад ноёд, язгууртан тайж, улс төрч, шинжлэх ухааны эрдэмтэн, зохиолч, яруу найрагч, хөгжмийн зохиолч зэрэг нөлөө бүхий хүмүүсийн нэртэй пайз чулуунууд чигжих зайгүй байдаг юм. Амиэн, Чартр, Кантрбюри зэрэгсүмийн загвараар түүнийг барьж байгуулаад, 1066 оноос хойш дээдэс язгууртнуудын хүндэтгэлтэй арга хэмжээг энд зохиосоор иржээ. Хан хүү Эндрю, Сара Фергусон нарын хурим болон 5 - р Генрихаан, 1 - р Элизабет хатан хаан, Диана гүнжийн оршуулгын ёслолыг энд хийж байсан юм.

Энэ бүх түүхэн тэмдэглэлт үйл явдлыг огт тоодоггүй, Роберт Ландон харин энэ удаад Английн Хөлөг баатар Исаак Ньютоны бунхныг зорьж Уэстминстерт хүрч иржээ.

Папын оршуулсан хөлөг баатар Лондонд буй.

Софи, Ландон хоёрыг гол танхим руу нэвтрэх замд, хамгаалалтын хоёр ажилтан тэднийг металлилрүүлэгч багана дундуур гарахыг хүсэв. Тэдэнд төмөр хольцтой зүйл бараг байгаагүй учир удажтүүртсэнгүй.

Уэстминстерийн дотор орж ирэхэд, гаднах ертөнцөөс бүрмөсөн таслагдсан юм шиг, нам гүмбайдал ноёлж эхлэхийг Ландон эрхгүй анзаарав.

"Бараг хүнгүй байх шив" гэж Софи шивэgnэв.

Ландон үүнд сэтгэл дундуур байв. Тэрээр Дуган сүмд болсон шиг зүйл битгий давтагдаасай гэж бодохдоо, энд олон хүн ирсэн байгаасай гэж залбирч байсан юм.

Гэвч одоо жуулчны улирал биш болохоор, бороотой 4 - р сарын үеэр хэн л энэ ордныг дүүргэв гэж дээ.

Энэ бодлыг нь таасан юм шиг Софи, "Биднийг орж ирэхэд, метал илрүүлэгчээр шалгасан юм чинь, энд зэвсэгтэй хүн нэвтрэх боломжгүй байх ёстой" гэв.

Ландон толгой дохсон боловч, сэжиг таамаг нь бүрэн арилсангүй. Түүний бодлоор тэд Лондоны цагдаа нарт бүхнийг мэдэгдэж, хамгаалалт дор явахыг хүсэв, Софи түүний саналыг зөвшөөрөөгүй ажээ.

"Бидэнд одоохондоо Онъсон чулуу байхгүй болохоор, эхлээд түүнийг олох ёстой!" гэж Софигийн хэлсэн нь аргагүй л зөв байв. Онъсон чулуу бүх зүйлийн түлхүүр болж байв.

Лейг аврах түлхүүр

Ариун Грейлийг олох түлхүүр

Энэ бүхний цаана хэн нуугдаж байгааг олж мэдэх түлхүүр .

Харамсалтай нь тэднээс урьтаж, Онъсон чулууны учрыг тайлсан бол, тэр хоёр гар хоосон буцахаас өөр аргагүй байв. Ландон хөөрхий Тийбинийг өөрийнхөө лимузинд хүлээстэй хэвтэж байгааг бодохоос, дотроо өрөвдөнө .

Сионий Прайорийн гишүүдийг алах тушаал өгөхдөө огт харамсаагүй, тэр үл мэдэгдэх хүн замдаа хөндөлдсөн, хэн нэгнийг өчиггүй устгахдаа, санаа нь зовохгүй биз.

"Хаашаа явах вэ?" гэж Софи эргэн тойрноо харж асуув.

Бунхан руу очих замыг Ландон ч бас мэдэхгүй байв. "Эндхийн ажилтнаас асуух хэрэгтэй*.

Энд дэмий сэлгүүцсэнээс хурдан зам заалгах нь дээр гэж Ландон бодно.

Уэстминстер бол Луврын музей шиг ороход хялбар мөртлөө, буцаад гарахад учраа олохгүй төөрчбудлихаар, хэцүү зохион байгуулалттай баригдсан билээ. Энэ барилгыг дээрээс нь харвал, тогтсонэртний уламжлалын дагуу загалмай хэлбэртэй барьжээ.

"Эндхийн ажилтнууд улаан хүрэн өмсгөлтэй байдаг юм" гэж Ландон хэлээд, мөргөл үйлдэж буйхэсэг хүний зүг харав.

"Би нэг ч тийм хүн олж харахгүй байна. Эсвэл бунхныг өөрсдөө олсон дээр байх?" гэж Софи саналболгов.

Ландон хариу хэлэлгүй, Софиг дагуулан баруун тийш эргэн алхав. Софи тийш явах зуураа, сая лойлгов бололтой, "Аа, за за. Ажилтныг эндээс л олье" гэж хэлэв.

Яг тэр мөчид Исаак Ньютоны бунхны өмнө нэгэн хүн зогсч байв.

Багш бараг 10 минутын турш, бунхны хөшөөг нарийвчлан ажигласаар л байлаа. Ньютоныгсонгодог загварын хослолтойгоор барималд дүрсэлсэн бөгөөд хүндийн хүч, хронологи, оптик зэрэгонол бүтээлээ шимтэн харж байгаагаар урлажээ. Хос далавчтай хоёр жаал хүү (сахиусан тэнгэр)хуйлсан цаас бариад түүний хөлийн дэргэд зогсож байгаагаар үзүүлжээ. Ньютоны хөшөөний ардэнгийн хийц бүхий пирамид суурилуулсан байв.

Пирамид хэдийгээр Багшид содон харагдсан ч, түүний сонирхлыг илүү татаж байсан зүйл болпирамидын орой дээр дүрсэлсэн өнөөх бөмбөрцгүүд байв. Багш Жак Сониехийн зохиосон тааврынгүн утгыг бодоод, бишрэн шагшиж байв.

Та нар түүний бунхан дахь бөмбөрцгийг эрж хайна.

Багш анхандаа тэрхүү бөмбөрцгийн утгыг дор нь олж мэдэж болно гэж өөртөө хэлж байсан ч, одоотүүний толгой нь бүр эргэчхэв. Тэнд зурхайн тэмдэг, сүүлт од, од, гариг эрхэс зэрэг бөмбөрцөгхэлбэрийг дүрсэлсэн маш олон зүйл байлаа.

Аль бөмбөрцөг нь байж болох вэ?

Та нар түүний бунхан дахь бөмбөрцгийг эрж хайна

Хэсэг жуулчид дөхөж ирэхэд, Багшийн бодол сарнив. Жуулчид харандаа цаас барьсан чигтээ,түүний дэргэдүүр өнгөрлөө. Чоосер, Теннисон, Диккенс нарын бунханд хүндэтгэл үзүүлэхээр явжбайгаа бололтой.

Багш ганцаараа үлдээд, дахин хөшөө рүү ойртож, бунхныг сайтар шинжлээ.

Ямар бөмбөрцөг байж болох вэ? гэж тэрээр тархиа гашилган бодно. Уг нь би Ариун Грейл тавханүсгийн зайтай ойрхон байгаа шүү дээ! Криптекс дээрх 5 үсгийг л зөв оруулах хэрэгтэй.

Багш чимээ гарсан зүг эргэж харвал, улаан хүрэн өмсгөлтэй ордны ажилтан эртний танил хоёрхүнийг нь дагуулан, хөшөөг чиглэн ирж байв. Тэр хоёр хүн бол Софи, Ландон нар байлаа. Багшүүнд огт сандарсангүй, хэдэн алхам арагш алхаад, тэднээс нуугдаж амжив. Тэрээр Софи, Ландонхоёрыг шүлгийн далд утгыг тайлж, энд ирэхийг мэдэж байсан ч, ийм хурдан хүрээд ирнэ чинээсанаагүй юм.

Багш уртаар санаа алдаад, өөрийн төлөвлөгөөг боловсрууллаа. Аль бага байхаасаа л тэрээргэнэтийн зүйлд хариу барих чадварыг гарамгай эзэмшсэн билээ.

Надад Онъсон чулуу байгаа!

Түүнээс гадна түүний халаасанд гар буу байгаа болохоор, Багш өөртөө итгэлтэй байв. Үнэндээшүлгийн утгыг тайлж, Онъсон чулууг онгойлгоход түүнд бэрхшээлтэй байсан болохоор, тэрхоёрын энд ирсэн явдал түүнд зарим талаараа ашигтай байж болохоор байв.

Нэгэнт Ландон шүлгийн утгыг тайлж энд ирсэн юм чинь, бөмбөрцгийн талаар ямар нэг зүйлмэдэж байж ч магад. Тэгээд бүр криптексийг онгойлгох нууц үгийг олчихвол, тэдэнд хүч хэрэглээдсүрдүүлж дөнгөнө шүү дээ!. Гэхдээ мэдээж энд биш. Хүний нүднээс далд өөр газар л сүрдүүлэххэрэгтэй.

Ордон дотуур ийш ирэх замдаа, нэгэн анхааруулгын пайз зүүсэн байсан газрыг Багш гэнэт саналаа.

Нээрээ, тэнд ч ажил хэргээ гүйцэлдүүлэхэд, яг тохирох юм байна шүү. Харин тийш очуулах ямарарга сэдэх вэ?

" Уэстминстер ордон"

Хэсэг 98

Ландон, Софи хоёр хэдийгээр Бунхныг ойрхон байдаг гэж ажилтнаар заалгасан ч одоо хүртэл олжхарахгүй л байв.

"Ядаж ганц ч гэсэн хүн энд байхгүй бололтой" гэж Софи шивэгнэв.

Ландон толгой дохино. Тэр хоёрт Ньютоны бунхан харагдахад,

"Би түрүүлж очоод, эхлээд шалгаадахья! Хэн нэг хүн байвал, чи эндээ түр байж байсан дээр байх" хэмээн Ландон шивэгнэн хэлэв.

Түүнийг хэлж дуусаагүй байтал, Софи түүний өмнө ороод алхчав. Тэр хоёрыг бунхан тийш дөхөхгусам, хар гантиган баримал хөшөө, далавчтай хөвгүүд, том пирамид болон бөмбөрцөг зэрэг дүрстодрон харагдав.

"Чи өмнө нь энд ирж байсан уу?" гэж Софиг асуухад, Ландон толгой сэгсрэв.

Ньютоны бунхан тэр чигээрээ бөмбөрцгөн дүрсээр бялхсан байв. Од, сүүлт од, гариг эрхэс гээд л ...

Эндээс шүлэгт дурдсан бөмбөрцгийг олно гэдэг бухал өвснөөс зүү эрэхтэй адил төвөгтэй мэт Ландонд санагдана. Тэрээр хөмсгөө зангидав.

Ариун Грейл, одон орны ухаан хоёр тийм ч их харилцан хамааралтай биш. Зөвхөн Сугар гариггэдэг үгээр л холбогдож мэднэ.

Харин Софи Ньютоны хөшөөний барьсан цаасан дээрх үгийг уншив.

"Хүндийн хүч, Хронологи, Оптик, Математикийн үндсэн зарчмууд" гэж тэрээр чанга дуугааруншаад, "Энэ чамд ямар нэг зүйлийг сануулж байна уу?" гэж Ландонаас шалгаав.

Ландон ойртож очоод, "Математикийн үндсэн зарчим гэдгийг гариг хоорондын таталцлын хуулиартайлбарладаг. Гэхдээ л учир битүүлэг, холбогдолгүй юм шиг санагдаад байна".

"Тэгвэл эдгээр зурхайн ордуудын талаар чи юу гэж бодож байна? Чи өмнө нь загас, хумхын ордныталаар надад ярьж байсан шүү дээ".

"Тийм ээ. Хумхын ордын төгсгөл ирж, Загасны орд эхлэхэд, Сионий Прайоричууд Сангрийлийнбаримтыг нийтэд дэлгэнэ гэж би хэлж байсан".

"Шүлгийн сүүлийн мөрөнд энэ тухай дурдсан гэж бодогдохгүй байна уу?"

Энэ бол бүхний эхлэл болсон үрт улаан жимсний тухай ...

Ландон энэ талаар огт бодож үзээгүй байв. Тэрээр Софигийн санааг ойлгож, толгой дохисон хэдийч, зөн билэг нь түүнд гариг эрхэс үүнд огт хамаагүй гэж шивнээд байв.

Сионий Прайорийн сүүлчийн тэргүүн гариг эрхэстэй холбоотой нууц үгийг өмнө нь огташиглаагүй байсан шүүдээ!

Мона Лиза, Мадонна, SOFIA гээд бүгд л одон оронтой огт холбоогүй өөр утгатай үгс байсан. Тиймболохоор, Жак Сониехийн зохиосон эцсийн нууц үг нь хэнд ч ойлгомжтой мөртлөө, бас маш гүнагуулгатай байх ёстой гэдэгт Ландон итгэж байв.

"Хар даа!" гэж Софи хэлээд, Ландоны гараас атгачхав.

Ландон цочиж, хэн нэг нь ирж байгаа юм болов уу гэж бодтол, Софи бунхны дэргэдэх тавиур тийшхуруугаараа зааж, "Энд хэн нэгэн ирсэн байна" гэж шивэгнэв.

Ландон үүнийг тоосонгүй.

Хэн нэг анзааргагүй хүн Ньютоны хөшөөний өмнө харандаагаа мартчихаад явсан биз
гэж бодоод, харандааг авахаар тонгойтол, хар өнгөтэй гантиган чулуун тавиур дээр
харандааны балаар бичсэн

үгс нүдэнд нь гялтганан тодров. Энэ мөчид Ландон Софигийн ямар учраас айж цочсоныг ойлгов. Чулуун дээр,

"Тийбин надад байгаа. Чаптрын танхимаар дайрч, урд хаалгаар гараад, цэцэрлэгт хүрч ир!".

Ландон айн балмагдаж, хөдөлж чадахгүй байв. Софи эргэн тойрныг нэгжиж харна.

Ландон хэдийгээр үүнд цочирдож сүрдсэн боловч, нөгөөтээгүүр сайхан мэдээ мэт түүнд бодогдов.

Лей амьд л байгаа юм байна.

"Тэд нууц үгийг мэдэхгүй байгаа юм байна" гэж Ландон шивэглэв.

Софи хариуд нь толгой дохиод, Өөр тохиолдолд бидэнтэй уулзахыг хүсэхгүй шүү дээ гэж бодов.

"Тэд Лейг барьцаалаад, нууц үгийг олж мэдэх гэж байгаа бололтой. Эсвэл энэ бүхэн занга ч байжмагадгүй" гэж Софи хэлэв.

Ландон толгой сэгсэрч, "Би тэгж бодохгүй байна. Цэцэрлэг гадаа гудамж руу харсан байдагболохоор, олны нүдэнд ил газар тэд биднийг сүрдүүлж чадахгүй" гэв.

Ландон өмнө нь энэ цэцэрлэгт ирж байсан агаад, жуулчид ордонд орохгүйгээр, гудамжнаасцэцэрлэг рүү шууд нэвтрэх боломжтой байдаг билээ.

"Биднийг цэцэрлэгт дуудсан нь итгэл төрүүлэхийг хүссэн бололтой. Бид хоёрт аюулгүй юм шигсанагдах юм".

Софи харин ч эргэлзсэн байдлаар, "Бид гадагш гарна гэдэг чинь, тэнд металл илрүүлэгчгүй газарлуу өөрсдөө яваад очно гэсэн үг".

Софигийн хэлсэн зөв гэдгийг ойлгоод, Ландоны царай нь үрчийв. Тэр бунхан руу эргэж хараад, нууц үгийн талаар эргэцүүлж бодов.

Лейг энэ бүхэнд оролцуулсан болохоор, би түүнийг аврах ёстой!

"Энд бичсэнээр бол хаалгаар гарч, цэцэрлэгт оч гэж бичсэн байна. Тэгэхээр хаалгаар гарахын өмнө, бид цэцэрлэгийн байдлыг дотроос ажиглаад, аюулгүй эрсдэлгүй алхам хийх эсэхээ шийдэж болох юм" гэж Софи санал дэвшүүлэв.

Түүний санааг Ландон дэмжив. Тэд бунхнаас холдож, ордны зам заагч тэмдгүүдийг ээлжлэнуншиж эхлэв.

КЛОИСТЕРС

ДИЙНЕРИ

КОЛЛЕЖ ТАНХИМ

МУЗЕЙ

ПИКС ТАНХИМ

"ГЭГЭЭН ФЭЙФ" МӨРГӨЛИЙН ГАЗАР

ЧАПТР ТАНХИМ

Ландоч, Софи хоёр Чаптр танхимын үүдэнд тавьсан "Засвартай!" гэсэн анхааруулгын дэргэдүүрбараг гүйх шахам өнгөрөөд, задгай дээвэртэй хэсгээр орон явахад, тэдний дээрээс аварга хүн үлээжбайгаа юм шиг салхи хүүгэнэ. Бас түүний хажуугаар, тэдний дээрээс бороо шиврэн дусалж байлаа.

"Бид танхимын төгсгөлд ойртож байна. Удахгүй хаалга харагдана. Баруун тийш эргээд л гүйцээ" гэж Ландон хэллээ.

"Танхим ч том, уужим зайтай юм аа" гэж Софи хаалга руу ойртонгоо, шивэгнэж хэлэв.

Гэвч булан тойроод хартал, тэнд хаалга байсангүй. Мухар булан байв. Гэтэл тэдний ард хаалгачахран хаагдаж. түгжээ нь тасхийх чимээ сонсогдов. Үүдний дэргэд зогсох тэр хүн гар буубарьчихсан зогсож байв. Тэр хүн хос суга таягаа тулаад, тэдний өөдөөс ширтэнэ.

Ландон нүдэндээ ч итгэсэнгүй. Тэдний өмнө Лей Тийбин зогсож байлаа.

Ньютоны бунхан

Хэсэг 99

Лей Тийбин Medusa Revolver - ынхаа онинд Софи, Ландон хоёрыг зэрэг тааруулж зогсохдоо, нүд ньгуниг харууслаар дүүрэн байв.

"Найзууд минь! Өнгөрсөн шөнө гэрт минь орж ирэх хүртэл, би та хоёрт хор хүргэе гэж огтхон чбодоогүй байсан юм шүү. Гэвч та хоёрын шаргуу зан чинь намайг ийм шийдвэр гаргахад хүргэлээ".

Та нарын ойлгоогүй олон зүйлийг хэлж өгмөөр л байна гэж Тийбин дотроо ярина.

"Надад итгээрэй. Энэ бүхэнд та хоёрыг оролцуулна гэж үнэндээ би төлөвлөөгүй байсан юм. Та нарөөрсдөө л намайг хайсаар, гэрт минь ирсэн".

"Лей!" гэж Ландон үгийг нь таслаад, "Чи чинь юу хийж байна аа? Бид хоёр чамд аюул тулгараад байна гэж бодож байсан юмсан. Чамд л туслах гэж ийшээ ирсэн шүү дээ".

"Бидэнд ярих зүйл их бий" гэж Тийбин хэлэв.

Ландон, Софи хоёр түүний гар дахь буу руу нүд салгалгүй ширтэнэ.

"Хэрэв би хүссэн бол, та хоёр өдийд үхчихсэн байх ёстой байсан. Өнгөрсөн шөнө гэрт миньирэхэд, би та хоёрын амийг хаацайлахын тулд, бүгдийг хийсэн. Сангрийлийг олох замд саад болжбуй хүмүүсээс бусдад нь хор хүргэхгүй гэж би өөртөө тангарагласан байснаас л тэр".

"Чи юу яриад байна аа? Сангрийлийг олоход хэнд саад хийсэн гэж?"

"Би бүхнийг олж мэдсэн" гээд Тийбин шүүрс алдаж, "Сионий Прайоричууд жинхэнэ үнэнийг хэзээч дэлгэхгүй байхаар шийдсэн гэдгийг би олж мэдсэн юм. Ийм л учраас шинэ мянган эхлэх мөчидямар ч онцгой зүйл, тэр дотроо Ертөнцийн төгсгөл ирээгүй юм".

Ландон эсэргүүцэж, үг хэлэхийг оролдсон ч Тийбин,

"Сионий Прайоричууд жинхэнэ үнэн түүхийг бидэнд хэлж өгөх ариун үүргийг хүлээсэн байсан" гээд тэрээр цааш нь, "Тэр нь Ертөнцийн төгсгөл болох үед хэрэгжих ёстой байлаа. Олон зуунытурш Да Винчи, Ботичеми, Ньютон нарын нүдний цөцгийн мэт хамгаалж, хайрлаж ирсэн нууцбаримтыг Жак Сониех ухвар мөчид бодлоор өөрийнхөөрөө шийдэж, тэр хугацаа нь болоогүй гэжүзсэн юм" гээд Софи руу харж, "Өвөө чинь Грейлийг үгүй хийсэн. Тэр Сионий Прайорийгнураасан. Үе үеийн өвөг дээдсийнхээ итгэл сэтгэлийг хөсөрдүүлсэн" гэв.

"Чи!" гэж Софигийн нүд хорсол дүүрэн гялалзаж хэлээд, "Чи миний өвөөгийн үхэлд буруутай юмбиз дээ?"

Тийбин бүсгүйг дооглон инээгээд, "Өвөө чинь болоод, түүний хүмүүс бүгдээрээ Ариун Грейлээсурван тэрслэгчид шүү дээ!"

Софи уур хилэндээ багтарч, түүний хэлснийг худал гэж бодно.

Тийбиний дуу улам чангарч, "Өвөө чинь сүмийнхэнд худалдагдсан. Сүмийнхэн өвөөг чинь дуугүйболгохын тулд, түүнийг ятгасан гэдэг нь тодорхой".

Софи толгойгоо сэгсэрч, "Сүмийнхэн өвөөг минь ятгаж чадахгүй байх байсан".

Тийбин хүйтнээр инээж, "Хонгор минь! Сүмийнхэн 2000 жилийн турш өөрсдийн худал, хуурмагявдлыг нуун дарагдуулахын тулд, бусдыг ятган сүрдүүлж, чаддаг ганц зүйлийг

харуулсаар ирсэн.Константиний үеэс хойш тэд Мэри Магдалин, Есүс хоёрын тухай үнэн түүхийг нууж далдалсангэдгийг чи өөрөө мэдэж байгаа. Одоо харин тэр цаг үе нь өнгөрөх ёстой. Хууран мэхэлдэг тэр цагүе улиран одох ёстой" гээд түгдэрч байснаа, "Нөвү авхай! Өвөө чинь танай гэр бүлийнхний талаарүнэнийг ярья гэж өмнө нь хэлж байсан уу?"

Софи зогтусаж, "Үүнийг яаж мэдэж байгаа юм бэ?"

"Энэ бол нууц. Харин таны сонсох ёстой гол зүйл бол ..." гээд Тийбин гүнзгий амьсгаа авч, "Танайаав, ээж, дүү нар чинь үнэндээ осолд ороогүй юм шүү дээ".

Энэ үгийг сонсонгуутаа, Софигийн биеэр гүйх бүлээн цус нь царцах шиг болов. Бүсгүй амаангалзуулан, хий дэмийн агаар залгина.

Ландон толгой сэгсэрч, "Чи чинь юугаа яриад байна аа, Лей?" хэмээн аргаа барсан байдалтай асуув.

"Роберт! Эндээс л бүх зүйл дэндүү учир холбогдолтой болж байгаа юм. Түүх давтагдаж, Сүмийнхэн Сангрийлийг ил болгохгүйн тулд, аллага үйлдсэн. Тэд Сионий Прайорийн тэргүүнийдотнын хүмүүсийн амийг золиосолж, Жак Сониехт хатуу сануулга өгсөн байна. Өөрөөр хэлбэлзагас шиг дуугүй бай гэж анхааруулсан".

"Тэр бол автын осол байсан" гэж Софи багынхаа бараан дурсамжийг сэдрээн, чангаар хэлээд, "Осол байсан!" гэж хашхирав.

"Түүний дараа, гэр бүлийн хоёрхон гишүүн үлдсэн. Сионий Прайорийн тэргүүн, бас түүний ачохин. Сүмийнхэн энэ боломжийг ашиглан, өвөөг ач охиноор нь сүрдүүлж, Сангрийлийн баримтыгзадруулахгүй байх арга сэдэж, энэ нь амжилттай хэрэгжжээ".

"Лей!" гэж Роберт сөрөөд, "Чамд энэ бүхнийг нотлох нотолгоо байхгүй шүү дээ".

"Нотолгоо гэнэ ээ?" гэж Тийбин тэр дор нь хариулаад, "Сионий Прайори сүмийнхний нөлөөндавтсан тухай нотолгоо чамд хэрэгтэй байна уу? Тэгвэл шинэ мянган эхэлчхээд байхад, одоо хүртэлдэлхий даяараа дүлий дүмбэ оргиод явж байгааг, чи нотолгоо биш гэж хэлэх үү?"

Тийбиний хэлсэн үг танхимаар цуурайтахад, Софи бодолд дарагдав.

Өвөө надад энэ тухай хэлэх гэсэн юм болов уу? Түүний гэр бүлийнхэн үнэхээр хорлогдсон юмболов уу? Би үнэндээ ослын талаар сайн мэдэхгүй шүү дээ. Сонины нийтлэлээс хайчилсан цааснытасархай л надад үлдсэн шүү дээ.

Өвөө нь Софиг бага байхад ганцааранг үлдээх маш дургүй байсныг бүсгүй санах. Тэр ч байтугайСофиг их сургуульд орж, дотуур байранд амьдардаг байхад, өвөө нь түүнийг хаа нэгтэйгээсажиглаж байгаа юм шиг түүнд байнга санагддаг байсан аж. Магадгүй Сионий Прайорийн нэггишүүн өвөөгийнх нь даалгавраар түүнийг хөндлөнгөөс харгалздаг байсан байх.

"Чи Жак Сониехийг хуйвалдсан гэж сэжиглээд алсан юм уу?" гэж Ландон Тийбинээс үл итгэсэнхарцаар асуув.

"Би эхэлж гохоо дараагүй юм шүү! Жак Сониех аль хэдийн үхчихсэн байсан. Сүмийнхэн түүнийгэр бүлийг сүрдүүлэхэд, өвгөн сүнсээ аль эрт тэдэнд худалдчихсан юм. Харин одоо тэр өөрийнх ньхийсэн алдааг бид залруулаасай гэж хүсч байгаа. Бид хамтдаа үүнийг хийгээсэй гэж тэр туйлаас иххүсэмжилж байгаа".

Софи эргэлзсэн байртай, "Танд яагаад туслах ёстой гэж?" хэмээн асуув.

"Яагаад гэвэл, хонгор минь! Чи бол Сионий Прайорийн сүйрлийн гол шалтгаан нь байсан. Ачохиноо хамгаалахын тулд, өвөө чинь аз туршсан алхам хийсэн. Өвөө чинь чамд бүх үнэнийг тайлбарлах боломжийг чи олголгүй, тэр чигтээ зайгаа авсан. Чи өвөөгөө чамайг хүлээхээс өөр

аргагүй байдалд оруулсан. Харин одоо чи энэ бүхнийхээ төлөөсийг төлж, жинхэнэ үнэнийг илгаргах ёстой".

Роберт Ландоны толгойд маш олон бодол, үй олноороо эргэлдэв. Тэр дотроос хамгийн тодорхойзүйл гэвэл, Софиг эндээс эсэн мэнд авч гарах хэрэгтэй гэсэн бодол байв. Ландоны санаачилснаар Тийбинийг энэ бүхэнд оролцуулсан нь, эцэстээ Софид хор нөлөөтэй зүйл болчихоод байв.

Би л Софиг Шатү Виллетэд авч очсон. Үүнийхээ хариуцлагыг би өөрөө хүлээх ёстой.

Ландон үнэндээ Тийбинийг буудна гэж огт төсөөлөхгүй байлаа. Гэвч Тийбин өөр бусдыг өрөвдөжэнэрэхгүйгээр буудаж чадсан юм чинь, тэр хоёрыг ордны энэ зузаан хананы дотор буудлаа гэхэдхэнд ч сонсогдохгүй өнгөрөх боломжтой байв.

Тэгээд ч гадаа бороо асгаж байхад, бууны чимээ сарних магадлал өндөр шүүдээ!

Софигийн чичирч байхыг Ландон анзаарав.

Сүмийнхэн Сионий Прайорийг нам гүм байлгахын тулд Софигийн гэр бүлийг хорлосон гэж үү?

Гэхдээ л орчин үед сүмд хүн хөнөөх явдал бараг гардаггүй гэдгийг Ландон мэднэ.

"Софиг зүгээр орхи!" гэж Ландон хэлээд, Тийбин рүү ширтэв. "Энэ асуудал зөвхөн чи бид хоёртхамаатай".

Тийбин төсөөлшгүй муухайгаар инээж, "Би энэ төрлийн шоу хийж үнэндээ чадахгүй. Гэхдээ бичамд өөр зүйлийг санал болгож байна гээд өрөөсөн таяган дээр ачааллаа өгч зогсоод, халааснаасаа Оньсон чулууг гаргаж ирээд, Ландонд үзүүлэв. "Энэ бол харилцан итгэлцлийн бэлэ г тэмдэг, Роберт!"

Роберт бүр төөрөлдөж гүйцэв.

Лей бидэнд Оньсон чулууг эргүүлэн өгөх юм гэж үү?

"Үүнийг ав!" гэж Тийбин хэлээд, Ландон руу гараа сунгав.

Тийбин зөвхөн ганц л тохиолдолд Оньсон чулууг буцааж өгөх ёстой гэж Ландон таамаглаад, "Чионгойлгочихсон юм уу? Чи доторх газрын зургийг авчихжээ?"

Тийбин толгой сэгсрээд, "Роберт! Би хэрвээ үүнийг онгойлгочихсон байсан бол, өдийд чамгүйгээр Грейлийг хайгаад явж байх байсан. Гэтэл тэгсэнгүй. Үнэндээ намайг ганцаараа Грейлийг олоорой гэж Бурхан зураагүй бололтой. Чамайг энд харсан, тэр мөчид чи надад туслах гэж ирснийг биойлгосон. Бид хамтдаа үүнийг хийх ёстой. Дэлхий тэр аяараа чин үнэнийг хүлээж байгаа".

Тийбиний энэ үг маш их үнэмшилтэй сонсогдох боловч, Ландон түүн дээр очиж, Оньсон чулуугавахад, түүний буу Софи руу чиглэсэн хэвээр л байв. Ландон криптексийг авахад, доторх цуу ньцалгилж байв. Криптексийн үсгүүд нь замбараагүй байрлалтай, онгойгоогүй хэвээр л байв.

Ландон Тийбин рүү харж, "Би яг одоо Оньсон чулууг шидэж хагалахгүй гэдгийг чи яаж

мэдэжбайгаа юм бэ?"

Тийбин бах нь ханасан байдалтай инээж, "Би чамайг Дуган сүмд хоосон криптексээр сүрдүүлжбайсныг чинь олж мэдсэн. Чамд Онсон чулууг эвдэх санаа хэзээ ч төрөхгүй. Чи бол түүхч -эрдэмтэн хүн, Роберт! Одоо чиний гарт 2000 жилийн түүхийг өөртөө тээж буй Сангрийлийнбаримтын "түлхүүр" атгаастай байна. Жинхэнэ нууцыг хадгалж, аврахын тулд, мянга мянган Хөлөг

баатрууд галд шатаж амиа алдсан. Тэднийг дэмий зүйлийн төлөө алтан амиа золиосолсон гэдэгт чиитгэхгүй байгаа биз дээ. Тиймээс чи эвдэлж чадахгүй. Харин түүний оронд, чи түүхэнд нэрээмөнхөлсөн тэр л хүмүүсийн эгнээнд багтах болно. Да Винчи, Ботичеми, Ньютон бүгд л чинийзамналаар явж байсныг чи ухаарах болно. Онyson чулуун доторх тэр зүйл гадагш чөлөөлөгдөнгарах мөчөө тэсэн ядан хүлээж, орилох дууг нь чи сонсохгүй байна уу? Одоо цаг нь болсон. Хувьзаяаны шугам биднийг энд учруулж, энэ мөчид хөтлөн авчирч, огтлолцуулсан байна".

"Би чамд тусалж чадахгүй нь, Лей! Би үүнийг яаж онгойлгохыг үнэндээ мэдэхгүй. Ньютоныбунхныг ч удаан харж амжаагүй. Нууц үгийг мэдлээ ч гэсэн ..." гэж хэлээд Ландон үгээ цэгнэн, хэлээ хазаад дуугүй болов.

"Мэдлээ ч гэсэн чи надад хэлэхгүй гэж үү?" гээд Тийбин санаа алдаж, "Би үүнд чинь их эмзэглэж, бас гайхаж байна. Чиний төлөө хийсэн миний тусын хариуд, чи ин гэж хэллээ гэж үү? Шатү Виллетийн босгыг алхангуут л, та хоёрыг би цааш харуулж дөнгөх байсан. Гэвч би өрөвч нинжинсэтгэлийн "үлгэр загварыг" та хоёрт үзүүлсэн шүү дээ".

"Өрөвч нинжин "үлгэр загвар" чинь тэгээд энэ үү?" гэж Ландон түүний буу руу ширтэнгээ асуулаа.

Энэ бол Сониехийн буруу. Сониех болон түүний бусад гишүүд Силаст худал хэлсэн. Хэрэвгээгүй бол, би Онyson чулууг хялбар аргаар гартаа оруулах байсан юм. Сионий Прайорийнтэргүүн Онyson чулууг охиндоо гэрээсэлж үлдээх байсныг, би яаж таамаглах юм бэ?" гээд Тийбин Софи руу басамжилсан харцаар харж, "Тэр нь тэгээд тэмдэгт судлаачаар асруулсан, хэн нэгэн арчаагүй эмэгтэй байсан" гээд Ландон руу эргэн харж, "Аз болоход, Роберт, тэр тэмдэгт судлаач ньчи байсанд би баярлаж байна. Чамайг байгаагүй бол, Онyson чулуу өдийд банканд дахь цоожтой хайрцагт үлдэж хоцрох байсан. Гэвч чи кодыг тайлж, Онyson чулууг гэрт, минь авчирсан".

Би өөр хаачих байсан гэж? хэмээн Ландон бодов. Грейлийн түүхчид хуруу дарам цөөн байдгаас гадна, Тийбин, тэр хоёр эчнээ танил байсан шүү дээ.

Тийбиний төрх маадгар болж, "Сониех үхэхээсээ өмнө, чамд хандаж нэг зурвас үлдээснийг би олжмэдээд, ямар нэг зүйл дамжуулсныг нь таамагласан юм. Онyson чулуу эсвэл, түүнтэй холбоотой өөр зүйлийн алин болохыг би яг таг мэдээгүй ч гэсэн, цагдаа нар чамайг мөрдөж эхлэхийг олжмэдэнгүүтээ, манай үүдийг тогших болов уу гэж гадарласан юм".

Ландон түүнийг ширтэнгээ, "Бид чам дээр очоогүй байсан бол яах вэ?"

"Тэр нөхцөлд би чамд тусалж дэмжиж байгаа мэт сэтгэгдэл төрүүлэхүйц төлөвлөгөөг боловсруулсан байсан. Эрт орой хэзээ нэгэн цагт Онyson чулуу Шатү Виллетэд ирэх л ёстой байсан юм. Энэ бүхнийг эртнээс бодож төлөвлөсөн байсан".

Ландон цочирдож, "Юу гэнэ ээ?"

"Силас миний хэлснээр хөдөлж, Шатү Виллетэд нэвтрээд, хэн нэгэнд хор хүргэхгүйгээр, Онyson чулууг авч, намайг үүнд холбоогүй гэдэг сэтгэгдлийг төрүүлэх ёстой байсан. Гэвч би кодыг тайлж чадахгүйгээ ойлгоод, та хоёроос "будаа идэх" гэж адал явдалт хамтын аялал

зохиосон юм. Аяллынявцад цааш ганцаараа явах боломжийг өөртөө олгохын тулд, Силасаар дахин Онъсон чулуугхулгайллуулах гэж альбиног наашаа авч явсан юм даа".

"Дуган сүм хүртэл!" гэж хууран мэхлүүлснээ ойлгосон, Софи амандаа бувгнав.

Дуган сүмд Силас тушаал ёсоор тэр хоёроос Онъсон чулууг булааж, харин Реми хөндлөнгөөсаяжиглах ёстой байсан ч, Ландон Онъсон чулууг хагалахаар сүрдүүлэхэд, Реми гарч ирж үнэн

төрхөө илчилсэн юм. Багшийг мэдэх цорын ганц хүн нь Реми байсан тул, энэ нь маш эрсдэлтэй алхам болжээ. Аз болж Реми Тийбинийг барьцааны хүн болгож жүжиглээд, Силас хүртэл түүний үзэгдэлд бүрэн автаад, бүрэн утгыг нь ч ойлгож амжаагүй байжээ.

Лимузинд хүлээстэй мэт хэвтэж байсан, Тийбин таславч хана хаагдангуут, урд бүхээг дэх Силасруу гар утсаараа ярьж, Опус Дейн сүм рүү очихыг түүнд тушаажээ. Мөн түүнчлэн нэрээ нууцалсан мэдээлэгч болж цагдаа руу утастаад, Силасын очиж буй сүмийн хаягийг тэдэнд мэдэгдэж, альбинохуврагийг замаасаа зайлуулсан байна. Харин Ремиг замаасаа зайлуулах асуудал түүнд үлдсэн байв. Тийбин хэдийгээр хичээл зүтгэлтэй үйлчлэгчдээ харамсавч, Грейлийн эрлийн замд золиос бол байх ёстой зүйлийн нэг хэмээн сэтгэл шулууджээ.

Тийбин лимузин дэх жижиг хөргөгч рүү ширтэнгээ, төлөвлөгөөгөө олж харав. Дашмаг, коньяк, самар зэргийг хөргөгчөөс авч, дашмагийн ёроолд самрын үйрмэг ихээр хийж, "хороо" найруулав. Учир нь Реми самрын харшилтай гэдгийг, Тийбин сайн мэдэж байлаа. Ремиг лимузинээ зогсооход, Тийбин арын хаалгаар буугаад, урд суудал дээр сууж, хормын дараа машинаас буугаад, буцажарын хаалгаар машинд орон, эд мөрийн баримтаа устгаж, эцсийн зорилгодоо хүрэхээр цааш явжээ.

Уэстминстерийн ордон тэндээс холгүй газар байв. Тийбин төмөр таягтай явж байсан учир, халаасан дахь гар бууг нь ордны хамгаалагч нар огт анзааралгүй өнгөрч болохоор байсан юм. Хамгаалагч нар түүнийг таягаас нь салгаад, ордонд мөлхүүлж оруулах зүрх байсангүй. Тэдний эргэлзээг бүрэн арилгахын тулд, Тийбин өөрийнхөө хэргэм зэргийг тодотгосон нэрийн хуудсаа үзүүлэхэд, хамгаалагч залуус бие биенээ томоор хараад, түүнийг тэр дор нь дотогш нэвтрүүлжээ.

"Mes amis," (Найзуудаа!) гэж Тийбин Францаар түгдрэлгүй хэлээд, "vous ne trouvez pas le Saint -Gaal, c'est le Saint- Graal qui vous trouve." (Грейлийг чи олохгүй бол, Грейл чамайг өөрөө олно.) гээдинээмсэглэв. "Бидний зам нэг ижил гэдгийг үүнээс өөрөөр яаж тайлбарлах юм бэ? Грейл биднийг өөрөө олж ирсэн, Роберт".

Хариуд нь тэнд нам гүм байдал автана.

Тийбин тэдэнд бараг шивэгнэх шахам, "Надад итгэ! Грейл биднийг хэдэн зууны тэртээгээс дуудаж байгааг та нар сонсохгүй байна уу?"

Энэ боломжийг бид алдах ёсгүй. Бид хамтдаа кодыг тайлж, хамтдаа криптиксийг онгойлгох болно" гээд нүд нь гялалзаж, "Бас андгай тангаргаа өргөж, зөвхөн үнэнийг нээж илрүүлэх болно".

Софи Тийбиний нүд рүү удтал ширтээд, хүйтэн цэвдэг дуугаар, "Би хэзээ ч өвөөгийнхөө алуурчиндандгай тангараг тавихгүй. Харин чамайг шорон руу илгээнэ гэдгээ андгайлахад бэлэн байна" гэв.

Тийбиний сэтгэл өмрөв үү гэлтэй, "Намайг хатагтай ингэж бодож байгаад, би гүнээ харамсаж байна" гэж хэлээд, Ландон руу эргэж түүн рүү буугаа чиглүүлж, "Роберт, чи бас ийм бодолтой байна уу, эсвэл надтай цуг байна уу?"

Хамба лам Арингарозагийн бие, сэтгэл аль аль нь өвчин шаналлыг мэдэрч байв. Түүний цээжиндхаван орсон, сум халуу дүүгэн буцлах мэт мэдрэмжийг төрүүлнэ. Энэ нь бие махбодын өвдөлт чбиш, харин сэтгэлийн гүнд шигдэн орсон өргөс мэт хөндүүрлэн өвдөж, битүү оргих ажээ.

Тэр нүдээ нээж харахыг оролдсон ч, борооны дуслууд нүд рүү нь орчхоод байв. Нэгэн хүчтэй гартүүнийг өргөхөд, кассокных нь хормой газарт чирэгдэж байхыг Арингароза бүдэг бадаг мэдрэв. Нүдээ арайхийн нээж харвал, түүнийг тэвэрч яваа хүн нь Силас байлаа. Нүсэр биет альбино

эмнэлгийн тусламж дуудан хашхираад, улаан нүднийх нь гал цог хэдийнээ бөхөж, цусан толбобүхий алаг болсон нүүрэндээ нулимс урсгасаар явах ажээ.

"Хүү минь!" гэж Арингароза шивэгнээд, "Чи бас өвдөж бэртжээ".

Силас цөхөрсөн дуугаар гиншиж, "Намайг уучлаарай! Эцэг минь" гэж хэлэхдээ үгээ ч гүйцээжхэлэх тэнхэлгүй болжээ.

"Үгүй ээ, Силас! ... Чи харин намайг уучлаарай. Энэ бүхэн миний буруу" гэж Арингароза хэлэв. "Би дэндүү гэнэнгээсээ болоод, чи болон өөрийгөө баллачихлаа. Багш анхнаасаа Ариун Грейлийгбидэнд өгөх бодолгүй байсан байна".

Арингароза Силасын гарт тэврүүлэнгээ, өнгөрсөн үеэ нэхэн дурсав.

Испанид Силасын хамт католикийн жижиг сүм босгож, дараа нь Нью - Йорк хотод Бурхны ялгуусаних ялалтын бэлгэдэл болсон Опус Дейн удирдлагын төвийн барилгыг Лексингтоны өргөн чөлөөндбосгосон юм.

Гэтэл 5 сарын өмнө Арингарозаг "дайрлага" дайрчээ. Түүний бүх амьдралаа зориулж байсан ажилүйлс нь бөхөж унтрахад тулсан аж. Кастел Гандольфод болсон уулзалт дээр түүний хувь заяаорвонгоороо эргэж, үүнтэй тэмцэх арга ухаан сийлэхээс өөр арга зам Арингарозад үлдсэнгүй.

Арингароза Кастел Гандольфо дахь номын санд сэтгэл дүүрэн, ихэмсэг бардам төрхтэй явжороход, түүнтэй гар барин түүний амжилтыг сайшаах олон хүн угтана гэж бодож байсан нь, огтөөрөөр эргэж, түүнийг 3 хүн угтсан аж. Тэр нь Ватиканы нарийн бичиг, тэргүүн зэргийн хоёрхамбатны хамт байв.

"Нарийн бичиг!" гэж Арингароза гайхан хэлэв.

Тэд Арингарозатай гар барьж мэндлээд, өөдөөс нь харсан сандал зааж, "Та суугаач!" гэжурИАЛАГХАН хэлэв.

Арингароза суунгаа, ямар нэг зүйл буруугаар эргэснийг ойлгожээ.

"Би иймэрхүү богино хэмжээний уулзалт хийхдээ маруухан хүн. Гэхдээ эхлээд энд дуудсан учрыгөөрт чинь шууд хэлсэн нь дээр байх гэж нарийн бичиг хэлэв.

"Тэг л дээ. Би сонсож байна" гэж Арингароза хэлээд, нөгөө хоёр хамбатан руу харж өгүүлэв.

"Эрхэм дээдэс болон түүний хүмүүс танай Опус Дейн одоогийн ээдрээтэй Нөхцөл байдлыганхааралтай хянаж үзсэн гэдгийг, та өөрөө гадарлаж байгаа байх".

Арингарозагийн уур омог нь дүрсхийв. Шинээр сонгогдсон, Папын либерал үзэл шинэчлэлийннөлөө нь одоо түүний байгуулсан сүмд сүүдрээ тусгах гэж байгааг ойлгов.

"Эрхэм дээдэс танай сүмийн үйл ажиллагааг өөрчлөх шийдвэр огтхон ч гаргаагүй гэдгийг бибаталж хэлье" гэж нарийн бичиг Арингарозагийн дүрсхийж буйг гадарлаад, хариуд нь маш түргэнөгүүлэв.

"Тэгвэл намайг яагаад энд дуудсан юм бэ?" гэхэд нарийн бичиг шүүрс алдаж,

"Хамбатан минь! Би үүнийг юу гэж тайлбарлахаа сайн мэдэхгүй ч болсон явдлыг шууд тоочинхэлэх нь зүйтэй болов уу. 2 өдрийн өмнө

Зөвлөлийн хурлаар Опус Дейг Ватиканаас тусгаарлах тухай шийдвэр гарсан".

Арингароза түүнийг буруу сонссон гэж таамаглаад, "Өршөөгөөрэй. Сая юу гэж хэлсэн бэ?" гэжлавлан асуув.

"Өнөөдрөөс хойш 6 сарын дараа, Опус Дейн сүм Ватиканд огт харьяалалгүй болно гэсэн үг. Чисүмээ бие даан удирдаж явуулна. Эрхэм дээдэс, гэгээнтэн чиний үйл хэрэгт огт оролцохгүй. Бидэнэ талаар хууль эрх зүйн баримт бичгийг аль хэдийн бэлдээд тавьчихсан байгаа".

"Гэхдээ ... би ... ийм юм байх ёсгүй".

"Нөхцөл байдлаас харахад ийм юм байж болно. Ингэх ч ёстой! Эрхэм дээдэс танай сүмийн үйлажиллагаа болон, арга хэлбэрийг огтоос сайшаахгүй байгаа" гээд цааш үргэлжлүүлэн. "Мөнтүүнчлэн гэлэнмаа нарын асуудлыг ч авч үзсэн. Шуудхан хэлэхэд Опус Дей Ватиканы хувьдшүдэнд орсон мах, нүдэнд орсон хог болоод байна".

Хамба лам Арингароза мэл гайхаж, "Юу гэнэ ээ?"

"Та үүнд гайхаад байх зүйлгүй".

"Тэгж яривал, Католикийн сүмүүд дотроос зөвхөн Опус Дейн шүтлэгтнүүд өсөн нэмэгдэж байгаа.Одоо бараг 1100 гаруй сүсэгтэн манай сүмд бүртгэлтэй шүүдээ!"

"Тэр үнэн. Тийм болохоор л бидэнд төвөг удаад байгаа юм".

Арингароза өвдгөө цохиж, "Тэр Эрхэм дээдсээсээ асуугаарай! Төвөг удаад байгаа тэр Опус Дейчинь 1982 онд Ватиканы банкийг аварсан юм шүү".

"Ватикан энэ явдалд үүрд талархалтай хандсаар ирсэн" гэж нарийн бичиг хэлээд, дууны өнгө ньхүйтэн хөндий болж, "Энэ байдал нь эцэстээ та нарыг ийм бардам зантай болгоход хүргэсэн юм".гэж өгүүлэв.

Арингароза цааш тэсвэрлэхээ больж, "Та нар намайг дуугүй өнгөрнө гэж бодоо юу? Өнөөдрийнбайдлаар Опус Дей л Ватиканы дуу хоолой болж байгаа".

Нэг хамбатан түүн рүү ширтэж, "Уучлаарай, та дуу хоолой гэсэн үү?"

Арингароза ширээ тулан зогсож, үгийнхээ утгыг улам тодорхой болгохыг хичээн, "Сүмийг яагаадшүтлэгтнүүд орхиж байгааг та нар мэдэх үү? Эргэн тойрноо сайн хар! Тэд сүсэг бишрэл, итгэлүнэмшлээ гэж байна. Сүм үүний эсрэг ямар арга хэмжээ авч байгаа юм бэ?"

"Хамба Арингароза!" гэж нарийн бичиг түүнд анхааруулаад, "Танай сүм өмнөх Паптай няг тхарилцаатай байсныг мэдэх хүний хувьд, Эрхэм дээдэс танд 6 сарын хугацаа өгч, хүндлэл үзүүлжбайгаа юм шүү. Хэрвээ та Эрхэм дээдсээс өөр үзэл бодолтой байгаа бол, түүнийгээ хамгаалж,сүмээ Ватиканаас тусдаа удирдсан нь харин ч дээр биш үү?"

"Би үүнийг огт зөвшөөрөхгүй. Түүнтэй хувиараа ярилцах болно".

"Эрхэм дээдэс тантай аминчлан ярилцахгүй байх гэж би айж байна".

Арингароза босч, "Түүнд өмнөх Папын үүсгэн байгуулсан сүмийг зөнд нь орхих эрх байхгүй".

"Өршөөгөөрэй!" гэж нарийн бичиг хэлэхдээ, нүдээ огт цавчсангүй, "Эзэн бүхнийг шийднэ. Эзэнбүхнийг захирна!"

Арингораза үл ойлгосон чигтээ, уулзалтыг орхин гарч, Нью - Йоркт ирээд, цаашдын эмгэнэлт хувьзаяагаа гашуудан төсөөлж байлаа. Гэтэл хэдэн долоо хоногийн дараа, түүн рүү нэг хүн ярьсан нь

бүх зүйлийг өөрчлөв. Тэр хүн Франц гэхээр аялгатай ярих бөгөөд, өөрийгөө Багш гэж Арингарозад танилцуулжээ. Тэрээр Опус Дейг хүнд байдалд орсон тухай сонссоноо, Арингарозад хэлжээ. Арингароза ийм мэдээллийг Ватиканы хананаас гадагш гарсанд гайхахад, хариуд нь тэр хүн,

"Би их урт чихтэй хүн шүү, хамбатаан!" гэж шивэгнээд, "Хэрвээ та надад тусалбал, агуу хүчирхэгнэр нөлөөг олж, Ватиканыг өмнөө сөхрүүлэн, итгэл бишрэлээ хамгаалан үлдэж чадна. Энэ болзөвхөн Опус Дейд ч биш, бусад бүх хүнд хамаатай".

Арингароза дахин амь орох шиг болж, "Та надад дэлгэрэнгүй тайлбарлаж өгөөч".

Гэгээн Маригийн эмнэлгийн үүдээр орохдоо, Арингароза аль хэдийнээ ухаан алдсан байв. Силасдөнгөж оронгуугаа, шалан дээр сөхрөн суугаад, тусламж эрэн хаширлаа. Хүлээн авах дээр байсан хүмүүс хагас нүцгэн цагаан зүст эр болон, түүний өмнө хэвтэх хувраг хоёрыг гайхан харна.

Арингарозаг тэргэнцэрт өргөж суулгасан эмч сэтгэл түгшсэн өнгөөр, "Тэр маш их цус алдсан байна. Тун хүнд байгаа бололтой" гэж Силас өгүүлэв.

Арингароза нүдээ нээж, Силас дээр харцаа тогтоогоод, "Хүү минь! ..." гэв.

Силасын цус буцлах шиг болж, "Эцэг минь! Хэрвээ миний хоногийн тоо гүйцээгүй л юм бол, биднийг мэхэлсэн тэр хүнийг би олоод, олсон даруйдаа устгана" гэхэд Арингароза толгойгоо алгуур сэгсэрч,

"Силас!... Чи надаас юу ч сурч амжаагүй байгаа бол, яг одоо миний хэлэх ганц үгийг тогтоож ав!" гээд Силасын гарыг зөөлнөөр атгаж, "Өршөөл энэрлийг Бурхан бидэнд илгээсэн нь том аз завшаан юм шүү!"

"Гэхдээ ..."

Арингароза нүдээ аньж, "Силас, чи залбирч мөргөх хэрэгтэй!" гээд тэргэнцэр дээр түрүүлэн, түүнээс холдон одов.

Хэсэг 101

Чаптр танхим.

Лей Тийбин Роберт Ландон руу буугаа чиглүүлэн зогсоно.

"Роберт, чи бас ийм бодолтой байна уу, эсвэл надтай цуг байна уу? хэмээн их түүхчийн хэлсэн үгтүүний чихэнд ахин дахин сонсогдоно.

Үүнд хариулахад үнэндээ бэрхшээлтэй байв. "Тийм" гэж хариулбал, Софигоос урвасан болох гээд, "Үгүй" гэвэл Тийбин тэр хоёрыг алах гээд байдаг. Ландон олон жил багшлахдаа, бууны аман доорзогсох агшинд ямар хариулт өгөх ёстой тухай чадварыг огт эзэмшээгүй ч гэлээ, зарим нэгээдрээтэй асуултыг хэрхэн эвтэйхэн өнгөрөөх аргыг дэндүү сайн сурчээ. Энэ бол "Тийм", "Үгүй" гэсэн хоёр хариултын дундах "Чимээгүй байх" гэсэн 3 дахь хувилбарыг сонгох явдал юм.

Ландон нүдээ огт цавчилгүй криптексийг аваад, хойш ухарч Софи, Тий бин хоёроос

холдож зогсов.Криптексийг авсан нь нэг талаар Тийбинд итгэл төрүүлж, нөгөөтээгүүр түүний асуултадхариулаагүй нь Софигоос урваагүй гэдгийг давхар хэлж байлаа.

Ингэж л цаг хожихоос өөр арга байсангүй.

Хэрэв криптексийг онгойлгочихвол, Софиг аварч болох л юм гэж Ландон бодоод, цонх руу дөхөжочингоо, Ньютоны бунхан дээрх элдэв дүрс чимэглэлийг нэхэн санах гэж бүх анхаарлаатөвлөрүүлэв. Та нар түүний бунхан дахь бөмбөрцгийг эрж хайна. Энэ бол бүхний эхлэл болсон үртулаан жимсний тухай ... Ландон нөгөө хоёр луу нуруугаа харуулаад, санаа авчхаар зүйлсийгтанхимаас хайсан боловч, тэнд юу ч байсангүй. Сониехийн оронд өөрийгөө тавиад үзье л дээ гэжбодоод, цонхоор харагдах Коллежийн цэцэрлэгт хүрээлэн рүү ширтэв.

Сониех байсан бол шинжлэх ухаан талаас биш, хүмүүнлэг соёл, урлаг, эсвэл түүхийн сэдвээр лсэтгэх байсан даа. Ариун шүтээн ... аяга ... сарнай ... хилсээр гүтгэгдсэн Мэри Магдалин, Дарь эхбурхан ... Ариун Грейл энэ бүхэнтэй л холбоотой байх ёстой,

Цэцэрлэгийн алимны модод Ландонг шоолох шиг таван талт навчаа дэрвүүлэн, салхинд бүжнэ.Навч нь яг л Сугар гаригийн тойрог замыг санагдуулах аж. Дарь эх бурхан цэцэрлэгт ирчихсэн юмшиг түүнд бодогдов. Бороонд бүжингээ, олон зууныг өртөөлөн дуулах мэт, Ландонд ямар нэг зүйлсануулах мэт үр жимсээ гайх уулах моддыг тэрээр харж зогсов.

Танхимын нөгөө талд Тийбин түүнийг итгэл дүүрэн харцаар харна.

Миний бодсоноор болж тэр удахгүй наашаа ирнэ.

Ландоны энд байгаа нь онцгой тохиолдол биш гэдгийг Лей мэднэ. Учир нь Жак Сониех Ландонтойуулзахаар товлосон өдрийг давхцуулан, Тийбин өөрийн төлөвлөгөөгөө хэрэгжүүлж эхэлсэн юм.Сониехийг Ландонтой уулзах болсныг, Тийбин чагнах төхөөрөмж ашиглан олж мэдээд, уулзахболсон шалтгааныг нь олох гэж тэвдсэнгүй. Ландоны гар бичмэл Сионий Прайорийнхнийанхаарлыг зүй ёсоор татжээ.

Ландон үнэн рүү дөхсөн зүйлийг номондоо бичсэнд, Сониех тэр номыг олон нийтэд хэвлэгдэхийгхүсээгүй бололтой. Сионий Прайорийн тэргүүн Ландонтой уулзаж, номоо хэвлүүлэхгүй байхыгхүсэх ёстой байжээ.

Жинхэнэ үнэнийг хэдий хүртэл нуух юм бэ? гэж Тийбин бодоод, хөдөлж эхэлсэн байна. Силасынхийсэн аллага цаанаа давхар зорилго агуулсан юм байж. Нэгд, Сониех Ландоныг ятгахаассэргийлэх, хоёрт, Онъсон чулууг гартаа оруулах.

Сониех, Силас хоёрын уулзалтыг товлоход ч түүнд хэцүү байсангүй. Эрхлэгч өвгөний эмзэг хэсэгрүү нь довтолж, тэр нь байгаа оножээ.

Силас Сониех руу нэгэн ламтан болж утастаад, "Мүсьюү Сониех! Намайг уучлаарай. Би тантайярилцах хэрэгтэй байна. Ламтан хүний хувьд, би нүглээ наманчилсан хүмүүсийн тухай хэн нэгэндярьж, сахилаа зөрчихгүй байх ёстойгоо мэдэж байна. Гэхдээ үүнийг ярихаас өөр аргагүй гэжбодлоо. Надад нэг хүн танай гэр бүлийнхнийг алсан гэж өөрөө батлаад, нүглээ наманчилсан юм".

Сониех цочин адгасан ч, түүний үгэнд эргэлзсэн бололтой, "Гэр бүлийнхэн маань ослоор өөдболсон. Цагдаа нар ч үүнийг тогтоосон шүү дээ".

"Тиймээ, авгын осол гэсэн биз дээ. Тэр хүн танай гэр бүлийнхний явж байсан, машиныг хажуугаасшахаж, гол руу унагасан юм билээ".

Сониех юу ч хариулсангүй.

"Мүсьюү Сониех! Хэрвээ энэ таны аюулгүй байдалтай холбоогүй байсан бол, би тань руузгалгахгүй байхсан. Гэвч тэр бас танай ач охины чинь талаар дурссан" гэв.

Үүнийг сонсон уу, үгүй юу Сониех сэхээ авч, Силастай уулзахаар болсон юм. Тэрээр Силасыг Луврын музейн ажлын өрөөндөө тэр оройдоо дуудаж, Софи руу анхааруулахаар өдөр нь утагтсан боловч, бүсгүй утсаа аваагүй юм. Сониех Роберт Ландонтой хийх уулзалтаа хүртэл, шуудтасалжээ.

Тийбин хамтрагч хосыг хооронд нь салгасандаа, дотроо сэтгэл хангалуун байв. Софи хэдийгээртүүнийг эсэргүүцсэн дүр үзүүлэвч, Ландон харин огт өөр дүр зурагтай харагдана. Тэр нууц үгийг олох гэж оролдон, цонхны дэргэд зогсож байв. Ариун Грейлийн амин чухал хүслийг ухамсарлаж, түүнийг хүлээнээс нь суллахаар мэрийж байлаа.

"Тэр чадах байсан ч, чамд онгойлгож өгөхгүй" гэж Софи хүйтнээр өгүүлэв.

Тийбин Ландон руу харангаа, Софи руу буугаа чиглүүлэн зогсоно. Цаг нь тулахад, энэ хүйтэнзэвсгийг хэрэглэхээс өөр аргагүй. Грейл бол түүний хувьд юутай ч зүйрлэшгүй үнэтэй зүйл билээ.

Тэр агшинд Ландон эргэж хараад, "Бунхан... бунхны нууц үгийг олох шиг боллоо".

Тийбины сэтгэл уярч, "Роберт надад хэлээч дээ?" хэмээн бараг гуйж гувшив.

Софи айн балмагдаж, "Роберт! Үгүй ээ. Чи түүнд итгэж болохгүй шүү дээ".

Ландон криптексийг атгасан чигтээ, том том алхсаар ирээд, "Гэхдээ тэр эхлээд, чамайг эндээс гаргах ёстой" гэж хэлээ.

Тийбиний урам хугарч, "Бид маш ойрхон байгаа шүү дээ! Чи надтай цуг зугаацмааргүй байна гэжүү дээ?"

"Зугаацах гэнэ шүү! Түүнийг явуул. Дараа нь Ньютоны бунхан дээр хамтдаа очье. Онсон чулуугтэнд очсон хойноо онгойлгох болно".

"Би хаашаа ч явахгүй шүү! Онсон чулууг өвөө минь надад өгсөн болохоор, зөвхөн би онгойлгох ёстой" гэж Софи шаардав.

Ландон айж сүрдсэн харцаар, "Софи, гуйж байна! Чамд аюултай шүү дээ. Би чамд туслахыг л хүсч байна".

"Туслах гэнэ ээ? Чамд өвөө минь итгэж, нууцыг бүү задруулаг гэсэндээ, энэ бүхэнд оролцуулсан. Тэр чамд итгэж байсан. Би ч чамд итгэж байсан".

Ландоны царай хувхай цайчхав. Харин Тийбинд байдал ашигтайгаар эргэсэнд, түүний нүд нь сэргэнэ.

"Софи!" гэж Ландон бүсгүйг царайчлаад, "Гуйж байна. Чи яв л даа!"

Бүсгүй толгойгоо сэгерэн, "Надад криптексийг өг! Эсвэл наадахаа хагалж устга! Эс бол би эндээс явахгүй"

"Юу?" гэж Ландон уулга алдав.

"Өвөө минь криптексийг алуурчны гарт өгснөөс, устгасан нь дээр гэж хэлэх байсан" гээд Софигийн нүдэнд дүүрэн нулимс гүйлгэнээд, Тийбин рүү харж, "Эсвэл намайг буудчих!"

Биөвөөгийнхөө өгсөн зүйлийг чиний бузар саварт оруулмааргүй байна".

Сайн байна гэж Тийбин бодоод, буугаа түүн рүү онилов.

"Үгүй ээ! Хэрэггүй ээ!" гэж Ландон орилоод, криптексийг толгой дээрээ өндөрт өргөж, "Лей, чибодохын ч хэрэггүй. Үгүй бол би үүнийг хагалж орхино шүү!"

Тийбин инээж, "Наад жүжигт чинь Реми л итгэх байх. Харин би бол үгүй".

"Тийм үү?"

"Яг тийм. Покер тоглож байгаа хүн доторх бодлоо нүүрэндээ илчилж болдоггүй юм. Харин одообол чи худал ярьж байна. Ньютоны бунхан дээрээс нууц үгийг олж болно гэдэг чинь худлаа биздээ. Чи нууц үгийг мэдэж байгаа чинь үнэн юм уу?"

"Тэгэлгүй яхав".

Ландоны харц тогтворгүй байгааг, Лей анзаараад худал гэдгийг нь ойлголоо.

Ландон Софиг аврахын тулд цөхрөнгөө барсан арга сэдсэн нь илт байв. Ландоны энэ санааггадарласан Тийбиний сэтгэл гонсойчхов.

Би чинь тайж хүн байтлаа, ганцаараа Оньсон чулууг нээж дөнгөхгүй гэж үү? гэж Тийбин дотроободлоо.

Ландон, Софи хоёр хэдийгээр өчүүхэн амьтан боловч, одоохондоо Ариун Грейл, Тийбин хоёрынал алинд нь аюул занал учруулж болохоор байлаа.

Энэ сүрдүүлгээс мултрахын тулд эрүүл ухаанаар сайтар тунгаах хэрэгтэй.

Ландоныг Оньсон чулууг газар тавихыг ятгаад, Тийбин өөрийнхөө төлөвлөгөөний эцсийг үзэхөстой байв.

"Харилцан тохиролцье л доо" гээд Тийбин буугаа доошлуулж, "Оньсон чулуугаа доош нь тавьчих. Бид ярилцах хэрэгтэй байна".

Худал үг нь илэрснийг, Ландон өөрөө ойлгов. Гэвч түүнийг Оньсон чулуугаа тавьбал, Лей тэрхоёрыг буудаж хорооно гэдгийг мэдэж байв. Ландон Софитой харц тулгараагүй ч, бүсгүй түүнд юугэж хэлснийг мэднэ.

"Энэ хүн Грейлийн төлөө юу ч хийхээс буцахгүй. Юу ч болсон гэсэн түүнд Оньсон чулууг бүү өг!"

Гэвч Ландон цэцэрлэгт хүрээлэн рүү харж байхдаа, шийдвэрээ аль эрт гаргасан байжээ.

Тэр шийдвэр нь Софиг хамгаалах. Бас Грейлийг хамгаалах.

Лейг харсаар байтал, Ландон Оньсон чулууг доош газар тавихаар бөхийв.

"Зөв дөө, Роберт!" гэж Тийбин шивэгнээд, буугаа түүн рүү чиглүүлж, "Доош нь тавь" гэж тушаав.

Ландон гэнэт больж, түүн рүү эгц ширтсэнээ, "Уучлаарай, Лей!" гээд гараа хүчтэй саван, криптексийг дээш шидчихэв. Сандарсан Тийбин өөрийн мэдэлгүй гохоо дарахад, бууны сум Ландоны хөлийн дэргэд туслаа. Одоо Тийбиний хамаг анхаарал өөр зүйлд, Оньсон чулуунд чиглэжээ.

Цаг хугацаа зогсчихсон юм шиг хором бүр алгуурлахад, агаарт шидэгдсэн Онъсон чулуу дээдцэгтээ хүртэл хөөрөөд, тэндээ хэсэг тогтож байснаа, доош алгуур буусаар, чулуун шал руу эрчлэнхурдлав.

Унагаж л болохгүй шүү! гэж бодсоор, Тийбин зөн совингоороо урьтан хөдлөв. Суга таягаа хөсөрхаяад, 2 гараа сунгасаар, Онъсон чулууг арайхийн барьж авлаа. Амжилтаа дүгнэж амжаагүй байтал, эрчиндээ унаж яваагаа тэр удалгүй ойлгов. Гар нь түрүүлж газарт хүрэхэд, барьж байсан криптекснь мултарч унаад, шил хагарах чимээ дуулдав.

Тийбин хүйтэн чулуун шалан дээр амьсгалж ч чадахгүй хөсөр хэвтэнэ. Удалгүй хамар цоргисонцууны үнэр танхимаар тарж, Тийбиний хурууны үзүүрт шингэн зүйл мэдрэгдэх шиг болов.

Тийбин криптексийг шүүрч аваад, "Роберт, чи мулгуу амьтан! Нууцыг устгачихлаа шүү дээ" гэж байдгаараа хашхирав.

Тийбин өөрийгөө хянаж ч чадахаа больжээ. Тэр Онъсон чулууг онгойлгох гэж оролдвол, өөрөөнээгдчихэв. Доторхыг нь шимтэн ажигласан чинь, шингэн цууны үлдэгдлээс өөр юу ч алга байв. Цуунд ууссан папирусын ор мөр тэнд огт харагдсангүй. Тийбин шалан дээр хөрвөөн, Ландон руу эргэж харвал, Софи түүн рүү буу чиглүүлчихсэн зогсож байв.

Тийбин гайхаж, Онъсон чулуу руу эргэн харвал, үсэгтэй цагиргууд нь нийлж APPLE (АЛИМ) гэсэн үгийг эвлүүлсэн нь харагдана.

"Евагийн идсэн бөмбөрцөг хэлбэртэй зүйл буюу нүгэл хилэнцийн эх үндэс. Дарь эх шүтээний нэрхүнд унах, том шалтгаан болсон тэр зүйл буюу алим" гэж Ландон сэтгэл хангалуун өгүүлэв.

Нээрээ, алим өөрөө сарнайн дүрс хэлбэртэй үрт бөмбөрцөг шүү дээ гэж Тийбин ухан бодлоо. Ньютоны толгой дээр алим унаснаар, эрдэмтэн өөрийн шинжлэх ухаан ы онол, бүтээлийнхээ санаагож, тэр нь сүмийнхныг хилэгнүүлсэн байж таарна.

"Роберт!" гэж хэлэхдээ Тийбин түүнийг үл итгэсэн харцаар хараад, "Чи үүнийг онгойлгожээ? Газрын зураг нь хаана байна?"

Ландон энгэрийнхээ халааснаас хуйлсан папирус гаргаж ирээд, доторхыг дэлгэж уншсанаа, нүдсалгалгүй ширтэх Тийбин руу харж бүхнийг мэдсэн, бас мэдэмхийрсэн дүрээр инээмсэглэв.

Тэр бүгдийг мэдэж байна!

Тийбиний мөрөөдөл болсон тэр зүйл яг өмнө нь байгааг ойлгоод, "Надад хэлээч дээ! Гуйж байна. Ээ бурхан минь! Одоо ч оройтоогүй байна шүү дээ!"

Чаптрын танхимд олон хүний хөлийн чимээ сонсогдоход, Ландон папирусыг халаасандаа буцаажийв.

"Үгүй ээ!" гэж Тийбин хашхираад, босохоор тэмцэнэ.

Хаалга хүчтэй савагдан, Бэзү Фааш яг л бух тулаанд дуудагдсан юм шиг Лей Тийбинийг нүдээргэлдүүлэн ширүүнээр хараад, Маньюрин бугаа далд хийж, Софи руу дөхөж очив.

"Та хоёр аюулгүй байгаад би баяртай байна. Намайг дуудсан даруйд очих ёстой байсан юм".

Английн цагдаа нар ахмадын араас танхимд урсан орж ирээд, эсэргүүцэл үзүүлэх чадваргүй болсонсэжигтнийг гавлав. Софи ахмадыг харсандаа бүр гайхширч, "Та биднийг яаж олоо вэ?" ФаашТийбин рүү заагаад, "Тэр энд орж ирэхдээ, нэр усаа мэдэгдсэн юм билээ. Хамгаалагчид энэ тухайцагдаа нарт дуулгаж, тэгээд бид наашаа ирсэн юм".

"Ландоны халаасанд байгаа!" гэж Тийбин галзуурсан мэт орилоод, "Ариун Грейлийн газрын зурагтүүний халаасанд байгаа" гэв.

Цагдаа нар Тийбинийг өргөж босгоод, авч явахаар завдахад, тэрээр эргэж хараад, "Роберт, чи хаанабайгааг нь хэлээч дээ!" хэмээн гуйж гувшив.

Ландон түүний араас хараад, "Зөвхөн сонгогдсон хүн л Грейлийг олох ёстой гэж чи өөрөө хэлсэншүү дээ" гэв.

Хэсэг 102

Кенсингтоны цэцэрлэгт манан татахад, Силас эргэн тойрон юу ч харж чадахгүй болов. Нойтонзүлгэн дээр өвдөглөн суугаад, цээжнээс нь сад тавин урсах бүлээн цусаа мэдрэх шиг болно. Гэвчтэр нүд цавчилгүй чанх урагш ширтэх аж.

Манан будан энэ газрыг диваажин болгон хувиргажээ. Түүнийг гараа дээш өргөн залбиралүйлдэхэд, гар дахь цусан толбонууд нь арилж, бороон дуслууд түүний биеийг өөртөө уусгах мэтсэтгэгдэл төрүүлнэ.

Би бол сүнс.

Силас шалба норсон чигтээ, огт ажралгүй мөргөсөөр л байв. Өршөөл нигүүлсэл, Христийнэнэрлийг гуйн залбирсаар л. Түүнээс гадна Арингарозааг амьд үлдээхийг юунаас ч илүүхүсэмжлэн, амандаа шившинэ.

Дуусгах ёстой ажил үлдсэн шүүдээ!

Нүдээ аньсан чигтээ сүүлчийн мөргөлөө хийх үед, түүнийг битүү манан хуччих шиг санагдав. Гэтэл хаа нэгтэйгээс Мануэль Арингарозагийн дуу гарах шиг болж,

"Өршөөл энэрэл гэдгийг бурхан бидэнд илгээсэн нь том аз завшаан юм шүү!" гэх нь дуулав.

Силасын өвчин алгуур намдаж, хамба ламын зөв байсныг ухаарлаа.

Хэсэг 103

Үдийн нар Лондонд эгц тусахад, агаарын чийг аажмаар арилж, хуурай болж эхлэв.

Лей Тийбин өөрийгөө буруугүй гэж залхтал ярьсаар, бас Ариун Грейл, нууц баримтууд, бүлэглэлийн талаар үлгэр шиг зүйл нуршихад, шүүх дээр жүжиглэх бэлтгэлээ одооноос хийжбайна гэж Бэзу Фааш бодов.

Үнэндээ Тийбин өөрийн хийсэн бүх л алхмаа цайруулахаар, нарийн төлөвлөгөөг эхнээс нь боловсруулсан байсныг Фааш мэднэ. Ямар ч хамааралгүй байсан Ватиканы сүм, Опус Дей хоёрыгөөрийн зоргоор хутган үймүүлээд, цөхрөнгөө барсан хамба, өөрийн ухаангүй хувраг хоёрыг өөртөөашигласан байлаа. Мөн түүнчлэн, Жак Сониехийн өрөөнд чагнах төхөөрөмжийг суурилуулснаар, хөдөлгөөнийг нь хязгаарладаг саа өвчнийхөө дутагдалтай талыг нөх өж, төлөвлөгөөгөө хэрэгжүүлжчадсан. Бас түүнээс гадна, Тийбинийг мэдэх цорын ганц хүн Реми харшлын шалтгаанаар, учирбитүүлэг байдалтай үхсэн байв.

Тийбин чагнах төхөөрөмжийн тусламжтайгаар, Жак Сониехийг урлагийн бүтээлд ухаангүйдурладгийг олж мэдээд, Грекээс хөлөг баатрын өмсгөлийг дуудлага худалдаагаар авч, ШатүВиллет дэх гэртээ эрхлэгчийг урьжээ. Ингээд түүнийг зоогонд ирэхээс өмнө, өмсгөл

дотор чагнахтөхөөрөмжийг байрлуулж, хүндэт зочиндоо бэлэглэсэн нь, Жак Сониехийн ширээн дээр байнгазалраастай байх болжээ.

Фааш машины ард суугаад түр амсхийн нүдээ аньж байхдаа, амжуулах бас нэг ажил байгаагаасанав.

Гэгээн Маригийн эмнэлгийн сэхээний өрөө саруулхан харагдана. "Та биднийг бишрүүлж байнашүү!" гэж сувилагч хэлээд, түүнийг харан инээмсэглэж, "Ид шидийн юм шиг л дороо сэргэжбайна" гэв.

Хамба Арингароза хариуд нь сулхан инээмсэглээд, "Бурхан намайг адисалсан юм шүү дээ".

Сувилагч түүнийг ганцааранг нь орхин гарав. Нарны гэрэл нүүрэн дээр нь тусч ээхэд Арингарозаөнгөрсөн шөнийн уртыг гайхан эргэцүүлэв. Тэрээр цэцэрлэгт хэвтэж байгаад үхлүүт одсон.Силасын тухай бодов.

Өршөөгөөрэй намайг, хүү минь!

Урьд шөнө Бэзү Фааш Арингароза руу залгаж Силасыг гэлэнмаагийн үхэлд холбоотой эсэхийгшалгаасан юм. "Дарь эхийн сүмд нэг гэлэнмаа алагдсан байна" гэж Фааш түүнд дуулгажээ.

Өнгөрсөн шөнө бүх зүйл буруугаар эргэж байгаад, Арингароза маш их балмагдаж байв.

Чи 4 хүн алчихлаа гэж үү, Силас?

Багштай холбоо тогтоож чадахгүйгээ мэдээд, ашиглуулсан гэдгээ Арингароза ойлгожээ.

Энэ бүх жигшүүрт, аймшигт хэргийн уригийг таслан зогсоохын тулд, зөвхөн Фаашид л мэдэгдэххэрэгтэй!

Ингэж л Фааш, Арингароза нар хамтдаа Силасын болчимгүй үйлдлийг зогсоох гэж өнгөрсөншөнийн турш нэлээд хичээл зүтгэл гаргасан юм.

Гэтэл телевизээр Английн их түүхч Лей Тийбин баривчлагдсан тухай мэдээ гарч байв.

"Таныг эсэн мэнд байгаад баяртай байна, эцэг минь!"

Арингароза түүнийг сөөнгө хоолойгоор нь танив. Сүрлэг том биетэй, өргөн нүүртэй, үсээ хойшсамнасан, бүдүүн хүзүүтэй, бараан хослол өмссөн тэр хүнийг харсан даруйдаа,

"Ахмад Фааш мөн үү?" гэж Арингароза асуув.

Ахмад түүнрүү ойртож, танил хар цүнхийг үүдний сандал дээр тавиад, "Энэ цүнх таных бололтой"гэв.

Арингароза өрийн бичгээр дүүрсэн хар цүнх рүү хараад, тэр дороо ичиж,

"Тиймээ. Баярлалаа!" гээд орны даавууг хуруугаараа имэрч байснаа, "Ахмадаа би танаас нэг зүйлхүсэх гэсэн юм" гэв.

"Тэг л дээ".

"Силасын Парис дахь гэр бүлийнхэнд ..." гээд сэтгэл догдлолоо дарж ядан, "Энд байгаа мөнгөнийталыг зориулж болох уу?" гэж асуув.

Фааш түүнийг удтал ширтэж байснаа, "Ингэх боломжгүй гэж би айж байна" гэв.

Тэд хэсэгтээ чимээгүй суув.

Зурагтаар нэгэн туранхай цагдаа хэвлэлийн бага хурал дээр ярилцлага өгч байв. Фааш түүн рүүанхаарлаа хандуулав.

"Дэслэгч Коле!" гэж BBC - ийн сурвалжлагч тулгасан байртай хэлээд, "Урьд шөнө танай ахмад гэмбуруугүй 2 хүнийг аллагад сэжиглэсэн байсан. Энэ нь ахмад Фаашийн хувьд албан тушаалд ньямар нэгэн байдлаар нөлөөлөх үү?"

Дэслэгч Коле сулхан инээмсэглээд, "Ахмад Фааш бол алдаа бараг гаргадаггүй хүний нэг.

Би энэ талаар түүнтэй одоохондоо санал солилцоогүй байна. Гэхдээ ахмад Софи Нөвү, Роберт Ландон нарыг сэжиглэсэн явдал нь эцэстээ жинхэнэ алуурчныг олоход маш чухал үүрэггүйцэтгэсэн".

Сурвалжлагчид бие бие рүүгээ сониучирхсан харцаар харав.

Коле үргэлжлүүлж, "Ахмад Фаашийн арга барил үргэлж зөв байдаг. Тэр одоо гэмт хэрэгтнийгбарьсан бөгөөд, Ландон, Нөвү нар гэм буруугүй нь нотлогдож, аюулгүй газарт байгаа гэдгийгдахин баталж хэлмээр байна".

Фааш сэтгэл хангалуунаар Арингароза руу инээмсэглэн хараад, "Энэ Коле ч цахиур хагална даа" гэж дэслэгчийг магтав.

Фааш урагш унжсан үсээ хойш илж, Арингароза руу ширтээд, "Эцэг минь, Парис руу явахаасааөмнө танаас нэг зүйл тодруулахаар энд ирсэн юм. Та наашаа Лондон руу ирэхдээ, онгоцнынисэгчид хахууль өгсөн гэж дууллаа. Энэ чинь олон улсын хилийн тухай хуулийн хэд хэдэнзаалтыг зөрчсөн гэсэн үг шүү дээ!"

Арингароза давхийж, "Өөр аргагүй байсан юм" гэж учирлав.

"Тийм байх. Манай хүмүүс нисэгчийг баривчлахад, тэр бас тэгж хэлсэн" гээд Фааш том гэгчийналмазан шигтгээтэй бөгж халааснаасаа гаргаж ирэв.

Арингарозагийн нүднээс нулимс асгарч, бөгжийг аваад хуруундаа зүүв.

"Та их тусч хүн юм" гээд хамба Фаашийн гарыг атгаж, "Баярлалаа!" гэж чин сэтгэлээсээ хэлэв.

Фааш босч цонх руу очоод, алсыг ширтэн бодлогошров. Дараа нь хамба руу эргэж хараад, "Эцэгминь, та эндээс хаа хүрэх вэ?" гэж асуув.

Урьд шөнө Кастел Гандольфод очихдоо бас ийм асуултад хариулж байснаа, Арингароза санаад, "Мэдэхгүй л байна даа. Яг л тан шиг би бас хаа хүрэхээ мэдэхгүй л байна".

"Тийм ээ. Би ч бодсоноосоо эрт чөлөөндөө гарах бололтой".

Арингароза инээмсэглэж, "Өчүүхэн итгэл ч гэсэн гайхамшгийг бүтээдэг юм шүү, ахмад аа!" гэлээ.

Хэсэг 104

Нууцын өлгий сүм гэгддэг Рослин бол Шотландын Эдинбургээс урагш 6 милл зайтай газарт байдагбилээ. 1446 онд түүнийг Христийн Хөлөг баатруудын холбоо байгуулж, одоо

бүхий л шашныурсгалын тэр дотроо, Христийн, Католикийн, Египетийн, Мэйсоны, Шашингүйн урсгалынхныбэлгэдэл дүрс тэнд хаа сайгүй байдаг юм.

Роберт Ландон, Софи хоёр Рослинийн үүдэнд ирж, машинаас буухад, үдийн нар хэвийгээд сүүдэрхүүшилж байв. Тэд Лондоноос Эдинбург орох богино зайн нислэгийн турш, замдаа огтхон ч амарччадаагүй ажээ.

Рослинийн уран хийцтэй үүд рүү ширтэнгээ, Роберт өөрийгөө гайхамшгийн оронд очсон Алисагуулайн гэр нүх рүү орох гээд зогсож байгаа мэтээр төсөөлөв.

Би зүүдэлж байна уу даа?. гэж тэр бодов. Гэвч Сониехийн бичсэн шүлэгт зөвхөн энэ л газрыгдурдсан байсан шүүдээ!

Эртний Рослиний доор Ариун Грейл хүлээж байгаа.

Ландон өмнө Грейлийн газрын зураг гэхээр, дээр нь хэрээсээр зурж тэмдэглэсэн, байршлын зурагмэтээр бодож байсан юм. Гэхдээ Ландон шүлгээс Рослиний тухай олж мэдэхдээ огтхон ч гайхаагүйюм. Угаасаа олон зууны турш, Рослин Ариун Грейлтэй нягт холбоотой байсаар ирсэн. Гэтэл бүрэрдэмтдийн тогтоосноор, Рослин доор нууц, том хонгил байгаа гэсэн нотолгоо тэр чигтээ шуугиантарьж байсан билээ. Үүнээс хойш энэ газар нууцыг сонирхсон мөргөлчдийн хөлд дарагдах болжээ.

Ландон өмнө нь энд ирж байгаагүй боловч, Рослинийг Ариун Грейлийн өлгий болсон газар гэжхүмүүс ярих бүрд, дотроо тэднийг шоолон тохуурхдаг байв.

Өмнө нь ийм байсан байж болно. Харин одоо бол үгүй!

Гэтэл одоо болохоор, Сионий Прайорийн Онъсон чулуунд энэ газрыг гэж хэлж байгаа болохоор, Ландон өөрийн өмнөх бодлоо таягдан хаяхаас өөр аргагүй байв.

Сониех яагаад Рослиний тухай дурдсан юм бол?

Үүнд хариулах ганц л уялдаа холбоо байгаа. Энэ бол Рослинд тэр хоёрын олж мэдэж амжаагүй, өөрзүйл байгаа гэдэг таамаглал байв.

"Роберт!" гэж Софи түүнийг дуудаад, "Энд чамд жигтэй санагдахгүй байна уу?" гэж хэлэхдээ, гартаа Сарнайн дүрст хайрцгаа барьжээ.

Ахмад Фааш хайрцгийг тэдэнд буцааж өгсөн юм. Өнөөх криптексүүд яг л анх байсан шигээхайрцаг дотор давхралдан байх ажээ. Дотор нь шилтэй цуу л байхгүй болохоос. Папирус ньхуйлаастай чигээрээ байж байв.

Тэднийг сүмийн барилгад дөхөж явах замд, нэгэн том хана үзэгдэх бөгөөд, ихэнх энгийн жуулчидтүүнийг баригдаж дуусаагүй хана гэж таамагладаг боловч, үнэндээ энэ бол маш онцгой хана ажээ.

Энэ ханыг Соломоны сүмийн баруун хананы тууриас санаа авч хийсэн байв. Өөрөөр хэлбэл, Хөлөгбаатруудын холбоо Соломон хааны сүмийг дуурайлгаж, Рослинийг барьсан гэж үздэг. Иерусалимдахь Соломон хааны сүмийн баруун хананы эгц доороос Хөлөг баатрууд хайж байсан үнэт эрдэнээолж авсан гэдэг.

Энэ бүхнийг давган өгүүлж байгаа мэт сэтгэгдэл Ландонд эрхгүй төрнө.

Ландоны төсөөлж байснаас, Рослиний үүдний хаалга энгийн даруу хийцтэй байв.

Жижиг модонхаалган дээр жижиг, хос төмөр бариул байх аж.

Энэ бол Рослин.

Энэ үг бол Сарнайн судал (RoseLine - Rosslyn) гэсэн үгний хувирсан хэлбэр бөгөөд, Грейлсудлаачид үүнийг одоо хүртэл Мэри Магдалинийг бэлгэдсэн бэлгэдэл гэж үздэг юм.

Энэ мөргөлийн газар удахгүй үүдээ барих гэж байгаа тул, Ландон яаравчлан хаалганы бариулаастатан онгойлговол, өдрийн турш бүгчимдсэн барилга бүлээн агаараа түүний өөдөөс үлээх нь, халууцсан хүн амьсгаагаа гарган, санаа алдаж байгаа юм шиг санагдав.

Доторхыг ажиглан харвал, дарь эх шүтээний бэлгэдэл болсон Сарнайн дүрс энд тэндгүй харагдана.

Ландоны нэг найзынх нь хэлснээр ёстой л "Дүрс бэлгэдлийн диваажин болсон газар" гэж хэлэхээр ажээ. Христийн загалмай, Жүүдийн од дүрс, Мэйсоны дүрс тэмдгүүд, Хөлөг баатруудын холбооныхэрээс дүрст шүтээн, пирамид, зурхайн тэмдэгтүүд, од гариг, эрхэс, ургамал, цэцэг, Сарнай, Таванхошуу зэрэг олон дүрсийг эргэн тойрон урлан шигтгэжээ. Мэйсоны ахан дүүс уран барилгынхосгүй авьяасаа энд эрхгүй шингээсэн нь илт байв.

Хэсэг жуулчдыг эс тооцвол, тэнд бараг хүнгүй шахам байв. Ажлын цагийнхаа сүүлчийн мөчийг хүртэл заавар, зөвлөгөөг хичээнгүйлэн хэлэх, тайлбарлагч залуу бас тэнд байв. Залуу тэр хоёрынорж ирэхийг анзаараад, хэдийгээр хаах цаг болсон ч гэсэн, найрсгаар хүлээн авч буйгаа илтгэн, эелдгээр инээмсэглэв. Ландон хариу толгой дохиж, дотогш нэвтрэн ороход, харин Софи байсан газартаа хөшчихсөн, мэл гайхаж зогсов.

"Яасан бэ?" гэж Ландон асуув.

Софи эргэн тойрноо харснаа, "Би энд...энд өмнө нь ирж байсан юм шиг сан агдаад байна".

Ландон үүнд гайхаж, "Гэхдээ чи Рослиний тухай өмнө нь сонсоогүй гэж надад хэлсэн шүү дээ".

"Тийм л дээ" гэж хэлээд, Софи эргэлзээгүйгээр, "Өвөө намайг бага байхад, энд авчирч байсан ч юмшиг... Би сайн санахгүй байна. Гэхдээ л энэ газар надад танил дотно санагдаад байх юм".

Сүмийн доторхыг ажиглах тусам, бүсгүйн эргэлзээ арилж, "Тиймээ. Би энд байснаа санаж байна. Энэ хос баганыг санаж байна".

Ландон тэр зүг хараад, хос багана харагдах бөгөөд, цонхоор тусах нарны гэрэлд тал хэсэг нь гэрэлтээд, харин нөгөө тал нь сүүдэртээд, их л өвөрмөц байдалтай үзэгдэх аж. Софи тийш ойртож очиход, Ландон түүний араас дагав.

Бүсгүй итгэл дүүрэн харцаар толгой дохиж, "Тиймээ. Би энд ирж байснаа санаж байна".

"Чамайг будлиж байгааг ойлгож байна. Энэ хос багана ганцхан энэ сүмд ч байдаггүй юм".

Софи эргэж хараад, "Юу гэсэн үг вэ?"

"Эдгээр багануудын хуулбарууд дэлхийн өнцөг булан бүрт байдаг юм".

"Рослиний баганыг дуурайлгаж хийсэн гэж үү?" гэж бүсгүй асуув.

"Үгүй дээ. Рослин өөрөө хуулбар барилга гэдгийг би чамд өмнө нь хэлсэн шүү дээ. Эдгээр хосбагана бол Соломоны сүмийн баганыг дуурайлгаж хийсэн юм шүү дээ. Мөн түүнчлэн Мэйсонызагвараар хийгдсэн, бүх барилгад ийм хос багана заавал байдаг юм".

"Би Мэйсоны загвартай иймэрхүү барилгад өмнө нь очиж байгаагүй" гэж Софи хэлээд, хос баганыгдахин ширтэнгээ, "Би баганыг энд л харсан гэж санагдаад байна".

Тэр сүм доторх бусад зүйлийг нэгжин харж, дурсамжийг нь сэргээж болох өөр зүйл хайж гарав.

Жуулчдыг гаргаж өгөөд, тэдэн рүү дөхөн ирж буй, тайлбарлагч залуу эелдгээр инээмсэглээд,

"Манайх удахгүй хаах гэж байна. Та бүхэнд юугаар туслахсан бол?" гэж асуув.

Тэрээр маш царайлаг бөгөөд, 20 дөнгөж шүргэж байгаа гэмээр харагдаж байв.

"Энд код ..." гэж Софи өөрийн мэдэлгүй дуу алдаад, "Энд код байх ёстой!"

Тайлбарлагч түүнийг сайшаасан байдлаар харж, "Тиймээ, хатагтай тэнд код байдаг юм".

"Тэр таазан дээр байх ёстой" гэж Софи хэлээд, баруун талын ханыг дагуулан дээш хараад, "Тэрхавьд л байх ёстой" гэв.

Залуу инээмсэглэж, "Та Рослинд өмнө нь ирж байсан бололтой" гэв.

Ландон тэрхүү кодын тухай бодов. Ихэнх хүмүүс энд бичигдсэн, нууц оньсого мэт дүрс - кодынуггыг тайлж чадвал, дээврийн хөндийг онгойлгож чадна гэж үздэг бол, үлдсэн хэсэг нь Грейлийнтүүхийг таазан дээр өгүүлсэн гэж таамагладаг.

Хэрэв эндхийн кодыг үнэн мөнөөр тайлбал, маш өндөр шан харамж өгнө хэмээн сүмийнудирдлагаас амласан хэдий ч, кодыг тайлсан хүн одоог хүртэл гарч ирээгүй байгаа юм.

Миний тайлсан анхны код! гэж Софи бодов.

Тэрээр модон хайрцгаа Ландонд өгөөд, өнөөх таазны доор зогсохдоо, анх энд ирсэн тэр үеэ дурсансанав.

Софи тэр үед балчир охин байжээ. Гэрийнхэн нь осолдсоноос хойш, жилийн дараа байсан боловуу. Өвөө нь түүнийг Шотланд руу амралтаараа авч явжээ. Тэд Парис руу харихын өмнө энд ирсэнбайж. Орой болж, сүм үүдээ барьсан байсан ч, өвөө ач охин хоёр сүмд байсаар л байсан юм.

"Өвөө эндээс явья л даа" гэж ядарч туйлдсан бяцхан Софи гуйхад,

"Одоохон, хонгор минь! Тун удахгүй. Энд өвөөд нь амжуулах ажил байна. Чи эсвэл намайгмашинд хүлээж байх юм уу?"

"Та бас л нөгөө нууц санаагаа сэдээд байна уу?" гэснээ охин гэнэт "Өвөө би дахиад код тайлжболох уу? Хөгжилтэй санагдаад байна"

"Харин л дээ. Чи энд ганцаараа байхаас айхгүй юу? Би гадаа гарчихна шүү дээ".

"Яалаа гэж дээ!" гэж охин унтууцаад, "Харанхуй болоогүй байхад"

Өвөө нь инээмсэглэж, "Маш сайн байна" гээд, охиныг нөгөө таазны дор дагуулж аваачихад, Софишалан дээр нуруугаараа хэвтээд, "Би таныг эргэж ирэхээс өмнө, энд байгаа кодыг тайлчихна" гэжхэлэв.

"Тэгвэл хоёулаа уралдья!" гэж өвөө нь хэлээд, түүний дээрээс бөхийж, духан дээр нь үнсэв.

"Би удахгүй ирнэ! Хаалга онгорхой орхичихье. Хэрэг гарвал өвөөгөө шууд дуудаарай!" гэв.

Софи тэнд хэвтэж байтал, нүд нь анилдаад явчхав. Дээр харагдах дүрсүүд учир утгагүй болсноо, удалгүй харагдахаа больчихлоо. Хүйтэн шал түүний дороос жиндүүлэхэд, Софи аргагүйн эрхэндсэрчхэв.

"Өвөө?!"

Хариу дуугарсангүй. Тэр босч, нүдээ нухлаад, онгорхой хаалгаар гадагш харвал, нар жаргаад, альхэдийн харанхуй болж байв. Охин гадагш гарч харвал, тэндээс холгүй нэгэн байшингийн үүдэндээр өвөө нь үл таних нэг хүнтэй ярилцаад зогсож байв.

"Өвөө?!" гэж охин дуудав.

Өвөө нь түүн рүү эргэж хараад, түр хүлээ гэсэн дохио өгч, гараараа даллав.

Удалгүй өвөө нөгөө хүнийг үнсчихээд, охин дээр ирэхдээ, нүдэнд нь нулимс гүйлгэнэж байв.

"Та яагаад уйлаа вэ өвөө?"

Өвөө нь түүнийг тэвэрч, энгэртээ наагаад, "Софи минь дээ! Энэ жил бид хоёр мөн ч олон хүнтэйсалах ёс хийлээ дээ. Өвөөд нь хэцүү байна".

Салах ёс гэхээр нь аав, ээж, дүү, эмээ нарыг хэлж байна гэж Софи таамаглаад, "Та бас өөр хүнтэйсалах ёс гүйцэтгэсэн юм уу?" гэж асуув.

"Тиймээ. Миний хамгийн дотнын, хайрт найз минь байгаа юм" гээд сэтгэл хөдлөлөө нуулгүйхэлээд, "Би тэр хүнтэй удаан хугацаанд уулзахгүй гэхээс, сэтгэл өвдөөд байна" гэв.

Ландон тайлбарлагч залуутай хамт, модон хайрцгаа бариад зогсож байв.

Одоо модон хайрцгийн хэрэг гарахаа ч өнгөрсөн байх аа! гэж тэрээр бодохын сацуу, Жак Сониехямар учраас шүлэгтээ Рослинийг дурдсан болохыг олж ядна.

Шүлэгт дурдсан эр, эм бэлгэдэл дүрсийг Ландон эндээс олж харахгүй байв.

Эртний Рослиний доор Ариун Грейл хүлээж байгаа.

Эр, эм бэлгэдэл дүрсээр замчлуулж түүнийг олоорой!

Ландон бас л аз дайрах мөчийг хүлээхээс өөр аргагүйгээ ойлгов.

"Би хошуугаа дүрж хүний хэрэгт оролцох дургүй л дээ" гэж тайлбарлагч залуу гэнэт хэлээд, Ландоны гар дахь Сарнайн дүрст хайрцгийг ажиглангаа, "Гэхдээ энэ хайрцгийг та хаанаас авсан юм бэ?"

Ландон сулхан инээмсэглээд, "Энэ тухай яривал их урт түүх болно" гэв.

Залуу түгдэрч байснаа, "Сонин юм даа! Манай эмээд бас яг ийм хайрцаг байдаг юм. Дотор нь үнэтэдлэлээ хадгалдаг, дээрээ сарнайн дүрстэй, бариул нь хүртэл адилхан юм".

Ландон залууг андуурсан гэж таамаглаад, "Төстэй байж магадгүй. Гэхдээ ..."

Гэтэл хаалга хаагдах чимээ гарч, Софи зэргэлдээх байшин руу очихоор сүмээс гараад Гүйж байх ньхарагдав. Энд ирснээс хойш бүсгүйн ааш араншин их хачирхалтай болоод байгааг, анзаарангаа Ландон хойноос нь дагаж гарахаар болов.

"Тэр байшин ямар учиртай юм бэ?" гэж Ландон залуугаас асуув.

"Рослиний сүмийн эрхлэгчийн гэр байгаа юм. Манай эмээгийнх. Эмээ маань Рослиний

удирдлагынтэргүүн".

"Танай эмээ чинь Рослинийн удирдлагыг тэргүүлдэг юм уу?"

Залуу толгой дохиж. "Би эмээтэйгээ хамт амьдарч, эндхийн ажилд нь тусалдаг юм" гэв.

Тэрээр мөрөө хавчаад цааш нь, "Би бараг бага байхаасаа л энд өссөн дөө. Эмээ маань намайг хүнболгосон юм".

Ландон Софид санаа зовоходоо хаалгаар гарч, бүсгүйг дуудахаар яаравчлав. Гэтэл тэр мөчид түүнийтолгойд нэгэн бодол харван орж ирэхэд, Ландон залуу руу эргэж хараад, дараа нь хайрцаг рууширтсэнээ, "Эмээд чинь бас ийм хайрцаг байдаг гэж чи хэлсэн үү?"

"Тийм. Маш адилхан".

"Эмээ чинь хаанаас авсан юм бол?"

"Өвөө хийж өгсөн гэсэн. Өвөө намайг багад нас барсан ч, эмээ одоо болтол түүний тухай дурсаньярдаг. Өвөөг маш уран гартай хүн байсан гэж эмээ хэлсэн".

Ландон зах сэжүүрээс нь олж харсан бололтой, "Эмээ чинь чамайг өсгөсөн. Тэгэхээр эцэг эх чиньяасан юм бэ?" бага байхад, тэд

Залуу түүнийг гайхсан харцаар харж, "Намайг өвөөтэй хамт явж байгаад осолдсон гэсэн".

Ландоны зүрх нь булгилж, "Авгын осол байсан уу?"

Тайлбарлагч бүр мэл гайхсан бололтой, "Тийм. Машины ослоор. Гэр бүлийнхэн маань бүгд нэг дорослоор нас барсан. Өвөө, аав, ээж бас..." гээд толгойгоо гудайлган гуниглахад, Ландон залгуулж,

"Бас эгчийгээ алдсан уу?" гэв.

Софи гүйсээр байшин руу очиход, түүний төсөөлсөн шиг янзаараа байв. Харуй бүрий болж байсанч, байшингаас нэг л дотно төрх харагдах аж. Жижиг цонхтой онгорхой хаалгаар, жигнэсэн талхныгүнэр хамар цоргино. Цонхоор гэрэл тусч байхыг хараад дөхөж очвол, байшинд хэн нэгнийцурхиран уйлах дуу сонсогдов. Хаалганы цонхоор дотогш шагайвал, настай эмэгтэй цаашаа харчихсан, уйлаад сууж байв. Тэр эмэгтэй жаазтай зураг барьчихсан, түүнийг алгаараа илээд, уйгашууд бүр мөсөн авгсан байдалтай байлаа.

Софи зургийг харвал, өвөөгийнх нь зураг яахын аргагүй мөн байна. Тэр эмэгтэй Жак Сониехийн нас барсныг өнгөрсөн шөнө олж мэджээ.

Софигийн хөл доорх модон шал шажигнан дуугарахад, нөгөө эмэгтэй алгуур эргэж харав. Бүсгүйтэндээс зугтах гэж оролдсон боловч, хамаг бие нь хөшиж орхижээ. Эмэгтэй Софиг харсан даруйдаа эргэлзэж дараа нь үл итгэсэн төрхтэй болж, удалгүй итгэж найдсан төрх царайдаа тодруулсаар, эцэст нь баяр хөөр дүүрэн харцаар түүнийг харав.

Настай эмэгтэй тэр дороо хаалга саван гарч ирээд, Софигийн хацрыг зөөлхөн илбээд,

"Ээ, охин минь! Чи өөрийгөө хар даа!"

Софи эмэгтэйг огт танихгүй боловч, хэн гэдгийг нь зөнгөөрөө ойлголоо. Бүсгүй үг хэлэх гэсэн боловч, амьсгал ч авах тэнхэлгүй болжээ.

"Софи!" гэж эмэгтэй хэлээд, түүний духыг нь үнсэв.

Софи ээрч түгдрэн, "... өвөө таныг хэлэхдээ ..." гэж бараг шивэгнэх шахам ярих аж.

"Тийм ээ! Би мэднэ" гэж эмэгтэй хэлээд, Софигийн мөрөн дээр гараа зөөлөн тавьж, "Өвөө, бидхөөр чинь маш олон зүйлийг нууж далдалсан. Тэгэхээс ч өөр аргагүй байсан юм. Намайг уучил,охин минь! Энэ бүгд чиний л төлөө байсан юм шүү дээ, гүнжхэн минь" гэв.

Софи түүний хэлсэн сүүлчийн үгийг сонсоод зогтосав. Өвөө нь түүнийг олон жилийн өмнө ийнхүүдуудаж байсныг санав. Өвөөгийнх нь дууны цуурай Рослинд хүртэл хадаж байхыг, Софи сэтгэлдээтөсөөлөн эргэцүүлээ.

Эмээ нь түүнийг тэврэн авч асгартал уйлангаа, "Өвөө чинь чамд бүх үнэнийг хэлэх гэж хэчнээн иххичээсэн гэж бодно. Гэвч санаснаар нь болоогүй юм. Тэр чамд их зүйлийг ярих байсан юм. Ихзүйлийг ч тайлбарлах байсан юм" гээд Софигийн духыг дахин үнсээд, "Одоо нууц гэж байхгүй,гүнж минь! Чи гэрийнхнийхээ жинхэнэ үнэнийг мэдэх цаг нь одоо болсон" гэж чихэнд нь барагшивэгнэх шахам хэлэв.

Софи эмээтэйгээ цуг байшингийн гадаах шатан дээр тэврэлдэн суугаад, элгээ дэвтэл уйлж суув.

Тайлбарлагч залуу тэдэн рүү дөхөж ирээд үл итгэсэн боловч найдвар тээсэн харцаар, "Софи юу?" гэж арайхийн асуув.

Софи нулимсаа ч арчаагүй чигтээ босч, толгой дохиод, огт танихгүй ч гэсэн судсаар нь ижил цусгүйж буй залуу дүүгээ зөнгөөрөө танилаа.

Ландоныг тэдэн рүү ойртож ирэх завсар, Софи одоогийн байгаа байдалдаа огтхон ч итгэж чадахгүйбайв. Өчигдөрхөн л хорвоо дээр орь ганцаараа гэж тэрээр бодож байсан ч, өнөөдөр энд огт өөргазар ирсэн хойноо, гэртээ харьчихсан, гэрийнхнээ олчихсон баяр хөөрөөр бялхаж байв.

Хэсэг 105

Рослин түнэр харанхуйд автжээ. Роберт Ландон үүдний довжоон дээр ганцаараа зогсоод,байшингийн дотроос сонстох баяр хөөртэй яриаг чагнан байв. Гартаа Бразил кофе барьчихсан үе үеочихдоо, алжаал ядаргаа аяндаа гаран арилж байгааг мэдэрнэ.

"Чи ийшээ чимээгүйхэн гараад ирээ юу?" гэх дуу түүний ард гарав.

Ландон эргэж хартал, Софигийн эмээ ард нь зогсож байв. Тэр эмэгтэй 25 жил гаруйн өмнө, МэриШавель нэртэй байжээ.

Ландон хариуд нь инээмсэглээд, "Би та нарыг тухтай ярилцаг гэж бодсон юм" гээд цонхоор дотогшхартал, Софи дүүтэйгээ дотно яриа өрнүүлэн сууж байв.

Мэри түүний дэргэд ирж зогсоод, "Ноён Ландон! Би нөхрөө алагдсаныг сонсоод, хамгийн түрүүндСофигийн төлөө санаа зовж байлаа. Түүнийг энд ингээд харсан даруйдаа, хэчнээн их баярлаждогдолсон гээч. Би танд талархаад ханахгүй байна".

Ландон хариуд нь юу гэж хариулахаа мэдэхгүй байв.

Мэригийн нөхөр түүнд итгэсэн болохоор, эмэгтэй ч бас итгэх ёстой гээд Ландонтай ярилцахыгхүссэн юм. Мэри Софигийн эцэг эхийн талаар ярьж эхлэхэд, Софи, Ландон хоёр зэрэгцэн суугаад,түүний ярихыг шимтэн сонсож байлаа.

Бүсгүйн эцэг эх Меровингийн овгийн хүмүүс байжээ.

"Меровингийн овог бол Есүс Христ, Мэри Магдалиний үр хойч юм шүү дээ!"

Софигийн эцэг, эх хоёрын аюулгүй байдлыг хангахын тулд, тэдний Плантард, Санткай гэсэн овгийн нэрийг бүр мөсөн сольжээ. Тэдний үр хүүхдүүд язгууртны удам угсааг залгамжлан, үлдэж, Сионий Прайорийн хараан дор сайтар хамгаалуулж байжээ. Гэнэт Софигийн эцэг эх хоёр ослоорөөд болоход, шалтгаан нь учир битүүлэг байсан тул, Сионий Прайорийнхан язгууртны удам угсаагилэрсэн байх вий хэмээн сэрэмжилсэн аж.

"Өвөө, бид хоёр чинь ..." гээд Мэри сэтгэл өвдсөн дуугаар, "... чиний эцэг эх нас барсныг утсаарсонсоод даруй хөдөлж, зарим нэг чухал шийдвэр гаргахаас аргагүй болсон юм" гээд нүднээс нь нулимс бөмбөрч,

"Тэр орой гэр бүлээрээ, бүгд 6 хүн зугаалахаар төлөвлөж байсан юм. Аз болж өвөө, бид хоёр чинь бодлоо өөрчлөөд, та хоёрыг авч үлдэхэд эцэг, эх чинь зугаалахаар явсан. Ослын тухай сонсоод, бид хоёр тэр дороо балмагдаж, үнэн худлыг олж мэдэлгүй, хэсэгтээ л сандралдсан".

Мэри ач охин Софи руугаа харж, "Бид хоёр ач нараа хамгаалахын тулд, зөв гэж бодсоноо л хийсэн. Жак цагдаа руу утастаж, намайг болон дүүг чинь тэнд хамт байсан гэж худал мэдүүлээд, бид хоёрыг ор сураггүй болгож, олны нүднээс хаацайлсан юм. Харин өвөө чинь Сионий Прайорийн тэргүүн байсан болохоор, ор сураггүй алга болж болохгүй байв. Ингээд арай том байснаар нь, чамайг Жактай хамт үлдээж, чамд бүхнийг зааж сургахаар шийдсэн юм. Гэр бүлийн хүмүүс тустусдаа амьдарна гэдэг жинхэнэ там байлаа. Өвөө, бид хоёр чинь маш ховорхон уулзалдаж, Сионий Прайорийн нэгэн ёслол, тэмдэглэлт өдрөөр л бие биенийхээ царайг арай гэж олж хардаг байсан".

Ландон үүнийг сонсонгуутаа, өөрт нь зориулж яриагүй болохыг ойлгоод гадагш гарлаа. Тэрээр Рослинд байгаагаа гэнэт санах.

Ариун Греил Рослинд байгаа юм гэж үү? Тийм бол шүлэгт дурдсан эр, эм бэлгэдэл дүрсүүд хаана байгаа юм бол?

"Надад наадахаа өгчих" гэж Мэри хэлээд, Ландоны гар луу заав.

"Өө, тэгье. Баярлалаа!" гээд Ландон хоосон аягаа эмэгтэйд өглөө.

Мэри түүн рүү харж, "Би нөгөө гар дахыг чинь хэлсэн юм, ноён Ландон!"

Ландон гар дахиа харвал, Сониехийн бичиж үлдээсэн шүлэгтэй цаас байлаа. Тэрээр зарим нэгүгийг мартчихаад, дахин харах гэж цаасыг гаргаж ирсэн байж.

"Өө, тийм. Тэгэлгүй яахав. Уучлаарай!"

Мэри түүнээс цаасыг авсандаа сэтгэл нь ханаж, "Парис дахь нэгэн банкны захирал Сарнайн дүрстэй хайрцгийг эргүүлж олж авахын хүслэн болчихсон сууж байгаа. Жакийн дотнын анд Андре Вехне бол маш итгэлтэй хүн шүү. Жакийн захиснаар, хайрцгийг олж авахын төлөө, тэр юу ч хийхээс буцахгүй байгаа байх даа".

Хүнд буу тулгах хүртлээ итгэл хүлээсэн байж шүү! гэж Ландон Вехнегийн тухай бодоод, түүний хамрыг хугартал цохисондоо ичих учир, Мэрид энэ тухай ярьсангүй.

Парис дахь тэргүүлэгч 3 гишүүний үхлийн тухай Ландон гэнэт санаад,

"Сионий Прайори одоо юу болох бол?" гэж асуув.

"Байдаг янзаараа л байх болно, ноён Ландон. Ахан дүүсийн холбоо хэдэн зууныг дамжсаар ирсэн, дамжсаар ч байх болно. Зарим нэг зүйл устаж алга болдог ч, нөхөн шинэчлэгдэх нь илүү түргэнбайдаг шүү дээ".

Ландон Софигийн эмээг Сионий Прайоритай нягт холбоотой гэж энэ үдшийн турш бодсоор яваабилээ. Үнэндээ Сионий Прайори бол эмэгтэй гишүүдээс бас бүрддэг байж болох л юм.

Тэргүүлэгч 4 гишүүний ард тэдний гэр бүлийн хүмүүс нь байгаа. Тийм болохоор эрэгтэй гишүүдээсээ ч илүүтэй эрх үүрэг хүлээсэн хүмүүс нь эмэгтэйчүүд байж болно шүү дээ!

Ландоныг Уэстминстерт байхад нь, Лей Тийбиний хэлсэн үгийг санах. Түүний хэлсэн үг бараг лхэдэн жилийн өмнөх шиг түүнд санагдана.

"Ертөнцийн төгсгөл ирэхэд, нөхрийг чинь Сангрийлийн баримтаа дэлгэж тавихгүй байхыгсүмийнхэн анхааруулж сүрдүүлсэн үү?"

"Бурхан минь, яалаа гэж?! Ертөнцийн төгсгөл гэдэг ойлголт чинь өөрөө буруу ташаа зүйл байхгүйюу. Сионий Прайорийн сургаал номлолын алинд ч Грейлийг задруулан дэлгэх ёстой гэсэн утгатайзүйл байхгүй. Харин ч Грейлийн нууцыг үүрд задруулахгүй байх үүргийг Сионий Прайорихүлээсэн юм".

"Үүрд гэнээ?" гээд Ландон мэл гайхав .

"Хамаг учир Грейлд байгаа юм биш. Харин бидний зүрх сэтгэлийн гүн дэх нууцад байгаа юм. Грейл бидний эргэн тойрон, хаа сайгүй оршиж байгаа" гээд Мари Рослин руу ширтэж, "Зарим хүнд Грейл бол мөнхийн амьдрал бэлэглэх тэр зүйл мэт санагддаг, өөр нэгэнд бол мартагдсан нууцтүүхийг илчлэх баримт гэж бодогддог. Харин ихэнх хүмүүс Грейлийг хэзээ ч гарт баригдашгүйтийм оюунлаг хийсвэр төсөөлөл гэж үздэг".

"Хэрвээ Сангрийлийн баримтууд үүрд нууц хэвээрээ үлдвэл, Мэри Магдалиний түүхийг хэн ч олжмэдэхгүй шүү дээ !"

"Тийм гэж үү? Чи эргэн тойрноо сайн хар! Мэри Магдалиний үнэн түүх урлаг, хөгжим, уранзохиолд аль хэдийнээ тусгалаа олсон. Олсоор ч байгаа. Харин одоо ариун шүтээнээ авранхамгаалах цаг ирснийг бид бүгд ухаарч байна. Чи ариун шүтээний талаар нэг ном би чиж байгаагэсэн үү?"

"Тийм"

Мэри инээмсэглэн, "Түүнийгээ дуусгаж, түргэн хэвлэж гарга, Ландон! Мэри Магдалин дууланбүжиглэг л дээ. Одоо энэ ертөнцөд шинэ хэмнэлтэй бүжиг хэрэгтэй".

Тэр мөчид Ландонд үүрэг хариуцлага ногдож байгааг ухаарав.

Саран авхай дээр хөөрч, Гурван марал одны ойролцоо тодрон гарч ирэв. Ландон Рослин руухараагаа бэлчээж, нууцыг мэдэх хүслэндээ тэсгэлгүй автана.

Битгий асуу! Цаг нь хараахан болоогүй байна гэж өөртөө тушаана.

Тэр Мэригийн гар дахь цаас руу нэг харж, Рослин руу бас дахин хартал,

"Танд асуух зүйл байна уу?" гэж Мари инээмсэглэн хэлээд, "Та надаас ямар нэг зүйл асуух бүрэнгавьяатай хүн шүү дээ".

Ландон бантсандаа болоод, огт дуугарсангүй.

"Та Грейлийг энд, Рослинд байгаа үгүйг мэдмээр байна уу?"

"Та хэлж болох юм уу?"

Мэри гүнээр шүүрс алдаад, "Хүмүүс яагаад Грейлийг зүгээр орхичхож болдоггүй юм бол?" гээдинээд алдаж, "Яагаад чи энд байгаа гэж бодоо вэ?"

Ландон түүний гар дахь цаас руу дохиж, "Нөхөр чинь шүлэгтээ Эр, эм бэлгэдэл дүрсээр замчлуулжолоорой! гэж бичсэн байсан. Гэхдээ би тэдгээр дүрсийг эндээс огт олж харсангүй".

"Эр, эм дүрсийг үү? Тэдгээр дүрсүүд юуг бэлгэдсэн гэж чи бодож байна?"

Мэри тоглоом шоглоом хийж зориуд асууж байгааг, Ландон ойлгосон ч, дүрсний учрыгтайлбарлав.

Мэригийн царайд бүдэг бадаг зүйл санагдсан мэт төрх тодроод, "Өө нээрээ тийм л дээ. Эрбэлгэдлийн дүрсийг ингэж зурдаг билүү?" гээд алган дээрээ долоовор хуруугаараа зурж дүрслэв.

"Тиим" гэж Ландон хариулав.

"Харин ингэж доош харуулбал" гээд алган дээрээ дүрслээд,

"Эм бэлгэдлийг төлөөлүүлж байгаа юм".

"Яг тийм".

"Рослинд байгаа хэдэн мянган дүрс тэмдэгт дотор эдгээр дүрс алга байна гэж үү?"

"Би ерөөсөө олж харсангүй".

"Хэрвээ чамд тэдгээрийг үзүүлбэл, чи амрахаар хэвтэх үү?"

Ландоныг хариулахын завдалгүй, Мэри Шавель Рослиний барилгыг чиглэн алхав. Ландон түүнийараас дагаж, барилгад ороход, Мэри танхимын гэрлийг асааж, танхимын тэхий гол руу заагаад, "Тэр байна ноён Ландон! Эр, эм бэлгэдлийн дүрсүүд".

Ландон хоосон чулуун шал руу хартал юу ч байсангүй. "Энд юу алга байна шүү дээ".

Мэри санаа алдаад, танхимын голд очиж зогсов. Ландон түүний зогсож байгаа газар дахь аваргадүрснээс өөр юу ч олж харсангүй.

"Энэ чинь Давидын одны дүрс биз дээ?" гэж Ландон хэлж дуусалгүй дүрс рүү ширтээд, гайхшранзогтусав.

Эр, эм бэлгэдлийн дүрс хамтдаа цогц байдлаар дүрслэгдсэн юм байна шүү дээ! Давидын од өөрөөр, эм бэлгэдэл дүрсний хослол юм байна.

Ландон хэсэгтээ үгээ олохгүй тэвдсэнээ, "Рослинд байгаа юм байна. Гарцаагүй. Яг тийм байна" гэв.

Мэри инээмсэглээд, "Харин л дээ".

Ландон бодолдоо авган, "Ариун Грейл тэгэхээр бидний доор байгаа хэрэг үү?"

Эмэгтэй инээд алдаж, "Наадах чинь зөвхөн таамаглал. Сионий Прайорийн эртний зорилго бол Грейлийг нэгэн цагт төрөлх эх орон Францад эргүүлэн аваачих явдал юм. Олон зууны турш Грейлхарь нутагт байсан боловч, Жак тэргүүн болонгуутаа л түүнийг Францад эргүүлэн татах төлөвлөгөөг бодож боловсруулсан юм. Грейлийг буцааж, хатан хааных нь суудалд суулгах хүндтэйүүргийг тэр өөртөө хүлээсэн".

"Тэгээд аваачсан уу?"

Мэригийн царай төв болж, "Ноён Ландон! Таны хийсэн бүх зүйлийг чинь харгалзан үзээд, Рослиний сүмийн удирдлагын тэргүүний хувьд, энд Грейл огт байхгүй гэдгийг баталж хэлэх байна".

Ландон бууж өгөлгүй, "Гэхдээ Онъсон чулуун дээр өгүүлснээр бол энд Ариун Грейл байгаа гэжзаасан шүү дээ! Рослин гэж шүлэгт бичсэн байсан".

"Магадгүй чи утгыг нь бүрэн ойлгоогүй байх л даа. Грейлийн тухай хуурамч зүйл ч бичсэн байжболно. Талийгаач нөхөр маань ингэж чадах л хүн".

"Гэхдээ тэр өөрөөр бичсэн байх учиргүй дээ. Та, бид хоёр эр, эм бэлгэдэл дүрсийн дээр зогсчбайна. Од эрхсийг дүрсэлсэн өндөр тааз дээрээс өнгийж байна. Мэйсоны уран гарт мастеруудын бүтээл барилга дотор байгаа. Энэ бүгдээс үзвэл Рослин байхаас зайлахгүй".

"Маш сайн. Одоо би шүлгийг нэг уншаадахья" гээд Мари цаасыг дэлгээд, албаар чанга дуугааруншив.

Эртний Рослиний доор Ариун Грейл хүлээж байгаа.

Эр, эм бэлгэдэл дүрсээр замчлуулж түүнийг олоорой!

Авьяаст мастеруудын бүтээл дунд,

Агаарт гялалзах түмэн оддын доор амгалан нойрсож байгаа.

Эмэгтэй уншиж дуусаад, дуугүй зогсож байснаа, удалгүй уруулд нь инээмсэглэл тодроод, "Ээ, Жакминь дээ!" хэмээн дуу алдав.

Ландон түүнд найдвар тавьж, "Та үүнийг ойлгочхов уу?"

"Ноён Ландон! Энгийн зүйлийг олж харах маш олон арга зам байдаг юм шүү дээ".

Ландон үүнд гайхав. Жак Сониехийн бүх л зүйл далд утгатай байсан атал, харин энэ шүлгээс далдагуулга олж харахгүй байв.

Мэри ядарсан бололтой эвшээгээд, "Ноён Ландон! Намайг өршөөгөөрэй. Би Грейлийн талаар албанёсоор сайн мэдэхгүй ч гэлээ нэр нөлөөтэй байсан хүний гэргийн хувьд, бас эмэгтэй хүний зөнсовингоор энэ бүхнийг сайн мэдэж байна".

Ландон үг хэлэх гэсэн боловч, Мэри цааш, "Та маш ээдрээтэй хэргийг давж гарсны дараа ч, энд Рослиноос ямар нэгэн хариулт авч чадахгүй байгаад би харамсаж байна. Гэхдээ хэн нэг нь таныг хайсан зүйлээ олно гэж надад шивнээд байна. Та үүнийг өөрөө удахгүй ойлгох болно" гээд Мэри инээмсэглээд, "Харин түүнийг олсныхоо дараа, та бусдын л адил тэр нууцыг өөртөө хадгалнагэдэгт би итгэлтэй байна".

Хаалга онгойх чимээ гарч, "Аан, та хоёр энд байсан юм уу?" гэж Софигийн дуу гарав.

"Би явах гэж байлаа" гэж эмээ нь хариулаад, Софи руу дөхөж очоод "Сайхан амраарай, гүнжминь!" гээд духыг нь үнсэв. "Ноён Ландоныг энд удааж болохгүй шүү!" гэв.

Бид хоёрыг зориуд энд үлдээж байна гэж Ландон бодов.

Софи маш дур булаам харагдах аж. Өнөөдөр болсон явдал бүсгүйн амьдралыг тэр чигт нь өөрчилснийг Ландон анзаарав.

"Чамд сайхан байна уу? Мөн ч хэцүү зүйлтэй тулгарсан шүү, бид хоёр".

Софи инээмсэглээд, "Надад одоо гэр бүл минь байна. Одоо л бүх зүйл эхэлж байна. Бидний хэн болох, хаанаас ирсэн нь одоо хамаагүй болсон".

Ландон чимээгүй зогсоно.

"Өнөө шөнөдөө чи энд хонох уу? Ядаж хэд хоног энд цугтаа байя л даа".

Ландон шүүрс алдаад, "Чи гэр бүлийнхэнтэйгээ цуг байсан нь дээр. Би маргааш өглөө Парис явна.

Бүсгүй үүнд сэтгэл дундуур байсан ч. Ландоны зөв гэдгийг мэдэж байв.

Тэд хэсэгтээ л юу ч ярьсангүй. Софи эцэст нь Ландоны гараас хөтөлж, сүмээс гарав. Тэднийг нэгэнжижиг довцог дээр гарахад, нүдний өмнө Шотландын уужим тал нутаг харагдаад, шинэ саран

үүлсийн цаанаас мэлтэлзэн туяарна. Тэр хоёрын аль аль нь сэтгэл үймэрсэн байдлаасаа салахынтулд, гараа чанга атгалцаад, зэрэгцэн зогсоно.

Одод дөнгөж түгж эхэлсэн боловч, зүүн зүгт нэгэн эрхэс гариг тодрон харагдахад, Ландон түүнийг харсан даруйдаа таниад инээмсэглэв.

Сугар гариг.

Эртний дарь эх шүтээн гэрэл цайруулан, тэнгэрт гялалзаж байв.

Ландон Софи руу эргэж харвал, бүсгүй нүдээ аньсан чигтээ, уруулдаа инээмсэглэл тодруулаад зогсож байв.

Ландон түүний гарыг зөөлөн сэгсрээд, "Софи?" гэж дуудав.

Софи алгуур нүдээ нээн, Ландон руу харав. Түүний царай сарны гэрэлд хосгүй үзэсгэлэнтэй харагдана. Бүсгүй дуниартсан нойрмог нүдээр түүнийг харж, "Сайн уу?" гэв.

Ландон түүнгүйгээр Парис явах болсондоо, сэтгэл дундуур гунигтай байв.

"Би чамайг өглөө сэрэхэд чинь явчихсан байна байх" гээд хоолой нь зангирч, "Уучлаарай, би т ийм сайн..".

Софи түүний хүзүүнд гараа нааж, дээш өндийгөөд, хацар дээр нь таалан үнсэв.

"Хоёулаа тэгээд хэзээ уулзах вэ?"

Ландон түүний харцанд уярч, "Хэзээ гэж үү?" гээд, бие биенээ ижил тэнцүү хүсэмжилж байгааг ойлгоод, "Би ирэх сард Флоренцод лекц уншина. Дараа нь долоо хоног тэнд хийх ажилгүй өнжих байх" гэлээ.

"Намайг тийшээ урьж байгаа юм уу?"

"Би дээд зэрэглэлийн люкс өрөөнд байх болно. Надад тэнд зориулж, Брунемески зочид буудалд өрөө захиалсан гэсэн".

Софи түүнийг шоолж инээгээд, "Чи ч бүр одооноос төлөвлөсөн байх шив, ноён Ландон!" гэв.

Ландон хэрхэн сонсогдох бол гэхээс түгшиж "Би чамайг ..." гэхэд, "Би чамтай Флоренцод уулзахыг юунаас ч илүү хүсч байна. Гэхдээ ганц болзолтойгоор" гэж хэлэхдээ, Софигийн дуу төв болж, "Ямар ч музей, сүм, бунхан, урлагийн бүтээл, шашин энэ тэр байхгүй шүү "Флоренцод үү? Бүтэндолоо хоног уу? Өөр тэнд юу хийх юм бэ?"

Софи дээш цоройж, энэ удаад Ландоны уруул дээр үнсэхэд, бие биедээ ойртсоор, тэдний харцтулгарч, бүтэн биеэрээ тэврэлдэн зогсов.

"За ойлголоо!" гэж Ландон хариулаад, "Тэгвэл болзоо болголоо шүү! гээд инээмсэглэв.

Төгсгөлгүй төгсгөл

Роберт Ландон зүүднээсээ цочин сэрэв. Орны дэргэд өлгөөтэй байх халаадны энгэр дээр "Рийцзочид буудал. Парис" гэж бичсэн байв. Тэрээр өрөөн дэх бүдэг гэрлийг хараад, үүр

цайж байгаа,орой болж байгаа алин болохыг ялгасангүй. Ландоны хамаг бие нь амраад, сэтгэл хангалуун байхаж.

Бүтэн хоёр өдөр нам унтсан бололтой.

Ландон ямар учраас сэрснээ бодоод олсонгүй. Орноосоо өндийж босоод, олон өдрийн турш маш ихзүйлийг эргэцүүлж байснаа санаад, одоо санагдаж буй зүйл урд өмнө нь түүнд огт тохиолдоогүйном шиг санагдав.

Ийм юм байж болно гэж үү?

Дүйнгэ царайлж хэсэг суусны эцэст, орноосоо хөндийрч, шүршүүрт оров. Гэвч түүнээс нэгэн бодолнь огт салсангүй.

Ямар сонин юм бэ?

20 минутын дараа Ландон зочид буудлаасаа гарчихсан, Вендомыг чиглэн алхаж байв. Тэр үед шөнөдунд болж байв. Уг нь тэрээр буудлын үүдний кафед цай ууж, бодлоосоо ангижирья гэж бодоодөрөөнөөсөө гарсан боловч, өөрийн мэдэлгүй Парисын гудамжаар алхаж байв. Тэр зүүн тийш эргэж,Рью де Петит - Шомп гудамж руу ороод, дараа нь урагш эргэж Рью Ришелью гудамжаар өгсөв.Цааш алхсаар, хар гантиган арк хүрээд, доош харвал засмал зам дээр хүрэл шигтгэмэл судалбайхыг олж анзаарав. Дээр нь N, S гэж бичсэн байв. Энэ нь Nord, Sud (Хойд, урд зүг) гэсэн зүг чигзаагч ажээ. Тэрээр S үсгийг даган явсаар Комеди - Франсайсын булангаар эргээд, зорьсон газраа олжхарав.

Нэгэнтээ Ландон Парисын зүг заагч энэ тэмдгийг даган явсаар, Сакре Көх гүүрээр Сейн мөрнийггаталж, Парисын Луврын музейд хүрч байсан юм. Энэ зүг заагч бол дэлхийн бөмбөрцгийн анхдагчуртраг буюу Парис хотын Сарнай судал (Rose Line) байлаа.

Ландон Рью Де Риволиг хөндлөн гараад, хэдхэн барилгын цаана хүссэн газар нь байгааг мэдэжбайв.

Эртний Рослиний (Rose Line - Сарнайн судал) доор Ариун Грейл хүлээж байгаа. Сониех үүнийг лнадад бичиж үлдээсэн хэрэг байж. Би өмнө нь энэ тухай болохгүй яав аа?

Тэрээр зүг заагчийг даган шогшсоор газар доорх хонгил хүрэв. Хонгилыг шогшиж туулаад, үзүүртнь хүрвэл нүднийх нь өмнө аугаа их хосгүй бүтээл сүндэрлэн харагдана.

Энэ бол Луврын Пирамид байлаа.

Шөнө дөлөөр гялтганан үзэгдэх Пирамидын гоо үзэсгэлэнг бахдаад ханахгүй байв. Гэвч Робертцааш алхсаар, Сарнайн судлыг дагасаар Каруссель ду Лувр луу явж оров. Энэ бол дугуй хэлбэртэйзасч сэлбэсэн, зүлэгт том талбай байв.

Ландон явсаар голд нь очоод, шилэн гадаргуутай талбай дээр зогсож, доош өнгийж харвал,урвуулсан Пирамид түүний нүдэнд тусав.

Авьяаст мастеруудын бүтээл дунд, Да Винчи, Ботичеллигийн бүтээлүүд бүгд л энд, Луврт байгааашүүдээ!

Ландон доош харсан чигтээ, Доош буух ёстой гэж бодов.

Тэр зүлэгт талбайгаас гарч, Пирамидын үүд рүү зүглэв. Жуулчид музей хаагдахаас өмнө гарч иржбайгаа бололтой, үүдээр хэсэг хүмүүс цуврах нь үзэгдэнэ. Ландон эргэдэг хаалгыг

түлхэн ороод, урсдаг шатаар доош буувал, түүний өөдөөс хүйтэн агаар үлээж, Ландоныг жиндүүлж байв. Тэрдоош буугаад, урт хонгил даган алхсаар, урвуулсан дүрстэй пирамид дээр ирлээ.

Таазнаас унжсан шилэн пирамид V үсэг хэлбэртэй харагдана.

Эм бэлгэдэл дүрс! гэж Ландон өөртөө хэлэв.

Ландон Урвуулсан Пирамидын таазан дахь сууриас үзүүр лүү дагуулан харсаар, шалнаас зургаанфутийн зайд ирээд, тэр хэсэг газарт харцаа тогтоов. Том пирамидын доор жижиг хэмжээтэй зөвхарсан пирамид байв. Жижиг пирамид 3 фут хүрэхтэй үгүйтэй өндөртэй аж. Ландон ши нэномынхоо гар бичмэлд энэхүү пирамидыг өнгөц дурдаад орхисон юм.

Хүнгүй шахам музейн хоосон танхимд хос пирамид үзүүрээрээ нийлэх шахан, өөд өөдөөсөөхараад, төгс байдлыг илэрхийлнэ.

Эм дүрс нь Дээрээ, эр нь Доороо!

Мэри Шавелийн хэлсэн үг Ландонд сонстох шиг болов. "Чи удахгүй бүхнийг ойлгох болно!".

Ландон Сарнайн судал (Рослиний) доор, аугаа мастерын бүтээлүүд дотор зогсож байгаагаа мэдэрчбайв.

Сониех үүнээс өөр аюулгүй ямар газрыг сонгож нуух байсан гэж? хэмээн бодоод, СионийПрайорийн тэргүүний шүлгийн утгыг сая л бүрэн ухаарав.

Ландон эгц дээр нь шилний цаанаас гялтганах, түм буман одод руу ширтлээ.

Агаарт гялалзах түмэн оддын доор амгалан нойрсож байгаа...

Гэнэт Ландоны чихэнд мартагдсан байсан үгс цуурайтах шиг санагдав.

"Ариун Грейлийг эрж хайх нь эцэстээ, Мэри Магдалиний шарилд сөгдөн мөргөнө гэсэн үг".

Ландон өөрийн эрхгүй өвдөг дээрээ сөхрөн суув.

Тэр мөчид газар дэлхийн гүн ангалаас эмэгтэй хүний ариун дагшин дуу гарч, Ландоны чихэнднэгэн үг шивнэх шиг болов...

Төгсөв